



Томас Майер

Николе Врайертай хамтран бүтээв

НИЙГМИЙН
АРДЧИЛЛЫН
ИРЭЭДҮЙ

**FRIEDRICH
EBERT** 
STIFTUNG

Impressum

„The future of social democracy“

„Zukunft der sozialen Demokratie“ - „Нийгмийн ардчиллын ирээдүй“, published by Friedrich-Ebert-Foundation Berlin 2005.

Published by Friedrich-Ebert-Stiftung,
Ulaanbaatar Office, Mongolia 2012

Contact:

Friedrich-Ebert-Stiftung,
Ulaanbaatar Office, Mongolia
Adresse: Red Cross Building 2.floor
Sukhbaatar district
Ulaanbaatar 210648
P.O. Box 831
Telephone: (+976) 11-312892
Fax: (+976) 11-312889
e-mail: oyun@fesmongol.net; info@fesmongol.net
www.fes.de

Томас Майер

**НИЙГМИЙН АРДЧИЛЛЫН
ИРЭЭДҮЙ**

Николе Врайертай хамтран бүтээв.

3 дахь хэвлэл

Фридрих - Эбертийн сангийн захиалгаар Фридрих - Эбертийн сангийн
улс төрийн академийн захирал Профессор, Доктор Томас Майер
туурвив.

Фридрих-Эбертийн сангийн улс төрийн академийн ажилтан Николе
Врайертай хамтран бүтээв.

Герман хэлнээс орчуулсан Фридрих - Эбертийн сангийн Монгол дахь
төлөөлөгчийн газрын захирал:
Ч.Оюунгэрэл

Хянан тохиолдуулсан: Г. Адъяа /доктор/

Хэвлэлийн эх бэлтгэсэн: Фридрих - Эбертийн сангийн Монгол дахь
төлөөлөгчийн газрын нарийн бичиг:
Ё. Батболд



Монгол улсад уг номыг хэвлэх, олшруулах эрхийг
зөвхөн Фридрих-Эбертийн сангийн
Монгол дахь төлөөлөгчийн газар эдэлнэ.

АГУУЛГА

Өмнөх үг	7.
Номын зохиогч Доктор, профессор Томас Майерийн Монголын уншигчдад зориулсан үг	10.
1 Оршил	13.
2 Үнэт зүйлс ба үндсэн ойлголтууд	20.
2.1 Либерал ардчиллын зөрчил	20.
2.2 Либертар ардчиллын дутагдалтай талууд	24.
2.3. Нийгмийн ардчиллын эрх зүйн шаардлага	26.
2.4 Нийгмийн ардчиллын үндэс	27.
2.5 Иргэдийн нийгмийн эрхүүд	33.
2.6 Түгээмэл үндсэн эрхүүд	36.
2.7 Хувийн хариуцлага ба иргэдийн үүрэг	42.
2.8 Нийгмийн эрсдэлүүд	45.
2.9 Улс төрийн антропологи	51.
2.10 Шударга ёс	56.
2.11 Тогтвортой байдал	66.
3. Улс төрийн үйл ажиллагаа	72.
3.1. Улс төрийн үйл ажиллагааны үүрэг хариуцлага	72.
3.2 Актёрууд, системүүд ба стратегиуд	75.
3.3 Улс төрийн удирдлага	78.
3.4 Нийгмийг ардчилах	82.
3.5 Иргэний нийгэм	85.
3.6 Олон нийт	94.
4 Улс төрийн эдийн засаг	102.
А. Эдийн засаг	102.
4.1 Даяаршил ба улс төрийн эдийн засаг	102.
4.2 Зах зээлд нийгмийн хариуцлага ногдуулах нь	119.
4.3. Өмчлөх эрх ба тэгш эрх чөлөөний тухай ойлголт	123.
4.4 Эдийн засгийн зохицуулалт	126.
4.5 Олон нийтийн таваарууд ба иргэдийн эрх	138.
Б. Нийгмийн баримжаат төр	147.
4.6. Хөдөлмөр ба хүмүүний алдар хүнд	147.
4.7 Зах зээлүүдийн нийгмийн хүрээлэл буюу зах зээлд нийгмийн хариуцлага ногдуулах нь	148.
4.8 Хөдөлмөрлөх эрх	152.

4.9	Үндсэн эрхүүд ба нийгмийн баримжаат төр	154.
4.10	Боловсрол	174.
4.11	Нийгмийн баримжаат зах зээлийн ирээдүй	182.
4.12	Үйл ажиллагааны хэтийн чиг хандлагууд	198.
5	Даяаршлын бодлого	211.
5.1	Нийгмийн ардчилал ба даяаршил	211.
5.2	Даяаршлын иргэний нийгэм	215.
5.3	Даяаршлын ардчиллын загварууд	217.
5.4	Дэлхийн зах зээлд хариуцлага ногдуулах нь	229.
5.5	Нийгмийн ардчилал Европ тивд	240.
5.6	Даяаршил нээлттэй процесс мөн.	246.
6.	Улс төрийн соёл	249.
6.1	Нийгмийн ардчиллын түгээмэл байдал	251.
6.2	Соёлын ялгаатай талууд болон социал иргэний нийгэм	253.
7.	Улс орнуудын загварууд	257.
7.1.	Улс орнуудын харьцуулалт	257.
7.2	Швед	258.
7.3	Их Британи	270.
7.4	Голланд	285.
7.5	Герман улс	298.
7.6	Япон	314.
7.7	АНУ	329.
7.8	Загваруудын харьцуулалт	342.
7.9	Дүгнэлт	358.
8	Бодлогын практик	363.
8.1	Нийгмийн ардчиллын бодлогын актёрууд	363.
8.2	Бодлогоор зохицуулах ба дасан зохицох стратеги	365.
8.3	Либертар ардчилал: Гажуудалтай ардчилал	371.
9	Хэтийн төлөв	374.
10.	Фридрих - Эбертийн сангийн тухай	377.
11.	Зохиогчийн тухай	379.
12.	Ном зүй	381.

Өмнөх үг

Фридрих-Эбертийн сан нь нийгмийн ардчиллыг дэмжин дэлгэрүүлэх үйл ажиллагаа явуулдаг улс төрийн сан юм. 1925 онд үүсэн байгуулагдсан цагаасаа эхлэн нийгмийн ардчиллын үнэт зүйлс, тэдгээрийг тодорхойлох, түгээн дэлгэрүүлэх, улс төр, эдийн засаг, нийгэмд хэрэгжүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлж ирлээ.

Та бүхэнд өргөн барьж байгаа энэхүү ном бол «Нийгмийн ардчиллын» төслийг дэлгэрэнгүй тайлбарлах, түүний өнөөгийн даяаршсан дэлхий ертөнцийн ирээдүйд гүйцэтгэх үүрэг, зорилтуудыг өргөн хүрээтэйгээр тодорхойлох оролдлого билээ. Хүн бүрийг хүний ёсоор аж төрж амьдрах нөхцөлөөр хангахын тулд тэдний иргэний болон улс төрийн үндсэн эрхүүдийг нийгэм, эдийн засгийн үндсэн эрхүүдээр баяжуулах шаардлагатай юм.

Нийгмийн ардчилал нь нийгмийн аюулгүй байдал, нийгмийн баялгаас тэгш хувь хүртэх эрхийг хангах, амьдралын боломжийг шударгаар хуваарилах үндсэн дээр суурилсан оролцооны тухай ойлголт юм. Иргэдийн нийгмийн эрхүүд нь иргэн бүрд өөрөө хувь заяаныхаа эзэн

байх үндсэн эрхийг баталгаажуулж ардчилалд өөрийн хувь нэмрээ оруулах эрх тэгш бололцоогоор хангагдах үндсийг нь бүрдүүлж өгдөг.

Өнөөдөр дэлхий дахинаа хэт либерал болон нийгмийн ардчиллын үзлийг баримтлагсдын хооронд мэтгэлцээн өрнөж байна. Хэт либерал ардчиллын үзлийг баримтлагсад иргэдийн эрх чөлөөг гагцхүү өөрийн голдирлоор зохицуулагдах зах зээл ба үйлдвэрлэлийн хэрэгслийн чөлөөт өмчлөл нь хангалттай баталгаажуулж чадна гэж үздэг. Харин өнгөрсөн үеийн түүхэн туршлага, өнөөгийн тулгамдсан асуудлуудын дүн шинжилгээгээр энэ нь хангалтгүй гэдэг нь батлагддаг. Нийгмийн баримжаат зах зээл нь нийгэм, эдийн засгийн шийдвэр гаргалтад иргэдийн хамтын оролцоог хангасан, эв санааны нэгдлийн зарчим дээр суурилсан нийгмийн баримжаат төртэй хамтран хүмүүсийн эрх чөлөөг хангаж ардчиллыг бэхжүүлж байдаг. Нийгмийн ардчилал нь ардчиллын шаардлагуудыг хангаж ардчиллыг иргэдийн өдөр тутмын амьдралд хэрэгжүүлж байдаг. Даяаршлын эрин үед нийгмийн ардчиллын ач холбогдол улам бүр өссөөр байна. Нийгмийн амьдралын бүхий л салбарт байгаль орчинд учирч буй аюулаас эхлээд дэлхий дахинд явагдаж буй цагаачлагчдын их урсгал, санхүүгийн дүрэм журмын дутагдалтай талууд хүртэл дэлхий дахины тогтвортой байдалд сөргөөр нөлөөлөх хэмжээнд хүрээд байгаа өмчийн болон амьдрах боломжийн тэгш бус хуваарилалт зэрэг нь гагцхүү зах зээлийн голдирлоор зохицуулагдах даяаршил нь ямар их аюул занал дагуулж буйг бэлхнээ харуулж байна. Зах зээлд улс төрийн болон нийгмийн хариуцлага ногдуулах нь дэлхий дахинаа үндсэн эрхүүдийг хангах, шударга хамтын ажиллагаан дээр суурилсан энх тайвныг бэхжүүлэхэд нэн чухал ач холбогдолтой. Энэхүү ном нь дээрх бодлогыг хэрэгжүүлэхэд тус болохуйц олон практик саналуудыг дэвшүүлж байна. Түүнчлэн нийгмийн ардчиллын шаардлагууд, тэдгээрийн үзэл санаа нь тодорхой нэг санал, арга хэмжээнээс хамаарахгүй, асар өргөн хүрээтэй гэдгийг харуулж байгаа юм. Нийгмийн ардчиллын төсөл нь улс төрийн болон нийгмийн үндсэн эрхүүдийг улс үндэстний төвшинд бол шинэчлэл хийх

хэлбэрээр, даян дэлхийн хэмжээнд бол даяаршилд улс төрийн болон нийгмийн хариуцлага ногдуулах замаар амьдралд бодитоор хангахыг зорьж байна. Нийгмийн ардчиллын төсөл нь ирээдүйд чиглэсэн шинэчлэлийн хөтөлбөр бөгөөд ардчиллын хувь заяатай салшгүй холбоотой юм.

Энэхүү номын үндсэн утга санаа болон нийгмийн ардчиллын төсөл аль хэр амжилттай хэрэгжих эсэх нь улс үндэстний хэмжээнд болон даяаршлын тавцан дээр хэдийчинээ олон нийгмийн болон улс төрийн актёрууд уг төслийн зорилтуудыг дэмжиж, тэдгээрийг хэрэгжүүлэхийн төлөө хамтдаа оюун бодлоо уралдуулахаас төдийчинээ хамаарна гэдгийг харуулахад оршино.

Миний бие энэхүү идэвх чармайлтыг хэрэгжүүлэхэд ном маань хувь нэмрээ оруулаасай хэмээн хүсэж байна.

Анке Фукс Фридрих - Эбертийн сангийн дарга
Берлин хот, 2004 оны 12-р сар

ДОКТОР, ПРОФЕССОР ТОМАС МАЙЕР

Монголын уншигчдад зориулсан үг

«Нийгмийн ардчиллын ирээдүй» хэмээх энэхүү бүтээл маань Монголын сонирхогч уншигчдын гар дээр очиж байгаад би баяртай байна. Нийгмийн ардчилал бол аль нэг улс оронд, эсхүл аль нэг тивд илүү тохирдог хөтөлбөр биш. Харин түгээмэл үндсэн эрхүүдийн нэгэн адил өөрийн шаардлагууд болон боломжуудын хувьд түгээмэл шинж чанартай юм. Нийгмийн ардчилал нь нийгмийн оролцоо, аюулгүй байдал, шударга ёсыг хөгжлийн зорилгоо болгон тодорхойлсон улс орон бүрийн хөгжлийн нэгэн боломж мөн.

Дэлхий дахины түүхэн хөгжил нь өнөөг хүртэл цаг хугацааны хувьд асар их зөрүүтэй байлаа. Энэ нь аливаа нийгэмд бусдын туршлагаас хуулбарлан дуурайлгүйгээр ихийг суралцах боломжийг олгодог. Европ тивийн 19-р зууны болон 20-р зууны эхэн үеийн үндсэн туршлага нь «нийт иргэдийнхээ оролцоог хангасан нийгмийн хөгжилд хүрэхийн тулд ардчиллыг зөвхөн шаардагдах дүрэм, журам бүтцүүдийн хамт байгуулах төдийгүй нийгмийн ерөнхий хүрээнд бүх иргэдээ хамгаалж чадахуйц нийгмийн хамгааллын системийг хэрэгжүүлж чадсан нөхцөлд л хүрдэг» гэдгийг харуулсан билээ. Олонхын зарчмын аргачлалын дүрэм, иргэний болон улс төрийн үндсэн эрхүүдээр хязгаарлагдах

цэвэр либертар ардчилал нь практик дээр ямагт олон иргэдэд сөрөг талуудыг авчирч иргэдийн дийлэнх хэсгийг нийгмийн амьдрал, улс төрийн тэгш оролцооноос тусгаарлагдахад хүргэдэг. Иймээс либертар ардчилал бодит байдал дээр гажуудалтай ардчилал бөгөөд хөгжилд саад тогтор учруулдаг.

1966 оны НҮБ -ын пактын шаардлагуудын дагуу нийгмийн болон эдийн засгийн үндсэн эрхүүд аливаа нийгмийн бүх иргэдийн амьдралд бодитоор хэрэгжиж чадсан нөхцөлд л сая ардчилал төгс хэрэгжиж бүх иргэдийн амьдралын чухал үнэлэмж болдог. Аливаа улс орон бүр иргэдийнхээ нийгмийн үндсэн эрхүүдийн бодит хэрэгжилтийг хэрхэн хамгийн сайнаар хангах бэ? гэдэг нь тухайн нийгмийн түүх, нэн ялангуяа хуримтлуулсан туршлага, хөгжлийн хүрсэн түвшингээс хамаардаг. Гэхдээ бүх хүүхдүүдэд эцэг эхийнх нь нийгмийн статусаас үл хамааран авьяас чадвар, оюун ухаанаа хөгжүүлэх тэгш боломжийг олгох боловсролын систем, орчин үеийн нийгмийн бүх төрлийн эрсдэлүүдээс найдвартай хамгаалагдсан иргэдийн нийгмийн эрхүүд, эдийн засгийн харилцаанд хариуцлага ногдуулах, ардчилсан зарчмаар хариуцлагыг хамтран хүлээх бодлогоор процессуудыг удирдах нь зайлшгүй байх ёстой шаардлагууд юм.

Монгол улс ганцаарчлан захирах дэглэмээс олон ургалч, эрх зүйт төрт ардчилалд шилжих шилжилтийг олон улсад үлгэр жишээ болохуйц замаар амжилттай хэрэгжүүлсэн билээ. Монгол улсад хорин жилийн туршид ардчилал тогтвортойгоор хөгжиж энэ нь Монголын ард түмэнд улс төрийн амьдралын зохистой хэлбэр хэмээн хүлээн зөвшөөрөгдсөн билээ. Ийм ч учраас Монгол улсад ардчиллыг өөрийн орны уламжлалт, бахдам соёлын хөрсөн дээр төгс хэрэгжүүлэх түүхэн зорилт тулгараад байна. Миний бие энэхүү бүтээл маань дээрх зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд өрнөх улс төрийн мэтгэлцээнүүдэд хэрэг болохуйц санал сэдлүүдийг өгөөсэй гэж хүсэж байна.

Уг номд орсон улс орнуудын харьцуулсан судалгаа нь бусад улс орнууд ямар замаар нийгмийн ардчиллыг амжилттай байгуулсан талаарх олон санал сэдлүүд, жишээнүүдийг зөвхөн дурдаад зогсоогүй шинэ либерализмын талыг баримтлагчдын өнөөгийн даяаршсан дэлхий дээр нийгмийн ардчилалд оршин тогтнох орон зай үгүй болсон гэдэг өөрсдийн ашиг сонирхолд нийцүүлсэн нотолгоо нь үндэслэлгүй гэдгийг баталж байгаа юм.

Дэлхий дээр эдийн засгийн хөгжлөөрөө тэргүүлж буй орнууд, нэн ялангуяа Скандинавын орнуудын хөгжлийн загвар нь хамгийн сайн бэхэжсэн, үүргээ хамгийн сайн биелүүлж буй нийгмийн ардчиллын жишээ юм.

Дээрх амжилтад нийгмийн ардчиллыг зөвхөн нийгмийн хамгаалал, нийгмийн оролцоог баталгаажуулаад зогсохгүй улс орны эдийн засгийн хөгжилд чухал хувь нэмэр оруулахаар байгуулж чадсан орнууд л хүрдэг. Зөвхөн үүнд нийгмийн ардчиллын замыг сонгон авсан энэ дэлхийн улс орон бүрийн болон дэлхий нийтийн нийгмийн ардчиллын ирээдүй оршин байна.

Оршил |

Өнөөгийн даяаршиж буй дэлхий дахинд хоорондоо эрс ялгаатай ардчиллын хоёр үндсэн ойлголт нөлөөгөө нэмэгдүүлэхийн төлөө тэмцэлдэж байна: Эдгээр нь АНУ-д хэрэгжиж буй либертар хэв шинжит ардчилал болон Европын хэв шинжит нийгмийн ардчиллын тухай ойлголтууд юм. Эдгээр хоёр загварын аль аль нь бүтцүүдийнхээ хүрээнд хүний эрх болон төлөөллийн ардчиллыг хамгаалдаг боловч Эдийн засаг - Нийгмийн байгууллын ямар хэлбэрүүд ардчиллын шаардлагуудыг илүү хангадаг бэ? гэдэг асуудал дээр хоорондоо эрс өөр байр суурийг баримталдаг. Энэхүү зарчмын зөрүүтэй байр суурь нь тухайн нийгмийн төдийгүй даяаршлын байгууллын үндсэн зарчмуудад тусгалаа олсон байдаг.

Энэхүү ном нь нийгмийн ардчиллын онол, практикийн оршил бөгөөд юуны өмнө нийгмийн ардчиллын үзэл баримтлал практикт хэрхэн хэрэгжиж байгааг харуулахыг зорьсон юм. Хэдийгээр энэхүү ном маань нийгмийн ардчиллын онол, практик болон ардчилсан социализмын онол дээр суурилсан боловч нийгмийн ардчиллын онолын түүхийг та бүхэнд толилуулах зорилгыг тавиагүй гэдгийг хэлэх нь зүйтэй. Мөн энд

улс төрийн үзэл суртлын түүхийг өгүүлэх зорилтыг тавиагүй. Хамгийн гол нь орчин үеийн ардчилал хэрхэн хуульчлагдаж байна бэ? Түүнд нийгмийн шударга ёс ямар үүрэг гүйцэтгэж байна бэ? Нийгмийн шударга ёс ямар үндсэн эрхүүд дээр суурилж байна бэ? Тэдгээр нь тухайн нийгмийн тогтвортой байдал, бүтээмжид ямар ач холбогдолтой юм бэ? гэдгийг харуулахыг үндсэн зорилгоо болгосон юм. Нийгмийн ардчиллын онол нь иргэн бүрийн үндсэн эрхүүдийг нэн ялангуяа нийгэм, эдийн засгийн болон улс төрийн үндсэн эрхүүдийг хамгийн дээд зэргээр хангахад улс төрийн үйл ажиллагааны ямар стратеги шаардлагатай бэ? гэдгийг харуулдаг. Мөн түүнчлэн хүний үндсэн эрхүүдэд аюул учруулж болохуйц нийгмийн эрсдэлүүдийг төрөл бүрийн нийгмийн байгууллауд ямар стратегиар даван туулдаг бэ? гэдэг харьцуулалтыг хийдэг.

Нийгмийн ардчиллын үзэл баримтлал нь бодлогын чухал асуудлуудад улс орнуудын туршлагаар нотлогдсон шийдлүүдийг олохыг гол зорилгоо болгодог. Бүх иргэдийн түгээмэл үндсэн эрхүүдийг орчин үеийн эдийн засаг, нийгмийн бүтцийн эрсдэлүүдээс найдвартай хамгаалахын тулд ардчилал нь ямар ямар байгууллага нэгж болон бодлого, оролцооны боломжууд, эрхүүдтэй байх ёстой юм бэ? Үүнд иргэдийн хувийн хариуцлага ч чухал үүрэгтэй. Иргэд иргэний нийгмийн өргөн хүрээтэй эрхүүдийг эдлэх шаардлага тавихын тулд нийгмийн болон улс төрийн ямар үүрэг, хариуцлага хүлээх ёстой бэ?

Нийгмийн ардчиллын онол нь улс орнуудын туршлага болон ардчилсан үйл ажиллагааны практик дээр суурилдаг. Нэлээд олон ардчилсан орнууд нийгмийн ардчиллыг тодорхой түвшинд, харин Скандинавын орнуудын хувьд өндөр төвшинд хэрэгжүүлээд байна. Холбооны Герман улсыг Холбооны Герман улсын үндсэн хуулийн цэц нийгмийн ардчилсан орон гэж тодорхойлсон байна. Энэхүү номд нийгмийн ардчилал нэрийн дор ямар практик хэрэгжиж байгаад дүн шинжилгээ хийж нийгмийн ардчилсан бүтцийн талаар ирээдүйд

хандсан урьдчилсан таамаглалуудыг дэвшүүлсэн нь илүү сонирхолтой болгож байгаа юм. Мөн энэхүү онолын хүрээнд өнөөгийн нөхцөл байдалд бодлогын ямар стратегиуд хэрэгжих боломжгүй бэ? гэдгийг нотлон харуулснаар практикт шинэ чиг хандлагуудыг олгож байгаа юм. Дэлхий дахины нийгмийн өөрчлөлтийн хурдац асар өндөр байгаа өнөө үед зөвхөн өнөөгийн нөхцөл байдлын хүрээнд (*status quo*) дүн шинжилгээ хийх нь бодит байдалд нийцэхгүй бөгөөд хариуцлагагүй хэрэг болох юм.

Нийгмийн ардчиллын онол нь онолын норматив элементүүдийг агуулж байдаг. Эдгээр онолын элементүүдийн хэрэгжих шаардлага нь түгээмэл байх гэдэг утгаар аль болох нөхцөл бага шаардах норматив суурийг сонгон авсан бөгөөд энэ нь дэлхийн аль ч өнцөгт хэрэгжих ёстой гэдэг ерөнхий шаардлага тавих нөхцөлд дөхөмтэй болгож байгаа юм. Энэхүү суурь нь 1966 оны НҮБ-ын хэлэлцээрээр батлагдсан иргэний болон улс төр, нийгэм, эдийн засгийн үндсэн эрхүүд бөгөөд уг хэлэлцээрт өөр өөр соёл иргэншилтэй, хөгжлийн төвшнөөрөө ялгаатай дэлхийн 148 улс орон нэгдэн ороод байгаа билээ. Эдгээр нормуудыг маш ерөнхий томьёолсон бөгөөд дээрх улс орнуудын харилцан адилгүй хөгжлийн төвшинг харгалзан үзсэн болно. Нийгмийн ардчиллын онолын нэг чухал судлагдахуун нь дээрх түгээмэл үндсэн эрхүүд нь ардчиллын онолын болон ардчилал, нийгмийн бодлогын ямар ямар үр дагавруудыг дагуулдаг, ямар нөхцөлүүдийг шаарддаг бэ? гэдэг асуудал юм. Түүнчлэн өнөөгийн дэлхий дахинд дээрх эрхүүдийг материаллаг талаас нь хангахад ямар институцийн болон эдийн засаг, нийгмийн бодлого, соёлын үйл ажиллагааны стратегиуд шаардлагатай бэ? гэдэгт зохих дүн шинжилгээг энд хийсэн.

Нийгмийн ардчиллын онол нь ардчиллын онолын судалгааны нэлээд өргөн цар хүрээг багтаасан байдаг. (Хүснэгт 1-ийг хар)

Хүснэгт 1: Ардчиллын онолын судалгааны цар хүрээ

Судалгааны цар хүрээ	Асуудлууд
Хэв шинжийн цар хүрээ	Нийгмийн ардчиллын үзэл баримтлал, либертар ардчиллын үзэл баримтлалаас юугаараа ялгаатай юм бэ?
Норматив цар хүрээ	Ямар хэм хэмжээнүүд ардчиллын хууль ёсны баталгааг хангадаг бэ?
Туршлагын болон-дүн шинжилгээний цар хүрээ	Нийгмийн асуудлуудыг шийдвэрлэхэд ардчилсан системүүдийн чадамж хэр өндөр бэ?
Тогтвортой байдлын судалгаа	Улс төрийн ардчиллын оршин тогтнох нөхцөлүүдийг хангахад ямар нөхцөлүүд шаардлагатай бэ?
Ардчиллын харьцуулсан судалгаанууд	Улс орнууд өөрийн онцлог нөхцөл байдалдаа зохицуулан хийсэн шийдлүүд ямар амжилтад хүрсэн бэ?
Шинэ үеийн ардчиллын судалгаа	Ямар ямар нөхцөл шалтгаан болон хэлбэр, үр дагаврууд ардчиллыг гажуудалд хүргэдэг бэ?

Дээрх бүх асуудлуудын хариултууд улс төрийн ардчиллын практикаас урган гардаг бөгөөд хоорондоо нягт холбоотой байдаг. Эдгээр асуудлууд нь нийгмийн ардчиллыг ардчиллын онолын талаас нь авч үзэх нөхцөлийг бүрдүүлдэг.

Нийгмийн ардчиллын төсөл нь улс төрийн болон нийгмийн үндсэн эрхүүдийг хангах үүргийг практик реализмтай холбож өгдөг. Уг төсөл нь өнөөгийн цогц нийгмийн хэрэгжүүлэх чадамж, бололцоонд тулгуурлан боловсруулагдсан. Энэ утгаараа нийгмийн актёруудын онол дээр суурилдаг. Нийгмийн актёруудын онол нь нийт нийгмийн үйл ажиллагааны бүх цар хүрээг тодорхойлохдоо дараах хоёр хүчин

зүйлсийг байнга харгалзан үздэг. Эдгээр нь: Нийгэмд бүрэлдэн тогтсон дэд системүүдийн зүгээс үйл ажиллагааны цар хүрээнд тавигдах хязгаарлалтууд, дэд системүүдийг өөрчлөхөд шаардагдах үйл ажиллагааны өгөгдсөн орон зай юм.

Нийгмийн ардчиллын тулгуур баганын нэг нь нийгмийн баримжаат төр юм. Гэхдээ нийгмийн ардчиллын тухай ойлголт нь нийгмийн бүх дэд системүүд тэдгээрийн хоорондын уялдаа холбоог судалдаг тул илүү өргөн хүрээтэй юм.

Үүнд дараах дэд системүүд хамаарна:

Нийгмийн ардчиллын дэд системүүд:

1. Улс төрийн систем
2. Үндсэн эрхүүдийн систем
3. Улс төрийн олон нийтийн систем
4. Иргэний нийгэм
5. Нийгмийг ардчилах дэд системүүд
6. Нийгмийн баримжаат төр
7. Боловсролын систем
8. Эдийн засгийн ерөнхий зарчмууд буюу эдийн засгийн засаглалын хэлбэр
9. Эдийн засгийн зохицуулалт
10. Компаниудын ерөнхий зарчмуудын систем буюу компаниудын засаглалын хэлбэр
11. Үндэстэн дамжсан зохицуулалт
12. Улс төрийн соёл

Эдгээр дэд системүүдийг маш олон хувилбараар зохион байгуулах боломжтой. Нийгмийн ардчиллын төслийн зорилт бол улс төр, нийгмийн үндсэн эрхүүд хамгийн баталгаатайгаар хангагдах нөхцөлийг бүрдүүлж чадах тийм хувилбараар дэд системүүдийг зохион байгуулахад оршино.

«Нийгмийн ардчиллын» тухай ойлголт нь дараах гурван цар хүрээнд тодорхойлогдоно:

Нэгдүгээрт: «Нийгмийн ардчиллын» ойлголт нь ардчиллын онолын үндсэн ойлголтуудын нэг юм.

Хоёрдугаарт: Нийгмийн ардчиллын ойлголтыг улс төрийн хөтөлбөрийг тодорхойлоход хэрэглэдэг. Хэдийгээр тавьж буй улс төрийн зорилгууд нь нийгмийн ардчиллын онолын зорилтуудтай агуулгын хувьд нийцдэггүй ч «Нийгмийн ардчиллыг» хөтөлбөрийн нэр болгон ашигладаг улс төрийн актёрууд байдаг. Нөгөө талаас иргэний нийгмийн болон улс төрийн бусад актёрууд нийгмийн ардчиллыг төлөөлөх хэмжээний зарим зорилтуудыг дэвшүүлэн тавьдаг учир социал демократ намууд уг ойлголтыг монополь болгон өмчлөх эрхгүй юм.

Гуравдугаарт: Нийгмийн ардчиллын ойлголт нь Европын зарим улсуудын үндсэн хуулиудад тодорхой байр суурь эзэлдэг тул төр эрх зүйн цар хүрээнд тодорхойлогддог.

Херман Хеллерийн үеэс нийгмийн ардчилал нь нийгмийн тогтвортой байдал, амьдралын боломжийн шударга хуваарилалт, ардчилалд оролцох нийгмийн оролцооны боломжуудын дотоод холбоон дээр суурилдаг.

Энэхүү ном дараах бүлгүүдэд хуваагдана:

1. **Үнэт зүйлс:** Либерал болон либертар ардчиллын дүн шинжилгээ: Нийгмийн ардчиллын онолын үндсэн ойлголтууд
2. **Улс төрийн үйл ажиллагаа:** Улс төрийн үйл ажиллагааны үүрэг хариуцлагын тухай ерөнхий ойлголт, Нийгмийг ардчилах, идэвх санаачилгатай иргэний нийгэм, шүүн хэлэлцэгч олон нийт бүрдэх нөхцөлүүдийг тодорхойлох
3. **Улс төрийн эдийн засаг:** Зах зээлийн нийгмийн хүрээлэл ба

- эдийн засгийн зохицуулалтын журмуудад дүн шинжилгээ хийх
4. **Нийгмийн баримжаат төр:** Нийгмийн ардчиллын ерөнхий зарчмууд, хөдөлмөрийн зах зээл, нийгмийн бодлогын хүрээнд хэрэгжүүлж буй шинэчлэлийн төслүүдийн тухай товч танилцуулга
 5. **Даяаршлын бодлого:** Даяаршлын улмаас тулгарч буй шаардлагуудыг тодорхойлох, даяаршлын иргэдийн хамтын нийгэмлэгийн боломжууд ба даяаршлыг ардчилах
 6. **Улс төрийн соёл:** Соёлын ялгаанууд ба иргэдийн хамтын нийгэмлэг, нийгмийн ардчиллын түгээмэл үндсэн ойлголтууд
 7. **Улс орнуудын хөгжлийн загварууд:** Нийгмийн ардчилсан улсуудын төрөл бүрийн загваруудыг хооронд нь харьцуулах
 8. **Улс төрийн практик:** Нийгмийн ардчиллын шинэчлэлийн прагматик бодлого, актёрууд, стратеги, туршлага

II Үнэт зүйлс ба үндсэн ойлголтууд

2.1 Либерал ардчиллын зөрчил

Либерал ардчиллын онол нь Европ тивд соён гэгээрлийн эрин үеэс орчин үеийн улс төрийн хууль ёсны сургаал хэмээн аажимдаа хүлээн зөвшөөрөгдсөн. Өнөөгийн барууны хэв шинжит үндсэн зарчим бүхий ардчилсан бүх улс орнууд либерал үндсэн загвар дээр суурилдаг. Уг загвар нь улс төрийн ноёрхлын дараах хэм хэмжээнүүд дээр суурилдаг.

- Хүний болон иргэний тэгш түгээмэл эрхүүд
- Эрх зүйт төрт ёс
- Улс төрийн засаглал үндсэн хуулийн дагуу тогтсон байх
- Олонхын зарчмаар зохион байгуулагдсан ард түмний бие даасан байдал

Хэдийгээр дээрх хэм хэмжээнүүд дэлхий дахины практикт байнга маргаан дагуулж байдаг боловч олон нийтийн хууль ёсны эсэх тухай мэтгэлцээнээс хүлээн зөвшөөрөгдсөн байдаг. Либерализм нь ялангуяа марксизм-ленинизм нуран унаснаас хойших шинэ цаг үед олноо хүлээн зөвшөөрөгдсөн, батлагдсан, түгээмэл улс төрийн ноёрхлын тухай хууль ёсны цорын ганц сургаал юм.

Либерализм нь сонгодог утгаараа байх тэр түүхэн цаг үеэсээ, тухайлбал Жон Локын (1623 - 1704) үеэс эрх чөлөөний тэгш байдал, түүнийг хамгаалах хүний эрхүүдийн тухай ойлголт дээр суурилсаар иржээ. Орчин үеийн төр үүсэн байгуулагдсан цагаас либерализм иргэдийн эрхийг тэгш хангах шаардлагыг үндсэн хуулиар баталгаажуулжээ. Үндсэн хуулийн өмнө бүх иргэн тэгш эрхтэй бөгөөд эдгээр эрхүүд нь эцсийн бүлэгт төрийн ноёрхлын утга, зорилго, хил хязгаарыг тогтоож өгдөг. Улс төрийн либерализмын үзэл санаа нь бүх хүнийг хүний ёсоор тэгш хүндлэн дээдлэх, (хувийн автономийн тэгш байдал) ба бүх шийдвэр гаргалтад тэдний эрхийн тэгш байдлыг хангах (улс төрийн автономийн тэгш байдал)-ыг шаарддаг.

Локе үндсэн хуульт төрийн зэрэгцээ хувийн өмч ба зах зээлийн эдийн засгийг үндсэн эрхүүдийг хангах баталгаа хэмээн үзэж байлаа. Сонгодог либерализмын үзлийг баримтлагсад Локе, нэн ялангуяа Адам Смит (1723 - 1790) нараас бусад нь нэг нь зарчмын, нөгөө нь арга хэрэгслийн хоёр гол үндэслэлүүдийг гарган тавьсан байна: **Зарчмын үндэслэл** нь зөвхөн өмчлөх эрх чөлөө ба цэвэр өөрийн голдирлоороо хөгжих зах зээл нь дангаараа эдийн засгийн хүрээнд үйл ажиллагаа явуулах эрх чөлөөг баталгаажуулж өгдөг ба хүн тус бүрийн үйл ажиллагааг гаднын аливаа хязгаарлалтуудаас хамааралгүй, чөлөөтэй байх нөхцөлийг бүрдүүлдэг гэж үздэг. **Арга хэрэгслийн үндэслэл** нь зөвхөн өмчлөх эрх чөлөө ба өөрийн голдирлоороо хөгжих зах зээл хэмээх либерал эдийн засгийн суурь хоёр байгууллагууд нь нийгмийг нийтийн сайн сайхан амьдралыг хангах зорилтод хамгийн ихээр ойртуулж нийгмийг хамгийн хямд өртөг бүхий төрийн ба нийгмийн үйлчилгээгээр хангах боломжийг бүрдүүлнэ гэж баталдаг.

Хорьдугаар зууны эхэн үеийг хүртэл либерал улс төрийн намуудын гол төлөөлөгчид, онолчид хувийн болон улс төрийн автономийн тэгш байдлыг хангах зарчмаас урган гарах

нийгмийн болон улс төрийн бүхий л үр дагавруудыг өмчийг хамгаалах сонирхолдоо хөтлөгдөн бүрхэг хэвээр орхигдуулах оролдлогыг хийж маш олон нотолгоо, үндэслэлийг дэвшүүлж байжээ. Өмчийг ийнхүү «маш радикал» хэлбэрээр хамгаалж ирсэн нь удаан хугацааны туршид улс төрийн автономит эрхүүдийг хязгаарлаж байжээ.

Либерализмын дээрх хоёр шийдэгдээгүй асуудлууд дээр нийгмийн ардчиллын онол суурилдаг. **Нэгдүгээрт:** тэгш байдлыг хангах зарчмыг хэрэгжүүлэх эрх зүйн шаардлагыг нийгмийн ерөнхий зарчмуудад ямар төвшинд тусгах бололцоотой бэ? **Хоёрдугаарт:** Хүн бүрт тэгш эрх чөлөөг эдлүүлэх зарчмыг бодит үнэн болгохын тулд нийгмийн бодит байдалд ямар нөхцөлүүд хангагдсан байх шаардлагатай бэ?

Эдгээр асуултуудад өгч буй хоорондоо зөрчилтэй өөр өөр хариултууд нь либерал ардчилал либертар ба нийгмийн чиглэлд хуваагдах шалтгаан нь болдог. Либертар ардчилал нь хувийн өмчтэй байх эрхийг эрх чөлөөтэй байх үндсэн эрхтэй эн тэнцүү ач холбогдолтой гэж үздэг. Нийгмийн ардчилал нь хувь хүн бүрд чөлөөтэй үйл ажиллагаа явуулах боломжийг нь олгодог төрийн болон нийгмийн үйлчилгээнээс тэгш хувь хүртэх үндсэн эрх нь хангагдсан нөхцөлд хүссэнээрээ үйл ажиллагаа явуулах эрх чөлөөгөө бодитойгоор эдлэх, бие даан амьдралаа төлөвлөх боломж бүрдэнэ гэж үздэг. Либертар ардчиллын үзэл баримтлал нь эрх чөлөөг баталгаажуулдаг үндсэн эрхүүдийг хэлбэр төдий хэрэгжүүлэх эрх зүйн шаардлагыг тавьснаар сэтгэл ханадаг бол нийгмийн ардчилал нь бүх хүмүүс үндсэн эрхүүдээ хангуулах эрхийг эдлэх ёстой гэж үздэг.

Үндсэн эрхүүдийг хэлбэр төдий хангах шаардлага нь хувь хүнд эрх чөлөөгөө эдлэх боломжийг нээж өгөх хамгаалагдсан эрх зүйн орчинг бий болгосноор хязгаарлагддаг бол үндсэн эрхүүдийн бодит нөлөөлөл нь эрх чөлөөгөө бодитоор

үйл ажиллагааны боломж болгон ашиглахад шаардагдах хэмжээний хувийн болон нийгмийн баялагтай байхыг шаарддаг.

Либерализмын гол дутагдалтай тал нь эрх чөлөө ба өмчийн хоорондын харьцааг бүрэн тайлбарлаж чадаагүйд оршино.

Локе өөрийн либерализмын тухай онолоо туйлын гэж хэлж болохоор өмчлөх хязгааргүй эрх дээр суурилсан байдаг. Чухам энд тэгш эрх чөлөөний норм зөрчигдөх эх суурь тавигддаг. Локе өмчийн тухай ойлголтдоо дараах гурван харилцааг тодорхойлсон: **Нэгдүгээрт:** Өөрөө өөртөө эзэн байх эрх чөлөө (Өөрийн хүссэнээр үйл ажиллагаа явуулах эрх чөлөө ба хувийн автономи), **Хоёрдугаарт:** Өөрийн санаа бодол, итгэл үнэмшилтэй байх эрх чөлөө (Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, шашин шүтэх, танин мэдэх эрх чөлөө), **Гуравдугаарт:** эрхийн дагуу өөрт хамаарах эд юмсыг эзэмших эрх чөлөө.

Эхний хоёр эрх чөлөөний ойлголт нь зөвхөн нэг хүний буюу хувь хүний эрх чөлөөний тухай асуудал бол гуравдугаарт нэрлэсэн эзэмших эрх чөлөөгөө эдлэхдээ эзэмшигч эдийн засаг, нийгмийн салбарт бусдын эрх чөлөөний хэрэгжилтийг хангах ёстой болдог. Тийм ч учраас эрх чөлөөт төр хууль ёсныхоо эрхийн дагуу иргэдийнхээ өмчид жишээ нь: Татварын хэлбэрээр нийтийн эрх чөлөөг хангахын тулд шаардлага тавих эрхтэй. Үүнээс гадна хувьдаа үйлдвэрлэлийн хэрэгслийг өмчлөгч нь өмчийнхөө хэрэглээнд ихэнх тохиолдолд бусдын хүч хөдөлмөрийг ашиглах шаардлагатай болдог. Өмчлөх эрхийн гуравдагч цар хүрээ өмч эзэмшигчид, эд зүйлс, өөрийн өмчгүй ажиллагсад ба төр хоорондын харилцаанд оршдог. Энэ тохиолдолд өмчгүй хүмүүсийн эрх чөлөөг хангах асуудал хөндөгдөж байдаг учраас өмчийг ашиглах эрхийн зарчмын хувьд хууль ёсны мөн эсэх асуудал гарч ирдэг.

Либерал онол нь хэн нэгэн хувийн өмчгүй этгээд өөрийн

амьжиргааны эх үүсвэрээ олохын тулд өөрийн эрх чөлөөг тодорхой хугацаанд өөр хэн нэгэнд буюу өмчтэй этгээдэд хязгаарлуулах асуудал үүсдэгийг анхаарлын гадна орхидог. Хувийн өмчгүй этгээдүүд өөрсдийн эрх чөлөөний боломжуудаа эдэлж чадах эсэх нь өмчлөгчдөөс хамааралтай болдог буюу өөрөөр хэлбэл тэдний эрхшээлд ордог. Энэ нь өмчлөх

Нийгмийн ардчиллын онол нь либерализмын энэ зөрчлийг хувийн өмчтэй байх эрхийг оролцогч бүх талуудын эрх чөлөөг тэгш хангах шаардлагаар хязгаарлаж өгснөөр шийдвэрлэдэг.

хязгааргүй эрх нь тэгш эрх чөлөөгөөр хангагдах үндсэн эрхтэй зөрчилддөг гэдгийг харуулж байна.

2.2 Либертар ардчиллын дутагдалтай талууд

Орчин үеийн либертаризмын 20-р зууны гол төлөөлөгчид нь Фридрих фон Хайек, Роберт Нозик нар юм. Тэд хөтөлбөртөө өмчлөх либерал, хязгаарлашгүй эрхийг эрх чөлөөг хангах үндсэн нөхцөл гэж үзсэн ба үүнээс улбаатай орчин үеийн эдийн засаг, нийгмийн томоохон зөрчлүүдийг анхаарлын гадна орхисон байдаг. Тэдний хөтөлбөр Локийн өмчийн хөтөлбөрийг үзэл суртлын хувьд бэхжүүлж өгчээ. Энэ нь өмчлөгч өөрт хамаарах эд зүйлсээ хэрэглэх ердийн хэрэглээг бусдад эрх чөлөөг эдлүүлэх чухал харьцаа хэмээн авч үзсэнээр батлагдаж байгаа юм. Өмчийн харилцааны бусад харьцуулалтад төдийлөн ач холбогдол өгөөгүй, эсвэл бүрэн орхигдуулсан байдаг. Тэгэхээр либертаризм нь эрх чөлөөний тухай ойлголтыг түгээмэл эрхүүдийн эрх зүйн формаль төвшинд хязгаарладаг. Либертар ардчиллын онол нь эрх чөлөөг зөвхөн сөрөг эрх чөлөөний хүрээнд авч үздэг. Уг онол эрх чөлөөний тухай ойлголт, төрийн зүгээс хамгийн багаар эдийн засагт оролцох оролцоог хангах байгууллагууд, эдийн засгийн бүх төрлийн таваарын хэлбэрээр байж болох аливаа хариуцлагаас ангид хувийн өмч ба өөрийн голдирлоороо зохицуулагдах чөлөөт зах зээлүүдийг хоорондоо салшгүй холбоотой гэж

үздэг. Либертаризм хүмүүс хоорондын харилцааг ч зах зээлийн процессоор өргөн хүрээнд зохицуулахыг оролддог. Төр бол зөвхөн улс төрийн байгууллыг хамгаалах үүрэгтэй.

Сонгодог либерализмын болон зарим либертар онолчид нийгмийн гүнзгий хямралуудын дарамтын улмаас нийгмийн баримжаат төрт ёс болон зах зээлийн зохицуулалтын зарим элементүүдийг хүлээн зөвшөөрөхөөс өөр аргагүй байдалд орсон юм. Гэхдээ тэд өөрсдийн үнэт зүйлс ба ардчиллын ойлголтдоо сонгодог либерализмын онолын ерөнхий зарчмуудад ямар ч буулт хийлгүйгээр үнэнч хэвээрээ үлдсэн юм. Дараах элементүүд нь либертар ардчиллыг тодорхойлдог.

Либертар онол нь ардчиллын болон эрх зүйн шаардлагыг улс төрийн үндсэн зарчмуудын хүрээнд хязгаарлаж өөрт хэлбэр төдий олгогдсон эрх чөлөөний боломжоо бодитоор ашиглаж чадах эсэхийг иргэдийн өөрсдийн чадварт (хөрөнгө чинээнд) даатган орхидог.

Либертар ардчиллын онцлог шинжүүд:

- Хэлбэр төдий буюу формаль эрх зүйт төрт ёс ба ардчилал
- Ардчиллын процессод оролцох иргэдийн оролцооны тэгш боломж хангагдаагүй.
- Хувь хүмүүсийн нийгмийн эрхүүдийг нийгмийн баримжаат төрийн зүгээс баталгаажуулаагүй.
- Макро эдийн засгийн зохицуулалтыг хүлээн зөвшөөрөх ухамсар бүрэн төлөвшөөгүй.
- Зах зээлийг эрх чөлөөг баталгаажуулах тэгш эрхт байгууллага гэж үздэг. (Улс төрийн эрх чөлөөг хангах байгууллагуудтай харьцуулахад)
- Үйлдвэрлэлийн хэрэгслүүдийг өмчлөх эрхэд ямар ч хязгаарлалт тавьдаггүй.
- Сөрөг эрх чөлөөний тухай ойлголтыг номлодог.
- Эдийн засаг болон нийгмийг ардчилах хөтөлбөрийг хүлээн зөвшөөрдөггүй.

2.3. Нийгмийн ардчиллын эрх зүйн шаардлага

Либерализмын зөрчлүүдийг шүүмжилсэн шүүмжлэлүүдээс нийгмийн ардчиллын үзэл баримтлал эх аван хөгжсөн түүхтэй. Нийгмийн ардчиллын онол нь дээрх зөрчлүүдийг практик дээр даван туулахад чиглэгдсэн нийгмийн төсөл юм. Нийгмийн ардчиллын онолч, ажилчны хөдөлгөөний удирдагч Фердинанд Лассалле 1864 онд өөрийн «Шинжлэх ухаан ба ажилчид» бүтээлдээ «Өмчийн болон тоног төхөөрөмжийн өмчлөлийн ялгаатай байдал нь хүмүүсийн нийгмийн тэгш бус байдлын үндэс мөн тул үүнээс ажилчдын байдлын ёс суртахууны санаа улбаатай» гэдэг нийгмийн ардчиллын гол үзэл санааг дэвшүүлжээ.

«Хувь хүн өөрийн хүчийг өөрийн зоргоор өөрийн тусын тулд дайчлаад тэр нь өөрийнх нь амьжиргаанд хүрэлцэхгүй байгаа нөхцөлд ёс заншлын тодорхой дүрэм журамд захирагддаг эв нэгдэлтэй, хамтдаа хүчээ нэгтгэж хамтдаа хөгжих ёс зүйн хувьд түүнд ойр хүмүүсийн нэгдэлд зайлшгүй хамаарагдах ёстой болдог.»

Жон Ст.Милл болон с о ц и а л - л и б е р а л Фавианы нийгэмлэгийн бусад онолчид л и б е р а л и з м ы н дутагдалтай талуудыг нийгмийн шинэчлэлийн бодлого явуулах

үндэслэл болгон авсан байдаг. Нэн ялангуяа шүүмжлэгчид түгээмэл үндсэн эрхүүд зөрчигдөхөд хүргэдэг гурван зөрчлийг онцгойлон авч үзсэн байдаг. Эдгээр гурван зөрчил нь нийгмийн ардчиллын онол, практикийн үндэслэл юм:

Нэгдүгээрт: Нийгмийн болон эдийн засгийн тэгш бус байдал нь тодорхой төвшнөөс дээш гармагц нийгмийн болон эдийн засгийн үйл ажиллагааны талбарт бусдаас хамааралтай буюу бусдын эрхшээлд орох харилцааг буй болгож тэр нь үүнд хамрагдсан хүмүүсийн хувьд хүний ёсоор амьдрах, халдашгүй дархан байдал нь алдагдахад хүргэдэг. (**Нийгмийн автономит байдал зөрчигдөхөд хүргэдэг.**)

Хоёрдугаарт: Хэрэв хүмүүсийн автономит байдал нь бусад

этгээд хүний ёсоор ажиллах боломжгүй хөдөлмөрийн харилцаа буй болгосны улмаас зөрчигдсөн бол тэдгээр хүмүүсийн түгээмэл үндсэн эрх зөрчигдсөн гэж үзнэ. (**Харьяат иргэдийн автономит байх шаардлагыг зөрчсөн гэж үзнэ.**)

Гуравдугаарт: Нийгэм, эдийн засаг, боловсролын тэгш бус байдал нь иргэд харьяат иргэдийн хувиар тэдэнд олгогдсон улс төрийн эрхүүдээ эдлэхэд нь саад тотгор болдог. (**Улс төрийн автономит байдал зөрчигдөхөд хүрнэ.**)

Дээрх шалтгаануудын аль аль нь нийгмийн ардчилал, улс орнуудын туршлагаар нотлогдсон бодит байдал нь нэн юуны өмнө нийгэм - эдийн засгийн үйл ажиллагааны бүх талбарыг үндсэн эрхүүдийн хэрэгжилтийн хүрээнд хамруулан авч үзэх ёстой гэдгийг харуулж байна. Зөвхөн ингэсэн тохиолдолд улс төрийн болон нийгмийн үндсэн эрхүүд хэлбэр төдий бус бодит утгаараа нөлөөлөх, цаашид хөгжих нөхцөл бүрдэнэ.

Либертар ардчиллын зөрчлүүд нийгмийн ардчиллын үндсэн хоёр шаардлагад тусгалаа олсон байдаг:

1. Түгээмэл эрх чөлөөний тухай ойлголтыг дэмжин дэлгэрүүлэхийн тулд эерэг ба сөрөг эрх чөлөөний тухай ойлголтыг эн тэнцүү авч үзэхийг шаарддаг сөрөг эрх чөлөөний тухай ойлголтыг халах.
2. Түгээмэл эрх чөлөөний тухай ойлголтыг дэмжин дэлгэрүүлэхийн тулд өмчийн харилцаанд оролцогч талуудын эрх чөлөөг зарчмын хувьд адилтган үздэг өмч ба эрх чөлөөг адилтган үздэг үзлийг халах

2.4 Нийгмийн ардчиллын үндэс

Төрийнэрхзүйн онолч, улстөрсудлаач эрдэмтэн Херман Хеллер Ваймарийн Бүгд Найрамдах Улсын үед нийгмийн ардчиллын тухай өргөн хүрээтэй онолын үндсийг анхлан тавьсан байна. Тэр Марксист - Ленинист онолыг баримтлагч коммунизмын

төлөөлөгчидтэй харьцуулахад либерал ардчиллын улс төрийн үзэл санааг тууштай хамгаалагч байжээ. Тэр зөвхөн либерал ардчиллын онолын дагуу капиталист нийгмийг хууль ёсны дагуу амжилттай шинэчилж болно гэдэгт итгэж байсан юм. Тэр мөн нийгмийн болон эдийн засгийн тэгш бус байдлыг зөвхөн нийгмийн шинэчлэл хийх замаар гэтлэн давах боломжгүй гэдэгт итгэлтэй байсан юм. Орчин үеийн улс гүрнүүд зарим шийдвэрлэгдэшгүй зөрчилдөөнийг агуулсан хэвээр байна. Ардчилсан төр бүх нийтийн дэмжлэгийг хүлээхийн тулд либерал баримтлалыг нийгмийн ардчиллын чиглэлд хөгжүүлэх шаардлагатай байж болзошгүй юм. Материаллаг эрх зүйт төрт ёсны шаардлагууд болон капиталист зах зээлийн функцийн нөхцөлүүдийн хооронд зөрчил үүссэн тохиолдолд улс төрийн либерализм зөвхөн хэлбэр төдий эрх зүйт төрийг хамгаалж харин өөрийн түгээмэл, хууль ёсны байх шаардлагуудыг эн тэнцүү хэмжээнд хамгаалж чаддаггүй. Энэ сул тал нь либерал ардчиллыг үнэмшилгүй, тогтвортой бус болгодог. Ардчилсан эрх зүйт төрийн хууль ёсны байх шаардлагууд хэрэгжих ёстой л юм бол эрх чөлөө, тэгш байдал хөдөлмөрийн болон нийгмийн баялгийн хуваарилалтын журамд нэгэн адил хэрэгжих ёстой гэдэг ухамсар төлөвших болно.

«**Материаллаг эрх зүйт төр**» гэдэг ойлголт Хеллерийн онолоор дараах 2 хүчин зүйлийг агуулж байдаг. **Нэгдүгээрт:** Ард түмний засан тохинуулах эрх чөлөөг хуулиар тогтооно. **Хоёрдугаарт:** тэгш байдлыг хангана гэдэг нь ашиг сонирхлыг эн тэнцүү харгалзан үзнэ гэсэн үг. Материаллаг эрх зүйт төрт ёсны тухай ойлголт нь бүх төрлийн ашиг сонирхлыг улс төрийн бүхий л шийдвэр гаргалтад эн тэнцүү үнэлэмжтэйгээр харгалзан үзэх шударга ёсны нэгэн хэлбэр юм.

Улс төрийн либерализмын тухай Хеллерийн онол, практикийн гол дутагдалтай тал нь бодит байдлын зөвхөн нэгээхэн хэсгийг тусгасанд оршино. Либерализм хүний болон иргэний

эрхүүдийг тэгш хэрэгжүүлэх нөхцөлүүдийг системтэйгээр бүхэлд нь тойрдог тул Хеллер тэдгээрийн онолын нотолгоог гаргаж, практикт хэрэгжүүлэх саналуудыг дэвшүүлж чадаагүй юм. Зөвхөн нийгэм - эдийн засгийн бодит байдал нь түгээмэл үндсэн эрхүүдийн хэрэгжилтийн үндсэн хэм хэмжээнд тусгалаа олсон нөхцөлд л улс төрийн нэгдэл бий болох боломжтой юм. Үүний тулд бүх нийтийн ашиг сонирхлыг эн тэнцүү хэмжээнд харгалзан үзэх хэмжээний харилцан буултыг нийгмийн ангиуд хооронд хийх шаардлага тулгарч байгаа юм.

Нийгмийн ардчиллын ойлголтод Хеллерээс дараах дөрвөн бүрэлдэхүүн хэсгийг авсан:

1. Шийдвэр гаргалтын процесс ардчилсан байх
2. Ардчилсан шийдвэр гаргах процессоос гарах үр дүнд ардчиллын цар хүрээг хадгалах ба өргөжүүлэх
3. Нийгэмд хүлээн зөвшөөрөгдсөн шударга ёсны хэм хэмжээний дагуу нийгмийн үндсэн зарчмуудыг тогтоох
4. Нийгмийн ашиг сонирхлын харилцан буулт ба зөвшилцлийг шударга ёсны дагуу тогтоодог улс төрийн соёлыг бий болгох

Либерал ардчиллын нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн үйл ажиллагааны цар хүрээг хадгалж байх нь нийгмийн бүх үйл явцад оролцогч тус бүрийн ашиг сонирхлыг хамгийн сайн хангах нөхцөлийг бүрдүүлдэг.

Хеллерийн онолоор ардчилсан эрх зүйт төр нь зарчмын хувьд нийгэм нь өөртөө улс төрийн замаар нөлөөлөх боломжтой. Иргэн төвтэй төрийн зарчмыг хэрэгжүүлэхийн тулд иргэд нь зөвхөн эрх зүйн хувьд хэлбэр төдий улс төрийн хамтын нийгэмлэгт хамаараад зогсохгүй үйл ажиллагааны чадамжтай буюу үйл ажиллагаанд нь оролцох боломжтой байх ёстой. Хеллер бүх иргэдийг төрт улсын эрх тэгш харьяат иргэд байлгахын тулд ямар нөхцөлүүд хангагдсан байх ёстой бэ? гэдэг асуудлыг дэвшүүлсэн.

Хеллерийн нийгмийн ардчиллын онолын дагуу бүх оролцогчид нь улс төрийн төвшинд шударгаар сонирхлоо нэгтгэх хүсэл сонирхолтой байх нөхцөлд л зах зээлийн капиталист ерөнхий зарчим үйлчилдэг нийгэмд төрийн бодлогын нэгдэлд хүрэх боломжтой ажээ. Хеллер гишүүд нь ашиг сонирхлоо нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн шударга ёсны төсөөллийн дагуу тэнцэтгэж чаддаггүй нийгэм сууриараа ганхахад хүрнэ гэдэг төрийн бодлогын үндсэн нотолгоог дэвшүүлсэн.

Тэрбээр шударга ёсыг дээдэлсэн нийгмийн соёлын хөгжлийн дөрвөн өөр үе шатыг тодорхойлсон:

Нэгдүгээрт: капиталист зах зээлийн эдийн засагтай нийгэмд «шударгаар тоглох» хүсэл эрмэлзэл байх ёстой. **Хоёрдугаарт:** Үүний өмнө бүх нийтэд хүлээн зөвшөөрөгдөхүйц нэгдэл улс төрийн процессод явагдсан байх. **Гуравдугаарт:** Нийгэм-эдийн засгийн байгууллауудыг материаллаг эрх зүйт төрийн шалгууруудын дагуу өөрчлөн байгуулах шаардлагатай. Энэ нь нийгмийн баримжаат төрийн болон ардчилсан эдийн засгийн бүтцүүдийг бий болгоно гэсэн үг юм. Дээрх үе шатуудыг хэрэгжүүлсний дараа **дөрөвдүгээрт** төрт улсын бүх харьяат иргэдэд нийгмийн ашиг сонирхлын зөрчлийг шударгаар зохицуулах боломжтой гэдэг итгэл үнэмшил бий болдог.

Хеллерийн онол нь улс төрийн өөрөө засан тохинуулах процессод эрх чөлөөний болон тэгш байдлын ёс зүйн хэм хэмжээг үндэслэлээ болгодог нийгмийн тухай онол юм. Зөвхөн дээрх хэм хэмжээнүүдийг нийгмийн ерөнхий зарчмуудад тусгасан тохиолдолд либерал ардчилал нийгмийн ардчилалд шилжиж хууль ёсных хэмээн хүлээн зөвшөөрөгдөх боломжтой болдог.

Нийгмийн ардчилал бол зөвхөн улс төрийн хүрээ төдийгүй нийгмийн бүхий л хүрээ нь ухаалгаар тодорхойлогдсон

шударга ёсны зарчмуудаар тодорхойлогддог нийгмийн тухай ойлголт юм.

Хеллерийн онолоор материаллаг байдлын хувьд шардрга хуваарилалттай нийгмийн ерөнхий зарчим нь гурван үндсэн тулгуур багана дээр оршин тогтнодог: Эдгээр нь хөдөлмөрийн шардрга журам, нийгмийн баялгийн шардрга хуваарилалтын журам, өргөн хүрээтэй нийгмийн хамгааллын бодлого юм. Дээрх журмуудыг ямар бүтцүүд хэрэгжүүлэх бэ? гэдгийг Хеллер тодорхойлоогүй, нээлттэй орхисон байна. Хеллер зөвхөн ажилтнууд хөдөлмөр зохион байгуулалтын тухай шийдвэр гаргалтад саналаа хэлэх эрхтэй байх ёстой, өмчлөх эрхийг хязгаарлах ёстой, олон улсын төвшинд хүлээн зөвшөөрөгдөх нийгмийн бодлогыг хэрэгжүүлэх ёстой гэж тодорхойлжээ.

Ардчилсан эрх зүйт төрөөс нийгмийн ерөнхий зарчмуудыг шардргаар тогтоохдоо эдийн засгийн өөрийн хууль ёсны дагуу хөгжих эрхийг хангаж өгөх ёстой. Хеллер төрийн оролцооны хязгаарлалтыг хуучин Зөвлөлт Холбоот Улсын төрийн төвлөрсөн зохицуулалт ба төлөвлөлтийн бодлогын туршлагын нөлөөн дор тогтоож бүхнийг төрд даатгах үзлээс татгалзахыг зөвлөсөн байдаг. Тэрээр «Эрх зүйт төр хөдөлмөрийн болон нийгмийн баялгийн хуваарилалтын журамд аль хэр гүнзгий хутгалдана, дараа нь өмчийн өөрөө удирдах зарчмыг дэмжихийн тулд тэр хэмжээгээр төрийн оролцоог бууруулах, өмчийг хувьчлах шаардлагатай болдог» гэсэн ерөнхий зарчмыг дэвшүүлсэн. Түүний бодлоор ямар ч тохиолдолд иргэдийн эрхийг хамгаалах бүтцийг бий болгох нь тэдний ашиг сонирхлоо хамгаалах идэвхийг сэргээдэг байна.

Нийгмийг ардчилах

Нийгмийн ардчилал нь шардрга ёсыг нийгмийн ерөнхий зарчмуудаар дамжуулан хэрэгжүүлэх үзэл баримтлал гэдэг утгаараа Хеллерийн хөтөлбөр нь юуны өмнө нийгмийг

ардчилах хөтөлбөр юм. Нийгмийг бүхэлд нь ардчилах тухай хөтөлбөр нь дараах хоёр асуудал дээр суурилдаг:

Нэгдүгээрт макро төвшинд: Шударга ёсны хэм хэмжээнүүд нь төрийн оролцоогоор дамжуулан бүх иргэдийн хүний ёсоор ажиллаж амьдрах, эрхүүдийн тэгш байдлыг хамгаалахыг шаардаж байдаг.

Хоёрдугаарт микро төвшинд: Шударга ёсны хэм хэмжээнүүд, шударга ёсны агуулга нь аливаа шийдвэрээр эрх ашиг нь хөндөгдөж буй хамрагдагсдын ухаалаг зөвшилцлийн үр дүнгээр тодорхойлогдож байх нөхцөлийг бүрдүүлэхийн тулд нийгмийн бүхий л дэд салбаруудад шударга бүтцийг бүрдүүлэхийг шаардаж байдаг.

Нийгмийн ардчиллын онолын энэхүү төсөл нь Херман Хеллерийн онолын санааг судалж нягтлан төгөлдөржүүлэх, түүнээс хойш өрнөсөн шинжлэх ухааны маргаан, мэтгэлцээнүүдийн үр дүнгээр баяжуулан шинэчлэх зорилгыг агуулж байгаа юм.

Гажуудалтай ардчилал

Орчин үеийн улс орнуудын туршлага дээр суурилсан ардчилал судлалд гажуудалтай ардчилал гэдэг ойлголтын сайн нотолгоо бүхий онолын ач холбогдол улам бүр нэмэгдсээр байна. Тэрээр гажуудалтай ардчиллын тухай ойлголтыг ардчиллын зохион байгуулалтын зарим элементүүд нь хэлбэр төдий хэвшсэн, бусад чухал элементүүд нь (бүх нийтээрээ сонгох, сонгогдох тэгш эрх гэх мэт) орхигдсон улс төрийн системүүдийн жишээн дээр тайлбарласан байна.

Хеллер либерал ардчиллаас нийгмийн ардчилалд шилжих шилжилт нь бүрэн явагдаж дуусаагүй ардчиллыг гажуудалтай ардчилал гэнэ хэмээн тодорхойлсон байна. Хеллер нийгмийн ерөнхий зарчмууд нь шударга ёсны материаллаг болон эрх

зүйт төрийн хэм хэмжээгээр тодорхойлогдоогүй хэлбэр төдий ардчиллыг гажуудалтай, тогтворгүй байдаг гэжээ. Түүний амьдарч байсан эрин үеийн туршлага нь түүнд дээрх хэв шинжүүдийг агуулсан ардчилал эзэрхэг ноёрхуу нийгэмд эргэн орох эрсдэлийг агуулж байдгийг сургажээ.

Нийгмээрээ шударга хэмээн хүлээн зөвшөөрсөн, шударга ёсны зарчмууд дээр суурилсан эдийн засаг-нийгмийн байгууллауд нь ардчилсан эрх зүйт төрийн тогтвортой байдлын үндэс мөн хэмээн Хеллер үзэж байлаа. Дээрх нөхцөлүүдийг хүлээн зөвшөөрөхгүй байх нь улс төрийн хямралд хүргэж болзошгүй тул эрх мэдэл бүхий нийгмийн анги ч шударга ёсыг дээдэлсэн бодлогыг хүлээн зөвшөөрөх ёстой гэж үздэг байжээ.

2.5 Иргэдийн нийгмийн эрхүүд

Либерализмын тухай улс төрийн онолд Жон Локе, Томас Пайне нарын үеэс улс төрийн ноёрхол нь нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн, хүчин төгөлдөр байх эрх зүйн шаардлагын дагуу хуульчлагдсан байхын тулд тодорхой нөхцөлүүдийг хангасан байх ёстой гэж үзсээр ирсэн. Үүний хамгийн гол шалгуур нь иргэд улс төрийн ноёрхлын үндэс суурь болсон нийгмийн ерөнхий гэрээний түнш, хувь хүртэгсдийн хувьд тэдний улс төрийн тэгш байдал хангагдсан байх явдал. «Citizenship» буюу иргэншил нь иргэдийн хууль ёсны, үүрэг хариуцлагын статус бөгөөд тэд бусад иргэдтэй тэгш эрхтэйгээр улс төрийн нийтээрээ дагаж мөрдөх дүрэм, журмуудыг хамтран тогтоож нийтийн шийдвэр гаргалтад тэгш эрхтэйгээр оролцох иргэн бүрийн эрхийн тухай ойлголт юм.

Иргэний эрхүүд ба нийгмийн ангиуд

Иргэдийн статусыг тодорхойлох «citizenship» буюу иргэншил нь иргэдийн үндсэн эрхүүдийг хэлбэр төдий хангах болон тэдгээрийг бодитоор хэрэгжүүлэх үйл явц хоёрын хоорондын зөрчлийг хамгийн оновчтой тодорхойлж шийдвэрлэх

боломжийг бүрдүүлдэг ойлголт юм. 1947 онд Томас Х. Маршал түүнийг алдрын замд хөтөлсөн «Харьяат иргэдийн эрхүүд ба нийгмийн ангиуд» сэдэвт илтгэлдээ иргэдийн статусын төрөл бүрийн цар хүрээг системчлэн тайлбарлаж 18-р зууны үеэс хүний болон иргэдийн эрхийн хөгжлийн түүхийг тодорхойлжээ. Бүх иргэд нийгмийн эрхээ хэрэгжүүлэх хэрэгсэлгүй байх нөхцөлд эдгээр эрхүүдийн хөгжилд үргэлж саад бэрхшээл учирч байсан түүхтэй аж. Эдгээр бэрхшээлүүдийг олноороо судлан таньж, зайлуулж чадсан нөхцөлд иргэдийн улс төрийн эрхүүд нийгмийн эрхүүд болон хөгжсөөр иржээ. Иргэний эрхүүдийн түгээмэл байдал нь эдгээр эрхийн хэрэгжүүлэлтэд учирч буй саад бэрхшээлүүдийг танин тогтоож, арилгах улс төрийн процессын хөдөлгөгч хүч мөн. Уг процессын зорилго нь хүн бүрийг өөрсдийн амьдралын практикт үндсэн эрхүүдээ хэрэгжүүлэх нийгмийн нөхцөлүүдээр хангах, улмаар үндсэн эрхүүдийн хэлбэр төдий хэрэгжилт нь бодит нөлөөллөөр улам бүр солигдох нөхцөлүүдийг бүрдүүлж чадах нийгмийн харилцааг бэхжүүлэхэд оршино.

Маршалын төгс, түгээмэл иргэдийн статусын цар хүрээний тухай онол нь түгээмэл үндсэн эрхүүдийн тухай анхдагч либерал ойлголт болон өдгөө хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Нэгдсэн Үндэстний Байгууллагаас 1966 онд батлан гаргасан хүний эрхийн түгээмэл тунхаглалаар тунхаглагдсан ард түмний эрхийн хоорондын гүүр нь болж байна.

Нийгмийн баталгаат байдал, иргэдийнхээ сайн сайхныг эрхэмлэгч төрийг байгуулснаар өрсөлдөөнд тулгуурласан эдийн засагт нийгмийн тэгш байдлыг хангах доод төвшинг тогтоож өгөх замаар бүх хүнд эрх чөлөөгөө эдлэх боломжийг бүрдүүлсэн. Нийгэм - эдийн засгийн статусын тэгш бус байдлыг иргэдийн нийгмийн эрхүүдээр хязгаарлаж, харьцуулж байх ёстой. Иймээс Маршал:

«Эдийн засгийн болон баталгаатай байдлын доод хэм хэмжээгээр хангуулах эрх нь... нийгмийн өвөөс тэгш хувь хүртэх эрхээс тухайн цаг үед мөрдөгдөж буй стандартуудын төвшинд соёлт хүмүүний ёсоор амьдрах эрх хүртэл багтана»

гэж хэлсэн байдаг. Ингэснээр ангиуд хоорондын зөрчлийг шийдвэрлэх хэмжээнд хязгаарлах боломжтой.

Нийгмийн бодит нөхцөлүүдийн дунд иргэний болон улс төрийн эрхүүдийг хэрэгжүүлэх эрх зүйн шаардлагыг хадгалж хангаж байхын тулд үндсэн эрхүүдийн тухай ойлголтод нэгэн шинэ ойлголт болох нийгмийн (социал) үндсэн эрхүүдийн тухай ойлголтыг төлөвшүүлэх шаардлагатай болсон юм. Жишээлбэл: Иргэд хүмүүжлийн доголдолтойн улмаас (боловсрол муутай учраас) хүнд хэлэх юмаар маруухан, үг хэлэх эрхээ бусдын анхаарлыг татах хэрэгсэл болгон ашиглаж чадахгүй бол үг хэлэх эрх төдийлөн ач холбогдолгүй болно. Либерал үндсэн эрхүүдийг нийгэм, эдийн засгийн үндсэн эрхүүд буюу эерэг эрх чөлөөний шинэ эрхүүдээр баяжуулж өгөх нь хүн бүрийн үндсэн эрхүүд бодитоор хэрэгжих нөхцөлийг бүрдүүлдэг.

20-р зууны нийгмийн үндсэн эрхүүдийн хөгжил нь иргэдийн үндсэн эрхүүдэд тэдгээрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хэрэгслүүдийг эзэмших эрх нь багтаж байвал бүх хүн үндсэн эрхүүдээ эдлэх нөхцөл хангагдана хэмээн төрт улсын иргэд өөрсдөө ухамсарлахад хүргэсэн байна. Энэ алхам хийгдээгүй нөхцөлд үндсэн эрхүүдийг эдлэх хууль ёсны үндэс үгүй болох аюул нүүрлэдэг. Учир нь эдгээр эрхүүдийг эдлэх бодит боломж, бололцоо зөвхөн цөөн тооны хүмүүст байдаг. Марксист - Ленинист фундаменталист онолыг хамгаалагчид нийгмийн үндсэн эрхүүд хангагдсан байх нь улс төрийн эрхүүд хангагдах нөхцөлүүдийг бүрдүүлнэ гэж нотолдог бол Маршал харьяат иргэд либерал улс төрийн эрхүүдээ эдэлж байж нийгмийн эрхүүдээ хөгжүүлэх боломж нь бүрдэнэ гэдгийг нотолсон

байна. Учир нь нийгмийн эрхүүд нь үндсэн эрхүүдийн бие даасан бүлгүүд биш бөгөөд харин бүх иргэдийн иргэний болон улс төрийн эрхүүдийг хэрэгжүүлэх эрх зүйн шаардлагын баталгаа юм.

2.6 Түгээмэл үндсэн эрхүүд

Олон улсын хүний эрхийн харта

1966 онд НҮБ олон улсын эрх зүйд улс төрийн ба нийгмийн үндсэн эрхүүдийг эн тэнцүү адилтган үзэхэд шийдвэрлэх алхмыг хийсэн. Тэд олон улсын конвенцын 2 төслийг баталсан: Иргэний болон улс төрийн эрхийн олон улсын пакт (иргэний пакт), эдийн засаг, нийгэм болон соёлын эрхийн олон улсын пакт (нийгмийн пакт) хэмээх төслүүдийг баталжээ. Дээрх хоёр конвенцод 35 улс нэгдэн орсны дараагаар 1976 онд хүчин төгөлдөр болсон байна. Эдгээрийн 1948 онд батлагдан гарсан хүний эрхийн тайлбар бичгээс ялгаатай нь конвенцод нэгдэн орсон улсуудад заавал биелүүлэх үүрэг ногдуулдаг. Мөн эдгээр пактууд нь олон талт гэрээ хэлэлцээрийн эрх зүйн шинж чанарыг агуулж байгаа юм. Уг тайлбар нь үндсэн эрхүүдийг хүндэтгэн үзэх үүргийг олон улсын эрх зүйн дагуу ногдуулдаг.

Хүйтэн дайны үед улс төрийн болон нийгмийн эрхүүдийг хооронд нь сэргэлдүүлэн тавьдаг байжээ. Баруунд иргэний болон улс төрийн эрх чөлөөг тууштай хамгаалдаг бол зүүний улсууд эдийн засаг, нийгэм болон соёлын эрхүүдийг баталгаажуулахыг эрхэмлэдэг байжээ. Эрхэмлэх эрхүүдийн ялгаатай байдал нь хоёр тусдаа гэрээ хэлэлцээрийг байгуулахад хүргэжээ. «Зүүнд» сөрөг эрх чөлөөний эрхийг зөвшөөрдөг бол «баруун» -ны төлөөлөгчид эерэг эрх чөлөөний эрхийг хүлээн зөвшөөрдөг байлаа.

Энэ хооронд НҮБ-ын нийгмийн пактад дэлхийн 148 улс нэгдсэн бол 151 улс иргэний пактад нэгдсэн байна. Харин АНУ

өнөөг хүртэл нийгмийн пактад нэгдэхээс татгалзсаар байна. Жимми Картер 1979 онд уг пактад гарын үсэг зурсан боловч улс төр - үзэл суртлын шалтгаануудын улмаас Картерийн засаг захиргаа түүнийг баталгаажуулах эсэх эцсийн шийдвэрийг гаргах эрх бүхий Сенатаар хэлэлцүүлээгүй орхисон байна. Рональд Рейган, Жорж Буш нарын засгийн газрууд эдийн засаг-нийгмийн эрхүүдийг хүлээн зөвшөөрөх талаар төдийлөн хүчин зүтгэл гаргаагүй юм. Тэд эдгээр эрхүүдийг биелүүлэх хэрэгтэй нийгмийн зорилтууд (**merely desirable social goals**) гэж үздэг учраас заавал биелүүлэх гэрээ хэлэлцээрүүдийн агуулга болгон авч үзэх шаардлагагүй гэж үздэг. Клинтонь засгийн газар дээрх эрхүүдийг үндсэндээ хүлээн зөвшөөрсөн боловч энэ зарчмын асуудлуудаар бүгд найрамдахчуудтай конгресст тэмцэлдэх шаардлагагүй гэж үзсэн байна.

Үндсэн эрхүүдийн эн тэнцүү ач холбогдол ба тэдгээрийн норматив үүсэл

НҮБ нь үндсэн эрхүүдийн дараах үндсэн хоёр зарчим дээр нэгдсэн байна:

Нэгдүгээрт иргэний, улс төрийн, соёлын, нийгмийн болон эдийн засгийн эрхүүд зарчмын хувьд эн тэнцүү ач холбогдолтой гэсэн нэгдүгээр үндсэн зарчим. Эдийн засгийн болон нийгмийн эрхүүдийг тухайн улс орны эдийн засгийн чадамжийн хэрээр хэрэгжүүлнэ.

Хоёрдугаарт үндсэн эрхүүд нь соёлын, шашны болон ертөнцийг үзэх үзлийн хувьд төвийг сахисан байна гэсэн хоёрдугаар үндсэн зарчим юм. Энэ зарчмын дагуу үндсэн эрхүүд даяаршлын хүрээнд хангагдах ёстой бөгөөд тэдгээрийн хэрэгжилтийг улс орон бүр ижил хэмжээнд батлах шаардлагагүй, хэрэв батлах шаардлагатай гэж үзвэл. Үндсэн эрхүүдийн хэрэгжилт түгээмэл бөгөөд тухайн орны соёлын уламжлалаас хамаарахгүй.

Нийгмийн ардчиллын онол нь бүхий л чухал асуудлуудад 1966 онд НҮБ-аас батлан гаргасан хүний эрхийн пакт дээр тулгуурлан хариулт өгдөг. Иймээс уг онол өөрийн норматив үндэслэлд философийн тусгай нотолгоо, тухайлбал шударга ёсны түгээмэл онолын хэлбэрээр гаргах шаардлагагүй юм.

Гэсэн хэдий ч НҮБ-ын үндсэн эрхүүдийн тунхаглалуудаар хуульчлагдсан иргэдийн либерал ба нийгмийн

эрхүүд, тэдгээрийн түгээмэл хэрэгжих эрх зүйн шаардлагыг нормативын хувьд нотлох боломжтой. Тэдгээрийн нотолгоо нь өнөөгийн даяаршлын эрин үед соёлын нэгэн судлагдахуун болсон байна. Эдгээр нотолгоонууд нь соён гэгээрлийн уламжлал болон түүн дээр суурилсан практик философи дээр, мөн шашны болон ертөнцийг үзэх үзлийн олон талт уламжлал дээр суурилах боломжтой. Ямар түүхэн эх сурвалжтай бэ? гэдэг нь үндсэн эрхүүдийн нийгэмд болон практикт хүчин төгөлдөр байх шаардлага дээр юуг ч өөрчлөхгүй. Иймээс нийгмийн ардчиллын онолд тусгай нотолгоо шаардлагагүй бөгөөд байх ч ёсгүй юм. Үндсэн эрхүүдийн пактууд нь хэдийгээр маш олон төрлийн сэтгэлгээний болон нотолгооны арга хэлбэрүүд байдаг боловч хүний болон иргэдийн үндсэн эрхүүдийн тухай ойлголт дээр нэгдсэн ойлголтод хүрэх боломжтой гэдгийг практик дээр баталж байгаа юм. Зөвхөн энэ практик нотолгоо нь дангаараа үндсэн эрхүүд хүмүүсийн нийгмийн болон улс төрийн амьдралын харилцааг бүрдүүлэхэд ямар үүрэг, ач холбогдолтойг бэлхнээ харуулж байна.

Эдийн засаг, нийгэм, соёлын эрхүүдийн тухай олон улсын пакт

Эдийн засаг, нийгэм соёлын эрхүүдийн тухай олон улсын пакт нь хоорондоо асар зөрүүтэй материаллаг эрх чөлөөний тухай ойлголт дээр суурилдаг. Уг пакт нь хүний болон иргэдийн түгээмэл эрхийг хангахын тулд дэлхийн бүх улс орнууд нийгэм, эдийн засгийн ямар нөхцөлүүдийг хангасан байх ёстой бэ? гэдгийг тодорхой, дэлгэрэнгүй, нарийвчилсан хэлбэрүүдээр

тодорхойлж өгдөг. Хэм хэмжээ тус бүрийг хамааруулж болох эрхэм зорилгыг «Аймшиг, зовлонгоос ангид эрх чөлөөт иргэдтэй байх» гэж тодорхойлсон. Уг пакт бүлэг тус бүрдээ дараах эрхүүдийг онцлон нэрлэсэн байна:

1966 оны НҮБ-ын пактад заасан нийгмийн үндсэн эрхүүд:

- Эрэгтэй, эмэгтэйчүүдийн тэгш эрх
- Хөдөлмөрлөх эрх
- Хөдөлмөрлөх шударга, зохистой нөхцөлөөр хангагдах эрх
- Өөрийн амьжиргааны эх үүсвэрийг чөлөөт сонголтоор сонгосон эсхүл хүлээн зөвшөөрсөн хөдөлмөрөөрөө бүрдүүлэх эрх
- Шударга цалин, Ижил хөдөлмөрт ижил цалин олгох зарчим
- Амьжиргааны хангалттай эх үүсвэртэй байх
- Аюулгүй, эрүүл хөдөлмөрлөх нөхцөлөөр хангуулах
- Үйлдвэрчний эвлэлд эвлэлдэн нэгдэх эрх, үйлдвэрчний эвлэлийн үйл ажиллагааны эрх чөлөө
- Ажил хаях эрх
- Нийгмийн баталгаат байдал
- Амьдралын зохистой стандартыг баталгаажуулах
- Өлсгөлөнгөөс ангид байх
- Бие бялдрын болон сэтгэл санааны эрүүл мэндийг дээд хэмжээгээр хангуулах, шаардлагатай тохиолдолд эмнэлгийн үйлчилгээг авах эрх
- Сурч боловсрох эрх, хувь хүнийг дээд зэргээр хөгжүүлэх зорилго бүхий хүний эрх, үндсэн эрх чөлөөг дээдэлсэн үзлээр хүмүүжих эрх
- Үндсэн буюу бүрэн дунд боловсролын сургалтад заавал хамрагдах үүрэг ба хувь хүмүүсийн чадварт тохирсон дээд шатны сургууль, дээд боловсролын сургалтад хамрагдах эрх
- Соёлын эрх

Эдгээр эрхүүд нь бүхэлдээ нийгмийн ардчиллын бодлогод ихээхэн үүрэг хариуцлагыг ногдуулдаг бөгөөд үндсэн цар хүрээнд бүх хүнийг нийгэм, эдийн засгийн гарааны ижил нөхцөлүүдээр хангах үүргийг ногдуулдаг:

- Хөдөлмөр эрхлэх боломжийг олгосноор зохистой амьжиргааны эх үүсвэрээ өөрөө олох эрхийг баталгаажуулж өгдөг.
- Нийгмийн аюулгүй байдал
- Нийгмийн анхан шатны үйлчилгээнд хамрагдах (боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээ)
- Хүний алдар хүндийг хөдөлмөрийн ертөнцөд хамгаалах
- Үйлдвэрчний эвлэлийн төлөөлөх эрхийг хөдөлмөрийн ертөнцөд болон улс төрийн тавцан дээр хамгаалах

Уг пакт эерэг эрх чөлөөний ойлголтоор тодорхойлогддог. Нийгэм-эдийн засгийн үйл ажиллагааны хүрээнд хамтын шийдвэрт оролцох автономит эрхийн цар хүрээ буюу нийгмийг ардчилах зорилтод чиглэсэн нийгмийн ардчиллын цар хүрээг дээрх тайлбарт бүрэн орхигдуулсан байна. Уг тайлбар нийгмийн үндсэн үйлчилгээгээр тэгш хангагдах хамгийн доод төвшинг тогтоож өгдөг ч хувь хүн бүрийн амьдралын боломжийн шударга хуваарилалттай холбогдсон бүх асуудлыг нээлттэй орхисон. Шударга ёсны тухай ойлголт зөвхөн цалин хөлс, хөдөлмөрийн нөхцөлтэй холбоотойгоор дурдагддаг. Шударга ёсны шалгуур үзүүлэлтүүдийг дэлгэрэнгүй тайлбарлаагүй, шударга хуваарилалтын шийдвэрлэх асуудлуудыг хаалттай орхисон тул нийгмийн шударга ёсоор дамжин хийгддэг үндсэн эрхийн каталогийн хэрэглээний тухай мэтгэлцээнийг улс орон бүрд өрнүүлэх болон дэлхийн улс орнуудын нэгдсэн харьцуулалтыг хийх шаардлагатай.

Үндсэн эрхүүдийг хэрэгжүүлэх арга хэлбэрүүд

Иргэний болон улс төрийн эрхийг хэрэгжүүлэх арга хэлбэрүүд нь нийгэм, соёл, эдийн засгийн эрхүүдийг хэрэгжүүлэх арга хэлбэрээс ялгаатай. Хэлбэр төдий формаль эрхүүдийг дэлхийн улс орон бүрт нэн даруй хэрэгжүүлэх боломжтой байдаг бол харин материаллаг эрхүүдийг тухайн улс орнууд өөрийн хөгжил дэвшлийн түвшинээсээ хамааран (**progressively**)

боломжийнхоо хэрээр хэрэгжүүлдэг. Өдгөө мөрдөгдөж буй олон улсын эрх зүйн дагуу иргэний болон улс төрийн эрхүүдэд үр дүнгийн үүрэг хариуцлага ногддог (**obligations of result**) бол материаллаг эрхүүдэд харьцааны үүрэг хариуцлага (**obligations of conduct**) ногдож байдаг. Дээрх хоёр бүлэгт харьяалагдах эрхүүд зөрчигдсөн тохиолдолд ногдуулах хариуцлага ч мөн өөр өөр байдаг. Хүний формаль эрхийг зөрчсөн тохиолдолд тухайн улс орныг шүүхэд дууддаг бол материаллаг эрхүүд зөрчигдсөн тохиолдолд улс орнууд НҮБ-ын холбогдох комиссод сайн дураараа илтгэл бичих үүрэг хүлээдэг. Түүнээс уг эрхүүд зөрчигдсөн тохиолдолд хувь хүн шүүхэд гомдол мэдүүлэх эрхгүй. Гэхдээ улс орон бүрд материаллаг эрхүүдийг хэрэгжүүлэх, хангахад бүх нөөц бололцоогоо дайчлан ажиллах үүргийг хүлээлгэдэг. Энэ утгаар нь авч үзвэл формаль болон материаллаг эрхүүд ач холбогдлын хувьд эн тэнцүү бөгөөд заавал биелэгдэх ёстой. Дээрх эрхүүдийг өргөн хүрээтэй, бүрэн утгаар нь хэрэгжүүлэх хурд улс орнуудын чадамж, нөхцөл байдлаас хамаардаг бөгөөд дараах хоёр хүчин зүйлээс хамаарна:

Нэгдүгээрт: Хариуцсан эрх мэдэлтнүүдийн улс төрийн хүсэл зоригоос

Хоёрдугаарт: Дээрх эрхүүдийг хэрэгжүүлэхэд шаардагдах эдийн засгийн нөөц бололцоо буй эсэхээс

Үндсэн эрхүүдийн хэм хэмжээнүүдийг заавал биелүүлэхийг эрмэлзэж буй улс орнуудын нийгмийн салбар бүрд байгууллагуудын, бүтцийн, процедурын онцлогуудыг тодорхойлж өгөх бололцоотой.

Нийгмийн ардчилал нь үндсэндээ даян дэлхийд улс төр, нийгэм, эдийн засгийн үндсэн эрхүүдийг тууштай хэрэгжүүлэх хөтөлбөр юм.

2.7 Хувийн хариуцлага ба иргэдийн үүрэг

Өдгөөг хүртэл НҮБ-ын ерөнхий чуулганаас хүмүүсийн үүрэг хариуцлагын тухай тайлбар батлагдан гараагүй байна. Ийм тайлбар ирээдүйд ч гарахгүй байх. Харин **«Дотоод үйл ажиллагааны зөвлөл»** буюу **«Inter Action Council»** хэмээх 1983 онд байгуулагдсан олон улсын, хараат бус байгууллагаас **«(Хүмүүсийн үүрэг хариуцлагын ерөнхий тайлбарыг»** боловсруулан гаргасан. Уг тайлбар 19 зүйлтэй, **«Хүний алдар хүндийг дээдлэх, халдашгүй эрх чөлөө, тэгш байдал, тэдний хоорондын эв санааны нэгдлийг хүлээн зөвшөөрөх»** үзэл баримтлал дээр суурилсан. **«Inter Action Council»** нь дараах шалтгаануудын улмаас хүний үүрэг хариуцлагыг онцгойлон авч үзэх нь чухал гэж үзсэн. **«Хүний үүрэг хариуцлагын тухай ойлголт нь эрх чөлөө ба хариуцлагын тэнцвэрт байдлыг хангахад чухал үүрэгтэй. Эрхийн тухай ойлголт нь илүү их эрх чөлөөг эдлэх тухай ойлголт дээр суурилдаг бол үүргийн тухай ойлголт нь хариуцлагатай илүү ойр ойлголтууд юм. Уг төслийг ерөнхийд нь авч үзэхэд зөвхөн ерөнхий моралын үүрэг хариуцлагыг тайлбарласнаас бус эрх зүйт төрт улсын иргэний болон нийгмийн иргэний хариуцлагын талаар бараг дурдалгүй орхигдуулжээ.**

Өнөө үе үндсэн эрхүүдийг үндсэн үүрэг хариуцлагуудаар баяжуулах шаардлагатай болсныг харуулж байна. Орчин үеийн нийгмийн баримжаат төрийн санхүүгийн хямралууд, орлого ба зарлагын хоорондох зөрүүг улам их болгосоор байна. Даяаршсан зах зээлийн нөлөөгөөр улс орнуудын үндэсний эдийн засгийн ачаалал даах чадамж улам бүр хумигдаж байна. Зарим улс орнуудад татварын ачааллыг цаашид улам нэмэгдүүлэхийн эсрэг иргэдийн тэмцэл идэвхжиж байна. Нийгмийн баталгаат байдал, тэгш байдлыг хангах зорилтуудыг улс орнууд эдийн засгийн хүчин чадамж, хувийн хариуцлагатай харьцуулж дэнслэн үзэх шаардлагатай. Нийгмийн баримжаат

төр хөгжихийн хэрээр дараах хамаарлууд улам бүр нэмэгдэж байна: Үндсэн үүргүүдийг тууштай харгалзан үзэхгүйгээр нийгмийн үндсэн эрхүүд хангагдах боломжгүй болдог. Үндсэн үүрэг хариуцлагуудыг хариуцлагатайгаар нотолж тэдгээрийн үндсэн эрхүүдтэй харьцуулсан харьцааг зөв зохистой тогтоох шаардлагатай.

Ажилчны хөдөлгөөний үед эрх ба үүргүүдийн хоорондын нягт холбоо илүү тодорхой байжээ. Жишээлбэл эв санааны нэгдлийг давхар үүрэг хариуцлага гэж ойлгодог байлаа. Нийт нь нэгнийхээ өмнө, нэг нь нийтийнхээ өмнө хүлээх хариуцлага хүлээх зарчмыг эв санааны нэгдэл гэнэ хэмээн тодорхойлдог байжээ. Өөрөө чадах чинээгээрээ хүчин зүтгэхгүйгээр аянчин мэлхийн үлгэр мэт бусдын хүчинд дулдуйдан амьдарвал эв санааны зарчмыг ноцтой зөрчиж буй хэрэг юм. Дээр үеийн нийгмийн хөдөлгөөнүүдийн үед хэвшил болоод байсан дээрх ойлголтоос нийтийнхээ өмнө хариуцлага хүлээж чадаагүй этгээдэд эв санааны тусламж үзүүлэх нь зөв үү? гэдэг асуулт гарч ирж байна.

Дээрх зарчмууд орчин үеийн нийгмийн баримжаат төрийг үүсгэн байгуулах суурийг тавьсан юм. Юуны өмнө нийгмийн баримжаат төрийн үндсэн хамгааллыг буй болгосон нь үндсэн эрхүүдийг хэрэгжүүлэх үндсийг тавьжээ. Нийгмийн ардчилал нийгмийг бүхэлд нь шинэчлэх төслийн хэмжээнд хөгжихийн хэрээр үндсэн үүрэг хариуцлагуудыг илүү нухацтай авч үзэх шаардлагатай болдог. Энэ нь нийгмийн хамгааллын системийг хүрсэн төвшнөөс нь ухраахгүй байх нэг үндсэн нөхцөл мөн.

Үндсэн үүрэг хариуцлагуудын нотолгоонд Роналд Дборкинсийн үндэслэл шийдвэрлэх ач холбогдолтой: «Хувь хүний анхдагч эрх чөлөөний эрх нь хувь хүн бүрд өөрийн амьдралын өмнө өөрөө хариуцлага хүлээх (хувь заяаныхаа эзэн байх) хариуцлагыг ногдуулдаг. Хүн бүр өөрийн амьдралын баталгааг хангах үүргээ

бүхий л боломжоороо биелүүлээд хүчин мөхөстөж буй тэр хэмжээнийхээ тусламжийг л нийтийн зүгээс шаардах эрхтэй. «Нийгмийн баримжаат төр нь өндөр хөгжсөн орнууд хувь хүн үүрэг хариуцлагаа хэрхэн биелүүлж байна гэдэг нотолгоо буюу хариуцлагын тооцоон дээр үндэслэн эрхийг нь хангадаг системд шилжиж болох юм. Үндсэн хуулиар баталгаажуулсан нийтийн сайн сайхны эсрэг санаатай үйл ажиллагаа явуулсан этгээдийн улс төрийн иргэний эрхийг хасдагтай нэгэн адил уг этгээд нийгмийн бусад үүрэг хариуцлагаа зөрчсөн бол түүний нийгмийн эрхүүдийг хасаж болох юм. Зарим нийгмийн баримжаат төртэй улсуудад уг зарчмыг хэрэгжүүлж эхлээд байна. Жишээлбэл Голланд улсад 1990 оноос ажилгүйдлийн тэтгэмжийн хэмжээг тухайн хүн ажилд орохоор хэр хэмжээний хүчин зүтгэл гаргаж байна бэ? гэдгээс хамааруулан тогтоож байна. Бусад орнууд энэ зарчмыг хэрэгжүүлэх, туршиж үзэх арга замыг эрэлхийлж байна.

Үндсэн үүрэг хариуцлагуудыг тодорхойлохдоо бүх хүмүүсийн алдар хүндийг дээдлэх шаардлага хангагдсан эсэхэд гол анхаарлаа хандуулах учиртай.

Нийгмийн ардчиллын тухай ойлголтод хувь хүний алдар хүндийг тухайн хүний нийгэмд оруулж буй хувь нэмрээс үл хамааран дээдлэх ёстой. Өөрөөр хэлбэл тухайн хүний нийгмийн анхдагч үндсэн эрхүүд ба хүний ёсоор амьдрах баталгааг өөрөө үүрэг хариуцлагаа биелүүлээгүй байсан ч төр, нийгэм хангах үүргийг хүлээнэ гэсэн үг юм. Хувь хүн нийгмийн өмнө хүлээх үүргээ биелүүлээгүй тохиолдолд нийгмийн халамжийн үйлчилгээний хэмжээг бууруулж болно. Үүний тулд нийгмийн хамгааллын хоёр өөр төвшинг тогтоох нь зүйтэй:

1. Хүн бүрийг томоохон эрсдэлүүдээс хамгаалах нийгмийн хамгааллын дээд төвшин буюу эрсдэлд өртсөн хүмүүсийг тодорхой цаг хугацааны туршид зарчмын хувьд эрсдэлд

өртөхөөс нь өмнөх байдлаас нь дордуулахгүй хэмжээнд байлгах баталгаат төвшин. Нийгмийн хамгааллын уг төвшний хэлбэр, хэмжээг тухайн хүн үүрэг хариуцлагаа аль хэр биелүүлснээс хамааран өөр өөр тогтоож болно.

2. Нийгмийн хамгааллын анхдагч буюу элементар төвшин:
Энэ төвшин бүх хүнд, тухайлбал өөрийн чадварт тохирсон ажил хөдөлмөр эрхлэх талаар санаа тавиагүй хүмүүст ч нэгэн адил хангагдсан байх ёстой.

Цалинг орлох бусад орлогын хэмжээг хүнийг хүний ёсоор амьдруулахад хүрэлцээтэй байх хэмжээнд тогтоох ёстой. Түүнээс доогуур тогтоож хэрхэвч үл болно. Нийгмийн хамгааллын өөр өөр түвшин тогтоосон нөхцөлд нийгмийн баримжаат төрийг шударга ёсны зарчмыг зөрчиж байна хэмээн шүүмжилдэг. Дахин ажил хөдөлмөр эрхлэхээр ихээхэн хүчин зүтгэл гаргаж буй хүмүүс энэ талаар огт санаа тавихгүй байгаа хүмүүстэй тэнцүү хэмжээний ажилгүйдлийн тэтгэмж авах нь шударга бус байна гэж гомдол мэдүүлдэг. Нийгмийн хамгааллын хоёр өөр түвшинг тогтоох нь зарчмын хувьд боломжтой. Хоорондын ялгаа нь ямар хэмжээнд байх, ер нь ийм хоёр өөр түвшин байх шаардлагатай эсэхийг зөвхөн улс төрийн хүрээнд, тухайн нийгмийн хуримтлуулсан туршлагын үндсэн дээр шийддэг.

2.8 Нийгмийн эрсдэлүүд

Хувь хүн бүрийн иргэний болон улс төрийн үндсэн эрхүүдээ ашиглах чадвар нь тэдний амьдралд тохиолдож болзошгүй нийгмийн болон эдийн засгийн эрсдэлүүдээс зонхилон хамаардаг.

Эрсдэлийн тухай ойлголт

Эрсдэл нь цогц ойлголт юм. Аюултай харьцуулахад эрсдэл зорилтот сонголтын нэг бүрэлдэхүүн хэсэг, нэгэн элемент байдгаараа онцлог. Нийгмийн ардчиллын онолд улс төрийн хамтын хариуцлагын үр дүнд үүсдэг учраас нийгмийн болон бүтцийн эрсдэлүүдийг онцгойлон авч үздэг.

Хувь хүний үндсэн эрхүүдийн хэрэгжилтэд саад тотгор учруулахуйц нийгмийн харилцаанаас үүдэлтэй, хамтын шийдвэрийн улмаас учирсан, эсхүл үүссэн шалтгаан нь арилаагүй хэвээр байгаа нийгмийн эрсдэлүүдийн өмнө улс төр хариуцлага хүлээнэ.

Нийгэм нь улс төрийн аргаар нөлөөлж болохуйц хамтын шийдвэрүүдийг иргэдийн үндсэн эрхүүдийн хэрэгжилтэд саад тотгор учруулахуйц эрсдэл авчрах үр дагавартай эсэхэд хяналт тавьж эрсдэл учирсан үед эрсдэлийн улмаас учирсан хохирлыг барагдуулах үүрэг хүлээнэ.

Нийгмийн эрсдэлүүд нь улс төрийн хамтын шийдвэрийн үр дагавар мөн тул тэдгээрийг улс төрийн үйл ажиллагаагаар залруулж хохирлыг барагдуулах боломжтой. Хувь хүмүүсийн хувьд нийгмийн эрсдэлийн эсрэг үйл ажиллагаа явуулах боломж маш хязгаарлагдмал юм.

Паул Жонсон капиталист зах зээлийн соёлоос үүдэлтэй эрсдэлүүдийг цогц байх шаардлагыг хангах үүднээс системчилсэн байна. Тэр эрсдэлүүдийг эрүүл мэндийн, амьдралын хэмнэлээс үүдэлтэй, эдийн засгийн болон экологийн эрсдэл хэмээн ангилсан байна. Ульрих Бек түүний энэ ангилал дээр орчин үеийн амьдралын хэв маягаас улбаатай амь нас, эрүүл мэндэд учирч болох эрсдэлийн бусад төрлүүдийг нэмж өгсөн. Эдгээр эрсдэлүүдийг аль хэмжээнд таньж мэдэх нь хувь хүмүүсийн мэдлэгээс хамаарах бөгөөд тэдгээр нь орчин үеийн техник, шинжлэх ухааны баялгийн үйлдвэрлэлтэй салшгүй холбоотой юм. Эдгээр эрсдэлд жишээ нь: химийн гаралтай тахлууд, цацраг идэвхт бодисын хор хөнөөл болон бусад иргэншлийн гаралтай өвчлөлүүд багтана. Эдгээр эрсдэлүүдийг энгийн нүд, энгийн аргаар тогтоох боломжгүй, тэдгээрийг тогтооход өндөр мэргэжлийн хүмүүсийн магадалгаа зайлшгүй шаардлагатай. Зөвхөн шинжлэх ухаан л өөрийн онол, туршилт, хэмжүүрийн багаж хэрэгслийн тусламжтайгаар хүмүүст

таниулах боломжтой. Эрсдэлийн олон төрөл нь бүх нийгэмд тохиолддог, бүх хүмүүсийн нийгмийн оршихуйд зарчмын чухал ач холбогдолтой учраас нийгэмд түгээмэл онцгой ач холбогдолтой байдаг. Тэдгээр нь нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн нийгмийн үндсэн таваарууд болох сэтгэл зүйн амьдрал, даван туулах чадвар, нийгэмд хүлээн зөвшөөрөгдөх байдал, түгээмэл үндсэн эрхүүд дээр суурилдаг.

Эрсдэлийн төрлүүд

Нийгмийн ардчиллын онол нь эрсдэлүүдийг хувийн сайн дурын эрсдэл, улс төрийн сайн дурын эрсдэл хэмээн хоёр үндсэн бүлэгт хуваадаг. (2-р хүснэгтийг хар)

Хүснэгт 2. Эрсдэлийн хоёр төрөл

	Эрсдэлийн төрлүүд	Шинж чанар	Илрэл	Жишээ
I.	Хувийн сайн дурын эрсдэл	Эдгээр эрсдэлүүд хувьдаа илүү ашиг олох гэсэн хувийн сонирхлоос үүдэлтэй.		Мэргэжил сонголт
II.	Улс төрийн сайн дурын эрсдэл	Эдгээр эрсдэлүүд эсвэл нийтийн сайн сайхны төлөө төрөөс гаргасан шийдвэрийн улмаас эсвэл улс төрийн дутуу дулимаг шийдвэрийн улмаас гардаг.	А. Нийгмийн болон бүтцийн эрсдэлүүд нь: Нийгмийн системчлэгдсэн бүтцийн нөлөөгөөр үүсдэг. Жишээ нь: капиталист зах зээлийн систем Б. Нийгэм болон технологийн эрсдэлүүд: Хувийн эсвэл хамтын ашиг сонирхлын түсын тулд нэвтрүүлсэн технологийн хэрэглээнээс үүдэлтэй. В. Нийгэм-соёлын эрсдэлүүд: Зарим талаараа улс төрийн шийдвэрээс эсхүл улс төрийн бодлогогүй үйл ажиллагааны улмаас үүдэлтэй.	Хөдөлмөр эрхлэх боломжгүй байх Цөмийн энергийг ашигласны улмаас цөмийн тахал дэгдэх, химийн тахлууд дэгдэх зэрэг Хүйс, арьсны өнгө, гарал үүслийн улмаас ажил мэргэжлийн эсвэл улс төрийн хүрээнд ялгаварлан гадуурхалтад өртөх

Хувийн сайн дурын эрсдэлүүд хувийн буруу сонголтоос үүдэлтэй учраас хувь хүн өөрөө тэдгээрийг гэтлэн давах ёстой. Энэ төрлийн эрсдэлүүдийн өмнө хувь хүмүүс өөрсдөө хариуцлагаа хүлээх ёстой. Эдгээр нь нийгмийн ардчиллын үзэл, онолд төдийлөн ач холбогдолгүй. Харин бүх төрлийн улс төрийн - сайн дурын эрсдэлүүд нь хамтын шийдвэрийн үр дагавар мөн тул хэн нэгэн хувь хүний үйл ажиллагаатай холбон үзэх боломжгүй. Энэ төрөлд нийт нийгмээрээ сонгон авсан эдийн засаг, нийгэм, эсхүл технологийн институцууд, бүтцийн өөрчлөлтөөс үүдэлтэй эрсдэлүүд багтана. Дээрх хэлбэрийн эрсдэлүүдэд ихэвчлэн олон тооны хүмүүс ижил хэлбэрээр өртдөг, тэдгээрийн шууд нөлөөлөлд автдаг учраас нийгмийн ардчилалд улс төрийн-сайн дурын эрсдэлүүд онцгой байр суурийг эзэлдэг. Учир нь гэм зэмгүй хувь хүмүүс эрх чөлөөгөө эдлэх болон оролцооны тэгш боломжоо хангах нөхцөл, нийгмийн үндсэн үйлчилгээнээс хувь хүртэх боломжийг нь бүрдүүлдэг хэрэгслүүдээсээ хагацдаг. Улс төрийн-сайн дурын эрсдэлийн үр дагавруудыг гэтлэн давах нийгмийн баталгаат байдлыг зохион байгуулж өгдөг нь нийгмийн ардчиллын онолын онцлог, давуу тал юм. Бүх иргэддээ үндсэн эрхүүдээ хангахад нь шаардагдах хэмжээний нийгмийн үндсэн үйлчилгээнүүдээс хувь хүртэх эрх зүйн шаардлагыг тавих үндсийг нь бүрдүүлж өгдөг. Нэн ялангуяа нийгмийн болон бүтцийн эрсдэлд өртсөн тохиолдолд үндсэн эрхүүдийг хангахад онцгой анхаардаг.

Эрсдэлүүд ба эрхүүд

Нийгмийн ардчиллын онол нь орчин үед нийгмийн болон бүтцийн бүх хэлбэрийн эрсдэлүүдэд анхаарлаа хандуулж байна. Сонгодог нийгмийн ардчиллын онол нь капиталист зах зээлийн эрсдэлүүд дээр суурилан өөрийн үндэслэлүүдээ нотолдог байсан. Гэхдээ эдгээр эрсдэлүүдтэй харьцуулсан үндэслэлүүд хэтэрхий ерөнхий агуулгатай байсан бөгөөд нэг талаас бүх иргэдийн түгээмэл үндсэн эрхүүдийг хэлбэр төдий

хангах шаардлага, нөгөө талаас нийгмийн эрсдэлд өртсөний улмаас түгээмэл үндсэн эрхүүдээ хэрэгжүүлэх, нийгмийн үндсэн үйлчилгээнүүдээс хувь хүртэх эрх нь баталгаагүй болсон хүмүүсийн бүлэг хоорондын зөрчлүүдийг арилгахад чиглэгдэж байжээ. Эхний ээлжид зах зээлд өөрийн мэдлэг чадвараар ажилгүйдэлд өртөх эрсдэлээс өөрийгөө хамгаалах чадваргүй иргэдийн нийгмийн хамгааллыг бүрэн хангахад чиглэгдэж байжээ.

Эхний үед эмэгтэйчүүдийн тэгш эрхийг хангахад нийгмийн зүгээс учирч байсан олон саад бэрхшээлийг арилгах асуудал яригдаж байсан бол орчин үед өөр олон төрлийн нийгмийн эрсдэлүүдийг шийдвэрлэх асуудал улс төрийнхний өмнө тулгарсаар байна. Эрсдэлүүдийн хэлбэр, үүссэн учир шалтгаан өөр өөр байдаг ч гарах үр дагавар нь адилхан байдаг. Тодорхой бүлэг хүмүүсийн үндсэн эрхүүдээ эдлэхэд шаардагдах хэрэгсэлд хүрэх боломж нь хаагддаг. Эндээс л нийгмийн ардчиллын шаардлагын үндсэн асуудал урган гардаг.

Үүссэн нөхцөл шалтгаан нь өөр өөр боловч үр дагавар нь адилхан байдаг.

Нийгмийн ардчилал чухам ямар учраас «нийгмийн» гэсэн тодотголтой байдаг бэ? гэдэгт хоёр үндсэн шалтгаан байдаг: **Нэгдүгээрт** үндсэн эрхүүд зөрчигдөхөд хүргэх нийгмийн болон бүтцийн шалтгаануудыг хамгийн түрүүнд хөндсөн учраас, **хоёрдугаарт** бүх хүмүүсийн түгээмэл үндсэн эрхүүдийг практик дээр бодитоор хангахын тулд нийгмийн ямар нөхцөлүүд хангагдсан байх шаардлагатай бэ? гэдгийг тодорхойлж өгсөн учраас. Либертар ардчиллын онол нь үндсэн эрхүүдийн хэлбэр төдий хэрэгжилт ба тэдгээрийг хэрэгжүүлэх ардчилсан институцуудыг байгуулахаар хязгаарладаг учраас эхнээсээ хаагдмал хэлбэртэй байдаг. Харин нийгмийн ардчиллын онол нь нийгмийн шинэ хэлбэрийн эрсдэлүүдийн өмнө нээлттэй

байх ёстой. Үндсэн эрхүүдийг хангахад учирч болзошгүй нийгмийн эрсдэлүүд гарсан тохиолдолд тэдгээрийг улс төрийн үйл ажиллагаагаар хязгаарлах, эсхүл үр дагаврыг нь нөхөн төлөх үндэслэлийг гаргаж ирэх нь нийгмийн ардчиллын сэдвүүд юм. Эрсдэл тохиолдсон үед үндсэн эрхүүдийн хэлбэр төдий хэрэгжилт болон бодит хэрэгжилт хоёрын хоорондын зайг багасгахын тулд бодлогын ямар арга хэрэгсэл, стратегийг ашиглах бэ? гэдгийг нийгмийн ардчилал нэн түрүүнд авч үздэг. Нийгмийн ардчилал нь нийгмийн бүх төрлийн эрсдэлүүдээс хамгаалах зохистой бүтцүүдийг байгуулах нь ардчилсан төрийн үүрэг мөн гэж үздэг. Эдгээр нь:

- Улс төрийн шинж чанартай
- Үндсэн эрхүүдийг хязгаарлахад хүргэдэг
- Олныг хамарсан
- Хувь хүн болон хамт олон өөртөө туслах замаар үр дагаврыг нь арилгах боломжгүй
- Нийгэмд оршин байгаа улс төрийн удирдлагын хэрэгслүүдийг ашиглан хязгаарлах эсхүл хяналтдаа авах боломжтой.

Өнөө үед хуучин, шинэ төрөл бүрийн нийгмийн эрсдэлүүд төрийн нийгмийн үйл ажиллагааны бодлогын нөхцөлүүдийг хангаж байна.

Хүснэгт 3. Нийгмийн эрсдэлүүдийн бүлгүүд

Нийгмийн эрсдэлүүдийн бүлгүүд	...оноос хойш
Капиталист зах зээлийн бүтцээс үүдэлтэй эрсдэлүүд	1830-аад оноос хойш
Хүйсийн харьцааны соёлын загваруудаас үүдэлтэй эрсдэлүүд	1860-аад оноос хойш
Орчин үеийн нийгмийн соёлын олон талт бүтцээс үүдэлтэй эрсдэлүүд	1960-аад оноос хойш
Аж үйлдвэржилтийн процессоос үүдэлтэй эрсдэлүүд	1970-аад оноос хойш
Нийгмийн асар хурдацтай шинэчлэлээс үүдэлтэй эрсдэлүүд	1975-аад оноос хойш
Орчин үеийн мэдлэгт суурилсан эдийн засгаас үүдэлтэй эрсдэлүүд	1990-аад оноос хойш
Нийгэм болон эдийн засгийн даяаршлаас үүдэлтэй эрсдэлүүд	1990-аад оноос хойш

Даяаршил улс төрийн хяналтаас гадуур өрнөсөн хэвээр байвал хамгийн ноцтой бусад эрсдэлүүдийг гааруулсан эрсдэлүүд гарсаар байх болно. Өнөөдөр даяаршлын улмаас дэлхийн хүн амын олонхын иргэний болон улс төр, нийгэм, эдийн засгийн эрхүүд хамгийн ихээр зөрчигдөж байна. Даяаршлын процесс маш олон талтай, асар их зөрчлийг агуулж байдаг учраас маш их эрсдэлийг дагуулдаг. Даяаршлаас улбаатай хамгийн ноцтой шинэ хэлбэрийн эрсдэл бол бодлого тодорхойлоход улс төрийн нөлөө буурч улмаар эрсдэлээс хамгаалах боломж хумигдахад хүрч буй явдал юм. Учир нь улс төрийн нөлөө бүхий шийдвэрүүдийг зөвхөн улс үндэстний болон бүс нутгийн түвшинд зөвхөн тухайн нутагт оршин суугчдын төлөө гаргах боломжгүй болсон. Нөлөө бүхий шийдвэрүүдийг гаргахын тулд олон үндэстний түвшинд буюу үндэстэн дамнасан улс төрийн нөлөөтэй, бодлого төлөвлөлтийн эрх мэдэлтэй байх шаардлагатай. Дээрх хэлбэрийн эерэг ба дэвшилтэт даяаршлыг төлөвшүүлэхэд ихээхэн цаг хугацаа шаардлагатай байна.

2.9 Улс төрийн антропологи

Хүний тухай үзэл нь либертар ардчилал болон нийгмийн ардчиллын эсрэг, тэсрэг байр суурьт голлох үүрэг гүйцэтгэдэг. Антропологийн эдгээр үндсэн төсөөллүүд улс төрийн практикийн олон асуултуудын хариултад чухал ач холбогдолтой байдаг. Юуны өмнө:

- Бүх хүмүүс нийгэмд шударга ёс тогтоохыг хүсдэг үү?
- Хүмүүс нийтийн ашиг сонирхлын төлөө идэвх зүтгэл гаргахад бэлэн үү?
- Ядуурал, ажилгүйдэл хувь хүмүүст хэрхэн нөлөөлдөг бэ?
- Нийгмийн баялгаас тэгш хувь хүртэх боломж, нийгмийн оролцоо ямар ач холбогдолтой бэ?
- Шударга ёсны хэм хэмжээнүүд удаан хугацаагаар зөрчигдөх нь ямар үр дагаварт хүргэдэг бэ?

Антропологи бодитой юу? эсвэл үзэл суртлынх уу?

Либертар ба нийгмийн ардчиллын гол зөрчил хүний тухай үзэлд эсрэг тэсрэг байр суурь баримталдгаас үүдэлтэй. Энэ нь тэдгээрийн эрхэмлэдэг эрх чөлөөний тухай ойлголтуудын өрсөлдөөнөөр илэрдэг. Либертар ардчиллын онол сөрөг эрх чөлөөний тухай ойлголт дээр суурилдаг бол нийгмийн ардчиллын онол эерэг эрх чөлөөний тухай ойлголт дээр суурилдаг. Либератизм хувиа хичээсэн аминч үзэл хүмүүс хоорондын харилцаанд давамгайлдаг гэж үздэг бол нийгмийн ардчиллын нь хүмүүс өөрийн ашиг сонирхлын зэрэгцээ нийтийн ашиг сонирхлыг хүндэтгэдэг гэж үздэг. (Хүснэгт 4)

Хүснэгт 4. Либертар ардчилал ба нийгмийн ардчиллын харьцуулалт

	Либертар ардчилал	Нийгмийн ардчилал
Антропологи	Эргэлзээтэй антропологи	Бодит антропологи
Эрх чөлөөний тухай ойлголт	Сөрөг эрх чөлөөний ойлголт	Эерэг эрх чөлөөний ойлголт
Харьцааны сэдлүүд	Хувийн сонирхол	Хувийн-болон нийтийн сонирхол
Хүний тухай үзэл	Зөвхөн өөрийн ашиг сонирхлыг хамгаалсан хувиа хичээгч	Харилцан ойлголцлыг эрхэмлэгч хувь хүн

Хүмүүс хоорондын харилцааны сэдлүүд

Хүмүүсийн улс төрийн харьцаа нь тухайн оршин буй нийгмийн харилцаа, харилцан ойлголцох боломжуудаас хамаардаг. Сонгогчдын сонголт буюу аль нэг үзлийг дэмжих үзэл төрөлхийн байдаггүй, харин улс төрийн процессын үр дүнд бий болдог. Нийгэмд оршин байгаа чиг хандлагуудаас сонгох, тэдгээрийг харьцуулах, олон нийтэд хүргэж буй нийтийн сайн сайханд хүргэх үндэслэлүүдийн харьцуулалт дээр улс төрийн үйл ажиллагааны ухаалаг сонголт сая бий болдог.

Бодит туршлага дээр тулгуурласан судалгааны үр дүн нь нийтэд хүлээн зөвшөөрөгдөх чадамжтай, үнэмшилтэй, сайн үндэслэлүүдийг олон нийтийн дунд дэвшүүлэн тавьж чадвал нийгмийн олонхын өөрийн хувь хөрөнгөтэй байх ашиг сонирхлын эсрэг чиглэгдсэн нийгмийн баримжаат төрийн шинэчлэлийн асуудлаар ч улс төрийн нэгдсэн шийдэлд хүрч чаддаг гэдгийг харуулдаг. Маш сайн үндэслэл бүхий мэтгэлцээнийг олон нийтийн дунд өрнүүлж чадвал сонгогчдын дийлэнх нь тэдний хувийн материаллаг ашиг сонирхлыг шууд хөндсөн, түүний эсрэг чиглэсэн бодлогыг ч дэмждэг. Харин улс төрийн сайн үндэслэл гаргаж чадаагүй тохиолдолд сонгогчид өөрсдийн төрөлх эрх ашгийн төлөө баттай зогсож тэдний ашиг сонирхлын эсрэг үйл ажиллагаа явуулж буй засгийн газрыг дараагийн боломж гармагц огцруулчихдаг байна.

Сонгуулийн судалгаануудаас авч үзвэл сонгогчдын олонх нь нийтийн ашиг сонирхлыг төдийгүй нийгмийн сайн сайхны төлөөх зорилтуудыг өөрсдийн сонголтод харгалзан үздэг нь батлагддаг. Иймээс хувь хүмүүс өөртөө хамгийн ашигтай байх тэр хувилбарыг сонгодог гэж үзэх нь өрөөсгөл юм. Эв санааны нэгдэл, нийтийн ашиг сонирхол хүмүүсийн үйл ажиллагаанд чухал байр суурь эзэлдэг. Нэн ялангуяа олон нийт бусад хүмүүс, бусад байгууллагуудын удирдагчид ч нэгэн адил эв санааны нэгдлийн төлөө үйл ажиллагаа явуулдаг гэдэг итгэл үнэмшилтэй байх нь тэдний нийтийн ашиг сонирхлын төлөө үйл ажиллагаа явуулах идэвх санаачилгыг улам нэмэгдүүлж байдаг.

Хувь хүмүүс сонголтдоо олон талт ашиг сонирхлыг харгалзан үздэг. Аюулгүй байдал, төрийн бодлогын залгамж чанарыг хангах хэрэгцээ, аливаа үйл ажиллагааны үр дүнг хамгийн өндөр байлгах гэсэн эрмэлзэл, ёс суртахууны хэм хэмжээнүүд, нийтийн ашиг сонирхол, үзэл суртлын чиг хандлага зэргийг харгалзан үздэг. Хүмүүсийн сонголтод ямар хүчин зүйл зонхилох үүрэгтэй байх бэ? гэдэг нь нийгмийн харьцаа,

нийтийн сайн сайхны төлөө явуулж буй бодлогын шударга ёсны чиг хандлагын хэм хэмжээнээс ихээхэн хамаардаг.

Нийгмийн тодорхой бүтцүүд, идэвхтэй, үүргээ гүйцэтгэх чадамжтай иргэний нийгэм, эсхүл шударга ёсны зарчим дээр суурилсан нийгмийн хамгааллын систем нь нийгмийн эв санааны нэгдлийг дэмжин тэтгэж байдаг. Харин нийтийн ашиг тусын төлөөх төслүүд сул хөгжсөн, улс төрийн нэгдсэн ойлголт төлөвшөөгүй, эрсдэлээс хамгаалах хамгаалалтыг хувь хүмүүст даатгасан нийгмийн соёл давамгайлсан нийгэмд эв санааны нэгдэл, нийтийн сайн сайхны төлөөх харилцаа хамгийн сул хөгжсөн байдаг. Философийн антропологид соёл, шашин шүтлэг, газар зүйн байрлал, нийгмийн хөгжлийн үе шатнаас үл хамааран бүх хүнд нийтлэг байдаг зургаан үндсэн хэрэгцээг тодорхойлсон: Эдгээр нь хүндлүүлэх, итгэх, бусдад хэрэгтэй байх, ноёлох, харилцан ойлголцох, эрүүл саруул нийгмийн хүрээлэл дунд амьдрах хэрэгцээ юм:

Хүмүүсийн дээрх үндсэн хэрэгцээнүүдийг хэсэгчилсэн байдлаар үл тоомсорлосон, эсхүл огт харгалзан үзээгүй аливаа бодлого урт насалдаггүй гэдгийг 20-р зууны туршлага нотлон харуулсан. Фундаменталист үзэл нь зохиомол суурин дээр албадлагын хэрэгслүүдийн тусламжтайгаар итгэлцлийг бий болгохыг оролддог. Либертариизм бусдад хэрэгтэй байхыг туйлын зорилго болгон дэвшүүлж, коммунизм харилцан ойлголцох хэрэгцээг үл харгалзаж, фашизм эрх мэдлийг бүхнээс чухалчилж бусдаар хүндлүүлэх, харилцан ойлголцох хэрэгцээнүүдийг огт харгалзаж үздэггүй. Эдийн засгийн хязгааргүй уян хатан бодлого итгэлтэй байх, ноёлох үндсэн хэрэгцээнүүдийг үл тоомсорлож ингэснээрээ өөрийн оршихуйн үндсийг үгүйсгэдэг.

Хүмүүсийн үндсэн хэрэгцээнүүдээс үйл ажиллагааны хөтөлбөрүүд урган гардаггүй ч хүний төлөө бодлогын хэм

хэмжээ, хязгаарыг тогтоодог. Дээрх үндсэн хэрэгцээнүүд бүрэн хангагдсан нөхцөлд л хамрагдах бүх хүмүүс санал нэгдэж нэгдсэн ойлголцолд хүрч чаддаг.

Улс төрийн антропологиос нийгмийн ардчиллын бодлогод тавигдах шаардлагууд

Улс төрийн антропологийн тухай ойлголтоос нийгмийн ардчиллын бодлогод дараах шаардлагууд урган гардаг:

Нэгдүгээрт: Нийгмийн болон улс төрийн эв санааны чадамж хэр өндөр байх нь иргэний нийгмийн үйл ажиллагааны ямар бүтэц байна?, нийгмийн баримжаат төрийн болон улс төрийн ямар институцууд байна? гэдгээс хамаардаг.

Хоёрдугаарт: Хувь хүмүүсийн нийгэмтэйгээ харьцах харилцаанд олон талт ашиг сонирхол нөлөөлдөг. Бусад хүмүүс хамтын үйлсийн төлөө өөрийгөө зориулахад бэлэн эсэх талаарх дүгнэлт, тухайн нийгэмд оршин буй байгууллагуудын итгэл даах чадвар зэрэг нь хувь хүмүүсийн нийтийн тусын төлөө үйл ажиллагаанд оролцох шийдвэр гаргах, эв санааны нэгдлийг хүндэтгэн үзэхэд чухал үүрэгтэй.

Гуравдугаарт: Иргэд олон нийтийн институцууд ба бүтцүүд үйл ажиллагаандаа шударга ёсыг эрхэмлэдэг гэдэгт итгэлтэй байх нь иргэний нийгэм идэвхтэй байх, шударга харьцаа тогтох нөхцөл илүү баталгаатай болдог.

Дөрөвдүгээрт: Төрийн оролцоо хамгийн багатай, хуучинсаг нийгмийн баримжаат төрүүд нь, эдгээр дээр суурилсан , эдгээрээр дамжин хуульчлагдсан хувиа хичээсэн байдлыг улам идэвхжүүлдэг.

Тавдугаарт: Хүмүүст байнга итгэл найдваргүй байдлыг төрүүлж байдаг нийгмийн амьдралын нөхцөлүүд, улс төрийн харилцаанууд

нь анхдагч үндсэн хэрэгцээнүүдийг зөрчиж байдаг. Үүний цаана хууль ёсны байх эсэх асар том асуудал нуугдаж нөгөө талаар улс төрийг үл сонирхох, нийгмийн эв нэгдлийг сарниулах зэрэг нийгмийн эрсдэлүүдийг дагуулж байдаг.

2.10 Шударга ёс

НҮБ-ын улс төр ба нийгмийн үндсэн эрхүүдийн харта нь зарчмын хувьд нийгмийн ардчиллын үзэл баримтлалын онолын болон улс төрийн хууль ёсны байдлын норматив суурийг бүрдүүлж байдаг. Гэхдээ аливаа улс төрийн системийн хууль ёсны байдал нь зөвхөн үндсэн эрхүүдийг хангах тогтолцоог бүрдүүлснээр баталгааждаггүй. Үүнээс гадна бүх иргэд нийгмийн баялаг болон амьдралын боломжууд нийгэмд шударгаар хуваарилагдаж байна гэдэг итгэл үнэмшилтэй байх нь түүнээс дутуугүй чухал ач холбогдолтой юм.

Шударга ёсны үүргүүд

Шударга ёсны зарчим нийгмийн ардчилалд олон чухал үндсэн үүргийг гүйцэтгэдэг.

1. Шударга ёсны зохицуулагч үүрэг

Шударга ёс нь хууль ёсны улс төрийн процессууд, төслүүдэд харьцуулалтын хэм хэмжээний үүргийг гүйцэтгэдэг. Сонирхлын бүлгүүд, улс төрийн намууд маргаантай асуудлуудын шийдлийн төлөө тэмцэлдэх явцдаа үл ойлголцолд хүрвэл шударга ёсны хэм хэмжээнүүдийг үндэслэлээ болгодог. Шударга ёсны хэм хэмжээнүүд дээр суурилсан нотолгоонуудын тусламжтайгаар нийгмийн боломжууд, эрхүүдтэй холбоотой зөрчилдөөнийг шударгаар шийдвэрлэхийг эрмэлздэг. Шударга ёс ийнхүү харьцуулалтын хэм хэмжээний үүргийг гүйцэтгэхдээ үл маргах баталгаат статусын хэлбэрээр бус харин зарчмын хувьд илүү зөвшилцөлд хүрч болохуйц санаа гэдгээрээ нөлөөлж байдаг.

2. Шударга ёсны нэгтгэгч үүрэг

Шударга ёс нь нийгэмд нийгмийн болон улс төрийн нэгтгэгч хүчин зүйлийн үүргийг гүйцэтгэдэг. Нийгмийн байдлын хувьд

дорой байгаа хэсэг нь «нийт нийгмийн хөдөлмөрийн болон таваарын журам» сайжирвал тэдний нийгмийн байдал сайжирна гэдэг хүлээлттэй байдаг. Нийгмийн байдлын хувьд сайн байгаа хэсэг нь тэдэнд нийгмийн болон улс төрийн тогтвортой байдал хэрэгтэй гэдэг утгаараа нийгэмд бүхэлд нь шударга ёсыг тогтоох эрмэлзэлтэй байдаг. Ийнхүү нийгэмд шударга ёсны хэм хэмжээний талаар нэгдсэн тодорхой ойлголцол тогтсон байх нь эрх зүйт төрийн ардчилсан үндсэн хууль үйлчлэх нөхцөлийг бүрдүүлдэг. Шүүн шийтгэхүй болон албан ёсны шийдвэр гаргалтын бүтцийн тусламжтайгаар шударга ёсны үндсэн зарчмуудыг алхам алхмаар хэрэгжүүлдэг.

3. Шударга ёсны чиглүүлэгч үүрэг

Шударга ёс нь нийгэм ба улс төрийн үйл ажиллагаанд чухал шалгуурууд, хэм хэмжээнүүд, чиг хандлагуудыг тогтооход онцгой чухал үүрэг гүйцэтгэдэг. Нийгмийн ардчилал хэрэгжихэд нийгмийн шударга ёсны үзэл санаа нь улс төрийн хамтын чиг хандлага хэмээн хүлээн зөвшөөрөгдсөн байхыг шаарддаг. Нийгмийн ардчилал нь нийгмийн болон эдийн засгийн харилцааг зохицуулах болон нийгмийн болон эдийн засгийн олон төрлийн сонирхлуудыг хэрхэн харгалзан үзэх тухай шалгуур үзүүлэлтүүдийг тодорхойлох ёстой. Шударга ёсны зарчмыг улс төрийн шийдвэрийн чиг хандлагыг тогтоогчийн үүргийг гүйцэтгэх чадамжтай байлгахын тулд нийгэмд шударга ёсны үүрэг хариуцлагын тухай нэгдсэн зөвшилцөлд хүрэх боломж нээлттэй байх ёстой. Шалгууруудыг хэрхэн тогтоож, яаж хэрэгжүүлэх бэ? гэдэг нь үргэлж маргаантай асуудал байдаг боловч тэдгээрийг тогтоож өгөх шаардлагатай юм.

4. Шударга ёсны хууль тогтоогч үүрэг

Шударга ёс нь иргэдийн ухамсарт улс төрийн системийн хууль ёсны байдлын тухай ойлголтыг тогтоож байдаг. Үйл ажиллагааны бүхий л талбаруудад хэрэгжүүлж буй бодлого болон улс төрийн процессуудад иргэд шударга гэдэг дүгнэлт өгч байх нь тэдгээрийн хууль ёсны байх үндэслэл нь болдог. Улс төрийн үр дүнг улс төрийн шударга байдлын тухай олон

нийтийн мэтгэлцээнээр шүүн хэлэлцэж, иргэдийн олонх нь түүнд итгэл үнэмшилтэй байвал сая хууль ёсных гэж үздэг.

Шударга ёсны хууль ёсны нөлөө нь бодлогын гурван цар хүрээг гурвууланг нь хамарч байдаг. (**polity, policy and politics**); Дээрх гурван цар хүрээнд үйл ажиллагаа, нийгэм - улс төрийн байгууллагуудыг байгуулах (хариуцсан байгууллагууд байгуулагдах) процессод өөр өөр хэлбэрээр чиг хандлагыг нь тогтоож өгдөг. Нийгмийн үндсэн хуулийн (**polity**) түвшинд шударга ёсны үнэт зүйл нь иргэдийн эрх үүргүүдийг тэнцүү хуваарилж тэднийг хамгаалах эрх зүйн чадамж бүхий бүтцүүдийг бий болгодог. Улс төрийн үйл ажиллагааны хөтөлбөрүүдийн (**Policy**) түвшинд шударга ёс хувь хүмүүсийн үйл ажиллагаа явуулах эрх чөлөөг хангахад шаардагдах боломж, нөөцүүдийг шударгаар хуваарилж байдаг. Улс төрийн хэрэгжилтийн (**Politics**) түвшинд шударга ёс улс төрийн шийдвэр гаргалтын процессод тэгш оролцооны боломжийг хангаж зөрчилдөөнийг арилгах улс төрийн соёлыг зохицуулж байдаг.

Шударга ёсны асуудлаар зөвшилцөлд хүрэх боломжтой юу?
Аливаа нийгмийн шударга ёсны хэм хэмжээ нь зөвхөн хэсэгчилсэн байдлаар тухайн нийгэмд үйлчилж буй хууль эрх зүйн хэм хэмжээнд тусгагдсан байдаг. Шударга ёсны нотолгооны тухай асуудал байнга маргаантай байдаг бөгөөд энэ нь зөвхөн нийгэмд үйлчилж буй эрх зүйн журам бүхэлдээ хууль зүйн хувьд хүчин төгөлдөр эсэх асуудал биш юм. Эрхийн хууль ёсны байдал нь ардчилсан хуулиудыг тогтоох аргачлал дээр үндэслэдэг. Хууль тогтоох аргачлал нь хууль ёсны байх нь эрх хууль ёсны байх баталгаа болдог. Иймээс шударга ёсны зарчим хүн бүрийг нийгмийн санаа бодол- хүсэл зоригийг бүрдүүлэх процессод оролцох тэгш бололцоогоор хангаж өгөхийг шаардаж байдаг. Иргэн бүр улс төрийн автономит эрхээ болон хууль ёсны эрхээ эдлэх тэгш боломжоор хангагдсан байх ёстой. Энэ утгаар нь авч үзвэл эрх нь ардчиллын зарчмуудыг тогтоогч нь юм.

«Шударга ёсны хэм хэмжээнүүдийг хэрхэн нотлох бэ?» гэдэг асуудал 1970-аад оноос хойш шударга ёсны тухай шинжлэх ухааны мэтгэлцээний нэгэн чухал сэдэв байсаар байна. Жон Раулс, Михаел Вальцер, Роналд Дборкин, Юүрген Хабермас нарын онолчид улс төрийн болон нийгмийн шударга ёсны өөр өөр шалтгаан, утгын шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулжээ.

Шударга ёсны агуулга

Хүний-болон иргэний эрхийн суурь тэгш байдал, либерал ардчиллын улс төрийн байгууллагууд нь шударга ёсны нөхцөлүүд болон элементүүдийг илэрхийлж байдаг гэдэг дээр шударга ёсны онолчдын дийлэнх нь санал нэгдээд байна. Түүнээс гадна дээрх онолчид тэгш байдлын хэм хэмжээг тогтоохдоо зөвхөн улс төрийн болон иргэний эрхүүдийг төдийгүй нийгэм, соёл, эдийн засгийн эрхүүд, боломжуудыг нэгэн адил харгалзан үзсэний үндсэн дээр тогтоосон байна.

Улс төрийн болон нийгмийн шударга ёсны эдгээр концепцууд нь утгын хувьд дараах таамаглалуудыг дэвшүүлсэн байдаг.

Нэгдүгээрт: Шударга ёс нь тэгш эрх чөлөөг эдлэх тухай ойлголт юм.

Хоёрдугаарт: Орлогын болон хөрөнгийн тэгш бус байдлуудыг нотлох шаардлагатай.

Гуравдугаарт: Бусдын эрхийг зөрчөөгүй гэдэг нь нотлогдож байгаа нөхцөлд тэгш бус байдлыг хууль ёсных хэмээн үзнэ.

Дөрөвдүгээрт: Шударга ёс нь амьдралын боломжийг тэгш хуваарилахыг шаарддаг. Амьдралын эхэн үед төдийгүй бүхий л амьдралынх нь туршид эерэг эрх чөлөөний боломжууд бүх хүнд ойролцоогоор тэгш байдлаар хуваарилагдаж байх ёстой.

Тавдугаарт: Шударга ёсыг нийгэм, эдийн засаг, төрийн бүхий л шийдвэрт хувь хүмүүсийн болон хамт олны оролцооны боломж хэр хангагдсан бэ? гэдгээр үнэлдэг.

Зургаадугаарт: Шударга ёс нь тухайн нийгмийн толь мөн. Учир нь шударга ёсны шалгуур үзүүлэлтүүд ба тэдгээрийг хэрэглэх нөхцөлүүд нь харилцан адилгүй байдаг тул тухай бүр шинэчлэн тогтоож байх шаардлагатай.

Долоодугаарт: Шударга ёс хоёр давхар шалгуураар тогтоогдож байдаг. Нэг талаас тодорхой шалгууруудаар, нөгөө талаас талуудын оролцоотойгоор хамтран тогтоож нийтэд танилцуулах замаар шинэчлэн тодорхойлогдож байдаг. Нийгмийн ардчиллын үзэл баримтлалд шударга ёсны үндэслэл нь эерэг эрх чөлөөний тухай ойлголт бөгөөд уг ойлголт нь шударга ёсоор дамжуулан амьдралын боломжийг тэгш хуваарилах тухай хөтөлбөрийн үндсийг бүрдүүлдэг.

1996 оны НҮБ-ын хүний эрхийн пакт нь олон улсын эрх зүйд нийцүүлэн улс төрийн болон нийгмийн үндсэн эрхүүдийн тэгш байдлыг нотолсон байдаг. Гэхдээ уг пакт нь амьдралын боломжуудын хуваарилалтын талаар олон шийдвэрлэх чухал асуудлуудыг нээлттэй орхисон бөгөөд энэ утгаараа шударга ёсны хэм хэмжээг дэндүү бүрхэг орхигдуулсан байна. Жишээ нь: «Хөдөлмөрийн зохистой нөхцөлүүд»-ээр хангуулах үндсэн эрхийг тодорхойлоогүй орхисон байна. Мөн ямар нөхцөлүүдийг «зохистой нөхцөл», ямар нөхцөлүүдийг «зохисгүй» гэж нэрлэх бэ? эдгээрийг ямар шалгууруудаар тодорхойлох бэ? гэдгийг тайлбарлаагүй орхисон байна.

Нийгмийн ардчилалд шударга ёсны хэм хэмжээний тухай зөвшилцөл зайлшгүй шаардлагатай юм. Шударга ёсны хэм хэмжээний тухай нэгдсэн ойлголтыг нийгэмд зайлшгүй төлөвшүүлэх шаардлагатай. Тийм ч учраас нийгэмд явуулах бүхий л шинэчлэлийн өмнө (татварын систем, нийгмийн хамгааллын систем, эдийн засгийн байгуулал, эсхүл боловсролын систем ер нь бүх салбарт) олон нийтийн хэлэлцүүлгийг зайлшгүй явуулж байх шаардлагатай. Нийгмийн ардчилалд нийгмийн шударга ёсыг төлөвшүүлэхэд чиглэгдсэн арга хэмжээнүүд, шалгуур үзүүлэлтүүдийн талаар олон нийт нэгдсэн ойлголтод хүрэх зайлшгүй шаардлагатай. Энэхүү мэтгэлцээний хөрс суурь тухайн нийгмийн соёлд бүрдсэн байх ёстой, эсвэл аажмаар бүрэлдэн бий болох ёстой. Шударга ёсны хэм хэмжээнүүдийн талаар байнга маргаан үүсэж байдаг тул тэдгээрийн талаар олон нийтийн нэгдсэн ойлголтыг тухай бүрд нь шинэчлэн тогтоож байх шаардлагатай.

**Шударга ёсны зарчмыг эв санааны нэгдлийн
зарчим болон нигүүлсэнгүй үзэлтэй харьцуулах нь**

Шударга ёсны тухай ойлголтыг эв санааны нэгдэл болон хүмүүнлэг нигүүлсэнгүй үзлийн тухай ойлголтоос өөрөөр тодорхойлох ёстой. Учир нь шударга ёс зөвхөн аливаа үйл

ажиллагааг явуулах үүргийг бусдад болон нийгэмд ногдуулдаг, шахалт үзүүлэх чадамж бүхий эрх зүйн үүргүүдийг ногдуулах эрх бүхий байгууллагуудаар дамжин хэрэгжих боломжтой. Харин эв санааны нэгдэл гэдэг ойлголтоор хүмүүс хоорондын харилцан туслалцааг илэрхийлдэг ба ёс зүйн хувьд үүрэг хүлээх боловч хэн нэгнийг бусдад тусал гэж албадах эрхгүй, эрхийг эдэлсэн хүн үүрэг хүлээх тухай ойлголтын хүрээнээс давсан асуудал юм. Эв санааны нэгдэл нь орчин үед хоорондоо харилцан туслалцахад бэлэн хүмүүсийн хамтын нийгэмлэгийн дунд бусдад туслах ёс зүйн үүрэг гэсэн утгаар хэрэглэгддэг.

Хүмүүнлэг, нигүүлсэнгүйн тухай ойлголт нь мөн бусдын халамж шаардлагатай хүмүүст туслалцаа үзүүлэх ёс суртахууны үүрэг хариуцлагын тухай ойлголт юм. Эв санааны нэгдэл нь хүмүүсийн хоорондын харилцан туслалцааг илэрхийлдэг бол хүмүүнлэгийн үйл ажиллагаанд харилцан бус зөвхөн нэг талын туслалцааг илэрхийлдэг. Эдгээр туслалцаа нь хүмүүнлэгийн бэлэг юм. Хүмүүнлэгийн үйл ажиллагаа нь төрийн үүрэг, үйл ажиллагаанаас гадуур явагддаг бөгөөд байнга бусдын туслалцаа хэрэгтэй байдаг эмзэг давхарга, хариу тус нэхэхгүйгээр бусдад туслах чадвартай чинээлэг давхарга хоёрын хоорондох харилцаа юм.

Эдгээр гурван ойлголтууд болон цар хүрээнүүдийн хоорондын ялгааг тодорхойлох нь нийгмийн ардчиллыг, нэн ялангуяа нийгмийн баримжаат төрийг юуны тулд үүсгэн байгуулах ёстой юм бэ? гэдэг нотолгоог гаргахад ихээхэн ач холбогдолтой юм. Жишээ нь: Нийгмийн хамгааллын системийг эв санааны нэгдлийн систем гэж нэрлэж байгаа бол уг системээс иргэддээ сайн дурын үндсэн дээр үйлчилгээ үзүүлдэг, иргэд нь харилцан туслалцдаг, харин эрх зүйн талаас нь авч үзвэл заавал хамрагдах шаардлагагүй систем юм байна гэж ойлгогдоно. Харин нийгмийн хамгааллын системийг шударга ёсны систем гэж нэрлэж байгаа бол шударга ёсны зарчмуудыг биелүүлэхийн тулд даатгуулагчид нь хувь хүртэх

эрхтэй систем гэж ойлгогдоно. Нийгмийн хамгааллын системээс хувь хүртэгчдийн өөрийгөө хүндэтгэх үзэл, бусад хүмүүс тэдэнд яаж хандах нь тухайн хүртэж буй хувь нь хууль ёсных мөн үү? үгүй юу? гэдгээс хамаарна. Эв санааны нэгдлийн ойлголтыг нийгмийн хамгааллын системийн хууль ёсны байх үндэсн гэж үзвэл даатгалын шимтгэл төлдөггүй, орлогогүй иргэдэд ашигтайгаар байна гэсэн үг. Харин шударга ёсны ойлголтыг хууль ёсны байх үндэс болгон авч үзвэл зөвхөн даатгалын шимтгэл төлөгчид төлснийхөө хэрээр хувь хүртэх эрхтэй. Дээрх ойлголтуудын үр дагавар практик дээр асар их зөрүүтэй байдаг тул нийгмийн ардчилал шударга ёсны тухай ойлголтод голлох ач холбогдол өгдөг.

Шударга ёсны тухай олон нийтийн хэлэлцүүлэг

Нийгмийн ардчилалд шударга ёсны хэм хэмжээнүүд олон нийтийн хэлэлцүүлгийн үр дүнд тогтоогдож, түгээгдэж байх учиртай. Үүний нэг үндсэн нөхцөл нь бүх нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн улс төрийн үнэт зүйлсийн хамгийн доод түвшин тогтсон улс төрийн соёл тухайн нийгэмд бүрдсэн байх ёстой бөгөөд уг соёл дээр суурилан олон нийтийн дунд шударга ёсны тухай хэлэлцүүлэг өрнөж байх ёстой. Түүнчлэн сөргөлдөгч талуудын хооронд ухаалаг харилцан ойлголцолд хүрэх хүсэл эрмэлзэл тодорхой хэмжээгээр байх нь чухал. Эрх зүйт төрт ардчиллыг үйл ажиллагааны ерөнхий цар хүрээг тодорхойлогч мөн гэдэг итгэл үнэмшлийг итгэл төлөвшүүлэх, төрийг чадамжтай байлгахын тулд тэд нэгдэлд бэлэн байх ёстой. Хэдийгээр дээрх нөхцөлүүдийн дийлэнх хэсэг ихэнх орнуудад бүрдсэн байдаг боловч дан ганц шударга ёсны тухай ухаалаг хэлэлцүүлэг хаа ч өрнөдөггүй. Олон нийтийн мэдээллийн хэрэгслээр өрнөж буй мэтгэлцээнүүд зөвхөн мэдээлэл, баримт нотолгоонд суурилдаггүй, цэнгээнт нэвтрүүлэг, үзэл санааны, ашиг сонирхлын зөрчилдөөнд анхаарлаа хандуулж байдаг. Нэн ялангуяа үзэгч сонсогчдын дийлэнх хэсэгт хүрч чаддаг шар хэвлэлүүд, ашгийн төлөөх хувийн радиогийн хэрэгслүүд, харилцан ойлголцолд чиглэгдсэн мэтгэлцээнийг өрнүүлэх таатай нөхцөлийг бүрдүүлж чаддаггүй.

Өндөр чанарын хэвлэмэл мэдээллийн хэрэгслүүд эсвэл олон нийтийн радио, телевизүүд шударга ёсны тухай хэлэлцүүлэгт илүү баримт нотолгоонд суурилсан мэдээ, мэдээлэл өгч мэтгэлцээнийг өрнүүлж чаддаг. Хэлэлцүүлэг, мэтгэлцээнийг өндөр түвшинд явуулахын тулд чөлөөт мэдээллийн хэрэгслүүд, баталгаатай чанарын үнэлгээ, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүдэд нөлөөлж чадахуйц иргэний нийгмийн байгууллагууд төлөвшсөн байх ёстой.

Шударга ёсны тухай олон нийтийн хэлэлцүүлэг тэдгээртэй зэрэгцэн өрнөж байдаг шинжлэх ухааны мэтгэлцээнээс хэд хэдэн онцлог ялгаатай байдаг.

Нэгдүгээрт: Мэтгэлцээн өөр өөр тавцан дээр өрнөдөг. (Холбоод, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүд, их сургуулиуд, сүмүүд, конгресс, улс төрийн намууд) Эдгээр нь хоорондоо холбоотой ч баримт нотолгоогоо гаргадаг стилүүд нь хоорондоо эрс ялгаатай. Шинжлэх ухааны байгууллагууд бол цэвэр шинжлэх ухааны баримт нотолгоон дээр суурилсан шинжлэх ухааны мэтгэлцээнүүдийг өрнүүлдэг.

Хоёрдугаарт: Олон нийтийн мэтгэлцээн практик асуудал дээр суурилдаг, тогтмол бус, тохиолдлын чанартай байдаг бөгөөд тэдгээр нь шударга ёсны тухай олон нийтийн тодорхойлолтыг гаргах зорилтыг хэзээ ч агуулдаггүй, хариг тодорхой бүтэлгүй явдалд тайлбар өгөх зорилготой явагддаг.

Гуравдугаарт: Бүх нөхцөлүүд болон баримт нотолгоонуудын талаар хангалттай тайлбар хийгддэггүй учраас олон нийтийн мэтгэлцээн ихэвчлэн бүрэн бус хэлбэрээр явагддаг.

Дөрөвдүгээрт: Олон нийтийн мэтгэлцээн үзэл санааны номлол, хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийн эрх мэдэл, ашиг сонирхол, илтгэх чадвараас ангид байж чаддаггүй, тэдгээрийн нөлөөлөлд байдаг.

Шударга ёсны тухай шинжлэх ухааны онол олон нийтийн мэтгэлцээнд шууд нөлөөлж байдаг. Шинжлэх ухааны мэтгэлцээн тодорхой баримт нотолгооны суурь болж ингэснээрээ тухайн нийгмийн соёлд тусгалаа олж байдаг. Улс төрийн соёл нь тухайн нийгэмд давамгайлж буй чиг хандлага, нийгмийн болон улс төрийн бодит туршлага, шинжлэх ухааны чиглүүлэх соёлоос бүрддэг учраас тухайн нийгэм дэх шударга ёсны ойлголтыг хамтран тодорхойлж байдаг.

Шударга ёсны тухай улс төрийн болон шинжлэх ухааны мэтгэлцээнүүд улс төрийн өндөр ач холбогдолтой. Маргаантай асуудал болон бодлогын шийдлүүд зөвхөн шударга ёсны мэтгэлцээнээр дамжин нийгмийн шүүлтүүрээр шүүгддэг. Улс төрийн хууль ёсны байдал, шударга ёсны хэм хэмжээнүүдийн хэрэгжилт нь хоорондоо салшгүй холбоотой. Улс төрийн бодлого хөтөлбөрүүд шударга ёсны мэтгэлцээнээр шүүгдэж шударга хэмээн үнэлэгдсэн тохиолдолд хууль ёсных хэмээн үнэлэгдэж дийлэнх олонхын дэмжлэгийг хүлээдэг. Энэ утгаараа олон нийтийн шударга ёсны тухай мэтгэлцээн, идэвхтэй, ардчилсан олон нийт нь цаг үеийн маргаантай асуудлаар цагаа олсон улс төрийн харилцан буултыг хийх нөхцөлүүдийг бүрдүүлэхэд шийдвэрлэх чухал үүрэгтэй юм.

Прагматик стратеги

Европын нийгмийн баримжаат улсуудын эдийн засаг-нийгмийн бодлогын цаг үеийн асуудлуудтай холбогдуулан Вольфганг Меркел 2002 онд нийгмийн ардчиллын бодлогын шударга ёсны тухай мэтгэлцээнийг прагматик байдлаар дөрвөн үндсэн параметрийн хүрээнд өрнүүлэх санал дэвшүүлсэн юм. Эдгээр нь **нэгдүгээрт**: шийдвэрлэх ач холбогдолтой гэдэг нь олон нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн, **хоёрдугаарт**: олон улсын түвшинд харьцуулалт хийснээр хэмжигдэх боломжтой, **гуравдугаарт**: дийлэнх орнуудад дутагдалтай байгаа нь нотлогдсон байх ёстой гэдэг шаардлагуудыг тавьж дараах

шалгуур үзүүлэлтүүдийг сонгон авчээ:

1. Ядуурлын хувь хэмжээ
2. Боловсролд оруулж буй хөрөнгө оруулалт
3. Хөдөлмөрийн зах зээлд хамрагдах боломж
4. Нийгмийн баримжаат төрийн зардал
5. Орлогын тэгш бус байдал.

Меркелийн санал болгосон нийгмийн шударга ёсны прагматик хэрэглээг үнэлэх эдгээр үзүүлэлтүүдийн дэс дараалал нөөцийн хомстлын улмаас, эсвэл илүү чухал гэсэн нотолгоо хангалттай бол өөрчлөгдөх боломжтой. Дээрх дэс дарааллыг тогтоох болсон шалтгаануудад юуны өмнө:

1. Ядууралтай хийх тэмцэл хамгийн чухал. Учир нь ядуурал үйл ажиллагааны олон салбарт хүмүүсийн хүний ёсоор амьдрах үндсэн эрхүүд зөрчигдөх, хязгаарлагдах шалтгаан болдог.
2. Боловсрол бол хувь хүмүүс эрх чөлөөний боломжууд болон хөгжлийн потенциалыг бүрэн дүүрэн ашиглахад хамгийн чухал нөлөөтэй нөөц юм.
3. Орлогын эх үүсвэрээ бүрдүүлэх ажилтай байх нь нийгэмд хүлээн зөвшөөрөгдөх, нийгмээс хувь хүртэх үндсэн нөхцөл юм.
4. Нийгмийн баримжаат төрийн зардал нь нийгмийн хамгааллын хүрсэн түвшинг илэрхийлэх шалгуур үзүүлэлт юм.
5. Орлогын ялгаатай байдлыг хөдөлмөрлөснийхөө хэрээр цалин хөлс авах зарчмыг зөрчилгүйгээр хязгаарлах нь зүйтэй боловч бусад зорилтуудтай харьцуулахад ач холбогдлын хувьд төдийлөн чухал бус юм. Энэхүү прагматик стратегийн хоёрдох алхам бол харьцуулсан аргачлалыг практикт нэвтрүүлэх, бусад оронд хамгийн сайн хэрэгжсэн жишээг загвар болгон авч хэрэгжүүлэх явдал юм.

Дээрх шалгуур үзүүлэлтүүдийг нарийвчлан судлах шаардлагатай.

Учир нь боловсролын салбарт зөвхөн төсвийн хөрөнгө оруулалт төдийгүй элсэлтийн бодит тэгш боломж бүрдсэн эсэх нь ихээхэн ач холбогдолтой. Түүнчлэн нийгмийн баримжаат төрийн зарцуулалтад зөвхөн хэмжээ бус бүтэц ихээхэн ач холбогдолтой гэх мэт. Меркелийн санал нь өнөөгийн нөхцөлд шударга ёсны хэм хэмжээнүүдийг хэрэгжүүлэх алхмуудыг үндсэн эрхүүдийг хэрэгжүүлэх эрх зүйн шаардлага нь шударга ёсны зарчмуудын дундаж түвшинг тогтоож байдаг, эдгээрийг тодорхой бодлогод ингэж тусгах боломжтой гэдэг жишээн дээр харуулснаараа ач холбогдолтой. Тэрбээр нөгөө талаас шударга ёсны хэм хэмжээнүүд, үндсэн эрхүүд, улс орнуудын тодорхой алдаа бүхий туршлага, тэдгээрийн тодорхой нөхцөл байдалд өгсөн тайлбарын харилцан уялдаан дээр улс төрийн хувьд ач холбогдолтой шударга ёсыг хэрэгжүүлэх стратегийг боловсруулах боломжтой гэдгийг харуулсан.

2.11 Тогтвортой байдал

1987 оны Брандтландын илтгэл, 1992 онд Рио Де Жанейро хотноо болсон НҮБ-ын байгаль орчин ба хөгжил сэдэвт бага хурал дээр илтгэл тавигдсанаас хойш тогтвортой байдал, тогтвортой хөгжлийн асуудал нь олон улс, иргэний нийгмийн байгууллагуудын үйл ажиллагаа болон олон үндэстний засгийн газруудын тулгамдсан зорилтуудын нэг болсон байна. Байгалийн нөөцөөс ирээдүй хойч үеийнхний амьдрал, өсөлт, чинээлэг амьдрал хамаарах учраас байгалийн нөөцийг шавхалгүйгээр, нөхөн сэргээгдэх тэнцвэрт байдлыг нь алдагдуулахгүйгээр орчин үеийн нийгэм тогтвортой хөгжлийн замыг сонгох ёстой гэдэг нэгдсэн зөвшилцөлд шинжлэх ухаан, улс төрийн хүрээнийхэн хүрээд байна. Тогтвортой хөгжил нь ирээдүй хойч үеийнхний амьдралынхаа хэрэгцээг хангах нөхцөл өнөө үеийнхнээс дордохгүй байхыг шаарддаг.

Энэ хооронд тогтвортой хөгжлийн олон тодорхойлолт гарсан байна. Байгаль орчинд ээлтэй, одоогийн нөөцийг хэвээр

хадгалсан хөгжлийн замыг сонгохын чухлыг бүгд ярьцгааж хөгжлийг нийгмийн шударга ёсыг хангах бүхий л шаардлагууд, энэ ертөнцийн хамгийн ядуу буурай хэсгийн амьдралыг дээшлүүлэх зорилготой уялдуулах нь манай эриний хамгийн чухал шаардлага болж байна гэдэг дээр санал нэгдэж байна.

Нийгмийн ардчиллын үзэл ба тогтвортой хөгжил:

Харилцан шүтэлцээ

Тогтвортой хөгжлийн стратегийн ихэнх үндсэн зарчмууд нь нийгмийн зарчмуудтай ямар нэгэн зөрчилгүйгээр уялддаг бөгөөд тэр ч байтугай нийгмийн ардчиллын зорилтуудад тогтвортой хөгжлийн зорилтууд агуулагдаж байдаг. Нийгмийн ардчиллын үзэл баримтлал, тогтвортой хөгжлийн хоорондын холбоо нь сонгодог шинэ либерал эдийн засаг эсвэл улс төрийн либерализмын хоорондын холбоог тогтоохоос хамаагүй хялбар, энгийн юм. Энэ нь тогтвортой хөгжлийн болон нийгмийн ардчиллын үзэл нь хоёулаа хөдөлмөр болон байгаль орчныг зах зээлийн хуулиудаас хамгаалах сонирхлоос эхтэй хамтын эх сурвалжтай холбоотой юм.

1980-аад оноос ядуурал, нийгмийн шударга бус байдал, хөгжлийн хоцрогдол, байгаль орчныг сүйтгэх асуудлуудын хоорондын уялдаа холбоо илүү тодорхой ойлгомжтой болсоор байна. Эдийн засгийн хамтын ажиллагаа ба хөгжлийн байгууллагаас «Тэгш бус байдал тогтвортой хөгжилд аюул учруулж байна.» хэмээн илтгэсэн бол Брандтландын илтгэлд «Ядуурал нь дэлхий дахинд учирч буй байгаль орчны бэрхшээлүүдийн гол шалтгаан бөгөөд шууд нөлөөлж байна.» гэжээ. Даяаршлын зах зээлийн систем нэвтэрснээр хөгжиж буй орнуудын ядуу иргэдийн амьдралын хэв маяг өөрчлөгддөг учраас тэд байгаль орчны сүйрлийн хамгийн эхний золиос болж байна. Жишээ нь: Зах зээлд чиглэсэн хөвөн даавууны үйлдвэрлэл Саха, Суданд шилжсэнээр тэндэхийн фермерүүд, малчид төрөлх газар нутгаасаа шахагдаж амьжиргааны эх

үүсвэр нь болсон уламжлалт мал аж ахуйгаа эрхлэхийн тулд үржил шим муутай хуурай газар луу түрэгдэж байна. Үржил шим муутай, хуурай газруудад газар тариалан эрхлэх гэсэн тэдний оролдлого зөвхөн цөлжилтийг нэмэгдүүлсэн юм. Үүний зэрэгцээ дэлхийн ундны цэвэр усны нөөц багасаж, эрэлт хэрэгцээ нь улам нэмэгдсээр байна. Чинээлэг орнуудын иргэд өндөр өртөгтэй ус нөөцлөх, давсгүйжүүлэх, цэвэршүүлэх технологиудыг хэрэглэн бэрхшээлийг даван туулж байгаа боловч ихэнх ядуу орнуудад ийм боломж байхгүй. Мөн олон ядуусын амьжиргааны эх үүсвэр болсон шүрэн нуруунууд устгахын аюулд тулгараад байна. Ойрын хэдхэн арван жилийн дотор бүрэн сүйрч хүмүүсийн хүнсний эх үүсвэр үгүй болж газарзүйн сүйрэл нүүрлэж болзошгүй болоод байна.

Байгаль орчинд хортой эдийн засгийн үйл ажиллагаа эрхлэх асуудал баян орнуудад ч ялгаагүй тэгш бус байдлаас үүдэлтэй. Өндөр хөгжилтэй орнуудын хөдөө аж ахуй өндөр үйлчилгээтэй хортон шавьж, хортой ургамал устгах бодисуудаас хамаарч байна. Эдгээр хорт бодисуудыг хууль бусаар оршин суугчид цацаж эрүүл мэндээрээ хохирч байна. Тухайн нийгэмд амьдралын хамгийн хүнд нөхцөлд амьдарч буй иргэд байгаль орчинд халгаатай өсөлтийн хамаг хүндийг үүрдэг. Эдгээр нь нийгмийн ардчиллын үндсэн зарчмууд болох бүх иргэд нийгмийн хамгаалалд байх, тэгш үнэлэмжтэй байх шаардлагуудыг зөрчиж байна. Нийгмийн ардчиллын үндсэн шаардлагуудын нэг нь экологийн хувьд тогтвортой эдийн засгийг хөгжүүлэх явдал. Үүний тулд дараах нөхцөлүүд хангагдсан байх шаардлагатай.

Нэгдүгээрт: Дэлхийн өнцөг булан бүрд засгийн газрууд эрчим хүчний хэрэглээ өндөртэй төслүүдээс аль болох татгалзах хэрэгтэй. (Нүүрс шатаах, мод огтлох, далан барих зэрэг.) Оронд нь байгалийн нөөцөд хал багатай, ариг гамтай хэрэглэдэг нарны эрчим хүчийг ашиглах, хуурай газрыг ойжуулах зэрэг

төслүүдэд илүү анхаарал хандуулах шаардлагатай байна. Эдгээрт эрчим хүч, түүхий эдийн хэрэглээний үр ашгийг дээшлүүлэх нь нэн чухал.

Хоёрдугаарт: Байгальд ээлтэй эдийн засгийн үйл ажиллагааг амжилтанд хүргэх суурь нөхцөлүүд нь шийдвэр гаргалтад олон нийтийг аль болох өргөн хүрээтэйгээр оролцуулах явдал: Бүх иргэдийг байгаль орчны асуудал, байгалийн нөөцтэй харьцах тухай шийдвэр гаргалтад татан оролцуулах ёстой бөгөөд тэдгээрийн хэрэгжилт ба хяналтад хамтран оролцох боломжоор хангагдах ёстой.

Гуравдугаарт: Өндөр хөгжилтэй аж үйлдвэржсэн орнууд хөгжиж буй орнуудаас өөрсдөө өндөр хэрэглээтэй амьдралын хэв маягаар амьдарч байгаа мөртлөө чинээлэг амьдралын түвшинд хүрэх хүсэл эрмэлзлээ хязгаарлахыг буурай хөгжилтэй орны иргэдээс шаардах ёсгүй төдийгүй өөрсдөө ч уг шаардлагыг хэрэглээндээ анхаарах шаардлагатай.

Дөрөвдүгээрт: Хөгжиж буй орнууд өндөр хөгжилтэй орнуудын алдааг давталгүйгээр тогтвортой хөгжлийн замыг сонгон авах ёстой.

Тавдугаарт: Үндэстэн бүрийн чинээлэг амьдрал хэр удаан хугацаанд үргэлжлэх нь тухайн улс орнуудын экологийн системийн амьдрах чадвараас хамаардаг учир улс орон бүр үндэсний болон даяаршлын эко системийн тогтвортой байдлыг хангах үйлсэд бүхий л бололцоогоо дайчлах ёстой.

Тогтвортой эдийн засгийн үйл ажиллагаа ажлын байруудыг бий болгодог.

Тогтвортой эдийн засагт шилжих шилжилтийг үйлчилгээ өндөр хөгжсөн орнуудын эрэлхийлж, хэрэгжүүлж буй нийтээрээ хөдөлмөр эрхлэх стратегийг нэгэн боломж болгон ашиглаж

болох юм. Эдийн засгийн компаниуд өртөг хэмнэхийн тулд дорой хөгжилтэй буюу доогуур стандарттай орнуудад үйл ажиллагаагаа явуулахыг илүүд үздэг хэмээн батлах нь олонтаа сонсогддог. Эдгээр компанийн “сонирхлыг татахын тулд” буурай хөгжилтэй орнууд өөрсдийн экологийн шаардлагуудыг бууруулах ёстой юм гэнэ. Гэтэл үүний эсрэг тал илүүтэй ажиглагдаж байна. Байгаль орчны стандартын шаардлага өндөртэй улс орнуудад шинэ аж үйлдвэрүүд, шинэ технологиуд хөгжиж ажлын байрууд олноороо бий болж байна. Жишээлбэл Дани улс салхин станцын турбины дэлхийн зах зээл дээр ноёлж өөрийн эрчим хүчний хэрэглээний 25%-ийг энэ технологиор хангаж байна. Ирээдүйд эрчим хүч бага хэрэглэдэг техник хэрэглээнд өргөнөөр нэвтрэх юм бол түрүүлж уг технологийг хөгжүүлсэн орнууд зах зээл дээр туршилт хийчихсэн байх тул илүү давуу талтай байх болно. Байгаль орчны салбарт ажлын байруудыг шинээр буй болгож байгаа өөр нэг жишээ бол газар тариалангийн том үйлдвэрүүдийн бүтцийн өөрчлөлт юм. Дээрх бүтцийн өөрчлөлт том хэмжээний талбайтай буудай тариалагчид, хиймэл бордоо, ургамал хамгаалах бодисуудын үйлдвэрлэл, томоохон мал үржүүлэх газруудад хийгдэж байна. Дээрх үйлдвэрлэлийн арга нь амьтны аймаг, загасны нөөцийг устгах хүлэмжийн хий, усны бохирдлыг нэмэгдүүлэх сөрөг талтай. Томоохон үйлдвэрүүд байгаль орчныг бохирдуулдаг арга технологи хэрэглээд зогсохгүй бүтээгдэхүүнээ байгаль орчинд ээлтэй үйлдвэрлэл явуулдаг тариачдаас бага өртгөөр зах зээлд нийлүүлдэг. Хэрэв байгаль орчинд ээлтэй үйлдвэрлэл явуулдаг тариачдад хөнгөлөлт үзүүлдэг төрийн татварын систем байдагсан бол тариаланчдын байгаль орчинд ээлтэй арга технологийг нэвтрүүлэх сонирхол нэмэгдэхсэн. Ингэвээс хөдөө аж ахуйн салбарын үйл ажиллагааны үр ашиг нэмэгдэж жижиг тариалангийн үйлдвэрүүд зах зээл дээр тэсэж үлдэх боломж нэмэгдэх болно.

Орон сууцнуудын халаалт, хөргөлтийн системүүдийг эрчим

хүчний хэмнэлттэй системээр солих, зуун километр гурван литр шатахуун хэрэглэдэг авто машинуудыг шинээр үйлдвэрлэх, том хотуудад нийтийн тээврийн хэрэгслүүдэд зориулсан замууд барьж авто замуудыг өөрчлөх, алдагдал ихтэй усан хангамжийн системийг шинэчлэх, дахин боловсруулалтад оруулах хог хаягдлуудын хэмжээг нэмэгдүүлэх, эрчим хүчний үйлдвэрлэх-нөөцлөх хуваарилах шинэ системүүдийг нэвтрүүлэх, үйлдвэрлэх зэрэг шинэ төслүүд хэрэгжвэл хэчнээн ажлын байр шинээр бий болох нь ойлгомжтой. Тогтвортой хөгжлийн эдгээр стратегиудыг үйлдвэрлэлийн өртгийг нэмэгдүүлэгч гэдэг утгаар нь авч үзвэл томоохон алдаа болно. Эдгээрийг эцэстээ эдийн засгийн үр өгөөжийг дээшлүүлэх, мөнгө хэмнэх, амьдралын чанарыг дээшлүүлэх, шинээр ажлын байр бий болгох боломж гэж авч үзэх нь зүйтэй.

Улс төрийн үйл ажиллагаа III

3.1. Улс төрийн үйл ажиллагааны үүрэг хариуцлага

Хүмүүсийн үндсэн эрх улс төр хариуцлагыг нь хүлээх ёстой. Эрсдэлийн улмаас зөрчигдсөн бүхий л тохиолдолд төр тэдний эрх ашгийг хамгаалах үүрэгтэй. Төр эрсдэлд өртсөн иргэдийн амьдралын боломжуудыг баталгаажуулж төрийн үйл ажиллагааны үр дагавраас үүссэн эрсдэлийн золиос болоогүй иргэдтэй адил түвшинд хангаж өгөх үүрэгтэй. Нэн түрүүнд төр эрсдэлээс хамгаалах, эрсдэл гаргуулахгүй байх үүргийг хүлээнэ. Төр энэ үүргээ биелүүлж чадаагүй бол эрсдэлийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлөх үүрэг хүлээнэ. Харин иргэн бүр юуны өмнө эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийн улмаас учирсан хохирлыг арилгахад өөрийн зүгээс боломжтой бүхнийг хийх үүрэг хүлээнэ. Жишээлбэл: Ажилгүй болсон иргэн дахин шинээр ажилд орохын тулд бүхий л чадлаа дайчлан ажиллах ёстой. Төр өөрийн хариуцлагын хүрээнд олгох ажилгүйдлийн мөнгөний хэмжээг ажилгүйдэлд өртсөн иргэн өөрийнхөө төлөө хэчнээн хичээл зүтгэл гаргав гэдгээс хамааруулан тогтоож болох юм. Энэ нь шударга ёсны зарчмын дагуу иргэн бүрийн нийтийн өмнө хүлээсэн үүрэг юм.

Нийгмийн ардчиллын бодлого хэрэгжих нэгэн чухал нөхцөл нь бүх иргэдийнхээ үндсэн эрхүүдийг бататган хамгаалдаг ардчилсан эрх зүйт төрийн аюулгүй байдал болон тогтвортой байдал хангагдсан байх явдал юм.

5-р хүснэгтэд нийгмийн хамгийн эрсдэлтэй салбаруудад нийгмийн ардчилсан төрийн үйл ажиллагааны үүргийг нэгтгэн харуулсан байна:

5-р хүснэгт: Хамгийн эрсдэл өндөртэй салбаруудад төрийн үйл ажиллагааны хүлээх үүрэг

Эрсдэлийн хэлбэрүүд	Төрийн үйл ажиллагаа-ны үндсэн үүрэг	Онцлог
Нийгмийн болон эдийн засгийн үндсэн эрхүүд зөрчигдөх	-Нийгмийн баримжаат төрийн зүгээс үзүүлэх мөнгөн туслалцаа -Нийгмийн автономит байдлыг хангах -Хөдөлмөрлөх эрхийг хангах	-Нийгмийн амьжиргааны эх үүсвэрийг баталгаажуулах -Бүх нийтийн болон мэргэжлийн боловсролыг хангах -Эрүүл мэндийн үйлчилгээ -Хөдөлмөр хамгааллын арга хэмжээнүүд -Капиталист зах зээлийн процессуудын зохицуулалт
Улс төрийн болон иргэний үндсэн эрхүүд зөрчигдөх	-Улсын иргэдийн улс төрийн нөөцийг тэгш хуваарилах	-Идэвх санаачилгатай олон нийтийг бүрдүүлэх -Улс төрийн процессод иргэдийн тэгш оролцоог хангах -Нийгмийг ардчилах

Иргэдийн үйл ажиллагааны үүрэг

Дээр дурдсан төрийн үйл ажиллагааны үүрэг нь түгээмэл үндсэн эрхүүдийг хангахад чиглэгддэг. Орчин үеийн өндөр эрсдэлтэй нийгэмд үндсэн эрхүүдийн хэрэгжилт нийгмийн дэд салбаруудад тодорхой үндсэн нөхцөлүүд хангагдсан байхыг шаарддаг.

Нэгдүгээрт: Бүх иргэдийнхээ улс төрийн автономит байдал, төрийн үйл ажиллагаанд нөлөөлөх бодит нөлөөллийг тэгш хангахын тулд улс төрийн систем нь оролцооны ардчилал гэдэг утгаараа оролцоо болон хяналтын хангалттай түвшнийг хангасан байх ёстой.

Хоёрдугаарт: Үндсэн эрхүүдийн системд үндсэн эрхийн үндсэн таван категориуд, нийгмийн болон эдийн засгийн үндсэн эрхүүдийг оролцуулан олон нийтийн эрх зүйн дагуу заавал хэрэгжих хангалттай түвшин тогтсон, иргэдийн нийгмийн оролцоо хангагдаагүй нөхцөлд иргэний эрх нь зөрчигдсөн тухай гомдол гаргах эрх нь нээлттэй байх ёстой.

Гуравдугаарт: Улс төрийн соёл нь нийгмийн ардчиллын улс төрийн үйл ажиллагааны үндэс, зорилго нь юм. Улс төрийн соёлд эрх чөлөө, шударга ёс, эв санааны нэгдлийн үнэт зүйлс хангалттай түвшинд нөлөөлдөг, нөгөө талаас дэмжигддэг байх ёстой.

Дөрөвдүгээрт: Чөлөөтэй улс төрийн олон нийт нь сонирхлын зөрчилтэй талууд шударга харилцан буултад хүрэх боломжийг бүрдүүлэх чухал нөхцөл юм.

Тавдугаарт: Иргэний нийгэм нь нэг талаас ардчилсан оролцоо, улс төрийн бие даасан шийдлийн илэрхийлэл нөгөө талаас улс төрийн олон нийт, улс төрийн системд ардчилсан зарчмаар нөлөөлөх нөлөө бүхий хэрэгсэл юм.

Зургаадугаарт: Боловсрол, соёл, эдийн засаг, захиргаа, хэвлэл мэдээлэл зэрэг нийгмийн дэд салбаруудын ардчилал нь нийгмийн автономит байдлын бодит түвшинг тогтооход чухал үүрэгтэй бөгөөд нийгмийн улс төрийн соёлыг төлөвшүүлэхэд чухал нөлөөтэй элемент юм.

Долоодугаарт: Нийгмийн баримжаат төр нь нийгмийн

хамгааллын системүүдийн нэгдэл учраас нийгмийн болон-бүтцийн эрсдэлүүдээс нийгмийн баталгаат байдлыг хамгаалах чухал хэрэгсэл мөн.

Наймдугаарт: Эдийн засгийн үндсэн зарчмууд нь хараат хөдөлмөр эрхлэгсдийн нийгмийн автономит байдлын түвшинг илэрхийлэгч бөгөөд хөдөлмөрийн болон тарифын нөхцөлүүдийг тогтооход шийдвэрлэх хэрэгсэл болж төрийн болон нийгмийн үйлчилгээний түвшинг тодорхойлж байдаг.

Есдүгээрт: Эдийн засгийн зохицуулалт нь эдийн засгийн процессуудыг нэн ялангуяа хөдөлмөрлөх болон байгаль орчныг хамгаалах чиглэлээр үндсэн эрхүүдийг хангах зорилгоор зохион байгуулах баталгаа нь болдог.

Аравдугаарт: Компаниудын үйл ажиллагааны үндсэн зарчмууд нь ямар ашиг сонирхол, нийгмийн үнэлэмж, эрхүүдийг компаниудын бодлогод харгалзан үзэх бэ? гэдгийг шийдвэрлэдэг.

Арваннэгдүгээрт: Үндэстэн дамнасан зохицуулалтын бодлого нь нээлттэй эдийн засаг, даяаршсан дэлхий дээр зах зээлийн улс төрийн хүрээллийг тогтоох буюу зах зээлд улс төрийн хариуцлага ногдуулах чухал нөхцөлүүдийн нэг юм.

Арванхоёрдугаарт: Боловсролын систем нь нийгэмд амьдралын тэгш боломжийг хангах түлхүүр нь юм.

3.2 Актёрууд, системүүд ба стратегиуд

Нийгмийн ардчиллын онол болон бодлогын түүх нь дийлэнх олонхын сонирхлыг нэгтгэсэн, хэрэгжих боломж бүхий үйл ажиллагааны концепцуудыг боловсруулж чадсан тохиолдолд орчин цагийн нийгмийг үндсээр нь өөрчлөх боломжтой гэдэг төсөөлөл дээр суурилсан. Нийгмийн бүхий л дэд салбаруудыг

бүрэн ардчилах нь уламжлалын дагуу нийгмийн ардчиллын шаардлагуудыг биелүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ гэсэн үг юм. Ингэхдээ нийгмийн харилцаануудыг өргөн хүрээнд «өөрчлөх боломж»-той гэж үзсэн. Энэ утгаараа нийгмийн ардчиллын төсөл нь рационал - бүтээн байгуулалтын парадигма дээр суурилдаг. Эдгээр дүгнэлтүүдийг орчин үеийн нийгмийн практик үйл ажиллагааны туршлага дээр үндэслэн хийсэн тул үүгээрээ ортодокс социализмын онолын гэнэн утопи үзлээс ялгаатай. Нийгмийн ардчиллын хуучны бусад загварууд нь үйл ажиллагааны онолын хураангуйлсан таамаглалууд дээр суурилдаг. Эдгээр нь олон тооны онолын сул талуудад хүргэж өнөөг хүртэл шинжлэх ухааны болон улс төрийн практикийн хувьд тэдгээрийн сул талуудыг харуулж байна.

Нийгмийн ардчиллын орчин үеийн онол нь актёруудын онолын шийдлийг гарааны цэгээ болгон сонгох ёстой. Дээрх шийдэл нь эхнээсээ актёруудын өнцгөөс харахад үйл ажиллагааны ямар концепцууд хэрэгжих боломжтой бэ?, ямар хязгаарлалтуудтай тулгарах бэ? ямар нөөц бололцоо байна? системийн ямар нөхцөлүүд тухай бүрд тулгарах бэ? гэдгийг харгалзан үздэг. Актёруудын онолын шийдэл нь үйл ажиллагааны болон системийн онолын нэгдэл бөгөөд уг шийдэлд нэн ялангуяа нийгмийн актёруудын сонирхлын-болон нөлөөллийн бүтцийг тооцоолсны үндсэн дээр нийгмийн дэд системүүдийн зөрүүтэй байдлыг тайлбарладаг. Актёруудын онолын онцлог асуудлууд нь:

- Актёруудын ашиг сонирхол, учир шалтгаанууд байгууллагууд болон системийн бүтцэд хэрхэн тусгалаа олдог бэ?
- Үйл ажиллагаа явуулж буй актёруудын сонирхол нийгмийн дэд системүүдэд ямар үүрэг гүйцэтгэдэг бэ?
- Нийгмийн байгууллагууд болон дэд системүүдэд үйл ажиллагаа явуулж буй актёрууд ямар онцлог хязгаарлалтуудтай тулгардаг бэ?
- Нийгмийн дэд системийн үйл ажиллагааны чиг хандлага

- актёруудын үйл ажиллагаанд ямар шаардлагуудыг тавьдаг бэ?
- Нийгмийн үүргийн системүүдийн өөрийгөө өөрчлөх нөхцөл, орон зай хаана оршдог бэ?

Нийгмийн дэд системүүдийн нийгмийн хөгжилд оруулж буй онцлог хувь нэмэр, нэн ялангуяа үйл ажиллагааны логик нь хоорондоо ялгаатай байдаг. Нийгмийн дэд системүүд нь бодлогын зорилтот өөрчлөлт болон ардчилах процессод тодорхой хязгааруудын хооронд нээлттэй байдаг. Учир нь дэд систем бүр тухайлбал эдийн засаг, шинжлэх ухааны салбарууд өөрийн дотоод зохицуулалтын дагуу нийгмийн сайн сайхны төлөө хувь нэмрээ байнга оруулж байдаг. Нийгмийн ардчиллын шинэчлэлийн төслүүд дараах гурван нөхцөлүүдийг биелүүлсэн байх ёстой:

Нэгдүгээрт: Норматив үндэслэл сайтай байх ёстой. **Хоёрдугаарт:** Нийгмийн дэд системүүдийн үүргийн логиктой зарчмын хувьд зөрчилдөхгүй байх ёстой. **Гуравдугаарт:** улс төрийн хүрээнд дийлэнх олонхын сонирхол нийцсэн байх ёстой.

Даяаршлын нээлттэй зах зээлийн нөхцөлд үйл ажиллагаа явуулах нөхцөлүүд улам хязгаарлагдмал, нийлмэл, тодорхой бус, олон талтай болсоор байна. Энэ нь нийгмийн ардчиллын онолын үндсэн асуудал болох үүргээ биелүүлэх чадамжид хүсээгүй саадыг учруулахгүйгээр төрийн зохицуулалтыг ямар хэмжээнд, ямар арга хэрэгслүүдээр дамжуулан хийж болох бэ? гэдэг асуултын хариултыг улам ээдрээтэй болгож байгаа юм.

Улс үндэстнүүдийн бие даасан байдал суларч буй өнөө үед актёруудын зүгээс нээлттэй зах зээлийг зохион байгуулах, нөлөөлөх боломж улам бүр хумигдсаар байна. Энэ нь нийгмийн ардчиллын үр өгөөжтэй - бүтээлч парадигмын шинэ шат эхэлж буйг харуулж байна.

Эндээс эдийн засгийн процессуудад зохицуулалт хийх боломж зарчмын хувьд үгүй болсон гэдэг дүгнэлтийг хийж болохгүй нь ойлгомжтой. Мэдээж өөр өөр ашиг сонирхол, төсөөлөлтэй илүү олон тооны актёрууд оролцох болсноор зохицуулалт нь илүү бэрхшээлтэй, зах зээл илүү нээлттэй болж байна.

3.3 Улс төрийн удирдлага

Нийгмийн ардчилал нь зөвхөн эрх зүйт төрт ардчиллын ерөнхий зарчимд нийцсэн зохистой үзэл баримтлал юм. Учир нь уг үзэл баримтлал төрийн зорилтууд, байгууллагууд, зохион байгуулалтын хэлбэрүүдээрээ дамжуулан хүний болон иргэний түгээмэл эрхүүдийг хэрэгжүүлэх үндсэн зорилготой. Эрх зүйт төрийн ардчилсан үндсэн хуулийн баталгаа нь үндсэн эрхүүдийг хэлбэр төдий баталгаажуулдаг. Бүх иргэдийн үндсэн эрхүүдийн бодит нөлөөллийг эрх зүйт төр өөрөө хангадаггүй. Тэдгээрийн хэрэгжилт зөвхөн нийгмийн өөрөө өөртөө үзүүлэх нөлөөгөөр биеллээ олдог. Үндсэн эрхүүдийг нийгмийн бодлого зохицуулалт, ба улс төрийн зохицуулалт, хуваарилалтын бодлогоо дамжуулан хэрэгжүүлдэг.

Хүмүүсийн үндсэн эрхүүд бодитойгоор нөлөөлөхгүй байгаа нийгмийн бүхий л салбарууд нь бодлого зохицуулалтын объект юм. Тэдгээрийг улс төрөөс удирдах ёстой. Улс төрийн удирдлага нь нийгэм өөрийн бүтэц, байгууллагуудаараа болон идэвх санаачилгаараа дамжуулан өөртөө нөлөөлөх бүхий л арга хэмжээнүүдийг багтаасан цогц ойлголт юм. Төр нь заавал биелэгдэх шийдвэрүүдийг гаргадаг, үүрэг ногдуулах үйл ажиллагааны хөтөлбөрүүдийг боловсруулдаг улс төрийн бүх байгууллагуудыг нэгтгэж байдаг. Төрөөр дамжуулан нийгэм өөрийн зохицуулалтыг хийж байдаг. Харин иргэний нийгэм, олон нийт нийгмийн ямар салбаруудад төрийн зохицуулалт шаардлагатай байгааг хамтран шийдвэрлэж байдаг. Энэ үйл явцын дунд иргэний нийгэм, олон нийт тэдгээрийн зохицуулалтын нөлөө хөгжиж байдаг.

Орчин үеийн нийгэмд улс төрийн өөрийн зохицуулалтын гурван хэрэгсэл байдаг. Эдгээр нь төр, зах зээл, иргэний нийгэм юм. Эдгээрийг хооронд нь янз бүрийн харьцаагаар хослуулах боломжтой. Зохицуулалтын эдгээр гурван хэрэгслийн алийг нь улс төрийн зорилгыг хэрэгжүүлэхийн төлөө ашиглах бэ гэдэг нь өөрөө улс төрийн асуудал юм. Энэ сонголтод дээрх хэрэгсэл тус бүрийн улс орнуудын туршлагаар батлагдсан нөлөөллийн нөхцөлүүд, нөлөөллийн хязгаарууд, хүсээгүй үр дагавар, нөлөөнүүдийг тооцоолж түүнчлэн иргэдийн үйл ажиллагааны автономит байдлыг хангах болон иргэдийн оролцоог хангасан нийгмийн хариуцлагын нөхцөлүүдэд тохирох эсэх зэрэг үнэлэмжийн шийдвэрүүдийг харгалзан үзэх ёстой.

Нийгмийн зохицуулалтын дээрх гурван хэрэгслүүд хүн төрөлхтний түүхийн бүхий л үед чухал үүрэг гүйцэтгэсээр ирсэн. Уг хэрэгслүүдийн харилцан үйлчлэл эринээс эринд, эрин зууны тодорхой үеүдэд өөрчлөгдсөөр ирсэн. Жишээ нь: ортодокс социализмын гол төлөөлөгчид хоёрдугаар дайны дараа нэлээд удаан хугацаанд төр бол нийгмийн хамт олны хүсэл зоригийн логик илэрхийлэл тул төрийн үйл ажиллагааг бүхнийг манлайлах чадамжтай гэж үзэж иргэний нийгмийн болон зах зээлийн удирдлагын ач холбогдлыг ойшоож үздэггүй байлаа. Харин хуучны ортодокс либерализмын төлөөлөгчид удирдлагын хэрэгслүүдийн ач холбогдлыг огт өөрөөр үнэлдэг байжээ. Тэд зах зээлийг төрийн болон иргэний нийгмийн үйл ажиллагааны нөхцөлүүдээс огт салангид гэж үзэн зах зээл бүхнийг удирдаж чадна гэж үздэг байжээ.

Нийгмийн удирдлагын хэрэгслүүдийн хорьдугаар зууны олон талт туршлага, тэдгээрт дүн шинжилгээ хийж тайлбарласан тоо томшгүй олон шинжлэх ухааны бүтээлүүдээс дараах дүгнэлтүүд урган гарч байгаа юм.

Төр, зах зээл, иргэний нийгэм

Нэгдүгээрт: Удирдлагын дээрх гурван хэрэгсэл нь гурвуулаа түгээмэл сонирхолд нийцсэн бодлогыг хэрэгжүүлэхэд өөрсдийн онцлогтой холбоотой үүргийн доголдолтой учраас зөвхөн хязгаарлагдмал хүрээнд хэрэглэхэд тохиромжтой. Аль нэгнээр нь төгс удирдлага хийх бололцоогүй.

Хоёрдугаарт: Удирдлагын аль нэг хэрэгслийг монополь хэлбэрээр сонгож авах гэсэн оролдлого бүр зөрчилтэй тулгардаг гэдгийг амьдрал дээр туршлагуудаар батлагдсан. Улс төрийн практик дээр удирдлагын хэрэгслүүдийг олон талт микс-холимог хэлбэрээр ашигладаг.

Гуравдугаарт: Аливаа нэг чиг хандлага буюу сонирхолд чиглэгдсэн бодлого улс төрийн үнэт зүйлс дээр суурилсан зарчмын парагматизмаас хэлбийх үед тухайн нөхцөл байдалд тохирсон улс төрийн удирдлагын асуудлуудыг тухайн нийгэмд удирдлагын гурван хэрэгслүүдийг гурвууланг нь тодорхой харьцаатайгаар оролцуулан шийдвэрлэдэг.

Дөрөвдүгээрт: Улс төрийн удирдлагын гурван хэрэгслүүдийг тодорхой харьцаагаар хослуулан хэрэглэснээс гарах үр дүн нь нэг талаас тухайн нийгмийн улс төрийн соёл, нийгмийн капиталаас нөгөө талаас уг хэрэгслүүдийг хэрэгсэл тус бүрийн давуутай талуудыг хамгийн их, сул талууд хамгийн бага байхаар хослуулж тэдгээрийн харилцан үйлчлэл хүссэн хэмжээнд удирдлагын хүссэн нөлөөг үзүүлж чадаж буй эсэхээс хамаарна.

Тавдугаарт: Дээрх хэрэгслүүдийн улс төрийн хэрэглээний үр дүн хэмжигдэхүйц байх ёстой. Хуримтлуулсан туршлагаа дутагдлыг дотроосоо засаж залруулахад ашиглах ёстой. Учир нь практик дээр уг хэрэгслүүдийн онцлог давуу болон сул талууд тэдгээрийг хэрэглэж буй актёруудын соёлын нөхцөлүүд өөрчлөгдөхийн хэрээр байнга өөрчлөгдөж байдаг.

Клаус Оффе өнөөгийн эрин үед дээрх гурван хэрэгслүүд ямар ач холбогдолтой бэ? гэдэг судалгаа хийсэн байна. Зах зээлийн логик олон үндэстний болон үндэсний түвшинд асар хурдацтай, үр дагавар ихтэй өргөжин тэлж нийгмийн болон эдийн засгийн даяаршлын нөлөөгөөр улс үндэстнүүдийн төрийн үйл ажиллагааны чадамж хязгаарлагдаж байгаа өнөө үед нийгмийн болон улс төрийн үндсэн байгууллагуудыг шинэ дизайнтайгаар шинэчлэн зохион байгуулах шаардлагатай болжээ. Нийгмийн зохицуулалтын механизмын үндсэн гурван хэрэгслүүд болох зах зээл, төр, нийгмийн зөв харьцааг тогтоохын тулд тэдгээрт харьяалагддаг удирдлагын хэрэгслүүд болох мөнгө, эрх мэдэл, эв санааны нэгдэл нь нөхцөл байдал өөрчлөгдөх бүрд шинэчлэгдэн тогтоогдож, өөрчлөгдөж байх учиртай. Эдийн засгийн даяаршлын шинэ давалгаа эхэлснээс хойших хэдэн арван жилийн дотор хуримтлагдсан байгаль орчны болон нийгмийн туршлагууд нь өнөөгийн нийгмийн зохицуулалтын шинэ шаардлагад нийцүүлэн соёлын болон улс төрийн удирдлагын боломжуудыг өөрчлөн зохион байгуулах шаардлага байгааг бидэнд харууллаа. Орчин үед улс үндэстнүүдийн төрийн зохицуулах чадвар дараах хоёр шалтгааны улмаас суларч байна. Нэг талаас орчин үеийн нийгэмд төрийн төвлөрсөн, хүнд сурталтай оролцоо зохисгүй, үр дүнгүй гэдэг нь нотлогдсон. Нөгөө талаас залуу үеийнхний дийлэнх олонхын идэвх чармайлтын чиг хандлага өөрчлөгдөж өнөөг хүртэл онцгой хэлбэрээр төрийн оролцоог хэрэгжүүлдэг, улс төрийн боловсролыг олгодог байсан улс төрийн системийн томоохон байгууллагуудыг сонирхох сонирхол нь улам буурч байна. Энэ нь нийгмийн болон улс төрийн удирдлагын шинэ хэлбэрүүд шаардлагатай болсныг харуулж байна. Төрийн шууд бус бусад актёруудыг дэмжсэн үйл ажиллагаа, иргэний нийгмийн идэвхтэй оролцоо, төр, зах зээл, иргэний нийгмийн хамтын ажиллагааны шинэ хэлбэрүүд улам бүр ач холбогдолтой болсоор байна.

3.4 Нийгмийг ардчилах

Либертар ардчилалд нийгмийг ардчилах тухай ойлголт анхнаасаа байгаагүй. Либертар ардчилал өөрийн зохицуулалттай зах зээл, өмчлөх хязгааргүй эрх, гэрээний эрх чөлөө нь хүний болон иргэний эрхүүдийг бүрэн хэрэгжүүлэх үндэс гэж үздэг. Нийгэм бол төр болон улс төрөөс ангид байх хувийн орчин гэж үздэг учраас нийгмийн болон бүтцийн эрсдэлийн улмаас түгээмэл үндсэн эрхүүдэд учирч болзошгүй аюул, тэгш бус байдал, нийгмийн хараат байдлыг огт харгалзан үздэггүй байсан. Ингэснээр либертар ардчилалд нийгмийн үүргийн системүүдийг ардчилах төслүүдийг тэгш эрх чөлөөтэй байх үндсэн эрхтэй уялдуулан хэрэгжүүлэх нөхцөл үгүй юм.

Харин нийгмийн ардчилалд нийгмийг ардчилах нь хамгийн чухал асуудал мөн. Нийгмийн ардчиллын үзэл баримтлалаар чухам нийгмийн дэд системүүдэд үндсэн эрхүүдийн бодит хэрэгжилт хангагдсан байх ёстой. Эдийн засаг, боловсрол, хэвлэл мэдээлэл, захиргаа, нийгмийн хамгаалал ер нь бүхий л дэд системд ардчилал ба улс төрийн үндсэн асуудал болох үндсэн эрхүүд, шударга ёсыг хэрхэн баталгаажуулах бэ? гэдэг асуудал тавигдаж байдаг. Нийгмийн үүргийн системүүдэд ажиллагсад нийт нийгмийн сайн сайхны төлөө ямар хувь нэмэр оруулж чадах бэ? оруулж байх ёстой бэ? зэрэг асуудал байнга тавигдаж байдаг.

Нийгмийн ардчилал бол нийгмийн бүх дэд системүүдийг бүрэн ардчилах тухай ойлголт мөн хэмээх ортодокс социализмын таамаглал орчин үеийн нийгэмд боломжгүй зүйл юм. Үүнд дараах шалтгаанууд байна: Нийгмийн дэд системүүд нь нийт нийгмийн сайн сайханд нөлөөлдөг учраас тэдгээрийн ерөнхий зарчмуудын тухай шийдвэр (үүргийн логик, хариуцлагын харилцааны зохион байгуулалт), гагцхүү нийгэмд хүлээн зөвшөөрөгдсөн ардчиллын түвшинд гардаг. Энэ түвшинд гарсан шийдвэрүүд нь улс төрийн шийдвэр байдаг учраас

олон нийтэд тайлбарлан таниулж хууль ёсных хэмээн хүлээн зөвшөөрүүлэх шаардлагатай. Аль ч дэд систем өөрийн бүтэц, нөлөөлөх арга зам, нийгэмд үзүүлэх үр дагаврыг хуулиар хүлээн зөвшөөрөгдсөн бодлогын хүрээнд зохион байгуулах ёстой. Нийгмийн аль нэг дэд систем, нэн ялангуяа улс орны эдийн засгийн дэд системийн гаргасан шийдвэрийн нөлөө тухайн системийн үйл ажиллагааны хүрээнээс хальсан бол уг шийдвэрийг хууль ёсны гэж үзэх боломжгүй. Нийгмийн дэд системүүдийн ерөнхий зарчмуудын талаар гаргасан улс төрийн шийдвэрт хамрагдах бүх хүмүүсийн үндсэн эрхүүдийг хүндэтгэн үзэх ёстой.

«Нийгмийг ардчилах» тухай ойлголт харьцангуй байдлаар эдийн засгийн салбарт нэн ялангуяа үйлдвэрлэлийн болон компанийн удирдлагад хамт олны шийдвэр гаргалтад оролцох эрхийн асуудалд ач холбогдолтой хэвээр байна. Харин уг ойлголтыг нийгмийн дэд систем бүрд тухайн системд ажиллагсдын ардчилсан олонхын зарчмыг зохион байгуулах ёстой ч эсхүл байвал зохистой хэмээх төсөөлөлтэй холбох юм бол утгагүй болно.

Үүрэгт нийцсэн оролцоо

Нийгмийн ардчилал нь нийгмийн дэд системүүдээс үүрэгт нийцсэн оролцоог шаарддаг. Үүрэгт нийцсэн оролцоог оролцогсдын үндсэн эрхүүд болон тухайн онцлог тохиолдолд тохирсон үүргийн логик дээр тулгуурлан тодорхойлдог. Үүнд дараах нөхцөлүүд байна:

Нэгдүгээрт: Шийдвэр гаргалтад оролцох оролцоо нь нийгмийн хамтын ажиллагааны бүхий л салбарт үндсэн эрхүүдийн хэрэгжилт, ач холбогдлыг баталгаажуулж өгдөг.

Хоёрдугаарт: Шийдвэр гаргалтад оролцох оролцоо нь зарчмын хувьд тухайн дэд системийн нийт нийгэмд болон бусад дэд

системүүдэд гүйцэтгэх үүрэг, үр өгөөжийг нэмэгдүүлж байдаг.

Гуравдугаарт: Ардчилах явцад дэд системүүдэд олон нийт бүрддэг учраас шийдвэр гаргалтад оролцох оролцоо нь нийгэмд ардчилсан зохицуулалт хийх боломжуудыг нэмэгдүүлдэг.

Нийгмийн үүргийн салбаруудыг бүрэн ардчилах нь нийгмийн ардчиллын ерөнхий зарчмууд үүргийн нөхцөлүүдтэй зөрчилддөг. Үүргийн салбаруудад зөвшилцөл ба олонхын зарчмыг зохион байгуулах юм бол зарчмын хувьд (хэрэгжүүлэх байгууллагуудыг байгуулах нь):

Дөрөвдүгээрт: Дэд системийн үүргийн логикийн нөлөө, цаашилбал түүний нийгэмд гүйцэтгэх үүргийг доголдуулна.

Тавдугаарт: Дэд системүүдийг удирдах төрийн удирдлагын чадамжийг бууруулна.

Зургаадугаарт: Бүлгүүдийн бие даасан байдлыг ард түмний бие даасан байдлаас дээгүүр тавихад хүргэнэ.

Иймээс нийгмийн ардчилал дэд систем тус бүрийн өөрийн онцлогт тохирсон үүрэгтээ нийцсэн оролцоог хангахыг тэнд ажиллаж буй бүх хүмүүсээс шаарддаг. Нийгмийн ардчилал дараах нөхцөлүүдэд эн тэнцүү үнэлэмжтэйгээр хандахыг шаарддаг:

Долоодугаарт: Дэд системүүдэд ажиллагсдын хүний ёсоор ажиллаж амьдрах эрхийг хангахын тулд тэдний шийдвэр гаргалтад оролцох эрхийн зохистой түвшин хангагдсан байх ёстой. (Нийгмийн автономит байдлыг хангах)

Наймдугаарт: Системийн үүрэгт нийцсэн оролцоог хангах явцдаа олж авсан мэдлэг чадвар, туршлагаа бүрэн дүүрэн

ашиглах боломжийг хүн бүрд олгохуйц хэмжээнд ажиллагсдын хамтын шийдвэрийн эрх хангагдсан байх ёстой.

Есдүгээрт: Дэд системүүдийн үүргийн онцлог логикуудад хэрэгжих хангалттай орон зай өгөгдсөн байх ёстой. Өөрөөр хэлбэл хариуцан ажиллаж буй мэргэжилтнүүдийн гаргасан шийдвэрийнхээ өмнө хүлээх хариуцлага тодорхой байх ёстой.

Аравдугаарт: Ажиллагсдын хамтын шийдвэрт оролцох оролцоо тухайн дэд системийн үүргийн арга хэлбэрт тохирсон байх ёстой.

Нийгмийн дэд системүүдэд ажиллагсдын хамтын шийдвэрт оролцох оролцооны хэлбэрүүд шаардлагатай төдийгүй, үүргээ гүйцэтгэхэд нь дэмжлэг үзүүлдэг. Гэхдээ үүргийн логик болон оролцоо хоёрын хооронд зөв харьцаа бий болсон нөхцөлд л тустай.

Эдийн засгийн компаний хувьд жишээ нь: Хөрөнгө оруулалтын тухай шийдвэр үүргийн логикийн үндсэн салбар юм. Хөрөнгө оруулагчид, тэдний даалгавраар ажиллаж буй хүмүүсийн хувьд хөрөнгө оруулалтын шийдвэр хамгийн чухал. Цалин хөлс олгох, мэргэжил дээшлүүлэх, албан тушаал дэвшүүлэх чиглэлээр ажилтнуудад тэгш хандах зарчмыг хэрэгжүүлэх нь нэн тэргүүнд хүнийг хүндэтгэх асуудал учраас хамтын шийдвэрийн асуудал юм.

Иймээс нийгмийн ардчилал хамтын шийдвэрийг дэд системүүдэд огт үгүйсгэхээс болон дэд системийн бүрэн ардчилал аль алинаас нь татгалздаг. Харин дэд системүүдийн үүрэгт нийцсэн хамтын оролцоо нэн чухал үүрэгтэй.

3.5 Иргэний нийгэм

Нийгмийн ардчилалд иргэний нийгэм шийдвэрлэх үүрэгтэй. Иргэний нийгмийн оролцооны чухлыг дараах эн тэнцүү үнэлэмж бүхий олон шалтгаануудаар нотолж болно:

Нэгдүгээрт: Иргэний нийгмийн үйл ажиллагаанд нийгмийн өөрийн удирдлагын ардчилсан бодлогын эх үүсвэр бүх иргэдээр дамжин бүрэлдэж байдаг.

Хоёрдугаарт: Нийгмийн ардчилсан шийдвэр гаргалтын үйл явцад иргэний нийгэм оролцсоноор иргэдийн ашиг сонирхол тусгагдаж төлөөллийн аргачлалд ардчилсан нөлөөг үзүүлж байдаг.

Гуравдугаарт: Иргэд иргэдийн нийгмийн үйл ажиллагаанд оролцсоноор иргэний үүргээ биелүүлэх үйл ажиллагааны чадамжаа дээшлүүлж байдаг.

Дөрөвдүгээрт: Иргэний нийгмийн байгууллагууд нийгмийн өөртөө туслах, гуравдагч этгээдэд туслах үйл ажиллагааг нийгмийн баримжаат төрийн зүгээс үзүүлж буй туслалцаанаас чанар, тоон болон материаллаг байдлын хувьд иргэдийн нийгмийн хэрэгцээнд илүү нийцсэн байдлаар үзүүлж чаддаг.

Либертар ардчилал иргэний нийгмийн төслүүдийг улс төрийн ашиг сонирхлын өргөн хүрээтэй хувьчлалын стратегитай адилгаж үзэх нь олонтаа. Олонх тохиолдолд зах зээлийн орчныг иргэний нийгэмтэй хольж хутгадаг. Ингэхдээ нийгмийн удирдлагын хэрэгслүүд болох төр - зах, зээл - иргэний нийгэм тус бүрдээ онцлог үйл ажиллагааны салбар, зохицуулалтын нөөцтэй байдаг гэдгийг олж хардаггүй.

Төрийн зохицуулалтын үүргийг сулруулахын зэрэгцээ төрийн хариуцлагыг нийгэмд үүрүүлэх хэлбэрээр тарамдуулж орхивол өөрөөр хэлбэл улс төрийн үүргүүдийг хувьчлах нь идэвхтэй иргэдийн нийгэмтэй байх шаардлагыг сулруулдаг.

Иргэдийн нийгэм нь төрийн бус гэхдээ улс төрийн үйл ажиллагааны концепц юм.

Доорх гурван шалгуур үзүүлэлтүүд иргэний нийгмийн үйл ажиллагааг тодорхойлдог.

- Иргэдийн идэвх санаачилга сайн дурынх байх
- Үйл ажиллагаа нь өөрийн зохион байгуулалттай байх
- Үйл ажиллагаа нь олны тусын тулд чиглэгдсэн байх

Улс төрийн идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг иргэдийн нийгмийн байгууллагууд төрийн байгууллагуудыг орлож чадахгүй. Эрхүүдийг хангах нь төрийн эрх мэдлийн үндсэн үүрэг юм. Иргэний нийгмийн байгууллага нь иргэд өөрсдийн ашиг сонирхлыг тэнцүүлэхийн төлөө нэгддэг хувийн-автономит үйл ажиллагаа биш юм. Иргэний нийгэм нь иргэд хамтын зорилгоо тодорхойлоод түүнийгээ хэрэгжүүлэхийн төлөө эв санааны нэгдэлтэй идэвх чармайлт гарган ажилладаг төрийн бус, гэхдээ улс төрийн үйл ажиллагаа юм.

Иргэний нийгэм дараах нийгмийн болон улс төрийн зургаан үүргийг хэрэгжүүлж чадна:

Нэгдүгээрт: Иргэний нийгэм нь улс төрийн системийн байгууллагуудын өмнө иргэдийн лобби байгууллагын үүрэг гүйцэтгэж нийгмийн ашиг сонирхлыг төлөөлдөг. Энэ утгаараа улс төрийн ардчилсан удирдлага хэрэгжүүлэх нэгэн нөхцөл юм.

Хоёрдугаарт: Иргэний нийгэм нийгэмд улс төрийн өөрийн зохицуулалтын үүргийг гүйцэтгэдэг.

Гуравдугаарт: Иргэний нийгэм улс төрийн санал солилцох, олон нийтийн харилцан ойлголцолд хүргэх арга хэмжээ, санал солилцох диалогийг зохион байгуулдаг.

Дөрөвдүгээрт: Иргэний нийгэм хамтын хүчийг нэгтгэж нийгмийн өөртөө туслах үйл ажиллагааг зохион байгуулдаг.

Тавдугаарт: Иргэний нийгэм нь иргэдийн улс төрийн нийгэмшилд дэмжлэг үзүүлдэг.

Зургаадугаарт: Иргэний нийгэм эв санааны нэгдэл болон нийгмийн капиталыг бий болгож, нөхөн сэргээж байдаг.

Хэдийгээр иргэдийн улс төрийн нийгэмшил, эв санааны нэгдлийг бий болгох нь иргэний нийгмийн үйл ажиллагааны дагавар нөлөө боловч эдгээр нь уг үүргийг хүлээсэн нийгмийн боловсролын системээс илүү найдвартай, баттайгаар иргэний нийгмийн үйл ажиллагааны хүрээнд бүрэлдэн тогтдог. Ийм ч учраас иргэний нийгэм нь ардчиллын бодлого, эв санааны нэгдэлтэйгээр иргэдийг аливаа үйл ажиллагаанд татан оролцуулахад өндөр ач холбогдолтой юм.

Хэвлэл мэдээллийн ардчилалд иргэний нийгмийн форумын үүрэг улам илүү ач холбогдолтой болсоор байна. Чухам энд л хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийн дээрээс доош чиглэсэн нэг урсгалт мэдээлэл, улс төрийн системийн өөрийгөө сурталчлах сурталчилгаа иргэний нийгмийн оролцоотойгоор мэдээлэл харилцан ярилцлагын хэлбэрт шилждэг. Иргэний нийгмийн байгууллагууд иргэдэд олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, улс төрийн томоохон нэгдлүүдийн нөлөөнөөс ангид илүү чөлөөтэй санал бодлоо солилцох, зөвлөлдөх олон нийтийн харилцан ойлголцлын нэгжүүдийг бүрдүүлж өгдөг. Иргэний нийгэм нь ардчилал хууль ёсны байх, нийгмийн шударга ёсыг хэрэгжүүлэхэд чухал үүргийг гүйцэтгэдэг.

Энэ утгаараа иргэний нийгэм нийгмийн өөртөө туслах туслалцааг зохион байгуулж улс төрийн системүүдэд хөндлөнгөөс оролцож, эрх зүйт төрийн байгууллагуудын сүүдэрт өөрийн засаглалыг тогтоож байдаг учраас нийгэмд маш чухал зохицуулалтын үүргийг гүйцэтгэж байдаг. Иргэний нийгэм аливаа нийгмийн ардчиллын чанарыг сайжруулж

байдаг. Иргэний нийгэм үүгээр зогсохгүй хууль ёсны байдал, ардчилал, үр ашгийг нэгтгэх боломжийг бүрдүүлж өгдөг, үүгээрээ өөр ямар нэгэн удирдлагын хэрэгслээр орлуулшгүй үүргийг гүйцэтгэж чаддаг удирдлагын чухал хэрэгсэл мөн.

Иргэний нийгэм нь бүх иргэдэд ардчиллын практикийн тухай ойлголт өгөх, хөгжлийн хувилбарууд, тэдгээрийн туршлага, нотолгооны талаар санал солилцох нөхцөлүүдийг бүрдүүлж байдаг учраас тухайн нийгмийнхээ тусгалын буюу хяналттай ардчиллын маш чухал талбар нь байдаг. Иргэний нийгэм нь мөн ардчилал, хөгжлийн боломжуудын талаар улс төрд суралцах өлгий юм. Нөгөөтээгүүр иргэний нийгэм аливаа нийгмийн улс төрийн соёлын илэрхийлэл, түүнийг үйлдвэрлэгч орчин юм. Энэ утгаараа удирдлагын бусад хэрэгслүүдийг нөхөгч, сайжруулагч биш, харин ардчиллын оршихуйн нэгэн чухал нөхцөл мөн.

Иргэний нийгмийн нийгмийн болон эдийн засгийн чадамж

Иргэний нийгмийн практикийг нийгмийн болон эдийн засгийн нөлөөлөл талаас нь авч үзсэний үндсэн дээр гуравдагч сектор гэдэг ойлголт бий болжээ. Иргэний нийгмийн олон холбоод, байгууллагууд нь нийгмийн аюулгүй байдал, сайн үйлс, чинээлэг амьдралыг үйлдвэрлэгчид юм. Иргэний нийгмийн байгууллагууд нь иргэдийн идэвх санаачилга, оюун санааны болон бие бялдрын эрүүл мэнд, амьдралын утга учрыг таних, туршлага хуримтлуулах, үйл ажиллагааны чиг хандлагыг тогтооход юугаар ч сольшгүй ач холбогдолтой. Мөн гуравдагч секторыг эдийн засгийн шалгуур үзүүлэлтүүд талаас нь авч үзвэл нийгмийн сайн сайхны төлөө үнэлж баршгүй хувь нэмэр оруулдаг. Холбооны Герман Улсад 21 сая сайн дурынхан, 500 000 орчим ашгийн бус байгууллагуудаар дамжуулан жилдээ нийт 2.3 миллиард «ажлын цагийг» гүйцэтгэж байна. Гуравдагч сектор эдийн засгийн хувьд нүдэнд харагдаж гарт

баригдахуйц чинээлэг амьдралыг үйлдвэрлэж байна. Герман орны хувьд нийгмийн сайн сайхны төлөө энэ хэлбэрийн үйлдвэрлэл байнга чухал үүрэг гүйцэтгэсээр ирсэн. Төрийн үүрэг, үйл ажиллагааны хэлбэрийг шинэчлэн томьёолсноор гуравдагч секторыг дахин «шинээр» нээгээд байна.

Төрөөс иргэний нийгмийг идэвхжүүлэх нь

Ардчилсан төр иргэний нийгмийн үйл ажиллагааг дэмжиж идэвхтэй иргэдийн оролцоот нийгэм бүрэлдэн тогтоход дэмжлэг үзүүлэх ёстой. Сөрөг эрх чөлөөний эрхүүд нь эерэг эрх чөлөөний эрхүүдийг хэрэглэх нөхцөлийг бүрдүүлж өгдөг учраас нэг талаас төр сөрөг эрх чөлөөг баталгаажуулж өгөх ёстой. Нөгөө талаас төр иргэний нийгэмд шаардлагатай үед үйл ажиллагаагаа явуулах тогтмол бус бүтцийг нь бүрдүүлж өгөх ёстой. Жишээлбэл төрийн үйлчилгээний байгууллагуудыг иргэдийн цаг үеийн идэвх санаачилга, хэрэгцээний дагуу болон нийгмийн хэтийн чиг хандлагыг урьдчилан харж дэмждэг байхаар өөрчлөн зохион байгуулж болох юм. Соёл, өндөр настнуудын асрамж, дунд сургуулиудад зах зээлийн элемент, төрийн элемент, нийгэм хамт олны элементүүдийг хослуулан хэрэглэх нь их амжилт авчирдаг гэдэг нь батлагдаад байна. Дээрх гурвалсан хэлбэр нь (комбинац нь) үйл ажиллагааны үр өгөөжийг дээшлүүлж, илүү олны тусын тулд хандуулж орон нутгийн асуудлыг орон нутгийн аж амьдралын нөхцөлүүдэд тохируулан шийдвэрлэхэд ихээхэн ач холбогдолтой юм. Зах зээл, төр, нийгэм хамт олныг хоорондоос нь эрс тусгаарлах гэсэн оролдлого явцгүй гэдэг нь улам бүр батлагдсаар байна. Хувийн эдийн засгийн хэрэгслүүдийг төрийн заавар, хамрагдах хүмүүсийн идэвх зүтгэлтэй хослуулсан тохиолдолд дээрх гурван үйл ажиллагааны хэлбэрүүдийн бүх давуу талуудыг тухайн гүйцэтгэх үүргийн хүрээнд нэгтгэсэн үйл ажиллагааны нэгэн шинэ загвар бий болдог. Юуны өмнө иргэдийг идэвхжүүлэгч төрийн шинэ хөтөлбөрүүд хэрэгжүүлэх

газар нь хот тосгод юм. Чухам энд л иргэний нийгмийн идэвх санаачилга хамгийн хүчтэй өрнөж байдаг. Иргэний нийгмийн идэвх санаачилгыг жишээ нь: ажлаас чөлөө олгох, мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулах болон материаллаг ба материаллаг бус бусад хэлбэрээр дэмжих боломжтой. Хамгийн чухал нь хот тосгонууд зөвхөн идэвх санаачилгатай иргэдэд нээлттэй байгаад зогсохгүй улам бүр тоо нь нэмэгдэж байгаа ганцаардмал, итгэл найдвараа гээсэн хүмүүст зориулан зорилтот «татан оролцуулах» стратеги боловсруулан нийгэм хамт олны хамтын шийдвэрт иргэдийн оролцоог нэмэгдүүлэх шаардлагатай. Энэ талаас нь авч үзвэл эдийн засгийн түвшинд ажилгүйчүүд, ганцаардмал хүмүүсийн тоо өсөж энэ нь иргэдийн тэгш оролцооны боломжийг хангах нөхцөлүүдийг боогдуулж байгаа нь хөгжлийн шинэ хандлага «Иргэдийн коммуна» төслийн хязгааруудыг харуулж байна.

Иргэний нийгэм үүргээ биелүүлэх нэг үндсэн нөхцөл нь төр хүмүүсийн амьдралын баталгаанд зайлшгүй шаардагдах нийгмийн болон эдийн засгийн нөхцөлүүдийг бүрдүүлсэн байх явдал. Энэ утгаараа иргэний нийгэм нийгмийн ардчиллын бодлогын хамгийн чухал төсөл мөн боловч төрийн нийгмийн болон эдийн засгийн бодлогыг орлохгүй.

Даяаршлын үйл ажиллагааны талбарууд

Даяаршлын ардчиллын бүхий л төслүүдэд иргэний нийгмийн актёрууд гол дүрд тоглодог. Иргэний нийгэм бүс нутгийн бодлогын хамтын ажиллагааны сүлжээг үүсгэж, бэхжүүлж, Нэгдсэн Үндэстний Байгууллага, даяаршлын байгуулал зэрэг олон улсын байгууллагуудын ардчилагдах процессод хувь нэмрээ оруулж, өөрөө даяаршлын улс төрийн зохицуулалтын элементийн үүргийг гүйцэтгэж байдаг. Орчин цагт төрийн бус байгууллагуудын тоо их хурдацтайгаар өсөж байна. Даяаршлын тавцан дээр иргэний нийгмийн байгууллагууд зах зээлийн ноёрхлын эсрэг зогсож зах зээлийг нийгэм, байгаль

орчин, макро эдийн засгийн зохицуулалтын бодлогод татан оролцуулах чиглэлээр голлон ажилладаг актёруудын үүргийг гүйцэтгэж байна. Даяаршилд шийдвэрлэх үүрэгтэй олон асуудлууд ТББ -аар дамжин олон нийтийн анхааралд хүрч байна. Түүнээс гадна ТББ-ууд олон улсын гэрээ хэлцлүүд мөрдөгдөж буй эсэхэд хяналт тавьдаг.

Иргэний нийгэм, ёс зүйн болон соёлын нэгдэл

Орчин цагийн олон талт соёл бүхий нийгмийн нэгдэлд иргэд хэдийгээр өөр өөр соёл, ёс заншилтай ч ардчиллын нэгдсэн соёлыг бүрдүүлж чадсан эсэх нь шийдвэрлэх үүрэгтэй байдаг. Иймээс улс төрийн иргэний нийгмийн байгууллагуудад олон талт соёлтой ардчиллын тогтвортой байдлыг хангахын тулд нийгмийн нэгдлийг дэмжих үүргийг гүйцэтгэдэг. Нэн ялангуяа иргэний нийгэм өөрөө мөн олон соёлт иргэдийн нэгдэл учраас нийгэм хамт олны ашиг сонирхлын төлөө үндсэн чиг хандлага тогтоох үүргийг илүү сайн биелүүлдэг. Өөр өөр соёл иргэншилд хамаарагддаг хүмүүс нийгэм, байгаль орчин, спорт, хотын тодорхой дүүргийн төслүүд дээр хамтран ажиллах тохиолдолд нийгмийн нэгдэл хамгийн сайн бүрдэж чаддаг.

Иргэний нийгмийн соёлын нэгдлийг бэхжүүлэх үүрэг даяаршлын эрин үед давхар ач холбогдолтой болж байна. Нэг талаас хотуудын хүн ам улам бүр нэмэгдэж буй цагаачлалын урсгалын улмаас улам олон талт соёлтой болж байна. Нөгөө талаас даяаршлын улмаас бий болсон нийгэм, эдийн засаг, байгаль орчны асуудлууд орон нутгийн түвшинд илүү тод болж байна. Иймээс иргэний нийгэм улам бүр өсөн нэмэгдэж буй нийгмийн болон соёлын туйлшралыг саармагжуулах, зөрчилдөөнийг намжаахад өөрийн хувь нэмрийг оруулж байна.

Шударга ёс ба иргэний нийгэм

Иргэний нийгэмтэй холбогдуулаад жишээлбэл Голландын «Хөдөлмөрийн нам» дээр нийгмийн ардчиллын үзэл баримтлал

Михаел Вальцерийн санал болгосон шиг шударга ёсны концепцын шинэ үлгэр жишээ болох уу? үгүй юу гэдэг талаар маргаан өрнөсөн байна. Уг концепц нь орлогын тусламж, сургуулийн тусламж, орон сууцны дэмжлэг зэрэг чухал үндсэн үйлчилгээний хуваарилалт ирээдүйд тухайн оршин сууж буй нутаг, хөршүүдийн хүрээнд шийдвэрлэгдэж байх нь зүйтэй гэсэн шаардлагыг агуулдаг. Эмзэг бүлгийнхэн - бусдын туслалцаа хэрэгтэй хүмүүсийг таньдаг, тэдний амьдрал аж байдлыг мэддэг, эцэст нь тэдэнд үзүүлэх туслалцааг өөрсдөөсөө гаргах иргэд ямар хэлбэрийн туслалцаа хэр хэмжээгээр шаардлагатай бэ? гэдгийг шийдвэрлэх нь хамгийн оновчтой гэж үздэг.

Гэхдээ уг орон нутгийн концепцод маргаантай асуудал их бий. Нийгмийн амьдралын нөхцөлүүдийн баталгаа дан ганц хөрш иргэдийн сайн санаа, үнэлэмжээс хамаарах тул бусдын туслалцаа хэрэгтэй хүмүүст үзүүлэх туслалцаа тэдэнд хэр таалагдахаас шалтгаалах нь. Муугаар бодоход амьжиргааны зайлшгүй хэрэгцээт зүйлсийг олгохоос татгалзах шийдвэр гарч болзошгүй бөгөөд энэ нь хүний ёсоор амьдрах тэгш бололцоогоор иргэн бүрийг хангах зарчим зөрчигдөхөд хүргэнэ. Нөгөөтээгүүр энэхүү шударга ёсны концепц нь зарим хөршүүд хоорондоо маш сайн туслалцаж зарим нь бие биедээ огт туслахгүй байж болох учраас нийгмийн үндсэн хангамжид тэгш бус байдал үүсгэж болзошгүй юм. Нөгөө талаар уг концепц иргэн бүр өөрийн нийгмийн байдлыг хангуулах эрхгүй тул бусдад хүндлэгдэх үндсэн хэрэгцээг зөрчиж байгаа юм. Энэ нь нийгмийн баримжаат төрийг иргэний нийгмээр орлуулах боломжгүй гэдгийг харуулж байна. Хүний ёсоор амьдрахад шаардагдах материаллаг нөхцөлөөр хангуулах үндсэн баталгаа иргэний нийгмийн идэвх санаачилгаас хамаардаг байж таарахгүй.

Нөөц, хэмнэлт, хязгаарууд

Нийгмийн ардчиллын онолоор иргэний нийгэм дараах үүргүүдийг гүйцэтгэх боломжтой:

Иргэний нийгмийн үүргүүд

- Сонгон авсан үйл ажиллагааны салбаруудад нийгмийг ардчилах
- Олон нийтийн санаа бодлыг бүрдүүлэхэд иргэдийн нөлөөллийн чадамжийг сайжруулах
- Эв санааны нэгдлийн зарчим дээр суурилсан өөртөө туслах туслалцааг зохион байгуулах
- Захиргааны үйл ажиллагаа, улс төрийн төлөвлөлтийн алдааг ардчилсан хэлбэрээр засах, залруулах
- Зах зээлийн системийн «бэрхшээлтэй» үр дагавруудыг арилгах, засаж залруулах, (Орон нутгийн эдийн засгийн актёруудыг иргэний нийгмийн сүлжээнд татан оролцуулах)
- Эв санааны нэгдлийн үйл ажиллагааг шаардлагатай тохиолдолд бүтцээр хангах
- Иргэдийг үүргээ биелүүлэхэд уриалах, шаардах

Иргэний нийгэм шууд ардчилал, эв санааны нэгдлийн үйл ажиллагааны практикт өргөн боломжийг нээж өгдөг. 1990-ээд оноос Европт улс төрийн намуудын нөлөө буурч байгаа нь иргэний нийгмийн нийгмийн ардчилалд гүйцэтгэх ролийг улам бүр нэмэгдүүлсэн байна. Даяаршлын улмаас амьдралын болон хөдөлмөрийн харилцааны нөхцөлд гарсан өөрчлөлтүүдийг зөвхөн орон нутгийн, бүс нутгийн хүрээнд зохистойгоор улс төрийн аргаар судалж шийдвэрлэх нь илүү үр өгөөжтэй. Энэ нь иргэний нийгмийн үйл ажиллагааны үндсэн талбар юм. Гэхдээ иргэний нийгэм ямар ч тохиолдолд нийгмийн удирдлагын бүх ачааг үүрэх боломжгүй. Иргэдийн нийгмийн эрх хангагдсан байх нь ямар ч тохиолдолд нийгмийн ардчилал хэрэгжих үндсэн нөхцөл юм.

3.6 Олон нийт Олон нийт ба ардчилал

Нээлттэй, мэтгэлцээний идэвхтэй улс төрийн олон нийт нийгмийн ардчиллын нэг үндсэн элемент юм. Олон нийт нь нийгмийн шударга ёсны тухай нэгдсэн ойлголт практик

мэтгэлцээний үр дүнд тогтож эдгээр нь улс төрийн үйл ажиллагааны төслүүдэд тусгалаа олох нөхцөлийг бүрдүүлдэг. Энэ нь нийгмийн ардчилалд улс төрийн нэгдэл бүрэлдэх үндсэн нөхцөлүүдийн нэг мөн. Идэвх санаачилгатай олон нийт хүмүүсийг мэдээлэл, нотолгоогоор хангаад зогсохгүй, иргэдэд нийгэм хамт олныг хэрхэн зөв зохистой зохион байгуулах тухай үнэлэмжид тулгуурласан нэгдсэн ойлголт бий болох боломжийг хангаж өгдөг. Жишээ нь: боловсрол, нийгэм, эдийн засгийн бодлогын үүднээс.

Орчин үеийн мэдээллийн эрин үед бодит байдал дээр өрнөж буй олон нийтийн мэтгэлцээнд илтгэх урлаг, үзэл санаа, гоо зүйн болон зар сурталчилгааны нотолгооны элементүүд нөлөөлж байна. Олон нийт зөвхөн тодорхой нотолгооны хүрээнд мэтгэлцээн өрнүүлдэг гэж үзэх нь мэдээж өрөөсгөл ойлголт. Хэвлэл мэдээллийн олон нийт цэнгээнт нэвтрүүлэг, худалдан авах харьцаанд нөлөөлөх, гоо зүй, мэдээлэл, олон нийтийн санаа бодлыг бүрдүүлэх, сэтгэл түгшээсэн, баяр хөөртэй нэвтрүүлгүүдийг холин нэвтрүүлж байна.

Хэвлэл мэдээллийн ертөнц хэдийгээр ийм холимог боловч тэдгээр нь олон нийт ардчиллын өмнө үүрэг хүлээдэг тул тэдэнд нотолгоонд суурилсан мэдээллүүд түгээх ёстой.

Европт ардчиллын ойлголтын мөн чанар өөрчлөгдөж байна. Улс төрийн намуудын ардчилал хэвлэл мэдээллийн ардчилал болон өөрчлөгдөж байна. Энэ хооронд улс төр олны анхаарал ихээр татсан үйл явдлуудад илүүтэй ач холбогдол өгдөг, тэдгээрийг маш өндөр мэргэшсэн хүмүүс сүржин зураглалтайгаар сэтгэл татахуйц дэглэн найруулж олон нийтэд хүргэдэг мэдээллийн системийн ноёрхолд автаад байна. Харин сонгодог улс төрийн намуудын ардчиллын үед иргэдэд үнэн бодит санаа бодлоо бүрдүүлэх боломж олгохын тулд хэвлэл мэдээллийн хэрэгслүүд улс төрийг ажиглах үүрэгтэй байдаг бол хэвлэл мэдээллийн ардчиллын үед улс төрийн актёрууд

бодлого, үйл ажиллагаагаа олон нийтэд илүү үр дүнтэй хүргэх, хэвлэл мэдээллийн тавцан дээр аль болохоор өөрийн хяналтад байлгаж чадах байр суурийг олж авахын тулд хэвлэл мэдээллийн системийг ажиглаж байдаг. Ийнхүү «улс төрийг хийх» нь улс төрийг илүү сонирхолтой болгож үзэгч, сонсогчдын тоог нэмэгдүүлдэг. Гэхдээ улс төрийн бодит үйл явдлуудад хангалттай анхаарал хандуулж чадаж буй эсэх, баталгаа нотолгоонуудыг харилцан солилцож чадаж буй эсэх эргэлзээ төрүүлдэг.

Хэвлэл мэдээллийн хэрэгслүүд улс төрийг ямар найруулга, дэглэлттэйгээр олон нийтэд хүргэж байна бэ?

Улс төр өөрийн танилцуулгаа хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр гаднаас нь харахад мэргэжлийн маш өндөр түвшинд голдуу театрын дүрэм журмуудын дагуу олон нийтэд хүргэдэг бөгөөд сүүлийн үед энэ нь улс төрийн системийн үндсэн үйл ажиллагаа болон хувираад байна. Улс төрийн дэглэлт, найруулгад дараах гурван стратеги хамгийн ихээр ажиглагддаг.

1. Үйл явдлын улс төр (**Event - Politik**): Үйл явдлуудыг зөвхөн хэвлэл мэдээлэлд зориулан найруулдаг. Бодит үйл явдлуудыг илүү аядуу, гоёчилсон, өнгөлөн далдалсан хэлбэрт оруулдаг.
2. Дүрийн (имежийн) улс төр (**Image - Politik**): Хувь хүмүүст нийгмийн хамгийн их хүсэн хүлээж буй дүрийг бий болгож өгөхийн тулд маш сайн тооцоолсон зохиомол үйл ажиллагаануудыг зохион байгуулдаг.
3. Бэлэг тэмдгийн чанартай өнгөц улс төр: Үйл явдлуудыг хэвлэл мэдээллийн хэрэгслүүд байгаа байдлаас нь илүүтэйгээр гоё сайхнаар дүрслэн үзүүлдэг.

Хэвлэл мэдээллийн ардчилалд бодлого, тэдгээрийн бодит хэрэгжилтүүдийг зарчмын хувьд хооронд нь салгаж орхидог. Үзэгч сонсогчид аль нь шуугиан дэгдээхийн төлөө явагдаж байгаа, аль нь болсон явдал бэ? гэдгийг хооронд нь ялгаж чадахаа больдог.

Орчин үеийн олны хүртээл болсон хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийн эдийн засаг

Орчин үеийн олны хүртээл болсон хэвлэл мэдээллийн хэрэгслүүд эдийн засгийн логик дээр суурилдаг. Тэдний бүтээгдэхүүнүүд таваарын шинж чанартай, тэдгээрийн борлуулалтын хэмжээнээс хэвлэл мэдээллийн концерний барааны эргэлт, ашиг хэр байх нь хамаардаг. Ийм ч учраас хэвлэл мэдээллийн систем олны анхаарлыг ямар аргаар хамгийн дээд зэргээр татаж чадах бэ? гэдэг дээр гол анхаарлаа төвлөрүүлж байдаг.

Олны хүртээл болсон, маш олон тооны үзэгч, сонсогчидтой олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийг зах зээл дээр худалдан авах замаар өнөөгийн болон хэтийн өрсөлдөгчдийг дарж авахаас гадна хэвлэл мэдээллийн бүтээгдэхүүнүүдээс олж болох ашгийг бүхий л сүлжээгээ ашиглан бүрэн дүүрэн шавхан ашиглахад чиглэгдэж байдаг. Хэвлэл мэдээллийн хэрэгслүүд бусад мэдээллийн хэрэгслүүдийг бүтээгдэхүүнүүдийнхээ борлуулалт сурталчилгаанд ашигладаг. Ер нь дэлхий дахинаа олны хүртээл болсон хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийн зах зээл, нэн ялангуяа зурагтын зах зээл дээр гэж хэлж болно, хэвлэл мэдээллийн том концернууд, тун цөөхөн тооны бүлгүүдийн мэдэлд байдаг. Томоохон хэвлэл мэдээллийн концернууд үндэстэн дамжсан үйл ажиллагаа явуулж ингэснээрээ бүс нутаг, соёл үзэл суртлын болон улс төрийн бие даасан байдлын сүүлчийн зангуунуудыг татан унагасаар байна. Томоохон концернуудын хамгийн чухал зорилт бол ашиг орлого олох.

Хэвлэл мэдээллийн ардчилал үнэн хэрэг дээрээ программ сонголт - үзэгчид - уншигчдын хэмжээнээс хамаардаг хэвлэл мэдээллийн систем юм. Нэвтрүүлгийн формат, дэглэлт найруулгын арга барилын тухай бүхий л шийдвэрүүд зөвхөн ашиг орлогыг нэмэгдүүлэхэд чиглэгдэж байдаг. Тэр ч байтугай хувийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүд мэдээ, магазин, улс төрийн мэдээлэл

зэргийг хүргэхдээ хамгийн олон үзэгч, сонсогчдод хүргэхийн тулд бодлогоор тусгай дэглэлт найруулгыг оруулж өгдөг. Дэглэлт найруулгын бүхий л нөөц бололцоог шавхан ажиллах тал дээр тухайн мэдээллүүдийн утгаас илүү ач холбогдол өгдөг. Аль болох олон үзэгч сонсогчидтой байх дарамт энэ хооронд олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийн нэвтрүүлэгт ч нөлөөлж байна. Олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүд, хувийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийн хооронд мэдээлэл олж авах байнгын өрсөлдөөн явагдаж байна. Тухайн үеийнх нь үзэгч сонсогчдын хэмжээ нь тэдгээрийн бүтээгдэхүүнүүдийн амжилтын илэрхийлэл болж байна. Хувийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийн арилжааны шинж чанар нь улс төрийн сэдвүүдийг үл тоомсорлох, улс төрийн шинж чанарыг сулруулах зэрэг аюулыг дагуулж байгаа юм.

Парламентаризм ба улс төрийн намуудад хэвлэл мэдээллийн зүгээс ирж буй дарамт

Хэвлэл мэдээллийн бүтээгдэхүүнүүдийн үйлдвэрлэлийн хугацаа богиносохын хэрээр нөгөө талаас ихэвчлэн удаан хугацаагаар үргэлжлэх улс төрийн процесс хоёрын хоорондын зөрчил нь улс төрийн намууд, парламентыг шахалтад оруулдаг. Хэвлэл мэдээллийн энэхүү логик тэдний ач холбогдлыг олон түмний дунд бууруулж болзошгүй. Тэдний үйл ажиллагааны хүрээ хумигдаж байна. Тэд бодлогоо таниулах, сонгуулийн ажилтанд тэргүүлэх зэрэгт нэр дэвшигчийнхээ хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийг амжилттай ашиглаж чаддаг чадварт талархах учиртай гэдгээ мэдэж байдаг. Хэвлэл мэдээллийн салбарт намаа өнгөлж явдаг улс төрчид, намын гишүүдийн хооронд санаа бодлын зөрүүтэй байдал үүсэх нь тухайн намын хэвлэл мэдээллийн салбар дахь нэр хүндийг бууруулдаг. Иймээс намын гишүүд хэвлэл мэдээллийн тавцан дээр өндөр байр суурь эзэлсэн удирдлагынхаа заавраар урьдчилсан болон нөхөн залруулах зөвшилд хүрэхэд бэлхэн байдаг.

Энэ хандлага засгийн газрын тэргүүн парламентаас гадуур хэлэлцээрт орох, сонирхлын бүлгүүдийг зөвшилцөлд хүргэх

ярилцлагуудыг зохион байгуулсныхаа дараа олсон амжилтаа өөрийн амжилт болгон олон нийтэд танилцуулсан үед илүү хүчтэй ажиглагддаг. Ингэснээр парламентын гишүүд үйл явдлын гадна үлдэж зарим нэг салбарт нарийвчилсан засвар хийхийг шаардахаас өөр оролцоогүй болж орхидог. Засгийн газрын бодлогын үндсэн чиглэлүүдийг тогтоох тухай шийдвэрүүдэд парламентын гишүүд ихэвчлэн оролцоо багатай байдаг.

Ардчилсан олон нийт бүрдэх нөхцөлүүд

Ардчилсан олон нийтийг тогтвортой байлгахын тулд олон нийтийн улс төрийн мэдээлэл дараах гурван үүрэгтэй байдаг:

1. Ил тод байдлыг хангах үүрэг: Улс төрөөр юу болоод байгааг ойлгох, харах боломжийг иргэн бүрд олгох ёстой.
2. Үнэлэмж тогтоох үүрэг: Иргэн бүрд өөрийн байр суурийг бусдынхтай харьцуулах боломжийг бүрдүүлэх ёстой.
3. Чиг хандлага тогтоох үүрэг: Иргэн бүрд өөрийнхөө арга барилаар олон нийтийн санал бодолтой харьцуулан чиг хандлагаа тогтоох боломжийг бүрдүүлж өгөх ёстой.

Олон нийтийн хэлэлцүүлэг нь нийгмийн улс төрийн өөрийн зохицуулалтын суурийг бүрдүүлж өгдөг. Уг хэлэлцүүлгийн хүрээнд шударга ёсны тухай мэтгэлцээн өрнөж төлөөллийн аргументуудыг шүүн хэлэлцэж эдгээр нь эцсийн дүндээ нийгэм хамт олныг нэгдэлд хүргэдэг. Үүргээ гүйцэтгэх чадамж бүхий ардчилсан олон нийтийг бүрдүүлэхийн тулд дараах нөхцөлүүд хангагдсан байх ёстой:

- Бүх иргэдэд улс төрийн шийдвэр гаргалтад чухал үүрэгтэй мэдээллүүдэд хүрэх боломж нээлттэй байх ёстой. (Пассив буюу идэвхгүй мэдээлэлд хүрэх боломж)
- Бүх иргэд мэдээлэлд идэвхтэй оролцох боломжоор хангагдсан байх ёстой. Актив-идэвхтэй мэдээлэлд оролцох боломж (Идэвхтэй мэдээллийн боломж)

- Хэлэлцүүлгүүд олон түмэнд нээлттэй байх ёстой.
- Засгийн газар, парламент бүх чухал шийдвэрүүдийн талаар олон нийтэд мэдээлж, гаргах болсон шалтгаануудаа тайлбарладаг байх ёстой.

Нийгмийн ардчиллын чиг хандлагын үүднээс авч үзэхэд идэвхтэй ба идэвхгүй мэдээллээр хангагдах боломжийн тэгш байдлыг харуулсан шалгуур үзүүлэлтүүд ихээхэн ач холбогдолтой. Эдгээрийн үндэслэлүүдийн тайлбар нь тун энгийн. Иргэн бүр өөрийн улс төрийн автономит эрхээ эдлэхийн тулд хангалттай мэдээлэл авах болон оролцооны боломжоор хангагдсан байх ёстой. Учир нь ардчилсан шийдвэрүүдийн чанар өмнө нь урьдчилан өрнөсөн олон нийтийн мэтгэлцээний чанараас хамаардаг. Эдгээр нь хоорондоо нягт холбоотой. Ардчилалд үүргээ гүйцэтгэх чадамж бүхий олон нийт бүрэлдэн тогтож чадаагүй бол ардчиллын цаашдын хувь заяа эргэлзээтэй болдог.

Өдгөө олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүд улс төрийн стратегийн дэглэлт найруулгын үзвэрийн талбар болж байгаа тул нийгмийн шударга ёсны ерөнхий зарчмуудын тухай мэтгэлцээний найдвартай орчинг бүрдүүлэх асуудал улам эргэлзээтэй болсоор байна. Иймээс иргэний нийгмийн мэдээлэл солилцох нэгжүүдийн ач холбогдолулам бүр нэмэгдэж байна. Хэвлэл мэдээллийн систем дотор «хамгаалагдсан салбаруудыг» хэвээр хадгалах, эсвэл шинээр бий болгох асуудал мөн хурцаар тавигдаж байна. Олон нийтийн телевиз, радиогийн салбарт арилжааны квотын дарамтаас хараат бус байх доод хэмжээг хадгалж байх шаардлагатай байна. Дээрх хоёр нөхцөл бүрдээгүй нөхцөлд нийгмийн ардчиллын үзэл баримтлалын үүргийн нөхцөлүүд алдагдахад хүрнэ.

Нийгмийн ардчиллын улс төрийн системд олон нийт нь төлөөллийн ардчиллын түвшинг тодорхойлдог. Оролцооны идэвхтэй олон нийт бүрдсэн тохиолдолд үлэмж тооны иргэд

улс төрийн системийн бүхий л түвшинд шийдвэр гаргалтад байнга оролцож байдаг. Нэн ялангуяа хэвлэл мэдээллийн холимог бүтэцтэй улс төрийн системд иргэд хүсэл сонирхлоо холбоод, улс төрийн намууд, иргэний нийгмийн үйл ажиллагаануудаар дамжуулан илэрхийлж хэрэгжүүлж байдаг. Оролцооны ардчилал шууд харилцааны нэгжүүдээр дамжин илэрхийлэгддэг. Харилцааны дээрх нэгжүүдэд хүмүүс үйл ажиллагааныхаа зорилтууд, арга замуудын талаар харилцан ойлголцож мэдээллийг цааш нь дамжуулж, боловсруулж байдаг. Баримт нотолгоонд суурилсан шударга ёсны стандартуудын тухай харилцан ойлголцолд хүрэх боломж мөн энд бүрддэг. Оролцооны ардчилал нь нийгмийг төлөөлөх бүх актёруудыг багтаасан, улс төрийн удаан үргэлжлэх процессуудыг цогцоор нь багтаасан мэдээллийн соёл бүхий нэгдмэл олон нийт дээр суурилж байдаг.

Улс төрийн эдийн засаг IV

А. Эдийн засаг

4.1 Даяаршил ба улс төрийн эдийн засаг

Нийгмийн ардчиллын улс төрийн эдийн засгийн үйл ажиллагааны хүрээ нь 1990-ээд оны эхэн үеэс улс төрийн онцгой нөхцөл байдал үүссэнтэй холбогдон гарсан шийдвэрүүд, үйл явдлуудын улмаас зуун жил тутамд тохиох парадигмын эрс өөрчлөлтөөр тодорхойлогдож байна. Уг өөрчлөлт улс үндэстнүүдийн болон бүс нутгийн бодлогыг тодорхойлогч актёруудын эдийн засаг, нийгмийн бодлогын үйл ажиллагааны цар хүрээг үндсээр нь шинэчлэн тодорхойлж байна. Энэ нь үндсэндээ нийгмийн ардчиллын улс төрийн актёруудын зүгээс санал болгож буй даяаршлыг эерэгээр зохион байгуулахад тэргүүлэх ач холбогдол бүхий тодорхой бус цаг хугацааны дараа ойрын ирээдүйд хэрэгжих хөтөлбөрүүдийн эдийн засаг - улс төрийн бодлогын үйл ажиллагааны цар хүрээг нэгэн адил өөрчилж байгаа юм. Энэ талаар дараагийн бүлгүүдэд дэлгэрэнгүй тайлбарлана. Үндсэн эрхүүдийг бодитоор хэрэгжүүлэх шаардлага амжилтад хүрч, даяаршлын эдийн засаг - нийгмийн бодлогыг улс төрийн зүгээс удирдах боломж бүрдсэн нөхцөлд ч даяаршлын тавцан дээр бүтээгдэхүүн болон санхүүгийн зах зээлийн нэгдэл үргэлжилсэн хэвээр байх тул үйл ажиллагааны цар хүрээ маш

хурдацтайгаар радикал хэлбэрээр өөрчлөгдсөн хэвээр байх нь хөдөлшгүй үнэн юм. Хэрвээ дэлхий дахины нээлттэй зах зээлүүд амьдралын бодит байдал буюу «**fact of life**» болоогүй, харин улс төрийн зохих шийдвэрүүд гарган зориудаар бүрдүүлсэн байлаа ч гэсэн даяаршлын үүргийн гол цөмийг бүрдүүлэгчид болох даяаршлын тавцан дээр өргөтгөсөн таваар - үйлчилгээ - хөрөнгө оруулалтын өрсөлдөөн зөнгөөрөө явагдах байсан нь тодорхой юм.

1970-аад оны үеэс «**Вреттон - вудс**» - «**Bretton - Boords**» институтийн шагналаас үүдэлтэйгээр хэрэгжиж эхэлсэн зах зээлүүдийн үндэстэн дамнан нэгдэх процесс 1990-ээд оны үед хөгжлийнхөө шийдвэрлэх босгыг давсан байна. 1989 онд зөвлөлтийн коммунист гүрэн төгсгөл болж Төв болон зүүн Европын бүс нутаг бүхэлдээ дэлхийн капиталист зах зээлд нэгдсэн байна. Эдийн Засгийн Харилцан Туслалцах Зөвлөлөөс (ЭЗХТЗ) Дэлхийн Худалдааны Байгууллагад шилжих шилжилт дэлхийн худалдааны нөхцөлийг бүхэлд нь либералчилсан байна. Түүнээс гадна Европын Холбооны нэгдсэн зах зээлийг байгуулах тухай Маастрихтын гэрээ амжилттай хэрэгжсэн нь эдийн засгийн хамгийн хүчирхэг бүсэд либералчлалын чухал алхмуудыг авчирсан байна. Үүний үр дагавраар дэлхийн худалдаанд нөлөө бүхий байр суурийг эзэлдэг улс гүрнүүдэд эдийн засаг - худалдааны өргөн хүрээтэй либералчлалын давллагаа эхэлсэн байна.

Дэлхий дахины эдийн засгийн үндсэн нөхцөлүүдэд олон талаар шийдвэрлэх өөрчлөлтүүд гарсаар байна:

Нэгдүгээрт: Цалин багатай эдийн засгийн зах зээлд нэвтрэх бололцоо илүү хялбар болсны улмаас хамгаалалтгүй, даяаршлын худалдаанд нээлттэй бүтээгдэхүүний зах зээл дээрх өрсөлдөөн улам ихээр хурцдаж байна.

Хоёрдугаарт: Санхүүгийн зах зээлийн уян хатан байдал улам нэмэгдсээр байгаа нь үндэстэн дамнасан капиталын урсгалын хөдөлгөөнт чанарыг нэмэгдүүлж, нэн ялангуяа хөрөнгө оруулагчдын томоохон санхүүгийн төвлөрлийг улам бүр нэмэгдүүлж байна.

Гуравдугаарт: Улс орнуудын улсын төсөв их хэмжээний алдагдалтай байх нь томоохон хэмжээний хөрөнгө оруулалтыг тухайн орнуудаас эргүүлэн татахад хүргэх магадлал өндөр тул санхүүгийн зах зээлийн даяаршмал уян хатан байдал улс орнуудын төсөвт ихээхэн дарамт үзүүлж байна.

Дөрөвдүгээрт: Үндэстэн дамнасан асар их хэмжээний тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалт нь орон нутгийн холбоодын ашиг сонирхлыг үл харгалзан гагцхүү тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалтаасаа богино хугацаанд их ашиг олох сонирхолд хөтлөгдөж байдаг учраас компаниудын бодлогод дарамт учруулж байна.

Улс үндэстнүүдийн эдийн засагчид даяаршлын шинэ парадигма шинэчлэгдэн өөрчлөгдөхөөс өмнө эдийн засгийн хямралыг хоорондоо эрс ялгаатай ч тус тусын онцлогт тохирсон стратегиар даван туулж бие даан оршин тогтнох чадвараа нотлон харуулж байсан бол харин өнөөгийн шинэ нөхцөлд нийгмийн баримжаат төрийн бүтцүүд болон эдийн засгийн зохицуулалтын журамд тодорхой хэмжээний дарамтууд ирж байна. Улс төрийн эдийн засгийн байгууллагуудын ерөнхий зарчмууд ба улс орнуудын нийгмийн баримжаат төрийн зохион байгуулалтуудын өмнө хүндхэн сорилтууд тулгараад байна. Даяаршлын нөхцөлд нийгмийн ардчиллын шинэ улс төрийн эдийн засгийн үйл ажиллагааны бодит стратегиуд нь нэг талаас норматив үндсэн шийдвэрүүд, нөгөө талаас актёруудын онолын хүрээнд тодорхойлогдсон нөхцөлүүдэд зохицсон, мөн дээрх шаардлагуудад нийцсэн хариултуудыг өгөх түвшинд боловсруулагдсан байх ёстой.

Иймээс нийгмийн ардчиллын улс төрийн эдийн засгийн дараах дүн шинжилгээ нь нээлттэй зах зээлийн нөхцөлд явуулах үйл ажиллагааны стратегийг тайлбарлахад чиглэгдэж байгаа юм. Уг номын даяаршил хэмээх бүлэгт өдгөөг хүртэл судлагдан танигдсан үйл ажиллагааны нөхцөлүүдийн хүрээнд даяаршлыг өөрчлөх боломжтой, ямар үр дагаврыг «best case scenario» буюу хамгийн сайн бодлогоор урьдчилан сэргийлэх боломжгүй харагдаж байгаа тухай маш өргөн хүрээтэй нотолгоонуудын тусламжтайгаар урьдчилан тогтоох оролдлого хийлээ.

Улс төрийн эдийн засаг

Улс төрийн эдийн засгийн онол нь анги, төр, зах зээл, ардчиллын харилцааг судалдаг. Улс төрийн эдийн засгийн гол хувьсах хэмжигдэхүүн буюу судлагдахуун нь нийгмийн сайн сайхны төлөөх дэглэмүүд юм. Учир нь тэдгээрээр дамжуулан эдийн засгийн системийн бүтцүүд болон үр дүнд бус төрийн аргаар нөлөөлөх боломжтой юм. Иймээс нийгмийн ардчиллын улс төрийн эдийн засаг нь юуны өмнө улс төрийн систем, эдийн засгийн систем, нийтийн сайн сайхны төлөөх төрийн байгууллагуудын хоорондын харилцааг судлах шаардлагатай.

Улс төрийн эдийн засгийг дараах гурван үе шаттайгаар судалдаг.

1. Нийгмийн ардчиллын норматив онолын үндсэн дээр асуудлууд болон шаардлагуудыг тодорхойлох, тайлбарлах
2. Үүний үндсэн дээр нийгмийн хөгжлийн явцад үүссэн асуудлууд, эрсдэлүүдийн, асуудлыг шийдвэрлэх стратегид түүхэн болон системчилсэн дүн шинжилгээг хийх.
3. Дараа нь дээрх асуудлуудыг амжилттай шийдвэрлэсэн улс орнуудын туршлагуудын харьцуулсан судалгаан дээр тулгуурлан тэдгээрийн улс төрийн шийдвэрүүдэд тайлбар хийх.

Уг харьцуулсан судалгаа нь нийгмийн ардчиллын улс төрийн эдийн засгийн ямар хувилбарууд өөр өөр соёл, улс төрийн

нөхцөлтэй орнуудад хэрхэн хэрэгжих боломжтой бэ? гэдгийг харуулдаг. Уг судалгаагаар улс орнуудын дараах талбарууд нийгмийн ардчиллын улс төрийн эдийн засагт хүссэн хүсээгүй нөлөөлж байдаг нь тодорхой харагддаг:

Үйлдвэрлэлийн бүтээмж ба өсөлт	Нийгмийн шударга ёс ба аюулгүй байдал
Уян хатан байдал ба техник технологийн дэвшил дээр суурилсан шинэчлэлт	Хараат хөдөлмөр эрхлэгсдийн хамгаалал ба нийгмийн хамгаалал
Өмчийн болон гэрээний эрх чөлөө	Нийгмийн холбоос ба зохицуулалт
Компаниудын бие даасан байдлыг хангах	Компанийн шийдвэр гаргалтад ажилтнуудын оролцоог хангах, улс төрийн шийдвэрээр ерөнхий нөхцөлүүдийг тогтоох

Улс төрийн эдийн засаг нь дээрх талбаруудын зайлшгүй нөлөөн дор оршин байдаг тул зохицуулалтын хэрэгслүүд болох төр, зах зээл, эв санааны нэгдлийн олон талт зарчмуудын прагматик хосолмол хувилбарууд нь зөвхөн нэг талт нэг зохицуулалтын зарчмыг дагасан загваруудаас илүү амжилтанд хүрдэг. Хэдийгээр зохицуулалтын зарчмуудыг төрөл бүрийн хувилбараар хослуулан хэрэглэсэн ч төгс загвар болж чадахгүй бөгөөд ихэвчлэн хүсээгүй дагалдах сөрөг үр дагавруудын улмаас «trade off» буюу «гацаанд орсон» хэвээр байдаг. Өдгөө өмнөх үл бүтэх санаануудтай харьцуулахад улс төрийн эдийн засаг нь патентын бэлэн жор гаргах бололцоогүй салбар гэдгийг нийтээрээ хүлээн зөвшөөрөөд байгаа билээ. Карл Полани, Эдуард Хайман нар улс төр ба зах зээлийн харьцаа нь үргэлж салбар тус бүрийн онцлог бөгөөд бэрхшээлтэй симбиозаар илэрхийлэгдэж байдгийг нотолсон юм. Улс төр ба зах зээлийг тухайн цаг үед тохирсон үндсэн эрхүүдийг цогц байдлаар хамгийн сайн хангаж чадахуйц хэлбэрээр зохион байгуулах нь нийгмийн ардчиллын улс төрийн эдийн засгийн үндсэн зорилго мөн.

Капитализмын хэв шинжүүд

Улс төрийн эдийн засгийн судалгаагаар барууны өндөр хөгжилтэй аж үйлдвэржсэн орнуудад ч зах зээлийн эдийн засаг хоорондоо асар ялгаатай гэдэг нь нотлогдсон билээ. Эдгээр орнууд огт өөр замуудаар ижил төстэй үр дүнд хүрсэн, эсвэл хөгжлийн ижил төстэй замыг туулсан ч өөр өөр үр дүнд хүрсэн жишээ олон байдаг. Зах зээлийн эдийн засгийн системүүд нь ихэвчлэн нийтийн сайн сайхны төлөө төрийн байгууллагуудын тодорхой хүрээллийн дунд оршин байдаг. Иймээс улс төрийн эдийн засаг нь улс төр, эдийн засаг, нийтийн сайн сайхны төлөө төрийн системүүдийн харилцан хамаарлыг судалдаг.

Нийтийн сайн сайхны төлөө төрийн байгууллагууд нь эдийн засгийн зохицуулалтын байгууллагуудтай зэрэгцэн хөгжиж иржээ. Тэдгээр нь орчин үеийн капитализм, зах зээлийн нийгмийн төгс бус байдлаас хамгаалах үүргийг гүйцэтгээд зогсохгүй орчин үеийн капитализмын үндсэн бүрэлдэхүүн хэсэг мөн. Зах зээлийн эдийн засаг, нийгмийн сайн сайхны төлөө төр хоёр нь харилцан хамааралтай бөгөөд бие биедээ харилцан нөлөөлж байдаг.

Судалгаагаар капитализмын олон төрлийн хэв шинжүүд оршин байгааг тогтоосон. Мишель Альберт жишээлбэл «Атлантын» болон «Райны» капитализм гэж ангилсан байдаг. Бибиен А. Шмидт «**managed capitalism**» буюу «**менежментийн капитализм**», «**market capitalism**» буюу «**зах зээлийн капитализм**», «**State capitalism**» буюу «**төрийн капитализм**» гэж капитализмыг гурав ангилсан байдаг. Энэ бүлэгт Петр Холл, Девид Соскисе нарын либерал буюу зохицуулалтгүй капитализм, нийгмийн буюу зохицуулалттай капитализм гэдэг хэв шинжүүдийг тайлбарлах болно. Капитализмын дээрх хоёр үндсэн хэв шинжүүдийн үндсэн ялгаануудыг улс төрийн эдийн засгийн дараах харилцаанууд дээр үндэслэн тогтоосон:

- Аж үйлдвэрийн харилцааны систем (Ажил олгогч эздийн холбоод ба үйлдвэрчний эвлэлүүдийн харилцаа)
- Мэргэжлийн сургалт ба мэргэжил дээшлүүлэх сургалт – «Corporate Governance» буюу компаниудын засаглал
- Компаниуд хоорондын харилцаа
- Компанийн удирдлага ба ажилтнууд хамт олны хоорондын харилцаа
- Компанийн шийдвэр гаргалтад ажилтнуудын оролцоо
- Эдийн засаг, улс төрийн хамтын ажиллагааны нэгдмэл чанар

Холл, Соскисе нар улс төрийн эдийн засгийг олон актёруудын үйл ажиллагааны талбар гэж үздэг. Тэд мөн уг талбар дээр актёр бүр өөрийн сонирхлыг хамгийн үр өгөөжтэйгөөр бусадтай хамтарсан стратегиар хэрэгжүүлэхийг оролддог гэж үздэг.

Хувь хүмүүс, менежерүүд, компаниуд, концернуудын бүлэглэл, засгийн газруудыг актёрууд гэж нэрлэж байгаа юм.

Холл, Соскисе нар капиталист эдийн засагт компаниудыг хамгийн нөлөө бүхий голлон тоглогчид буюу актёрууд гэж үздэг. Технологийн хувьслыг нэвтрүүлэх, олон улсын хэмжээнд өрсөлдөх чадварыг хадгалахад компаниуд голлох үүрэг гүйцэтгэдэг. Компаниудын дотоод харилцаа, компаниуд хоорондын харилцаа, компаниуд-засгийн газар хоорондын харилцааг судалдаг улс төрийн эдийн засгийн нэгэн хэлбэр гэж нэрлэж болох юм.

Холл/Соскисе нарын капитализмын хэв шинжүүдийн судалгаа нь өөр өөр зах зээлийн эдийн засгийн байгууллагуудын бүтцийг нийгмийн ардчиллын хэм хэмжээний хүрээнд шүүмжлэлтэйгээр харьцуулан судлах дүн шинжилгээний ерөнхий хүрээг тогтоож өгдөг. Гэхдээ уг судалгаагаар улс орон

бүрийн эдийн засгийн чадамж нь нийгмийн ардчиллын хэм хэмжээтэй хэрхэн уялдаж байгааг голлон судалдаг.

Дараах хэсэгт капитализмын дээр дурдсан хоёр хэв шинжүүдийг нарийвчлан тодорхойлсон:

Либерал буюу зохицуулалтгүй зах зээлийн эдийн засагтай улс орнууд: (АНУ, Их Британи, Австрали, Канад, Шинэ Зеланд, Ирланд)

Нэгдүгээрт: Компаниудын санхүүжилт нь тогтмол давтамжтай, түр хугацаанд гэнэт огцом өсөх ногдол ашгийг бий болгож түүнээс нь хувьцаа эзэмшигчид ашиг орлого олж байдаг өмчийн зах зээлээс зонхилон хийгдэж байдаг. Энэ утгаараа менежмент муу бол компани нь дампуурах эсхүл аль нэг хүчтэй өрсөлдөгч нь дайснаа дарахын тулд худалдан авдаг. (shareholder modell)

Хоёрдугаарт: Хувьцаа эзэмшигчид нь аль болох их ногдол ашиг хүртэх ганцхан сонирхолтой байдаг. Уг сонирхол компанийн стратегийг тодорхойлж байдаг.

Гуравдугаарт: Компаниуд хоорондын уялдаа холбоо маш сул. Банкнууд болон компаниуд бусад компаниудын хяналтын зөвлөлд төлөөлөлгүй байдаг.

Дөрөвдүгээрт: Компаниудын хамтын ажиллагааны хүрээнд байгуулагдсан байгууллагууд бараг байдаггүй. (Судалгаа, технологийн шилжилт, стандартчилал гэх мэт)

Тавдугаарт: Холбоод нь өөрийн удирдлагын байгууллагууд гэхээсээ илүү ловви байгууллагуудын хэлбэрээр хүчтэй үйл ажиллагаа явуулдаг. Хууль тогтоогч байгууллагын хязгаарлагдмал орчин нь компаниуд өөртөө туслах картел хэлбэрийн бүтэц бий болгоход саад тотгор учруулдаг.

Зургаадугаарт: Хөдөлмөрийн харилцаанд түр хугацааны хөдөлмөр эрхлэлтийн харилцаа зонхилдог.

Долоодугаарт: Цалин хөлсний хэлэлцээрүүд зөвхөн компаниудын түвшинд явагддаг.

Наймдугаарт: Уян хатан хөдөлмөрийн зах зээл нь мэргэжлийн ерөнхий ур чадвар шаардах, компаниудын хооронд хөрвөх чадвар сайтай, мэргэжил дээшлүүлснээр сайжруулах боломжтой боловсролын систем дээр түшиглэж байдаг.

Есдүгээрт: Бөөний үйлдвэрлэл, боловсрол болон цалингийн бага түвшин дээр суурилсан үйлдвэрлэлийн загвар зонхилсон байдаг.

Аравдугаарт: Уг систем уян хатан бөгөөд зах зээлийн өөрчлөлтөд дасан зохицох чадвар сайтай.

Арваннэгдүгээрт: Үйлдвэрлэлийн энэхүү загвар асар хурдацтай шинэчлэлийг дагуулдаг. (Ихэвчлэн технологийн шинэчлэлийн улмаас үйлдвэрлэлийн шинэ шугам - процессууд бий болдог.)

Арванхоёрдугаарт: Нийгмийн сайн сайхныг бий болгох шинэчлэлийн процессод хүргэх тэнцвэржүүлэлтийн механизмууд ихэвчлэн сул хөгжсөн байдаг.

Зохицуулалттай зах зээлийн эдийн засагтай орнууд: (Герман, Япон, Швейцар, Голланд, Бельги, Швед, Норвеги, Дани, Финланд, Австри)

Нэгдүгээрт: Эдийн засгийн харилцаанууд нь ихэвчлэн зах зээлийн бус хэлбэрийн зохион байгуулалтын бүтцүүд болон компаниуд хоорондын хамтын ажиллагаа болон хамтарсан оролцооны олон талт хэлбэрээр зохицуулагдаж байдаг.

Хоёрдугаарт: Компаниудын санхүүжилт нь банкны зээлээр хийгддэг тул удаан хугацааны хөрөнгө оруулалт хийгдэх боломжтой.

Гуравдугаарт: Менежментийн үйл ажиллагааг зах зээл үнэлэхээс илүүтэйгээр банкнууд, компаниуд, ажилтнууд, төрийн актёруудын төлөөлөл бүхий сүлжээнүүд хянаж байдаг.

Дөрөвдүгээрт: Хувьцаа эзэмшигчдийн ашиг сонирхлоос илүүтэйгээр олон тооны нийгмийн салбаруудын ашиг сонирхол давамгайлж байдаг. («Stakeholder» - загвар)

Тавдугаарт: Цалин хөлсний хэлэлцээрүүд компаниудын түвшинд бус салбаруудын түвшинд явагддаг.

Зургаадугаарт: Хөдөлмөр эрхлэлтэд удаан хугацааны харилцаа зонхилж байдаг.

Долоодугаарт: Боловсролын загвар нь компаниуд болон салбарын хэмжээний нарийн мэргэжил, ур чадварыг хооронд нь холбож байдаг. Ажилтнууд, ажил олгогчдын тэргүүлэх холбоод боловсролын менежментийг тодорхойлж байдаг.

Наймдугаарт: Тухайн ашиглагдаж буй үйлдвэрлэлийн шугам-процессууд удаан хугацаагаар хэрэглэгддэг бөгөөд зөвхөн бага хэмжээний хэсэгчилсэн өөрчлөлтүүдийг тасралтгүй хийж байдаг. Технологийн шинэчлэл зохицуулалтгүй зах зээлтэй харьцуулахад харьцангуй бага хийгддэг.

Есдүгээрт: Тогтвортой байдал-нийгмийн тэнцвэрт байдал хоорондоо холбоотой байдаг.

Аравдугаарт: Нөхцөл байдал өөрчлөгдөхөд системийн дасан зохицох чадвар муу, удаан хугацаа шаарддаг.

Арваннэгдүгээрт: Хамтын ажиллагааны дүрмүүдийг оролцогч талууд өөрсдөө тодорхойлдог.

Капитализмын хэв шинжүүдийн буюу «**varieties of capitalism**» судалгаа нь капитализмын төрлүүдийн аль нэгнийх нь давуутай талуудыг тогтоох зорилгыг тавиагүй. Зах зээлийн дээрх хоёр хэв шинжүүд нь хоёулаа байр сууриа олсон, бүтцийн хувьд тогтворжсон, хангалттай, тогтвортой эдийн засгийн чадамжийг бий болгох чадвартай. Холл/Соекисе нар ямар учраас улс орнуудын компаниуд даяаршлын улмаас тулгарч буй шаардлагуудад харилцан адилгүй хариу үйлдэл үзүүлж байгааг судалсан байна:

Жишээлбэл: Английн компаниуд ханшийн өөрчлөлтийн улмаас тулгарч буй бэрхшээлүүдийг гадаадын зах зээл дээр борлуулагдаж буй өөрийн үйлдвэрийн барааны үнийг нэмэгдүүлэх замаар даван туулж ингэснээр ачааллыг үйлчлүүлэгчиддээ үүрүүлж орхисон. Харин Германы компаниуд ханшийн өөрчлөлтийн улмаас тулгарсан бэрхшээлүүдийг бүтээгдэхүүний үнийг хэвээр байлгаж олох ашиг буурсантай эвлэрсэн ч өөрсдийн зах зээлд эзлэх хувиа хэвээр хадгалан үлдэхэд илүү ач холбогдол өгсөн. Дээрх харилцан адилгүй хариу үйлдлүүдийг дараах байдлаар тайлбарлаж болно. Английн фирмүүд хөрөнгийн зах зээлээс хамааралтай учраас олох ашгаа хэвээр хадгалах ёстой. Германы компаниуд тэдний олох ашиг буурсан ч тэдний өмчид хүрэх зам түр хугацааны ашгаас үл хамаарах тул тэсэж үлдэх чадвартай.

Английн фирмүүд зах зээлд эзлэх хувиа алдсан тохиолдолд богино хугацаанд ажиллах хүчнээ олноор нь халах боломжтой. Хөдөлмөрийн зах зээл нь нээлттэй, ажлаас халагдахаас хамгаалах хамгаалалт сул байдаг нь энэ тохиолдолд тэдний давуу тал болж байгаа юм. Германы компаниудын хувьд зөвхөн тухайн компанид ажиллахаар тусгай мэргэшсэн ажилтнуудаа

удаан хугацаагаар ажиллуулдаг, тэднийг бусад компаниудад хөрвүүлэн ажиллуулах бололцоо муутай байдаг.

Капитализмын хэв шинжүүдийг нийгмийн ардчиллын үзэл баримтлалын үүднээс нарийвчлан авч үзэхэд зохицуулалтгүй зах зээлүүдийн зарчмын гол дутагдалтай дараах талууд ажиглагдаж байна:

Нэгдүгээрт: Компаниудын үнэлгээ, хувьцаа эзэмшигчдийн ашиг нь зохицуулалтгүй зах зээлийн эдийн засагт үнэмлэхүй үүргийг гүйцэтгэдэг тул компаниуд богино хугацаанд их ашиг олоход л бүх анхаарлаа төвлөрүүлж байдаг. Компаниудын үйл ажиллагааны урт хугацааны үр дагаврууд болох жишээлбэл нийгмийн болон экологийн асуудлуудад хангалттай анхаарал төвлөрүүлж чаддаггүй.

Хоёрдугаарт: Компаниудын менежментийн дээд түвшин нь харьцангуй хяналтгүй үйл ажиллагаа явуулах эрх мэдэлтэй байдаг тул бусад бүлгүүдийн, нэн ялангуяа ажилтнуудын ашиг сонирхол орхигдож байдаг. Тэдний санаа бодлыг шийдвэр гаргалтад хангалттай хэмжээнд харгалзан үздэггүй.

Гуравдугаарт: Зохицуулалтгүй зах зээлийн эдийн засаг маш уян хатан, зохицуулалтгүй хөдөлмөрийн зах зээлтэй байдаг. Зохицуулалтгүй зах зээлийн эдийн засагтай орнуудын ажилтнууд ерөнхий мэргэжил эзэмшсэн байдаг бол зохицуулалттай зах зээлийн эдийн засагт компаниуд өөрийн онцлогт тохирсон нарийн мэргэшсэн ажилтнуудтай байдаг. Иймээс ажилтнууд ажил олгогчидтой харьцуулахад байр суурь султай байдаг. Үйлдвэрчний эвлэлийн байгууллага нь сул, цалингийн төвлөрсөн хэлэлцээр явагддаггүй зэрэг нь байдлыг улам дордуулж байдаг.

Эдийн засгийн засаглалын концепцын чухал үндсэн зарчмууд
Нийгмийн ардчиллын улс төрийн эдийн засагт улс ардын

аж ахуйн зорилт ба хэрэгслүүдийг хооронд нь ялгаж өгөх нь зарчмын чухал ач холбогдолтой юм. Хувь хүмүүсийн үндсэн эрхүүдийг баталгаажуулахын тулд эдийн засаг хувь хүмүүст үйл ажиллагаа явуулах эрх чөлөөг нь аль болох өргөн хүрээнд хангаж өгөх үүрэгтэй. Өөрөөр хэлбэл: Зах зээл аль болох өргөн хүрээтэй байх ёстой гэсэн үг юм. Нөгөөтэйгүүр материаллаг эрх чөлөөний хэм хэмжээнүүдийг хангахын тулд нийгмийн үндсэн үйлчилгээгээр хангагдсан байх нь эерэг эрх чөлөөг хангах нэгэн нөхцөлийг бүрдүүлдэг. Дээрх эрх чөлөө ба эрхүүдийг хангахын тулд эдийн засгийн процессуудыг улс төрийн аргаар удирдаж, зохицуулах ёстой. Зах зээлүүдэд тодорхой зорилгод чиглэгдсэн улс төрийн хүрээлэл тогтоож өгөх буюу улс төрийн хариуцлага ногдуулах зайлшгүй шаардлагатай.

Эерэг эрх чөлөөний үндсэн зарчим бол хүн бүрд хүний ёсоор амьдрах нөхцөлийг бүрдүүлэх явдал бөгөөд бүх хүмүүсийн эрх ашгийг эдийн засгийн системд ч нэгэн адил тэнцүү хэмжээгээр хүндэлж, хамгаалж байхыг шаарддаг. Уг үндсэн зарчмын хэрэгжилт нь компаниудын засаглалд ажилтнууд, ажил олгогч нарын эрхүүдийн хооронд зөрчил үүсэхэд хүргэдэг.

Нийгмийн ардчилалд үндсэн эрхүүдийг хангахад илүү ач холбогдол өгдөг учраас эдийн засгийн системийг зарчмын хувьд улс төрийн оролцоонд нээлттэй байх ёстой гэж үздэг. Эцсийн бүлэгт үндсэн эрхүүд улс ардын аж ахуйн зорилтуудыг тодорхойлдог. Нийгмийн болон эдийн засгийн үндсэн эрхүүд нь эдийн засгийн систем, түүний зохион байгуулалтын хэлбэрүүд, процессуудын явцын байдал, үр дүнг хамтран тодорхойлж байдаг. Аливаа нийгмийн улс ардын аж ахуйн систем нь улс төрийн эдийн засгийн үндсэн асуудлууд тогтмол шийдвэрлэгдэж байдаг улс төрийн аргачлалын үр дүн байдаг. Энэхүү аргачлалд эдийн засгийн төрөл бүрийн хэрэгслүүдийн хэрэглэгдэх нөхцөлүүд, тэдгээрийн үр дагаврын тухай мэдлэг, мэдээллүүд нөлөөлж байдаг. Уг аргачлалын хүрээнд

бэрхшээлтэй, зөрчилдөөнтэй дэд зорилтуудын харьцуулалт хийгдэж дэс дараалал нь тодорхойлогдож байдаг.

Нийгмийн ардчиллын улс төрийн эдийн засаг практик, үр өгөөж, хэм хэмжээний хувьд хуульчлагдсан эдийн засаг - улс төрийн хэрэгслүүдийн сонголтуудын нотолгоог гаргаж өгдөг. Уг нотолгоонуудаар дараах асуултуудад хариулт өгдөг. Ямар хэрэгслүүд таваар болон үйлчилгээний үйлдвэрлэлийн процессод эдийн засагч, арвигч хямгаач чанар, үндсэн эрхүүдийг нэгэн зэрэг хангадаг бэ? Хамтын сонирхол болон хувийн автономит шийдвэр гаргалтын үйл ажиллагааны цар хүрээг хамгийн дээд хэмжээгээр хэрхэн хангах бэ? Байгууллагуудын зохион байгуулалтын ямар хэлбэр эдийн засгийн зохион байгуулалтын үр өгөөжийг хамгийн дээд хэмжээнд баталгаажуулж чадах бэ?

Нийгмийн ардчиллын эдийн засгийн ерөнхий зарчмуудыг хэрэгжүүлэх байгууллагуудын зарим бүтцүүд нь эдийн засгийн өөр өөр ерөнхий зарчмуудын хэрэгжилтийн өдгөөг хүртэл хуримтлагдаж ирсэн түүхэн туршлага болон тэдгээрийн шинжлэх ухааны тайлбаруудаас урган гарсан:

- Зах зээл нь нийгэм, байгаль орчин, улс төрийн амьдралын нөхцөлүүдийн өргөн хүрээлэлд орших ёстой. Өөрөөр хэлбэл зах зээлд нийгэм, байгаль орчин, улс төрийн хариуцлага хүлээлгэх.
- Зах зээлийн логикийг хөгжүүлэх орон зайг аль болох өргөн цар хүрээтэй тогтоож өгсөн тохиолдолд л бүтээмж, нөөцийг (санхүү, материаллаг бааз, үйлдвэрлэх хүч) үр ашигтай хуваарилах боломж бүрдүүлэх.
- Ажилчид, албан хаагчдын шийдвэр гаргалтад оролцох зохистой хэлбэрийг хангаж өгөх.
- Гадаад эдийн засгийн тэнцвэртэй байдлыг хангах, бүх хүнийг ажлын байраар хангах, үнийг тогтвортой байлгах,

нийт эдийн засгийн тэнцвэртэй өсөлтийг хангах зорилгоор макро эдийн засгийн зохицуулалт хийх.

- Хөдөлмөрийн зах зээлийн идэвхтэй бодлого явуулах.
- Зах зээлд ногдуулах хариуцлагыг үндэстэн дамжсан улс төрийн бодлогоор зохицуулах.

Либертар ба нийгмийн баримжаат эдийн засгийн зөрчил

Либерал ардчиллын либертар ба нийгмийн тайлбаруудын үндсэн зөрчил нь үйлдвэрлэлийн хэрэгслийг өмчлөх эрх ба зах зээлийн ерөнхий зарчмуудын эрх зүйн статус ба зах зээлийн ерөнхий зарчмуудыг өөрөөр тайлбарладагт оршдог. Роберт Нозик либертар либерализмын ойлголтоор үйлдвэрлэлийн хэрэгслийг өмчлөх эрх нь хүний эрхийн салшгүй нэгэн хэсэг гэж үздэг гэдгийг баталсан байна. Иймээс өмчлөх эрхийг гуравдагч этгээдийн эрхээр хязгаарлаж болохгүй гэж үздэг. Үйлдвэрлэлийн хэрэгслийг эзэмших эрх уг ойлголтын дагуу эрх чөлөөний тухай ойлголттой салшгүй холбоотой. Либертаризм нь либерал эдийн засгийн ерөнхий зарчмын дагуу үйлдвэрлэлийн хэрэгслийг эзэмших эрх хувь хүмүүсийн эрх чөлөөгөө эдлэх эрхийн асуудал мөн тул төрийн зүгээс зохицуулалт хийх шаардлагагүй гэж үздэг. Тэгэхээр үйлдвэрлэлийн хэрэгслийг эзэмшигч байх уу? үгүй юу гэдэг нь тухайн хүн эрх чөлөөгөө хэрхэн эдлэх тухай л асуудал юм. Иймээс либертар концепц үйлдвэрлэлийн хэрэгслийн өмч тэгш хуваарилагдсан эсэх, хэрэв тэгш бусаар хуваарилагдсан бол түүний үр дагавар гуравдагч этгээдийн хүний ёсоор амьдрах эрх, эрх чөлөөнд нөлөөлж буй эсэхийг харгалзаж үздэггүй. Уг концепцын логикийн дагуу зах зээл нь эдийн засгийн иргэдийн үл хязгаарлагдах эрх чөлөөний эрхүүдийг баталгаажуулж өгдөг. Иймээс дээрх салбарт төрийн оролцоог улс төрийн хувьд боломжгүй, иргэдийн эрх чөлөөг хязгаарлах гэсэн оролдлого түүгээр ч барахгүй зах зээлийг үүргээ гүйцэтгэх явцад саад учруулж буй явдал гэж үздэг.

Либерал ардчиллын нийгмийн тайлбарыг өөрийн

зохицуулалттай зах зээлүүдийн түүхэн туршлага дээр суурилан хийдэг. Европын бүх улсуудын капитализм үүсэн хөгжиж байсан эхний үеийн туршлагаар зах зээл нь иргэдийг эдийн засгийн тэгш эрх бүхий иргэд гэдэг утгаар нь авч үзвэл иргэдийн дийлэнх хэсгийн эрх чөлөөгөө эдлэх боломжид үлэмж бэрхшээл учруулж эрх мэдлийн хэт төвлөрлийг бий болгодог учраас өөрийгөө сөнөөхөд хүргэдэг гэдгийг харуулсан. Либерал ардчиллын нийгмийн тайлбар нь өөрийн зохицуулалттай зах зээл нь өөрийн системийн шинж чанартай гажуудлын улмаас эрсдэл, нийтийн сайн сайхны төлөө чиглэгдсэн арга хэмжээнүүд, иргэдийн эрх чөлөөгөө эдлэх боломж, амьдралын хэрэгцээ, үндсэн эрхүүдэд ноцтой саад учруулдгийг нотолдог. Ортодокс социализмын үзэлтэй харьцуулахад нийгмийн ардчиллын онол нь эдийн засгийн либерал байгууллагуудыг үгүйсгэдэггүй, харин тэдгээр нь түгээмэл үндсэн эрхүүдтэй хэрхэн уялдаж байгааг авч үздэг. Үндсэн эрхүүд ба либерал эдийн засгийн байгууллагууд хоорондоо зөрчилдөх тохиолдолд нийгмийн ардчиллын онол үүссэн асуудалд тухайн нөхцөлд тохирсон хөдөлмөрлөх эрх зүйн хязгаарлалтууд, нийгмийн баримжаат төрийн оролцоо, эдийн засгийн зохицуулалтын засваруудыг санал болгодог.

Өөрийн зохицуулалттай зах зээлийн нөлөөний тухай нийгмийн шүүмжлэлийг зарчмын болзошгүй аюулын цар хүрээний матриксаар нэгтгэн илэрхийлэх боломжтой. Нийгмийн шүүмжлэл нь түүхийн хөгжлийн явцад хуримтлагдаж буй шинэ туршлагуудад зарчмын хувьд нээлттэй:

Нэгдүгээрт: Зах зээлээс хангалттай орлого олж чадахгүй байгаа хүн бүр хүний ёсоор амьдрах нөхцөл болон өөрсдийн сэтгэл зүйн байдлын хувьд хохирч байдаг. Энэ нь хүний наад захын үндсэн эрхүүд ба хувийн автономит байдлыг зөрчиж байдаг.

Хоёрдугаарт: Хувийн өмчгүйн улмаас хүний ёсоор амьдрах

боломжийг нь хязгаарласан, өөрөө хувь заяаныхаа эзэн байх эрхийг нь зөрчсөн хөдөлмөрийн гэрээ байгуулан бусдын төлөө ажиллахаас өөр аргагүй байдалд орсон хүмүүсийн үндсэн эрхүүд зөрчигддөг. Ингэснээр тэд нийгмийн автономит байдлаа алддаг.

Гуравдугаарт: Амьдралын хэрэгцээт зүйлсийн тэгш бус хуваарилалтын улмаас улс төрийн оролцооны боломжоо зохих ёсоор нь эдэлж чадахгүй байгаа хүмүүсийн иргэний эрх нь туйлын хязгаарлагдмал байдаг. Ингэснээр тэдний улс төрийн автономит байдал зөрчигдөж байдаг.

Дээрх хохирлуудын цар хүрээгээр нийгмийн ардчиллын улс төрийн эдийн засгийн байгууллагуудын үндсэн зарчмууд тодорхойлогдож байдаг.

- Үйлдвэрлэлийн хэрэгслийг эзэмших эрх нь гуравдагч этгээдийн хүний эрхийг хөнддөг учраас тэдний үндсэн эрхүүдийн хэрэгжилтийг хангахын тулд өмчлөгчийн эрхийг хязгаарлах ёстой.
- Хүмүүсийн үндсэн эрхүүд хоорондоо зөрчилдсөн тохиолдолд үндсэн эрхүүдийн тэгш байдлыг хангах замаар уг зөрчлийг шийдвэрлэнэ.
- Ардчилсан эрх зүйт төр хууль ёсны өмчлөх эрхүүдийг зохицуулдаг. Уг зохицуулалтад хууль ёсны өмчлөх эрх нь гуравдагч этгээдийн баталгаажсан үндсэн эрхүүдэд нийгмийн ямар нөлөөлөл үзүүлж байгааг харгалзан үздэг.
- Зах зээл нь нийгмийн байгууллага бөгөөд түүний хязгаар, зорилтууд, үүргийн арга хэлбэр нь либерал, улс төр, эдийн засаг, нийгмийн үндсэн эрхүүдийн хэм хэмжээнээс хамаардаг. Иймээс зах зээл нь улс төрийн зохицуулалт, хариуцлагын дор оршдог.
- Зах зээл нь дээрх хязгааруудын хүрээнд нийгмийн зорилтуудыг хэрэгжүүлж байдаг. (Хангалуун амьдралын түвшин ба эрх чөлөө)

- Зах зээлийг эрх чөлөөг хангах үүрэг талаас нь авч үзвэл ардчилсан эрх зүйт төрийн байгууламжуудтай адил түвшинд оршдоггүй.
- Зах зээлийн тухай улс төрийн шийдвэр ба түүний хязгаарлалтууд нь эдийн засаг ба нийгмийн үндсэн эрхүүдийг хангах хариуцлагаас урган гардаг. (Бүтээмж, таваарын хангамж, хэрэгцээ хангахад чиглэгдсэн эрэлт, эдийн засгийн үйл ажиллагаа явуулах эрх чөлөө)
- Зах зээлийн хэлбэр, хязгаарууд, дотоод ерөнхий зарчим, хууль ёсны нөлөөлөх салбарууд нь үндсэн эрхүүдээр дамжин хуульчлагдах улс төрийн шийдвэрүүдээс хамаардаг.
- Нийгмийн болон эдийн засгийн үндсэн эрхүүд, эдийн засгийн ерөнхий зарчмуудад үйлчлэх хэрэгслүүдийн шинж чанар, улс төрийн хариуцлагын бүтэц зэрэг нь макро эдийн засгийн зохицуулалт хийхийг шаардаж байдаг.
- Макро эдийн засгийн хөгжлийн удирдлагын арга хэлбэрийг тодорхойлоход үндсэн эрхүүдээс гадна тухайн үеийн улс төрийн олонх, зах зээл ба төрийн оролцооны үр дагаврын тухай шинжлэх ухааны мэдлэгийн түвшин чухал үүрэгтэй байдаг.
- Хөдөлмөрлөх эрхийн зохицуулалт, компаниудын шийдвэр гаргалтад ажилтнуудын оролцох оролцооны эрх, тарифын автономит байдал талаас нь авч үзвэл үндсэн эрхүүдийн хэм хэмжээ нь эдийн засгийн ерөнхий зарчмуудын доод хязгаарыг тогтоож өгдөг. Тухайн процессод оролцоогүй ч эрх нь хөндөгдөх нийгмийн бусад гишүүдийн эрхийг ижил түвшинд харгалзан үзэх ёстой.

4.2 Зах зээлд нийгмийн хариуцлага ногдуулах нь

Нийгмийн ардчиллын эдийн засгийн онолын таамаглал бүрийг бодитой байлгахын тулд тухайн таамаглалууд бусад улс орнуудын туршлагаар амжилтад хүрнэ гэдэг нь нотлогдсон байх ёстой:

Нэгдүгээрт: Карл Полани өөрийн зохицуулалттай зах зээлд гаднаас зохицуулалт хийх гэж оролдох нь зөвхөн саад тотгор болж байдаг гэж нотолсон нь догматик төсөөлөл юм. Бодитоор оршин буй зах зээлүүд бүгд нийгмийн хүрээлэл дунд оршсоор ирсэн.

Хоёрдугаарт: Нийгмийн ардчиллын хүрээнд хэрэгжих бүхий л эдийн засгийн загварууд бусад өөр хэлбэрээр зохион байгуулагдсан эдийн засгийн загваруудтай өрсөлдөх чадвартай байх ёстой. Өрсөлдөх чадваргүй бол оршин тогтнох чадвар, улс төрийн хууль ёсны байдлаа алдана гэсэн үг юм.

Гуравдугаарт: Капитализмын хэв шинжүүдийн судалгаагаар дэлхий дээр хоорондоо асар их ялгаатай зах зээлийн эдийн засгийн зохион байгуулалтууд оршин байгаа нь тогтоогдсон. Улс төр ба эдийн засгийн шийдвэрүүдийг эдийн засгийн өөр өөр системд орших улс орнуудын бодит туршлагууд дээр тулгуурлан гаргах ёстой.

Дөрөвдүгээрт: Нийгмийн ардчиллын улс төр ба эдийн засгийн зохицуулалтын тухай онол нь зөвхөн зах зээлийн логик, төрийн үйл ажиллагаа, иргэний нийгмийн идэвх санаачилгыг хэрхэн зөв зохистой уялдуулах бэ? гэдэг асуултад хариулт өгдөг. Уг хариулт нь нормативын хувьд нотлогдсон, практик зорилтуудад хамгийн ойр томъёологдсон байх ёстой. Судалгааны өнөөгийн түвшин удирдлагын гурван хэрэгсэл болох - **Иргэний нийгэм** - **Зах зээл** - **Төр** нь тус бүрдээ функцийн давуу болон сул талуудтай байдаг тул нэг нэгийг нь дангаар нь бус хослуулан хэрэглэвэл илүү үр дүнтэй гэдэг нь улс орнуудын туршлагаар нотлогдоод байгаа билээ. Зарчимд чиглэгдсэн прагматик үйл ажиллагаа бүр дээрх удирдлагын хэрэгслүүдийн функцийн үр өгөөжийг аль болох өндөр байх, тухайн хэрэгсэл тус бүрийн функцийн доголдлыг аль болох бага хэмжээнд байхаар зохион байгуулахад чиглэгддэг.

Хуучны ортодокс либерализмын онол нь зах зээлийг удирдлагын цорын ганц төгс төгөлдөр хэрэгсэл хэмээн үзэж түүнийг иргэний нийгмийн болон төрийн хэлбэрийн удирдлагын хамаарлаас ангид авч үздэг байжээ. Зах зээлийг эрх чөлөөг хэрэгжүүлэгч хэмээн үздэг байсан учраас аливаа шүүмжлэлээс ангид үздэг байлаа. Харин ортодокс социализм үүний эсрэг төрийн үйл ажиллагаа бол төгс төгөлдөр бүхнийг удирдан чиглүүлэгч хүч, нийгмийн хамт олны хүсэл зоригийн логик нэгдмэл илэрхийлэл гэж үздэг байсан тул төрийг иргэний нийгмийн болон зах зээлийн хэлбэрийн удирдлагаас ангид авч үздэг байлаа. Дээрх хоёр догматик таамаглалууд онолын хувьд нотлогдоогүй, тэдгээрийг практикт хэрэгжүүлэх оролдлогууд үндсэн эрхүүдийг олон хэлбэрээр ноцтойгоор зөрчигдөхөд хүргэдэг.

Зах зээл

Карл Полани зах зээл - нийгмийн харилцааны түүхийн судалгаандаа зах зээлүүд саяхныг болтол буюу 20-р зууны эхэн үед сүйрэлд орсон зарим зах зээлийг эс тооцвол тухайн нийгмийнхээ нийгэм, соёл, улс төрийн нягт хүрээлэлд оршин байдаг гэдгийг баттайгаар нотолсон байна. 1920-иод оны дэлхийн эдийн засгийн хямралаас хойш нийгмийн сайн сайхны төлөөх бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг хамгийн дээд түвшинд хүргэхийн тулд төр ба зах зээл хоорондоо нягт хамтран ажиллах ёстой гэдэг нь тодорхой болсон. Зах зээл үйл ажиллагааны чадамж бүхий хяналт, нөхөлт, зохицуулалтын дор оршиж, эдийн засгийн шийдвэр гаргах салбарууд улс төрийн шийдвэрүүдээр тодорхойлогдож, хязгаарлагдаж байх нөхцөлд л зах зээлүүд нийгэмд чухал ач холбогдолтой удирдлагын үүргээ гүйцэтгэж чаддаг. Өнгөрсөн хугацаанд дундад болон зүүн европын орнууд шинэ либерал завсрын үеийг давж зах зээлд «хүрээлэл» тогтоох буюу хариуцлага ногдуулах замыг дахин сонгоод байна. 21-р зууны эхэн үед орчин үеийн ардчиллын улс төрийн үндсэн чиглэлүүд практик үйл ажиллагаанд зах зээлийн «хүрээлэл» тогтоох буюу хариуцлага тогтоох зайлшгүй шаардлагатай гэдэг

дээр санал нэгдээд байна.

Шинжлэх ухааны энэхүү мэдлэг удаан хугацааны туршид хүнд нөхцөлийг туулан байж практикт хүлээн зөвшөөрөгдсөн байна. Уг мэдлэг олон улс орнуудад төрөл бүрийн урсгалуудад тусгалаа олсоор байсан боловч 1980-аад оноос нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн байна. Нийгмийн ардчиллын түүхэнд дараах туршлага, нотолгоонууд энэхүү суралцах процессод шийдвэрлэх үүрэг гүйцэтгэжээ.

Эдуард Вернштайн Марксын зах зээлийн удирдлагын тухай үнэлгээ нь туршлагын буруу таамаглал дээр суурилсан гэдгийг харуулсан. Маркс капитализм нь эдийн засгийн төвлөрлийн процессыг үүсгэх бөгөөд тэр нь эцэстээ улс ардын аж ахуйг цөөхөн тооны монополиуд, олигархуудын эрхшээлд оруулах болно гэдэг урьдчилсан таамаглал дэвшүүлсэн. Вернштайн дээрх таамаглалын эсрэг капиталист эдийн засгийн бүтэц илүү олон талтай болж тоо томшгүй олон жижиг-дунд-том үйлдвэрийн газрууд бий болгоно гэжээ. Вернштайн үүгээр зогсохгүй зөвхөн зах зээл л тоо томшгүй олон эдийн засгийн мэдээллийг хөдөлмөрийн бүтээмж, нийгмийн нөөц, хөгжлийн боломжуудын алдагдалгүйгээр эд хэрэглэгчдийн бие даасан байдалд халдалгүйгээр бүтээлчээр боловсруулах удирдлагын хэрэгсэл мөн гэж баталсан байдаг.

Зөвлөлтийн төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засаг ид хөгжин цэцэглэж түүний эдийн засаг, нийгэм, улс төрийн өртөг нүдэнд харагдахуйц өсөн нэмэгдэж байх үед дээрх нотолгооны ач холбогдол улам нэмэгдэж байлаа. 1920-иод оны үед уг онол улс ардын аж ахуй судлаач Эдуард Хайманы судалгаагаар улам баяжуулагдсан байна. Тэр монополиос ангид хөгжиж буй зах зээлүүд нь эдийн засгийн шийдвэрүүдэд нийгмийн зүгээс нөлөөлөх нөлөө бүхий хэрэгслүүд юм гэдгийг баталсан байна. Үүний зэрэгцээ эдийн засгийн ардчиллын концепц хөгжсөн

байна. Уг концепц нь зах зээлийн зохицуулалтын зарчмыг дэмжиж нөгөө талаас бүх түвшинд үйлдвэрээс компани, салбараас нийт улс ардын аж ахуйн бүхий л эдийн засгийн шийдвэр гаргалтад үйлдвэрчний эвлэлийнхэн болон улс төрийн төлөөлөгчдийн оролцоог хангахыг шаарддаг.

4.3. Өмчлөх эрх ба тэгш эрх чөлөөний тухай ойлголт

Европын түүхэнд хувийн өмчтэй байх хязгааргүй эрхийг тунхаглагч шинэ либерал концепц нэлээд хожуу хөгжсөн нь тухайн үедээ хэвийн бус үзэгдэлд тооцогдож байсан юм. Эрх зүйн сэтгэлгээ, улс төрийн практикт хувийн өмч бол бусдын эрхийг хэрэгжүүлж буй нэгэн хэлбэр гэдэг үзэл давамгайлж энэ нь цаг хугацаа өнгөрөх тутам батлагдана гэж үздэг байлаа. Уг үзэл хувийн өмч зөвхөн өмчлөгчийн хувийн эрх ашигт үйлчлэх ёсгүй, нийтийн ашиг тусын тулд зориулагдах ёстой гэдэг үзэл дээр суурилж байсан юм. Энэхүү нийгмийн өмчийн тухай ойлголтыг улс төрийн абсолютизм үүсэж улс төрийн эрх мэдлийг нийгмийн хариуцлагаас салгаж улмаар нийтийн ашиг сонирхлын эсрэг хандуулж эхэлсэн тул үндсээр нь авч үзэх шаардлага тулгарсан байна. Абсолютизмыг эсэргүүцэгчид хувийн өмч нь өмчтөнгүүдийн эрх чөлөөгөө эдлэх нөхцөлийг бүрдүүлж буй тул тэд өмчлөх эрхээ ямар нэгэн хязгаарлалтгүйгээр эдлэх ёстой гэсэн эсрэг нотолгоог гаргаж ирсэн байдаг. Гэхдээ тэд уг дүгнэлтдээ мөн тухайн цаг үед нийгэм татвар ногдуулах замаар хувийн өмчөө өмчлөх эрхэд тодорхой хэмжээний хязгаарлалт тавьж эхэлсэн гэдгийг анхаарлын гадна орхигдуулжээ. Аливаа хязгаарлалтаас ангид өмчлөх эрхийг хувийн өмчтөнгүүдэд эдлүүлэх боломж аль ч нийгэмд байхгүй юм. Энэ бол улс төрийн үл гүйцэлдэх үзэл юм. Өмчлөх эрхийн хэм хэмжээ, хязгаарыг улс төрөөс тогтоосоор ирсэн бөгөөд тогтоосоор ч байх болно.

Практик дээр жишээ нь: Нийгмийн ямар зорилгын төлөө хэдэн хувийн, ямар хэлбэрийн татварыг ямар шатлалтайгаар цаашид

тогтоох бэ? зэрэг шийдвэр байнга гарч байдаг. Гэхдээ хувь хүмүүсийн өмчийг төр ямар нэгэн нөхөн олговор олгохгүйгээр, зуун хувь мэдэлдээ авч болохгүй гэдэг зарчим үйлчилдэг. Бусад бүх асуудал хамтын нийгэмлэг буюу нийгмийн улс төрийн шийдвэрлэх асуудал бөгөөд тухайн улс орны улс төрийн соёлын уламжлалаас хамааран өөр өөр байдаг.

Холбооны Герман Улсын эрх зүйн практикт өмчийн концепцыг тусгасан байдал

ХБНГУ-д нэн ялангуяа Үндсэн Хуулийн дараах заалтууд эдийн засгийн таваар дахь өмчийн нийгмийн цар хүрээг тодорхойлдог.

14-р зүйл [Өмч, Өмчийг эзэмшигчийн нас барсны дараа захиран зарцуулах тухай эрх зүйн баримт бичгүүд, Өмчийг зохих дүрэм журмын дагуу нийтийн тусын тулд дайчлах]

- (1) Өмч болон өмчийг залгамжлуулан өвлүүлэх асуудлыг баталгаажуулна.(...)(2) Өмчид хариуцлага ногдоно. Өмчийн хэрэгдээ нийтийн тусын тулд зориулагдана. (3) Өмчийг нийтийн тусын тулд дайчилж болно.(...)

15-р зүйл [Өмчийг нийгэмчлэх]

«Газар, байгалийн баялаг, үйлдвэрлэлийн хэрэгслүүдийн нөхөн олговор, түүний хэлбэр, хэмжээг тогтоох тухай зохих хуулийн дагуу нийгмийн тусын тулд нийгмийн өмчид эсвэл хамтын нийгэмлэгийн эдийн засгийн өөр хэлбэрт шилжүүлж болно.»

Компаниудын шийдвэр гаргалтад ажилтнуудын оролцоог хангах тухай шүүхийн нэгэн тогтоолд Холбооны үндсэн хуулийн шүүх өмчтэй холбоотой шийдвэр гарсны улмаас эрх нь хөндөгдөж буй талуудын үндсэн эрхүүдийг ямар харьцаатайгаар авч үзэх ёстой тухай заасан байдаг. Үүндээ хувийн өмчийн хэрэглээний үнэлэмжийн хоёр өөр цар хүрээг тогтоосон байдаг.

Өмчийн эрх зүйн цар хүрээ нь өмчлөгчдөд «өөрийн хүссэнээр амьдрах» баталгаа нь болж байдаг тул хувь хүмүүсийн эрх

чөлөөтэй холбоотой. Өмчтэй байх үндсэн эрх, үйл ажиллагаа явуулах эрх чөлөөтэй байх үндсэн эрх хоёрын хоорондын уялдаа холбоог Холбооны үндсэн хуулийн шүүхээс харьцангуй явцуу тогтоосон байдаг. Шүүх төрийн зүгээс өмчлөх эрхийг хязгаарлах шаардлагагүй гэж үздэг. «Өмч нь хувь хүмүүсийн эрх чөлөөгөө баталгаажуулах хэрэгслийн үүргийг гүйцэтгэж байгаа тохиолдолд онцгой хамгаалалтад байх ёстой.» гэж шүүх үздэг. Харин өмч хувийн хэрэгслүүдийн үүргийн хүрээнээс хальж өмчийн нийгмийн цар хүрээний асуудал яригдаж эхлэх үеэс төрийн зохицуулалтын үйл ажиллагаа эхлэх ёстой гэж Холбооны үндсэн хуулийн шүүх үздэг. «Хувийн өмчийн объектын нийгмийн хамаарал, нийгмийн үүрэг нэмэгдэх тутам хууль тогтоогчийн зүгээс хувийн өмчийн хэрэглээ болон хязгаарлах цар хүрээг тодорхойлж өгөх шаардлага улам бүр нэмэгдэнэ» гэж заасан. Энэ нь эдийн засгийн компанийг өмчлөгчийн эрхийн тухай шийдвэрт илүү тодорхой харагдана. Бусдын хувийн өмчийг ашиглан амьжиргааны эх үүсвэрээ олдог ажилтнууд, албан хаагчид амьдралаа хариуцлагатайгаар авч явахын тулд үйл ажиллагааны болон мэргэжлээ өөрөө сонгох эрх чөлөөний хувьд хязгаарлагдмал байдалд ороход хүрдэг гэж шүүх онцгойлон заасан байдаг. Хууль тогтоогчид өмчгүй иргэдийн үндсэн эрхүүдийг өмчтэй иргэдийн үндсэн эрхүүдтэй эн тэнцүү авч үзэх үүрэгтэй гэж хэлж болох юм. Тиймээс хувийн өмчийн хэрэглээнд зохицуулалтын дүрэм, хязгаарыг тогтоож хэрэгжүүлэх нь хууль тогтоогчийн үүрэг юм.

Компаниудын шийдвэр гаргалтад ажилтнуудын оролцох эрхийн тухай хууль нь өмчлөх эрхийн нийгмийн цар хүрээг тогтоох нэгэн оролдлого юм. Хувийн өмч өмчийн цар хүрээний хувьд чөлөөтэй хэрэглэгдэж болох бөгөөд (жишээ нь: Өмчлөгч өмчөө компаниас татан авах тохиолдолд) хамт олны зөвшөөрлийг авах шаардлагагүй. Гэхдээ нийгмийн цар хүрээ талаас нь авч үзвэл хэдийгээр хувийн өмч боловч тухайн компанид ажиллагсад татан авахад хориг тавих эрхтэй.

Үндсэн хуулийн зүгээс авч үзвэл хувийн өмчид өмчийн цар хүрээний хувьд татвар төлөх замаар нийгмийн өмнө хариуцлага хүлээлгэдэг. Татварын хэмжээг улс төрийн шийдвэрээр тогтоодог. Энэ нь өмчийн тодорхой хэсгийг нийтийн сайн сайхны төлөө зарцуулна гэсэн үг юм.

Хувийн өмч ба үндсэн эрхүүд зөрчигдөх тохиолдлууд
Үйлдвэрлэлийн хэрэгслийн хэлбэрээр хувийн өмчийг эзэмшигч гуравдагч этгээдийн үндсэн эрхүүдийг зарим тодорхой нөхцөлд зөрчихөд хүргэдэг. Жишээ нь: эдийн засгийн таваарын хувийн өмчтэй байх тохиолдолд:

- Өмчгүй хүмүүсийн өмчтэй болох замд саад тотгор учруулдаг.
- Зах зээлийн төвлөрөл, түүний үр дагавраар өрсөлдөөн хязгаарлагдах нь үнийн хэт өсөлт болон эд хэрэглэгчдийн бие даасан байдал хязгаарлагдахад хүргэдэг.
- Мэдээллийн процессод нөөцийг тэгш бус идэвхжүүлсний улмаас улс төрийн тэгш байдал зөрчигдөхөд хүрдэг.
- Улс төрийн эзэрхэг хэсэгт шахалт үзүүлэх замаар ардчиллын зарим хөтөлбөрүүдийн хэрэгжилтэд саад тотгор учруулдаг.

Нийгмийн ардчилалд үндсэн эрхүүд зөрчигдөх дээрх хэлбэрүүдийг улс төрийн үйл ажиллагаагаар хязгаарлахын тулд зах зээлд эдийн засгийн хариуцлага ноогдуулж, зохицуулалтын бодлогыг явуулдаг.

4.4. Эдийн засгийн зохицуулалт

Зах зээлүүд системийн гаралтай функцийг гажуудлыг агуулж байдаг тул эдийн засгийн үр ашиг, улс төрөөр дамжин тодорхойлогдох нийгмийн ашиг сонирхлын хоорондын зөрчлийг бууруулах зорилготой эдийн засгийн зохицуулалтын бодлого шаардлагатай. Зах зээлүүд өөрийн зохицуулалтын

удирдлагын механизмуудаараа зохицуулагдаж байх нөхцөлд л нийгмийн үүргээ гүйцэтгэх чадамжтай байдаг, тэдгээр нь нийгмийн үнэлэмжүүдтэй зарчмын хувьд тохирч байдаг гэдэг санаа нь зах зээлүүдийн өнөөг хүртэл хуримтлагдсан бүхий л туршлага, мэдлэгтэй зөрчилдөж байгаа юм. Эдийн засгийн зохицуулалтын бодлого нь эдийн засгийн шийдвэр гаргалтад мөрдөгдөх ерөнхий зарчмуудын боловсруулалт, тэдгээрийн хэрэгжилтэд тавих хяналт, биелүүлээгүй тохиолдолд шахалт үзүүлэх арга хэлбэрүүдийн цогц юм. Уг бодлого хэрэгжилтийн маш олон урьдчилсан нөхцөлүүдийг шаарддаг бөгөөд ихэнх тохиолдолд хүсээгүй дагалдах үр дагавруудыг дагуулж байдаг.

Улс төрийн шийдвэр гаргах системүүдийн үүргийн логик болон эдийн засгийн дэд системүүдийн үүргийн логикуудын хооронд аль нэгнийх нь логикийг нөгөөд нь шилжүүлснээр арилахгүй зарчмын үл ойлголцол, зөрчил агуулагдаж байдаг. Иймээс улс төрийн логикийн хэрэгслүүдээр дамжуулан эдийн засгийн логикийн хязгаарууд ба зорилтуудыг тогтоож өгөх ёстой. Гэхдээ тэдгээрийн үндсэн агуулгыг хүсээгүй, дагалдах хэлбэрээр алдагдуулахгүй байхад ихээхэн анхаарах ёстой.

Орчин цагийн түүхэнд дээрх хоёр системийн функцийн логикийг хооронд нь нэгтгэх гэсэн хоёр удаагийн нийгмийн томоохон оролдлого тэмдэглэгдсэн. Дээрх хоёр оролдлогууд хоёулаа нийгэмд дааж давшгүй их хохирол учруулж бүтэлгүйтсэн. Энэ нь **нэгдүгээрт** зах зээлийн логикийг улс төрийн зохицуулалтын логикоос ангид авч үзэх, түүний бие даасан байдлыг хангах гэсэн либертар оролдлого байв. Энэ оролдлого дэлхийн нэгдүгээр дайны дараах жилүүдэд дэлхийн эдийн засгийг хямралд хүргэснээр дуусгавар болсон. **Хоёрдох** нь марксизм - ленинизмийн онол дээр суурилан эдийн засгийн дэд системүүдийг зөвхөн улс төрийн эрх мэдлээр удирдах гэсэн коммунист зөвлөлтийн оролдлого байсан юм. Дээрх оролдлого үйлдвэрлэх хүчний хөгжлийг олон арван жилийн

туршид доройтуулсаар аажимдаа эдийн засаг улс төрийн системийг бүхэлд нь уналтад хүргэснээр төгсгөл болсон юм.

Нийгмийн ардчиллын үзэл баримтлал нь зах зээлүүдийг аль болох улс төрөөс тодорхойлсон зорилтуудтай нийцүүлэн хөгжүүлэх чадамж бүхий эдийн засгийн зохицуулалтын хэлбэрийг номлосоор ирсэн. Хэдийгээр зах зээлийн зохицуулалт хийгдэх боловч тэдгээрийн үйл ажиллагааны чадамж бүрэн хадгалагдаж байхад анхаарах ёстой. Зах зээл нь өөрийн шинж чанарын хувьд уян хатан, хөдөлгөөнтэй, зөвхөн хязгаарлагдмал хүрээнд урьдчилан тооцоолох боломжтой байдаг тул эдийн засгийн зохицуулалтын бодлогыг амжилттай хэрэгжүүлэхийн тулд уг бодлогын зорилтууд, хэрэгслүүд мөн уян хатан, хөдөлгөөнтэй байх ёстой. Тийм ч учраас эдийн засгийн зохицуулалтын хэрэгслүүдийн уян хатан чанар, прагматик нээлттэй байдлыг зөвхөн ганц улс төрийн ашиг сонирхлуудын харилцан буултын үр дүн гэж үзэх нь өрөөсгөл юм. Зах зээлийн уян хатан чанар ба прагматик нээлттэй байдал нь чухал үндсэн эрхүүд ба нийгмийн эдийн засгийн функцийн нөхцөлүүдийн дотоод зөрчлүүдээс урган гардаг. Хангалуун амьдралын түвшинг дээшлүүлэх, худалдааны чөлөөт сонголтуудыг хангах зорилтууд нь хөдөлмөрийн насны бүх иргэдийг ажлын байраар хангах, хүрээлэн байгаа орчны экологийн тэнцвэртэй байдлыг хангах, эдийн засгийн өсөлтийг тогтвортойгоор нэмэгдүүлэх зорилтуудтай нийцэж байх ёстой.

Зах зээлийн улс төрийн зохицуулалтын бодлогыг амжилттай хэрэгжүүлэхийн тулд хууль ёсны зохицуулалтын механизмыг бий болгох, тэдгээрийн хэрэгжилтийн явцад шаардлагатай тохиолдолд гүйцэтгэх засаглал болон хуулийн хяналтын байгууллагуудын зүгээс албадлагын хэрэгслүүдийг хэрэглэхэд шаардагдах эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлагатай. Улс төрийн нийгэм нь зарчмын хувьд зах зээлийн эдийн засгийн дэд системүүдэд нөлөөлөх боломжоор хангагдсан

байх ёстой. Улс төрийн зохицуулалт хийнэ гэдэг нь макро эдийн засгийн удирдлагаар дамжуулан компаниудын үйл ажиллагааны хүрээнд хөндлөнгөөс оролцох бололцоог бүрдүүлэх гэсэн санаа юм. Нөгөө талаар уг үйл ажиллагааны цар хүрээ нь компаниуд нийгмийн зүгээс хүсэж буй хэмжээнд үйл ажиллагаагаа явуулах нөхцөлийг хангах, шаардлагатай тохиолдолд тэдний үйл ажиллагаанд төрийн зүгээс дэмжлэг үзүүлэх хэмжээнд нээлттэй байх ёстой.

Ихэнх тохиолдолд зах зээлүүд тэдгээрийн үйлдвэрлэгч эдийн засгийн функцтэй салшгүй холбоотой олон төрлийн гажуудлыг өөртөө агуулж байдаг тул «Зах зээл гажуудах»-д хүргэдэг гурван нэгдмэл үндсэн шалтгаануудыг хооронд нь ялгаж өгөх шаардлагатай:

1. Байгалийн монополиудын оршин тогтнол

Дан ганц зах зээлийн зохицуулалт нь жишээлбэл төмөр зам, эрчим хүчний хангамж, цахилгаан холбоо зэрэг салбаруудад шаардлагатай бүтээмжийг үйлдвэрлэж чадахгүйд хүргэж, үйлдвэрлэсэн ч хэт өндөр үнээр хэрэглэгчдэд хүрэх нөхцөлийг бүрдүүлдэг. Дээрх салбарууд нийгмийн онцгой чухал дэд бүтэц бөгөөд үндсэн хангамж үйлдвэрлэгддэг учраас төрийн үйл ажиллагаа, зохицуулалт зайлшгүй шаардлагатай. Зөвхөн улс төрийн хөндлөнгийн оролцоо буюу зохицуулалтаар зах зээлтэй төсөөтэй нөхцөлүүдийг бүрдүүлж эдийн засгийн бүтээмжийг үйлдвэрлэх боломжтой.

2. Сөрөг зөрчилдөөнүүд

Зах зээлийн оролцогчид зардал, ачааллыг гуравдагч этгээдэд үүрүүлж орхисны улмаас нийгмийн зардлыг нэмэгдүүлж уг зардлыг улс төрийн хамтын нийгэмлэг нөхөн төлөхөөс өөр аргагүй байдал үүсэхийг сөрөг зөрчлүүд гэнэ. Үүний жишээ бол хортой бодисын нөлөөгөөр байгаль орчин бохирдох, зах зээлийн өсөлтийн эрчтэй динамикийн улмаас ажилгүйдэл бий болгох зэрэг юм. Өөр нэг жишээ бол: даяаршлын нөлөөгөөр

үндэстэн дамнасан санхүүгийн хямрал үүссэний улмаас эдийн засгийн өсөлт буурч үй олноороо ажилгүйдэлд нэрвэгдэж буй явдал. Эдийн засгийн зохицуулалтын бодлого дээрх хэлбэрийн гадаад нөлөөг огт үүсгэхгүй байх эсхүл дээрх хүндрэлүүд учирсан тохиолдолд үүсгэгчдээр нь төлүүлэх замаар нийгэмд ачааг үүрүүлэхгүй байхад чиглэгдэнэ.

3. Тэгш бус мэдээллийн улмаас хохирох

Олон салбаруудад үйлдвэрлэгчид болон бүтээгдэхүүн, үйлчилгээний хэрэглэгчид үнэ, чанарын талаар зарчмын хувьд тэгш бус мэдээлэлтэй байдаг. Жишээ нь: Хуучин авто машин худалдан авагч гэрээ байгуулагдахаас өмнө машины чанар муу эсвэл сайн гэдгийг мэдэх бололцоо маш багатай байдаг. Мөн үүний нэг тодорхой жишээ бол: Өвчтөнүүд нь эмч нарын түвшинд анагаахын боловсрол эзэмшээгүй байдаг тул худалдан авч буй эмнэлгийн үйлчилгээнийхээ чанарын тухай үндсэн ойлголт муутай байдаг. Ульрих Век эдгээр тохиолдлуудыг зах зээлийн гажуудал, тэр ч байтугай эрсдэлийн үйлдвэрлэлийн нэгэн шинэ хэлбэр гэж нэрлэсэн байна. Орчин үеийн техникийн хэрэглээний улмаас үүсэх шинэ хэлбэрийн эрсдэлүүд хохирогчдод маш гүнзгий нөлөөлөөд зогсохгүй, хохирогчид уг хохирлын тухай мэдэх боломж бараг үгүй байдгаараа онцлог юм. Аюултай бодисын хор хөнөөлийн тухай тоон мэдээлэл тодорхой байлаа ч уг тоон үзүүлэлт хэр хэмжээний аюул авчрах бэ? гэдгийг зөвхөн мэргэжлийн хүмүүс л тооцоолж чадна. Уг мэргэжилтний юу хэлэхээс хувь хүмүүсийн хувь заяа хамаарна гэсэн үг.

Тэгш бус мэдээллийн асуудал улс төрийн зохицуулалтыг шаардах дараах хоёр өөр шаардлагуудыг дагуулдаг.

Нэгдүгээрт: Хүнсний бүтээгдэхүүнүүдийн орц, үйлдвэрлэлд хэрэглэгдэх материалуудын хортой бодисын агуулга зэрэг бүтээгдэхүүний шинж чанарыг илэрхийлэх үзүүлэлтүүдийг

маш сайн тодорхойлохыг шаардаж байна.

Хоёрдугаарт: Эрсдэлийн үнэлгээ хараат бус байх ёстой. Жишээ нь хорт бодисуудын хэмжээ тогтоосон хэмжээнээс давсан тохиолдолд үүсэх үр дагаварт үнэлгээ өгөх. Энэ тохиолдолд иргэд өөрсдөө хянаж шалгах боломжгүй учраас мэргэжилтнүүдийн үнэлгээнд найдахаас өөр аргагүй. Иймээс мэргэжилтнүүдийн санал зөвлөгөөг зохион байгуулах, олон нийтэд хүргэх нь төрийн үүрэг юм. Дээрх төрлийн эрсдэлүүдээс урьдчилан сэргийлэх нь улс төрийн зохицуулалтын үүрэг мөн.

1990-ээд оноос хойших хөгжлийн дараах гурван үндсэн чиг хандлагын улмаас эдийн засгийн зохицуулалт хийх шаардлага улам нэмэгдсэн. **Нэгдүгээрт:** өмнө нь төр хариуцдаг байсан үйлчилгээний салбарууд ихээр хувьчлагдсан, **хоёрдугаарт:** зах зээлийн үндэстэн дамжсан нэгдэл нь гадаад нөлөөллүүд, тэдгээрийг улс төрийн аргаар зохицуулах боломжуудын хоорондын ангальг улам бүр нэмэгдүүлсэн, **гуравдугаарт:** зохицуулалтгүй эдийн засгийн өсөлтийн улмаас урьдчилан тооцоолох боломжгүй иргэншил-байгаль орчны эрсдэлүүд нэмэгдсэн. Хөгжлийн дээрх чиг хандлагын улмаас зохицуулалтын бодлогыг өрсөлдөөний нөхцөлүүдийг баталгаажуулах хүрээнд хязгаарлах ёстой гэж үздэг либертар үзэл олон салбарт хамгаалалтад ороход хүрээд байгаа юм. Өнөө үед эдийн засгийн зохицуулалтын бодлого хэрэгжүүлэх шаардлагатай гэдэг нь нийтэд ойлгомжтой болоод байна. Иймээс дараах асуултуудад нэн даруй хариулт өгөх шаардлага тулгараад байна: Эдийн засаг - улс төрийн ямар хэрэгслүүд хамгийн тохиромжтой бэ? Эдийн засгийн бодлогын зорилтуудыг улс төрийн шийдвэр гаргалтын ямар хэлбэрүүдээр тодорхойлох бэ? Уг зорилтуудыг хэрэгжүүлэх улс төрийн хүсэл сонирхлыг даяаршлын тавцан дээр хэрхэн идэвхжүүлэн зохион байгуулах бэ?

Өнөөгийн эдийн засаг ба техникийн иргэншил нь хоорондоо эрс ялгаатай эсрэг тэсрэг улс төрийн стратеги шаардах дараах

хоёр төрлийн эрсдэлүүдийг бий болгож байгаа юм. Нэгдүгээрт: Нийгэм ба бүтцийн эрсдэлүүд, хоёрдугаарт техник ба шинжлэх ухааны үйлдвэрлэлийн боломжуудын шинэ хэлбэрүүдээс үүдэлтэй эрсдэлүүд, Нэгдүгээрт нь капиталист ерөнхий зарчим дээр суурилсан нийгмийн бүтцэд өөрт нь агуулагдаж байдаг тул тэдгээрийн шалтгааныг нарийн тодорхойлж улс төрийн аргаар төгс шийдвэрлэх боломжтой. Хоёрдугаарт хамаарах эрсдэлүүдийн улмаас өөр төрлийн бэрхшээлүүд үүсдэг. Энэ эрсдэлийн сонгодог жишээ бол цөмийн энергийн хэрэглээ юм. Цөмийн энергийн хэрэглээнээс ямар хэлбэрийн эрсдэл гарах бэ? эрсдэлийн хэмжээ ямар байх бэ? түүгээр ч зогсохгүй уг шинэ технологиос татгалзсан тохиолдолд нийгмийн сайн сайханд хэр хэмжээний хохирол учрах бэ? гэдэг ч тодорхой бус байгаа юм.

Зохицуулалтын бодлогын стратегиуд

Өнөөг хүртэл нийгмийн ардчиллын төслийн хүрээнд макро эдийн засгийн зохицуулалтын дараах дөрвөн стратегиуд боловсруулагдаж тэдгээр нь харилцан адилгүй түвшинд практик дээр туршигдсан байна. Эхний хоёр стратегиуд нь программын хүрээнээс халиагүй бол нөгөө хоёр нь дэлхийн олон орнуудад удаан хугацааны туршид практикт амжилттай хэрэгжиж иржээ. Эдгээр нь:

1. Эдийн засгийн ардчилал
2. Ажилтнуудын фондоор дамжуулан өмчлөгчдийн эрхийг ардчилах
3. Кенсийн макро эдийн засгийн зохицуулалтын онол
4. Төр ба нийгмийн түншүүдийн хоорондын эргэх зохицуулалт бүхий шинэлэг хамтарсан хэлбэрийн төрөл бүрийн хувилбарууд

Макро эдийн засгийн дээрх дөрвөн стратегиуд нь капиталист зах зээлүүдийн удирдлагын функцүүдийг хамрагдах иргэдийн үндсэн эрхүүдтэй зөрчилдөхгүй байх хязгаарыг хүртэл хүлээн зөвшөөрдөг.

1. Эдийн засгийн ардчилал

Эдийн засгийн ардчиллын концепц нь Герман улсад эдийн засагч эрдэмтэд, үйлдвэрчний эвлэлийн онолчдын хамтын ажиллагааны хүрээнд Ваймарын Бүгд Найрамдах улсын үед үлгэр жишээ болохуйц түвшинд хүртэл хөгжсөн байна. 1990-ээд оныг хүртэл засгийн газрын хөтөлбөрүүдийн хүрээнд хэрэгжсээр ирсэн ч социал демократууд засгийн газрыг тэргүүлж байх үедээ өөр намуудын тэргүүлсэн засгийн газруудаас илүү өргөн хүрээнд уг хөтөлбөрийг хэрэгжүүлж байсан уу? гэвэл үгүй юм. Бүх түвшинд эдийн засгийн бодлогын болон макро эдийн засгийн шийдвэрийг тэгш төлөөлөл бүхий парламентаризмын хэлбэрээр гаргах замаар эдийн засгийн удирдлагыг хэрэгжүүлж болно гэдэг төсөөлөл дээр уг концепц суурилдаг. Уг загвар орой дээр нь засгийн газар, ажилтнууд, ажил олгогчдын гуравны нэгийн харьцаатай тэгш төлөөлөл бүхий эдийн засаг ба нийгмийн нэгдсэн зөвлөл байрлах шийдвэр гаргалтын пирамид хэлбэрт бүтцийг төсөөлж уг бүтэц нь макро эдийн засгийн зорилтуудыг тодорхойлно гэж үздэг. Түүний доор байрлах шийдвэр гаргалтын түвшингүүд дээр удирдлагын нэгдсэн зааварчилгаануудыг нарийвчлан тогтоох, тайлбарлах үүрэг бүхий эдийн засаг - нийгмийн зөвлөлүүд жишээ нь: компаниудын хяналтын зөвлөлүүд байрлана.

Эдийн засгийн ардчиллын загварт шийдвэр шаардсан бэрхшээлтэй асуудлууд олон байгаа: Оролцогч улс төрийн актёрууд, ажилтнууд, ажил олгогчдын төлөөлөгчдийн хооронд хэрхэн харилцан буулт эсхүл зөвшилцөлд хүрэх бэ? Талууд харилцан ойлголцолд хүрч чадаагүй тохиолдолд шийдвэрт хэрхэн хүрэх бэ? Үндэстэн дамнасан нэгдсэн зах зээлүүдийн шаардлагад нийцэхүйц хурдан хугацаанд хариулт өгөх хэмжээнд системийн уян хатан чанар бүрдсэн үү? Хэдийгээр дээрх асуултууд чухал асуултууд боловч ийм систем хөрөнгө оруулагчдын сонирхлыг татах уу? гэдэг хамгийн чухал асуудал юм. Тэд өөрийн хөрөнгөө захиран зарцуулах эцсийн шийдвэр

гаргах эрхгүй, компаниудын шийдвэрт бусад оролцогч актёрууд хориг тавих эрхтэй. Компанийн удирдлагын шийдвэр гаргалтад оролцох дээрх хэлбэр нь төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засагтай харьцуулахад илүү ардчилалтай ч компанийн эздийн үйл ажиллагаанд ижил хэмжээний хязгаарлалт тавигдаж байгаа юм. Хамтын шийдвэр гаргалтын уг хэлбэр ямар үр дагаварт хүргэх бэ? гэвэл тухайн системийг сонирхох хувийн хөрөнгө оруулагчдын сонирхлыг бууруулж ингэснээр практик үүргээ гүйцэтгэх чадамжтай байх анхдагч нөхцөлийг нь үгүй хийж байгаа юм. Дээрх нөхцөлд эдийн засгийн функцийн логик хөгжих боломж бараг бүрдэхгүй.

Европын олон оронд социал демократууд засгийн эрхийг барьж байх үедээ мөрийн хөтөлбөртөө эдийн засгийн ардчиллын концепцыг бүрэн хэрэгжүүлэх оролдлого хийж байсан жишээ байхгүй. Коммунист Зөвлөлт Холбоот улсын төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засаг нуран унасны дараа эдийн засгийн ардчиллын зохицуулалтын загварыг иж бүрнээр нь хэрэгжүүлэх асуудал бараг орхигдсон гэж хэлж болно. Уг концепцын зарим элементүүд социал демократ улс төрийн намуудын мөрийн хөтөлбөрүүдэд тусгагдсан хэвээр байдаг.

2. Ардчилагч ажилтнуудын фонд

Уг загварыг Шведийн үйлдвэрчний эвлэлийнхэн болон зарим тэргүүлэх эдийн засагчид хамтран боловсруулсан бөгөөд 1970 -аад оны үед богино хугацаанд практик дээр туршсан юм. Уг загвар маш энгийн улс төр ба эдийн засгийн логик дээр суурилдаг. Эдийн засгийн өсөлт буурсны улмаас ажилтнуудын бодит цалин зогсонги байдалд орсон үед тэдний орлогын тодорхой хувийг компанийн хувьцаа хэлбэрээр олгодог. Уг хувийг компаниас тусдаа фондод байршуулж тэндээс тухайн орны бусад хувийн компаниудад эргэх хөрөнгө оруулалтыг хийдэг. Энэ замаар тухайн компанийн шийдвэр гаргалтын эрх мэдэл аажмаар фонд эзэмшигчдийн гарт шилждэг

боловч харин үйлдвэрийн хэрэгслийн хэлбэрээр оршин буй хувийн өмчөө тодорхой цаг хугацааны дараа алдах эрсдэлээс хамгаалагдсан байдаг.

Шведийн компаниудын холбоод ардчилагч ажилтнуудын фондыг хамгийн ойрын шалтгааны улмаас бусдын хөрөнгийг булаах хөнгөн хэлбэрийн өнгөлөн далдлалт бүхий хэлбэр гэж үзсэн байна. Тэдний зүгээс хүчтэй шахалт үзүүлсний дараа улс төрийн нөхцөл шалтгаануудын улмаас уг туршилт зогссон учраас түүнээс гарах үр дагавар харагдах хэмжээнд хүртэл үргэлжлээгүй юм.

Компаниудаас гадуур ажилтнуудын фондыг бүрдүүлэх нь ашиг сонирхлын төлөөлөгчдөд «хоёрдмол үүрэг» ногдох аюултай. Үйлдвэрчний эвлэлийн гишүүдэд капитал өмчлөгчийн давхар үүрэг ногдоно гэсэн үг. Ингэснээр тэд нэг талаас өмчлөгчдийн үүргийг хүлээж нөгөө талаас ажилтнуудын эрх ашгийг хамгаалах давхар үүрэг ногдож шийдвэрлэхэд хэцүү асуудалтай тулгардаг. Дээрх загварын гол бэрхшээл нь хувийн хөрөнгө оруулагчид тэдний итгэмжлэгдсэн төлөөлөгчид аажмаар шийдвэр гаргалтын бие даасан байдлаа алдаж ингэснээр дээрх төрлийн загварт хамтран оролцох сонирхлоо гээдэг аюултай. Хэдийгээр уг загвар улс төрийн хэрэгжилтийн логикийн дутагдалтай талуудынхаа улмаас хэрэгжих бололцоогоо алдсан ч нөгөөтээгүүр эдийн засгийн логикийн эргэлзээтэй асуудлууд нь түүний функцийн тохирох эсэх тухай асуудлыг хөндөж байгаа юм.

3. Макро эдийн засгийн зохицуулалтын Кенсийн онол

Дэлхийн хоёрдугаар дайны дараах гучин жилд Европын социал демократ засаглалтай улс орнууд кенсийн макро эдийн засгийн зохицуулалтын бодлогыг нийгмийн ардчиллын улс төрийн эдийн засгийн зохицуулалтын хаан замнал хэмээн хошуурцгааж байлаа. Уг стратеги нь төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн

бүхий л хэлбэрээс татгалзахын зэрэгцээ социал демократ үзэл баримтлалд уламжлал болсон эдийн засгийн болон нийгмийн бодлогын зорилтуудыг хэрэгжүүлэхийг амлаж байлаа. «Алтан үе» -ийн практик эхэндээ уг таамаглал зөв гэдгийг баталж буй мэт харагдаж байлаа. Кенсийн зохицуулалтын онолоор зах зээл-төрийн зохицуулалтын давуу талуудыг агуулсан хүсээгүй сөрөг үр дагавар багатай хэрэгслийг тэд олсон мэт харагдаж байлаа.

Кенсийн зохицуулалтын дийлэнх хувь нь капиталист зах зээлийн эдийн засгийн өсөлтийн явцаас тэнцвэржих давтамжит бус төрийн төсвийн зарцуулалтын бодлогыг эдийн засгийн нийт эрэлтийг нэмэгдүүлэх, олон нийтийн таваарын үйлдвэрлэл буюу нийгмийн үйлчилгээг дэмжих нийтийн зарлагын хөтөлбөрүүдтэй хослуулахад чиглэгдэж байлаа. Түүнчлэн энэ замаар нийгмийн ардчиллын шинэчлэлийн бодлогын бүрэлдэхүүн хэсэг болох эдийн засгийн өсөлтийг тогтворжуулах, бүх нийтийг ажлын байраар хангах хөдөлмөр эрхлэлтийн бодлогыг хэрэгжүүлэх нөхцөл бүрдэж улс төрийн зүгээс ногдуулсан нийтийн үүрэг мөн хэрэгжиж байлаа. Эдгээр нь социал демократ шинэчлэлийн хөтөлбөрийн бүрэлдэхүүн хэсэг болж байлаа. Нэн ялангуяа 1960 - 1970-аад онд эдийн засгийн зохицуулалтын уг хэлбэр цэцэглэн хөгжиж байлаа. 1970-аад оны дунд үеэс үндэстэн дамнасан зохицуулалтын Вреттон - Вудсын хэрэгслүүдийн бууралт маш хурдан хугацааны дотор зах зээлүүдийн даяаршлын нэгдлийг бий болгож дээрх хэлбэрийн макро эдийн засгийн зохицуулалтын хүч маш эрчимтэйгээр саарсан байна. Мөнгөний хүүгийн бие даасан байдал алдагдаж даяаршлын түвшинд нэгдсэн санхүүгийн зах зээлүүдийн хязгааргүй нөлөө нь үндэсний түвшинд явагдаж байсан кенсийн зохицуулалтын бодлогын хэрэгслүүдийн нөлөөг үлэмж хэмжээгээр бууруулсан байна. Эдгээр хэрэгслүүд олон ажиглагчдын үзэж байгаагаар бүрэн хэмжээгээр эрх мэдлээ алдаагүй боловч тэдгээрийн бие даасан макро-эдийн засгийн зохицуулалтын чадамж даяаршлын нөхцөлд маш ихээр суларсан байна.

4. Шинэ хамтын ажиллагааны Эргэх - Зохицуулалт

Социал демократ засаглалтай олон орнуудад (Жишээ нь: Швед, Голланд, ХБНГУ зэрэг) тухайн үед Кенсийн зохицуулалтын бодлого маш амжилттай хэрэгжиж байсан бөгөөд шинэ хамтын ажиллагааны Эргэх - Зохицуулалтын хэрэгслүүд нэгэн зэрэг хэрэглэгдэж байсан юм. Уг стратеги үйлдвэрчний эвлэлийнхэн, компаниудын холбоод, төрийн актёрууд хоорондын тохиролцоонд заагдсан эдийн засгийн үндсэн өгөгдлүүд, зорилтот өгөгдлүүдийг хамтарсан боловсруулалт, тэдгээрийн практик хэрэгжилтийг хангаж өгдөг. Шинэ хамтын ажиллагааны зохицуулалт тарифын автономит эрхийг бүрэн хэмжээгээр шахан зайлуулж чадаагүй боловч олон талаар макро эдийн засгийн зохицуулалтыг хариуцсан актёруудыг хооронд нь холбож байлаа. Тэдний үйлчлэлийн чадамж өндөр байгаа нь хариуцсан байгууллагууд нь зорилтуудын тодорхойлолт, хэрэгжилтийн хяналтыг нэг гарт төвлөрүүлж чадсанд оршино.

Дээрх хэлбэрийн зохицуулалтын үр дүн юуны түрүүнд оролцогч актёруудын харилцан итгэлцлээс ихээхэн хамаардаг. Уг харилцан итгэлцэл хамтын ажиллагааны процесс, үр дүнгийн явцад нөхөн шинэчлэгдэж байдаг. Итгэлцэл үгүй болсон тохиолдолд уг загвар хэрэгжих суурьгүй болдог.

Эдийн засгийн даяаршлын улмаас улс үндэстний түвшинд хэрэгжиж байсан макро эдийн засгийн зохицуулалтын үндэсний стратегиуд хямралд орж эхэлсэн байна. Нээлттэй зах зээлүүдийн зүгээс ирэх дарамт ихэссэн нь хамтын ажиллагааны бүтцийн зохион байгуулалтад хүндрэл учруулж амжилтад хүргэх нөхцөлүүд өөрчлөгдсөөр байна. Германы «Хөдөлмөрийн холбоо»-г (1998 - 2002) хамтарсан зохицуулалтыг хэрэгжүүлэх зорилгоор байгуулсан бөгөөд уг байгууллагын үйл ажиллагаа жишээ нь: Хэлэлцээрт оролцогч талууд зөвхөн аргагүй байдалд орсон нөхцөлд тохиролцоонд

хүрч шаардагдах харилцан буултыг хийдэг гэдгийг харуулсан байна. Уг хамтын ажиллагааны сайн дурын холбогч хүч нь шинээр урган гарч буй шаардлагуудад тохирсон хамтын шийдлийг олоход хүрэлцдэггүй байна. Компаниудын хувьд өртөг багатай орнууд уруу шилжих сонголтын боломж улам бүр нээлттэй болсоор байна. Үйлдвэрчний эвлэлийнхэн гишүүдээ олноор алдаж байгаа нь тэдний төлөөллийн эрх мэдлийг бууруулж энэ нь эргээд тэдний өөрчлөлт шинэчлэлд нээлттэй байх бололцоог хязгаарлаж байна.

Даяаршлын процессод уламжлалт хамтын зохицуулалтын үр дүн эцэстээ нээлттэй өөрчлөлтийн үр дүнгээс хамаарч байна. Чухал шийдвэрүүдийн дийлэнх нь төвлөрсөн бус эсхүл секторын түвшинд гарч байна.

4.5 Олон нийтийн таваарууд ба иргэдийн эрх

Нийтийн үйлчилгээ буюу нийтийн таваарууд нь ардчиллын улс төрийн эдийн засгийн үндсэн элемент мөн. Шударга ёс ба эв санааны нэгдлийн стандартуудыг хангахын тулд нийгмийн ардчиллын бодлогод ямар ямар нийтийн тавааруудыг заавал хангасан байх ёстой бэ? эдгээрээс хувь хүртэхийн тулд ямар гарааны нөхцөлүүдийг харилцан адилгүй нийгмийн орон зайд хангасан байх ёстой бэ? ямар нийтийн тавааруудыг бүс нутгийн, үндэсний, даяаршлын орон зайд хангасан байх ёстой бэ? гэдэг нотолгоог онол, хөтөлбөрүүд гаргаж өгөх ёстой.

Ойлголт ба үүрэг

Нийгмийн таваарууд гэдэг нь тэдгээрийн хэрэглээ ба ашиглалт нь байгалийн болон улс төрийн орон зайд орших бүх хүмүүст буюу тухайн өгөгдсөн орон зайдаа нээлттэй байх ёстой тавааруудыг хэлнэ. Хэн нэгний нийгмийн таваараас хэрэглэх эрхийг боогдуулж болохгүй. Энэ нь нийгмийн тавааруудын бодгаль шинж чанар, тэдгээрийн хууль ёсны зохицуулалт, хуульчлагдсан эрхүүдээс урган гарч байгаа юм. Жишээ нь :

Агаарын чанарын асуудал нь бодгаль чанартай тул хязгааргүй оролцооны жишээ юм. Харин нийгмийн суурь хамгаалал бол хууль ёсны эрхийнхээ дагуу хэрэглэх эрх чөлөөний болон хүний эрхийг хамгаалах жишээ юм. Эсвэл дунд сургуульд чөлөөтэй суралцах эрх олон улс оронд хууль ёсны түгээмэл үндсэн эрхүүдийнхээ хүрээнд олон нийт нийтийн тавааруудыг хэрэглэж байгаа жишээ юм. Энэ утгаар нь авч үзвэл хуулиуд, эрхүүд мөн нийтийн таваарууд мөн.

Нийгмийн ардчилалд нийтийн таваарын баталгаа нь үндсэн эрхүүдийг тэнцүү хэмжээнд эдлэхэд болон шударга хуваарилалтад нэн чухал үүрэгтэй. Тэдгээр нь бүгдэд нэг л арга замаар нээлттэй байх ёстой нийгмийн тавааруудыг илэрхийлдэг. Тэдгээрийн хэрэглээ нь хувь хүмүүсийн материаллаг нөөцөөс үл хамаарна. Нийтийн тавааруудад эрхүүд, байгууллагууд, нийгмийн болон хүмүүсийн аюулгүй байдал түүнчлэн цэвэр агаар, бохирдолгүй хүрээлэн байгаа орчин, эрүүл мэндийн үйлчилгээ, боловсрол хамаардаг. Эдгээр тавааруудын баталгааг өөрийн зохицуулалттай зах зээл болон хувь хүмүүсийн хооронд гэрээ байгуулснаар шийдэхгүй, харин улс төрийн үйл ажиллагаагаар хангана. Либертар үзэл баримтлал нь нийтийн тавааруудыг хуульчлагдсан шударга ёсны бодлогын нийгэм эдийн засгийн стратеги бус харин тэдгээр нь үйлдвэрлэл хамт олны шийдвэр гаргалтын процессыг шаарддаг тул хувь хүмүүсийн хувийн эрх чөлөө, юуны өмнө иргэдийн өмчлөх эрхийг хязгаарладаг сайнаар хэлбэл заавал байх ёстой яршигтай зүйлс гэж үздэг.

Нийгмийн ардчилалд «цэвэр нийтийн таваар» болон «хамтын эзэмшлийн таваар»ууд онцгой ач холбогдолтой. Дотоод болон гадаад аюулгүй байдал эсхүл бохирдолгүй хүрээлэн буй орчин гэх мэтийн «цэвэр нийтийн таваарууд»-д ямар ч өрсөлдөгч байхгүй. Хүссэн хүсээгүй бид бүгдээрээ хэрэглэдэг. Эдгээр нөхцөлүүд «хамтын эзэмшлийн таваар»-т нэгэн адил хамаатай.

Хамтын эзэмшлийн таваарууд нь «цэвэр нийтийн таваар»-тай харьцуулахад үйлдвэрлэгддэггүй, харин өгөгдсөн байдаг. Жишээ нь: Цэвэр агаар. Иймээс гуравдагч этгээдийн буруутай үйл ажиллагааны улмаас хамтын эзэмшлийн тавааруудын чанарыг муутгах, устгах тухай ойлголт байдаггүй. Тэдгээрийг хамгаалах, хэвийн байлгахад тусгай үйл ажиллагаа шаардагддаг.

Нийгмийн ардчиллын концепцод дараах гурван шалтгаануудын улмаас нэн ялангуяа цэвэр нийтийн болон хамтын эзэмшлийн таваарууд ач холбогдолтой юм.

Нэгдүгээрт: Эдгээр таваарууд нь бараг ямар нэг онцгой тохиолдолгүйгээр хүмүүний ёсоор амьдрах амьдралын нөхцөлүүд, тэр ч байтугай амь насны баталгаанд шийдвэрлэх ач холбогдолтой.

Хоёрдугаарт: Нийтийн тавааруудыг нийгмийн ардчиллын нийгмийн үндсэн эрхүүдийн ойлголт талаас нь авч үзвэл зах зээлийн хангамжид даатган орхиж болохгүй таваарууд юм.

Гуравдугаарт: Нийтийн тавааруудын хангамж, хэмжээ, хуваарилалт ямар түвшинд байх тухай улс төрийн шийдвэр гарна. Хамтын эрхийнхээ хэлбэр, чанарын тухай улс төрийн шийдвэрт гаргалтад оролцох нь иргэдийн улс төрийн үндсэн эрхэд нийцэж байгаа юм.

Нийгмийн ардчилалд хувь хүн бүр үндсэн эрхүүдийнхээ хүрээнд нийтийн таваараас тодорхой хэмжээгээр хувь хүртэх эрхтэй. Тэдгээр нь ямар хэлбэртэй байх, тэдгээрийн санхүүжилт, бүтээх эх үүсвэрүүд, гарааны нөхцөлүүдийг хэрхэн зохицуулах зэрэг нь эхний ээлжид нээлттэй асуудлууд юм.

Нийтийн таваарууд ба шударга ёс

Нийгмийн ардчиллын концепцод нийтийн таваарууд шударга ёсны ойлголтоос урган гардаг бөгөөд аливаа нийгэмд шударга

ёсны ойлголтын тодорхой түвшин тогтсон байдаг. Хүмүүсийг хүмүүний ёсоор амьдрах тэгш нөхцөлөөр, тэгш эрх чөлөөгөөр хангах үзэл дээр суурилсан, эрх чөлөөний ойлголтын материаллаг бүрэлдэхүүн хэсгүүдийг багтаасан улс төр, нийгмийн тэгш байдалд чиглэсэн шударга ёсны бүх онол нь эцэстээ амьдралын боломжийн наад захын тэгш хуваарилалтыг баталгаажуулсан байх ёстой. Амьдралын боломжийн наад захын боломжуудын тэгш хуваарилалтын тухай ойлголтыг төрөл бүрийн онолд өөр өөрөөр тодорхойлсон байдаг. Жон Раулсын шударга ёсны онолд иргэдийн шударга үндсэн хангамжийн концепцын дагуу иргэдийн тэгш эрх чөлөө эдлэх боломжийг хангах хэмжээний нийгмийн таваараар хангах ёстой гэж үздэг. Михаел Вальцерын хэвлэл мэдээлэлд чиглэсэн шударга ёсны онолоор амьдралын наад захын боломжуудын тэгш хуваарилалт нь нийгмийн тавааруудын хэрэглээнд чиглэгдсэн хуваарилалттай адилхан гэж үздэг. Рональд Дворкины онолдоо хувь хүмүүсийн эрх чөлөөний боломжуудын хуваарилалтад амьдралын наад захын тэгш байдлын баталгааг нэлээд өндөр түвшинд тогтоосон. Энэ нь түүний концепцын гол цөм нь бөгөөд шударга ёсны ойлголт нь насан туршид нь нөөцийг тэгш хуваарилах явдал гэж үздэг.

Материаллаг амьдралын боломжийг баталгаажуулах наад захын тэгш байдлын хэмжээ концепц тус бүрд харилцан адилгүй тогтоогдсон бөгөөд тэдгээрийн нотолгоонууд харилцан адилгүй байдаг ч эцэстээ хүн бүрд хүмүүний ёсоор амьдрах тэгш байдлыг баталгаажуулах, эерэг эрх чөлөөний зарчмуудыг хангахад чиглэгддэг. Эдгээр зарчмууд нь хувийн автономит байдал болон улс төрийн автономит байдлын тэгш байдлыг багтааж иргэн бүр хүмүүний ёсоор амьдрах, төрт улсын иргэдийн оролцооны тэгш боломжийг хангахад бодитоор шаардагдах нийгмийн тавааруудаар хангагдсан байхыг шаарддаг. Эдгээр нь цаашилбал нийгмийн болон эдийн засгийн шийдвэр гаргалт, ерөнхийдөө нийгмийн автономийн нөхцөлүүдийг багтааж байдаг.

Тэгш байдлын наад захын түвшинг хэр өндөр тогтоох бэ? гэдэг шийдвэрийг улс төрийн хүрээнийхэн гаргадаг. Улс төрийн хамтын нийгэмлэг бүр /улс орон бүр/ **нэгдүгээрт**: нийгмийн ямар тавааруудыг хэр хэмжээтэйгээр нийтийн таваарын хэлбэрээр хангасан байх ёстой бэ? гэдгийг шийдэх ёстой. Жишээ нь: Эрүүл мэндийн үйлчилгээ, суурь боловсрол эсвэл нийгмийн хамгааллын үндсэн үйлчилгээний салбаруудад. **Хоёрдугаарт**: нийгмийн таваарын хангамж бүх хүнд үнэгүй байх уу? эсвэл тодорхой хэмжээний үндсэн хураамж тогтоох уу? бүгдэд адил тэнцүү байх уу? эсвэл нийгмийн байдлын дагуу өөр өөр хураамжтай байх уу? гэдгийг улс төрийн хүрээнийхэн шийднэ. Физик шинж чанар бүхий нийтийн таваарууд, жишээ нь: Агаарын хувьд дээрх асуудлууд тавигдахгүй нь ойлгомжтой. **Гуравдугаарт**: нийтийн тавааруудын санхүүжилтийн хэлбэрийг тогтоох шаардлагатай.

Нийтийн ямар тавааруудыг хэр хэмжээтэйгээр ямар хэлбэрээр хүртээх бэ? гэдэг нь тухайн улс төрийн хамтын нийгэмлэгийн шударга ёсны ойлголтоос хамаарна. Шударга ёс улс төрийн үйл ажиллагааны дараах гурван цар хүрээн дээр суурилдаг.

1. Нийгмийн байгууламжуудын систем дээр
2. Нийтийн бүтээмж ба эрхүүд дээр
3. Нийгмийн амьдралын боломжуудын хуваарилалт дээр

Нийтийн таваарууд улс төрийн үйл ажиллагааны эхний хоёр цар хүрээний дунд оршдог. Эхний цар хүрээн дунд шийтгэх эрх хэмжээний байгууллагууд эсвэл засгийн газрын системийн байгууллагууд нь нийтийн таваарууд юм. Хоёрдох цар хүрээний хувьд нийтийн таваарын жишээ: Агаарын орон зайн хяналт, суурь боловсрол олгох улсын дунд сургуулиудын хүрэлцээ, аюулгүй байдал, хүнсний бүтээгдэхүүнүүдийн хяналт, орон нутгийн барилгын эрх болон нийгмийн хамгааллын үйлчилгээ зэрэг юм.

Нийтийн таваарууд ба нийгмийн хамгаалал

Нийтийн тавааруудын хүртээмж нь бүх иргэдийн эрх чөлөөг хангахад өөр өөр арга замаар хуваарилагддаг чухал ач холбогдолтой. Асар их нөөц баялаг эзэмшдэг тул бараг бүхий л хэрэгцээгээ өөрсдөө хангах чадвартай иргэдийн хувьд цөөхөн тооны нийтийн таваарууд болох жишээлбэл: нийтийн аюулгүй байдал ба дэд бүтцийн асуудал сонирхлыг нь татаж байдаг. Материаллаг нөөцийн ядуурлын улмаас хувийн таваарын хэрэгцээнийхээ ихэнх хэсгийг хангаж чадахгүй иргэдийн хувьд материаллаг нийтийн таваарын хангамж нь эрх чөлөөний боломжуудаа хангах нэг нөхцөл нь болж байдаг. Төр орлогын баталгааг нь хангаж өгөх тохиолдолд жишээ нь: нийгмийн халамжийн үйлчилгээ нь нийтийн таваарт хамаардаг. Нийгмийн халамж иргэн бүрд зах зээл дээрх хувийн таваарын хэрэгцээг нь хангаж ингэснээрээ амьдралын боломжийг нь хангаж өгдөг. Эмзэг бүлгийн иргэдийн худалдан авах чадвар энэ тохиолдолд улс төрийн хамтын нийгэмлэгээс нийтийн таваар хэмээн тунхаглаж, төрөөс бүрдүүлж өгөх боломжоос шууд хамаарна.

Нийтийн таваараар хангах баталгаа - зах зээл, төр ба иргэний нийгмийн үүрэг роль

Нийтийн таваарын хангамжийг төр дангаараа хариуцах ёстой юу? Эсвэл бусад актёрууд болох жишээ нь зах зээл, иргэний нийгэм тэдгээрийн үйлдвэрлэлд оролцох ёстой юу? гэдэг нь маргаантай асуудал юм. Нийтийн таваарын хангамжийг төр дангаараа хариуцах ёстой юу? гэдэг асуудал удаан хугацааны туршид мэтгэлцээний гол сэдэв байлаа. Энэ нь буруу ойлголт юм. Нийтийн таваарын хангамжид эцсийн бүлэгт тэдгээрийн бодит хүртээмж чухал. Иймээс төрд хувийн үйлдвэрлэгчид эсвэл иргэний нийгмийг нийтийн тавааруудын хангамжид оролцуулах уу? үгүй юу гэдгийг шийдэх эрх нь нээлттэй. Төр нийтийн тавааруудын бүх хариуцлагыг дангаараа хариуцдаг тул нийтийн таваарын нөхөн үйлдвэрлэлийн асуудлыг хоёр актёруудын

нэгэнтэй, эсвэл хоёулантай нь зохион байгуулж болно.

Нэлээд олон тооны чухал нийтийн таваарууд, жишээлбэл: амьдралын чанарыг сайжруулдаг (нийгмийн халамжийн өөртөө туслах ажиллагаа) нийтийн тавааруудыг иргэний нийгэм дангаараа үйлдвэрлэж болно. Иргэдийн сайн дурын үйл ажиллагаагаар олон салбарт ихээхэн хувь нэмрийг оруулж болно. Нийгмийн ардчиллын зарчмууд нь хүний болон иргэний үндсэн эрхүүдийг хангахад чухал ач холбогдол бүхий нийтийн тавааруудын хангамжийг төр хариуцахыг шаарддаг. Чухам энд түгээмэл үндсэн эрхүүдийг хэрэгжүүлэх шаардлага хурцаар тавигддаг.

Нийгмийн таваарын үйлдвэрийн хэлбэрээр өрнөж буй иргэний нийгмийн идэвх санаачилгыг олон арга хэлбэрээр дэмжиж болно. Нэг талаас төр иргэний нийгмийн идэвх санаачилгыг өрнүүлэх тухайн цаг үед нь тохирсон бүтцээр хангаж өгөх үүрэгтэй. Нөгөө талаас төрийн албаны өөрчлөлт шинэчлэлээс иргэний нийгмийн идэвх санаачилгыг өрнүүлэх нийгмийн шинэ чиг хандлага үүсэж болно. Нийгмийн үйлчилгээний салбарууд болох соёл, сургууль, ахмадын асаргааны салбарт иргэний нийгмийн идэвх санаачилгын чадамжууд нийтийн таваарын хангамжийн стратеги хэлбэрээр хэрэгжих бололцоотой. Идэвхжүүлэгч төрийн концепц нь зах зээл, төр, иргэний нийгмийн холбоон дээр суурилдаг. Энэ нь төр нийтийн таваарын хангамжийг баталгаажуулах үүргээсээ мултарна гэсэн үг биш. Бүтээмжийг бий болгох төрөл бүрийн хэлбэрүүдийг хооронд нь хослуулснаар үр өгөөж нь дээшлэх тохиолдол олонтаа байдаг. Нийгмийн ардчиллын төсөлд ямар актёрууд ямар нийтийн тавааруудын үйлдвэрлэлд оролцох бэ? гэдэг хэрэгсэл болон прагматик асуудлуудаас ямар нийтийн таваарууд байх ёстой бэ? тэдгээрээс хувь хүртэхийн тулд ямар нөхцөлүүдийг хангасан байх ёстой бэ? гэдэг зарчмын асуудал илүү чухал юм.

Даяаршлын нийтийн таваар

«Global Public Goods» буюу «Даяаршлын нийтийн таваарын» концепц нь НҮБХХ-ийн олон шинэ төслүүдийн хүрээнд боловсруулагдсан бөгөөд эхнээсээ улс төрийн үйл ажиллагаатай шууд холбоотой боловсруулагдсан. Уг концепц нь нэг талаас жишээлбэл: олон улсын аюулгүй байдал, экологийн тогтвортой байдал, санхүүгийн зах зээлийн тогтвортой байдал зэрэг шинж чанарын хувьд бүх хүмүүст хамааралтай тэр ч утгаараа бүхний анхаарлын төвд байдаг нэлээд олон үндсэн тавааруудыг тодорхойлсон. Эдгээр нь нөгөө талаас нэлээд олон тооны хамтын үндсэн таваарууд болох эрүүл мэндийн үйлчилгээ, дунд болон дээд сургуулийн сургалт, нийгмийн аюулгүй байдал, хөдөлмөр эрхлэлт зэргийг тодорхойлдог. Уг таваарууд нь норматив үндэслэлүүдийн улмаас дэлхийн өнцөг булан бүрд хүмүүний ёсоор амьдрах тодорхой нөхцөлүүдийн доод хэмжээг тогтоож өгдөг тул бүх хүнд нээлттэй байх ёстой. Эдгээрийн хангамж хөгжлийн хамтын ажиллагааны хүрээнд даяаршлын хамтын ажиллагааны төслийн хэлбэрээр хэрэгжиж эхлээд байна.

АНУ болон олон улсын хөгжлийн хамтын ажиллагаатай шууд холбоотой байдаг нь энэхүү концепцын давуу талууд юм. Нөгөө талаар хамтын нийтийн тавааруудын нэлээд хэсэг нь хуваагдашгүй тул нийтийн анхаарлын төвд байх ёстой гэдэг ойлголт түгээмэл болсон нь олон давуу талуудыг авчирдаг. Мөн уг концепцын хүчтэй тал нь түүний гуравдагч - ертөнцөд чиглэгдсэн байдагт оршдог. Энэ талаас нь авч үзвэл шууд нэг талыг баримталсан нь илэрхий харагдах зарим нэг албадмал, норматив хандлагууд нь дэлхийн хоцрогдсон хэсэгт хүмүүний ёсоор амьдрах үндсэн нөхцөлүүдийг бүрдүүлэхийн зэрэгцээ дэлхийн баян болон ядуусын хооронд хариуцлагатай холбоог тогтооход чухал ач холбогдолтой. Дараагийн нэг давуу тал бол хамтын таваарыг үйлдвэрлэх хариуцлагын чухал хэсгийг дэлхийн илүү баян чинээлэг, үйл ажиллагааны чадамжтай

хэсэгт ногдуулсанд оршино.

Энэхүү онол нь нийгмийн ардчиллын үнэт зүйлсийн тухай ойлголтыг үндэстэн дамнасан үйл ажиллагааны түвшинд, нэн ялангуяа Хойд - Өмнөдийн харилцаанд илүү тодорхой болгоход чиглэсэн нэгэн оролдлого юм.

Б. Нийгмийн баримжаат төр

4.6. Хөдөлмөр ба хүмүүний алдар хүнд

Ирээдүйн хөдөлмөрөөрөө амьдрах нийгмийн тухай ойлголтод бараг эргэлзээ төрүүлэхгүй байгаа нэгэн таамаглал бол хөдөлмөрийн зах зээл даяаршлын нөлөөнд автагдсаны улмаас тасралтгүй үргэлжлэх хөдөлмөр эрхлэлтийн намтартай хүн ховор тохиолдолд тооцогдох явдал юм. Дундаа тасалдсан, алаг цоог хөдөлмөр эрхлэлтийн намтартай, өөрийн хүссэн, үл хүссэн шалтгаануудын улмаас хагас өдрөөр ажилласан, урт богино хугацаагаар ажилгүйдэлд өртсөн байх нь хэвийн үзэгдэл болон хувирч байна.

Мэдлэгт суурилсан нийгмийн эдийн засгийн даяаршил, асар хурдацтай техникийн өөрчлөлт хувьслын улмаас бүтцийн өөрчлөлт, ажлын байрны шилжилт гарах хугацаа улам бүр богиносож дадлага туршлага, мэргэжлийн ур чадварын үнэлэгдэх хугацаа ч улам бүр богиноссоор байна. Насан туршдаа суралцах, ажил мэргэжлээ солиход байнгын бэлэн байх нь ирээдүйн хөдөлмөр эрхлэлтийн салшгүй нэгэн хэсэг болох нь. Хөрвөх чадвар өндөртэй өндөр боловсрол эзэмших нь ирээдүйдээ итгэл төгс байх, ажлын байрны баталгааг хангаж чадахаа нэгэнт больжээ. Боловсрол тэдэнд магадгүй шилжилтийн үеийг нь хөнгөвчлөхөд тус болох байх. Шилдэг мэргэжилтнүүдийг ч энэ хувь заяа тойрч өнгөрөхгүй. Мэргэжлийн мэдлэг, туршлага, ур чадвар байсхийгээд үнэ цэнээ гээж байнгын хөдөлмөр эрхлэх баталгаа болж чадахгүй. Олонх хүмүүсийн хөдөлмөр эрхлэлтийн намтарт олон төрлийн, санаанд оромгүй «Pachwork» буюу «нөхөөсний ажил» зайлшгүй бүрэлдэхүүн хэсэг болох нь. Нэлээд хугацаанд сурсан мэргэжлээрээ ажиллах, дараа нь урт богино хугацаагаар

ажилгүйдэлд өртөх, мэргэжлээ солих, хагас өдрөөр ажиллах, дахиад л ажилгүйдэлд өртөх, мэргэжил дээшлүүлэх, дараа нь шинээр эзэмшсэн мэргэжлээрээ бүтэн цагаар нэлээд хугацаагаар ажилтай байх нь ердийн хувь заяа болж.

Хэдийгээр олон хүн «мэдлэгт суурилсан эдийн засгийн» шинэ эрин үед хөдөлмөр эрхлэлтийн иймэрхүү түүхтэйгээр хөдөлмөрийн чадвартай насаа өнгөрөөж байгаа боловч хоёр төрлийн засварыг хөдөлмөрийн зах зээл дээр хийжээ.

Нэгдүгээрт: Бүх нийтээрээ хөдөлмөр эрхлэх боломжийг хэзээ ч үл няцаах.

Хоёрдугаарт: Хэвийн хөдөлмөрийн харилцаа олон хүмүүсийн хувьд ач холбогдлоо алдаж байгаа боловч зарим салбарт ач холбогдол нь буурахгүй хэвээр байх болно.

4.7 Зах зээлүүдийн нийгмийн хүрээлэл буюу зах зээлд нийгмийн хариуцлага ногдуулах нь

Бүх туршлага, судалгаанууд Арматия Сений үндэслэл дээр суурилдаг. Капитализмын улс төрийн иргэншлийн үндсэн чиглэл хөдөлмөрийн насны бүх хүнийг ажлын байраар хангахад чиглэгдэх ёстой. Орлогын эх үүсвэрийг бүрдүүлэх хөдөлмөр эрхлэлт хувь хүмүүст өөртөө итгэлтэй байх, нийгмийн зүгээс үнэлэгдэх, хүндлэгдэх нөхцөлүүдийг бүрдүүлдэг. Иймээс хэвийн байдлаар хөдөлмөр эрхлэгсдийг ажлын байрнаас нь салгаж, оронд нь өөр аргаар амьжиргааны эх үүсвэрээ бүрдүүлэх замыг санал болгож буй шинэчлэлийн бүх төслүүд ухвар мөчид шийдвэр юм. Хангалттай орлогын эх үүсвэрийг бүрдүүлэх ажлын байртай байх нь нийгмийн шударга ёсны нэг үндсэн шаардлага мөн. Энэхүү зорилтыг оновчтой бодлогоор хэрэгжүүлэх боломжтой. Гэвч ирээдүйд болох хөдөлмөрийн зах зээлийн нэгдэл тогтворгүй хөдөлмөрийн харилцаан дээр суурилах бөгөөд хэвийн хөдөлмөрийн харилцаа улам бүр уян хатан болно.

Эдгээрээс хоёр үндсэн асуудлууд урган гарна:

1. Улс орнуудын туршлагаар нэгэнт батлагдсан танил нөхцөлд бүх хүнийг ажлын байраар хэрхэн хангах бэ?
2. Хөдөлмөрлөх нөхцөлийг улам бүр уян хатан болгох зайлшгүй шаардлагыг нийгмийн аюулгүй байдал, тогтвортой байдалтай хэрхэн уялдуулах бэ?

«Зах зээлүүдийн эсрэг» бодлого явуулах нь даяаршсан эдийн засгийн нөхцөлд боломжгүй зүйл. Уг бодлогыг хэрэгжүүлэх нь нийгмийн сайн сайхны төлөө үйлст ихээхэн сөргөөр нөлөөлөх тул ард түмний зүгээс дэмжлэг хүлээхгүй, ихээхэн эсэргүүцэлтэй тулгарах болно. Тиймээс ч «зах зээлүүдтэй хамтрах» бодлогын тухай өдөр тутам яригдаж байдаг. Иймээс зах зээлийг зохион байгуулах, зах зээлд нөлөөлөх бодлого капитализмыг иргэншүүлэхэд чиглэгдэх ёстой бөгөөд зах зээлүүдийн ашиг сонирхлын төлөө бодлого явуулахаас татгалзсан хэлбэрээр байж болохгүй юм.

Зах зээлүүдэд нийгмийн хариуцлага ногдуулж буй хэмжээ нь бүх хүнд адил тэгш амьдралын боломж, хүний ёсоор амьдрах баталгааны түвшинг илэрхийлдэг. Хүн бүр өөрийгөө хүндэтгэх, нийгмийн зүгээс хүндлэл хүлээх, үнэлэгдэх нөхцөлүүд, мөн түүний материаллаг амьдралын баталгаа адил түвшинд баталгаажсан байх ёстой. Шударга ёсны дээрх хэлбэрийн стратеги л орчин үеийн нийгмийн тогтвортой байдлыг хангаж чадна.

Даяаршлын эрин үед улс үндэстний түвшинд Кенсийн онолын дагуу эрэлтэд тулгуурлан зах зээлийг удирдах бодлого, эдийн засгийн төлөвлөлт улам бүр нөлөөгөө алдаж байгаа нь зах зээлийн зохицуулалтын бодлого нь огт хэрэггүй болсон гэсэн үг биш юм. Улс үндэстний хэмжээнд явуулах «зах зээлтэй»

хамтарсан хөдөлмөр эрхлэлтийн бодлогын үйл ажиллагааны цар хүрээ өргөн хэвээр байгаа юм. Зохицуулалтын бодлогын ач холбогдлыг баталгаажуулсан 5 үнэмшилтэй шалтгаан байгаа юм. Эдгээр шалтгаанууд нь бодит, улс орнуудын туршлагаар нотлогдсон, гарцаагүй амжилтад хүрэх тодорхой стратегиудад хүргэх замыг заах болно:

Нэгдүгээрт: Бүх нийтийг ажлын байраар хангах зорилгыг даяаршлаас харьцангуй «хамгаалагдсан» секторт хэрэгжүүлэх бололцоотой. Дээрх салбаруудад хөдөлмөр эрхлэлтийн шавхагдаагүй нөөц их байдаг. Харин нөөцийг оновчтой ашиглахад татвар, нийгмийн даатгалын шимтгэл, бага орлоготой иргэдэд төрөөс хөнгөлөлт үзүүлэх тухай улс төрийн шийдвэрүүд онцгой ач холбогдолтой юм. Дээрх шийдвэрүүдийг улс орнуудын болон Европын хэмжээнд гаргах бололцоотой.

Хоёрдугаарт: Голландын «Хөдөлмөр эрхлэлтийн гайхамшиг» нь хагас өдрийн хөдөлмөр эрхлэлтийг нийгмийн - болон тэтгэврийн хангамжид бүрэн хамрагдах эрхийг хөндөхгүйгээр дэмжих нь улсын төсөв, нийгмийн даатгалд хэт ачаалал үүсгэхгүйгээр ажилгүйдлийг дорвитой бууруулах бололцоотой гэдгийг харуулсан юм.

Гуравдугаарт: Дани улсын 1990-ээд оноос явуулсан нийгмийн либерал бодлого нь эдийн засгийн уян хатан бодлого, нийгмийн баталгаат байдал хоёрыг уялдуулах боломжтой гэдгийг харууллаа. Данид нэг талаар шинээр мэргэших, мэргэжлээ дээшлүүлэх дарамт, ажил хайлт өндөр байдаг ч нөгөө талаар нийгмийн хамгааллын түвшин өндөр байдаг. Үүний зэрэгцээ түр зуурын ажлын байруудыг тодорхой эргэлтээр буюу тодорхой бодлогын дагуу эзэнтэй болгож байдаг. Ингэснээр нэг талаас бүх хүний ашиг сонирхлыг багтааж нөгөө талаас хүн бүрийн баталгаат байдлыг эдийн засгийн зүгээс мэргэжлийн ур чадвараа байнга дээшлүүлэх болон нийгмийн тогтвортой

байдлыг хангах шаардлагуудад нийцүүлэн хангаж чаддаг.

Дөрөвдүгээрт: Европын холбоо нэгдсэн зах зээл болон мөнгөн тэмдэгтэд шилжсэнээр холбооны гишүүн орнуудын өрсөлдөх чадвар, эдийн засгийн өсөлт нэмэгдэх нөхцөлүүдийг сайжруулсан. Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн ерөнхий зарчим, улс төрийн байгууллагуудын шинэчлэлийн нэгдсэн бодлого явуулснаар эерэг нэгдлийг үр дүнтэй явуулах чухал нөхцөлүүдийг бүрдүүлж чадсан. Эдгээр нь эргээд бүх нийтийг ажлын байраар хангах европын бодлогыг зөвшилцөлд хүргэхэд чухал юм.

Тавдугаарт: Хөдөлмөр эрхлэлтийн коэффициент өндөртэй, ажилгүйдэл багатай орнуудад эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийн коэффициент ч мөн өндөр байдаг. Гэр бүлд ээлтэй нийгмийн бодлоготой, олонх эмэгтэйчүүдийн мөрөөдөл болсон гэр бүл, хөдөлмөр эрхлэлтийг хослуулах бодлого биеллээ олсон байх нь бүх нийтийг ажлын байраар хангах бодлогыг хэрэгжүүлэхэд чухал хувь нэмэр оруулдаг. Эдгээр нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд чиглэсэн бодит стратегиуд бөгөөд нийгмийн баримжаат төрийн үндсэн шинэчлэлд чиглэгдсэн. Гэхдээ тэдгээрийн үйлчилгээг хүрсэн түвшингээс нь ухраах бус харин өөрчлөгдөн шинэчлэгдэж буй нөхцөл байдалд тохируулан шинэчлэх зорилготой. «Шинэ» уян хатан нийгмийн баримжаат төр хүн бүрд хөдөлмөрийн ертөнцөд нэр төртэйгөөр ажиллах ажлын байраар дахин хангагдах, мэргэжил дээшлүүлэх давтан сургалтад хамрагдах бололцоогоор хангах үүрэгтэй. «Шинэ» нийгмийн баримжаат төр хамтран ажиллах, хувийн санаачилгыг өрнүүлэх үүргийг хүлээнэ. Иймээс нийгмийн баримжаат төр нь эдийн засгийн шаардлага, хувь хүмүүсийн боломжуудын хоорондын зохицуулалтыг хийх зарим үүргийг өөртөө хүлээнэ.

4.8 Хөдөлмөрлөх эрх

Хүн бүрийг хүний ёсоор амьдрах боломжоор хангах, нийгмийн иргэдийнтэгш байдлыг хангахын тулд бүх нийтийн хөдөлмөрлөх эрхийг хангах ёстой. Орлогын эх үүсвэрээ бүрдүүлэх ажилтай байх нь хувь хүн бүрийн өөрийгөө хүндлэх болон нийгэмд үнэлэгдэхэд чухал ач холбогдолтой. Энэ нь нэн түрүүнд хувь хүн бүрд өөрийн хичээл зүтгэлээр хөдөлмөрийн зах зээлээс ажлын байр олох үүргийг ногдуулдаг. Төр хөдөлмөрийн зах зээл дээр байр сууриа олоход нь иргэдэд дэмжлэг үзүүлэх, зохион байгуулах үүргийг хүлээнэ. Төр нь хөдөлмөрийн зах зээл дээр гарах саад бэрхшээлүүдийг бууруулж иргэн бүрийн тэгш байдлыг хангах үүрэгтэй.

Хөдөлмөрлөх эрх нь зах зээлийн нөхцөлд нэгэнт эзэлсэн ажлын байраа хадгалах, хүссэн цагтаа хөдөлмөр эрхлэх баталгаа нь болохгүй. Хөдөлмөрлөх эрхийг хангахын тулд төр дараах бодлогыг явуулах үүрэг хүлээнэ:

Нэгдүгээрт: Төр нь макро эдийн засгийн бодлогоороо дамжуулан бүх нийтийг ажлын байраар хангах бодлогыг дэмжих үүрэгтэй.

Хоёрдугаарт: Төр нь бодлогын хүрээнд хувиасаа хэчнээн ч хичээл зүтгэл гаргаад ажлын байр олж чадахгүй байгаа хүмүүсийн нийгмийн баталгааг хангах, түүнтэй холбоотой зорилтот туслалцааг үзүүлэх, хөдөлмөрийн зах зээлийн хөгжлийн тухайн үеийн эрэлт хэрэгцээнд тохирсон шинэ ажил олоход нь туслалцаа үзүүлэх үүрэг хүлээнэ.

Хөдөлмөрийн нийгэм дэх өөрчлөлт хувьсал нь орлогын эх үүсвэрээ олох хөдөлмөр эрхлэлтэд хандах хандлага, үнэлэмжийг өөрчилж болно. Соёлын хувьсал, нийгмийн соёлын ялгаатай байдал нь орлогын эх үүсвэрээ олох хөдөлмөр эрхлэлтийн тухай ойлголт нийгмийн зарим бүлгүүдийн амьдралын хэв маяг,

хүсэл мөрөөдөлд ач холбогдлоо гэж ч болох юм. Нийгмийн үйл ажиллагааны бусад хэлбэрүүд илүү өндөр үнэлэмжтэй болж харин хөдөлмөр эрхлэлт хүний амьдралын тодорхой үе шатанд хувь хүмүүсийн өөрийн үнэлэмж, нийгмийн зүгээс хүлээх хүндлэлд ач холбогдолтой болж болох юм. Иймээс хөдөлмөрлөх эрхийн тухай ойлголтын цар хүрээ нь ирээдүйд нийгэмд тустай төрөл бүрийн үйл ажиллагаанд оролцох эрх хэмээн өргөжих боломжтой юм.

Гуравдугаарт: Төрийн бодлогын гуравдагч цар хүрээнд төр нь цаашдаа зөвхөн хараат хөдөлмөр эрхлэгсдийн хөдөлмөрийн харилцааг хамгаалаад зогсохгүй хөдөлмөр эрхэлдэггүй хүмүүсийг ч тэгш эрхтэйгээр хамгаалах үүргийг хүлээх болж байгаа юм.

Хөдөлмөр эрхэлж буй хүмүүсийн эрх ашгийг ажил хайгчдын эрх ашгаас давуу байдлаар хамгаалах бүтцийг бүрдүүлэх нь ажил хайгчдын хувьд шинээр ажилд орох боломжийг хаах, ажилд орсон ч маш тогтворгүй хөдөлмөрийн харилцаанд орох нөхцөлийг бүрдүүлэхэд хүргэнэ. Нэгэнт бий болсон хөдөлмөрийн харилцааг онцгойлон хамгаалах нь нийгмийн сайн сайханд хохирол учруулдаг бөгөөд нийгмийн шударга бус байдлыг үүсгэдэг. Иймээс хөдөлмөр эрхэлж байгаа болон ажил хайж байгаа хүмүүсийн эрх ашгийг ижил түвшинд хамгаалах чадвар бүхий хамгааллын хэлбэрийг сонгон авах нь зүйтэй. Энэ нь олон улс орнууд үндсэн ажиллагсдаа «онцгойлон хамгаалдаг», хагас өдрөөр хөдөлмөр эрхлэгсэд, тогтвортой бус хөдөлмөрийн харилцаанд байгаа хүмүүсээ «төдийлөн хайхардаггүй» бүтцээ бүх салбарт ижил хэмжээний хамгаалалтын түвшинг бүрдүүлэхийн тулд өөрчлөхийг шаардаж байна. Хөдөлмөрийн зах зээлийн ялгавартай хамгааллыг арилгах стратегийн жишээнүүдийг Дани болон Голланд орнуудаас харж болно. Эдгээр орнуудад үндсэн ажиллагсдыг ажлаас халагдахаас хамгаалах хуулийн заалтуудын

зарим заалтуудыг илүү уян хатан болгож нөгөө талаар хагас өдрөөр хөдөлмөр эрхлэгсдийн эрхүүдийг өргөжүүлсэн байна. Мөн шинээр ажилд орогсдод тавигдах шалгууруудыг нэмэгдүүлэхгүй байх зохицуулалтуудыг хийсэн байна.

4.9 Үндсэн эрхүүд ба нийгмийн баримжаат төр

Нийгмийн ардчилал нь үндсэн эрхүүдэд тулгуурласан нийгмийн баримжаат төрт ёсны олон шинжээр ялгагддаг. Нийгмийн баримжаат төр нь дараах нийгмийн үүргүүдийг биелүүлэх ёстой:

Нэгдүгээрт: Нийгмийн баримжаат төр нь үндсэн эрхүүд болон амьдралын боломжуудын шударга хуваарилалтыг хангахын тулд нийгмийн шударга ёсыг хангах үүрэг хүлээнэ. Энэ утгаараа нийгмийн баримжаат төр нь иргэдийн эрхэд учирч болох нийгмийн эрсдэлүүдэд нийгмийн ардчиллын зүгээс өгөх үндсэн хариулт юм.

Хоёрдугаарт: Нийгмийн баримжаат төр нь иргэдийн нийгэм, эдийн засгийн хувьсалт өөрчлөлтөд идэвхтэй оролцох идэвхийг сэргээж байдаг тул эдийн засгийн үр ашиг, эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэхэд хувь нэмрээ оруулдаг. Түүнээс гадна нийгмийн баримжаат төр орлогын доод хэмжээг баталгаажуулах замаар эрэлтийг нэмэгдүүлдэг учраас эдийн засгийн өсөлтөд түлхэц болдог.

Гуравдугаарт: Нийгмийн баримжаат төр нь иргэдэд олон төрлийн нийтийн таваарыг нийлүүлж байдаг учраас нийгэм, улс төрийн тогтвортой байдалд чухал хувь нэмэр оруулдаг.

Аса Бригс нийгмийн баримжаат төрийг сонгодог утгаар нь дараах байдлаар тодорхойлсон байна:

«Иргэдийнхээ аюулгүй байдал, сайн сайхныг хуульчлан

дээдэлдэг төр зах зээлийн механизмыг дараах үндсэн гурван чиглэлээр зорилттойгоор өөрчлөх зорилгыг агуулж байдаг.

Үүнд:

Нэгдүгээрт: тэдний эрхэлж буй хөдөлмөрийн зах зээлийн үнэлэмж, эзэмшлээс үл хамааран хувь хүмүүс, гэр бүлийн орлогын доод түвшинг баталгаажуулах, **хоёрдугаарт:** хувь хүмүүс, гэр бүлүүдийг чадавхижуулах замаар баталгаагүй байдлыг хязгаарлах /өвчлөх, насан өндөр болох, ажилгүйдэлд өртөх зэрэг эрсдэлийг даван туулах, хямралаас гарах/, **гуравдугаарт:** бүх иргэддээ тэдний статус, ангийн байдлаас үл хамааран нийгмийн үйлчилгээний хамгийн дээд стандартыг хангаж өгөх»

Нийгмийн баримжаат төр нь зах зээлийн капитализмаас үүссэн тогтворгүй байдлыг зах зээлээс үл хамаарах төрийн аюулгүй байдлын баталгаагаар намжааж байдаг. Тогтвортой байдлыг хангахад чиглэгдсэн үйлчилгээний хэлбэр, хэмжээ, үйл ажиллагааны салбарууд үндсэн эрхүүдийг хангахад чиглэгдэх ёстой. НҮБ-ын хүний заяагдмал эрхүүдийн тунхаглалд үндсэн эрхүүдийн нийгмийн болон эдийн засгийн үндсэн эрхүүдийг хангахыг «зөвхөн» засгийн газруудын үүрэг хэмээн заасан нь иргэдийн болон улс төрийн эрхүүдийн хэрэгжилтийн үр дүнгийн үүргээс ялгаатай юм. Аливаа төрд түүний боломж бололцооноос хэтэрсэн нийгмийн болон эдийн засгийн эрхүүдийг хангах үүргийг ногдуулж болохгүй. Харин эдгээр эрхүүд нь заавал хангагдах ёстой үндсэн эрхүүд учраас тэдгээрийн хэрэгжилтэд тэгш байдлыг хангах зарчим заавал хэрэгжих ёстой тул тухайн улсын төр нь өөрийн эдийн засгийн боломж бололцооны хэмжээнд ямар ч тохиолдолд заавал хангах үүргийг хүлээдэг. Энэ утгаар нь авч үзвэл нийгмийн баримжаат төрөөс иргэдийн үндсэн эрхүүдийг хангах үүрэг нь түгээмэл шинж чанартай юм.

Харин нийгмийн хамгааллын зохион байгуулалтын хэлбэр, нийгмийн хамгааллын үйлчилгээний хэмжээг улс төрийн шийдвэрээр тогтоодог бөгөөд эдгээр хүчин зүйлүүд тухайн улс орны дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ, хөдөлмөрийн бүтээмж, улс төрийн систем, улс төрийн соёлоос хамаардаг. Нийгмийн ардчилалд зохиогч, илгээгч хоёрын нэгдмэл байдлыг хангах зарчим, түүнтэй холбогдсон бүхий л журмууд мөрдөгдөж байх учиртай. Нийгмийн баримжаат төрийн шийдвэр гаргалтад иргэдийн оролцоо хангагдсан байх ёстой.

Нийгмийн баримжаат төрийн үүрэг нь нэн түрүүнд үйл ажиллагааны таван үндсэн салбарын хүрээнд тавигддаг: Эрүүл мэнд, Хүмүүжил - Боловсрол, Орон сууцны хангамж, Нийгмийн аюулгүй байдал, Хувь хүмүүст хандсан үйлчилгээ. Нийгмийн ардчилалд дээр дурдсан хамгааллын салбаруудын доод хязгааруудыг хэрхэн тогтоох нь нээлттэй асуудал юм. Хамгийн гол нь нийгмийн үндсэн эрхүүд хангагдаж байх ёстой. Хэзээ, ямар нөхцөлд төрийн байгууллыг нийгмийн баримжаат төрийн шаардлагыг хангасан гэж үзэх бэ? Харин улс орнуудад нийгмийн баримжаат төрийн олон хэлбэр оршин байгаа нь судалгаагаар нотлогдсон. Түүний бүтэц тухайн улс төрийн систем, нийгэм, эдийн засгийн хөгжлийн түвшин, улс төрийн эрх мэдлийн харьцаа, улс төр-үзэл санааны тогтолцоо зэргээс хамаардаг.

Эдийн засгийн өндөр хөгжилтэй ардчилсан орнуудад оршин байгаа нийгмийн баримжаат төрийн хэлбэрүүд

Гоеста Эспринг - Андерсон 20-р зууны сүүлийн дөрөвдүгээр хагаст байгуулагдсан нийгмийн баримжаат төрүүдийн системчилсэн харьцуулалтыг хийсэн байна. Тэр «иргэдийнхээ аюулгүй байдал, сайн сайхныг дээдлэгч төрүүдийг» либерал, консерватив, социал демократ гэж ангилсан байна. Эспринг - Андерсоны харьцуулсан судалгаагаар хойд зүгийн орнууд нэн

ялангуяа Швед социал демократ, ХБНГУ консерватив, харин АНУ либерал төрийн хэв шинжүүдийн сонгодог жишээнүүд юм.

Скандинав хэлбэрийн түгээмэл нийгмийн баримжаат улсууд дараах түгээмэл онцлогтой байдаг.

- Нийгмийн даатгал, халамжийн бүх төрлийн үйлчилгээнээс хувь хүртэх эрх, нийгмийн эрхүүдээр тодорхойлогдох нийгмийн иргэний төр дээр суурилдаг.
- Ажлаас халагдах, өвчлөх зэрэг шилжилтийн бараг бүх хөтөлбөрүүдэд цалинг орлох мөнгөн олговрууд нь маш өндөр, өмнөх авч байсан цалин, орлоготой нь бараг ижил хэмжээнд байдаг.
- Нийгмийн баримжаат төр нь татварын орлогоос зонхилон санхүүждэг.
- Уг системд эрүүл мэнд, хүмүүжлийн салбараас гадна нийгмийн үйлчилгээний олон алба жишээ нь: өдөр өнжүүлэхтэй сургуулиуд, өндөр настуудын асрамж зэрэг үйлчилгээнүүдийг үзүүлдэг.
Нийгмийн баримжаат төрөөс өдөр өнжүүлэхтэй сургуулиуд ажиллуулах зэрэг гэр бүлийг идэвхтэй дэмжих бодлогыг явуулсны үр дүнд эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийн коэффициент өндөр байдаг.
- Судалгаанд хамрагдсан орнуудад хөдөлмөр хамгааллын бодлогын стандарт доогуураас /Дани/ өндөр хүртэл /Швед/ янз бүр байдаг. Гэхдээ уг стандартуудыг ямар ч тохиолдолд хөдөлмөрийн зах зээлийн идэвхтэй бодлого, мэргэжил дээшлүүлэх сургалтуудаар дэмжиж байдаг.
- Аж үйлдвэрийн харилцааны хамгийн чухал шийдвэрүүд нийгмийн түншүүдийн хамтын ажиллагааны хүрээнд үндэсний түвшинд гардаг. Эдгээр хэлэлцээрүүдийн үр дүн хөдөлмөр эрхлэгсдийн дийлэнх хэсгийн эрх ашгийг хамгаалдаг.
- Төр нь бүх нийтийг ажлын байраар хангах макро-эдийн

засгийн бодлогыг дэмжих үүрэгтэй.

- Хөдөлмөрийн зах зээл дээр амжилт олоогүй тохиолдолд нийгмийн үйлчилгээнээс мөнгөн олговор авах нийгмийн сүлжээнд шилжих шилжилт харьцангуй хялбар.
Европ тивд хамгийн түгээмэл тархсан консерватив нийгмийн баримжаат төрийн дэглэм дараах онцлогтой байдаг:
- Нийт системийн үндсэн бүтэц нь хөдөлмөр эрхлэлтэд суурилсан, мэргэжлийн болон статусын бүлгийнх нь дагуу ангилсан нийгмийн хамгааллын систем байдаг.
Төрөл бүрийн хөтөлбөрүүдийн шилжилтийн түвшнүүд хоорондоо маш их ялгаатай байдаг. Жишээ нь: Тэтгэврийн системийн цалинг орлох орлогын хувь маш өндөр байдаг мөртлөө ажилгүйдлийн даатгалын цалинг орлох орлогын хувь маш бага байдаг. (Италид)
- Нийгмийн баримжаат төрийн санхүүжилт цалингийн хэмжээнээс хамааруулан тогтоох нийгмийн даатгалын шимтгэлүүдээс зонхилон бүрдэнэ.
- Эрүүл мэндийн үйлчилгээнээс гадна зөвхөн цөөн төрлийн нийгмийн үйлчилгээ доод түвшинд байдаг. Энэ салбарт гуравдагч сектор ба хувийн хэвшлийнхэн чухал үүрэгтэй байдаг.
- Эрчүүд гэр бүлээ тэжээгчийн үүргийг гүйцэтгэдэг идэвхгүй гэр бүлийн бодлого явуулдаг. Энэ нь эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийн коэффициент доогуур байх үндэслэл болдог.
- Хөдөлмөр эрхлэгсдийг хамгаалах баталгаа өндөр байдаг нь хөдөлмөрийн зах зээлийн идэвхгүй бодлого явуулдагтай холбоотой.
- Өргөн хүрээтэй мэргэжлийн сургалтын хөтөлбөрүүд хэрэгждэг. Эдгээр сургалтууд хэд хэдэн салбарт хөрвөх чадвартайгаар зохион байгуулагддаг.
- Тарифын гэрээнд оролцогч талуудын харилцааг зохицуулах систем нь хатуу зохион байгуулалттай. (Зохицуулалттай

аж үйлдвэрийн харилцаа, секторуудын хүрээнд явагддаг тарифын хэлэлцээрүүд тэргүүлэх үүрэгтэй. Хэрэгжилтийн процент нь өндөр, хуулийн нэгэн адил хэрэгждэг.)

Англи- Саксони улсуудад зах зээлийн зарчмууд нь тэргүүлэх үүрэгтэй байдаг либерал зах зээлийн загварууд өргөн тархсан байдаг бөгөөд тэдгээр нь дараах үндэслэлүүд дээр суурилдаг:

- Чухал хөтөлбөрүүдийг тодорхой зорилтот бүлгүүдэд зориулан хэрэгжүүлдэг ба тэдний хэрэгцээг хангахад чиглэгдсэн, нийгмийн эмзэг давхаргад багтдаг гэдэг нь нотлогдсон хүмүүст зориулагддаг.
- Төрөл бүрийн хөтөлбөрүүд дэх цалинг орлох мөнгөн олговрын хэмжээ маш бага байдаг. Хөтөлбөрүүдийг зонхилон ердийн татваруудаас санхүүжүүлдэг.
- Эрүүл мэнд, боловсролын салбаруудыг эс тооцвол системчлэгдсэн нийгмийн үйлчилгээ бараг байдаггүй.
- Гэр бүлийн бодлогын түвшин доогуур.
- Хөдөлмөр эрхлэгсдийг хамгаалах хамгаалалт сул. Хөдөлмөрийн зах зээлийн бодлого нь идэвхгүй, мэргэжлийн боловсролын сургалтын системийн хөгжил сул.
- Аж үйлдвэрийн харилцааны зохицуулалт байхгүй. Зах зээл ихэвчлэн зуучлагчийн үүргийг гүйцэтгэдэг. Үйлдвэрчний эвлэлийнхэн төдийлөн хүчирхэг бус, тарифын хэлэлцээр төвлөрсөн бус хэлбэрээр явагддаг тул хөдөлмөр эрхлэгсдийн зөвхөн тодорхой хэсгийг хамардаг.

6-р хүснэгт: Эспринг-Андерсены дэглэмүүдийн онцлогийг нэгтгэн харуулсан хүснэгт

Хэв шинжүүд	Онцлог шинжүүд	Төр, зах зээл, гэр бүлүүдийн байр суурь	Орнуудын ЖИШЭЭ
Либерал хэв шинжит төр	• Хэрэгцээг тодорхойлсны үндсэн дээр нийгмийн халамжийн хэмжээг тогтоодог. • Хэмжээний хувьд бага, түгээмэл хэлбэрийн шилжилтийн мөнгөн олговруудыг олгодог. • Нийгмийн хамгааллын хөтөлбөрүүдийн санхүүжилтийн хэмжээ харьцангуй бага байдаг. • Нийгмийн эрхүүд нь хязгаарлагдмал. • Нийтийн туслалцааг хүртэгсэд харьцангуй бүгдээрээ ядуурлын ижил түвшинд амьдардаг. • Ядуучуудад зориулсан нийгмийн халамжийн хэмжээ өндөр. • Нийгмийн халамжийн сангаас хувь хүртэх босго өндөр, мөнгөн олговрын хэмжээ бага байх нь хэвийн үзэгдэл.	Чөлөөт зах зээл ба гэр бүлийн үүрэг ролийг чухалчилж үздэг.	АНУ Канад Австрали Их Британи

Консерватив хэв шинжит төр	• Статуст суурилсан даатгалын байгууллагуудтай. • Төрийн албан хаагчдад нийгмийн даатгалаас мөнгөн олговор олгоход өгөөмөр ханддаг. • Статусын ялгааг хэвээр хадгалахыг чухалчлан үздэг. • Гэр бүлийн уламжлалт хэлбэрийг хадгалахыг чухалчилж үздэг. • Хөдөлмөр эрхэлдэггүй эмэгтэйчүүдийн хувьд нийгмийн даатгалаас хувь хүртэх эрх нь хаалттай. • Гэр бүлд үйлчилгээ үзүүлэх албадын хөгжил сул. • Нийгмийн нэгжүүдийн өөртөө туслах чадвар шавхагдсан үед тэдгээрийн дээр орших нийгмийн нэгжүүд тусламжийн гараа сунгах зарчим үйлчилдэг: Гэр бүлүүдийн өөртөө туслах чадвар шавхагдаж хүчин мөхөстсөн үед л төр тусламжийн гараа сунгана.	Нийгмийн сайн сайхныг үйлдвэрлэгч -ийн хувьд зах зээл нь шахагдаж байх ёстой.	Франц Герман Итали
Түгээмэл хэв шинжит төр	• Нийтийн ашиг сонирхлыг чухалчлах, статусын тэгш байдал • Төр нийтийн тэгш байдлыг өндөр түвшинд хангах үүрэгтэй. • Аж үйлдвэрийн ажилчид ажилтан, албан хаагчидтай ижил эрхийг эдэлдэг. • Нийгмийн бүх ангиуд түгээмэл даатгалын системд хамрагддаг. • Зах зээлийн ашиг сонирхлыг хязгаарладаг. • Төр нийгмийн үйлчилгээнд өндөр хариуцлага хүлээдэг. • Эмэгтэйчүүдэд гэр бүл, хөдөлмөр эрхлэлтийг хослуулах боломжийг бүрдүүлж өгдөг.	Төр нийгмийн сайн сайхны төлөө гол хариуцлагыг хүлээдэг.	Норвеги Швед Дани Финлянд

Эдгээр нь нийтийн сайн сайхны төлөө капиталист төрийн гурван ертөнц буюу идеал хэв шинжүүд юм. Улс орон бүр дээрх хэв шинжүүдээс гажсан эсвэл олон хэв шинжийн элементүүдийг нэгэн зэрэг агуулсан байж болно.

Нийгмийн ардчилалд нийгмийн баримжаат төрийн ямар загвар илүү тохирох бэ?

Нийгмийн баримжаат төрийн хэв шинжүүд нь хоорондоо нийгмийн иргэдийн эрхүүдийг хангах ямар бүтцийг бүрдүүлсэн бэ? гэдгээрээ ялгагддаг. Либерал хэв шинжит нийгмийн баримжаат төрүүдэд иргэдийн нийгмийн эрхийг хангах бүтцийн байгууллагууд байгуулдаггүй. Ямар нэгэн эрх зүйн шаардлагуудыг тавилгүйгээр олон хэлбэрээр ядууст тусалдаг. Консерватив болон түгээмэл хэв шинжит нийгмийн баримжаат төрүүд нь иргэдийн нийгмийн эрхүүдийг хангах төрөл бүрийн бүтцүүдийг бий болгосон байдаг. Үүнээс үүдэн либерал хэв шинжит нийгмийн баримжаат төрүүд нийгмийн болон эдийн засгийн үндсэн эрхүүдийг хангах үүргээ биелүүлдэггүй гэсэн дүгнэлт гарч байгаа юм. Нийгмийн ардчиллын хувьд: **Үндсэн эрхүүдийг консерватив хэв шинжит төр, социал демократ хэв шинжит төр хоёрын аль нь илүү сайн хангаж чадах бэ?** гэдэг асуулт нээлттэй үлдэж байгаа юм. Энэ асуултын хариулт тухайн улс орнуудын онцлог нөхцөл байдлуудаас хамаардаг. Хэрэгжүүлэх арга зам нь өөр байлаа ч дээрх хоёр загвар хоёулаа нийгмийн болон эдийн засгийн үндсэн эрхүүдээс урган гарах зарчмын шаардлагуудыг хангах чадвартай. Харин нийгмийн болон эдийн засгийн тэгш байдлыг хангах түвшин харилцан адилгүй байж болно.

Нийгмийн ардчиллын онолд дээр үндэслэн нийгмийн баримжаат төрийн тодорхой загварыг тодорхойлох боломж үгүй ч дээрх загваруудыг үнэлэх шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулан гаргах бололцоотой. Хамгийн чухал хоёр шалгуур үзүүлэлтүүд бол:

- Нийгмийн баримжаат төр нийгмийн болон эдийн засгийн үндсэн эрхүүдийг хангаж байна уу?
- Нийгмийн тусламжийг хүртэгсэд дээрх эрхүүдийг хангах шийдвэр гаргалтын бүтцэд оролцох хангалттай оролцооны эрх эдэлж байна уу? гэдэг асуудал юм.

Уг хоёр шалгуур үзүүлэлтүүд консерватив болон социал демократ нийгмийн баримжаат төрийн загваруудад хоёуланд нь биелэгдсэн байж болно. Герман болон Шведэд нийгмийн даатгалын системүүдэд өөрийн удирдлагын загварууд буюу аж ахуйн бие даасан тооцоон дээр суурилсан загварууд голлох үүрэгтэй байдаг. Мөн дээрх хоёр улсад нийгмийн даатгалын сангаас хувь хүртэгсэд эрх зүйн үндэслэл бүхий шаардлага тавих эрхтэй. Нийгмийн үндсэн эрхүүд эрх зүйн хувьд баталгаажсан байдаг.

Нийгмийн баримжаат төрийн төрөл бүрийн загваруудыг тодорхойлох дараагийн нэг шалгуур үзүүлэлт бол иргэдийн нийгмийн даатгалын сангаас хувь хүртэх эрхийг хууль эрх зүйн хүрээнд баталгаажуулсан эсэх тухай асуудал юм. Нийгмийн даатгалын сангаас хувь хүртэх эрхийг хуулиар баталгаажуулсан байдал нь иргэдийн эрх, аргагүй байдал эсвэл даатгалын шимтгэл дээр суурилсан байж болно. Аргагүй байдлыг шалгуур болгон авсан тохиолдолд нийгмийн даатгалын сангаас хувь хүртэх эрх зүйн шаардлага бүхий эрх үүсэхгүй. Харин нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хэмжээнээс хамаарах тохиолдолд шимтгэл төлөгч бүр хувь хүртэх эрх зүйн үндэслэл бүхий эрх нь нээгдэнэ. Харин нийгмийн даатгалын сангаас хувь хүртэх эрх нь иргэний эрхүүд дээр суурилсан тохиолдолд уг эрхийг нь үндсэн хуулиар баталгаажуулдаг.

Нийгмийн ардчилалд нийгмийн тусламжийн сангаас хувь хүртэх иргэний эрх үндсэн хуулиар баталгаажсан байхаас гадна мөнгөн тэтгэлгийн хэмжээ нь тухайн хүний нийгмийн

амьдралд оролцох тэгш эрхийг хангах хэмжээнд хүрэлцэхүйц байх нь чухал. Иймээс нийгмийн тусламжийн хэмжээг тогтоох нь нийгмийн тодорхой нөхцөл байдлуудаас хамаарна. Ямар ч тохиолдолд хамгааллын тусламжийн төрөл, хэмжээ нь ардчилсан хяналтын процессын үр дүнд тогтоогдож байх ёстой. Түүнээс гадна нийгмийн даатгалын сангаас тэтгэлэг олгох баталгааны хэлбэр нь нэгдүгээрт хувь хүртэгсдийн хүмүүний ёсоор амьдрах нөхцөлийг хангаж хоёрдугаарт тухайн иргэний хувьд иргэний статусыг нь зөрчихгүй байх ёстой бөгөөд харин тэднийг идэвхтэй дэмжих ёстой.

Ардчилсан нийгэмд нийгмийн эрхүүдийн өргөн хүрээтэй системийг бүрэлдүүлэхийн тулд дараах нөхцөлүүд хангагдсан байх шаардлагатай:

- Нийгмийн баримжаат төрийн загвар нь зах зээлийг дэмжиж зохицуулагчийн үүргийг гүйцэтгэх чадамжтай байх ёстой.
- Нийгмийн эрхүүдийг хангахад улс төрийн дэмжлэг үзүүлэх ёстой.
- Нийгмийн эрхүүдийн хангалт олон нийтийн мэтгэлцээнээр шүүгдэж байх ёстой.

Нийгмийн баримжаат төрийн байгууллагуудын болон санхүүгийн онцлогууд

Эспринг - Андерсен улс орнуудын туршлага дээр суурилсан харьцуулсан судалгаагаараа нийгмийн баримжаат төрүүд нийгмийн сайн сайхны төлөөх үйлсэд зарцуулах зардлын хэмжээгээрээ төдийгүй байгууллагуудын хэлбэрээрээ ялгаатай байдаг гэдгийг харуулсан.

Консерватив хэв шинжит болон социал демократ хэв шинжит нийгмийн баримжаат төрийн загварууд дундаж давхаргынханд харьцангуй өндөр нийгмийн хамгааллын түвшинг баталгаажуулж өгдөг. Ингэснээрээ тэдний улс төрийн тогтвортой байдлыг хангаж байдаг. Хэдийгээр татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн

ачаалал өндөр байдаг боловч тухайн нийгмийн системүүд нь дундаж давхаргынхны идэвхтэй дэмжлэгийг хүлээж байдаг. Энэ утгаараа дээрх хэлбэрийн системүүд тогтвортой ардчилсан бааз суурьтай байдаг. Нөгөө талаар нийгмийн баримжаат төрийн байгууллагуудын хэлбэр нь өөрөө ардчилсан хууль ёсны байх баталгаагаа хангаж байдаг. Нийгмийн дийлэнх олонхыг бүрдүүлэгч дундаж давхаргын ашиг сонирхлыг хамгаалагч, нийгмийн сайн сайхны төлөөх төрийн байгууллагууд тэдний дэмжлэгийг хүлээж, түүн дээр суурилж байдаг. Скандинавын түгээмэл хэв шинжийн нийгмийн сайн сайхны төлөөх төрүүд нь ашиг сонирхол ба байгууллагуудын тэнцвэр дээр суурилсан улс төрийн байгууллагуудын удаан хугацааны тогтвортой хэлбэрийн бүтээгдэхүүн мөн.

Нийгмийн сайн сайхны төлөөх либерал хэв шинжтэй төртэй улсуудад нийгмийн үйлчилгээг дундаж давхаргынханд зонхилон хандуулсан холбоо байдаггүй. Нийгмийн хамгааллын асуудлыг бараг бүхэлд нь зах зээлд даатган орхидог. Зарим тохиолдлуудад зах зээлд түшиглэн байгуулсан даатгалуудад нийгмийн тодорхой эрсдэлүүдийн үед төрийн зүгээс хөнгөлөлт үзүүлдэг боловч түүний зах зээлээс шууд хамаарах хамаарлыг арилгаж чаддаггүй. Либерал хэв шинжит нийгмийн баримжаат улсуудад дундаж давхаргын өөрсдөө санхүүжүүлж буй даатгалын систем дээр нэмэлт эх үүсвэр болгон хууль ёсны даатгалын системийг бүрдүүлж болох боловч иргэд нь өндөр хэмжээний татвар төлөхөд бэлэн бус байдаг. Дундаж давхаргынхны зүгээс нийгмийн баримжаат төрийн санхүүжилтэд нийгэм-эдийн засгийн сонирхолгүй байдаг. Дээрх улсуудад маш хатуу хяналттай, маш доогуур тогтоосон хэрэглээний стандартад тохируулсан нийгмийн үйлчилгээг урьдчилан боловсруулсан хөтөлбөрийн дагуу тогтмол бууруулж байдаг. Гэхдээ либерал ардчилсан улсуудад ч нийгмийн хамгааллын найдвартай системтэй байх нийгэм - ёс зүйн болон нийгмийн нэгдэлд хүрэх сонирхол байхыг үгүйсгэхгүй. Улс төрийн үйл ажиллагааны чиг хандлагад дээрх идэвх санаачилгыг орхигдуулж болохгүй.

Нийгмийн баримжаат төрт улсуудын судалгаанд хангамж, даатгалын гурван өөр төрлийн зарчмуудыг онцгойлон судалсан:

1. Харьяат иргэдийн хангамж: Энэ зарчмын дагуу иргэдийн ажил мэргэжлийн байдал, хөдөлмөр эрхэлж байна уу? ажилгүй юу гэдэг статусаас үл хамааран хамгийн өргөн хүрээтэй нийгмийн хамгааллын систем үйлчилдэг. Бүх харьяат иргэдэд нээлттэй. Түүний зохион байгуулалтын үндсэн хэлбэр нь нэгдсэн даатгал. Нийгмийн тэгш бус байдлыг тэгшитгэхэд үлэмж хувь нэмрийг оруулдаг.

2. Нийгмийн халамжийн зарчмаар хэрэгжих нийгмийн хамгаалал: Энэ нь хэсэгчилсэн буюу түвшин доогуур нийгмийн халамжийн систем юм. Зөвхөн зах зээл болон гэр бүлийн байдал хүндэрсэн нөхцөлд л төр нийгмийн бодлогоороо дамжуулан тусламж үзүүлнэ. Зөвхөн тун аргагүй байдалд орсон үед л туслалцаа үзүүлнэ гэдэг үндсэн зарчимтай. Уг хэв шинжит нийгмийн баримжаат төрт улсуудад эмзэг давхаргад багтана гэдэг нь бүрэн батлагдсан, эсвэл бусдын тус дэм зайлшгүй шаардагдах тодорхой эмзэг бүлгийн хүмүүс (өрх толгойлсон ганц бие эцэг, эх, олон хүүхэдтэй гэх мэт) нийгмийн халамжид хамаарагдана.

3. Нийгмийн даатгал: Уг зарчмын дагуудаатгуулагч амьжиргааны эх үүсвэр хомстож бэрхшээл тохиолдсон нөхцөлд хуулиар заавал төлөх үүргийнхээ дагуу шимтгэл төлдөг нийгмийн даатгалаас тэтгэмж авдаг. Нийгмийн даатгалын шимтгэл төлсөн учраас даатгалын сангаас мөнгөн тэтгэмж авах хууль ёсны эрх бүхий эв санааны нэгдэлтэй хамтын нийгэмлэгийг нийгмийн даатгал гэнэ. Нийгмийн даатгал нь бусдаас хамааралтай хөдөлмөр эрхлэгсдийг ихэвчлэн гэр бүлийн гишүүдийнх нь хамт даатгалд хамруулдаг онцлогтой.

Нийгмийн даатгалын сангаас олгох мөнгөн тусламжийг гишүүдийнхээ баталгаат байдал буюу статусыг хөдөлмөрөөрөө

олсон орлогынх нь пирамидын дагуу (их шимтгэл төлсөн нь их хэмжээний мөнгөн тусламж) олгох зорилготой. Нийгмийн даатгалын шимтгэл, нийгмийн даатгалаас олгох мөнгөн тусламж нь тодорхой шатлалтай.

Дээрх гурван загварын санхүүжилтийн эх үүсвэр нь хоорондоо эрс ялгаатай: Харьат иргэдийн хангамж ба халамжийн зарчмаар хэрэгжих нийгмийн хамгаалал нь татвараас санхүүждэг. Харин нийгмийн даатгал нь даатгуулагчдын хөдөлмөрөөрөө олох орлогынхоо хэмжээнээс хамааран төлөх шимтгэлээс зонхилон санхүүждэг. Нийгмийн баримжаат төрийн санхүүжилтийн арга хэлбэр нь тухайн улс орны дэлхийн зах зээл дээр өрсөлдөх чадвар, цаашилбал бүх нийтийг ажлаар хангах зорилтын хэрэгжилтэд нөлөөлдөг. Мөн төрийн санхүүжилтийн арга хэлбэрээс тухайн оронд дахин хуваарилалт ямар нөлөөтэй байх бэ? гэдэг хамаарна. Тухайн улс орны сонгон авсан даатгалын хэлбэр (даатгал, харьяат иргэдийн хангамж, халамжийн зарчмаар хэрэгжих нийгмийн хамгаалал) нь нийгмийн баримжаат төрийн улс төрийн хууль ёсны чадамжид нөлөөлж байдаг.

АНУ-ын нийгмийн сайн сайхны төлөөх нийгэм нь либертар ардчиллын нэгэн загвар мөн.

АНУ-д нийгмийн халамжийн зарчим дээр суурилсан нийгмийн даатгалын загвар хэрэгждэг. АНУ-ын иргэд нийгмийн хамгааллаас хувь хүртэх хууль ёсны эрхгүй. Тэнд зах зээлийн зарчим ноёрхдог. Иргэд эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд бүгд өөрийн хөдөлмөрөөр амьжиргааны эх үүсвэрээ бүрдүүлэх үүрэгтэй. Нийгмийн сайн сайхны төлөөх бүтээгдэхүүний үйлдвэрлэлд гэр бүл, тэдгээрийн хоорондын эв санааны нэгдэл хоёрдогч чухал байр суурийг эзэлдэг. Эмзэг бүлгийн хүмүүст зориулсан нийгмийн сайн сайхны төлөөх бүтээгдэхүүн үйлдвэрлэлд сүмүүдийн холбоо, хөршүүдийн туслалцаа болон нийгмийн сайн сайхны төлөө үйл ажиллагаа явуулдаг бусад байгууллагууд

чухал үүрэгтэй байдаг. Энэ утгаараа нийгмийн эрхүүдийн хэрэгжилт ганцаарчилсан хэлбэртэй, бүрэн бус байдаг.

Энэ загварын сул талуудыг туслалцаа авагсдыг бусдын хамаарлаас ангид байлгадаг, хүмүүсийн үйл ажиллагааны эрх чөлөөг илүү сайн хангаж өгдөг хэмээн зөвтгөдөг. Уг загвар нь либерал улс төрийн бодлого хэрэгжих урьдчилсан нөхцөлүүдийг хамгийн сайн бүрдүүлж өгдөг нийгмийн бодлого гэж тайлбарладаг. Гэхдээ энэ байр суурийг няцаах нэлээд бодитой нотолгоонууд олон байдаг.

- АНУ-ын иргэд нийгмийн зүгээс «цалинг орлох» тусламж авах эрх зүйн үндэслэл бүхий үндсэн эрхгүй тул «нийгмийн эрсдэлүүдээс» хамгаалах найдвартай хамгаалалтгүй байдаг. Төрийн зүгээс авах туслалцааны хэлбэр хэмжээ тодорхой бус. Иймээс иргэдийн нийгмийн болон улс төрийн үйл ажиллагааны чадамжид сөргөөр нөлөөлөхүйц, хүний ёсоор амьдрах эрх нь зөрчигдөж болзошгүй, нийгмийн амьжиргааны эх үүсвэр нь баталгаатай бус байдалд сэтгэл зовнин амьдардаг.
- Иргэдийн өөртөө итгэх итгэл, нийгмийн зүгээс тэднийг хүндэтгэх хүндэтгэл баталгаатай бус. Учир нь бусдын туслалцаанаас хамааралтай эмзэг бүлгийнхэн хувь хүмүүс болон нийтийн тусын төлөө үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудын туслах хүслээс шууд хамааралтай амьдардаг.
- АНУ-ын систем нийгмийн байдлын хувьд хоорондоо асар зөрүүтэй тэгш бус байдалд хүргэдэг. Дахин хуваарилалтын процесс хүртээмжгүй, ядуурлын түвшин маш өндөр байдаг.

Нийгмийн сайн сайхны төлөөх улс дахь эрх ба хариуцлага
Госта Эспринг Андерсен нийгмийн сайн сайхны төлөө улсуудыг хүмүүсийн оруулж буй хувь нэмрээс нь үл шалтгаалан нийгмийн үндсэн баталгааг ямар түвшинд хангаж буйгаар нь

дүгнэж байх нь зүйтэй гэж санал болгосон байна. «**Dekom-modifizierung**» гэдэг нь тухайн хүний зах зээл дээр бүтээж буй бүтээмжээс үл хамааран нийгмийн үндсэн үйлчилгээнээс тэгш хувь хүртэх эрхийг баталгаажуулах тухай ойлголт юм. Хүн түр хугацаагаар эсхүл удаан хугацаагаар амьжиргааны эх үүсвэрээ бүрдүүлэх хөдөлмөр эрхлэх албадлагаас ангижирч нийтийн туслалцаанд найдан амьдарна. Бүтээмжээс үл хамааран нийгмийн үндсэн баталгааг хангах тухай ойлголт нь хөдөлмөрийн зах зээлээс гадуур төрийн хуулиар баталгаажсан хууль ёсны тусламжийн байгууллагуудыг үүсгэн байгуулна гэсэн үг юм. Еспринг Андерсен Скандинавын социал демократ улсуудад бүтээмжээс үл хамааран нийгмийн үндсэн баталгааг хангах хангамж хамгийн өндөр, либерал нийгмийн сайн сайхны төлөөх улсуудад хамгийн бага байдаг гэж дүгнэсэн байна.

Гэхдээ энэ хэмжигдэхүүн нийгмийн ардчиллын концепцод тохирох уу гэдэг асуудал үүснэ. Нэлээд олон чухал үндэслэлүүд зах зээлийн албадлагаас хэр ангид байна бэ? гэдэг нь нийгмийн үндсэн эрхүүдийн хангалт хэр түвшинд байна бэ? гэдгийг харуулах үзүүлэлт биш гэдгийг баталж байгаа юм.

Нэгдүгээрт: 1990-ээд оны үед Скандинавын нийгмийн баримжаат улсууд анх удаагаа татварыг хэт бууруулсны улмаас ажилгүйдэл, санхүүгийн хомстол зэрэг ноцтой асуудлуудтай тулгарч байлаа. Тэгэхээр Скандинавын орнуудын бүтээмжээс үл хамааран нийгмийн үндсэн баталгааг хангах «хамгийн шилдэг практик жишээ» болж чадахгүй юм.

Хоёрдугаарт: Эрх эдэлсэн бол хариуцлага хүлээх ёстой гэдэг талаас нь авч үзвэл өөр нэг асуудал үүснэ: Хөдөлмөр эрхлэхээс татгалзаж биеийн амрыг харагч хүмүүс нөөцөөс шударга бус аргаар хэрэглэж ингэснээрээ гуравдагч этгээдийн нийгмийн эрхээ эдлэх нөхцөлийг нь хумигдуулж үйл ажиллагаа явуулах

боломжийг нь хязгаарлана. Хэрэв хэтэрхий олон тооны хүмүүс зах зээлийн албадлагаас ангижирч хөдөлмөр эрхлэхээс татгалзвал бүх нийтийн материаллаг хангамж хэвийн хэмжээнээс буурах, хомстох аюултай. Нийгмийн болон эдийн засгийн тэгш эрхүүдийг хамгийн дээд хэмжээгээр хангахын тулд нэг талаас хувь хүн бүр бусдын эрхийг дээд зэргээр хүндэтгэж нөгөө талаас эрх зүйн хамтын нийгэмлэгийг нэгдсэн нэг цогц хэмээн үзэж түүний ашиг сонирхлыг дээд зэргээр харгалзан үзэх шаардлагатай.

Бүтээмжээс үл хамааран нийгмийн үндсэн баталгааг хангах индекс зөвхөн хувь хүмүүсийн эрхүүдийг хэт өрөөсгөл байдлаар эрхэмлэн тэдний үндсэн үүргүүдэд тун бага анхаарал хандуулсан байдаг. Энэ шинж чанараараа нийгмийн ардчиллын хэрэгжилтийн хэмжигдэхүүн болгон авч үзэхэд учир дутагдалтай. Учир нь хувь хүн бүр нийгмийн нэгдсэн системд амьжиргааны эх үүсвэрээ бүрдүүлэх ажлын байраар хангагдах эрхтэй төдийгүй хөдөлмөр эрхлэх үүрэгтэй. Хувь хүмүүст хөдөлмөр эрхлэх бодит боломж байсаар атал биеийн амрыг харж хөдөлмөр эрхлэхгүй байгаа тохиолдолд нийгмийн баримжаат төр хууль ёсны эрхийнхээ дагуу түүнд хууль ёсны шахалт үзүүлэх хэлбэрээр нийгмийн хамгааллын системээс авах тэтгэмжийн хэмжээг нь бууруулж болно.

Өнөө үед хамгийн өндөр түвшинд хөгжсөн, хамгийн өндөр материаллаг хангамжийн түвшин бүхий нийгмийн хамгааллын системүүдтэй орнууд ч гэсэн хөдөлмөрийн зах зээл дээр амжилт олохгүй байгаа хүмүүсийг аль болох хурдан хугацаанд, шаардлагатай тохиолдолд хуулийн дагуу шахалт үзүүлэн хөдөлмөрийн зах зээл дээр эргүүлэн авчрах зорилтыг дэвшүүлж байна. Жишээлбэл: Шведэд бүтээмж муутай үйлдвэрлэлийн секторт ажиллаж байсан хүмүүсийг илүү өндөр бүтээмжтэй салбаруудад шинээр бий болж буй ажлын байруудад ажиллуулахын тулд шинээр мэргэшүүлэх арга хэмжээнүүдийг

идэвхтэй хэрэгжүүлж байна. Шинээр буй болсон ажлын байранд ажиллахын тулд нүүх шаардлага гарвал төрийн зүгээс тэдэнд материаллаг туслалцаа үзүүлдэг. Мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдагсад шаардлагатай газар луу нүүн шилжих үүрэг хүлээдэг.

Дээрх хэлбэрийн хөдөлмөрийн зэх зээлийн бодлого эдийн засгийн бүтээмж, нийгмийн баталгаат байдал, хамрагдагсдын эрх үүргийг үр өгөөжтэй хэлбэрээр хооронд нь холбож өгдөг. Ингэснээр нийгмийн эрхүүд хязгаарлагдахгүй харин ч тэдний хууль ёсны байдал баталгаажиж нийгмийн ардчиллын зорилтуудад илүү нийцэж байгаа юм. Энэ утгаараа хувь хүн бүрийн эрх үүргийн тэнцвэрийг хангахад чухал ач холбогдолтой.

Нийгмийн баримжаат төр нь хууль ёсыг тогтооход нөлөө бүхий яриа хэлцүүдээс хамааралтай болох нь

Нийгмийн баримжаат төрийн тодорхой хэлбэр үүсэн бий болох нь тухайн нийгэмд оршин байгаа чиг хандлагууд, санал сэдэл, итгэл үнэмшлээс хамаардаг. Эцсийн бүлэгт иргэд тодорхой шинэчлэлийн хөтөлбөрүүдийг дэмжиж байна уу? эс дэмжиж байна уу? гэдгээ сонгуульд оролцохдоо өөрсдийн сонголтоороо илэрхийлдэг. Тэдний сонголтод хувийн сонирхлоо эдийн засгийн шинэчлэлийн хүрээнд олж харах чадвар, нийгмийн ашиг сонирхлыг харгалзан үзэх чадвар, шударга ёсны асуудлууд чухал үүрэг гүйцэтгэдэг. Нийгмийн баримжаат төрийн тусгай төслүүдийг дэмжсэн эсвэл тэдний эсрэг нотолгоонууд эдийн засаг - сэтгэлгээний, ёс зүйн болон түүхэн туршлагын салбаруудад үүсэн бий болдог. Эдгээр нь ихэвчлэн шинэлэг сэдлүүдэд нөлөөлж байдаг. Энэ замаар нийгмийн баримжаат төрийг хууль ёсны болгох «яриа хэлцүүд» үүсэн бий болдог.

Шведийн нийгмийн баримжаат төр нь дундаж давхаргынхан болох тариаланчид болон ажилтнуудын нийгэм - эдийн засгийн ашиг сонирхлыг эн тэнцүү харгалзан үздэг гэдэг

нотолгоог үнэмшилтэй болгож байгаа юм. Нөгөөтэйгүүр энэ нотолгоо харьцангуй цомхон бүтэцтэй нийгэмд харилцан эв санааны нэгдэл дээр суурилсан харилцаанд оршихоос өөр аргагүй гэдэг санаан дээр суурилдаг. Нийгэмд аажимдаа «иргэд харилцан эрх, баталгаат байдлаа баталгаажуулдаг, нийгмийн үйлчилгээнээс хувь хүртэх нь иргэдийн эргэлзээгүй эрх мөн гэдэг «ухамсар бүрэлдэн тогтдог. Үүнээс гадна тухайн орны эдийн засгийн ололтын үндэс нь «нийгмийн баримжаат төрийн хэлбэрээр зохион байгуулагдсан эв санааны нэгдлийн үр дүн мөн» гэдэг эдийн засгийн сэтгэлгээний тайлбар түлхэц болж өгдөг.

Шведийн нийгэмд нийгмийн баримжаат төрийн тухай эерэг яриа хэлцүүд тархсан байдаг бол харин АНУ-д нийгмийн баримжаат төрийн тухай сөрөг яриа хэлцүүд тархсан байдаг. АНУ-д эртний хатуу ёс заншлыг ягштал баримтлагч уламжлалын нөлөөн дор нийгмийн баримжаат төрийн тэтгэлэгт дулдуйдан амьдрагчдад нэгэн хэлбэрийн ёс зүй-шашин шүтлэгийн зэмлэл ногдуулдаг. Зах зээлд хөлөө олоогүй хүн бүрийг хувь хүний бүтэлгүйгээс болж байна хэмээн буруутгадаг. Дээрх хэлбэрийн яриа хэлцүүдэд ядуурал, бусдын туслалцаанд шүтэн амьдрах болсон нь хувь хүнд бурхны зүгээс үзүүлж буй шийтгэл гэдэг шашин шүтлэгтэй холбоотой тайлбар өгөх хандлага байдаг. Уг яриа хэлцүүдэд иргэдийн нийгмийн эрхүүдийг хангах тухай ойлголт тохирдоггүй. Бурхны шийтгэлийг илүү амсуулахын тулд нийгмийн зүгээс эмзэг бүлгийнхэнд үзүүлэх туслалцаа мөчиг тачиг байх ёстой, тэгвэл эдийн засгийн өсөлтөд өөрийн хувь нэмрээ оруулах, өөрийгөө илүү дайчлах урам зориг нь хэвээр байж миний ингэж уруу дорой яваа нь миний л буруу гэдэг ухамсар сууна гэж үздэг.

Германд сүүлчийн зууны сүүлийн хагаст нийгмийн баримжаат төрийн тухай яриа хэлцүүд утгын хувьд ихээхэн өөрчлөгдсөн. Нийгмийн баримжаат төр үүсэн хөгжиж байсан хаант

улсын үед хувь хүн бүрийн нийгэмд эзэлж буй статусаас нь хамааран нийгмийн хангамжаас шат дараалсан хувь хүртээх эцгийн эрхт эзэрхэг төрийн үзэл санаан дээр суурилж байв. Тухайн үеийн нийгэмд консерватив чиг хандлага зонхилж байсан тул хүүрнэлүүдэд нийгмийг статус бүлгүүдэд, тодорхой түвшингүүдэд хуваах ёстой гэдэг асуудал зонхилох байр суурийг эзэлж хүн бүр нийгэмд эзэлж буй байр суурийнхаа хэрээр нийгмийн хангамж хүртэж байх ёстой гэдэг үзэл давамгайлж байснаас тэгш байдлын хэм хэмжээг харгалзан үзэх ёстой гэдэг ойлголт бүрдээгүй байлаа. Нийгмийн зүгээс туслалцаа хүртэх нь муугийн шинж гэж ад шоо үзэхгүй ч иргэний эрх гэдэг утгаар нь тодорхой хязгаарлалтгүй хүлээн зөвшөөрөх хэмжээнд хүрээгүй байлаа.

Ваймарын Бүгд Найрамдах улсын нуран унасан туршлага нь дэлхийн хоёрдугаар дайны дараах нийгмийн баримжаат төрийн тухай яриа хэлцүүдэд хүчтэй нөлөө үзүүлсэн. Цөөн тооны онолчид Ваймарын Бүгд Найрамдах Улс төрийн албан хаагчдыг төрд үнэнчээр зүтгүүлэхийн тулд тэднийг хүчтэй дэмжсэн нийгмийн бодлого явуулж эдийн засагт хэтэрхий ачаалал үүрүүлсний улмаас нуран унасан гэж үзэж байлаа. Тэд нийгмийн бодлогыг хүрсэн түвшнээс нь ухраахыг шаардаж байсан юм. Гэхдээ дэлхийн хоёрдугаар дайны дараа парламентад суудалтай улс төрийн намуудаас аль ч нам нийгмийн баримжаат төрийн загвар хэрэгтэй юу? гэдэг асуудлыг хөндөж байгаагүй ч консерватив болон социал демократ намуудын нийгмийн тухай яриа хэлцүүд чухам энэ үеэс хоорондоо ялгагдах болсон юм. Консерватив намынхан нийгмийн туслалцааг хүртэх шаардлагатай эмзэг бүлгийнхнийг буруутгахыг чухалчилж дэндүү хавтгайруулсан хэт өгөөмөр нийгмийн баримжаат төр нь эдийн засгийн зогсонги байдалд хүргэсэн гэж тайлбарлаж байсан бол тэдний социал демократ сөрөг хүчнийхэн эмзэг бүлгийнхэнд нийгмийн тусламж шаардлагатай байгаа нь зах зээлийн бүтцээс шалтгаалдаг,

нийгмийн хамгаалал, эдийн засгийн чадамж хоёр хоорондоо холбоотой гэж үзэж тайлбарлаж байсан билээ.

4.10 Боловсрол

Сурах, мэргэжлийн боловсрол олох, мэргэжил дээшлүүлэх эрх нь нийгмийн ардчиллын түлхүүр мөн. Чухамхүү боловсрол иргэн бүрийн ирээдүйд шийдвэрлэх үүргийг гүйцэтгэдэг. Хувь хүний авьяас чадварт тохирсон боловсролыг ерөнхий боловсролын сургуулиуд, мэргэжлийн сургалт, дээд сургуулиудаар олгох нь хувь заяаныхаа эзэн байх, хүссэнээрээ амьдрах боломжийг бүрдүүлж, шийдвэр гаргах эрх чөлөө, нийгмийн амьдралаас хувь хүртэх, бие даасан, хувь заяандаа эзэн байх гэрэлт ирээдүйн үүд хаалгыг нээж өгдөг. Боловсрол нь мөн шударга, эдийн засгийн өндөр чадамжтай нийгмийг байгуулах түлхүүр мөн. Мэдлэгт суурилсан орчин үеийн нийгэмд мэргэжил, мэдлэг боловсролоо тогтмол дээшлүүлэх идэвхтэй, хүсэл эрмэлзэлтэй өндөр боловсролтой ажиллах хүчин нь эдийн засгийн бүтээмжтэй, өрсөлдөх чадвартай, эдийн засгийн дэвшилд хүрэх үндсэн нөхцөл мөн. Хувь хүнийг ажилгүйдлээс хамгаалах хамгийн найдвартай даатгал бол боловсрол мөн. Эзэмшсэн мэргэжилгүй хүмүүс дээд сургууль төгссөн хүмүүстэй харьцуулахад хамгийн түрүүнд, хамгийн удаан хугацаагаар ажилгүйдэлд өртдөг.

Нийгмийн ардчилалд төрийн үндсэн үүрэг бол бүх иргэддээ өөрийгөө хөгжүүлэх чөлөөтэй, тэгш бололцоог хэлбэр төдий бус бодитоор бүрдүүлэх явдал юм. Энэ ойлголтын үндсэн дээр зорилгоо тодорхойлсон нийгмийн баримжаат төрийн үндсэн зорилт нь бүх хүнд боломжийн тэгш байдлыг хангах зорилттой салшгүй холбоотой байдаг. Энэ утгаараа боловсролд оруулж буй хөрөнгө оруулалт нь хувь хүмүүсийн эрх чөлөөний боломж, нийгмийн хөгжлийн чадамжийг нэмэгдүүлэхэд оруулж буй хөрөнгө оруулалт юм.

Эдийн засаг хөгжлийн хамтын ажиллагааны байгууллагын судалгаанууд: Судалгаанд хамрагдсан орнуудад хөдөлмөр эрхлэгсдийн боловсролын түвшинг дээшлүүлэхэд хөдөлмөрийн бүтээмж эрс дээшилж байгааг харуулсан байна. Хөдөлмөр эрхлэгсдийн «Илүү өргөн хүрээтэй» болон илүү сайн боловсрол аж үйлдвэр өндөр хөгжсөн орнуудын дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтөд эерэгээр нөлөөлсөн нь батлагддаг. Тэгэхээр боловсролд хөрөнгө оруулах нь хэзээд өгөөжөө өгдөг байна. Гэхдээ уг хөрөнгө оруулалтын үр өгөөж нэлээд удаан хугацааны дараа харагддаг. Боловсролын салбарын процесс болон шинэчлэлүүдийн өгөөжөө өгөх хугацааны хэмжигдэхүүнийг дараах жишээн дээр илүү тодорхой тайлбарлаж болно. 2004 онд ерөнхий боловсролын сургуулийг дүүргэсэн сурагчийн суралцах чадвар дээшилсэн бол тэр нь 1990 оны үед хэрэгжүүлсэн сургах арга барилыг өөрчилсний үр дүн байдаг. Уг сургалтын шинэ арга барилыг 1960-аад оны үед боловсрол олсон багш нар нэвтрүүлсэн байх жишээтэй.

Хүүхдийг бага наснаас нь дэмжих

Хүүхэд мэндэлсний дараах эхний хэдэн жилд хүний хөгжлийн хамгийн эрчимтэй үе явагддаг. Ийм эрчимтэй суралцах эрч хүч амьдралын дараагийн үеүдэд дахин тохиодоггүй. Чухам энэ үед алдагдсан алтан боломжуудыг дахин нөхөн ашиглах үе дахин хэзээ ч тохиохгүй байж болзошгүй, дахин нээгдлээ гэхэд өмнөхөөсөө хамаагүй их хичээл зүтгэл шаардагдана. Сургалтын арга хэмжээнүүдээр хүний хөгжлийг дэмжих, туслалцаа үзүүлэхэд хамгийн их амжилтад хүрэх боломж амьдралын эхний жилүүдэд хамгийн өндөр байдаг.

Судалгаагаар хүүхдийн бага нас «сэтгэн бодох» чадварыг хөгжүүлэхэд хамгийн чухал үе гэдэг нь батлагдсан байна. «Сэтгэн бодох чадвар» гэдэг нь нэг талаас мэдээллийг ойлгох, тайлбарлах, бүтээлчээр боловсруулах чадварыг хэлнэ. Нөгөө талаас хурдан, үр бүтээлтэй, дахин дахин шинээр суралцах

чадварыг хэлнэ. Мэдлэгт суурилсан нийгэмд технологийн шинэчлэл болон мэргэжлийн ур чадварт тавигдах шаардлагууд маш хурдан хугацаанд хувьсан өөрчлөгдөж байдаг тул сэтгэн бодох чадвар гол суурь нь болж байдаг. Сэтгэн бодох чадвар хүүхдүүдийн сурлагын амжилтад шийдвэрлэх үүргийг гүйцэтгэдэг төдийгүй насанд хүрсэн үедээ амжилттайгаар шинээр мэргэших, насан туршдаа суралцах чадвартай байх суурь нь болдог. Сэтгэн бодох чадварын тестүүдийг амжилттай бөглөдөг хүүхдүүдийн ерөнхий боловсролын сургуулиас дээд шатны сургалтад шилжих шилжилт харьцангуй хялбар байдаг.

Хүүхдийн сэтгэн бодох чадварын хөгжилд эцэг эхийнх нь нийгмийн гарал үүсэл, боловсролын түвшин хүчтэй нөлөө үзүүлдэг. Амьдралын боломжийн тэгш байдлыг хангахын тулд бүх хүүхдүүдэд тэдний нийгмийн гарал үүслээс үл хамааран сэтгэн бодох чадварыг хөгжүүлэх тэнцүү боломжоор хангах боловсролын системийг бий болгох явдал юм. Хүүхдүүд эцэг эхийнхээ нийгмийн статусыг «өвлөн авдаг» явдлыг аль болохоор таслан зогсоох хэрэгтэй. АНУ, ХБНГУ, Англи зэрэг орнуудын өнөөгийн боловсролын систем уг хандлагыг таслан зогсооход дорвитой ахиц гарах боломжийг бүрдүүлж чадахгүй байна. Харин хойд Европын гурван орон болох Швед, Дани, Норвегид нааштай өөрчлөлтүүд ажиглагдаж байна. Тухайн улсуудад эцгийнх нь боловсрол нь сургуулийн насны хүүхдийн сэтгэн бодох чадварын хөгжил, сурлагын амжилтад ямар ч нөлөөгүй байдаг. Дээрх улсуудад хэдэн арван жилийн өмнөөс сургуулийн өмнөх насныхныг сургуульд бүрэн хамруулдаг болсон. Эдийн засгийн болон соёлын хувьд доогуур түвшинд байгаа гэр бүлээс гаралтай хүүхдүүд зарчмын хувьд нийгмийн байдлын хувьд дээгүүр эрх мэдэлтэй гэр бүлээс гаралтай хүүхдүүдтэй тэнцүү хэмжээний сэтгэн бодох чадварыг хөгжүүлэх боломжоор хангагдаж байна. Тиймээс Скандинавын хүүхдүүд нийгмийн гарлын хувьд ялгаваргүй, сэтгэн бодох чадварыг нь хөгжүүлэх боломж бүхий нийтийн сургуулиудад

суралцаж байгаа нь хожим боловсролын кариераа хийхэд нь түлхэц болж өгдөг. Амьдралын боломжийн тэгш байдлыг бодитоор хангахад сургуулийн өмнөх насны бүх хүүхдүүдийг сургалтын арга хэмжээнүүдээр дэмжих явдал шийдвэрлэх чухал ач холбогдолтой.

Ерөнхий боловсролын сургуулийн сургалт

Өнөөг хүртэл тухайн хүний нийгмийн гарал нь түүний сэтгэн бодох чадварын хөгжил төдийгүй сургалтад хамрагдах боломж өөрөөр хэлбэл сургуулиа ямар дүнтэйгээр төгсөх бэ? гэдэгт нөлөөлсөөр ирсэн. Бага ангиас нь сурлагаар нь ангилал тогтоодог дунд сургуулийн системтэй орнуудад сурагчдын гэр бүлийн байдал, тэдний сурлагын амжилт хоёрын хоорондын уялдаа холбоог сулруулахад хүндрэлтэй байдаг. Нийгмийн гарал үүсэл нь боловсролын тэгш бус байдалд нөлөөлдөг үзэгдлийн эсрэг хамгийн үр өгөөжтэй гэдэг нь олон улсын туршлагаар батлагдсан жор бол нэгдсэн сургуулиудыг байгуулах явдал. Нэгдсэн дунд сургуулийн системийн давуу тал бол сурлагаар сайн хүүхдүүд сурлагаар маруухан нэгэндээ тусалдаг. Сурлага сайтай сурагчид сурлагаар маруухан нэгэндээ туслах явцдаа нийгмийн чадамж нь өсөж хөгжиж байдаг.

Мөн түүнчлэн өдөр өнжүүлэхтэй бүтэн өдрийн сургуулиуд амьдралын боломжийн тэгш байдлыг хангахад чухал үүрэгтэй. Бүтэн өдрийн сургуулиуд нийгмийн доод давхаргын хүүхдүүдийн сурлагын амжилтыг ахиулах бололцоог бүрдүүлдэг. Бүтэн өдрийн сургуулиуд нийгмийн ардчиллын бусад зорилтуудыг хэрэгжүүлэхэд туслалцаа үзүүлдэг. Хүүхдүүдийн эцэг эхүүдэд мэргэжлээрээ ажиллах, нийгмийн амьдралд идэвхтэй оролцох оролцоог нь нэмэгдүүлдэг. Цаашилбал хүйсийн байдлаар оногддог байсан уламжлалт хөдөлмөрийн хуваарийг өөрчилж эрэгтэй, эмэгтэйчүүдийн тэгш байдлыг хангахад дэмжлэг үзүүлдэг. Бүтэн өдрийн сургуулиуд хөдөлмөр эрхлэлтийн тэгш боломжийг хангах, нэн ялангуяа эмэгтэйчүүдийн тэгш байдлыг

хангахад чухал хувь нэмэр оруулдаг. Бүтэн өдрийн сургуулиуд эцэг эхчүүдийн бүтэн өдрөөр хөдөлмөр эрхлэхэд дэмжлэг үзүүлж хүйсийн тэгш байдлыг хангахад дорвитой дэмжлэг үзүүлдэг.

Нийгмийн ардчилал нь хувийн хариуцлага, өөрийн удирдлагыг ерөнхий зарчмаа болгосон ерөнхий боловсролын сургуулиудыг дэмждэг. Нэг талаас бүх хүмүүсийг суралцаж хөдөлмөрлөх нь өөрийн хариуцлага гэж үзэх ухамсраар хүмүүжүүлэх ёстой. Нөгөө талаас сургалтын үйл ажиллагаа эрхэлсэн байгууллагуудад ажлаа өөрийн хариуцлагын дор төлөвлөх бололцоогоор хангаж өгөх шаардлагатай. Мөн төр боловсролын процессыг зохион байгуулах эрхийг хариуцсан салбарынханд шилжүүлэх хэрэгтэй. Энэхүү эрхийг шилжүүлэх тохиролцоонд чанарыг ямар шалгууруудаар тодорхойлох, бүтээмжийг ямар хэмжигдэхүүнүүдээр үнэлэх, сургалтын агуулга, ажилд зайлшгүй мөрдөгдөх зарчмууд, шалгалтын арга хэлбэр, өөрчлөх журам зэргийг нарийвчлан заасан байх шаардлагатай. Сурган хүмүүжүүлэх ажилд эцэг эх, хүүхдүүдийг татан оролцуулах шаардлагатай. Уг хамтын оролцоо нь: Сургууль бол амьдралд хөлөө олох мэдлэг боловсрол олж авахын тулд хүмүүс хоорондоо харилцан туслалцдаг өлгий гэдэг шинэ ойлголтыг төлөвшүүлнэ. Зохион байгуулалтын дээрх хэлбэр нь нийгмийн үүргийн системд сургуулийг ардчилах зохимжтой хэлбэр мөн.

Хувийн хариуцлагын зарчмаар зохион байгуулагдсан сургуулиуд нь нийгмийн орчинд мэдээллийн солилцоог зохион байгуулдаг учраас өөрөө суралцагч байгууллага юм. Эдгээр сургуулиуд нь сурагчдын хувийн харилцаа болон орон нутгийн, бүс нутгийн онцлогт зохицох чадвартай байдаг.

Мэргэжлийн боловсрол

Хувь хүн бүрийн анхны мэргэжлийн сургалт нь хүссэн

мэргэжлээрээ хөдөлмөр эрхлэх гарааны нөхцөлийг бүрдүүлж ингэснээр өөрийнхөө өмнө хариуцлагаа хүлээх чадвартай болгодог. Хэдийгээр ирээдүйд анх суралцсан мэргэжлээрээ насан туршдаа ажиллах боломж улам бүр хязгаарлагдаж байгаа боловч хүмүүсийн нийгэмд байр суурьтай байх, бусдын хүндэтгэлийг хүлээх, сэтгэл хангалуун байх хэрэгцээг хангахад боловсрол, хөдөлмөр эрхлэлт шийдвэрлэх үүрэгтэй.

Иймээс залуу хүн бүр өндөр түвшинд анхны мэргэжил олгох сургалтад хамрагдах хууль ёсны эрхээр хангагдах эрхтэй байх ёстой. Мэргэжлийн сургалтын бодлогын ерөнхий зарчмууд:

- Мэргэжлийн сургалтад хамрагдах хүсэлт гаргасан бүх хүмүүс, түүний дотор сурлагын амжилтын үзүүлэлт доогуур хүмүүс ч мэргэжлийн сургалтад хамрагдах эрхтэй.
- Мэргэжил сонголтын өргөн боломж нээлттэй байх ёстой.
- Олон нийт боловсролын түвшинг өндөр байлгах хариуцлагыг хүлээнэ.
- Мэргэжлийн сургалтын хариуцлагыг төр, эдийн засаг хамтран хүлээнэ.
- Үндэсний сургалтын системүүд олон улсын түвшинд хөрвөх чадвартай байх ёстой.

Мэргэжлийн боловсролын ирээдүйд эдийн засгийн байдал хүндэрсэн нөхцөлд ч бүх залуусыг мэргэжлийн сургалтад хамруулах, мэргэжил олгох боломж нээлттэй байх нь чухал.

Их сургуулийн боловсрол

Орчин цагийн мэдлэгт суурилсан эдийн засагт улам олон тооны өндөр түвшинд бэлтгэгдсэн дээд сургууль төгсөгчид шаардлагатай байна. Их дээд сургуулиа амжилттай төгсөх нь хувь хүмүүст эрх чөлөөний боломжоо илүү эдлэх боломж, нийгмийн чинээлэг амьдралын түвшинг ахиулах нөхцөлийг хангаж өгдөг. Сургалтын хугацаа урт байх тусмаа төгсөгчдийн

тоо цөөрдөг нийтлэг хандлага байдаг. Дээд боловсрол олгох сургалтын хугацаа богино орнуудад их дээд сургуульд элсэгчдийн тоо харьцангуй их байдаг. Сургалтын хугацааг харилцан адилгүй урт, богино сонголт ихтэй хувилбаруудаар тогтоох нь хувь хүмүүсийн дээд сургуульд элсэн орох саад тотгорыг арилгахад төдийгүй хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд илүү уян хатан зохицоход тустай. Сургалтын хугацаа, төгсөлтийн хэлбэр олон сонголттой байх нь сургууль завсардалтын тоог эрс бууруулдаг.

Ихэнх орнуудад ажилчин гэр бүлээс гаралтай хүүхдүүд их дээд сургуульд суралцах хувь харьцангуй доогуур харин төрийн албан хаагчид, хувиараа хөдөлмөр эрхлэгсэд, чөлөөт уран бүтээлчид, албан хаагчдын хүүхдүүд харьцангуй олноороо их дээд сургуулиудад элсэн суралцаж буй хандлага ажиглагддаг. Гэр бүлийн гарал үүсэл дараа үеийнхнийхээ сурч боловсрох хүсэл эрмэлзэлд байнга удирдан чиглүүлэх нөлөөтэй байдаг. Өнөөг хүртэл үйлчилж ирсэн сонголтын механизм цаашид ч үйлчилсэн хэвээр байх болно. Дээд боловсролын сургалтын бодлого нийгмийн байдлын хувьд бага орлоготой гэр бүлээс гаралтай авьяаслаг залуу хүмүүсийг сургалтын төлбөр, амьжиргааны эх үүсвэрийг бүрдүүлэхэд нь санхүүгийн тусламж үзүүлэх замаар зорилготойгоор дэмжихэд чиглэгдэнэ.

Мэргэжил дээшлүүлэх сургалт ба насан туршдаа суралцах
Хувь хүн бүр өөрийгөө тасралтгүй хөгжүүлж мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдахад байнга бэлэн байх нөхцөлд л насан туршдаа хөдөлмөр эрхлэх боломж нь бүрдэнэ. Сургалтын эхний жилүүдэд цаашид суралцах чадвар суулгах суурь боловсрол олгогддог тул мэргэжил дээшлүүлэхэд бэлэн байх, чадварыг сургалтын эхний жилүүдийн хөтөлбөрт суулгаж өгөх нь зүйтэй. Оролцогсдын хувийн хариуцлага, өөрийгөө удирдах чадвар мэргэжил дээшлүүлэх сургалтын суурийг тавьдаг. Иргэдэд цаашид үргэлжлүүлэн суралцах

хэрэгцээг тухай бүрд нь танин мэдэх, өөрт тохирсон сургалтыг сонгон авах, өөрийгөө чадваржуулах, мэргэжил дээшлүүлэх сургалтаас ямар амжилт гарах бэ гэдгийг өөрөөр хэлбэл мэргэжил дээшлүүлэх сургалтын өртөг ба ашгийн харьцааг зөв үнэлэх мэдлэгийг олгох шаардлагатай.

Эдийн засгийн болон боловсролын бодлогын шийдвэрүүд хоорондоо зөрчилдөх учиргүй. Мэргэжил дээшлүүлэх сургалт нь компаниудад ашигтай тул компанийн зүгээс тусалдаг байх ёстой. Компанийн ажил нь сурч боловсрох боломж нээлттэй, ажилтнууд нь бие даан мэдлэг чадвараа дээшлүүлэх боломжоор хангагдсан байдлаар зохион байгуулагдсан байх ёстой.

Мэргэжилдээшлүүлэхсургалтадхамрагдагсдындундтэнцвэртэй бус байдал оршсоор байгаа бөгөөд ихэвчлэн формаль буюу өндөр боловсролын дипломтой боловч чадвар муутай хүмүүсийг илүү дэмжсэн бодлого түлхүү хэрэгждэг нь нууц биш. Ирээдүйд мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдагсдын тоог нэмэгдүүлэх шаардлагатай байна. Сурч боловсрох боломжоо бүрэн дүүрэн эдэлж чадаагүй хүмүүсийг олон нийтийн хариуцлагаар хожим нь илүү дэмжих шаардлагатай. Ажлын цагийн зохион байгуулалтын шинэ загварууд болох цагийн данс, жилийн чөлөө зэрэг зохицуулалтууд хувь нэмрээ оруулж мэргэжил дээшлүүлэх сургалтад шаардагдах цагийн боломжийг олгож тэдний хэрэгжилтэд дэмжлэг үзүүлдэг.

Швед улс хамгийн сайн практик хэрэгжилтийн үлгэр жишээ болж чадна. Тэнд мэргэжил дээшлүүлтэд зарцуулсан цагийг тэтгэвэр тооцох орлогод оруулан тооцдог. Түүнээс гадна Шведэд төсвийн зардлаар суралцах насны хязгаарыг 45-аас 50 нас болгож нэмэгдүүлсэн байна. Шведэд насанд хүрэгчдэд боловсрол олгох олон хэлбэр байдаг. Ажилчдын боловсрол, шашны нийгэмлэгүүд, архидалтын эсрэг хөдөлгөөнүүдийн идэвх санаачилгаар явагддаг нийтийн тусын төлөөх чөлөөт

сургалтууд болох орон нутгийн ард түмний сургуулиуд, оройн гимназиуд, бичиг үсэг тайлагдаагүй хүмүүст зориулсан тусгай сургалтуудын тоо цөөрч төр ба тарифын гэрээнд оролцогч талуудын хамтын санхүүжилтээр зохион байгуулдаг өндөр өртөг бүхий мэргэжил дээшлүүлэх болон өөр шинээр мэргэших сургалтын хөтөлбөрүүд зонхилох боллоо.

Нийгмийн ардчиллын сургалтын бодлогын үндсэн зарчмууд
Нийгмийн ардчиллын сургалтын бодлогын үндсэн зарчмууд нь:

Нэгдүгээрт: Хүн бүрд өөрөө хувь заяаныхаа эзэн байх чадварыг нь олгох, өргөн хүрээтэй ерөнхий боловсролын сургуульд аль болох эрт, бага насандаа суралцах эрх эдлүүлэх.

Хоёрдугаарт: Хүн бүр мэргэжлийн боловсролын болон мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамрагдах эрхтэй.

Сурч боловсрох эрхийн хүрээнд үндсэн гурван хүчин зүйлс байдаг. **Нэгдүгээрт** суралцах эрх нь бүх иргэдийн нийгмийн үндсэн эрхүүд юм. **Хоёрдугаарт** амьдралын боломжийн тэгш хуваарилалтын зарчим, Нийгмийн аливаа нэг бүлэгт нийгмийн гарал үүсэл эсвэл эдийн засгийн байдлын улмаас системтэйгээр давуу эрх олгож эсвэл хохироож болохгүй. **Гуравдугаарт:** боловсролын идэвхтэй бодлого явуулах нь төрийн үүрэг мөн. Дээрх гурван нөхцөл бүрдсэн тохиолдолд амьдралын боломжийн тэгш хуваарилалт зөвхөн хэлбэр төдий бус бодит байдлаар хангагдана.

4.11 Нийгмийн баримжаат зах зээлийн ирээдүй **Капитализмын хэв шинжүүдийн харьцуулалт**

Төрийн зохицуулалтыг дэмждэг эсвэл төрийн зохицуулалтаас татгалзсан капитализмын маш олон төрлийн хэв шинжүүд байдаг. Эдгээрийг либерал ба төрийн зохицуулалттай зах зээлүүд гэсэн үндсэн хоёр бүлэгт хамааруулан хуваадаг. Дээрх

хэв шинжүүдэд голлох ролийг гүйцэтгэдэг, тэдгээрийн голлох актёруудын харилцааг хооронд нь зохицуулдаг байгууллагууд болох компаниуд, банкнууд, эдийн засгийн холбоод, үйлдвэрчний эвлэлүүдийн харилцааг дурын хэлбэрээр уялдуулан зохицуулах боломжгүй.

Дээрх байгууллагууд нь тухайн улс төрийн эдийн засгийн дотоод бүтцийг бүрдүүлж байдаг бөгөөд тухайн улс орны түүхэн хөгжлийн үр дүнд үүсэн байгуулагдсан, даяаршлын өрсөлдөөний үед системийн гадуурх шаардлагуудыг шүүх, боловсруулах шүүлтүүрийн үүргийг гүйцэтгэж байдаг. Эдгээр нь системийн бүтцийн өөрчлөлтөд тухайн системдээ тохирсон, түүний шинж чанарыг хадгалсан хариултуудыг өгч байдаг. Энэ талаас нь авч үзвэл улс төрийн эдийн засгийн хэв шинжүүдийн дотроос тэр нь илүү гэх хэв шинж байдаггүй, нэг талаар илүү байхад нөгөө талаар дутмаг байдаг. Тухайн улс орнуудын хөгжлийн түвшингүүдийн онцлогийг үл харгалзан авч үзэхэд дээрх хоёр загвар хоёулаа даяаршлын дарамт дор тус бүрийн онцлогт тохирсон арга хэлбэрээр эдийн засгийнхаа чадамжийг хамгаалж чаддаг. Гэхдээ тухайн улс орнуудын харилцан адилгүй эдийн засгийн чадамж дээр суурилсан учраас өөр өөр хэмжээнд байх нь ойлгомжтой.

Эдийн засгийн хэв шинжийн дээрх хоёр төрлийн системчлэгдсэн ялгаа нь тэдгээрийн тус бүрийн онцлогийг агуулсан чадамжийн өөр өөр хэм хэмжээнүүдэд оршин байдаг. Зохицуулалттай ба зохицуулалтгүй зах зээлийн эдийн засаг нь шинэ технологи, техникт суурилсан эдийн засгийн хөгжлийн олон төрлийн хувилбаруудыг хөгжүүлж байдаг бөгөөд орлого болон хөдөлмөрийн хуваарилалт нь ч харилцан адилгүй байдаг.

Зохицуулалттай зах зээлийн үйлдвэрлэлийн системүүд өндөр чанартай үйлдвэрлэлийн стратегийг хэрэгжүүлэхэд харьцангуй хялбар харин тухайн үед хамгийн борлуулалт өндөртэй байгаа

бүтээгдэхүүний үйлдвэрлэлд богино хугацаанд шилжихэд тохиромжгүй байдаг. Цаашилбал зохицуулалттай эдийн засгийн байгууллаууд хязгаарлагдмал эдийн засгийн дэвшилд хүрэхэд илүү давуу талтай, харин эдийн засгийн суурь буюу үндсэн дэвшилд хүрэхэд тохиромжгүй байдал ажиглагдаж байна. Улс төрийн эдийн засгийн байгууллагуудын үйл ажиллагааны ерөнхий цар хүрээний ялгаатай байдлын улмаас компаниудын үйл ажиллагааны стратегид системийн шинж чанартай ялгаатай байдал үүсдэг. Энэ ялгаатай байдлыг зохицуулалтгүй зах зээлийн системтэй Их Британийн компаниуд, зохицуулалттай зах зээлийн эдийн засагтай Герман улсын компаниуд адилхан шаардлага тулгарахад харилцан адилгүй хариу үйлдэл үзүүлж байгаа жишээн дээр тайлбарлаж болно. Валютын хөрвөх ханш өөрчлөгдсөний улмаас тухайн орнуудаас гадаад зах зээл дээр экспортод гаргаж буй бүтээгдэхүүний үнэ нэмэгдэхэд Их Британийн компаниуд олж буй ашгаа бууруулахгүйн тулд алдагдлыг хэрэглэгчиддээ үүрүүлж байхад Германы компаниуд үнийг хэвээр байлгаж олж буй ашгаа багасгахыг хүлээн зөвшөөрч харин зах зээл дээрх борлуулалтын хувиа хэвээр хадгалах бодлого явуулж байна.

Капитализмын хэв шинжүүдийн судалгаа нь адилхан шаардлага тулгарсан үед компаниудын үзүүлж буй хариу үйлдлийг тайлбарлах дүн шинжилгээний ерөнхий хүрээг тодорхойлж өгч байгаагаараа ач холбогдолтой юм. Их Британийн компаниуд богино хугацаанд ашиг орлого огцом буурахад их ашиг олж байдаг хөрөнгийн зах зээлээс хамааралтай тул дотоодын зохицуулалтгүй зах зээл дээр өөрсдийн ашгийн хувь хэмжээг бууруулахгүй байхыг эрмэлздэг. Харин тэд гадаад зах зээл дээрх борлуулалтын хувиа алдсан тохиолдолд хөдөлмөрийн зах зээл нь задгай, нээлттэй тул богино хугацаанд ажиллах хүчээ бөөнөөр нь халах замаар алдагдлаа нөхдөг. Харин Германы компаниудын хувьд зохицуулалттай зах зээлийн

санхүүгийн систем богино хугацаанд олох ашгаас үл хамааран хөрөнгө хуримтлуулах боломж нь нээлттэй байдаг учраас нэлээд хугацаагаар ашиг буурахад тэсэж үлдэх чадвартай юм.

Нийгмийн ардчиллын үзэл баримтлалын үүднээс олон талаас нь чанарын үнэлгээ хийхэд «shareholder value»-д буюу хувьцаа эзэмшигчдийн ашиг сонирхол голлох үүрэгтэй зах зээл буюу зохицуулалтгүй зах зээлийн байгууллагуудын бүтэц нь дараах үндсэн дутагдлуудтай байдаг.

Нэгдүгээрт: Түр хугацаанд их ашиг олоход чиглэгдсэн компаниудын стратеги нь тухайн компаниудын стратеги төлөвлөлтөд урт хугацааны үр дагавруудыг тусгах боломжийг хаадаг тул нийгэм, байгаль орчны асуудлуудыг улам хүндрүүлж байдаг.

Хоёрдугаарт: Компаниудын удирдлага ямар ч хяналтгүй менежментийн багийн мэдэлд байдаг тул нийгмийн төрөл бүрийн бүлгүүд нэн ялангуяа ажилтнуудын эдийн засгийн шийдвэр гаргах процессод оролцох оролцоо хаагдмал байдаг.

Гуравдугаарт: Зохицуулалтгүй зах зээлүүдийн ажиллах хүчин нь маш ерөнхий бэлтгэгдсэн, маш уян хатан ямар ч зохицуулалтгүй хөдөлмөрийн зах зээл дээр үйл ажиллагаа явуулдаг тул өндөр мэргэшсэн ажиллах хүчинтэй зохицуулалттай зах зээлтэй харьцуулахад бэрхшээлтэй. Энэ нь ажиллах хүчний хараат байдлыг нэмэгдүүлдэг.

Дөрөвдүгээрт: Зохицуулалтгүй зах зээлийн хөдөлмөрийн харилцааны энэхүү бүтэц дээр үйлдвэрчний эвлэл нь сул, цалин хөлсний нэгдсэн хэлэлцээр байдаггүй зэрэг бүтцийн гаралтай бэрхшээлүүдийг улам хүндрүүлэх шалтгаан болдог.

Бүтээмжийн норматив цар хүрээ

Нийгмийн ардчиллын улс төрийн эдийн засагт капитализмын

хэв шинжийн дүн шинжилгээний хүрээг ардчилал, нийгмийн хамгаалал, нийгмийн оролцооны бүтээмжийн цар хүрээнүүдээр өргөжүүлж тэдгээрийн нөлөөг онцгойлон авч үздэг. Энэ нь эерэг эрх чөлөөний эрхүүдийн хэрэгжилтийн хүрээг тодорхойлно гэсэн үг бөгөөд үүнд амьдралын боломжийн тэгш хуваарилалт, нийгмийн аюулгүй байдал, нийгмийн автономит байдал, нийгмийн бүтцийн эрсдэлүүдээс хамгаалах хамгаалалт зэрэг багтдаг. Цаашилбал ажлын байран дээр хүний алдар хүндийг хамгаалах, орлогыг шударгаар хуваарилах, компанийн болон макро эдийн засгийн түвшний шийдвэр гаргалтад бүлгүүдийн ашиг сонирхлыг зохих хэмжээнд тэнцүү харгалзан үзэх зэрэг хамаарна. Улс төрийн эдийн засгийн бүтээмжийн дээрх цар хүрээнүүдийг макро эдийн засгийн бүтээмжийн чадавхын үзүүлэлтүүд болох ажилгүйдэл, ханшийн уналт, эдийн засгийн өсөлт зэрэгтэй дүн шинжилгээ болон нормативын харьцуулалт хийж хооронд нь харьцуулж үзэх ёстой.

Эерэг эрх чөлөөний цар хүрээнд амьжиргааны эх үүсвэрээ бүрдүүлэх хөдөлмөр эрхлэлт нэг үндсэн категори нь юм. Хөлсний хөдөлмөр эрхэлснээр хүмүүс зөвхөн орлогоо олоод зогсохгүй өөрөө хувь заяаныхаа эзэн байж амьдрахад шаардагдах нийгмийн үндсэн үйлчилгээнээс хүртэж эдгээр нь тэдний нийгмийн болон соёлын хүрээнд бусдад хүндлэгдэх, өөрийгөө хүндлэх үндсийг бүрдүүлж байдаг.

Тэгэхээр хөдөлмөрөөрөө орлогын эх үүсвэрээ бүрдүүлэх ажлын байртай байх нь иргэдийн эерэг эрх чөлөөний эрхүүдээ хэрэгжүүлэх анхдагч нөхцөл юм. Нийгмийн ардчиллын улс төрийн эдийн засагт хөдөлмөрийн зах зээлийн нээлттэй байдал нь бүтээмжийн хэм хэмжээний болон эрх чөлөө, шударга ёсны амин чухал хэмжигдэхүүн мөн. 1980-аад оноос өргөн хүрээтэй менежментийн шийдвэрт нь саад тотгор болох зүйлгүй, түргэн хугацаанд техник, технологийн шинэчлэлийг нэвтрүүлж эдийн засгийн өсөлтийг дээшлүүлэх боломжтой, хөдөлмөрийн зах

зээл нь маш уян хатан, зах зээл нь дасан зохицох чадвар сайтай, хөрөнгийн зах зээл дээр хурдан хугацаанд хөрөнгө босгох чадвартай тул мөнгөний ханшийн уналт, ажилгүйдэл зэрэг чухал эдийн засгийн бүтээмжийн цар хүрээнүүдэд даван туулах чадвар илүүтэй мэт харагдаж байлаа. Харин зохицуулалт өндөртэй зах зээлүүдэд бүтцийн улмаас бий болсон ажилгүйдэл удаан хугацааны туршид маш өндөр байгаа юм. Либертар онолчид чухамхүү энэ сул тал дээр дөрөөлөн зохицуулалттай зах зээлүүд хөдөлмөрийн зах зээлээ үйлдвэрлэлийн арга хэлбэрийн өөрчлөлт, даяаршлын зах зээлийн өрсөлдөөнд зохицуулан өөрчлөх чадваргүй хэмээн нотолцгоож байна. Харин зөвхөн ажилгүйдлийн коэффициентыг үндэслэл болгон зохицуулалттай ба зохицуулалтгүй зах зээлүүдийг харьцуулан сайн муу хэмээн дүгнэх нь ихээхэн өрөөсгөл юм. Жишээлбэл АНУ -ын сүүлийн хориод жилийн хугацааны ажилгүйдлийн байдлыг бусад зохицуулалттай зах зээлтэй улс орнуудынхтай харьцуулахад макро эдийн засгийн нөхцөлүүдээс шалтгаалан зарим үед өндөр, зарим үед доогуур байжээ. 1983 - 1988 онд Швед, Норвеги, Швецари, Австри улсуудын ажилгүйдлийн коэффициент АНУ-аас доогуур ойролцоогоор Японы ажилгүйдлийн коэффициенттэй ойролцоо 3%-иас доогуур байжээ. Гэтэл мөн адилхан зохицуулалттай зах зээлтэй хөрш орнууд болох Дани, Франц, Нидерланд, Бельги улсуудад ажилгүйдлийн коэффициент маш өндөр 9 - 12% байсан байна. 1992 онд Швед, Нидерланд, Норвеги, Швейцарийн ажилгүйчүүдийн тоо мөн АНУ-аас доогуур 7.5% байсан байна. Түүнчлэн АНУ-ын эдийн засгийн үсрэнгүй хөгжлийн жил болох 1998 онд Нидерланд, Норвеги, Швейцарын ажилгүйдлийн коэффициент 4.6%-тай тэнцэж байсан нь мөн АНУ-аас доогуур байжээ. Гэтэл мөн адилхан зохицуулалтгүй зах зээлтэй Их Британийн ажилгүйдлийн коэффициент 1990 - 1998 оны хоорондох дөрвөөс найман жилд Эдийн Засаг Хөгжлийн Хамтын Ажиллагааны Байгууллагын дунджаас дээгүүр байжээ. Зарим зохицуулалттай зах зээлтэй орнуудад ажилгүйдлийн

коэффициент ийнхүү өндөр байгаа нь маш олон шалтгаантай гэдгийг зохицуулалттай зах зээлүүдийн харьцуулсан судалгаа харуулж байгаа бөгөөд гагцхүү капитализмын хэв шинжүүдийн байгууллагууд хоорондын хамтын ажиллагааны хувилбаруудаас хамаардаг гэж үзэх нь өрөөсгөл юм. Зохицуулалтгүй зах зээлүүд зах зээлийн өөрчлөлтөд дасан зохицох чадвараар илүү, эдийн засгийн хөгжлийн багтаамжаараа ажилгүйдлийг хурдан хугацаанд бууруулах боломжтой мэт харагдавч тэдгээрийн байгууллагуудын бүтцүүд, нэн ялангуяа уян хатан зохицуулалтгүй хөдөлмөрийн зах зээл (солилцооны боломж сайтай, компани ба ажилтнуудын хоорондын холбоос сул гэдэг утгаараа) нь ажилгүйдлийн өндөр коэффициентийг бууруулахад зарчмын хувьд нөлөө үзүүлж чаддаггүй. Цаашилбал маш уян хатан хөдөлмөрийн зах зээлийн нийгэмд учруулах нэмэлт зардлуудыг ажилгүйдлийн статистиктай харьцуулж үзэх нь зүйтэй. Ажлын байрны зөвхөн тоо бус чанар чухал ач холбогдолтой. Жишээлбэл маш бага цалин хөлстэй ажлын байранд ажиллагсад хэдийгээр хөдөлмөр эрхэлж байгаа боловч богино хугацаанд ядуусын эгнээнд шилжиж материаллаг эрх чөлөөний боломжуудаа хэрэгжүүлэхэд шаардагдах нөөцийг хуримтлуулах боломжгүй болдог тул материаллаг эрх чөлөөний эрхээ эдэлж чадахгүйд хүрдэг. Хэт уян хатан зохицуулалтгүй хөдөлмөрийн зах зээл нь мэдлэг чадварын болон орлогын хуваарилалтын доод шатлалд өөрийнхөө амьдралын нөхцөлүүдийг хүссэнээрээ бүрдүүлэх автономит эрхийг хязгаарладаг. Цалин хөлсний хэмжээг тогтоох процесс зохицуулалтгүй, зөвхөн компаниудын түвшинд нэгдсэн хэлэлцээргүй явагддаг зах зээлийн эдийн засагт цалин хөлсний зөрүү маш өндөр байх хандлага байдаг. АНУ, Их Британи зэрэг эдийн засгийн тэгш бус байдал нь бүтээмжийн болон шударга ёсны зохих хэм хэмжээнүүдээс хол давсан орнуудад ядуурал болон нийгмийн тэгш бус байдал зохицуулалттай зах зээлтэй орнуудаас илүү өргөн хүрээтэй тархсан байдаг. Мөн амьдралын нөхцөл нийгмийн гарал үүсэл «өвлөгдөх» буюу үеэс үе дамжих

үзэгдэл үүнтэй холбоотойгоор амьдралын боломжуудын тэгш бус хуваарилалт зохицуулалтгүй зах зээлтэй орнуудад илүү түгээмэл байдаг. Эерэг эрх чөлөө, хүн бүрд хүний ёсоор амьдрах эрхийг баталгаажуулах хэм хэмжээ талаас нь авч үзвэл зохицуулалтгүй зах зээлд маш их дутагдал байдаг.

Нөгөө талаар зохицуулалттай зах зээлүүдэд байдаггүй, зохицуулалтгүй зах зээлд түгээмэл байдаг маш бага цалинтай эдийн засгийн секторууд үй олноороо ажилгүйдэлд өртөх, удаан хугацаагаар ажилгүй байх нөхцөлийг бүрдүүлж байдаг. Аж үйлдвэрийн эдийн засгаас мэдлэгт суурилсан үйлчилгээний эдийн засагт шилжих шилжилт хөдөлмөрийн ертөнцөд бүтцийн өөрчлөлтийг дагуулж хөдөлмөрийн зах зээл, нийгмийн системүүд, зохицуулалттай зах зээлийн нэгдсэн удирдлагын байгууллагуудын өмнө хүндхэн сорилтуудыг тавьж байна. Гэтэл нэн ялангуяа ажилгүйдлээс хамгаалах чиглэлээр байгуулсан байгууллагууд ажилгүйдлийг бууруулахад хамгийн их саад учруулж байна. Нэн ялангуяа нийгмийн хамгааллын систем нь орлогын татвараар зонхилон санхүүждэг, үүний улмаас хөдөлмөрийн өртөг буюу цалингийн нэмэгдэл зардлууд нэмэгдэж байдаг орнуудад удаан хугацаагаар үй олноороо ажилгүйдэлд өртөх шалтгаануудын нэг нь нийгмийн хамгааллын систем нь болж байдаг. Зарим хатуу зохицуулалттай зах зээлтэй, хатуу тарифын системтэй орнуудад жишээлбэл Герман улсад «даатгалд хамрагдагсад» «даатгалд хамрагдаагүй» бүлгүүдийн хоорондын ялгаа буюу туйлшрал улам их болж байгаа нь ажиглагдаж байна. Уг туйлшрал нь зохицуулалтгүй зах зээлтэй харьцуулах хэмжээнд хүрээд байна. Хараар буюу хууль бусаар хөдөлмөр эрхлэх явдал улам хүрээгээ тэлж буй нь зохицуулалттай зах зээлийн нэгдэл суларч байгаагийн нэгэн илэрхийлэл юм.

Олон улсын бүтээгдэхүүний зах зээлийн ерөнхий нөхцөлүүд өөрчлөгдөж, улам бүр төрөлжиж байгаа зах зээлийн булангууд

үүсэн буй болж байгаатай холбогдуулан олон улсын түвшинд эрсдэл өндөртэй, хамгаалалтгүй эдийн засгийн секторуудын өрсөлдөх чадварыг зөвхөн бүтээгдэхүүн болон үйлдвэрлэлийн процессод тасралтгүй шинэчлэлт хийх, үнийг бууруулах замаар хадгалах боломжтой. Олон улсын тавцан дээрх өрсөлдөөн компаниудын бүтээмжийг нэмэгдүүлэхэд тустай. Энэ нь эцсийн бүлэгт олон улсын зах зээл дээр байр сууриа олсон улс орнуудын хувьд ч эрсдэл өндөртэй, хамгаалалтгүй салбаруудад хөдөлмөр эрхлэгсдийн тоог хязгаарлахад хүргэж байгаа юм. Бодит байдал дээр эрсдэл өндөртэй салбарт ажиллагсдын тоо өндөр хөгжсөн зах зээлийн эдийн засагтай орнуудад ч буурсан байна. Харин хамгаалагдсан секторуудад (орон нутгийн түвшинд үйлдвэрлэгдэж тухайн орон нутагтаа хэрэглэгдэх үйлчилгээ) ажиллагсдын тоо нэмэгдэж байна. Гэхдээ уг хамгаалалттай салбаруудад ажиллагсдын тоо хувийн секторын маш бага цалинтай ажлын байрууд болон төсвийн нийгмийн үйлчилгээний салбаруудад нэмэгдэж байна. Энэ нь эргээд тухайн нийгэм татварын ачааллын ямар хувь хэмжээг хүлээн зөвшөөрдөг бэ? гэдгээс хамаарах үйлдвэрлэлийн дэглэмд тогтсон нийгмийн баримжаат төрийн хүрээлэл буюу зах зээлийн төрийн зохицуулалт, нийгмийн баримжаат төрийн санхүүжилт, улс төрийн шийдвэрүүдийн үр дагавар юм.

Цаашдаа зохицуулалттай зах зээлүүд үйлдвэрлэлийн арга хэлбэрүүд болон олон улсын ерөнхий нөхцөлүүдийн өөрчлөлтөд зохицуулалтгүй зах зээлүүдээс өөр хариу үйлдэл үзүүлэх боломж байх ёстой. Хойшид нийгмийн баримжаат төрийн зохион байгуулалт, түүний зүгээс эдийн засгийн процессод үзүүлж буй нөлөө, тэндээс гарч буй үр дүнг зохицуулалтгүй зах зээлийн үйл явцтай харьцуулах харьцуулалтад хамруулж байх нь зүйтэй.

Нийгмийн баримжаат зах зээл

Үндсэн эрхүүд дээр суурилсан нийгмийн баримжаат төртэй

холбоотой, бүх хүнийг ажилтай байлгах зорилго бүхий макро болон микро эдийн засгийн зохицуулалтын бодлого хэрэгжүүлдэгэдийн засгийн системүүдийг нийгмийн баримжаат зах зээл гэж нэрлэж болно. Нийгмийн ардчиллын улс төрийн эдийн засагт капитализмын хэв шинжийн судалгааг нийгмийн баримжаат төрийн хэв шинжүүдийн судалгаагаар өргөжүүлэх шаардлагатай. Нийгмийн баримжаат төр ба эдийн засгийн хэв шинжүүдийн харилцан шүтэлцээний дүн шинжилгээ нь зах зээлийн эдийн засаг ба нийгмийн баримжаат төрийн хоорондын харилцааны дөрвөн үндсэн хэв шинжүүд байдаг гэдэг дүгнэлтэд хүргэдэг:

Нэгдүгээрт: Зохицуулалтгүй зах зээл ба либерал нийгмийн баримжаат төрийн хосолсон хэлбэр: Менежментийн бие даасан шийдвэр гаргахад үйлдвэрчний эвлэлийнхнийг саад тотгор учруулагчид гэж үздэг учраас компаниудын үйл ажиллагааны зохицуулалтад тэдний үүрэг роль их сул байдаг. Ийм улс орнуудад ихэвчлэн улс төрийн намуудын хоёр туйлт систем оршин байдаг ба тэдгээрийн хоорондын зөрчилдөөн эдийн засгийн хуваарилалтын асуудал дээр илэрч байдаг.

Хоёрдугаарт: Улсын хэмжээнд зохицуулагдсан зах зээл ба түгээмэл, нийгмийн болон улс төрийн эрхүүдийн тэгш байдлыг эрхэмлэгч, дахин хуваарилагч, үйлчилгээнд чиглэсэн нийгмийн баримжаат төрийн хосолсон хэлбэр: Зохицуулалттай зах зээлүүдийн үндэсний түвшинд ажил олгогч эзэд ба үйлдвэрчний эвлэлийн дээд шатны төлөөллийн байгууллагууд цалин хөлснөөс эхлээд олон нийтийн боловсрол, шийдвэр гаргалтад талуудын оролцох оролцоо хүртэл өргөн хүрээтэй чухал асуудлуудаар хэлэлцээр хийдэг. Дээрх хэлэлцээрүүдэд засгийн газрууд ихэвчлэн хурал даргалагчийн үүргийг гүйцэтгэдэг. Тун ховор тохиолдолд удирдах үүргийг гүйцэтгэдэг байна. Энэ хэлбэрийн төр, эдийн засгийн харилцааны бүтэцтэй улсуудад социал демократ намууд зонхилох үүрэгтэй, олон жижиг хөрөнгөтний намуудын блок зэрэгцэн оршиж байдаг.

Гуравдугаарт: Хэсэгчилсэн зохицуулалттай зах зээлүүд ба хөдөлмөр эрхлэлт, орлогын хуваарилалт, нээлттэй байдалд чиглэгдсэн нийгмийн баримжаат төрийн хосолсон загвар: Энэ загвартай улсуудад мэргэжил олгох сургалтууд компаниудын түвшинд явагддаг, хэрэв үйлдвэрчний эвлэл компаниуд оролцвол төрийн сургуулиудаар олгодог. Үйлдвэрчний эвлэлийнхэн аж үйлдвэрийн салбарт ажилладаг гишүүдээ зохион байгуулж ингэснээрээ компаниудын дотоодод хөдөлмөрийн нөхцөлийг бүрдүүлэх ба цалин хөлсийг тогтооход чухал үүрэг гүйцэтгэдэг. Эдгээр орнуудад улс төрийн намуудын гурван туйлт систем оршин байдаг ба тэдгээр нь либерал, католик, социал демократ чиглэлүүдээр хоорондоо ялгаатай байдаг.

Дөрөвдүгээрт: Аж үйлдвэрийн бүлгүүдийн зохицуулалттай зах зээлүүд («keiretsu») - либерал нийгмийн баримжаат төрүүдийн хосолсон загвар: Эдгээр орнуудад «хөрөнгөтний» намууд зонхилох байр сууриудыг эзэлж намууд хоорондын өрсөлдөөн нь үзэл суртлын шинж чанаргүй байдаг.

Хоёрдугаар, гуравдугаар загварууд ба Япон улсын туршлагад хийсэн дүн шинжилгээ нь дөрөвдүгээрт бичигдсэн загварууд тэдгээрийн хувилбарууд нийгмийн ардчиллын нөхцөлүүдийг хангаж байгааг харуулж байна. Зохицуулалтгүй зах зээлүүд ба либерал нийгмийн баримжаат төрийн хосолсон загвар хамгийн бодитоор АНУ-д хэрэгжиж байгаа бөгөөд энэ нь либертар капиталист ардчилал юм.

Капиталист эдийн засгийн олон талт дүн шинжилгээнд нийгмийн сайн сайхны төлөөх төрийн зохион байгуулалтуудыг нэмж оруулан судалсан үр дүн: маш олон тооны улс төр, эдийн засгийн байгууллагууд нь хамтарсан болон улс төрийн актёруудтай харилцан нөлөөлөлд оршдог бөгөөд тэдгээр нь тухайн оршин буй бүтцээр дамжин нөхөн үйлдвэрлэгдэж

байдаг. Цаашилбал үйлдвэрлэлийн дэглэм, нийгэм эдийн засгийн тэгш бус байдлын загвар, нийгмийн баримжаат төрийн дэглэмүүд ба улс төрийн намууд дахь улс төрийн актёрууд ба сонирхлын бүлгүүдийн хэв шинжүүдийн адил төсөөтэй талуудыг илүү тодорхой болгож өгдөг.

Байгууллагууд ба тэдгээрийн холимог бүтцүүд

Хөдөлмөрийн зах зээлийн системүүд, компаниудын зохион байгуулалт ба санхүүжилт, нийгмийн баримжаат төрийн бүтцүүдийн байгууллагууд хоорондын харилцааны сүлжээ нь зохицуулалтгүй зах зээлүүдийн эерэг талуудыг ашиглах нөгөө талаар тэдгээрийн сөрөг талуудыг зохистой нийгмийн хамгааллын системүүдээр засаж залруулах нөхцөлүүдийг тодорхой болгож өгдөг. Жишээлбэл Данид ажилтнуудыг ажлаас халагдахаас хамгаалах хамгаалалтыг сулруулснаар АНУ болон Их Британийн хөдөлмөрийн зах зээлүүдээс илүү уян хатан хөдөлмөрийн зах зээлтэй болсон байна. Ингэснээр Данийн компаниуд ажиллах хүчнээ уян хатан нэмэгдүүлэх эсвэл бууруулах боломжтой болжээ. Харин үүнээс үүдэлтэй ажиллах хүчний баталгаатай бус байдлыг олон улсын дунджаас дээгүүр хэмжээний ажилгүйдлийн мөнгө олгох, дахин хөдөлмөр эрхлэх боломжийг нь хангахын тулд хөдөлмөр эрхлэлтийн идэвхтэй бодлого явуулах, болон нийгмийн зүгээс үзүүлэх туслалцааны олон хэлбэрүүдийг нэвтрүүлэн тодорхой хэмжээгээр тогтворжуулсан байна. Бага цалинтай сектор нь өргөн хүрээтэй, зохицуулалтгүй хөдөлмөрийн зах зээл дээр суурилсан үйлдвэрлэлийн дэглэмүүдтэй оронд нийгмийн хамгааллын систем нь сул хөгжсөн бол нийгмийн ноцтой асуудлуудыг үүсгэдэг. Эдгээр нийгмийн хүсээгүй ур дагавруудад ажилтнууд хөдөлмөр эрхэлсээр атал ядууралд өртөх, нийгмийн тэгш бус байдал зэрэг багтдаг бөгөөд үүгээр ч зогсохгүй нийгмийн задралын ноцтой хэлбэрүүд бий болдог. Энэ үзэгдэл АНУ-ын жишээн дээр маш тодорхой харагддаг. 1993 онд 1.339.695 хүн шоронд сууж байсан нь 100.000 оршин

суугч тутмаас 519 хүн ял эдэлж байжээ гэсэн үг. Герман улсад тухайн онд 100.000 оршин суугч тутмаас 80 хүн шоронд ял эдэлж байжээ. Врасе Вестерн, Катерина Векет нар Европт шоронд ял эдлэгч эрэгтэйчүүдийн дунд ажилгүй эрчүүдийн эзлэх хувь нэгийг харьцах 20 - 50 хүний хооронд байдаг бол АНУ -д гурван ялтан тутмын нэг нь ажилгүй хүн байдаг гэдгийг тогтоожээ. Нийт шоронд ял эдлэгчдийн тоог хөдөлмөрийн зах зээлд оруулан тооцвол 1976 - 1994 оны хооронд 15 - 19 насны бүлгийн хөдөлмөр эрхлэгсдийн квот АНУ-аас давж байжээ. Энэ тооцоо 1995 онд албан ёсны ажилгүйдлийн квот Германд 7.1%, АНУ-д 7.5% байсныг харуулж байна. Харин дээрх хоёр улсад шоронд ял эдлэгчдийн тоог харгалзан үзэх юм бол ажилгүйдлийн квот Германд 7.4%, АНУ-д 7.5% болон нэмэгдэх байжээ. Системийн харьцуулалтыг илүү өргөн хүрээнд хийвэл бодит хэв шинжүүдийн түгээмэл үндсэн эрхүүдийн хэрэгжилтэд үзүүлэх нөлөө илүү бодитой харагдана.

Холимог харилцааны онцлог шинжүүд

Эдийн засагт шаардлагатай ерөнхий нөхцөлүүдийг бүрдүүлэх тухай улс төрийн шийдвэр гарсан, иргэдийн нийгмийн эрхүүд нийгмийн баримжаат төрийн түгээмэл дэглэмүүд ба шийдвэр гаргалтад оролцох талуудын оролцоогоор баталгаажсан, эдийн засагт улс төрийн давуу эрх зарчмын хувьд хөрөнгө оруулалтын эрх хэлбэрээр бодлогын ерөнхий зарчим хэмээн хүлээн зөвшөөрөгдсөн тун тааламжтай нөхцөлд ч гэсэн улс төрийн эдийн засгийн байгууллагуудын бүтцийн сонголт нь тухайн тодорхой нөхцөлд тохируулан нийгмийн сайн сайхны төлөөх капитализмын хувилбаруудаас прагматикаар сонгох сонголт юм. Тухайн холимог харилцаануудаас алийг нь сонгох тухай улс төрийн шийдвэрт нийгмийн ардчиллын зүгээс хоёр үндсэн үзүүлэлтүүдийг түлхүү анхаарах хэрэгтэй. Үүнд:

Нэгдүгээрт: Улс орнуудын бодит туршлага дээр үндэслэсэн эдийн засгийн биелэгдэх боломж бүхий зорилтуудыг дотоодын

нийт бүтээгдэхүүн, байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэхгүй байдлаар хүрч болох эдийн засгийн өсөлт талаас нь судлах

Хоёрдугаарт: Хэв шинжүүдийн онцлог давуу талууд болох хөдөлмөр эрхлэлтийн коэффициент өндөр, ажлын байрны баталгаат байдал, тасралтгүй байдал, бүтээмж, техник технологийн дэвшилд суурилсан эдийн засгийн шинэчлэлт зэргийг онцгойлон дэмжсэн улс төрийн хууль ёсны шийдвэрүүд гарсан эсэх

Нийгмийн баримжаат зах зээлүүд даяаршлын эрин үед
Даяаршил нь капитализмын хэв шинжүүдийг хооронд нь ойртуулж үндсэн эрхүүд дээр суурилсан нийгмийн баримжаат төргүй либерал загвар луу шилжихээс өөр аргагүй байдалд хүргэнэ гэдэг таамаглал үндэслэлгүй юм. Скандинавын орнууд болон европын зарим улсуудын амжилтууд дээрх таамаглалыг үгүйсгэж байгаа юм.

Зах зээлийн зохицуулалтыг хариуцсан байгууллагуудтай орнуудын актёрууд тэдгээр бүтцийг бас ашигладаг чиг хандлага ажиглагдаж байна. Хэдийгээр сүүлийн хориод жилийн дотор зохицуулалттай зах зээлийн бүтцүүд болон механизмууд шинэ нөхцөл байдалд дасан зохицохын тулд өөрчлөгдсөн ч дээрх улсуудын улс төр ба нийгмийн актёрууд дээрх байгууллагуудын зохицуулалт, тэнцвэржүүлэлт, мэдээлэлд итгэл үзүүлсэн хэвээр байна. Даяаршлын зах зээлийн шинэ нөхцөл байдалд дасан зохицохын тулд зохицуулалтгүй зах зээлүүд ямар учраас хөдөлмөрийн харилцааг эрс уян хатан, зохицуулалтгүй болгох, нийгмийн хамгааллын системээ задлах хэлбэрийг сонгож байгаа, харин зохицуулалттай зах зээлүүд ямар учраас зохион байгуулалттай дасан зохицох стратегийг сонгож байгаагийн нэгэн шалтгаан юм.

Шинэ либерал үзлийг баримтлагчид зохицуулалтгүй зах зээлүүд даяаршлын улмаас явагдаж буй санхүү болон

бүтээгдэхүүний зах зээлүүдийн нэгдэлд илүү хурдацтай хариу үйлдэл үзүүлж дасан зохицох чадвар сайтай хэмээн нотолдог боловч сүүлийн үеийн туршлага зохицуулалттай зах зээлүүд дунд болон урт хугацаанд илүү өөрийгөө хамгаалах чадвар сайтай гэдгийг харуулж байна. Бага цалинтай секторууд нь илүү өргөн хүрээтэй, нийгмийн баримжаат төр нь сул хөгжсөн, татварын хувь хэмжээ доогуур үйлдвэрлэлийн дэглэмтэй орнууд даяаршлын өрсөлдөөнийг нийгмийн хамгаалал ба зах зээлийн зохицуулалтыг хурдацтай задлах замаар даван туулах боломжтой. Харин зохицуулалттай зах зээлүүд адилхан сорилтууд тулгарахад өндөр мэргэшсэн нийгмийн хувьд баталгаатай ажиллах хүчиндээ тулгуурлан өндөр үнэтэй, тусгай бүтээгдэхүүнүүдийн зах зээлд орон зай эзлэх замаар амжилттай даван туулах бололцоотой. Харин бага цалинтай, мэргэжлийн ур чадвар тааруухан ажиллах хүчнийхээ нийгмийн асуудлуудыг цалинг орлох нэмэлт тэтгэлэг тусламжуудыг олгох замаар шийдвэрлэх бололцоотой.

Улс төрийн давуу эрх

Өөр өөр нийгэм, эдийн засаг, улс төрийн зорилтуудтай, олон хэлбэрийн нийгмийн сайн сайхны төлөө капиталист ардчилал оршин байдаг нь бодит үнэн юм. Нийгмийн ардчиллын улс төрийн эдийн засагт зах зээлийн эдийн засгийн олон хэлбэр хэрхэн хөгжиж ирсэн, ямар учир шалтгаануудын улмаас хэрхэн өөрчлөгдсөн, юуны өмнө нийгмийн ардчиллын хэм хэмжээнүүдийг ямар хэлбэрээр, хэр хэмжээнд төрөл бүрийн зах зээлийн байгууллагуудын бүтцийн тухайн хувилбарт тусгаж болох бэ? гэдэг асуудал илүү чухал юм. «Капитализмын хэв шинжүүдийн судалгаа»-гаар нээлттэй зах зээлүүдийн нөхцөлд ч улс төрийн эдийн засгийн зохицуулалттай зах зээл ба үндсэн эрхүүд дээр суурилсан нийгмийн баримжаат төрийн хосолсон загвар нь түүний бүтцүүд өөрчлөгдөж буй нөхцөлд дасан зохицож чадсан нөхцөлд оршин тогтнох чадвартай гэдгийг харуулж байгаа юм. Зах зээлүүдийн хүрээлэл, зохицуулалт

болон түгээмэл нийгмийн баримжаат улсууд даяаршлын нөхцөлд ч нийгмийн ардчиллын амжилтад хүрэх найдвар бүхий төсөл хэвээр байх болно. Нийгмийн баримжаат төрийн харьцуулсан судалгаа нь бүтцийн ямар нөхцөлүүдийн тусламжтайгаар нийгмийн баримжаат улсуудыг тогтвортой, амжилттай зохицуулалт хийх боломжтой бэ? эдийн засгийн динамикийг дээшлүүлэхэд ямар хувь нэмэр оруулах чадамжтай байх бэ? гэдэг асуудлаар чухал зааварчилгааг өгдөг.

Эдийн засгийг улс төрөөс зохицуулах шаардлага 1990 -ээд оноос нийгэм, улс төрийн ерөнхий хөгжлийн дараах гурван хандлагын улмаас ихээхэн нэмэгдсэн байна: Нэг талаас өмнө нь төрийн гүйцэтгэж байсан, төр хариуцаж байсан үйлдвэрлэл ба үйлчилгээнүүдийг илүү өргөн хүрээнд хувьчилсан, хоёрдугаарт зах зээлүүдийн үндэстэн дамнасан нэгдэл эрчимжиж энэ нь нэг талаас зах зээлийн нөлөөгөөр үүссэн гадаад нөлөөллийн хүчин зүйлүүдийн хамрах хүрээ ба нөгөө талаас тэдгээрийг улс төрийн аргаар зохицуулах боломжуудын хоорондын ангальг улам бүр гүнзгийрүүлсэн, гуравдугаарт зохицуулалтгүй эдийн засгийн өсөлтийн улмаас гарсан урьдчилан тооцох боломжгүй иргэншил ба байгаль орчны эрсдэлүүд улам бүр нэмэгдэж буй зэрэг болно. 1970 - 1980-аад оны үед олон салбаруудад зохицуулалтыг үгүй болгосон ч энэ хооронд үүссэн асуудлуудыг тухайн асуудалд тохирсон дахин зохицуулалтуудаар шийдвэрлэсэн байна. Хөгжлийн дээрх хандлагын улмаас зохицуулалтын бодлогыг өрсөлдөөний нөхцөлүүдийг хангах хүрээнд хязгаарлах гэсэн либертар байр суурийг баримтлагчид хамгаалалтын байдалд шилжээд байна. Нийгмийн ардчиллын улс төрийн эдийн засгийн зайлшгүй шийдвэрлэх асуудлуудын нэг нь зохицуулалттай эдийн засгийн нийтлэг шинэ үндэслэлүүдийг гаргаж тавих асуудал юм. Энэ нь тухайн орнууд болон олон улсын тавцан дээр үүсээд байгаа бэрхшээлтэй асуудлуудын агуулга, бүтцийн шинжилгээн дээр хийгдэх учраас төдийлөн хүндрэлтэй бус асуудал юм. Үүний

тулд зохицуулалтын бодлогын хэрэгслүүдийг тодорхойлох, тэдгээрийг хэрэглэх зорилтуудын тухай улс төрийн шийдвэр гаргуулах, шаардагдах улс төрийн хүсэл зоригийг даяаршлын тавцан дээр зохион байгуулах шаардлагатай.

4.12 Үйл ажиллагааны хэтийн чиг хандлагууд Нийгмийн баримжаат төр

Туршлага ба чиг хандлага

Эдийн засгийн өндөр хөгжилтэй орнуудын түгээмэл үндсэн эрхүүдийг хангахыг зорьж байгаа бүх нийгмийн баримжаат төрүүдэд нээлттэй зах зээлийн нөхцөлд шинэ хэлбэрийн ноцтой асуудлууд тулгараад байна. Тухайн орнуудын засгийн газрууд энэхүү дарамтаас ангижрахыг хүсэвч тогтвортой байдал, нийгмийн нэгдэл, иргэдийн оролцооны бэлэн байдал, тэдний нийгмийн тогтвортой байдлыг хангах чадвар, улс төрийн үйл ажиллагааны системийн улс төрийн хууль ёсны байдал зэрэгт аюул учруулах ноцтой үр дагаврыг авчирч болзошгүй эрсдэлүүдийн дарамт саад учруулж байна.

Нийгмийн сайн сайхны төлөө либерал улсууд нийгмийн хамгааллын хүрсэн түвшинг бууруулах, нийгмийн хамгааллын зардлуудыг хувийн секторт үүрүүлэх замаар эдийн засгийн хувьд амьдрах чадвартай боловч нийгмийн тэгш бус байдал, ядуурлаас улбаатай олон шийдвэрлэгдээгүй асуудлууд тэдгээрийн норматив хууль ёсны байдлыг ганхуулж байна.

Нийгмийн сайн сайхны төлөөх социал демократ улсууд нийгмийн хамгааллын түвшинг бууруулах, шимтгэл төлснийхөө хэрээр нийгмийн хамгааллын үйлчилгээг хүртэх өөрийн хариуцлагын зарчмыг түлхүү баримтлах замаар илүү тогтвортой зохион байгуулагдсан байдаг. Мөн үйлчилгээний салбарын төсвийн байгууллагуудад ажиллагсад татварын өндөр хувь хэмжээг хүлээн зөвшөөрдөг, эдийн засагт ээлтэй татварын

хосолмол систем чухал үүрэг гүйцэтгэдэг. Тухайн улсуудын иргэд татварын өндөр хувь хэмжээг хүлээн зөвшөөрсөн хэвээр байх нөхцөлд гагцхүү хөдөлмөрийн насны бүх иргэдийг ажлаар хангах зорилт мэргэжлийн ур чадвар төдийлөн шаардахгүй үйлчилгээний салбарт хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, орлогын доод шатлалд багтах цалингийн хэмжээ ихээхэн доогуур байдаг нь бэрхшээлтэй асуудал үүсгэдэг. Энэхүү бэрхшээл нь тухайн орнуудын уламжлалт үндсэн үнэлэмж болох нийгэм, улс төрийн эрхүүдийн тэгш байдлыг хангах зарчимтай зөрчилддөг учраас улс төрийн зүгээс саад бэрхшээлтэй тулгардаг.

Европ тивийн нийгмийн сайн сайхны төлөөх консерватив улсуудад олон шийдвэрлэгдээгүй асуудлууд тулгараад байна. Эдгээрт эдийн засаг ба хөдөлмөр эрхлэлтэд ээлгүй татварын бүтэц, нийгмийн хамгааллын системүүдийн санхүүжилт төдийлөн тогтвортой бус, ажлын байруудыг эзэмшигчдийн хамгаалалт их өндөр зэрэг асуудлууд хамаарна.

Бүх нийгмийн баримжаат төрүүд удаан хугацааны туршид нээлттэй зах зээлүүдийн зүгээс ирж буй дарамт, хүн ам зүйн бүтцэд гарч буй өөрчлөлтүүд хэмээх хосолсон дарамтад оршиж төрийн санхүүжилтийн үндсээ хамгаалахын тулд хөдөлмөрийн насны бүх иргэдийг ажилтай байлгах зорилтоо хэрэгжүүлэхийг зорьж байна. Бүхнийг ажлын байраар хангах нь нийгмийн ардчиллын норматив үндсэн зорилтуудын нэг төдийгүй нийгмийн баримжаат төрийн санхүүгийн тогтвортой байдлыг хангах хамгийн чухал үндсэн нөхцөл мөн.

Нийгмийн ардчиллын төсөлд нийгмийн баримжаат төрийн либералчлалыг нэмэгдүүлэх, нээлттэй зах зээлийн зоргоор цалинг бууруулахыг хориглодог тул нийгмийн баримжаат төрийн тогтвортой байдлыг хангах тал дээр учирч буй асуудлуудыг шийдвэрлэхдээ өөрийн хууль ёсны байх

нөхцөлүүдийн нормативуудыг хэвээр хадгалахын тулд хөгжлөөрөө түрүүлж яваа улс орнуудад амжилттай хэрэгжиж батлагдсан стратегиудыг хэрэгжүүлэхийг чухалчилдаг.

Нэгдүгээрт: Нийгмийн баримжаат төрийг орлогын татвараар санхүүжүүлэх нь нээлттэй зах зээлүүд дээр цалингийн хэмжээнээс хамааран хэмжээг нь тогтоох шимтгэлээр санхүүжүүлэхээс илүү тохиромжтой гэдгийг харуулж байна. Цалингийн нэмэлт зардлыг улам нэмэгдүүлдэг нийгмийн даатгалын шимтгэлүүд нь нэг талаас хөдөлмөрийн зах зээл, нэн ялангуяа бүтээмж болон орлого багатай салбаруудад ноцтой хүндрэлүүдийг үүсгэдэг бөгөөд энэ нь нэн ялангуяа нийгмийн баримжаат төрийн үйлчилгээ хамгийн өндөр байхыг шаарддаг хямралын үед төрийн санхүүгийн үндсийг удаан хугацаагаар ганхуулахад хүргэдэг. Нийгмийн баримжаат төрийн санхүүжилтэд нэн ялангуяа хүн ам зүйн бүтцийн өөрчлөлт ноцтой хүндрэл учруулж гэр бүл болон хөдөлмөр эрхлэлтэд эрэгтэй, эмэгтэйчүүдийн гүйцэтгэх үүрэг өөрчлөгдөж хөдөлмөр эрхлэх хүсэлтэй хүмүүсийн тоо нэмэгдсэнээс үүдэлтэй хөдөлмөрийн зах зээлийн нэмэлт ачааллыг даах чадваргүй байна.

Хоёрдугаарт: Улс орнуудын харьцуулсан судалгаагаар төсвөөс санхүүжих зохих хэмжээний үндсэн тэтгэвэр тогтоох нь нээлттэй зах зээлийн нөхцөлд ч санхүүжилт нь баталгаатай, хөдөлмөрийн зах зээлд сөрөг нөлөө үзүүлдэггүй өндөр насны баталгааг хангахтай холбоотой асуудлыг шийдвэрлэх арга зам гэдэг нь харагдаж байна. Уг арга зам нь түгээмэл шударга ёсны стандартуудыг хангах үндэс бөгөөд нэгэн цагт олж байсан орлогын түвшинг үлдсэн бүх хугацаанд амьдралынх нь бүхий л үеийг хамруулан баталгаажуулах нь нийгмийн баримжаат төрийн үүрэг мөн үү? гэдэг нь бас авч үзүүштэй асуудал юм. Нөгөө талаас үндсэн тэтгэвэр тогтоох нь нийгмийн үе бүхэнд шударга гэж үнэлэгдэж чадах уу?, Үеүд хоорондын хуваарилалтын зөрчлийг зөвхөн энэ аргаар шийдвэрлэж болох уу? зэрэг асуудлуудыг мөн харгалзан үзэх ёстой.

Гуравдугаарт: Орлогын эх үүсвэрээ олох нийгмийн хөдөлмөрөөр бүх иргэдийг хангах нь шударга ёсны зарчмын тэгш байдлын хамгийн чухал хэм хэмжээний илэрхийлэл тул хөдөлмөрийн зах зээлийг идэвхжүүлэх, мэргэжил дээшлүүлэх хөтөлбөрүүд болон хөдөлмөр эрхлэх идэвх санаачилгыг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн нийгмийн тусламжуудыг зохион байгуулах нь шилжилтийн мөнгөн тэтгэлэгүүд ба тухайн хүний статусыг хамгаалах арга хэмжээнүүдээс илүү ач холбогдолтой. «Making Work - Pay» «бүтээх - хөдөлмөр - хөлс төлөх» нормын дагуу хэрэгжиж буй бүх төслүүд нь ажлын байрууд хөдөлмөрлөх зохистой нөхцөлүүдийг хангаж буй нөхцөлд онцгой арга хэлбэрээр хуульчлагдсан мэт харагддаг. Учир нь орлогын эх үүсвэрээ бүрдүүлэх нийгмийн хөдөлмөр эрхлэлтэд оролцох оролцоо нь хөдөлмөр эрхэлж буй хүмүүсийг нийгмийн амьдралын бусад олон харилцаанд оролцох оролцоогоо хангахад чадваржуулдаг бөгөөд нөгөө талаар хөдөлмөр эрхлэлтэд өөрсдийн эзэлсэн байр сууриа хамгаалах, сайжруулах хамгийн сайн баталгаа нь болдог.

Дөрөвдүгээрт: Аль болох хөдөлмөр эрхлэлтэд ээлтэй ажлаас халагдахаас хамгаалах хэлбэрүүдийг нэвтрүүлснээр хөдөлмөрийн зах зээл дээрх алагчлахыг арилгах, орлогын эх үүсвэрээ бүрдүүлэх хөдөлмөр эрхлэлтийн төрөл бүрийн категориудын стандартуудыг хооронд нь ойртуулах нь, шударга ёсны нөхцөлүүд болон хөдөлмөр эрхлэлтийн зорилтууд талаас нь авч үзвэл хууль ёсны шаардлагууд юм. Эдгээр шаардлагууд нь хөдөлмөр эрхэлж буй хүмүүст хуулиар заасан тодорхой хугацааны туршид амьдралын стандартаа хэвээр хадгалах, ажилгүйдэлд өртсөн тохиолдолд дахин хөдөлмөр эрхлэхэд нь аль болох дээд зэргийн дэмжлэг үзүүлэх баталгааг хангадаг тул ажилгүйдлээс хамгаалах урьдчилсан нөхцөлийг бүрдүүлж өгдөг.

Тавдугаарт: Мэдлэгт суурилсан эдийн засгийн «Outsourcing», «Freelancing» болон хагас өдрөөр ажиллах зарчмууд

нэвтэрсэнтэй холбоотой бий болсон шинэ хэлбэрийн ажлын байрууд болон хөдөлмөрийн уламжлалт хэвийн харилцаануудын нийгмийн хамгааллын бүх төрлүүдийг, мөн өндөр насны хамгааллыг ижил түвшинд бүрдүүлэх нь хөдөлмөр эрхлэлтийн нөөцийг бүрэн дүүрэн ашиглах чухал үндсэн нөхцөл юм. Энэ нь нөгөө талаар хөдөлмөрийн насны бүх хүмүүсийг ажлын байраар хангах зорилтын хэрэгжилтэд дэм үзүүлж нийгмийн бүтцийн эрсдэлүүд тулгарсан тохиолдолд бүх хүнд тэнцүү хэмжээний хамгаалалтын доод түвшнийг хангах зохих нөхцөлүүдийг бүрдүүлдэг.

Зургаадугаарт: Өндөр хөгжсөн үйлчилгээний эдийн засагтай нийгмийн баримжаатулсуудын хувьд өгөгдсөн нөхцөл байдлын дунд нийгмийн хамгааллын системийг гэр бүл - хүүхдүүдийн сайн сайхны төлөө үндсээр нь шинэчлэх нь нийгмийн ардчиллын сонгодог нөхцөлүүдийг бүрдүүлэх шалгарсан арга юм. Нийгмийн хамгааллын системийг шинэчлэхдээ эдийн засгийн хөгжилд бүтээлч хувь нэмэр оруулах шударга ёсыг дэмжин дэлгэрүүлэх чадамжтай тогтвортой байхаар зохион байгуулах ёстой.

Нийгмийн баримжаат төрийн тогтвортой шинэчлэлийн эдийн засгийн хөгжлийг дэмжих төвүүд нь дотооддоо гэр бүл төвтэй болон боловсрол төвтэй шинэчлэлийн стратегиудтай нягт холбоотой байдаг. Тэдгээрийн элементүүд нь:

Нэгдүгээрт: Сургуулийн өмнөх насны хүүхдүүдийг аль болох багаас нь бүтэн өдрийн ясли цэцэрлэгээр хүмүүжүүлэх иргэдийн эрхийг хангах, тэдгээрийн санхүүжилтэд орлогын хэмжээнээс хамаарсан шатлалаар шимтгэл хураах замаар дэмжлэг үзүүлэх

Хоёрдугаарт: Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийн коэффициентийг дээшлүүлэх

Гуравдугаарт: Эцэг эхийн нийгмийн статус буюу гарал үүсэл хүүхдэд өвлөгдөх байдлыг халснаар амьдралын боломжоор тэгш хангах зарчмын хэрэгжилтийг эрс дээшлүүлэх

Дөрөвдүгээрт: Төрөлтийн коэффициентийг эрс дээшлүүлэх Энэ замаар нийгмийн байгууллагуудыг хэвээр хадгалан хүйсийн тэгш байдлыг хангах, нийгмийн баримжаат төрийн санхүүжилтийг тогтвортой байлгах, улс төрийн хоёрдох боломжийг нээх үндсийг тавих нөхцөлүүд бүрдэх юм. Боловсролын суурийг аль болох бага насанд нь тавих нь хожим дахин суралцахад бэлэн байх чадавхыг суулгах хамгийн найдвартай баталгаа юм. Бүх нийтэд нээлттэй бүтэн өдрийн дунд сургуулиуд нийгмийн баримжаат төрийн бүтцийн чухал тулгуур мөн.

Нийгмийн ардчиллын нийгмийн баримжаат төрийг түүний нормативын үндсүүд болон санхүүжилтийн үндсүүдийн тогтвортой байдал, эдийн засгийн үүргээ гүйцэтгэх чадавх талаас нь авч үзвэл дараах нөхцөлүүдийг хангасан тохиолдолд баталгаат байдал нь хангагдсан гэж үздэг:

Нэгдүгээрт: Бүх иргэд ямар ч эрсдэл тохиолдсон үед амьжиргааны зохих түвшнээр хангуулах үндсэн эрхээр хангагдсан байх ёстой. Гэхдээ иргэдийн хувийн хариуцлага анхдагч нь байх ёстой.

Хоёрдугаарт: Нийгмийн бүтцийн эрсдэл учирсан үед эрсдэлд учирсан хүмүүсийн үндсэн эрхүүдийг зохих хугацаанд, зохих хэмжээнд тэдний эрсдэлд орохоос өмнөх үеэс дордуулахгүй түвшинд хангаж өгөх ёстой. Цаг хугацаа нь тодорхой хязгаартай байна.

Гуравдугаарт: Удаан хугацааны туршид, ямар ч тохиолдолд амьдралын төлөвлөгөөнд урьдчилан тусгах боломж бүхий

хугацааны доторх эрсдэлд орсон нөхцөлд шударга ёс ба нийгмийн үндсэн эрхүүдийн систем талаас нь авч үзвэл үндсэн баталгааны ижил түвшинг төрөөс баталгаажуулж өгөх нь хангалттай бөгөөд түүнээс давсан эрсдэлийн хамгаалалтыг хувь хүмүүст даатган орхих нь зүйтэй.

Дөрөвдүгээрт: Нийгмийн баримжаат төрийн хамгаалалтын системүүд ямар түвшинд байх бэ? дээрх шаардлагуудаас хэр хэмжээнд илүү байх бэ? гэдгийг тухайн нийгэмд оршин байгаа шударга ёсны тухай ойлголтуудын хэмжээнд тогтоодог. Гэхдээ уг давсан түвшнүүд шударга ёсны түгээмэл зарчмууд болон үндсэн эрхүүдээс заавал биелэгдэх шаардлага болон тавигдахгүй.

Тавдугаарт: Европын нийгмийн баримжаат улсуудын туршлага түүний дотор 1990-ээд оны Голландын, зуун солигдсоны дараагийн эхний жилүүдийн Германы туршлага нийгмийн баримжаат төрийн хөгжлийн замын бүтцийн хамаарал үнэмлэхүй бус харин улс төрийн хувьд харьцуулагдах боломж бүхий хэмжигдэхүүн гэдгийг харуулж байна. Гадаад болон дотоод хүчин зүйлүүдийн улмаас үүссэн хямралын дарамтууд маш хүчтэй ашиг сонирхол дээр тулгуурласан нийгмийн баримжаат төрийн бүтэцтэй улсуудад ч гэсэн бусад орнуудад амжилтад хүрсэн загваруудыг дуурайсан гүнзгий шинэчлэлүүдийг хэрэгжүүлэх чадвартай байдаг гэдгийг харуулсан.

Эдийн засаг

Өнөөг хүртэл хуримтлагдсан туршлагыг онолын талаас нь тайлбарлавал нээлттэй зах зээлүүдийн зүгээс ирэх дарамтын улмаас улс төр эдийн засгийн дэглэмүүд либерал зах зээлийн загварт ойртоно гэсэн хүлээлт үр дүнгүй гэдгийг харууллаа. Харин улс төрийн эдийн засгийн төрөл бүрийн загварууд хөгжлийнхөө явцад өөрсдийн дотоод бүтцийн байгууллагуудынхаа давуу талууд дээр суурилан өөртөө

хамгийн ашигтай стратегийг боловсруулан нээлттэй зах зээл дээр орон зайгаа эзэлж чаддаг гэдгийг харуулж байна. Нийгмийн ардчиллын шаардлагуудыг хамгийн сайн биелүүлж чадах зохицуулалттай зах зээл ба үндсэн эрхүүд дээр суурилсан нийгмийн баримжаат төрийн хосолсон загвар нь даяаршлын нөхцөлд дасан зохицох нэлээд хэдэн нөхцөлүүдийг хангаж чадсан тохиолдолд оршин тогтнох чадвартай төдийгүй эдийн засгийн хувьд өндөр бүтээмжтэй, өрсөлдөх чадвартай, улс төрийн хувьд амжилттай байж чадна гэдгийгээ нотлон харуулж байна. Дээрх хувилбар нийгмийн ардчиллын үндсэн нормативын шаардлагуудыг хамгийн сайн хангаж чаддаг:

Нэгдүгээрт: Уг загвар макро эдийн засгийн түвшин болон цалин хөлс - хөдөлмөрийн нөхцөлүүдийг тогтоох түвшний шийдвэр гаргалтуудыг хооронд нь уялдуулан зохицуулах боломжуудыг бүрдүүлдэг. Мөн компаниудын түвшний шийдвэр гаргалтад нийгмийн ашиг сонирхлын өргөн хүрээтэй оролцоог эдийн засгийн функцэд саад тотгор учруулахгүйгээр тусгах бололцоог хангадаг.

Хоёрдугаарт: Уг загвар нь үндсэн эрхүүд дээр суурилсан нийгмийн баримжаат төрийн системүүд, эдийн засгийн бүтээмжийн системүүдийг харилцан бие биенээ тогтворжуулах байдлаар нэгтгэж ингэснээрээ үндсэн эрхүүдийн хэрэгжилтийг ойролцоогоор ижил түвшинд хүргэдэг.

Гуравдугаарт: Уг загвар нь бусад загваруудтай харьцуулахад үндсэн эрхүүдийг харьцангуй ижил түвшинд хангадаг, хууль ёсны бус тэгш бус байдлыг харьцангуй бага бий болгодог тул тухайн нийгэмдээ нийгмийн болон улс төрийн нэгдлийг илүү сайн хангадаг.

Улс орнуудын харьцуулалтын судалгааны хүрээнд амжилтад хүргэх нь туршлагаар батлагдсан хэд хэдэн дасан зохицох стратегиуд байдаг:

Нэгдүгээрт: Судалгаа, эдийн засгийн шинэчлэл, боловсролын бодлогын үр өгөөжтэй стратегиудыг хэрэгжүүлсний үр дүнд анхаарал татсан салбаруудад ажиллагсдын тоо буураагүй ч бас бараг нэмэгдээгүй байна.

Хоёрдугаарт: Ажиллагсдын тоог тусгайлан хамгаалагдсан үйлчилгээний салбарт л нэмэх боломжтой юм. Нийгмийн баримжаат төрийн хэв шинж, түүний санхүүжилтийн загвараас хамааран төсвийн салбарт ажиллагсдын тоог нэмэгдүүлэхэд харилцан адилгүй хувь нэмрийг оруулсан байна. Ямар ч тохиолдолд хувийн эдийн засгийн секторын шинээр ажлын байр бий болгох чадамж хөдөлмөрийн насны бүх иргэдийг ажлын байраар хангах зорилтыг хэрэгжүүлэхэд шийдвэрлэх үүрэгтэй байдаг. Дээрх зорилтыг хэрэгжүүлэхэд энэхүү номын нийгмийн баримжаат төр хэмээх бүлэгт заасан арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх шаардлагатай. Нийгмийн ардчиллын төсөлд боолын эдийн засаг хаалттай тул нийгэм болон төсвийн үйлчилгээний цар хүрээг нэмэгдүүлэхийг улс төрийн зүгээс дэмжиж хамгаалдаг.

Гуравдугаарт: Улс төр ба эдийн засгийн зохицуулалтын системүүдэд нээлттэй зах зээлийн нөхцөлүүдэд дасан зохицох тусгай хэлбэрүүд шаардлагатай байдаг. Хөрөнгийн нээлттэй зах зээл, орчин үеийн уян хатан шинэ технологи, аж үйлдвэржилт буурч байгаагийн улмаас цалин хөлс ба хөдөлмөрийн нөхцөлүүдийг хооронд нь холбох илүү уян хатан хэлбэрүүдийг нэвтрүүлэх шаардлага тулгарч байна. Хамтын ажиллагааны бүтцийн төвлөрлийг сааруулах тэдгээрийг компаниудын онцлогт тохирсон шийдвэрүүдэд илүү нээлттэй болгох шаардлага илүү ач холбогдолтой болж байна.

Дөрөвдүгээрт: Хөдөлмөрийн зах зээлийн уян хатан байдлыг хангах бодлого, ажиллах хүчний мэргэжил мэдлэгийг өндөр түвшинд дээшлүүлэх, өөр мэргэжлээр мэргэшүүлэх, нийгмийн

баримжаат төрийн бүтцийг хөдөлмөр эрхлэх сонирхлыг нэмэгдүүлэхээр шинэчлэх зэрэг нь амжилтад хүргэх урьдчилсан нөхцөлүүд мөн.

Тавдугаарт: Туршлагаас харахад нийгмийн ардчилалд чиглэгдсэн уламжлалт бодлогын хувьд даван туулахад хэцүү босго бол татварын орлогын эх үүсвэрүүдийн татварын ачааллыг даах хязгаар тун хязгаарлагдмал өөрөөр хэлбэл татварыг өсгөх боломж маш бага байдаг явдал. Мөн энэ хязгаар эдийн засгийн хөгжлийн зарим ноцтой асуудлуудыг нээлттэй зах зээлийн нөхцөлд улс үндэстний түвшинд шаардлагад нийцэх хэмжээнд шийдвэрлэх боломжгүй, үндэстэн дамнасан зохицуулалтын системүүдтэй хүч хавсрах шаардлагатай гэдгийг харуулж байна. Татварын системийн хувьд Европын Холбооны бүс нутгийн түвшинд зохицох арга хэмжээ авч байгаа нь чухал алхам юм. Эдгээрээс давсан асуудлуудыг шийдвэрлэхэд удаан хугацаа шаардлагатай гэдэг нь харагдаж байна.

Зургаадугаарт: Нийгмийн ардчиллын улс төр, эдийн засгийн стратегийн хувьд улс үндэстний түвшинд болон бүс нутгийн түвшинд зорилгодоо хамгийн сайн хүрэх, ерөнхийдөө цаашдаа ч үр өгөөжтэй хэвээр байх дасан зохицох шинэчлэлийг хийхийн оронд даяаршлын нэгдсэн ерөнхий хүрээ тогтож дуусахыг хүлээвэл маш том стратегийн алдаа болно.

Нийгмийн хамгааллын систем нь орлогын татвараас санхүүждэг байх нөхцөлд бүх салбарт нийгмийн эрсдэлүүдээс хамгаалах тэгш үндсэн хамгаалалтыг бүрдүүлэх нь шударга хэрэг гэж олон нийт хүлээн авах болно. Энэ нь түгээмэл үндсэн эрхүүдийн хэрэгжилтийг тэгш хангаж нийгэм, улс төрийн тэгш байдлыг хангах шударга ёсны хэм хэмжээгээр хуульчлагдах боломжтой. Хамрагдах хүмүүс аль болох залуу үедээ хамгаалалтын энэхүү арга хэлбэр, түвшинг сайн мэддэг бол тэгш үндсэн хамгаалалтын иймэрхүү систем шударга

ёсны стандартуудыг хангадаг. Харин нийгэмд ажлын байр хангалттай байх ёстой. Энэ нөхцөлд хамрагдах хүмүүс ямар хэмжээнд, ямар арга хэлбэрээр нийгмийн баталгаажих доод түвшнээс хэр дээгүүр түвшинд даатгуулахаа өөрсдөө шийднэ. Иймэрхүү хэлбэрийн нийгмийн баримжаат төрийн стратеги нь эрхүүд ба хувь хүмүүсийн хувийн хариуцлагын хоорондын тэнцвэртэй харьцааны норматив шаардлагуудыг тухайн нийгмийн гишүүдийн нийгмийн баталгаажих доод түвшний зүгээс авч үзвэл хангадаг.

Нийгмийн ба бүтцийн эрсдэлүүдээс хамгаалах улс төрийн хариуцлагын тухай онолыг урьдчилан харах боломжгүй гэнэтийн эрсдэлийн улмаас ажлын байраа алдсан бол ажилгүй болсон иргэдэд ажил мэргэжлийн чиг хандлагаа өөрчлөх, амьдралаа өөрөөр төлөвлөхөд нь хангалттай хүрэлцэхүйц цаг хугацаанд эрсдэлд өртөхөөсөө өмнө олж байсан орлоготой нь харьцуулах хэмжээний цалинг орлох орлогыг хуулиар тогтоогдсон хугацаанд олгож байх тухай онолоор нэмж баяжуулах шаардлагатай. Хэр удаан хугацаанд цалинг орлох орлогыг олгох, цалингийн ямар хувь хэмжээгээр олгох бэ? гэдгийг тухайн тодорхой нөхцөлийн нийгэм ба соёлын харилцаануудыг харгалзан үзсэний үндсэн дээр тухай бүр шийднэ.

Тухайн нийгмийн улс төр - нийгмийн соёлд агуулагдан байх нийгмийн шударга ёсны стандартууд нь үндсэн хамгаалалтын доод хэмжээнүүдээс хол дээгүүр, цалингийн хэмжээнээс хамааран тогтоогдох цалинг орлох орлогын түвшинг нийгмийн хамгааллын системүүдээс олгодог байхаар тогтоож болно. Скандинавын орнуудад цалинг орлох орлогын хэмжээ нийгмийн хамгааллын тогтоосон доод хэмжээнээс байнга дээгүүр байсаар ирсэн. Шударга ёсны түгээмэл нотлогдсон хэм хэмжээ, түгээмэл үндсэн эрхүүдийн хэрэгжилт талаас нь авч үзвэл эрсдэлд өртсөн хүмүүсийн тухайн үеийн амьдралын түвшинг хамгаалахын тулд нийгмийн баталгаажих доод

түвшингээс дээгүүр баталгааг тодорхой хугацаагаар, тодорхой түвшинд хангах үүргийг төр хүлээх албагүй юм. Тэр ч байтугай хамрагдсан хүмүүсийн тухайн нэгэн үед хүрсэн амьдралын түвшинг хамгаалахын тулд олгож буй мөнгөн тэтгэлэг нь зөвхөн шимтгэлээс бус улсын төсвийн нэмэлт санхүүжилт авч буй тохиолдолд улс төрийн ба нийгмийн эрхүүдийг тэгш хангах тухай шударга ёсны ойлголтын хэм хэмжээнүүдийг зөрчиж байна, тэгш бус байдлыг дэмжиж байна гэж шүүмжлэлд өртөж болох талтай. Учир нь энэхүү зарчим нь хамрагдсан хүмүүсийн тухайн үеийн буюу нэгэн удаа хүрсэн түвшинг хамгаалж ингэснээрээ нийгмийн тэгш бус байдлыг нийгмийн баримжаат төрийн зүгээс нормчилж буй хэрэг юм. Гэхдээ тухайн нийгэмд нийгмийн эрсдэлүүдээс хамгаалах хэлбэрийн талаар нэгдсэн зөвшилцөлд хүрсэн тохиолдолд нийгмийн хамгааллын хүрсэн түвшнийг хуульчлах олон эерэг шалтгаан олдох нь ойлгомжтой.

Нээлттэй зах зээл, түүнтэй холбоотой эдийн засгийн зохицуулалтын системүүд болон нийгмийн баримжаат төрийн хэвшинжүүдийн өрсөлдөөн нь зах зээл ба нийгмийн баримжаат төрийн хосолмол хэлбэрийг бүхэлдээ өөрчлөгдөхийг шаардаж байгаа юм. Хөдөлмөрийн хөлсний хувь хэмжээгээр ногдуулах шимтгэлээс санхүүжих эсхүл татвараас санхүүжих аль ч хэлбэрийг сонгосон тохиолдолд нийгмийн хамгааллын орлогоос санхүүжих стратегийн хэрэгжих орон зай нь хязгаарлагдмал юм. Тухайн нийгэм дунджаас дээгүүр орлогын албан татвар төлөхөд байнга бэлэн байх нөхцөлд ямар нэгэн бэрхшээл үүсэхгүй. Харин уг бэлэн байдал үгүй болох нөхцөлд орлогын албан татвараар санхүүжих тогтолцоо нь хөдөлмөрийн зах зээлд сөрөг нөлөөтэй тул бүтцийн задралд хүргэж улмаар нийгмийн баримжаат төрийн тогтвортой зохион байгуулалтад саад учруулна. Тэгэхээр олон орны хувьд даяаршлын улмаас шинээр үүссэн нөхцөлүүд урт хугацааны туршид нийгмийн баталгаажих доод түвшнээс дээгүүр нийгмийн баталгааг хангах боломжийг хязгаарлах

шүүлтүүрийн үүргийг гүйцэтгэж байгаа юм. Энэхүү нээлттэй зах зээлийн улмаас буй болж байгаа хязгаарлагдмал нөхцөл нь дээр дурдсан нотолгоонуудын хүрээнд шударга ёсны түгээмэл зарчмууд болон түгээмэл үндсэн эрхүүдтэй нийцэж байгаа юм. Энэ нь эцсийн бүлэгтээ тухайн нийгмийн шударга ёсны бодлогын тухай мэтгэлцээний хүрээнд үндсэн эрхүүд болон шударга ёсны ерөнхий зарчмуудын дагуу нийгмийн баримжаат төрийн хамгааллын үйл ажиллагааны цар хүрээг хэрхэн тодорхойлсноос хамаарах асуудал юм.

Даяаршлын бодлого V

5.1 Нийгмийн ардчилал ба даяаршил Даяаршил улс төрийн эрсдэл болох нь

Даяаршил нь өндөр зэрэглэлийн цогц процесс бөгөөд маш олон төрлийн хоорондоо зөрчилдөөнтэй үр дагавруудыг дагуулж байдаг. Даяаршлын хөгжлийн хэтийн зорилтыг тодорхойлох боломж бүрдээгүй байна. Даяаршил өнөөг хүртэл улс үндэстнүүдийн түвшинд хэрэгжиж байсан зохицуулалтын системүүдэд ихэвчлэн сөрөг нөлөө үзүүлж олон нөхцөл шалтгаануудын улмаас дэлхий дахинд ардчилал, улс төр, нийгмийн үндсэн эрхүүдийн хэрэгжилтэд сөрөг нөлөө үзүүлж байна.

Нэгдүгээрт: Зах зээлүүд, байгаль орчны сүйрэл, цагаачлалын урсгал, зохион байгуулалттай гэмт хэргүүд, үй олон хэрэглэгчтэй цахим мэдээлэл зэрэг нь улам бүр улс үндэстнүүдийн хил хязгаараас хальж байхад ардчиллын үйл ажиллагааны хүрээ зөвхөн улс үндэстнүүдийн хил хязгаарт хязгаарлагдсан хэвээр байна. Ингэснээр улс орны иргэдийн эрх улам бүр нөлөөгөө алдаж ардчиллын зарчмууд ноцтойгоор зөрчигдөж улмаар ардчиллын үйл ажиллагааны чадамжийг сулруулж хууль ёсны байдалд аюул учруулж байна.

Хоёрдугаарт: Эдийн засгийн даяаршил өнөө үед улс үндэстнүүдийн хил хязгааруудыг үгүй болгоход хүчээ төвлөрүүлж байна. Ингэснээр даяаршил зах зээлүүдийн соёл, социал, экологи, нийгмийн хүрээллийн бүтцүүдийг үгүй болгож байна. Эдийн засгийн өндөр хөгжилтэй орнууд чухамхүү эдгээр бүтцүүдийн тусламжтайгаар капиталист зах зээлийг хазаарлаж хариуцлага ногдуулж байсан юм. Энэхүү бүтцийг үгүй болгосноор орчин үеийн ардчиллын суурийг ганхуулж байгаа юм.

Гуравдугаарт: Даяаршлын улмаас улам эрчимжиж буй зах зээлээр удирдуулсан шинэчлэл нь улс төр, нийгмийн үндсэн эрхүүдээс улам бүр холдож байна. Энэхүү хөгжлийн хүчнүүд нь хамрагдсан хүмүүс болон тэдгээрийн эрхийн өмнө хүлээх улс төрийн хяналт ба хариуцлагаас улам бүр холдож байна.

Дөрөвдүгээрт: Асуудал үүсэж буй хүрээ, асуудлын үйлчлэлийн хүрээ улам бүр үндэстэн дамнасан шинж чанартай болж тэдгээрийг хязгаарлах хэрэгсэл нэгэнт үгүй болсон тул хэдийгээр нэгдсэн зохицуулалтад шаардагдах хэрэгслүүдээ бүрдүүлж чадаагүй байгаа боловч олон үндэстнүүдийн улс төрийн нийгэмлэгүүдэд хүчээ нэгтгэх шаардлага тулгараад байна. Өнөөгийн байдлаар даяаршил зөвхөн сөрөг үр дагавартай байгаа бөгөөд энэ байдлаараа 1970-аад оноос хойш үндсэн эрхүүд ба ардчилалд шинэ хэлбэрийн эрсдэлүүдийг бий болгож байна. Үндэстэн дамнасан шинж чанартай эдийн засаг нийгмийн гаж хөгжлийн шалтгаануудыг арилгах, засварлахад улс төрийн нөлөөллийн боломжуудыг улам бүр хязгаарлаж байна. Улс үндэстнүүдийн бие даасан байдал тэдэнд үндэстэн дамнасан үйл ажиллагаа явуулах хэлбэр тогтоогүй байхад тэдний үйл ажиллагаа цар хүрээний хувьд улам бүр хумигдаж байна. Нийгэм, эдийн засаг, экологийн нэгдүгээр шатны эрсдэлүүдийн зэрэгцээ улс төрийн аргаар нөлөөлөх боломжгүй хоёрдугаар шатны эрсдэлүүд тулгарсаар байна.

Ардчилалд тулгарч буй шаардлагууд

Сөрөг даяаршил, ардчилал хоорондоо холбоотой боловч эрс ялгаатай дараах гурван шаардлагуудыг тулган тавьж байна:

Нэгдүгээрт: Норматив түвшинд ардчиллын үр өгөөжтэй шинэчлэлийн асуудал шийдэгдэх ёстой.

Хоёрдугаарт: Улс төрийн хувьд хэрэгжүүлэх боломжтой, тухайн тулгарч буй асуудлуудын шийдэлд тохирсон даяаршлын зохицуулалтын загваруудыг бий болгох шаардлагатай.

Гуравдугаарт: Хамгийн сайн загваруудыг алхам алхмаар хэрэгжүүлэх улс төрийн голлон тоглогч актёруудын холбоодыг зохион байгуулах шаардлагатай.

Даяаршил ба нийгмийн ардчилал

Даяаршлын эрин үе ардчиллыг мөн даяарчлахыг шаардаж байна. Ардчиллын даяаршилд дараах элементүүд хамаарна:

Нэгдүгээрт: Улс төрийн бүхий л асуудлуудыг даяаршлын түвшин дээр шийдвэрлэх боломжийг бүрдүүлэхийн тулд либерал ардчиллын шийдвэр гаргалт ба үйл ажиллагааны арга барилын үүргийн чадамжийг баталгаажуулах шаардлагатай.

Хоёрдугаарт: Улс үндэстнүүдийн түвшинд улс төрийн хүрээнд шийдвэрлэх боломжтой асуудлуудыг цаашид ч шийдвэрлэж байхын тулд ардчилсан шийдвэр гаргалтын бие даасан байдлыг хамгаалах шаардлагатай.

Гуравдугаарт: Нээлттэй зах зээлийн даяаршлын, социал, улс төрийн болон экологийн хүрээллийг бий болгох, өөрөөр хэлбэл хариуцлага ногдуулах

Дөрөвдүгээрт: Тухайн нийгэм тус бүрд дээр дурдсан

элементүүдийг хэрэгжүүлэх улс төрийн үйл ажиллагааны нөхцөлүүдийг бүрдүүлэх

Сөрөг даяаршил нь нийгэм улс төрийн бүх актёруудад өгөгдсөн «**Fact of life**» буюу амьдралын өгөгдөл биш юм. Сөрөг даяаршил нь өнөө үед бүрэн танигдаагүй байгаа ч маш өргөн хүрээнд зохион байгуулах боломжтой. Үүний тулд эхлээд ямар нормативын болон системийн логик, актёрын онолын нөхцөлүүдийн дор эерэг даяаршлыг зохион байгуулах боломжтой бэ? гэдгийг тодорхойлох шаардлагатай.

Дэлхийн иргэдийн эрхийн концепц нь норматив нөхцөлд хамаарна. Үндэстэн дамнасан хүрээнд ардчиллыг бэхжүүлэх бодит боломжуудын тухай асуудал системийн логикийн нөхцөлүүдэд хамаарна. Улс орнууд болон нийгмийн актёруудын олон талт ашиг сонирхлуудыг эерэг даяаршлын төлөө хэрхэн уялдуулан зохицуулах бэ? гэдэг асуудлын хариулт актёруудын онолын нөхцөлүүдэд хамаарна.

Хэдийгээр олон ялгаатай талууд байдаг боловч өргөн хүрээтэй актёруудын холбоодыг байгуулах үндэслэл болох даяаршлын нийтлэг ашиг сонирхлууд бий. Үүнд:

Нэгдүгээрт: Эерэг даяаршлыг зохион байгуулахгүй бол улс үндэстнүүдийн оршин тогтнох үндэс болсон экологийн тэнцвэрт байдалд өөрийгөө хөнөөх хэмжээний аюул нүүрлээд байна.

Хоёрдугаарт: Хүн төрөлхтний дийлэнх хэсгийн нийгмийн амьдралын нөхцөлүүд нийгмийн баталгаажих доод түвшинг баталгаажуулахгүй бол байнга хямралд өртөж болзошгүй байдалд байна.

Гуравдугаарт: Санхүүгийн зах зээлийн зохицуулалт хангалтгүй байгаа нь эдийн засгийн асар өргөн талбайг хамарсан түймэр

мэт аюул учирч болзошгүй нөхцөлийг байнга агуулж байна.

Эдгээр туршлагууд нь нийгмийн ардчиллыг даяарчлах төслийн гарааны нөхцөлүүд юм.

5.2 Даяаршлын иргэний нийгэм

Даяаршил ба үндсэн эрхүүд

Түгээмэл үндсэн эрхүүдийн хэрэгжилтийн асуудал яригдахад даяаршлын иргэдийн пассив буюу идэвхтэй бус статусын ойлголт гарч ирдэг. Үүгээр зогсохгүй даяаршил нь үндсэн эрхүүдийг хөндөх шийдвэр гаргалтад бүх хүмүүсийг оролцуулж байх даяаршлын иргэдийн идэвхтэй статусыг шаардаж байдаг.

Даяаршлын үед хүний үндсэн эрхүүд зөрчигдөх магадлал улам нэмэгддэг. Иргэд үндсэн эрхүүд нь зөрчигдөхөөс өөрсдийгөө хамгаалах боломжоор хангагдсан байх ёстой. Хүний үндсэн эрхүүд, амьдралын сонирхол өөр улс орнуудад явуулж буй үйл ажиллагаанаас хамааран зөрчигдөх боломж бүхий дэлхий дээр амьдарч байгаа нөхцөлд тэдгээрийг хамгаалах асуудал үйл ажиллагаагаа бусад голлон тоглогчдын үйл ажиллагаатай уялдуулах хүмүүсийн чадвараас хамаардаг. Үүний тулд хүний нийтлэг үндсэн эрхүүдийг иргэдийн даяаршлын улс төрийн эрхүүдээр баяжуулах шаардлагатай. Учир нь даяаршлын нийгэм хамт олон эрх нь зөрчигдсөн иргэдэд тэдгээрийн үүссэн нөхцөлтэй нь идэвхтэй хамтран тэмцэх эрхийг олгодог.

Дэлхийн иргэний нийгэм

Дэлхийн иргэдийн статус нь улс төрийн дэлхийн иргэдийн нийгмийг бий болгохыг шаарддаг. Дэлхийн иргэдийн нийгмийн байгууллагын болон байгууллагын бус хэлбэрүүд тухайн өгөгдсөн нөхцөл дунд прагматик байдлаар хөгжих ёстой.

Улс төрийн иргэдийн нийгэм хамт олныг хамтын амьдралд нь мөрдөгдөх тоглоомын дүрмээ харилцан ойлголцсон

хүмүүсийн хамтын ажиллагааны нэгэн хэлбэр хэмээн ойлгож болно. Энэ ойлголтын гол цөм нь тэгш эрх ба тэгш үүргийн харилцан баталгаа болон улс төрийн шийдвэр гаргалтад оролцох тэгш оролцооны боломжуудыг бүрдүүлэх санаа юм. Дэлхийн иргэдийн эрхүүд нь даяаршлын улс төрийн ардчиллын гарааны нөхцөлүүд мөн.

Нийгмийн (социал) стандартууд ба түгээмэл үндсэн эрхүүд

Олон улсын эрх зүйд иргэний болон улс төрийн эрхүүдийн хэрэгжих хэлбэрийг үр дүнгийн хариуцлага, социал ба эдийн засгийн эрхүүдийн хэрэгжилтийг үйл ажиллагааны хариуцлага хэмээн хооронд нь зааглах нь дэлхийн нийгэм хамт олныг задралд хүргэх шалтгаан болохгүй. Дээрххоёр үндсэн эрхүүдийн хэлбэрүүдийг хэрэгжүүлж байгаа олон улсын туршлагуудын судалгаануудаас үзвэл: Үндсэн ажилтнуудын язгуур эрхүүдээс давсан нийгэм, эдийн засгийн үндсэн эрхүүдийн хэрэгжилт нь тухайн улс орны эдийн засгийн чадамжийн түвшинтэй уялдаагүй бол бүтцээ задлах хандлагатай болдог. Ажилчдын язгуур эрхүүд (албадлагын хөдөлмөрийг хориглох, хүүхдийн хөдөлмөрийг ялгаварлан гадуурхах, эвлэлдэн нэгдэх эрхийг баталгаажуулах, тарифын хамтарсан хэлэлцээр байгуулах эрх зэрэг нь ажилчдын язгуур эрхэд хамаарна.) нь хүний эрхийн салшгүй хэсэг, тухайн улс орны эдийн засаг, нийгмийн дэвшилд эерэг үүрэг гүйцэтгэдэг тул тэдгээрээс хальсан нийгмийн эрхүүдийг хангах эсэх нь тухайн улс орны хөгжлийн түвшингээс хамаардаг.

Ажилчдын язгуур эрхүүдийг эдийн засгийн талаас нь авч үзвэл эдийн засгийн хөгжил болон тухайн улс ардын аж ахуйн үр ашгийг нэмэгдүүлэхэд тустай. Иймээс эдгээр эрхүүдийн хэрэгжилт иргэний болон иргэдийн эрхүүдийн нэгэн адил маш хатуу хяналтын дор байх ёстой. Улс орон бүр өөрийн хөгжлийн хүрсэн түвшнээс хамааран ажилчдын язгуур эрх ашгаас давсан нийгэм, эдийн засгийн эрхүүдийн

хэрэгжилтийн талаар шийдвэрээ гаргадаг. Эдгээр эрхүүдийн хэрэгжилтэд хөндлөнгөөс шахалт үзүүлбээс эдийн засгийн хувьд тогтворжоогүй орнуудад эдийн засгийн ноцтой бэрхшээлүүдийг дагуулж ингэснээрээ өөрийн зорилтуудтайгаа зөрчилдөхөд хүргэдэг.

Иргэдийн болон улс төрийн үндсэн эрхүүд, ажилчдын язгуур эрхүүдийг хэрэгжүүлэх тал дээр шууд бус байдлаар шахалт үзүүлэх нь нийгмийн болон эдийн засгийн эрхүүдийг дэвшилттэйгээр хэрэгжүүлэхэд нөлөөлж байдаг. Эрхийн дээрх хоёр бүлгүүдийн хэрэгжилт баталгаажих нь нийгмийн бусад эрхүүдийн хэрэгжилтийг илүү баталгаатай болдог.

Даяаршлын ардчилал талаас нь авч үзвэл: Ажилчдын язгуур эрхүүдээс хальсан эрхүүдийн хэрэгжилт тухайн улс орны хөгжлийн түвшингээс хамаардаг бол ажилчдын язгуур эрхүүд заавал биелүүлэх хариуцлагын хэлбэрээр хэрэгжих боломжтой төдийгүй хэрэгжих ёстой.

5.3 Даяаршлын ардчиллын загварууд

Үндсэн чиглэлүүдийн маргаан

Сөрөг даяаршлын үед улс төрийн бие даасан байдал, хууль ёсны байх баталгаа хумигдаж буй байдлыг эерэг даяаршлаар даван туулах ёстой. Үүний тулд улс төрийн шийдвэр гаргалтын болон удирдлагын шинэлэг хэрэгслүүдийг бий болгох шаардлагатай.

Шинжлэх ухаан эерэг даяаршлын бүтцүүдийн олон төслүүдийг боловсруулан гаргасан бөгөөд тэдгээр нь хоорондоо үндсэн чиглэлийн хувьд ялгаатай байдаг. Америкийн улс төрч эрдэмтэн Венжамин Варбер нарын радикал үндсэн ардчилагчид дэлхий дахинаа иргэний нийгмийг идэвхжүүлснээр даяаршлын капитализмын хөгжлийг тогтоон барих боломжтой гэдэг таамаглалыг дэвшүүлсэн. Тэд төлөөллийн ардчиллын

байгууллагууд иргэдийн жинхэнэ сонирхлоос дэндүү хол, даяаршлын үр өгөөжтэй зохицуулалтыг дэлхий дахинаа зохион байгуулахад бэлэн бус гэж тайлбарладаг. Эдийн засагч эрдэмтэн Карл Кристиан фон Вайцзекер нарын либертар ардчиллагчид даяаршлын зах зээлийг улс төрийн аргаар зохицуулахаас аль болох зайлсхийх шаардлагатай гэж номлодог. Тэд ардчилсан хувиарлалтын бодлогын хэв заншлыг шүүмжилж түүний оронд зах зээлийн дарамт дор зөнгөөрөө явагдах бүтээмж, дэвшилд найдан орхих нь зүйтэй гэж үздэг. Тэд ингэснээрээ үндэстэн дамнасан эдийн засгийн зохицуулалтаас бүрэн татгалзаж даяаршилд шударга ёс тогтоох бодлогоос мөн татгалздаг. Тэд цаг хугацааны явцад зах зээлийн голдрилоор дэлхий дахинаа амьдралын нөхцөлүүд аяндаа ойролцоо түвшинд хүрэх болно гэж үздэг.

Нийгмийн ардчиллын хэтийн төлөвөөс харвал дээрх таамаглалуудын алийг нь ч хүлээн зөвшөөрөх үндэслэлгүй юм. Үндэстэн дамнасан иргэний нийгэм даяаршлын ардчиллын шийдвэрлэх нөлөө бүхий элемент мөн боловч үндэстэн дамнасан бусад байгууллагууд, хамтын ажиллагааны холбоонууд, зохицуулалтын дэглэмүүдийг дангаараа орлож чадахгүй учраас ганцаараа баталгаа болж чадахгүй. Зөвхөн даяаршлын зах зээл, түүний зохицуулалтын механизмуудад бүгдийг даатгах нь сүйрэлд хүргэх үр дагавруудыг дур зоргоор нь орхисон хэрэг болно: Байгаль орчны сүйрэл, Санхүү ба хөдөлмөр эрхлэлтийн хямрал, дэлхий дахинд амьдралын боломжийн шударга бус, хэт өрөөсгөл хуваарилалт гэх мэт.

Иймээс шийдвэрлэх гол асуудал бол: Даяаршлын дэглэмийг хэрхэн ардчилсан хэлбэрээр зохион байгуулах бэ? Энэ асуултын хариулт нь эвлэлдэн найрамдсан Дэлхийн Бүгд Найрамдах Улсыг байгуулах явдал бус бөгөөд харин үндэстэн дамнасан хамтын ажиллагааг «бодит»-тойгоор идэвхжүүлэх явдал мөн. Эерэг даяаршлын хүрээнд хууль ёсны зохицуулалтын механизмыг

боловсруулах нь шийдвэрлэх рольтой юм. Уг зохицуулалтын механизм нь зорилтуудыг хооронд нь ойртуулах нээлттэй процессын хэлбэртэй байж болох бөгөөд тэдгээрийн явцад олон тооны хэрэгслүүдийг ашиглах нь зүйтэй.

Даяаршлын ардчилал нь дэлхий дахины түүхэнд ардчиллыг бэхжүүлэх гуравдагч алхамтай эн тэнцэхүйц ач холбогдолтой юм. Эхний алхам эртний Грек улсын хот улсуудад хийгдсэн. Хоёрдох алхам Европын соён гэгээрлийн нөлөөгөөр 18-р зууны үеийн улс орнуудын ардчиллаас бүрдэж байсан юм. Нийгмийн ардчиллын төсөлд ардчиллын баталгааны энэхүү гуравдагч алхам шийдвэрлэх чухал ач холбогдолтой: Зөвхөн даяаршлын улс төрийн тавцан дээр үүргээ гүйцэтгэх чадамж бүхий шийдвэр гаргалтын бүтцүүдийг байгуулж чадсан нөхцөлд л нийгмийн ардчилал хэрэгжих нөхцөл бүрдэнэ. Иймээс либерал ардчиллын даяарчлагдсан шинэчлэл нь нийгмийн ардчилал хэрэгжих нэг нөхцөл мөн.

Даяаршлын ардчиллын загварууд

Даяаршлын ардчиллын судалгааны өнөөгийн түвшин түүнийг хэрэгжүүлэх олон төрлийн саналуудыг боловсруулсан байна. Нийгмийн ардчиллын онолын хүрээнд боловсруулагдсан бүхий л саналууд нийгмийн ардчиллын урьдчилсан нөхцөлүүдтэй холбоотой байх ёстой. Тэдгээрээс дараах дөрвөн загвар хамгийн өндөр ач холбогдолтой юм:

1. Даяаршлын хөршийн загвар (**Global governance**)
2. Демарчи буюу ардчилсан загвар
3. Ертөнцийн иргэний үзэл дээр суурилсан ардчиллын загвар
4. Үүрэг шилжих Дэлхийн Бүгд Найрамдах Улсын загвар

Дээрх загвар тус бүр улс төрийн сэтгэлгээний өөр өөр онолын уламжлалаас эхтэй бөгөөд байгууллагуудын бүтцийн талаас нь авч үзвэл өөр өөр туйлын зорилготой, үндэстэн дамнасан

шийдвэр гаргалтын хэм хэмжээг мөн өөр өөрийн замаар тодорхойлдог. Үүгээр ч зогсохгүй эдгээр загваруудын хэрэгжих боломж, хэрэгжилтийн явц нь мөн ялгаатай. Эдгээрийг даяаршлын ардчиллын асуудлуудыг шийдвэрлэх саналууд гэж ойлгож болно.

1. Даяаршлын хөршийн загвар (Global governance)

Даяаршлын хөршийн комиссын 1995 оны тайлан илтгэлд даяаршлын хөршийн ойлголтыг үндэстэн дамнасан улс төрийн удирдлагын тусгай загвар хэмээн нэрлэсэн байна. Энэ нь үндсэндээ улс төрийн даяаршлын либерал ардчилсан хувилбарууд юм. Уг загвар дараах онцлог шинжүүдийг агуулсан байдаг:

- Удирдлагын төрөл бүрийн элементүүд нь хоорондоо харилцааны сүлжээтэй.
Даяаршлын зохицуулалтын процессод баримтлах даяаршлын ёс зүйг бүрдүүлэх
- Ардчиллын байгууллагуудын шинэ бүтцийг бий болгохын тулд НҮБ-ыг шинэчлэх
- Дэлхийн эдийн засгийн аюулгүй байдлын зөвлөлийг байгуулах
- Нийгэм, эдийн засгийн үндсэн эрхүүдийг хэрэгжүүлэх, тэдгээрийн хэрэгжилтэд хяналт тавих байгууллагуудыг шинээр байгуулах
- Улс төрийн бүс нутгуудыг холбох, ардчилах, өргөжүүлэх
- Бүх шатанд иргэдийн оролцоог идэвхжүүлэх

2. Ардчиллын загвар

Энэхүү загварыг даяаршлын хөршийн загварын хэрэгжилтийн явцад үүссэн ардчиллын гажуудлыг засах зорилгоор боловсруулсан. Уг загвар нь даяаршлын иргэний нийгмийн нэгэн хэлбэр юм. Энэ утгаар нь уг загварыг демарчи буюу эртний Грекийн тосгодын толгойлогчдын нэрээр нэрлэсэн

байна. Энэ нэр нь уг загварыг байгууллагуудыг онцолсон бусад загваруудаас зааглаж өгдөг. Энэ концепцын үндэс нь даяаршлын ардчиллыг бодит амьдралын орчин ба өдөр тутмын туршлагын хүрээнд л хэрэгжүүлэх боломжтой гэдэг төсөөлөл юм. Даяаршлын эрин үед үр дүнтэй үйл ажиллагаа явуулах чадамжтай улс төрийн нийгэмлэгүүд бол орон нутгийн нийгэмлэгүүд бус харин нийтлэг сонирхолтой эсвэл адилхан асуудалд нэрвэгдсэн үндэстэн дамнасан нийгэмлэгүүд болон өргөждөг. (Байгаль орчны хамгаалал, шашин шүтэх эрх чөлөө, хүйсийн тэгш байдлыг хангах, эсвэл хүний эрхийн асуудал зэрэг). Энэ загварын онцлог шинжүүд нь:

- Үйл ажиллагааны чадамж бүхий улс төрийн зохицуулалтын шинэ хэлбэрүүдийг бий болгох
- Улс төрийн төлөөллийн тавцан дээр шууд зөвшилцөх, шийдвэр гаргалтын үндэстэн дамнасан процедурыг зохион байгуулах
- Дээрх процедурыг идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг улс төрийн нийгэмлэгүүд, иргэний нийгмийн бүлгүүдтэй холбох
- Ардчилсан өөрийн засаглалын цоо шинэ бүтцүүдийн төслийг боловсруулах
- Улс үндэстний төгсгөл

3. Ертөнцийн иргэний үзэл дээр суурилсан ардчиллын загвар

Энэхүү загвар нь ардчиллын дэмрчи загварын нэгэн адил даяаршлын хөршийн концепцын ардчиллын сул талуудыг арилгахын тулд боловсруулагдсан. Уг загвар цаад утгаараа нийгмийн ардчиллын онолд оруулж буй нэгэн хувь нэмэр бөгөөд зан суртахууны болон материаллаг талаас нь авч үзвэл хүн төрөлхтөн нийтлэг нэг хувь заяатай болсон гэдэг санаан дээр суурилдаг. Иймээс хүн төрөлхтөн улс төрийн хувьд нэгэн нэгдэл мөн гэдэг ойлголтын дор зохион байгуулалтад орох ёстой. Уг загвар дараах онцлог шинжүүдтэй байдаг.

- Ардчилсан өөрийгөө захирах бүгд найрамдах улсын ёс зүй дэлхий дахинаа эртнээс тогтсон гэж үздэг.
- Бүх хүмүүс өөрсдийгөө даяаршлын улс төрийн хамтын нийгэмлэгийн нэгэн хэсэг гэж үздэг болсон цагт л даяаршлын ардчилал тогтох бололцоотой.
- Ардчиллын бүх туршлага улс төрийн хамтын нийгэмлэгүүд болон иргэний нийгмийн холбоодтой холбогдсон байх ёстой.
- Иргэний нийгмийн үйл ажиллагаа дэлхий дахинаа тэдгээрийн хоорондын уялдаа холбоог хангах ардчилсан хуулиудаар зохицуулагдаж байх ёстой.
- Улс төрийн хамтарсан үйл ажиллагааны үндэстэн дамнасан хэлбэрүүдээс дэлхий дахинаа харилцан уялдаатай үйлчлэх ардчилсан хуулиуд төрдөг.
- Дэлхийн иргэдийн бие даасан байдлыг олон төрлийн хоорондоо давхацсан эрх мэдлийн төвүүдээр дамжуулан хангах ёстой.
- Дэлхийн иргэдийн ардчилал нь бие даасан улс үндэстнүүдийн концепц болон зөвхөн үндэсний иргэн харьяатын бие даасан байдлыг даван туулна гэсэн үг юм.
- Дэлхийн иргэдийн үзэл дээр суурилсан ардчиллыг иргэн харьяатын өргөтгөсөн хэлбэр гэж ойлгож болно. (Хувь хүн бүр иргэний эрхээ улс үндэстнийхээ , бүс нутгийнхаа, даяаршлын ардчиллын түвшинд хэрэгжүүлнэ.)
- Үндсээр нь бүрэн шинэчлэх НҮБ уг загварт шийдвэрлэх үүргийг гүйцэтгэнэ.
- Дэлхийн Худалдааны Байгууллага, Дэлхийн Банк, Олон Улсын Валютын сан зэрэг байгууллагууд шударгаар бүрдүүлсэн хяналтын зөвлөлүүдийн хяналтын дор ажиллана.
- «Дэлхийн хүний эрхийн шүүхийн хороо»-г байгуулах шаардлагатай.
- Бүс нутгийн хамтын ажиллагааны улс төрийн системүүдийг өргөжүүлж үйл ажиллагааг нь идэвхжүүлж тэдгээрийн шийдвэр гаргалтын хэлбэрүүдийг сайжруулах шаардлагатай.

- Дэлхийн иргэдийн эрхийг мөрдөх, хэрэгжүүлэх асуудлыг бүхий л түвшинд баталгаажуулж шаардлагатай тохиолдолд шахалт үзүүлэх хэрэгтэй.
- Дэлхийн нийт эдийн засгийг ардчилсан бүтцүүдээр үр өгөөжтэйгөөр хязгаарлаж зохицуулах шаардлагатай.

4. Үүрэг шилжих Бүгд Найрамдах Улсын загвар

Даяаршсан дэлхий дээр ардчиллын зан суртахууны ямар нөхцөлүүд шаардлагатай бэ? гэдэг ганцхан асуултын норматив эргэцүүлэл дээр уг загвар үндэслэдэг. Германы социал демократизмын зүгээс уг загварын зарим хэсгүүд ихээхэн дэмжлэг хүлээсэн байна. Хэдийгээр уг загвар бусад загваруудтай төстэй тал олонтой ч үндэстэн дамнасан улсыг байгуулах нь даяаршлын ардчилал бэхжих нөхцөл мөн гэж үздэгээрээ бусад загваруудаас ялгаатай юм.

Энэхүү загварын онцлог шинжүүд нь:

- Дэлхийн нийгэм нь бүх хүмүүсийн үндсэн эрхүүдийг дэлхийн өнцөг булан бүрд найдвартай хамгаалж чадах, биелүүлээгүй тохиолдолд шахалт үзүүлэх боломж бүхий түгээмэл эрхийг хүчин төгөлдөр болгохыг шаардаж байна.
- Улс төрийн намуудаас ангид даяаршлын нэр хүнд бүхий байгууллага дээрх түгээмэл эрхүүдийг батлан гаргаж биелүүлээгүй тохиолдолд шахалт үзүүлэх чадамжтай байх ёстой.
- Дээрх эрх мэдэл бүхий байгууллага түүнээс өгөгдсөн үүрэг даалгаврууд нь биелэгдэж байхын тулд төрт улсын шинж чанаруудыг агуулсан байх ёстой.
- Ардчилсан, эрх зүйт дэлхийн бүгд найрамдах улсыг байгуулах нь даяаршлын шаардлагуудад зохистой хариултыг өгч чадах цорын ганц хариулт мөн.
- Дэлхийн ардчилсан бүгд найрамдах улс бүх түвшинд, бүх салбарт холбооны улсын болон үүрэг шилжүүлэх зарчмын дагуу ангилагдах ёстой.

- Дэлхийн ардчилсан бүгд найрамдах улс нь иргэний нийгмийн болон бусад өөрийгөө захирах улс төрийн үйл ажиллагааны олон хэлбэрүүдэд үйл ажиллагааны хангалттай орчныг бий болгож өгөх ёстой.
- Дэлхийн бүгд найрамдах улсын бүтцийг байгуулах үйл явц нь удаан үргэлжлэх процесс юм.

Даяаршлын ардчиллын нээлттэй арга

Даяаршлын нийгмийн ардчиллыг хэрхэн хэрэгжүүлэх бэ? гэдэг асуултад дээрх загваруудын аль нь ч дангаараа хангалттай хариултыг өгч чадахгүй. Загваруудын нэгж элементүүдийг хооронд нь нормативын хувьд сайн нотлогдсон, зарчмын хувьд хэрэгжих боломжтойгоор хослуулах замаар эерэг даяаршлын практик ерөнхий зураглалыг гарган авч болох юм.

- Дэлхийн нийгэм хамт олныг хэрэгжүүлэх, Ингэснээр дэлхийн өнцөг булан бүрд бүх иргэдэд улс төрийн дэлхийн нийгмийн бүх түвшинд шийдвэр гаргалтад оролцох эрхийг нь хангана.
- Даяаршлын зах зээлд нийгмийн, соёлын, эдийн засгийн хариуцлага ногдуулах. Даяаршлын ардчилалд эдийн засаг улс төрийн хариуцлагын бүтцүүдийн захиргаанд байх ёстой.
- НҮБ-ын үйл ажиллагааны үр өгөөжийг дээшлүүлэх, Өнөөгийн бүтцийн төлөөлөх чадвар, хариуцлагыг дээшлүүлэх
- Үндэстэн дамнасан иргэний нийгмийг байгуулах
- Улс үндэстнүүдийн хил хязгаараас хальсан улс төрийн эрх мэдлийг хэрэгжүүлэх хүчирхэг байгууллагыг байгуулах
- Даяаршлын ардчилал нь зөвхөн улс төрийн иж бүрэн зохицуулалтын нэгэн шинэ хэлбэрээр амжилтад хүрнэ гэдэг итгэл үнэмшил. Бүтцийн болон бүтцийн бус улс төрийн актёруудын хамтын ажиллагааны шинэ хэлбэрүүдийг цаашид улам хөгжүүлэх шаардлагатай.

- Бараг бүх концепцууд сүүлийнхээс бусад нь «дэлхийн улс» гэдэг нэр томьёог хэрэглэхгүй байхаар тохиролцсон. Ардчилсан үүрэг шилжих зарчмын дагуу даяаршлын ардчиллыг даяаршлын төрийн хэлбэрээр байгуулах боломжгүй юм.

Эдгээр ерөнхий нөхцөлүүд нь нийгмийн ардчиллын улс төрийн бүтцийн суурийг даяаршлын бодлогын түвшинд бүрдүүлдэг. Үүнийг доор дурдсан дөрвөн загваруудын зарим нэг элементүүдээр баяжуулж болно:

- Демарчи загварын дэлхийн ардчиллын улс төрийн асуудлуудыг үүрэгт нийцсэн шийдлүүдээр шийдвэл амжилтад хүрэх магадлал өндөртэй гэдэг таамаглал онцгой анхаарал татдаг.
- Дэлхийн иргэний үзэл дээр суурилсан ардчиллын загварын хоёр санаа онцгой сонирхол татдаг. Нэгдүгээрт: Дэлхийн нийгэм хамт олны бүтцийг байгуулах боломжтой бөгөөд шаардлагатай, хоёрдугаарт: Үндэстэн дамнасан хууль тогтоогч байгууллагын бүтцийг байгуулах ёстой гэдэг санаа.
- Үүрэг шилжүүлэх дэлхийн бүгд найрамдах улсын загвар дээр суурилан улс төрийн шийдвэр гаргалтын бүтцийн үүрэг шилжүүлэх зохион байгуулалтыг байгуулах санаа. Энэ санаа төрт улсын зарим элементүүдийг агуулж байдаг боловч (Жишээ нь: иргэдийн эрхийн зохицуулалтын хүрээнд шахалт үзүүлэх салбарт) бүхэлд нь авч үзвэл дэлхийн улсын нэгэн хэлбэр хэмээн ойлгоход учир дутагдалтай юм.
- Даяаршлын хөршийн комиссын төслөөс дэлхийн нийгмийн болон улс төрийн зохицуулалтад зөвхөн олон талт таамаглалууд бодит байдалд нийцнэ гэсэн санаа чухал. Хамтын ажиллагаа, зөвлөгөөн, шийдвэр гаргалтын олон хэлбэрийг хооронд нь хослуулах шаардлагатай.

Даяаршлын бодлогын зохион байгуулалтын нээлттэй арга нь дээр дурдсан хүчин зүйлүүдийн улмаас дараах зургаан элемент дээр суурилдаг:

Нэгдүгээрт: Эрх ба үүрэг дээр суурилсан дэлхийн иргэний нийгмийн концепцын дагуу иргэн бүрийг дэлхийн өнцөг булан бүрд улс төрийн чухал шийдвэр гаргалтад идэвхтэй оролцох эрхээр хангах

Хоёрдугаарт: Үндэстэн дамнасан болон улс үндэстний хил хязгаараас давсан үйл ажиллагаа явуулдаг улс төрийн байгууллагуудыг ардчиллах, өргөжүүлэх болон үйл ажиллагааны хүрээг нь тэлэх. Юуны өмнө НҮБ түүний харьяа байгууллагууд. Нэн ялангуяа ард түмнүүдийн танхим (парламент) болон дэлхийн эдийн засгийн аюулгүй байдлын зөвлөлийг байгуулах (хяналт тавих, ерөнхий нөхцөлүүдийг тогтоох, эдийн засгийн процессуудад хөндлөнгөөс оролцох эрхтэйгээр)

Гуравдугаарт: Улс төрийн зохицуулалтын бүс нутгийн системүүдийн дотоод ардчиллыг бэхжүүлэх, идэвхжүүлэх, тоог нь олшруулах, үйл ажиллагааны хүрээг нь тэлэх түүнчлэн хамтын ажиллагааны сүлжээг нь сайжруулах (нэн түрүүнд Европын Холбоо, Зүүн Өмнөд Азийн улсуудын холбоо, Аргентин, Бразил, Парагвай, Чили улсуудын хамтарсан дотоодын зах зээл, Хойд Америкийн чөлөөт худалдааны хэлэлцээр АНУ, Канад, Мексикийн хооронд байгуулагдсан чөлөөт худалдааны гэрээ зэрэг байгууллагууд)

Дөрөвдүгээрт: Үндэстэн дамнасан дэглэмүүдийн чадавхыг сайжруулах. Дэлхийн эдийн засаг ба дэлхийн нийгмийн онцгой чухал салбаруудад улс төрийн хариуцлага үүргийн дагуу зохицуулагдах ёстой. (Жишээ нь: Худалдаа, хөдөлмөр, байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй байдал). Киотогийн протокол болон, дэлхийн хөдөлмөрийн байгууллага, дэлхийн

худалдааны байгууллагын гэрээ хэлэлцээрүүдэд дээрх хэлбэрийн дэглэмүүдийн сургалт эхлээд байна. Үндэстэн дамнасан дэглэмүүдийн зохицуулалтад хамрагдсан улсуудын шийдвэр гаргалтад оролцох оролцоог сайжруулах, илүү шударга болгох

Тавдугаарт: Ардчилсан улсын байгууллагууд үндэстэн дамнасан иргэний нийгмийн байгууллагуудад илүү дэмжлэг үзүүлэх хэрэгтэй. Үүнээс гадна дэлхийн нийгмийн улс төрийн шийдвэр гаргалт, зөвлөгөөнд иргэний нийгмийн байр суурийг бэхжүүлэх шаардлагатай. Хүний эрхийг хамгаалах, хүмүүнлэг хөдөлмөрийн нөхцөлүүдийг бүрдүүлэх, байгаль орчныг хамгаалах, хүйсийн тэгш байдлыг хангах зэрэгт үндэстэн дамнасан иргэний нийгмийн үүрэг улам нэмэгдэж илүү чухал болсоор байна. Тэдгээрийн оролцох асуудлын хүрээ, үйл ажиллагааны боломжид ямар нэгэн хязгаарлалт байхгүй.

Зургаадугаарт: Дэлхийн улс төрийн олон нийтийг бүрдүүлэх нь дэлхийн нийгэм хамт олны сургалт төдийгүй даяаршлын ардчиллын хяналт ба шүүмжлэлд ихээхэн ач холбогдолтой. Даяаршсан дэлхий дээр бэрхшээлтэй асуудлуудад олон нийтийн анхаарлыг хандуулж, хэлэлцүүлэх нь дэлхийн нийгэм хамт олны ухамсрыг хамгийн сайнаар бэхжүүлэх боломж юм. Дэлхийн олон нийт нь нийгмийн асуудлууд болон тэдгээрийг шийдвэрлэх концепцуудыг зуучлан таниулах чухал орчин юм.

Иргэний нийгэм нь нэн ялангуяа дэлхийн нийгмийн ардчилалд амин чухал хоёр салбарт шийдвэрлэх үүргийг гүйцэтгэж чадна: **Нэгдүгээрт:** Даяаршлын ерөнхий нөхцөлүүд болон зохицуулалтын зорилтууд ба нормын талаар зөвлөлдөх, **хоёрдугаарт:** даяаршлын ардчиллын төрөл бүрийн актёрууд эдгээр нормуудыг мөрдөж буй эсэхэд хяналт тавих. Үйл ажиллагааны салбар тус бүр дээр хүүхдийн хөдөлмөр, байгаль орчны сүйрэл, хар тамхины худалдаа зэрэг асуудлуудаар тус тусын үүргийн дагуу ажиллаж буй

мэргэжилтнүүд, байгууллагууд нь иргэдийн идэвх санаачилгын байгууллагуудын сүлжээний хүрээнд дээрх нормуудыг хамгийн сайнаар боловсруулан гаргаж тэдгээрт хяналт тавих боломжтой. Эцсийн бүлэгт олон улсын байгууллагууд, үндэстэн дамнасан дэглэмүүд тавьсан зорилтуудын уялдаа холбоог хангах, хяналт тавих хариуцлагыг хүлээдэг.

Иргэний нийгмийн үүрэг бол харилцан ойлголцлын процессыг хангах болон хамтын туршлагуудыг хуримтлуулахад оршино. Иргэний нийгмийн нэгжүүдэд даяаршлын процессыг удирдахад тус нэмэр болох чухал нормууд, үнэт зүйлс бүрэлдэн тогтдог билээ. Иргэний нийгэм нь удирдлагын элементүүдийг боловсруулахад туслаад зогсохгүй эдгээр хэрэгслүүдийг хамтарсан үйл ажиллагаандаа хэрэглэхэд шаардагдах эв санааны нэгдлийг бүрдүүлж байдаг.

Иймээс иргэний нийгэм улс төр болон даяаршлын бодлогод чухал үүрэг гүйцэтгэдэг. Гэхдээ иргэний нийгэм даяаршлын ардчиллын бүх үүргийг дангаараа гүйцэтгэх чадамжгүй.

Даяаршлын нийгмийн ардчилал

Дээрх дүн шинжилгээнүүд нь даяаршлын нөхцөлд нийгмийн ардчилал олон талтай, үлэмж бэрхшээлтэй улс төрийн төсөл боловч зөвхөн норматив дэмжлэгтэй найдвар төдий зүйл биш юм гэдгийг харуулж байна. Нийгмийн ардчилал нь даяаршлын тавцан дээр улс төрийн олон төрлийн актёрууд болон дэлхийн нийгэм болон улс орнуудын нийгэмлэгийн нөхцөлүүдтэй нийцэх боломжтой төсөл юм. Энэ нь боломжтой гэдгийг өнөөгийн үндэстэн дамнасан хамтын ажиллагааны хүрээнд бий болсон нөхцөлүүд харуулж байна. Нийгмийн ардчилал нь улс төрийн шийдвэр гаргалтын төрөл бүрийн түвшнүүдийн хоорондын сүлжээг дэлхийн иргэдийн зохистой түвшинд бий болгож хөгжүүлэхийг шаардаж байна. Үүрэг шилжүүлэх зарчим нь бүх түвшний шийдвэр гаргалтыг хуваарилах үндсэн дүрэм байх ёстой.

5.4 Дэлхийн зах зээлд хариуцлага ногдуулах нь

Хорьдугаар зууны сүүлийн дөрөв дэх хагаст олон улс үндэстнүүдийн таваарын худалдаа, үйлчилгээнд үндэсний түвшинд тавигдаж байсан босго бүрэн үгүй болж үгүй болоогүй нөхцөлд маш их хязгаарлалтад орсон байна. Тээвэрлэлт болон мэдээлэл солилцооны өртөг энэ хугацаанд үлэмж буурч дэлхий дахины бүх үйлдвэрлэгчид дэлхийн бүх зах зээл дээр бараа үйлчилгээгээ гаргах боломжтой болсон байна. Өмнө нь улс үндэстний хэмжээнд эсвэл бүс нутгийн хэмжээнд хязгаарлагдмал байсан зах зээлүүд нэгэн цул дэлхий дахины мега - зах зээлд нэгджээ. Чанар, үнэ, өртгийн өрсөлдөөн бодит байдал дээр зарчмын хувьд хил хязгааргүй болсон байна.

Эдийн засгийн даяаршлын хамгийн бэрхшээлтэй асуудал бол зах зээлүүдэд нийгэм, улс төр, эдийн засгийн хариуцлага ногдуулах явдал учир дутагдалтай байна. Нэн ялангуяа санхүүгийн зах зээл дээр дээрх асуудал хамгийн ноцтой байдалтай тулгараад байна. Олон тэрбумаар тоологдох мөнгө цөөн тооны хөрөнгө оруулалт болон төлбөрийн сан дээр төвлөрөөд байна. Санхүүгийн олон талт үйл ажиллагаа тоног төхөөрөмж болон валютын хямралаас найдвартай хамгаалах чадвартай болжээ. Өдөр бүр биржүүд дээр эргэлдэж буй санхүүгийн капитал худалдааны урсгалаас салангид болж тэдний бие даасан байдал эрс сайжирсан байна. Биржүүд дээр гарч буй хэт мэдрэмтгий байдал, ноёлох харилцааны хэлбэрүүдээс улбаатай гэнэтийн шийдвэрүүд ганцхан шөнийн дотор улс ардын аж ахуйнуудыг хямралд хүргэж уг хямрал гинжин урвалаар бүхий л улс орнуудын бүлгүүдийг хамрах боломжтой. Дэлхийн санхүүгийн зах зээлийн өнөөгийн бүтэц ихэвчлэн либертар шинж чанартай учраас хувь хүмүүст үлэмж хэмжээний давуу талыг бүрдүүлэх боломжтой. Тэдний энэ давуу талыг дэлхий нийтээрээ хангалуун амьдралын түвшин, ажлын байр, хамрагдсан улс орнуудын улс ардын аж ахуй нь асар өндөр үнээр төлж болзошгүй. Дээрх тохиолдолд

хамрагдсан орнуудын иргэдийн үндсэн эрхүүд ноцтойгоор зөрчигдөх нөхцөлүүд үүснэ.

Үндэстэн дамнасан компаниудад тавих улс төрийн хяналт сул байгаагаас эдийн засгийн даяаршлын бас нэгэн бэрхшээлтэй асуудал үүсдэг. Эдгээр компаниуд экологи, татвар, нийгмийн шаардлагын хувьд хамгийн сул улс орнуудад салбаруудаа нээсээр байна. Тэд ихэнх тохиолдолд эдийн засгийн асар их эрх мэдлээ ашиглан үйл ажиллагааныхаа ерөнхий нөхцөлүүдийг бүрдүүлэхэд ашиг сонирхлоо тусгуулж чаддаг. Зарим компаниудын эргэлт зарим жижиг орнуудын улсын нийт төсвөөс давж байдаг. Зарим нь өөрсдөдөө ашигтай тооцооны аргачлалыг хэрэглэн ашгаа татварын хувьд ээлтэй улс орнуудад гаргах замаар байрлаж буй улс орнуудынхаа улсын татвараас зайлсхийж чаддаг. Эдгээр компаниуд бүтээгдэхүүнүүдээ үйлдвэрлэлийн эдийн засгийн хувьд хамгийн тохиромжтой улс орнуудад хэсэгчлэн үйлдвэрлэх замаар үйлдвэрлэлийн процессуудаа зохион байгуулдаг. Жишээ нь: АНУ-д нь төв нь байрладаг авто машины үйлдвэрлэл эд ангиудаа Ази, Европ, Латин Америкаас татан авдаг. Нөгөө талаас үйлдвэрлэлийн энэхүү арга салбар үйлдвэрүүдэд ажиллаж буй хамт олны хүчийг сулруулж тэр ч байтугай салбаруудын оршин буй орнуудын засгийн газруудын нөлөөг бууруулдаг. Сөрөг даяаршлын эдгээр хүчин зүйлүүдийг даяаршлын хэмжээнд зах зээлд улс төрийн хариуцлага ногдуулах замаар даван туулах ёстой. Үүний тулд практикт ойр эрдэмтэд, нөлөө бүхий голлон тоглогчид хэрэгжүүлэх боломж бүхий концепцуудыг боловсруулсан байна. Тэдгээрийн зарим нэгэн бүрэлдэхүүн хэсгүүд хэрэгжих шатандаа явж байна.

Үндэстэн дамнасан эдийн засгийн зохицуулалтын зорилтууд
Девид Хэлд үндэстэн дамнасан эдийн засгийн зохицуулалтын дараах таван арга хэмжээнүүдийг санал болгоод байна:

Нэгдүгээрт: Үндэстэн дамнасан түвшинд улс төрийн зорилтууд, эдийн засгийн үйл ажиллагааны хоорондын тэнцвэрийг шинээр тогтоох шаардлагатай. Хуулиар зах зээлийн үйл ажиллагааны ерөнхий хүрээг тогтоож өгөх хэрэгтэй.

Хоёрдугаарт: Даяаршлын хэмжээний актёруудын эдийн засгийн зохицуулалтын шинэ хэлбэрүүдийг бий болгох шаардлагатай. (Олон улсын Валютын сан, Дэлхийн банк, Эдийн засаг, хөгжлийн хамтын ажиллагааны байгууллага, Их долоогийн бүлэг зэрэг). Энэ зорилтыг биелүүлэхийн тулд зохицуулах агентлагийг байгуулах шаардлагатай. Уг байгууллага нь бүс нутгийн болон даяаршлын түвшин дээр эдийн засгийн үйл ажиллагааг үр өгөөжтэй зохицуулах чадамжтай байх ёстой.

Гуравдугаарт: Олон улсын санхүүгийн зах зээлүүдийг зохицуулалтад оруулах ёстой. Энэ нь онцгой чухал ач холбогдолтой. Энэхүү зохицуулалтыг хийгээгүй нөхцөлд үндсэн эрхүүд зөрчигдөх нөхцөлүүдийг бий болгож, улс орнууд болон нийгмийн улс төрийн үйл ажиллагаанд аюул учруулахуйц томоохон эрсдэлүүд гарах магадлал өндөр.

Дөрөвдүгээрт: Дэлхийн банк, олон улсын валютын сангийн үйл ажиллагаанд зарчмын шинэчлэл хийх шаардлагатай. Хөгжлийг дэмжих даяаршлын зээллэгийн нөхцөлүүдийг бүрдүүлэх шаардлагатай.

Тавдугаарт: Ардчилсан, хяналттай улс төрийн шийдвэр гаргалтын үр дүнд хэрэгжиж буй бол үндэстэн дамнасан эдийн засгийн зохицуулалтын үйл ажиллагааг хууль ёсны хэмээн үзэж болно. Үндэстэн дамнасан байгууллагуудын шийдвэр гаргалтыг ардчилах, Дэлхийн аюулгүй байдлын зөвлөлийг шинэчлэх чиглэлээр чухал алхмууд хийгдээд байна.

Дээрх таван арга хэмжээнүүд ардчиллын бодлогоор

нотлогдсон даяаршлын бодлогын үйл ажиллагааны үүрэг хариуцлагыг тодорхойлж байгаа юм. Эдгээр таван арга хэмжээний тусламжтайгаар зах зээлүүдийг дахин үндсэн эрхүүд ба ардчиллаар тодорхойлогдох хариуцлагын бүтцийн хяналтад оруулах боломжтой. Энэ замаар сөрөг ардчиллыг алхам алхмаар эерэг даяаршилд шилжүүлж болно.

**Нэгдсэн Үндэсний Хөгжлийн Хөтөлбөрийн
үндэстэн дамнасан эдийн засгийн зохицуулалтын төсөл**

НҮБХХ-ийн шинэ төслүүдийн хүрээнд даяаршлыг зохицуулах «Даяаршлын олон нийтийн таваарыг хангах» концепцыг боловсруулсан. Дэлхийн зах зээлд хариуцлага ногдуулах зорилго бүхий уг төсөл дэлхийн бүх иргэдийн үндсэн эрхүүдийг хангах нөхцөлүүдийг бүрдүүлэх даяаршлын олон нийтийн таваарыг баталгаажуулах зорилгыг агуулсан. Эдгээрт: олон улсын аюулгүй байдал, экологийн тогтвортой байдал, санхүүгийн зах зээлийн тогтвортой байдал, түүнчлэн эрүүл мэндийн үйлчилгээ, боловсрол, дээд боловсрол, нийгмийн аюулгүй байдал, хөдөлмөр эрхлэлтэд хамрагдах боломж зэрэг багтана. Энэ концепц нь дээрх нийгмийн таваарууд нь хүний ёсоор амьдрах нөхцөлийг дэлхийн өнцөг булан оршин суугаа бүх хүмүүст бүрдүүлэхийн тулд нээлттэй байх ёстой гэж үздэг.

Уг концепц нь хөгжлөөрөө хоцрогдож буй дэлхийн улс орнуудын иргэдэд хүний ёсоор амьдрах нөхцөлүүдийг хангахын тулд юу хийх ёстой бэ? гэдгийг тодорхой болгож нөгөө талаар хамтын хариуцлага хүлээх үүргийг чинээлэг, үйл ажиллагааны чадамж өндөртэй орнуудад хүлээлгэж байгаа юм. «Даяаршлын нийгмийн таваарыг хангах» концепцыг бүхэлд нь авч үзвэл нийгмийн ардчиллын төслийг баяжуулж байгаа юм. Уг концепц нийгмийн ардчиллын үнэт зүйлс болон зорилтуудыг үндэстэн дамнасан түвшин дээр хэрхэн хэрэгжүүлэх боломжтой бэ? гэдгийг харуулдаг.

Дэлхийн зах зээлд нийгмийн ардчиллын хариуцлагыг ногдуулах элементүүд ба стратегиуд

Нийгмийн ардчиллын хэтийн чиг хандлага талаас нь авч үзвэл таваарын нэгдсэн зах зээлийн дараах гурван төсөл чухал ач холбогдолтой юм:

Нэгдүгээрт: Дэлхийн Худалдааны Байгууллагын дэглэмийн зүгээс худалдаанд учруулж буй саад тотгоруудыг арилгах. Юуны өмнө хөгжиж буй орнуудад сөрөг талуудыг дагуулж буй бэрхшээлийг арилгах

Хоёрдугаарт: Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагаас хүний ёсоор ажиллах хөдөлмөрлөх нөхцөлүүдийг тогтоосон хэм хэмжээнүүдийг дэлхий дахинд мөрдөх, Түүнчлэн дээрх нөхцөлүүдийг хангасан орчинд үйлдвэрлэгдсэн бүтээгдэхүүнүүдийг зах зээлүүд дээр тусгай тэмдэглэгээтэй гаргадаг болох

Гуравдугаарт: Үйлдвэрлэл ба бүтээгдэхүүний экологийн стандартуудыг тогтоох даяаршлын дэглэмийг нэн даруй боловсруулах. Эдгээр дэглэмүүд нь өнөө мөрдөгдөж буй экологийн дүрмүүдээс илүү өндөр шаардлагуудыг агуулж байх ёстой. Энэ зорилтын чухал үндсүүдийн нэг нь Киотогийн протокол мөн.

Даяаршлын нийгмийн ардчилал дэлхийн зах зээл дээр гарч буй эрсдэлүүдийг бууруулж тэдгээрийн үр дагавруудыг улс төрийн аргаар зохицуулах зорилтыг дэвшүүлж байна. Дэлхийн зах зээлд хариуцлага ногдуулах бодлогыг дараах стратегиудтай уялдуулах шаардлагатай:

1. Хөгжлийн бодлогын стратеги

Хөгжлийн бодлого дараах хоёр зорилтыг хэрэгжүүлэх ёстой:

Нэгдүгээрт: Бүх хүмүүсийн үндсэн эрхүүд дэлхийн өнцөг булан

бүрд баталгаатай байх ёстой. **Хоёрдугаарт:** Ядуу болон баян орнуудын иргэдийн хангалуун амьдралын өнөөгийн асар хол зөрүүг бууруулах ёстой.

Хөгжлийн бодлого даяаршлын харилцаан дахь тогтвортой байдал, харилцан хүндлэлийг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлдэг. Хөгжлийн бодлого нь өргөн утгаараа аюулгүй байдлын урьдчилан сэргийлэх бодлого бөгөөд цагаачлагчдын асар өргөн урсгал, цагаачдыг хүлээн авч буй орнуудын тэднийг нэгтгэхэд тулгарч буй бэрхшээлүүд, цагаачлагчдын зовлон зүдүүрийг нимгэлэхэд тусална.

Хөгжиж буй орнуудын төсөвт хөгжлийн тусламжийн мөнгийг шилжүүлэн хуваарилах нь дангаараа учир дутагдалтай. Энэ нь хээл хахууль, төрийн ангийн эрх мэдлээ бэхжүүлэх зорилгод зориулагддаг тул «муу» дэглэмүүдийг улам гааруулдаг. Хөгжлийн тусламж нь олон нийтийн таваарын хангамж, ардчиллыг бэхжүүлэхэд төвлөрөх ёстой. Үүргээ биелүүлэх чадамжтай эрүүл мэндийн систем, ерөнхий боловсрол, дээд боловсрол, орлогын эх үүсвэрийг бүрдүүлэх ажлын байрууд зэрэг нь улс орны ардчиллын хөгжилд түлхэц болох хүмүүсийн амьжиргааг дээшлүүлэхэд чухал ач холбогдолтой элементүүд юм. Эдгээр зорилтуудыг биелүүлэх түлхүүрүүд нь юуны түрүүнд Дэлхийн Худалдааны Байгууллагын бүтцүүдэд байдаг. ДХБ нь шийдвэр гаргалтын процессоо ардчилах шаардлагатай. Дэлхий дахинд худалдааны шударга журмыг тогтоох нь Брандтын илтгэлдээ нотолсны дагуу худалдааны хүчирхэг гүрнүүдийн хувьд ч ашиг сонирхолд нь нийцсэн шаардлага юм.

Түүнээс гадна ихэнх хөгжиж буй орнуудын хувьд хөдөө аж ахуйн салбар тухайн орнуудын эдийн засгийн хөгжил, ажлын байрыг бий болгоход голлох үүргийг гүйцэтгэдэг. Хөгжиж буй орнуудын хөдөлмөр эрхлэлтийн байдлыг дээшлүүлэхийн тулд хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнүүдийг баян орнууд уруу импортлох нөхцөлүүдийг хөнгөвчлөх шаардлагатай.

2002 оны Йоханнесбургийн том наймын уулзалтаас тогтвортой хөгжлийн бодлогын ерөнхий чиглэлүүдийг тогтоосон. Нэн түрүүнд баян орнуудаас ядуу орнууд уруу байгаль орчинд ээлтэй технологийг шилжүүлэх асуудлыг дэмжих тухай заажээ. Ингэснээр ядуу орнуудад байгаль орчны хамгааллыг сайжруулах зорилтыг эдийн засгийн өсөлтийн бодлоготой уялдуулах боломж бүрдэх юм.

2. Ардчиллыг дэмжих

Ихэнх ядуу буурай орнууд диктатурын дэглэмийн ноёрхлоос гарсан ч гажуудалтай ардчилал тогтсон байдаг. Ардчиллын судалгаагаар хөгжлийн хоцрогдол, улс төрийн тогтворгүй байдал хоорондоо холбоотой гэдгийг улс орнуудын туршлага дээр тулгуурлан баталсан байдаг. Энэ нь нэг талаас ардчилал эдийн засаг, нийгмийн хөгжил, хангалуун амьдралын хүрсэн түвшингийн шударга хуваарилалтыг дэмжиж байдагтай холбоотой. Нөгөө талаас эдийн засгийн амжилттай хөгжил нь эргээд улс төрийн оролцоо, ардчиллыг дэмжиж байдаг нь батлагдсан. Идэвхтэй хөгжлийн бодлого нь ардчилал ба эдийн засгийн хөгжилд дэмжлэг үзүүлдэг.

3. Эдийн засаг ба санхүүгийн бодлогын стратеги

Нэгдүгээрт: Дэлхийн зах зээлд хариуцлага ногдуулахын тулд Олон улсын Валютын Санг шинэчлэх шаардлагатай. ОУВС нь ноцтой хямрал үүссэн нөхцөлд шаардагдах хэмжээний эрүүлжүүлэх зээлийг олгох чадвартай байх ёстой. ОУВС хямралаас урьдчилан сэргийлэх салбарт үйл ажиллагаа явуулах ёстой. ОУВС-гаас улс орнуудын засгийн газруудад өгч буй зөвлөгөө ил тод, олон нийтээр шүүн хэлэлцэгдэх боломжтой байх ёстой. Зээллэгүүд тухайн улс орнуудын хөгжлийн шаардлагад нийцэж байх ёстой. Юуны түрүүнд ОУВС саналаа боловсруулах, зээлийн хэмжээг тогтоохдоо хөндлөнгийн хараат бус экспертүүдийн саналыг харгалзан үзэх шаардлагатай. ОУВС дотоод бүтцэдээ ядуу буурай

орнуудын ашиг сонирхлыг шударгаар тусгах хэрэгтэй. АНУ-ын хориг тавих онцгой эрхийг хүчингүй болгох асуудлыг тавих нь зүйтэй. Ихэнх донор орнууд ОУВС-нд дэлхийн баян хэсгийн төлөөлөл, ихэнх тусламж хүлээн авагч орнууд дэлхийн ядуу хэсгийн төлөөлөл тул санал хуваарилалтыг санал нэгтэйгээр шинэчлэх шаардлагатай. Даяаршлын банкны системийг бүс нутгийн хэмжээнд зохион байгуулах нь хамрагдагсдын ашиг сонирхлыг шударгаар харгалзан үзэхэд тус дөхөм үзүүлж болох юм.

Хоёрдугаарт: Дэлхийн Банк болон Олон Улсын валютын Сангийн үүргийг хянаж Дэлхийн Банк зөвхөн ядуурлыг бууруулах асуудлыг, ОУВС санхүүгийн хямралын асуудлыг тус тус хариуцдаг байхаар салгаж болох юм. ОУВС богино хугацааны зээл олгох чиглэлээр, Дэлхийн Банк бүтцийн хөгжлийн хөтөлбөрүүдийн удаан хугацааны санхүүжилтийн чиглэлээр тус тус ажиллах бололцоотой. Энэ санаа дээрх хоёр төсөл өрийг бууруулах, хөгжлийн төслүүдийн санхүүжилтийг бүрэн ялгаж салгахад тус дөхөм болно.

Гуравдугаарт: 1999 онд байгуулагдсан санхүүгийн тогтвортой байдлыг хангах чуулганыг дэлхийн санхүүгийн зохицуулалтын байгууллага болгон өөрчлөн байгуулж болох юм. Дэлхийн санхүүгийн урсгал нэмэгдэж байгаатай холбогдон дээрх байгууллагын зах зээлд хариуцлага ногдуулах үүрэг улам бүр нэмэгдэж байна. Мөн уг байгууллага нь нэг талаас үндэстэн дамнасан санхүүгийн урсгалыг зохицуулж нөгөө талаас уг байгууллагыг эрсдэлийн менежментийг хийх хэрэгслүүдээр хангаж өгөх шаардлагатай. Уг байгууллага нь зах зээлүүдийг ажиглах, хянах шаардлагатай тохиолдолд тэдгээрт хөндлөнгөөс оролцох эрхтэй байх ёстой.

Дөрөвдүгээрт: Эдийн засаг, нийгмийн асуудал эрхэлсэн НҮБ-ын аюулгүй байдлын зөвлөлийг байгуулах талаар

шинжлэх ухаан, улс төрийн хүрээнийхэн зөвшилцөлд хүрээд байна. Энэхүү зөвлөл даяаршлын эдийн засаг, нийгмийн үйл ажиллагаагаа үндсэн эрхүүдийн хэрэгжилттэй уялдуулж энэ чиглэлээр ажилладаг байгууллагуудад үйл ажиллагааны чиглэлүүдийг өгөх үүрэгтэй. Энэ байгууллага нь мөн хөгжиж буй орнуудад үйл ажиллагаагаа явуулж буй үндэстэн дамнасан концернуудын мөрдөх дүрмийг боловсруулах, тэдгээрийн хэрэгжилтэд хяналт тавих, шаардлагатай тохиолдолд шахалт үзүүлэхэд тохиромжтой байгууллага мөн.

4. Нийгмийн баримжаат даяаршлын стратеги

Нийгмийн болон эдийн засгийн үндсэн эрхүүдийг даяаршлын тавцан дээр хангах зорилгоор нээлттэй зах зээлүүдэд нийгмийн хариуцлага ногдуулдаг. Дээр тайлбарласнаар нийгмийн үндсэн эрхүүдийн хэрэгжилт тухайн улс орнуудын нийгэм, эдийн засгийн боломжуудаас хамааран заавал хэрэгжих бус харин алхам алхмаар хэрэгжих ёстой. Аж үйлдвэржсэн орнуудын зарим төлөөлөгчид олон улсын эрх зүйчдийн дээрх дүрмийг шүүмжилдэг. Тэд улс орнууд эдийн засаг, нийгмийн хөгжлийн түвшингээсээ үл хамааран нийгмийн үндсэн эрхүүдийг заавал хэрэгжүүлэх үүрэгтэй гэж үздэг. Тэгэхдээ дараах нотолгоог дэвшүүлэн тавьдаг: Улс орнуудад харилцан адилгүй нийгмийн хариуцлага ногдуулах нь зарим орнуудад өрсөлдөөний давуу тал олгодог гэж үздэг. Жишээ нь: Ажилгүйдлийн даатгалгүй орнууд цалингийн нэмэлт зардал багатай байдаг тул компаниуд ажиллах хүчнийг хямдаар худалдан авах боломжтой болдог. Үүний эсрэг гаргалгаа бол хөгжиж буй орнуудад нийгмийн үндсэн эрхүүдийг нэн даруй хэрэгжүүлэх үүргийг ногдуулах нь эдийн засаг, нийгмийн ноцтой асуудлуудыг үүсгэнэ. Энэ тохиолдолд дээрх орнууд цалингийн нэмэлт зардал багатай гэдэг тухайн цаг хугацааны өрсөлдөөний давуу байдлаа алдаж ингэснээр эдийн засгийн хөгжлийн боломжоо алдахад хүрч болзошгүй. Эдийн засгийн хөгжил нь нийгмийн эрхүүдийг баталгаажуулах суурь мөн.

НҮБ-ын нийгмийн эрхүүдийн тухай пакт болон тэдгээрийг хангах шаардлагуудад ажилчдын язгуур эрхүүд болон нийгмийн өргөтгөсөн стандартуудыг хооронд нь салгахыг шаарддаг. Ажилчдын язгуур эрх ашигт албадлагын хөдөлмөр, хүүхдийн хөдөлмөрийг ялгаварлан гадуурхах, эвлэлдэн нэгдэх эрх чөлөө, тарифын хамтын хэлэлцээр байгуулах эрх зэрэг хамаарагдана. Өргөтгөсөн нийгмийн стандартуудад (ажилгүйдэл, эрүүл мэнд, тэтгэвэр мөн хөдөлмөрийн зах зээлийн арга хэмжээнүүд болох шинээр мэргэшүүлэх, хөдөлмөрийн гэрээг шударгаар байгуулах, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ, ажлын цагийн дээд хязгаар, ажлын байрны эрүүл мэндийн хамгаалал, компанийн шийдвэр гаргалтад оролцох эрх зэрэг) нийгмийн даатгалын төрөл бүрийн хэлбэрүүд багтдаг. Ажилчдын язгуур эрхүүд эдийн засгийн өсөлт, чинээлэг амьдралыг дэмжиж байдаг бол өргөтгөсөн нийгмийн стандартуудын хэрэгжилт буурай хөгжилтэй улсуудын эдийн засгийн дэвшилд сөргөөр нөлөөлдөг тал бий. Иймээс нийгмийн стандартуудыг тэдгээрийн эдийн засгийн өсөлт, чинээлэг амьдралд нөлөөлөх үр дагавар талаас нь прагматик байдлаар шалгаж үзэх шаардлагатай. Нэн түрүүнд эдгээр нийгмийн стандартууд нь үйлдвэрлэлийн үр ашгийн тухайн түвшинд нийцэж байна уу? үгүй юу гэдгийг хянан үзэх нь зүйтэй. Уг түвшнээс хэт доогуур бус мөн хэт ачаалал үүрүүлэх хэмжээнд байж болохгүй.

Ажилчдын язгуур эрх ашигууд нь хөдөлмөрийн зах зээлийг зохих түвшинд үйл ажиллагааны чадамжтай байлгах зах зээлийн эдийн засгийн хөгжлийг хангах нөхцөлүүд мөн. Үүний нэг жишээ бол албадлагын хөдөлмөрийг хориглох нь хүний алдар хүндийг хамгаалах төдийгүй ажиллах хүчийг тухайн хүний мэдлэг чадварт тохирсон ажлын байранд ажиллуулах цаашилбал макро эдийн засгийн үр өгөөжийг дээшлүүлэхэд тустай. Хүүхдийн хөдөлмөрийг хориглох асуудал нь удаан хугацааны туршид хүний нөөцийг үр ашиггүй зарцуулахаас хамгаалдаг тул алсдаа мөн нийт эдийн засгийн үр өгөөжийг

дээшлүүлэхэд хувь нэмрээ оруулдаг. Үүнээс ажилчдын язгуур эрх ашигуудыг нэн даруй хангах нь тухайн улс орны эдийн засгийн хөгжилд дэмжлэг үзүүлдэг. Харин нийгмийн өргөтгөсөн стандартуудыг тухайн орны эдийн засгийн хөгжилтэй уялдуулан дэс дараатайгаар хангаж болно.

Өнөө үед ажилчдын язгуур эрх ашиг болон нийгмийн стандартуудын хэрэгжилтийн дараах таван стратегиуд өрсөлдөж байна:

1. Эдийн засаг, нийгэм, соёлын эрхүүдийн олон улсын пактын хяналтын механизмууд: Уг пактад гарын үсэг зурсан орнууд таван жил тутамд үндсэн эрхүүдийн хэрэгжилтийн тухай илтгэлийг бичиж өгч байх үүргийг хүлээдэг. Тэдний илтгэлд Эдийн Засаг, Нийгэм, Соёлын эрхүүдийн хороо үнэлгээ хийдэг. Уг үнэлгээгээр дээрх эрхүүдийг илүү сайн хангах тухай зөвлөмжүүдийг өгч болно. Шахалт үзүүлэх хамгийн хурц хэлбэр бол НҮБ-ын хүний эрхийн комиссоос тухайн орон эрхийг ноцтой зөрчсөн тухай буруушаасан тогтоол гаргадаг.

2. Олон улсын хөдөлмөрийн байгууллагын норм тогтоох-хяналт шалгалтын аргачлал: ОУХБ нь нийгмийн болон эдийн засгийн эрхүүдийн хэрэгжилтэд хяналт тавьдаг. Өөрөөр хэлбэл ОУХБ үндсэн эрхүүдийн томъёоллыг улам тодорхой болгож нийгмийн стандартуудыг тодорхойлж тэдгээрийг хэрэгжүүлэхэд шаардагдах мэдээллээр улс орнуудыг хангаж зарим орнуудын хэрэгжилтийн байдал хангалтгүй бол олон нийтийн зүгээс шахалт үзүүлэх ажлыг зохион байгуулдаг.

3. Нийгмийн шаардлагуудыг Дэлхийн Худалдааны Байгууллагын гэрээний бүрэлдэхүүн хэсэг болгон тусгуулах: Зарим аж үйлдвэржсэн орнууд нийгмийн стандартуудыг ДХБ-ын гэрээний нөхцөлүүдэд тусгуулахаар төлөвлөөд байна. Тэд нийгмийн стандартуудын нэлээд хэсгийг хангасан улс орнуудад

оролцогч орнуудын зах зээлд нэвтрэх боломж олгох шаардлагыг тавьж байна. Зарим орнууд нийгмийн стандартуудыг зөрчсөн тохиолдолд ОУХБ-ын дэглэмийн дагуу тодорхой хугацаагаар зах зээлд нэвтрүүлэхгүй байх аж. Хөгжиж буй орнууд дээрх санал нь өрсөлдөх чадварт сөргөөр нөлөөлж болзошгүй гэж болгоомжилж буй учраас татгалзаж байна.

4. Үндэстэн дамнан уйл ажиллагаа явуулж буй компаниудын харьцааны ёс зүйг баримтлах. 1998 он гэхэд ОУХБ-д компаниудын харьцааны ёс зүйн 215 зүйл бүртгэгдсэн байна. Эдгээр нь олон төрөл зүйлтэй, маш тодорхой томъёологдсон байдаг. Тэдгээрийн хэрэгжилт компаниудын ажилчдын зөвлөл, иргэний нийгмийн бүлгүүд, олон нийтийн зүгээс үзүүлэх шахалтын хэмжээнээс хамаардаг. Өнөөг хүртэл нийгмийн үндсэн стандартуудыг хангахад шахалт үзүүлэх чадамжтай дэлхий дахинд мөрдөгдөх компаниудын харилцааны ёс зүйн кодексийг батлан гаргаж чадаагүй байна.

5. Нийгэм болон байгаль орчны шаардлагыг хангасан үйлдвэрлэлийн хэлбэрүүдэд чанарын дардас олгох. Нийгмийн таваарын чанарын тэмдгийг зарчмын хувьд иргэний нийгмийн байгууллагуудын зүгээс нийгмийн болон байгаль орчны стандартуудыг хангасан бүтээгдэхүүнүүд болон компаниудад олгоно. Худалдан авагчид уг чанарын тэмдгийг үндэслэн бүтээгдэхүүнээ сонгох нь нийгмийн болон байгаль орчны бусад стандартуудыг хангахад дэмжлэг болно.

5.5. Нийгмийн ардчилал Европ тивд

Сөрөг даяаршил нь дээр дурдсанчлан улс үндэстний түвшинд улс төрийн удирдлагын чадамжийг үлэмж бууруулсан. Цаашид гишүүн орнууд Европын Холбооны түвшинд улс төрийн удирдлагын чадамжаа дахин сэргээж чадах эсэх, Европын эрх мэдлийг эерэг даяаршлын дэвшлийн төлөө ашиглах боломж бий эсэх асуудлууд тавигдаж байна.

Зах зээлийг зохицуулах нийгмийн болон улс төрийн эрх мэдлийг эргүүлэн тогтоох боломжтой юу? Европын Холбоо нийгмийн ардчиллын төсөлд нийцтэй байх хоёр үндсэн шинжийг агуулж байгаа юмс **Нэгдүгээрт:** Хэдийгээр харилцан адилгүй түвшинд байгаа боловч бүх гишүүн орнууд нийгмийн ардчиллын төслийн элементүүдийг дагаж мөрдөж байгаа юм. **Хоёрдугаарт:** Европын хамтын нийгэмлэг эерэг нэгдлийн бодлогыг амжилттай хэрэгжүүлэх улс төрийн байгууллагуудтай юу? (Парламент, комиссууд, шүүхийн товчоо, Зөвлөл, Төв банк гэх мэт). Эдгээр байгууллагуудын тусламжтайгаар өнөөг хүртэл хэрэгжиж ирсэн сөрөг нэгдлийн гажуудлыг засах боломжтой.

Хэрэв Европын Холбооны түвшинд зах зээлийг зохицуулах улс төрийн эрх мэдлийг эргүүлэн тогтоож чадвал эдийн засгийн даяаршлаас үүдэлтэй ардчиллын гажуудлыг залруулах ихээхэн боломж нээгдэнэ гэсэн үг. Ингэснээр гишүүн орнуудад эдийн засгийн даяаршлын зүгээс ирж буй дарамт ч ихээхэн багасах боломжтой.

Европын Холбооны үйл ажиллагааны чадамж нь даяаршлын түвшинд улс төрийн зохицуулалтын чадамжийг дахин бий болгох нөхцөлийг бүрдүүлэх юм. ЕХ нь үндэстэн дамнасан дэвшилттэй ардчиллын загвар байх боломжтой. Европын түвшинд зах зээлд хариуцлага ногдуулах асуудал амжилттай шийдэгдвэл эерэг даяаршлын загварыг хэрэгжүүлэх боломж мөн нэмэгдэнэ.

Европын Холбооны хүрээнд үйл ажиллагаа явуулах боломжуудыг нухацтай ажиглахад одоогийн бэрхшээлүүд Европ тивд нийгмийн ардчилал бусад үзэл баримтлалуудаас тодорхой ялгарах хугацаа холгүй байгааг харуулж байгаа юм. Европын нэгдлийн түүхэнд өмнө нь тохиолдож байгаагүй амжилттай нэгдэл нь өнөөг хүртэл сөрөг нэгдэл, нэгдсэн зах зээлийг бүрэлдэн тогтоход улс үндэстнүүдийн зүгээс учруулж

буй саадыг арилгасан түүх юм. Эдийн засгийн зохицуулалттай, нийгмийн баримжаат төрийн нэгдэл зах зээлийн нэгдлээс хоцрогдсон хэвээр байна. Фритц В. Шарф судалгаандаа Европ тивд нийгмийн ардчилал онцгой ач холбогдолтой гэдгийг нотлох дөрвөн уялдаа холбоог тодорхойлсон байна:

Нэгдүгээрт: Өнөөг хүртэл явагдсан нэгдлийн процессууд чөлөөт зах зээл ба улс төрийн удирдлагын чадамжийг нэмэгдүүлэхэд ихээхэн түлхэц болсон байна. Европын комисс болон Европын нэгдсэн шүүх үндэсний зах зээлүүдэд гарахад учрах бэрхшээл саадыг дэс дараатайгаар арилгасаар иржээ. Европын эрх тогтоох бодлогод либертар зах зээлийн төсөөллийг удирдлага болгосон. Ингэснээр улс үндэстнүүдийн нийт эдийн засгийн салбартаа төлөвлөлт, зохион байгуулалт хийх боломж улам хязгаарлагдсаар байна. Өдгөө Европын Холбоонд улс үндэстний болон европын холбооны түвшинд нөлөө бүхий зохицуулалтын механизм бий болоогүй байхад эрх зүйн хувьд баталгаажсан чөлөөт зах зээл тогтчихоод байна.

Хоёрдугаарт: Европын эрх зүй гишүүн улсуудад шууд мөрдөгдөөд зогсохгүй улс үндэстнүүдийн эрх зүй, түүнчлэн үндсэн хуулийн эрх зүйгээс ерөнхийдөө давуу эрхтэйгээр мөрдөгдөж байна. Энэ байдал европ тив даяар либерал ардчиллын зах зээлийн ерөнхий зарчмууд хүчин төгөлдөр болгоход хүргэжээ. Улс үндэстний түвшинд оршин байсан нийгмийн ардчиллын холимог эдийн засгийн төсөөлөл хууль ёсны бус болж эрх зүйн хүрээ нь хумигдсаар байна. Комисс, шүүхийн товчоонууд гишүүн орнуудын засгийн газруудын оролцоогүйгээр анхдагч гэрээ хэлэлцээрүүдийг буруу тайлбарлаж ирсэн нь энэхүү үр дүнд хүргэжээ.

Гуравдугаарт: Европын холбоонд үр уршиг ихтэй хэрээс хэтэрсэн тэгш бус байдал газар авчээ. Нэг талаас сөрөг нэгдлийн арга хэмжээнүүд улс үндэстнүүдийн засгийн газруудын

зөвшөөрөлгүйгээр хэрэгжсэн байхад эерэг даяаршлын бүх арга хэмжээнүүдийг явуулахын тулд (зах зээлийг засварлах арга хэмжээнүүд гэсэн үг) улс үндэстнүүдийн засгийн газруудын зөвшилцөл шаардлагатай. Энэ нь эерэг даяаршлын арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг либерал зах зээлийн бодлоготой харьцуулахад маш бэрхшээлтэй болгож байгаа юм.

Дөрөвдүгээрт: Эдийн засгийн макро удирдлага, нийгмийн бодлого, хөдөлмөрийн зах зээлийн бодлого, экологийн бодлого, боловсролын бодлого зэрэг нийгмийн ардчиллын бүхий л чухал концепцууд эерэг нэгдлийн салбарт багтдаг. Дээрх бодлогын салбаруудад сайд нарын зөвлөл дэх улс орнуудын засгийн газруудын төлөөлөгчид санал нэгдсэн байх ёстой. Санал нэгдэх асуудалд улс орнуудын эдийн засгийн төрөл бүрийн сонирхлууд, үзэл санааны байр суурь, байгууллагуудын бүтэц зэрэг саад учруулдаг. Иймээс дээр дурдсан тэгш хэмт бус байдал нь нийгмийн ардчиллын төсөлд сөрөг нөлөө үзүүлдэг.

Дээрх дөрвөн бэрхшээлээс гадна Европын бүх засгийн газрууд Европын нэгдсэн бодлогын хөгжлийн хөтөлбөрийг баримтлах боломжгүй, улс үндэстнүүд байнга өөрийн үндэсний ашиг сонирхолд баригдаж байдаг нь нөлөөлж байдаг.

Энэ бүхнээс дүгнэлт хийхэд европ тив даяар нийгмийн ардчиллыг тогтооход Европын хэмжээнд өнөө оршин байгаа бүтэц хангалттай бус гэдэг нь харагдаж байна. Харин тив даяар дагаж мөрдөх нийгмийн стандартууд, ерөнхий нөхцөлүүдийн тухай дүрмүүдийг Европын Холбоо тогтооно гэдэг хүлээлт илүү бодитой юм. Уг стандартууд, ерөнхий дүрмүүдийг дараа нь улс үндэстнүүдийн засгийн газрууд нийгмийн бодлогоороо дамжин хэрэгжүүлэх ёстой. Нийгмийн хамгаалал нь цаашид ч нэлээд удаан хугацаанд улс үндэстнүүдийн үндэсний бодлогын төсөл хэвээр байх болно. Учир нь нийгмийн хамгааллын системүүдийн бүтэц, санхүүжилт улс орон бүрд эдийн засгийн бүтээмжийн нэгэн адил хоорондоо маш ялгаатай байдаг.

2004 оны 6-р сард Европын Холбооны төр засгийн тэргүүнүүд европын холбооны анхны үндсэн хуулийг батлан гаргасан. Уг үндсэн хууль Хүний болон иргэний эрхүүдийн чарта, европын холбооны комиссуудыг үйл ажиллагаа явуулахад шаардагдах бүх иргэдийн шаардлага зэрэг нийгмийн ардчиллын чухал элементүүдийг багтаадаг.

Европын нэгдсэн нийгмийн бодлогын хэтийн хандлага

Европын засгийн газрууд нийгмийн бодлогын салбартаа өнөөгийн байдлаар тодорхой хязгаарлалтууд тогтоогоод байна. Учир нь нийгмийн бодлого нь улс орнууд үндэснийхээ бодлогыг хууль ёсны хэмээн хүлээн зөвшөөрүүлэх, сонгогчдын саналыг авахад шийдвэрлэх ач холбогдолтой бөгөөд нөгөө талаас олон үндэстний түвшинд үндэсний чадавхыг тодорхой хязгаарлалтуудын хүрээнд хадгалж байхад хэрэгтэй юм.

Улс үндэстнүүдийн нийгмийн бодлогын үзэл санааны үндэслэлүүд нь нийгмийн баримжаат төрийн хамгааллын өндөр түвшинд хүрсэн түүнийгээ хэвээр хадгалах улмаар өндөр түвшинд хүргэхийг эрмэлзэж буй иргэдийн болон иргэдийн өөрийн хариуцлагыг нэмэгдүүлэхийг эрмэлзэж буй засгийн газруудын хооронд харилцан адилгүй байдаг. Үүнээс гадна төрийн нийгмийн хамгааллын арга хэмжээнүүдийн санхүүжилтийн түвшин тухайн орны эдийн засгийн хөгжлийн түвшингээс хамаардаг тул харилцан адилгүй байдаг. Цаашилбал улс орнуудын нийгмийн хамгааллын бүтцүүд өөр өөр арга хэмжээнүүд дээр (тэтгэвэр, эрүүл мэнд, гэр бүл гэх мэт) онцгойлон төвлөрсөн байдаг тул бүтцийн ялгааг анхаарлын гадна орхиж болохгүй. Байгууллагуудын ялгаа нь санхүүжилтийн системүүд болон нийгмийн сайн сайхны төлөөх бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн (олон нийтийн, нийтийн тусын төлөө ашгийн бус эсвэл хувийн байгууллагууд) өөр өөр хэлбэрээр илэрдэг.

Европын нэгдсэн нийгмийн хамгааллын системд шилжих үйл явц улс орон бүрд үндсэн өөрчлөлтүүд хийх буюу өөрөөр хэлбэл нийгмийн баримжаат төрийн байгууллагуудын өөр системд шилжихийг шаардана. Жишээ нь: Татвараас санхүүждэг эрүүл мэндийн албатай байсан улс хувийн эмч нарын хөрөнгөөр санхүүжих даатгалын системд шилжих, эсвэл татвараас санхүүждэг үндсэн тэтгэвэр орлогын хэмжээнээс хамаарах тэтгэврийн даатгалд шилжих гэх мэт.

Нэгдсэн зохицуулалтын эерэг нөхцөлүүд бол Европын бүх орнуудад нийгмийн арга хэмжээнүүдийн бодит зардалд гайхалтай зохицож буй байдал. Эдийн засаг, хөгжлийн хамтын ажиллагааны байгууллагын тоо баримтууд хэдийгээр баян орнууд ядуу орнуудтай харьцуулахад ДНБ-нийхээ илүү хувь хэмжээг нийгмийн хамгаалалдаа зарцуулдаг боловч зөвхөн Европын Холбооны хүрээнд чинээлэг амьдрал, нийгмийн хамгааллын арга хэмжээний зардал хоёрын хооронд шууд хамааралтай гэдгийг харуулж байна. Европын Холбооны онцгой харьцааг гишүүн орнуудын хоорондын далд зөвшилцлийн үр дүн хэмээн тайлбарлаж болох бөгөөд үүний үндсэн дээр нийгмийн баримжаат төрийн ач холбогдол тухайн орны чинээлэг амьдралын түвшинтэй шууд хамааралтай өсөх болно. Дээрх зөвшилцлийн үр дүнд нийгмийн хамгааллын арга хэмжээний зардал нэгэн тодорхой босго хувь хэмжээнээс доош байж болохгүй гэдэг тодорхой тохиролцоонд хүрч чадвал нийгмийн хамгааллыг зохих түвшнээс дор ортол бууруулахаас хамгаалах болно.

Дээрх тохиолдолд Европын нийгмийн бодлого эерэг нэгдлээр тодорхойлогдох хэмжээнд хүрэхгүй ч Европын нийгмийн баримжаат төрийн сонгодог хэлбэр болж чадахгүй ч гэсэн олон орнуудын туршлага, практикт хамгийн сайн хэрэгжсэн жишээнүүдийг хэрэгжүүлэх замаар Европын нийгмийн баримжаат улсуудад өдгөө тулгараад байгаа

бэрхшээлүүдийг шийдвэрлэж чадах тодорхой түвшинд дөхөж очих бололцоотой юм. Үүний тулд олон нийтэд төдийлөн таалагдахгүй зарим шийдвэрүүдийг богино хугацааны дотор гаргах шаардлагатай. Эдгээр шийдвэрүүд олон нийтийн дэмжлэгийг хүлээх магадлал багатай тул гарах магадлал мөн багатай. Иймээс энэ хариуцлагыг хүлээх европын нэгдсэн дүрмүүдийг даган биелүүлэхээс өөр зам үлдэхгүй бөгөөд энэ тохиолдолд европын нийгмийн бодлогын олсон амжилтын тодорхой хэсэг ч гэлээ хадгалагдан үлдэх юм.

Нийгмийн баримжаат төрийн шинэчлэлүүдийг хийх шийдвэрийг улс үндэстнүүд гаргавал нэгдсэн нэг шийдэлд хүрэхгүй ч европ тивийн хэмжээнд нийгмийн бодлогын зохицуулалтыг нэвтрүүлэхэд тус дөхөм болно. Үүний тулд эхний ээлжид Европын нийгмийн системүүдийн ирээдүйн ерөнхий бүтцийн тухай зарчмын нэгдсэн ойлголтод хүрэх ёстой бөгөөд энэ нь үндэсний зохицуулалтын системийн зарим дэд салбарууд хоорондоо ойртоход хүргэж болох юм. Хоёрдох алхам бол системүүдийг хамтран баталсан нэгэн загварт ойртуулах явдал бөгөөд энэ нь хэдийгээр хоорондоо ялгаатай хэвээр байх боловч аажимдаа байгууллагуудын олон хэлбэр удаан хугацааны туршид оршин тогтнох боломжийг алсуураа хязгаарлах болно. Европын нэгдсэн загварт ойртох, түүнийг бүх улс орнуудад хэрэгжүүлэхэд урт хугацаа шаардагдах нь ойлгомжтой.

5.6 Даяаршил нээлттэй процесс мөн.

Эерэг даяаршил бол ерөнхийдөө нээлттэй процесс. Нэгэн цагт тохиролцсон зохицуулалтын бодлого бүхий л цаг хугацааны туршид өөрчлөгдөхгүй байх боломжгүй. Уг бодлого нь шинэ шинэ туршлага мэдлэгээр байнга баяжуулагдан хөгжиж байх учиртай. Олон нийтийн таваарыг бий болгодог учраас бүхний анхаарлын төвд байдаг зохицуулалтын бодлого нь өөрөө тогтвортой бус байдаг. Даяаршлын нийгмийн нөхцөлүүд улс

төрийн ороо бусгаа байдал, улс орнуудын байнга өөрчлөгдөж байдаг ашиг сонирхлууд нь даяаршлын бодлогыг цаг үеийн үйл явдалд нээлттэй бодлого болгон хувиргадаг. Зарчмын энэхүү нээлттэй байдал дээр нийгмийн ардчиллын бодит онол суурилах ёстой.

Хэдийгээр нээлттэй байдал бодит үнэн мөн боловч **«best case scenario»** хамгийн сайн найруулгыг хийх боломж бас бий. Уг боломж эерэг даяаршлыг тогтоох, ойрын ирээдүйд хэрэгжих боломжтой саналуудаас бүрддэг. Жишээ нь: Үндэстэн дамнасан санхүүгийн урсгалуудыг удирдаж байх даяаршлын санхүүгийн хяналтын байгууллагыг байгуулах бололцоо харагдаж байна. Мөн ОУХБ-ын стандартууд болон Киотогийн протоколын дагуу нийгмийн болон экологийн стандартуудыг хангах боломж бүрдэх бололцоотой. Гуравдагч зарчмын хувьд хэрэгжих боломжтой салбар бол дэлхийн худалдаанд илүү шударга дүрмүүдийг мөрдөх, үндэстэн дамнасан компаниудын үйл ажиллагааны харьцаанд тавих хяналтыг сайжруулах.

Даяаршсан дэлхий дээр бодлогын бүх салбарт дараах хоёр дүрэм мөрдөгдөнө:

Нэгдүгээрт: Ардчиллын норматив үндсэн элементүүд, үндсэн эрхийн хэрэгжилт, эдийн засгийн зохицуулалт, нийгмийн хамгааллын баталгаажих доод түвшин зэрэгт үр дүнгийн үүрэг хариуцлагууд (**obligations of result**) ногддог. Тэдгээрийг нэн даруй дагаж мөрдөх ёстой.

Хоёрдугаарт: Нийгмийн хамгааллын түвшин, нийгмийн оролцооны боломжийн хуваарилалтын хэмжээ, орлого болон хөрөнгөөс хамаарах амьдралын боломжийн хуваарилалт нь улс төрийн үйл ажиллагааны зорилт болгон дэвшүүлэх хариуцлагыг (**obligations of conducts**) ногдуулдаг. Тэдгээрийн хэрэгжилт тухайн үеийн боломжоос хамаардаг.

Нийгмийн ардчиллын онол бодит байдлаас суралцаж онолын хэрэгслүүдээ тухайн үеийн нийгмийн нөхцөлүүдэд тохируулан хэрэглэхийг зорьж байна. Иймээс нийгмийн ардчиллын онол тодорхой тогтсон норматив үндэслэл дээр суурилдаггүй, нийгмийн шинэ өөрчлөлт хувьсалд тохирсон хариултыг эрэлхийлж байдаг. Дараах хоёр зорилтууд хоорондоо нягт холбоотой: Ардчилалд нийгмийн хариуцлага ногдуулж илүү ардчилсан болгох ингэснээр эдийн засгийн үр өгөөжийг дээшлүүлэх, нийгмийн нэгдэл, ардчиллын тогтвортой байдалд хувь нэмрээ оруулж байдаг.

Улс төрийн соёл VI

Нийгмийн ардчиллын онолын зарим төлөөлөгчид нийгмийн ардчилал нь үндсэндээ улс төрийн соёл юм, уг онолыг бүхэлд нь авч үзвэл улс төрийн соёлын нэгэн хэлбэр мөн гэж нотолцгоодог. Тэд өнөөгийн нөхцөлд нийгмийн ардчилал нь иргэний нийгмийн улс төрийн төсөлтэй адил гэдэг санаагаа энэ нотолгоогоороо давхар илэрхийлээд байгаа юм. Хэдийгээр дээрх нотолгоо нийгмийн ардчиллын концепцын нэгэн чухал элемент мөн боловч дэндүү явцуу юм. Нийгмийн ардчилал улс төрийн соёлын хүрээлэлд оршиж, улс төрийн соёл уг онолыг хууль ёсны болгож, бүрдүүлж, хадгалж байдаг. Гэхдээ нийгмийн ардчилал илүү өргөн утгатай. Нийгмийн ардчилал бол нэн түрүүнд эрхүүдийн систем, байгууллагууд болон үйл ажиллагааны хөтөлбөрүүд бүхий хэрэгжүүлэгч байгууллагуудтай улс төрийн бүтэц юм. Нийгмийн ардчиллын загвар нь иргэний нийгмийн улс төрийн төсөл төдий байх юм бол улс төрийн соёлын хувьд коминтаризм, эсвэл иргэний нийгмийн либертар хувилбар төдий зүйл байхсан. Ийм нөхцөлд нийгмийн хамгаалал зөвхөн нийгмийн иргэдийн идэвх зүтгэлийн тухайн үеийн байдлаас хамаарах болно. Нийгмийн ардчиллын төсөл нь төгс хэрэгжсэн нөхцөлд улс төрийн хувьд хэрэгжүүлэгч бүтэцтэй, төрийн зүгээс шахалт

үзүүлэх эрх мэдлээр баталгаажсан компаниудын шийдвэр гаргалтад ажилчдын оролцооны эрх, нийгмийн хамгаалалд хамрагдах эрх гэх мэт эрхүүд баталгаажсан байдаг.

Аливаа нийгмийн улс төрийн соёл бол хамтын үнэлэмж, чиг хандлага, байр суурь, дадал заншил, хамтын үйл ажиллагаанд оролцох бэлэн байдал зэрэг шинж чанаруудын улс төрийн эерэг нэгдэл мөн. Улс төрийн соёл бодит байдал, улс төрийн ерөнхий зарчим бүрийн үүргээ гүйцэтгэх чадамж, нөлөөлөлд шийдвэрлэх үүрэгтэй юм.

Нийгмийн ардчилал бол либертар ардчилалтай харьцуулахад улс төрийн соёлын тусгай элементүүдийг хэрхэн тодорхойлж байгаагаас шууд хамаардаг:

Нэгдүгээрт: Улс төрийн соёл нь улс төрийн эв санааны нэгдэлтэй үйл ажиллагаа явуулах орчныг бүрдүүлж нийгмийн өөрийгөө захирах иргэний нийгмийн хэлбэрүүдийг дэмжиж байх ёстой.

Хоёрдугаарт: Улс төрийн үндсэн эрхүүдийн хэрэгжилт, тэдгээрийг хангах зорилт бүхий улс төрийн үйл ажиллагааны хөтөлбөрүүдийг дэмжих улс төрийн олонхыг бүрдүүлэх ёстой.

Гуравдугаарт: Улс төрийн соёл олон нийтийн мэтгэлцээнд байнгын дэмжлэг үзүүлж байх ёстой. Олон нийтийн мэтгэлцээн ашиг сонирхлын өрсөлдөөн, тэдгээр дээр суурилсан улс төрийн үйл ажиллагааны хөтөлбөрүүдэд олны анхаарлыг хандуулж шударга ёсны ойлголтын тухай мэтгэлцээнийг өдөөж байх ёстой.

Дөрөвдүгээрт: Улс төрийн соёлд харилцан ойлголцолд чиглэсэн мэтгэлцээнүүдийг өрнүүлж байх олон нийтийн орон зай хэрэгтэй. Зөвшилцөл болон зөрчилдөөний зохистой

тэнцвэрийг хангах хүсэл эрмэлзэл улс төрийн соёлд байх ёстой.

6.1 Нийгмийн ардчиллын түгээмэл байдал

Нийгмийн ардчиллын түгээмэл байх шаардлагыг зөвхөн төрийн хэлбэр төдий бүтцүүд, зохион байгуулалтын хэлбэрүүд, нийгмийн үүргийн системүүдийн хүрээнд авч үзэж болохгүй. Уг шаардлага нэн түрүүнд улс төрийн соёлын түвшинд тавигддаг. 1960-аад оноос хойш хийгдсэн улс төрийн соёлын судалгаануудын үр дүн ардчиллын улс төрийн соёлд өөрийн байр сууриа баттай эзлээгүй хэлбэр төдий ардчилсан бүтцүүд үүргээ биелүүлэх чадамжгүй эсвэл удаан хугацаанд оршин тогтнох чадваргүй гэдгийг харуулж байна. Энэ утгаар нь авч үзвэл ардчилал нь соёлын хувьд төвийг сахисан бус юм. «Барууны соёлыг» ардчилалтай адилтгах, барууныг дэмжигчдийн зүгээс «барууны эсрэг» өрсөлдөгчид гэж үздэг нь үндэслэлгүй юм. Либерал ардчиллыг тогтооход шаардагдах улс төрийн соёл энэ дэлхийн шашинлаг үзэл давамгайлсан шашны онцлог соёлын уламжлалыг агуулсан байх төдийгүй харин нийгмийн хариуцлагын үндсэн нормуудыг орчин үеийн соёлд суулгаж өгөх явдал юм. Эдгээр нь үйл ажиллагааны бүх салбаруудад зөрүүтэй байдлыг зохицуулах шударга дүрмүүд дээр суурилдаг.

Дээрх судалгаагаар 9-р зууны үеэс Европ тивд бүрэлдэн тогтсон барууны уламжлал ардчиллыг төрүүлээгүй бөгөөд харин орчин үеийн соёлд шилжих шилжилтийн улмаас уг уламжлал эрс өөрчлөгдсөнөөс ардчилал төрсөн гэдэг түүхэн нотолгоо тодорхой болсон. Соён гэгээрэл, 18-р зууны Франц, АНУ-ын ардчилсан хувьсгал ардчиллын соёлын үндсийг бүрдүүлсэн байна. Хүний эрх болон ардчилал нь орчин үеийн автономит нотлогдошгүй нөхцөлөөс эхтэй.

Улс орнуудын туршлагад хийсэн дүн шинжилгээнүүд: Орчин үеэс өмнөх соёлыг задран унахад амьдралын хэв маяг, шашин,

улс төрийн дэглэмүүдийн хооронд ялгаанууд үүссэн. Эдгээр ялгаанууд эрх мэдэлтнүүдийн заавраар үнэн мөний эх үүсвэрт нэвтэрснээр батлагдах боломжгүй юм. Дэлхийн шашин ба соёлын уламжлал нь орчин үеийн соёлын өмнөх соёл задран унах үед орчин үеийн улс төрийн болон соёлын үнэт зүйлсэд чиглэсэн либертар урсгал бий болж байсныг харуулдаг. Нэгэнт үүссэн ялгаатай байдлыг ойртуулах тухай шийдвэр нь нэн даруй хамрагдсан хүмүүсийн хувийн болон олон нийтийн автономийн тухай асуудал болон хувирдаг. Зөвхөн хүний эрхүүд болон ардчилал хамтын хэв журмын дээрх ялгаануудыг арилгах соёлын нормууд болон техник болон үлддэг. Орчин үеийн либерал соёл нь «барууны» соёлын дотор аль ч үед маргаангүй байж чадах сүлжээг бий болгож чадаагүй бол харин либералчлагдах чиг хандлага нь бусад чиг хандлагуудтай харьцуулахад тухайн нийгмийн онцлог туршлага, тулгарсан бэрхшээлүүдийн хүрээнд шашинлаг соёлын уламжлалыг илүү идэвхжүүлдэг ажээ. Либерал, уламжлалт болон фундаменталист иргэншлүүдийн хэв маягуудын хоорондын ялгаа нь өнөө үед соёлын бүхий л төрлүүдийн бүрэлдэн тогтох зарчим юм. Улс төрийн үндсэн асуудал нь либерал ардчиллын байр суурийн тухай асуудал болно. Фундаменталист үзлийг баримтлагсад либерал ардчиллын үндсүүдийг үндсэндээ үгүйсгэж эсвэл тэднийг ихээхэн товчилдог. Үүнд тэдний бүтцийн зарчим оршдог. Баруунд ч нэгэн адил фундаменталист үзлийг баримтлагсад байдаг бөгөөд тэд нар хүний эрхүүд болон ардчиллыг эсэргүүцэгчид юм. Ийм ч учраас «барууны» соёл болон ардчилал нь адил зүйл гэдэг нотолгоо батлагдах боломжгүй гэдэг нь харагдаж байна.

Сүүлийн хориод жилийн дотор хийгдсэн олон судалгааны ажлууд дэлхий дээр өдгөө оршин буй бүхий л соёлын төрлүүдэд харилцан адилгүй нэр томъёогоор илэрхийлэгдсэн байдаг боловч хүмүүс хоорондын эрх ба үүрэг хариуцлагын нөхөн үйлдвэрлэлийн зарчмууд үнэлэмжийн системд

тусгагдсан байдгийг харуулсан. Хүмүүс хоорондын харилцан туслалцааны үүргийг илэрхийлэх эв санааны нэгдлийн тухай ойлголт ч мөн адил. Соёлын бүхий л хэлбэрүүдийн дунд хамгийн оройдлоо гэхэд 20-р зууны үеэс иргэний нийгмийн дунд улс төр болон сэхээтнүүдийн мэтгэлцээнүүдэд үндсэн эрхүүд болон ардчиллын үнэлэмжүүдийг басамжлагчдаас хамгаалдаг цаашид хөгжүүлэхийг эрмэлздэг идэвхтэй бүлгүүд бүрэлдэн бий болсон байна.

Орчин үеийн Энэтхэг улс олон талаар үлгэр жишээ болохуйц орон мөн. Ганди, Неру нар хэдийгээр олон гажуудалтай боловч хагас зуун жилээс удаан хугацаагаар ерөнхийдөө үүргээ гүйцэтгэн хэрэгжиж буй либерал ардчиллыг байгуулсан байна. Энэтхэг орныг богино хугацаанд тогтворгүй байдал үүссэнийг эс тооцвол тогтвортой ардчилал гэж хэлж болно. Энэтхэг улс зарим нэг онцгой тохиолдлуудыг эс тооцвол зорилготойгоор улс төрийн зөрчилдөөнийг намжаах стратегийг амжилттай хэрэгжүүлдэг. Жишээ нь: Эрх зүйт төрт ардчиллын хүрээнд хинди болон исламын шашинтнуудын хооронд хамтын ажиллагааг хөгжүүлсэн. Хинди болон исламын шашинтууд тэдний захын фундаменталист бүлгүүдийг эс тооцвол либерал ардчилал, түүний үнэт зүйлсийг дэмждэг.

6.2 Соёлын ялгаатай талууд болон социал иргэний нийгэм

Иргэдийн олонх дараах чиг хандлагуудыг дэмжиж байх тохиолдолд ардчилал тогтвортой байдаг.

- Иргэд бусад иргэддээ итгэдэг байх
- Өөрсдийн амьдарч буй улс төрийн системийг сэтгэл хөдлөл болон хамтын үнэлэмж талаас нь хүлээн зөвшөөрдөг байх
- Улс төрийн системийн дотор хувь хүртэх боломжоо ашиглах болон өөрийн хариуцлагаа ухамсарладаг байх
- Идэвхтэй уян хатан байх

- Зарим асуудлын улмаас үүссэн зөрчилдөөнийг шийдвэрлэхэд ардчиллын үндсэн итгэл үнэмшлийн үүднээс ханддаг байх
- Улс төрийн санал зөрүүтэй байдал болон хүмүүсийг хүлээн зөвшөөрөх байдал хоёрыг хооронд нь ялгаж салгах чадвартай байх

Олон талт соёлтой нийгэмд дээрх минимал каталогийг хоёр хэмжигдэхүүнээр баяжуулах шаардлагатай: **Нэгдүгээрт:** бүх иргэд нийгэм хамт олны дунд өрнөж буй олон нийтийн мэтгэлцээнд оролцох боломжоор хангагдсан байх, **Хоёрдугаарт:** итгэл, уян хатан байдал, харилцан хүндлэлийг үндэстний соёлын болон соёл ба шашны орчны хязгаараар хязгаарлагдахгүй байх ёстой.

Ардчиллын улс төрийн соёлын наад захын шаардлагуудыг иргэн харьяатын үүргийн тухай онолоос улбаатай ардчилсан иргэн харьяатын ололт амжилтаар баяжуулах шаардлагатай: Ардчилсан үндсэн хуультай нийгэмд соёл - гоо зүй, этно - соёлын, үзэл санааны эсвэл соёл - шашны түвшинд бүрдсэн үнэлэмжүүд ардчиллын улс төрийн соёлын наад захын шаардлагуудад шингэсэн байх ёстой. Энэ нь харилцан хүндэтгэл, нийгэм хамт олны тогтвортой нэгдлийг бий болгоход шаардагдах нөхцөлүүд юм.

Дараах асуултууд зүй ёсоор гарч ирж байгаа юм. Бүтцийн, улс төрийн, эрх зүйн ямар нөхцөлүүдийн дор улс төрийн хамтын соёлын наад захын шаардлагууд хэрэгжих боломжтой бэ? Улс төрийн соёлыг хүлээн авах нь бусад тодорхой соёлын онцлог хэв шинжүүдэд хөндлөнгөөс оролцож буй хэрэг мөн үү? Улс төрийн соёлын үндсэн асуудлуудаар нэгдсэн зөвшилцөлд хүрэх нь зэрэгцэн орших концепцыг үгүйсгэж ассимиляц буюу адилтгах үзлийг дэмжиж буй хэрэг бус уу?

Эдгээр асуултад хариулт өгөх нь практик дээр нэлээд хүндрэлтэй. Нийгмийн ардчиллын шаардлагад нийцсэн иргэн харьяатын үүргүүдийг олон нийтэд хүртээлтэй нийгмийн хариуцлага болгохын тулд дараах хүчин зүйлс ач холбогдолтой болно: Цагаачдад харьяат иргэдийн нэгэн адил төрт улсын иргэдийн статусыг олгох хэрэгтэй. Учир нь хамтын эрх зүйн журмын хэтийн хөгжилд тэдний оролцоотой байсан тохиолдолд цагаачид хүлээн зөвшөөрөх болно. Нөгөө талаас цагаачдыг өөрсдийн уугуул соёлын үүргийг биелүүл гэж албадаж болохгүй. Эрх зүйт төрт ардчилсан нийгэмд амьдарч буй иргэн бүр өөрийн уугуул соёлыг нуун далдлах шаардлагагүй. Нөгөө талаас нийтийн тусын тулд иргэн бүр нээлттэй нийгмийг эрх зүйт үндсэн хуульт зарчмаар хөгжүүлэхэд гар бие оролцоход бэлэн байх ёстой.

Эрх зүйт төрт ардчилсан нийгэмд улс төрийн соёлын түвшин дээрх ассимиляц болон этно - соёлын түвшин, соёл - шашны түвшин дээрх амьдралын хэв загварын ялгаатай байдлыг ялгаж салгаж байх нь зүйтэй. Нэгдсэн улс төрийн соёлыг бүрдүүлэхийн тулд нэгдсэн хэлтэй эсвэл хамгийн наад зах нь саадгүй орчуулга хийх боломжийг бүрдүүлэх зайлшгүй шаардлагатай. Энэ бол олон нийтийн харилцан ойлголцлын наад захын шаардлага. Үүнээс гадна хамтын улс төрийн үнэлэмжүүдээр улс төрийн соёлыг дэмжиж байхын тулд соёлын түүхийн зохих суурь мэдлэгтэй байх шаардлагатай. Улс төрийн соёлын дээрх хоёр нөхцөлийг хангах нь боловсролын системийн үүрэг мөн. Боловсролын систем улс төр, соёлын ассимиляцыг бүрдүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг. Этно ба соёлын болон соёл ба шашны түвшин дээр ялгаатай байдлууд хэвээр байж болно. Үүний нэг жишээ бол нийгэм, улс төрийн үнэт зүйлс нь нэг бол нэг мусульман шашинтан, нэг бол католик шашинтан хоёр манай нийгэмд хоорондоо эрс ялгаатай амьдралын хэв заншлаар амьдардаг байж болно.

Бүх оролцогчдын үнэлэмжүүдийг өөрчлөх нэгдэл бол маш удаан хугацаа шаардах процесс Өөр өөр байдлаа харилцан хүлээн зөвшөөрөлцөх нь дээрх процессод зайлшгүй чухал бөгөөд бүх оролцогчдоос тодорхой хэмжээнд өөрийгөө өөрчлөхийг шаарддаг. Нэгдэл амжилттай явагдсан тохиолдолд шинэ зүйл үүсдэг. Бүх хүмүүсийн харьцаанд нөлөөлж заримыг нь өөрчилдөг. Энэ өөрчлөлт эргээд улс төрийн соёлд нөлөөлдөг. Хүлээн авагч нийгэм бүр ардчилсан эрх зүйт төрийн улс төрийн соёлыг бүрдүүлэх үүднээс элсэн орох нөхцөлүүдийг тавих эрхтэй. Өөр өөр уугуул соёлтой иргэдийг элсүүлэн авснаар тухайн улсын төрийн үндсийг шийдэх нийгмийн «үндсэн бүрэлдэхүүн» өөрчлөгддөг.

Олон талт соёлтой нийгмийн нэгдэл нь нийгмийн нөөцүүд, боломжуудаас тэгш хувь хүртэх нөхцөлийг хангах харилцан хүлээн зөвшөөрөх бодлого хэрэгжүүлэхийг шаардаж байдаг. Харилцан хүлээн зөвшөөрөх эерэг эрх чөлөөний цар хүрээний материаллаг хэсгийг харгалзан үзэхгүйгээр тэдгээрийн соёлын цар хүрээг хөгжүүлэх магадлал асар бага юм. Бусдыг хүлээн зөвшөөрөх явдал нь тэдний үндсэн эрхүүд дээр суурилна. Соёлын өөрийгөө батлах үндсэн эрх нь зөвхөн иргэний, улс төрийн төдийгүй нийгмийн болон эдийн засгийн үндсэн эрхүүдэд нэгэн адил хамаарна.

Нийгмийн ардчиллын хүрээнд бусдыг хүлээн зөвшөөрөх бодлого дараах тэнцүү үнэлэмж бүхий гурван үндсэн элементүүд дээр суурилдаг.

- Бусдын соёлын үнэт зүйлсийг хүндэтгэн үзэх
- Хамтын нийгэм хамт олны үндэс болсон эрх зүйт төрт ардчиллыг хүндэтгэн үзэх
- Нийгмийн нөөц баялаг боломжуудаас тэгш эрхтэйгээр хувь хүртэх

Улс орнуудын загварууд VII

7.1. Улс орнуудын харьцуулалт

Нийгмийн ардчилал үндсэн эрхүүдийн нэгэн адил тэдгээрийн хэрэгжилтэд соёлын хүрээнээс хальсан түгээмэл шаардлагуудыг тавьдаг. Үндсэн эрхүүд болон үндсэн үнэлэмжүүдэд нийгмийн ардчиллын зүгээс тавих цар хүрээ тодорхой ёс зүйн дагуу ангилагдах төрөл бүрийн хувилбарууд болон улс орнуудын онцгой асуудлууд туршлагад орон зайг бий болгодог. Энэхүү бүлэгт зургаан орныг нийгмийн ардчиллын стандартуудын байдлуудаар нь харьцуулсан. Эдгээр орнуудын сонголтыг хийхдээ Швед, Голланд, ХБНГУ зэрэг улсуудыг хэдийгээр өөр өөр хөгжлийн замыг туулсан ч нийгмийн ардчиллын шаардлагуудыг өндөр түвшинд хангасан тул сонгон авсан. Мөн АНУ, Их Британи зэрэг дээрх орнуудын эсрэг туйл болох либертар ардчиллыг өөр өөр хөгжлийн замаар харилцан адилгүй түвшинд хэрэгжүүлсэн орнуудыг сонгон авсан. Япон орон хэдийгээр тэс өөр уугуул соёлтой боловч европын загвараар хөгжсөн, хэдийгээр өөрийн гэсэн онцлог шинжүүдтэй боловч нийгмийн ардчиллын олон шаардлагуудыг хангасан орон юм.

7.2 Швед

Хэдийгээр бусдын анхааруулга сануулга тус орныг «Нийгмийн сайн сайхны төлөө диктатур» гэж цөөнгүй нэрлэдэг ч «Шведийн загвар» 1970-аад оныг хүртэл нийгмийн ардчиллын шилдэг загвар болж байлаа. 1970-аад оны дунд үеэс буюу Социал демократууд засгийн эрх барих эрхээ алдсанаас хойш дэлхийн эдийн засгийн хөгжилд учирсан бэрхшээлүүдийн улмаас «Шведийн загвар»-ын нэр хүнд буурч эхэлжээ. Төсвийн алдагдал, ханшийн уналт, татварын хувь хэмжээ нэмэгдэж нөгөө талд нь ажилгүйдэл хамгийн доод түвшинд, эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийн байдал өндөр зэрэг ололт амжилтууд. Маш тайван орон. 200-аад жилийн турш дайн тулаанд хүртэл асуудал хурцдаж байсан түүхгүй, нөгөө талд нь ерөнхий сайд нь алагдсан, түүний алуурчид өнөөг хүртэл олдоогүй байгаа орон. Дундад болон Өмнөд Европынхны гайхшралыг төрүүлдэг нэг зүйл бол олон нийтийн бүхий л үйл ажиллагааг цөөн тооны нууцын тэмдэг дарсан цөөхөн бичиг баримтуудаас бусдыг нь хувь хүн ямар нэгэн шалтаг шалтгаан нэрлэлгүйгээр үзэж болдог иргэдийн эрх. Нөгөө талаас «шил» мэт ил тод иргэн харьяатуудтай байх нь олон нийтийн харилцаа хувь хүний дугаараар дамжиж шаардлагатай тохиолдолд хуульд нийцэж буй эсэхийг шалгадаг нь мөн ойлгомжгүй. 1990-ээд оны эхээр хөдөлмөр эрхлэлтийн салбарт ноцтой бэрхшээлүүд учирсан ч энэ хооронд Шведэд хангалттай ажлын байр бий болгож бүхнийг ажлаар хангах зорилт амжилттай хэрэгжиж Европын тогтвортой байдлын пактыг хэдийн биелүүлээд байна. Ажилгүйдлийн квотыг 8.1% -иас (1996) 4.6% (2002) болгон бууруулсан нь улсын нийт төсвийг ашигтай байхад хүргэж 2002 он гэхэд ДНБ-ний 1.5%-д хүрсэн байна.

Улс төрийн систем

«Шведийн загвар» бол улс төрийн тэнцвэртэй байдлын үлгэр жишээ болсон юм. Зөвшилцөл, Хэлэлцээр, Нэгдэл нь улс төрийн системийн тэргүүлэх ач холбогдолтой үгс.

Ардчилсан, хамтарсан ашиг сонирхлын тэнцвэрийн онцлог шинж нь өргөн хүрээтэй парламентын хэлэлцүүлгийн өмнөх болон парламентаас гадуурх зөвлөгөө болон хэлэлцүүлгийн арга хэлбэрүүд бөгөөд нэн түрүүнд улс төрийн хүчнүүдийн «Ремис - арга»-ын хүрээнд өөрсдийн байр сууриа илэрхийлэх эрх юм. Дээрх хэлбэрээр Шведэд шинэ сэдвүүд, нийгмийн хөдөлгөөнүүдийг улс төрийн хувьд нэгтгэж улс төрийн томоохон туйлшралууд үүсэхээс сэргийлдэг. Шведэд бусад улс орнуудтай харьцуулбал төр ба нийгмийг хооронд нь зааглах байдал харьцангуй бага. Нийгмийн хүчнүүд холбоод, улс төрийн намуудын төлөөллийн хэлбэрээр улс төрийн процессуудад шууд нөлөөлдөг.

Шведийн үндсэн хуульд Монархи бол улс орны төрийн тэргүүн мөн гэж заасан байдаг. Социал демократ ажилчны нам Бүгд Найрамдах засаглалын хэлбэрийг нэвтрүүлэхийн төлөө байдаг. Төрийн тэргүүний дараа Парламентын дарга хоёрдогч дээд албан тушаал юм. Парламентын тэргүүнийг сонгуульт хугацааны туршид сонгодог. Тэр парламентын дарга төдийгүй бусад орнуудад төрийн тэргүүн нь гүйцэтгэдэг зарим үүргийг мөн давхар гүйцэтгэдэг. Засгийн газрыг бүрдүүлэхэд тэр мөн тэргүүлэх үүргийг гүйцэтгэдэг. Парламентын сонгуулийн хугацаа дөрвөн жил. 1998 оноос сонгуулийн хуудсан дээр тодорхой нэр дэвшигчийг тодруулахын тулд тэдний нэрийн дугаарыг дугуйлдаг болсон. Сонгуулийн тойрог бүрд дунджаар арван мандат ногддог. Парламентын Райхстаг буюу эзэнт улсын хурал хэмээн нэрлэдэг. 349 суудлаас 310 нь мужуудын тогтсон суудал байдаг. Үлдсэн 39 суудал нь тэнцэтгэлийн мандаттай байдаг. Райхстагт сонгогдохын тулд улс төрийн намууд 4%-ийн босгыг давсан байх ёстой. Хэрэв улс төрийн аль нэг нам 4%-ийн босгыг давж чадаагүй бол сонгуулийн тойрогт доод тал нь 12%-ийн санал авсан бол Райхстагт сонгогдох эрхтэй. Сонгуулийн зэрэгцээгээр бүх ард түмний зөвлөлдөх санал асуулга явуулж болдог. Өнөөг хүртэл таван удаа явагджээ:

1922 онд архийг хориглох тухай, 1955 онд тээврийн зүүн гарын дүрмээс баруун гарын дүрэмд шилжих шилжилтийн тухай, 1957 онд нэмэлт тэтгэврийн тухай, 1980 онд цөмийн эрчим хүчний тухай, 1994 онд Европын Холбоонд элсэх тухай санал асуулгууд явуулжээ.

Шведийн намуудын систем нь барууны ертөнцөд хамгийн тогтвортой «**хөлдүү**» намуудын систем гэж нэрлэгддэг үлгэр жишээ систем. Бараг бүтэн далан жилийн туршид 1921-1988 онд улс төрийн амьдралд нь таван улс төрийн намууд ноёлж байсан. Социал Демократ Ажилчны Нам, Либерал Нам, Консерватив барууны нам, Тариачдын Нам, Шведийн Коммунист Нам. Тогтвортой байдлын энэ зураг 1980 оноос үндсээрээ өөрчлөгдсөн байна. Удаан жилийн туршид Шведийн намуудын системийн онцлог шинж болж байсан дээрх блокийн бүтэц үндсээрээ өөрчлөгдсөн. Зүүн - Барууны тэнхлэгийн дагуу нийгмийн болон хөрөнгөтний хоёр том блок оршиж байлаа. Дээрх блокууд олон асуудлаар намуудын байр суурийг тодорхойлдог байлаа. Экологийн асуудал хурцаар тавигдаж эхэлсний дараа улс төрийн шинэ цар хүрээ, улс төрийн шинэ хуваагдал бий болж эдийн засгийн өсөлтийг экологийн тэнцвэрт байдалтай сэргүүлэн тавьдаг шинэ бүлэглэлүүд үүссэн байна. Энэ хуваагдал Зүүн - Барууны тэнхлэгийг өөрчилж эхэлжээ. Намуудын хооронд шинэ блок үүсчээ. Ногоонтны нам намуудын тогтвортой байдлыг алдагдуулж анх удаа Шведийн Райхстагт суудал авсан байна. Шведийн намуудын системд удаан хугацааны туршид тэргүүлэх үүрэг гүйцэтгэж байсан Социал Демократ Ажилчны Нам ач холбогдлоо гэж эхэллээ. СДАН нь 1917 оноос хойш 1971 - 1985 онд засгийн эрхийг хамтран барьж байжээ. 1932 оноос 1976 онд 44 жилийн турш засгийн эрхийг олонхоороо бүрдүүлж байжээ. СДАН -аас 1976-1978, 1979 - 1982 онд ерөнхий сайдууд тус тус сонгогдож байжээ. Төв намын гэнэтийн амжилт нь 1960 оноос байгаль хамгааллын асуудлыг бодлого хөтөлбөртөө

тусгаж Байгаль орчны сүйрэл, хотжилттой холбоотой үүссэн сэтгэл хангалуун бус байдлыг социал демократ бүтцийн бодлогын тусламжтайгаар хэрэгжүүлж сонгогчдын саналыг авч чадсантай холбоотой. Гэхдээ төвийн намын үйл ажиллагаа 1980-аад оноос эрс буурсан байна. СДАН 1991 онд сонгогчдын саналын дөнгөж 37.7%-ийг авсан байна. 1994 онд 45.3%-ийн санал авч дахин тогтворжиж эхэлсэн байна. Харин 1998 оны Райхстагийн сонгуульд нийгмийн сайн сайхны төлөөх төрийн баталгааг бууруулах зарим арга хэмжээг хөтөлбөртөө тусгасны улмаас ойролцоогоор 9%-ийн санал алдсан байна. Нийгмийн сайн сайхны төлөө төрийн хүрсэн түвшнийг хэвээр нь хадгална гэж далбаан дээрээ бичээд сонгуульд оролцсон Зүүний намууд өмнөх сонгуульд авсан саналаа хоёр дахин нэмэгдүүлсэн байна. Харин 2002 оны сонгуульд СДАН дахин 40 орчим хувийн санал авсан байна.

Шведийн улс төрийн системийн нэг онцлог бол Райхстагийн хууль зүйн омбудсмэнүүдийн хяналтын бүтэц юм. Бодит байдал дээр хууль зүйн дөрвөн омбудсмэнүүд дөрвөн жилийн туршид Райхстагийн даалгавраар Райхстагаас хараат бусаар ажилладаг. Тэдний үндсэн үүрэг бол шүүхүүд болон захиргааны байгууллагууд хуулийг хэрхэн хэрэглэж буйд хяналт тавьдаг. Омбудсмений тусламжтайгаар иргэдийн шүүх болон захиргааны байгууллагуудад итгэх итгэл нэмэгддэг. Дээрх дөрвөн омбудсмэнүүдээс гадна ижил төстэй үүргүүдийг гүйцэтгэх бусад омбудсмэнүүдийг ажиллуулдаг. Өнөө үед ийм байгууллагууд тухайлбал хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах, тэгш эрх, хэвлэл, үндэстнийг ялгаварлан гадуурхах, тахир дутуу хүмүүсийн эрхийг хамгаалах зэрэг салбаруудад байгуулагдан ажиллаж байна.

Улс төрийн засаглалын хяналтын асуудлаар дараах хоёр байгууллагууд онцгой ач холбогдолтой байдаг. Үүний нэг нь төрийн албаны бичиг хэрэгтэй бүх нийтээрээ танилцах зарчим.

Нөгөө талаар хэвлэл мэдээллийн хувийн салбарт төрийн зүгээс үзүүлэх хөнгөлөлт нь олон ургалч үзлийг дэмжих ёстой. Хэвлэл мэдээллийн салбарт бий болж буй хэт төвлөрлийг сааруулахын тулд 1970-аад оны эхээс сонинуудад төсвийн зүгээс санхүүгийн дэмжлэг үзүүлж байна.

Үндсэн эрхүүдийн систем

Эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд тэгш эрхтэй байх үндсэн эрх: Шведэд эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлт хөдөлмөрийн зах зээл дээр түгээмэл. Бүх эмэгтэйчүүдийн 63.9% нь хөдөлмөр эрхэлдэг нь судалгаанд сонгон авсан улс орнуудын дотор хамгийн өндөр үзүүлэлт юм. Хүүхэд хүмүүжүүлэх олон нийтийн байгууллагууд (цэцэрлэг, ясли) Шведэд сайн хөгжсөн. Түүнээс гадна Швед улс (**dual breadwinner - norm**) буюу хосолмол - норм бодлогыг хэрэгжүүлж гэр бүлийн гишүүд тус тусдаа татвар төлөх бодлогыг хэрэгжүүлээд байна. Швед улсад эмэгтэйчүүдийн улс төрийн байгууллагуудад оролцох оролцоо бусад орнуудтай харьцуулахад харьцангуй маш өндөр. Парламент дахь эмэгтэйчүүдийн оролцоо 1998 оны Райхстагийн сонгуулиас хойш 42.7% байна.

Өндөр насны тэтгэвэрт гарсан үедээ амьжиргааны хангалттай эх үүсвэртэй байх үндсэн эрх «Ардын түгээмэл тэтгэвэр»-ийн даатгалаар хангагдаж байдаг. Уг даатгал нь бүх ахмад настануудын хэрэгцээнээс үл хамаарах үндсэн хангамжийг бүрдүүлдэг. Гурваас дээш жил Шведэд амьдарч буй хүн бүр 65 нас хүрмэгцээ бүх хүнд ижил хэмжээгээр ноогдох улсын төсвөөс санхүүждэг энэхүү тэтгэврийг авах эрхтэй. Харин 40 жилийн турш Шведэд өөрийн орон байртай амьдарсан бол энэхүү үндсэн тэтгэврийг бүрэн хэмжээгээр нь авах эрх нь нээгдэнэ. Шведийн өндөр настануудын тал хувь нь энэхүү үндсэн тэтгэврээс гадна мэргэжлийн болон хувийн даатгалаас нэмэгдэл тэтгэвэр авдаг. 1958 оноос олгогдож буй нэмэгдэл тэтгэврийн зарчмын дагуу өндөр настанууд хамгийн их орлоготой байсан

арван таван жилийнхээ дундаж орлогынхоо 65 %-ийг авна. Түүнээс гадна нэмэгдэл тэтгэвэрт 1990-ээд оны эдийн засгийн хямралын улмаас өргөн хүрээтэй шинэчлэл хийсэн байна. Энэ шинэчлэлээс хойш хамгийн их орлоготой арван таван жил биш харин бүх ажилласан жилээс нь тогтоодог болсон байна. Түүнээс гадна тэтгэвэр тогтоохдоо дундаж наслалтыг оролцуулан тооцдог болжээ. Дундаж наслалт өсөх тутам сар тутам авах тэтгэврийн хэмжээ багасна.

Хангалттай амьжиргааны эх үүсвэртэй байх үндсэн эрхтэй холбогдуулан авч үзэхэд Швед улс хамгийн бага ядуурлын квоттой орон. Үүнийг НҮБ-ын «Human Poverty Index» хүний хөгжлийн индекс мөн баталж байгаа юм. Швед орон энэхүү бүлэгт сонгон авсан 6 орны дотор төдийгүй хамгийн өндөр хөгжилтэй 17 оронтой харьцуулж үзэхэд ядуурлын түвшин нь хамгийн доогуур байдаг, ядуурлаас хамгаалах арга хэмжээний хувьд нэгдүгээр байрт ордог.

Үйлдвэрчний эвлэлд эвлэлдэн нэгдэх эрх ажил хаялт хийх эрх хангагдсан. Ажилчдын 90% нь үйлдвэрчний эвлэлийн гишүүд. Үйлдвэрчний гишүүнчлэлийн тоо ийнхүү өндөр байгаа нь ажилгүйдлээс хамгаалах даатгалын гишүүнчлэл, үйлдвэрчний эвлэлийн гишүүнчлэл удаан хугацааны турш хоорондоо холбоотой байснаас улбаатай. Харин 1904 оноос хөдөлмөр эрхэлж буй хүн бүр ажилгүйдлийн даатгалд заавал даатгуулах үүрэгтэй болсон.

Нийгмийн баримжаат төр

Олон улсын мэтгэлцээнүүдэд Швед улс нь байнга гайхалтай амжилтад хүрсэн, нийгмийн сайн сайхны төлөө төрийг бүрэн байгуулж дууссан орны хувьд үлгэр жишээ болж байдаг хэрнээ хамгийн их шүүмжлэлд өртөж байдаг. Шведийн нийгмийн бодлогын онцлог бол улс төр болон нийгмийн тэгш байдлыг үлгэр жишээ болохуйц хэмжээнд хангаж чадсан явдал юм.

Цэвэр орлогод түвшин тогтоох, ажилчид, албан хаагчид, төрийн албан хаагчдын тэгш байдлыг хангах бодлогыг хэрэгжүүлснээр улс орон даяар улс төр ба нийгмийн тэгш байдлыг хангаж чадсан байна. Түгээмэл нийгмийн хамгааллын системүүд нь нийгмийн болон улс төрийн тэгш байдлыг хамгийн сайн хангасны тод илэрхийлэл мөн. Иргэдийн нийгмийн статусын тусгал болсон нийгмийн хамгааллын системээс Швед орон ямагт татгалзсаар ирсэн. Шведийн нийгмийн баримжаат төр, түүний нийгэм, улс төрийн тэгш байдлын бас нэгэн онцлог бол эрэгтэй, эмэгтэйчүүдийн тэгш байдлыг хангах, гэр бүлийн баталгааг гэр бүлийн амьдралын үндэс гэж үздэг хуучны үзлийг хэвээр хадгалах оролдлого зэрэг юм. Европын бусад улсуудтай харьцуулахад Швед улс эмэгтэйчүүдийн тэгш байдлыг зөвхөн улс төрд төдийгүй хөдөлмөр эрхлэлтийн салбарт хангаж чадсан орон юм.

Шведийн системийн бас нэгэн гол онцлог бол нийгмийн хамгааллын системийн түгээмэл байдал мөн. Нийт хүн амаа насан өндөр болох, өвчлөлт зэрэг эрсдэлүүдээс хамгаалж чадсан. Эрсдэлийн хамгаалалтыг олон нийтийн хангамжийг нийгмийн хамгааллын сангаас санхүүжүүлэх замаар зонхилон шийдвэрлэдэг. Нийгмийн тусламжийн хүрээнд хэрэглээнээс хамаардаг, ялгавартай халамжийн арга хэмжээнүүдийг авч явуулахаас татгалздаг. Нийгмийн хамгаалал нь татвар болон даатгуулагчдын шимтгэлээс санхүүждэг «харьяат иргэдийн хангамж» юм. Шведийн нийгмийн бодлого ямарваа нэгэн шилжилтийн мөнгөн тусламж өгөхөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүд авч хэрэгжүүлэхийг илүүд үздэг. (Ажилгүй болсон үед ажилгүйдлийн мөнгө олгохоос ажилгүйдэл бий болгохгүй байхад илүүтэй анхаардаг. Орч) Энэ бодлого ажилгүйдлийн салбарт илүү тодорхой харагддаг. Хөдөлмөрийн зах зээлийн идэвхтэй бодлого хэрэгжүүлэхэд ажилгүйдлийн мөнгөнөөс хамаагүй илүү мөнгийг зарцуулдаг байна. Гэсэн хэдий ч шилжилтийн мөнгөн тэтгэлгийн хэмжээ бусад

улсуудтай харьцуулахад харьцангуй өндөр, амьжиргааны баталгаажих доод түвшингээс өндөр дундаж амьдралын стандартыг баталгаажуулж өгдөг.

Шведийн нийгмийн сайн сайхны төлөөх төрийн үндсэн зарчим нь явцуу утгаар нь авч үзвэл нийгэм, улс төрийн хэлбэртэй: Төрийн удирдлагын функцийг нийгмийн бүхий л хүрээнд хүлээн зөвшөөрөх ухамсар бүрэлдэн тогтсон байдаг. Тэр ч байтугай хөрөнгөтний урсгалын намууд ч төрийн удирдах ролийг хүлээн зөвшөөрдөг. Тийм ч учраас 1970, 1980-аад оны үед макро эдийн засгийн түвшинд өргөн хүрээтэй төрийн удирдлагыг хэрэгжүүлэх гэсэн оролдлого ямар нэгэн эсэргүүцэлтэй тулгараагүй байна. Дээрх оролдлогууд даяаршлын улмаас амжилтад хүрээгүй ч эдийн засгийн урьдчилан таамаглах боломжгүй нөхцөлүүдийн дунд нийгмийн сайн сайхны төлөөх хөгжлийн бодлогоо гайхалтай амжилттайгаар хэрэгжүүлж байгаа юм. 1994 онд дахин засгийн эрхэнд гарсан социал демократууд өмнө нь засгийн эрх барьж байсан хөрөнгөтний намын нийгмийн хамгааллын системийн бүтцийг хэвээр нь байлгах бодлогыг үргэлжлүүлсэн юм. Өвчилсөн тохиолдолд мөнгөн тэтгэлэг олгох, тахир дутуу болох, ажилгүйдлийн мөнгө зэргийн хэмжээг бууруулж, олгох нөхцөлүүдэд илүү хатуу шаардлага тавьдаг болсон. Ингэснээр хөдөлмөр эрхлэх сонирхол нэмэгдэж нөгөөтээгүүр мөнгөний ханшийг тогтвортой байлгах, төсвийн зарчмын бодлогуудыг амжилттай хэрэгжүүлэх нөхцөлүүд бүрдсэн байна.

Боловсролын систем

1962 оноос хойш Шведэд 9 жилийн сургалттай ерөнхий боловсролын заавал дүүргэх сургалтын тогтолцоо бүрдсэн. Энэ сургуулийн 8-р анги хүртэл дүн тавьдаггүй «**анги улираадаггүй**» онцлогтой. Ерөнхий боловсролын сургуулийг дүүргэсэн сурагчдаас ойролцоогоор 98% нь сайн дураараа гимназид дэвшин суралцдаг. Гимнази нь дээр үеийн мэргэжлийн

сургалт, ерөнхий боловсролын сургууль, гимназийн сургалтыг нэгтгэсэн өргөн хүрээтэй курсийн системтэй сургалт юм. Жил тутамд гимнази төгсөгчдийн 30 - 35% нь дээд сургуульд элсэн суралцдаг.

Швед орон насанд хүрэгчдэд олон талт сургалтын хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж чаддагаараа онцлог: нэн ялангуяа ажилчдын боловсролын салбар, шашны нийгэмлэгүүд, архидалтын эсрэг хөдөлгөөнүүдийн идэвх санаачилгаар зохион байгуулагддаг орон нутгийн ард түмний дээд сургуулиуд, оройн гимназиуд, бичиг үсэг тайлагдаагүй хүмүүст зориулсан тусгай хөтөлбөрүүд зэрэг чөлөөт, өргөн хүрээтэй нийтийн, ашгийн бус сургалтын хөтөлбөрүүд болон төр болон тарифын гэрээнд оролцогч талуудын хамтарсан санхүүжилтээр нэлээд өндөр өртөгтэй мэргэжил дээшлүүлэх, шинээр мэргэшүүлэх сургалтууд зэрэг явагддаг.

Боловсролын салбарын хөрөнгө оруулалт улсын төсвийн 7%-тай тэнцдэг. Судалгаанд хамрагдсан зургаан орнуудын дунд Швед улс боловсролын салбарт хамгийн их хөрөнгө зарцуулдаг, тэргүүлэх байрыг эзэлдэг орон юм. Улс орнуудын P15A харьцуулсан судалгааны дүнгээр: Нийт 31 орнуудын дунд Швед улс унших чадварын хувьд 9-р байрт, байгалийн шинжлэх ухааны чадварын хувьд 10-р байрт, математик чадварын хувьд 15-р байрт орж байна. Шведэд бичиг үсэгт тайлагдаагүй хүмүүсийн хувь нь нийт хүн амынхаа 7.3%-тай тэнцэж байгаа нь дэлхийд хамгийн багад тооцогдож байна.

Капитализмын хэв шинж

Швед нь Герман, Япон улсын нэгэн адил зохицуулалттай зах зээлийн эдийн засагтай орон юм. Дайны дараах үеэс хоорондоо маш сайн уялдаа холбоотой, нэгдмэл эдийн засаг-улс төрийн хөгжлийн хамтын удирдлага бүхий загвараар хөгжиж ирсэн. Энэхүү хамтын удирдлага нь 1970-аад оны

сүүлчээр засгийн эрх барьж байсан социал демократуудад эдийн засгаа пост кенсийн аргаар буюу (Кенп-МеШпег)-ийн загвараар удирдах боломжийг олгосон нь бүхнийг ажлын байраар хангах бодлогыг хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн байна. Уг удирдлагын загварыг «эв санааны нэгдлийн зарчим дээр суурилсан цалингийн бодлого», хөдөлмөрийн зах зээлийн идэвхтэй бодлого болон аж үйлдвэрийн хэсэгчилсэн бодлогоор дэмжсэн байна.

Аж үйлдвэрийн харилцаа ба хөдөлмөрийн зах зээлийн бодлого

Шведийн үйлдвэрчний эвлэлийнхэн германы үйлдвэрчний эвлэлийнхэнтэй харьцуулахад компаниудад шууд нөлөөлөх боломжоор илүү. Энэ нь нэг талаас хөдөлмөр эрхлэгсдийн дунд үйлдвэрчний эвлэлийн гишүүдийн эзлэх хувь харьцангуй өндөр байгаатай холбоотой. Нөгөө талаас ажилтнуудын төлөөлөл үйлдвэрийн ажилчдын зөвлөл болон үйлдвэрчний эвлэлийн шугамаар давхарддаггүй. Үйлдвэрчний эвлэлийнхэн бол компаниудын түвшинд ажилтнуудын цорын ганц төлөөлөл юм.

Үйлдвэрчний эвлэлийн дээвэр байгууллага буюу Улсын Байгууллага (Landesorganisation:LO) болон Ажил Олгогчдын Төв Холбоо (Svenska Arbetsgivarforeningen:SAF) 1938 онд «Салтжевадений үндсэн хэлэлцээр»-ийг байгуулсан нь дайны дараа үеийн хөдөлмөрийн харилцааг зохицуулах гол бичиг баримт болж байлаа. Уг хэлэлцээрээр хөдөлмөрийн эрх зүйн бүхий л асуудлуудыг Норвегийн нэгэн адил хуулиар бус тарифын гэрээнүүдийн системээр зохицуулна хэмээн заасан. Өөрөөр хэлбэл хөдөлмөрийн харилцааны асуудлуудыг төрийн оролцоогүйгээр зохицуулах ерөнхий зарчмыг тунхагласан юм. Харин 1970-аад оны үед дээрх ерөнхий зарчим олон талаар зөрчигдөхөд хүрч хуулийн дагуу хөдөлмөрийн эрх зүйн зохицуулалтуудыг нэвтрүүлсэн байна.

Нэгдүгээрт 1974 онд ажлаас халагдахаас хамгаалах хууль хэрэгжиж эхэлснээр ажил олгогчдын ажилтнуудыг дураараа ажлаас халах эрхийг хязгаарлаж ажлаас халагдах бодит үндэслэлүүдийг шаардах болсон байна. Цаашилбал компанид ажилласан жилээс хамааран ажлаас халагдах мэдэгдэл өгөх хугацаа уртсаж ажлаас халагдах процессод үйлдвэрчний эвлэлийнхний нөлөө өссөн байна.

Хоёрдугаарт 1978 онд ажиллах орчны тухай хууль батлагдсан нь хууль ёсны хөдөлмөр хамгааллын хуулийн зорилгыг эрүүл мэндийн байдлыг хэвээр хадгалахад оршино хэмээн тодорхойлсон нь хөдөлмөрийн ертөнцийг илүү хүнлэг болгож тус улсыг хөдөлмөр хамгааллын эрх зүйн байдлаар бусад орнуудтай харьцуулахад хол түрүүлэхэд нь хувь нэмрээ оруулсан байна. Ингэснээр хөдөлмөр хамгааллын асуудлыг хариуцсан ажилтанд тодорхой нөхцөлд аюултай ажиллагааг бие даан зогсоох эрхийг олгосон байна. Үүний үр дүнд 1990-ээд онд Швед улс өндөр хөгжилтэй аж үйлдвэржсэн П үйлчилгээний нийгэмтэй улсуудын дунд үйлдвэрлэлийн осол хамгийн цөөнтэй орны тоонд багтах болсон байна.

1990 онд Шведэд ажилгүйчүүдийн тоо гэнэт огцом өссөн байна. Улс төрийнхөн бүхнийг ажлын байраар хангах зорилт бүхий бодлогыг баримталж, «хөдөлмөрийн нийгмийн» үзэл санаа Шведийн нийгэмд гүн шингэсэн нөхцөлд үүссэн учраас энэ үзэгдлийн учир шалтгааныг тайлбарлах шаардлагатай. Олон улсын мөнгөний системийн өөрчлөлтүүд, газрын тосны үнийн шок нь аль 1980-аад оны үеэс хөдөлмөр эрхлэлтийн байдлыг хүндрүүлж эхэлсэн байна. 1985 - 1986 оны санхүүгийн зах зээлийн дахин зохицуулалт нь тухайн цаг үеийг хүртэл төрийн зохицуулалтад байсан зээлийн хүүгийн хэмжээнд урт хугацааны өөрчлөлтүүдийг авчирч Шведийн хүчирхэг аж үйлдвэрийн хувьд капиталын экспортыг нэмэгдүүлсэн байна. 1989 оноос хөдөлмөр эрхлэлтийн байдал эрс муудаж 1990-

1992 оны хооронд нийгмийн бүтээгдэхүүн эрс буурсан байна. Үүний зэрэгцээ ажил олгогчид тухайн үеийг хүртэл амжилттай хэрэгжиж байсан хамтын ажиллагаанаасаа татгалзаж төвлөрсөн бус, илүү уян хатан цалингийн бодлого хэрэгжиж нийгмийн хамгааллын тусламжууд буурахад хүрсэн байна.

Даяаршил болон 1980-аад оноос хойших эдийн засгийн өөрчлөлтүүд Шведийн зөвшилцлийн загварыг сулрахад хүргэсэн нь хожим батлагдсан билээ. Гэхдээ өнөөг хүртэл тус улсын улс төрийн болон эдийн засгийн системд хэт ачаалал үүсэж буй байдал ажиглагдахгүй байна. Харин Швед улс бусад улсуудтай харьцуулахад өнөөг хүртэл ажилгүйдэлтэй хийж буй тэмцэл нь төдийлөн амжилтад хүрээгүй байна. Шведийн ажилгүйдлийн коэффициент 6.4% байгаа нь Японы 4.7%, Их Британийн 4.7%-тай харьцуулахад харьцангуй өндөр байгаа юм. Ажилтнуудыг хамгаалах уламжлалт стандартуудыг мөрдсөн хэвээр боловч ажилгүйдлийн тэтгэмжийн хэмжээг мөн бууруулсаар байна.

Улс төрийн соёл ба иргэний нийгэм

Шведийн улс төрийн соёлд прагматик шинжтэй зөвшилцөл давамгайлдаг. Уг соёл социал демократуудын манлайлалтай нягт холбоотой. Жишээ нь: улс төрийн бүх намууд 1990-ээд оныг хүртэл бүхнийг ажлын байраар хангах бодлогыг тууштай баримталсан. Мөн тус орны улс төр, соёлд манлайлах байрыг эзэлдэг «ардын өлгий» хэмээх ойлголтын цаана өргөн хүрээтэй зөвшилцөл агуулагдаж байдаг: Нийтийн сайн сайхны төлөө олон нийтийн амьдралын түвшинг дээшлүүлэх өргөн хүрээтэй нийгмийн хөтөлбөрүүдийг нийгэм санал нэгтэйгээр дэмжиж байдаг. Хэдийгээр Шведийн улс төрийн соёлд нийгмийн ардчиллын үзэл санааг тууштай дэмждэг уламжлал хэвээр боловч ард түмний парламентдаа итгэх итгэл буурсаар байна. 1988 онд иргэдийн 50% нь Райхстагтаа итгэж байсан бол 1996 онд зөвхөн 18% нь итгэдэг гэсэн байна.

Швед нь нэг үндэстний, нэгдмэл улс төрийн соёлтой орон. Тус улс колонигүй, газарзүйн хувьд тусгаар байсан тул цагаачид болон үндэсний цөөнхүүд түүхэнд нь үүрэг гүйцэтгэж байсан тохиолдол үгүй. Хүн амын аравны ес нь эвангел - лютерийн төрийн сүмдээ харьяалагддаг. Шашны улс орныхоо дотоод бодлогод нөлөөлөх нөлөө бусад орнуудтай харьцуулахад харьцангуй бага. Скандинавын бусад орнуудын нэгэн адил сүмүүд нь төрийн үйл ажиллагааг хүлээн зөвшөөрөгдөхөд хувь нэмрээ оруулсаар ирсэн.

Судалгаанд хамрагдсан бусад орнуудтай харьцуулахад төрийн удирдан чиглүүлэх үүрэг өндөр ч төр ба нийгмийн хоорондын ялгаа бага. Нийгмийн хүчнүүд нь өндөр зохион байгуулалттай, улс төрийн процессод шууд нөлөөлдөг. Нийгмийн сайн сайхны төлөөх төр өндөр хөгжсөн байх нь хүмүүсийн сайн дурын байгууллагуудад цалингүй ажиллах идэвхийг бууруулдаг гэдэг нотолгоо байдаг ч Шведэд энэ нотолгоо батлагддаггүй. Шведийн хүн амын 36% нь төрөл бүрийн холбоодод олон холбоодын нэрийн өмнөөс хөлсгүй хөдөлмөр, сайн дурын үйл ажиллагаа эрхэлдэг.

Хэтийн чиг хандлага

Шведэд социал демократууд болон төвийг баримталсан нийгмийн бүлгүүд хоорондоо байнга нягт холбоотой байсаар ирсэн. Тиймээс нийгмийн сайн сайхны төлөөх загвар нийгмийн өргөн хүрээтэй зөвшилцөлд тулгуурласаар ирсэн, цаашид ч тулгуурласан хэвээр байх болно. Засгийн газар солигдох эсвэл хөрөнгөтний үзлийг баримтлагсдын байр суурь бэхжих үед Шведэд нийгмийн сайн сайхны төлөөх төрд хандах хандлага бараг өөрчлөгддөггүй. Гэсэн хэдий ч Шведэд нийгмийн сайн сайхны төлөөх өсөлт дээд хязгаартаа хүрчихээд байна.

7.3 Их Британи

Их Британи нь нийгмийн баримжаат төр, нийгмийн ардчиллын

тухай мэтгэлцээнүүдэд байнга загвар болон дурдагдаж байдаг. Нэгдсэн Хаант улс нь аж үйлдвэржилт болон худалдааны либералчлалд пионерын - анхдагчийн үүргийг гүйцэтгэсэн билээ. Үүний дагуу нийгмийн баримжаат төрийн дэглэмийн эхний элементүүд Скандинавын болон европын эх газрын хөршүүдээс нь түрүүлж өөр хэлбэрээр хөгжиж эхэлсэн байна. Үүнээс гадна Их Британи түүхэнд онцгой үүрэг гүйцэтгэж дэлхийн 2-р дайныг дуустал дэлхийн империалист гүрэн байлаа. Эзэнт улсын «эх орны» дотоод бодлого болон нийгэм эдийн засгийн хөгжил нь өнөөгийн «**commonwealth**» улсуудын адил нийгмийн баримжаат төрийн хэв шинжээр тодорхойлогдож байжээ.

1945 оноос хойш Виллиам Вебериджесийн төслүүд барууны аж үйлдвэржсэн бараг бүх орнуудын нийгмийн баримжаат төрийн дэглэмд нөлөөлсөн байна. Гэста Эспринг Андерсан Их Британийг нийгмийн сайн сайхны төлөө төрийн либерал буюу ангел - захсений чухал загвар болгон авсан бөгөөд өнөө үед нийгмийн сайн сайхны төлөөх Шинэ Хөдөлмөрийн (**New Labour**) концепцууд төрөл бүрийн социал демократ намууд, засгийн газруудад ерөнхий чиг хандлагуудаа тодорхойлоход нь чухал ач холбогдолтой хэвээр байна. Засгийн эрхийг барьж буй хөдөлмөрийн намууд («**Labor Party**») дэлхий дахинд орчин үеийн нийгмийн ардчиллын гуравдагч замын тухай мэтгэлцээнд тэргүүлэх байр суурийг эзэлж байна.

Британийн нийгмийн ардчиллын хөгжил нь практик бодлогын хувьд болон шинжлэх ухаан - онолын хөгжлийн хэтийн чиг хандлагад өндөр ач холбогдолтой юм.

Улс төрийн систем

Улс төрийн систем нь маш өндөр түвшинд эрх мэдлийг хязгаарладгаараа онцлог тул Их Британийг төвлөрсөн нэгдмэл улс гэж нэрлэж болно. Парламент нь **de jure** буюу эрх зүйн хувьд хязгааргүй бие даасан байдалтай. Үндсэн хууль болон

дээд шатны шүүхийн байгууллагын өмнө (Германд бол үндсэн хуулийн цэцийн гэх мэт) өмнө хэлбэр төдий ч хариуцлага хүлээдэггүй тул сонгуульт хугацаандаа хязгааргүй эрх мэдлийг хэрэгжүүлдэг. Парламентаас гарч буй бүх тогтоол шийдвэрүүд, хуулиуд парламентын энгийн олонхоор батлагдан гардаг. Иймээс тухайн засгийн газруудын бие даасан байдал ч бараг хязгааргүй. Уг хязгааргүй бие даасан байдлыг зөвхөн Их Британид хэрэглэдэг гэж хэлж болохуйц сонгуулийн мажоритар систем улам бэхжүүлж байдаг. Уг систем нь сонгогчдын цөөнхөд дийлэнх олонхоо ноёлох боломжийг бүрдүүлж өгдөг. Их Британийн парламентаризмд эвслийн засгийн газар байгуулагдах тохиолдол маш ховор. Сөрөг хүчнийхэнд хууль тогтоох процессод оролцох боломж байхгүй, ихэнхдээ бүрэн хаагдмал учраас парламентын шийдвэрт оролцох боломж огт байхгүй. Тэдний үйл ажиллагаа засгийн газрын үйл ажиллагааг шүүмжлэх хүрээнд хязгаарлагдаж тэдэнд засгийн газрын хууль тогтоох хөтөлбөрийг өөрчлөх болон саатуулах ямар ч боломж байхгүй. Нийтийн сайн сайхны төлөөх дэглэмийн асар хурдацтай өөрчлөлтийг үүгээр тайлбарлаж болно. Бодлогын чиг хандлагыг богино хугацааны дотор үндсээр нь өөрчлөх боломжтой. Үүний нэг жишээ бол Тетчерийн засгийн газраас 1970-аад оны үед гаргасан хөдөлмөр ба үйлдвэрчний эвлэлийн тухай хууль тогтоомжууд юм. Цөөхөн жилийн дотор консерватив засгийн газарт түүхэн цаг хугацааны туршид бүрэлдэн тогтсон хөдөлмөрийн харилцааны системүүдийг үндсээр нь өөрчлөх боломж олгосон юм. 1970-аад оны улс төрийн хурдацтай өөрчлөлтөд олон улсын түвшинд шүүмжлэлтэй хандаж байсан бол өдгөө тус загварын боломжуудыг онцлох болжээ. Учир нь хөдөлмөрийн нам өдгөө хийж буй шинэчлэлийн бодлогын хүрээнд засгийн газрынхаа бодлогыг хэрэгжүүлэх явцдаа хязгаарлалт тавих боломжоор туйлын хомс байна.

Их Британийн намуудын системийг «хоёр намын» систем гэж нэрлэж болно. Хэдийгээр либерал ардчилсан нам (Liberal

Democrats) сүүлийн жилүүдэд гуравдагч намын байр суурийг эзэлж илүү чухал үүргийг гүйцэтгэж байгаа боловч энэ нь түр зуурын үзэгдэл юм. Намуудын гол өрсөлдөөн консерватив (**Conservatives**) болон хөдөлмөрийн намуудын (**Labour Party**) хооронд явагддаг. Европ тивд улс төрийн зөвшилцлийн стил давамгайлж байдаг бол Их Британид баялаг уламжлал бүхий мэтгэлцээний соёл давамгайлдаг. Улс төрийн зөв шийдвэр гаргахын тулд хурц мэтгэлцээнүүдийг өрнүүлэх нь хэвшил болсон үзэгдэл. Британийн парламентыг «ярьдаг» парламент гэж нэрлэх нь олонтаа. Вибиан Шмидт мэтгэлцээний энэ хэлбэрийг мэдээлэл солилцох мэтгэлцээн (**«communicative discourse»**) гэж нэрлэсэн. Мэтгэлцээний уг хэлбэрийн үед цөөхөн тооны элитүүдийн хүрээнд бодлого тодорхойлогддог. Бодлого тодорхойлогдсоны дараа тэдний улс төрийн шийдвэрийг олон нийтэд танилцуулдаг.

Үндсэн эрхүүдийн систем

Их Британийн хувьд бичигдсэн үндсэн хуульгүй учраас хуульчлагдсан үндсэн эрхүүдгүй байдгаараа онцлог. 1998 онд Британийн эрх зүйд Европын Хүний Эрхийн Конвенц, Европын нийгмийн эрхийн хартыг оруулсан нь дээрх дутагдлыг тодорхой хэмжээнд хүртэл залруулсан байна. Үндсэн эрхүүдийн оронд зарим нь заавал биелүүлэх конвенцууд болон тодорхой тохиолдол бүрд тохирсон шүүхийн шийдвэрүүд үйлчилдэг. Европын үндсэн хууль Их Британид мөрдөгдөж эхэлснээр нийгмийн үндсэн эрхүүд хэлбэр төдий хэрэгжиж эхлэх болно.

Үйлдвэрчний эвлэлийг байгуулах үндсэн эрх Их Британид хангагдсан байдаг. 1999 онд «Хөдөлмөрийн нам» үндэсний цалингийн доод хэмжээг нэвтрүүлсэн байна. Үүнээс нэг жилийн дараа хагас өдрөөр ажиллагсдад бүтэн өдрөөр ажиллагсадтай адил цалин, хөдөлмөр эрхлэлтийн нөхцөлүүд бусад нэмэгдлийг олгохыг ажил олгогчдод заасан хууль батлагдан гарсан байна. Эрэгтэй, эмэгтэйчүүдийн тэгш байдал Их Британид Европын

бусад эх газрын орнуудын адил зөвхөн хэсэгчилсэн байдлаар хангагдсан байдаг. Эмэгтэйчүүд нь дунджаар эрэгтэйчүүдийн цалингийн 73%-тай тэнцэх цалинг авдаг бол Европын Холбооны дундаж 76.3% байна. Хөдөлмөрийн насны нийт эмэгтэйчүүдийн зөвхөн 44.4% нь бүтэн өдрөөр хөдөлмөр эрхэлж байна. Парламентад эмэгтэйчүүдийн эзлэх хувь 17.1% засгийн газарт 35.3% байна.

Нийгмийн баримжаат төр

Их Британи Эспринг Андерсены хэв шинжийн судалгааны дагуу либерал нийгмийн сайн сайхны төлөөх төрийн ангилалд багтдаг. 1940 - 1976 онд Их Британид алдарт Вебериж - систем байгуулагдан бэхэжсэн байна. Энэ систем нь Уильям Вебериж хэмээгчийн дайны үед боловсруулсан төлөвлөгөөнөөс эхтэй бөгөөд гурван бүрэлдэхүүн хэсгээс бүрддэг төрөөс зохион байгуулах бүх нийтийн амьжиргааны баталгаажих доод түвшнийг хангах системийг нэвтрүүлэх, үндэсний эрүүл мэндийн үйлчилгээг (**National Health Service**) нэвтрүүлэх, үндэсний хэмжээнд бүхнийг ажлаар хангах бодлогыг хэрэгжүүлэх. 1975 оныг хүртэл Британийн ихэнх засгийн газрууд намын харьяалал, үзэл баримтлалаасаа үл хамааран кенсийн онол дээр суурилсан бүх хүнийг ажлын байраар хангах бодлогыг хэрэгжүүлэхийн төлөө чармайж байв. 1970-аад оны үеэс бусад орнуудын нэгэн адил нээлттэй зах зээлийн нөхцөлд дээрх бодлогыг хэрэгжүүлэх боломж улам бүр хязгаарлагдмал болсон байна. Уг бодлого 1970-аад оны газрын тосны хямралын дараа мөнгөний ханшийн уналт, эдийн засгийн зогсонги байдлын хосолмол хүндрэлд хүргэсэн байна. Үүний дараа 1979 онд Маргарет Тетчерийн удирдлагын дор эдийн засаг, нийгмийн бодлогод шинэ хандлагыг тогтоосон байна. Санхүүгийн болон төрийн оролцоог хязгаарласан, хамтын эрсдэлүүдийг хувьчлахад чиглэгдсэн бодлогын тусламжтайгаар шинэ чиг хандлагыг тодорхойлсон байна. Маргарет Тетчерийн удирдлагын дор явуулсан шинэчлэлүүдийн үр дүн Британийн

нийгмийн сайн сайхны төлөө төрийг либерал загвараар түлхүү хөгжихөд хүргэсэн байна. Британийн улс төрийн соёлд либерал үнэлэмжүүд илүү гүн суурилсан байдаг тул хүн ам нь бусад орнуудтай харьцуулахад неолиберал бүтцийн өөрчлөлтүүдийг илүү нааштайгаар хүлээн авсан байна.

1997 оноос хойш засгийн эрхийг барьсан Тони Блейрын засгийн газар Тетчерийн олон чиг хандлагыг хэвээр үлдээж ядууралтай тэмцэх салбарт илүү эрчимтэй үйл ажиллагаа явуулсан байна. Шинэчлэлүүд хөдөлмөрийн чадвартай ядуучуудыг хөдөлмөрийн зах зээлд нэгтгэхэд илүү анхаарал хандуулж байна. Гэхдээ албадлагыг биш дэмжлэгийг урьтал болгосон байна. Британийн системийг бүхэлд нь авч үзвэл үгээгүй ядуурлыг бууруулахад маш үр өгөөжтэй систем боловч нийгмийн тэгш бус байдлыг улам бүр хурцатгадаг систем юм. Нийгмийн даатгал, хүүхдийн мөнгө, хэрэглээнээс хамаарах нийгмийн тусламжийг нэгтгэсэн үндсэн хангамжийн боломжийн системээр дамжин хэрэгждэг.

Их Британид нийгмийн сайн сайхны төлөө бүтээгдэхүүн үйлдвэрлэгч байгууллагуудын зохион байгуулалтад зах зээлүүдийн хуваарилалтын нөлөө, хөдөлмөрийн зах зээлийн оролцоо давамгайлах үүрэгтэй байдаг. Үйлдвэрүүдийн болон ассоциацуудын нийгмийн сайн сайхны төлөө бүтээгдэхүүн үйлдвэрлэлд оруулах хувь нэмэр маш бага байдаг.

Ажилгүйдэл, осол, жирэмсэн эхчүүд, өндөр насны тэтгэвэр зэрэг түгээмэл нийгмийн даатгалууд нь даатгалын шимтгэл болон татвараас санхүүждэг. Үндэсний эрүүл мэндийн алба болон нийгмийн баталгаажих доод түвшин нь зөвхөн татвараас санхүүждэг.

Боловсролын систем

Урт хугацааны туршид Их Британид олон нийт ард түмний

боловсролд анхаарал хандуулдаггүй байлаа. Зөвхөн эцэг эхчүүд хүүхдүүддээ ямар боловсрол олгох тухай шийдвэр гаргах учраас ерөнхий боловсролын сургуульд суралцах эсэх нь сайн дурын асуудал байх ёстой гэдэг үзэл давамгайлж байлаа. Доод давхаргаас гаралтай хүүхдүүдийн хувьд ядуучуудын сургуулиуд байдаг боловч тухайн үеийн нийгмийн харилцааг хүлээн зөвшөөрөхөд чиглэгдсэн шашин - ёс суртахууны хүмүүжилд анхаардаг, сургуулийн боловсролд төдийлөн ач холбогдол өгдөггүй. 1902 оныг хүртэл Их Британид нийтийн шат ахиулан сургах сургуулиуд байгаагүй харин зөвхөн нийтийн тусын төлөө ашгийн бус болон хувийн сургуулиуд байжээ. Төрийн өмнөх сургалтын байгууллагууд нь «байнга анги давхаргуудыг хооронд нь заагласан шинжтэй байсан бөгөөд 20-р зуунд аажмаар уг ангилал бага зэрэг буурсан байна.»

Эрүүл, дайчин цэргүүдийг Британи, Голландаас гаралтай шилжин суурьшигчдын хойч үеийн хооронд Өмнөд Африкт дэгдсэн дайн болох Бурений дайнд хангалттай олон тоогоор дайчлах шаардлага гарсан учраас бүх нийтийн боловсрол олгох сургуулийг олноор нь байгуулж эхэлсэн байна. Анхны боловсролын байгууллага хүүхдүүдийг хоол хүнсээр цадтал хангах даалгавартайгаар байгуулагдаж байжээ. Дэлхийн эдийн засгийн хямрал эхлэх хүртэл улс орон даяар суурь боловсрол олгох сургуулиуд олноороо байгуулагдаж байжээ. Тэдгээр сургуулиудад сурахын тулд 1944 оныг хүртэл сургалтын төлбөр төлдөг байжээ. Дайны дараа дээрх гурван бүрэлдэхүүнтэй сургуулиудыг цаашид байлгах уу? эсвэл нийтийн сургуулиудыг байгуулах уу? гэдэг асуудлаар хурц маргаан өрнөсөн байна. Эцэстээ орон нутгийн хүмүүжлийн байгууллагуудын шийдвэрлэх асуудал хэмээн орхисон байна. Хөдөлмөрийн намуудын тэргүүлж байсан засгийн газрын шахалт дор нийтийн сургуулийн концепцууд хэрэгжиж эхэлсэн байна.» Мэргэжлийн боловсролын салбарт Баруун Европын бусад орнуудаас ялгаатай нь удаан хугацааны туршид бодлогын түвшинд ач

холбогдол өгдөггүй байжээ. Мэргэжлийн бэлтгэлийг тухайн үед олноороо байсан хувийн сургуулиуд ихэвчлэн хангадаг байжээ. Мэргэжлийн боловсролын үнэмлэхийг олгох нэгдсэн комисс байхгүй байжээ. Залуучуудын нэлээд хэсэг нь компаниуд мэргэжлийн боловсролд ач холбогдол өгдөггүй байсан учраас мэргэжлийн боловсролгүйгээр хөдөлмөрийн гараагаа эхэлдэг байжээ. Иймээс залуучуудын ажилгүйдэл ноцтой түвшинд хүрсэн байна. 1988 оноос эхлэн Боловсролын шинэчлэлийн акт «**Education Reform Act**» батлагдсанаар улс төрийн зүгээс сургалтын хөтөлбөрүүдийн ерөнхий агуулгад зааварчилгаа гаргаж сургалт дууссаны дараа нэгдсэн журмаар сертификат олгож байхаар болсон байна.

Дээд сургуулийн байгууллагууд дайны дараа эрчимтэй хөгжсөн байна. Улс орон даяар олон тооны Их Сургуулиуд, Техникийн коллежууд байгуулагдаж дээд боловсрол олох боломжуудыг нэмэгдүүлсэн байна. Энэ арга хэмжээ тодорхой амжилтад хүрсэн байна. Гуравдагч шатны боловсрол олж буй залуучуудын тоо 1988 - 1995 оны хооронд хоёр дахин нэмэгдсэн нь үүний баталгаа юм.

Ерөнхийд нь авч үзвэл Британийн боловсролын систем цөөн тооны өндөр мэргэшсэн элитүүдийн сургалтад ямагт үр дүнтэй байсаар ирсэн. Харин бүх нийтийн боловсролын салбар нь хүн амын нийтлэг бүлгүүдийн боловсрол гэдэг ойлголтод багтдаг бөгөөд төдийлөн амжилтад хүрээгүй, дутагдалтай хэвээр байдаг. Британийн сурагчдын сурлагын амжилт Эдийн Засгийн Хамтын ажиллагааны байгууллагын судалгаагаар харьцангуй сайн дундаас дээгүүр байна. Харин нарийвчилсан судалгааны үр дүнгээс харахад Британийн боловсролын системийн сул талууд харагддаг. Их Британид сурагчдын эцэг эхчүүдийн нийгэм - эдийн засгийн статус хүүхдүүдийн хожмын мэргэжил сонголт, боловсролд шийдвэрлэх нөлөөтэй байдаг. Нийгэм - эдийн засгийн статус султай сурагчдын дээд

сургуульд хамрагдах байдал нийгэм - эдийн засгийн статус өндөртэй хүүхдүүдийнхээс харьцангуй доогуур байна. Төрийн сургууль төгссөн хүүхдүүдийн дөнгөж 27% нь Их сургуульд элсэж байхад хувийн сургууль төгсөгчдийн 82% нь их сургуульд элсэж байна.

Капитализмын хэв шинж

Их Британи либерал зах зээлийн сонгодог хэв шинжид хамрагддаг. Санхүүгийн систем, аж үйлдвэрийн харилцаа, компанийн шийдвэр гаргалтад ажилчдын оролцоо зэрэг нь Германыхаас үндсээрээ өөр зохион байгуулагдсан. Их Британид идэвхтэй өрсөлдөөнтэй зах зээлүүдэд онцгой ач холбогдол өгдөг бөгөөд тэдгээр нь нийгэмд төв удирдан чиглүүлэгч үүргийг гүйцэтгэдэг. Хувьцааны арилжааны зах зээл тэргүүлэх байр суурийг эзэлдэг. Хөдөлмөр эрхлэгсдийн хамгаалал зохицуулалттай зах зээлүүдтэй харьцуулахад харьцангуй сул.

Аж үйлдвэрлэлийн харилцаа

Британи шиг либерал зах зээлийн эдийн засагт ажилтнууд-болон ажил олгогчдын холбоод төдийлөн нөлөөтэй байж чаддаггүй. Хэдийгээр 1970-аад оны дунд үеэс эцэс хүртэл Британийн үйлдвэрчний эвлэл харьцангуй нөлөөтэй байсан боловч дайны дараах үеийн түүхэнд бодит байдал дээр тэдний эрх мэдэл байнга сул хэвээр байжээ. Нэн ялангуяа Тетчерийн засгийн газар үйлдвэрчний эвлэлийн тухай хууль батлуулсан нь үйлдвэрчний ролийг үлэмж хэмжээгээр бууруулан удаан хугацаагаар хязгаарласан байна. Мөн ажил олгогчдын холбооны ач холбогдол буурсаар байна. Тэдний бүтэц Германтай харьцуулахад харьцангуй сул юм. Үүний үр дүнд тарифын гэрээгээр зохицуулагдах хөдөлмөрийн харилцааны тоо буурч аж үйлдвэрлэлийн харилцаанд «түншийн харилцаа автоматаар өөрчлөгдөх» **«atomistic exchange relationship»** хандлага газар авч байна.

Хэлэлцээрүүд ажил олгогч үйлдвэрчний хооронд явагдаж байгаа тохиолдолд тэдний шууд бус нөлөө үйлдвэр аж ахуйн нэгжийн түвшинд хадгалагдаж байдаг. Германд компаниуд олон тооны бие даасан үйлдвэрчний эвлэлийнхэнтэй хэлэлцээрт ордог бол Британийн компаниуд практик дээр «single unionism» буюу «зөвхөн нэг холбоотой» тулдаг байна. Компаниуд зөвхөн нэг үйлдвэрчний эвлэлийн холбоог хэлэлцээрийн түншээр хүлээн зөвшөөрдөг бөгөөд ингэснээрээ олон тооны бие даасан үйлдвэрчний эвлэлүүдтэй хэлэлцээрт орох шаардлагагүй болсон. Уламжлалын дагуу үйлдвэрчний эвлэлүүд нь салбарын бус мэргэжлийн бүтцийн дагуу байгуулагдсан байдаг.

Их Британи шиг либерал зах зээлүүдэд компаниудад компаниудын ажилтнуудын зөвлөл болон ажилтнуудын төлөөллийн бусад байгууллагуудтай байх үүрэг ногддоггүй. Германыхтай төстэй ажилтнуудыг шийдвэр гаргалтад оролцуулах тухай ойлголт Их Британид танил бус. Британийн менежментийн хэсгүүд өөрийн компанид ажиллаж буй ажилтнуудын төлөөлөлд тодорхой нөхцөлд л ач холбогдол өгдөг. Иймээс ажилтнуудын төлөөлөл бүтцийн дахин өөрчлөлтийн явцад компанийн удирдлагын асуудлаар санал солилцох чухал түнш нь болдог.

Мэргэжлийн сургалт, мэргэжил дээшлүүлэх болон давтан сургалт

Их Британид тусгай мэргэжлийн сургалт харьцангуй сул хөгжсөн байдаг. Ажил олгогчдын зүгээс ажилтнуудын эрчимтэй сургалтад төдийлөн ач холбогдол өгдөггүй. Үүнд дараах гурван учир шалтгаан байдаг. Ажилтан албан хаагчдын нэг компанид ажиллах дундаж хугацаа харьцангуй богино байдаг тул хувь хүн бүрд хийсэн хөрөнгө оруулалт эргэж нөхөгдөхгүй байх аюул байнга нүүрлэж байдаг. Өөрөөр хэлбэл байнгын өрсөлдөөн дунд оршдог компаниудад боломж олддоггүй. **Хоёрдох**

үндэслэл нь нэгдүгээрх үндэслэлтэйгээ уялдаатай. Маш уян хатан хөдөлмөрийн зах зээл дээр өндөр мэргэшсэн ажилтнуудыг богино хугацаанд шаардагдах боловч шаардлагатай тохиолдолд мөн богино хугацааны дараа тэднийг халах шаардлага тулгардаг. **Гуравдугаарт:** аж үйлдвэрийн болон компаниудын онцгой чадваруудад суурилсан өрсөлдөөний давуу талуудыг бий болгох шаардлага зохицуулалттай зах зээлүүдтэй харьцуулахад харьцангуй бага юм. Иймээс Британийн хөдөлмөрийн зах зээлийн өрсөлдөөний давуу тал урьдын адил бүтээмжийн доод түвшинд хэвээр байгаа юм.»

Ажилтнууд ч компанийн онцлогт тохирсон нарийн мэргэжил эзэмшихийг төдийлөн хүсдэггүй, харьцангуй богино хугацаанд ямар нэг компанид харьяалагддаг тул бусад компаниуд болон салбаруудад ч хэрэг болох ерөнхий мэргэжил эзэмшсэн байх нь илүү ашигтай байдаг. Иймээс Их Британийн компаниуд үйлдвэрлэхэд хялбар, стандартчилагдсан үйлдвэрлэлийн арга дээр илүү анхаардаг. Үүнээс үүдэлтэй бүтээмжийн хоцрогдлын талаар дэлхийн хоёрдугаар дайнаас хойш засгийн эрхийг барьсан бүх засгийн газрууд шүүмжилсээр ирсэн боловч дорвитой арга хэмжээ аваагүй өдий хүрчээ. Холл Соскисе нарын үзэж буйгаар бол компанийн онцлогт тохирсон нарийн мэргэжлээс ерөнхий мэргэжлийг дэмжих нь Британийн эдийн засагт илүү ашигтай. (Ямартай ч одоохондоо) Эдгээр нөхцөлүүдээс харахад өдгөө засгийн эрхэнд байгаа Хөдөлмөрийн намын боловсролын бодлогыг ерөнхий боловсрол дээр төвлөрүүлэх арга хэмжээнүүд авч буй нь нэг их гайхалтай хэрэг биш юм. Мэргэжлийн боловсролыг дэмжих «**University for Industry**» буюу «Аж үйлдвэрийн их сургуулийг» байгуулах зэрэг арга хэмжээнүүд авах нь ховор байдаг.

Компаниудын дотоод бүтэц ба тэдгээрийн
хоорондын харилцаа

Либерал зах зээлийн менежерүүд зохицуулалттай зах зээлийн

менежерүүдээс илүүтэй өндөр ашгийн төлөө ажилладаг. Уг зорилгодоо хүрэхийн тулд менежментийн мэдэлд хэрэгжүүлэлтийн ихээхэн нөөц байдаг. Германд шийдвэр гаргах эрх бүхий тэргүүлэх менежментэд хяналтын зөвлөл хяналт тавьж шийдвэр гаргахдаа ажилтнуудын төлөөлөл, хувьцаа эзэмшигчидтэй зөвшилцдөг бол Британийн компаниудын эрх мэдэл хүчтэй төвлөрсөн байдаг. «**Chief Executive Officer**» буюу «Гүйцэтгэх зөвлөлийн дарга» компани болон удирдлагыг удирддаг бөгөөд түүнд хяналтын зөвлөл, ажилтнуудын хэн нь ч ямар нэг хязгаарлалт тавих боломжгүй. Гүйцэтгэх зөвлөл шийдвэрээ дангаараа ихэнхдээ бусад менежерүүдтэй зөвлөлдөн гаргаж хариуцлагаа дангаараа хүлээдэг. Шийдвэр дээрээсээ доош чиглэсэн байдаг. Британийн компаниуд «**CEO dominated system**» буюу «Гүйцэтгэх зөвлөл давамгайлсан» бүтэцтэй байдаг. Компаниуд зохицуулалттай зах зээлийнхтэй харьцуулбал илүү уян хатан байдаг. Хөдөлмөр эрхлэгсдийн хамгаалалт тун сул байдаг нь маш богино хугацаанд чиглэлээ өөрчлөх боломжийг компаниудад олгодог.

Компаниудын хоорондын харилцаа зах зээлийн харилцаан дээр суурилдаг бөгөөд заргалдах боломжтой хэлбэр төдий эрх зүйн харилцаанд оршдог. Шинэ технологи нэвтрүүлэхдээ ихэвчлэн шинжлэх ухаан, техникийн өндөр боловсролтой хүмүүсийг авч ажиллуулах замаар хийдэг. Судалгааны институтүүдийн эрдэмтэд, инженерүүд чөлөөт эдийн засаг руу шилжих, эдийн засгаас шинжлэх ухаан уруу шилжих нь сонгодог зохицуулалттай эдийн засагтай харьцуулахад харьцангуй их байдаг. Компаниудын хамтарсан болон удаан хугацааны хамтын ажиллагааны сүлжээнүүд харьцангуй ховор байдаг.

- Санхүүгийн системүүд болон компаниудын өмчийн бүтцүүд Их Британид компанийн тухайн үеийн бодит орлогын байдал маш чухал байр суурийг эзэлдэг. Уг орлогын хэмжээ нь маш

эрчимтэй санхүүгийн зах зээл дээр хөрөнгө олж авах боломжийг шийддэг. Өндөр чадвартай хөрөнгө оруулагчид компаниудын дотоод мэдээлэлд нэвтрэх боломжоор хязгаарлагдмал байдаг нь Германы «Сүлжээний мониторингийн сүлжээ»-ний системтэй харьцуулахад өөр бөгөөд санхүүгийн байдлын үнэлгээ нь олон нийтэд нээлттэй үнэлгээний шалгууруудаас хамаардаг бөгөөд эдгээр нь тухайн компаниудын ашгаас голлон хамаардаг. Түүнээс гадна Их Британид өмчийн өөр бүтэц компаниудын орлогын байдалд зохицуулалттай зах зээлийн эдийн засгаас илүүтэйгээр нөлөөлдөг. Германд компаниудын хувь нийлүүлэгчдийн дийлэнх нь стратегийн сонирхол бүхий хөрөнгө оруулагчид байдаг бол Их Британийн Компаниуд-Банкнуд - төсвийн секторт өөр дүр зураг ажиглагддаг. Британийн компаниудын өмчлөгчдийн 80 орчим хувь нь өндөр ашиг олох сонирхол бүхий форт - фолио хөрөнгө оруулагчид, гэр бүлийн өмчлөлийнхөн байдаг. Өндөр ашиг олох зорилго нь Британийн компаниудыг шинэ секторуудад техникийн дэвшилд суурилсан өөрчлөлтүүдийг хийх, бэхэжсэн секторуудад үнийн өрсөлдөөн хийхэд хүргэдэг. Хурдан хугацаанд өндөр ашигт хүрэхийн тулд «Дайсагнагч» компаниудыг худалдан авах нь зах зээлийн санхүүжилт хангалттай, санхүүгийн зах зээлүүдийн бүтцийн улмаас зохицуулалттай зах зээлтэй харьцуулбал илүү хялбар байдаг. Орлого олоход чиглэгдсэн бүтэц нь гайхалтай хүнд суртал багатай бүтэцтэй хослоод Британийн компаниудад өндөр ашиг олох шинэ зах зээлд ороход чиглэгдсэн бүтцийн өөрчлөлтүүдийг түргэн хугацаанд хийх боломжуудыг олгодог. Ашиг орлого багатай салбаруудаас мөн түргэн хугацаанд гарах боломжийг бүрдүүлдэг. Нөгөө талаас энэ чиглэл Британийн эдийн засгийн онцлогийг «**short - termism**» буюу түргэн хугацаанд өөрчлөлтөд ордог гэж тодорхойлогдоход хүргэдэг.

Компаниудын ажилтнуудтайгаа харьцах харьцаа
Компаниудын ажилтан тус бүртэйгээ харилцах харилцаанд зохицуулалттай зах зээлүүдтэй харьцуулахад зах зээлийн хүчнүүдийн нөлөөлөл асар хүчтэй байдаг. Ажилтнууд харьцангуй

богино хугацаанд аливаа нэг компанид харьяалалтай байдаг тул компаниуд ба ажилтнуудын хоорондын холбоо сул байдаг. Үйлдвэрчний эвлэлийн байгууллагууд нь сул, ажлаас халагдахаас хамгаалах хамгаалал сайнгүй учир богино хугацааны дотор ажлаас халагдах магадлал өндөр байдаг. Нөгөөтээгүүр уян хатан хөдөлмөрийн зах зээл дээр өндөр боловсролтой ажилчдад шинээр ажлын байр олох нь хялбар байдаг.

Британийн компаниуд зохицуулалттай зах зээл дээр үйл ажиллагаа явуулж буй компаниудтай харьцуулахад хүнд суртал багатай байдаг. Компаниудын гүйцэтгэх зөвлөл хөдөлмөр зохион байгуулалтад мөн голлох үүрэг гүйцэтгэдэг. Герман улстай харьцуулахад мэргэжлийн өндөр ур чадвартай ажилтнуудын баг болон ажиллах байдал тун сул байдаг. Хөдөлмөрийн хуваарилалтад уламжлалт, хатуу хувиар хадгалагдан үлджээ.

Улс төрийн соёл ба иргэний нийгэм

Их Британийн улс төрийн соёл хоёр үндсэн чиглэлээр тодорхойлогддог: Норматив нэгдэл сул ба прагматизм хүчтэй. Дэлхийн дайны дараа тогтсон үнэлэмжийн олон ургальч байдал өнөө ч үргэлжилсэн хэвээр. Консервативчууд болон «Хөдөлмөрийн нам»-ын үнэлэмжүүд хоорондоо асар ялгаатай хэвээр. Консервативчууд либертар шийдлүүдийг илүүд үзэж ядуусын асуудлыг хэрэгцээнд нийцүүлэн шийдэхийг уриалдаг бол «Хөдөлмөрийн нам» нийгэмд чиглэсэн амьдралын боломжуудыг тэгшитгэх бодлогыг баримталдаг. Британийн бодлогын норматив түвшинг эс харгалзан үзвэл прагматизм чухал байр суурь эзэлдэг. Үүний нэг жишээ бол «Хөдөлмөрийн нам» төсвийн секторын шинэчлэлийг **«What counts is what works»** уриатайгаар хийсэн байна. Нэн ялангуяа энэхүү бодлогын прагматизм Европын бодлого дээр хүчтэй илэрдэг бөгөөд эх газрын Европчуудын ирээдүйд чиглэсэн бодлоготой зөрчилддөг байна. Мөн нормативын нэгдэл сул, прагматик чиг хандлага давамгайлдаг нь шинэчлэл Европын бусад хэсгүүдээс

эрчимтэй явагдахад нөлөөлдөг.

Иргэний нийгмийн идэвх зүтгэл ба ардчилсан оролцоо нь зөрчилтэй дүр зургийг харуулдаг. Нэг талаас сүүлийн жилүүдэд нийтийн тусын төлөө ашгийн бус байгууллагуудын нийгмийн сайн сайхны төлөө болон байгаль орчны салбарт гишүүдийн тоо нь өссөн байна. 1950-аад оны үед сонгогчдын сонгуульд оролцох оролцоо 70-80 хувийн хооронд хэлбэлзэж байсан бол энэ хооронд 59 хувь болтлоо буурсан байна. Үүнийг «Хөдөлмөрийн нам»-ын тодорхойгүй байр суурь, бодлогын олон салбаруудад нөлөө бүхий намуудын улс төрчид хоорондоо бараг ялгагдахгүй байр суурь баримталж буйтай холбон тайлбарладаг. Социологи судлаач Филипп Коулд улс төрд урам хугарсан иргэдийн тоо өсөж байгааг тогтоосон байна. Хүн амын дийлэнх хэсэг улс төрийг сонирхохоо больсон байна.

Өнөө ба ирээдүй

Британийн нийгмийн баримжаат төрийн өнөөгийн хөгжлийг олон улсын түвшинд харьцуулан үзвэл «Блайризм» хүлээн зөвшөөрөхгүй байхын аргагүй олон амжилтад хүрээд байгаа юм. Үндсэн эрхүүдийг Британийн үндсэн хуулиар баталгаажуулсан. Цалингийн доод түвшин, нийгмийн халамжийн хэмжээг нэмэгдүүлэх, тэтгэврийн доод хэмжээг тогтоох, ядуусын тоог бууруулсан зэргийг дурдаж болно. Түүнээс гадна дороос дээш чиглэсэн дахин хуваарилалт хурцдаагүй, юуны өмнө макро эдийн засгийн сайн менежментийг нэвтрүүлж, нийгмийн халамжийн хуваарилалтад өөрчлөлт оруулснаар хөдөлмөр эрхлэгсдийн тоог эрс нэмэгдүүлсэн. Гэсэн хэдий ч тэтгэврийнхэн болон хүүхдүүдийн дунд ядуурал өндөр, «**in work poverty**» буюу хөдөлмөр эрхэлж буй хүмүүсийн дунд ч ядуурал өндөр, боловсрол эзэмших боломж ба нийгэм - эдийн засгийн статусын хоорондын хамаарал өндөр, зохицуулалтгүй хөдөлмөрийн зах зээл, сүүлийн үед хүн амын дийлэнх хэсэг нь улс төрөөс хөндийрсөн зэрэг хүндрэлтэй асуудлууд оршсоор байна.

7.4 Голланд

Улс төрийн систем

Голланд улс экспортлогчдын дунд тэргүүлэх байр эзэлдэг, төвлөрсөн бүтэцтэй орон. Үйлдвэрчний эвлэлийнхний хоорондын нэгдэл сул, хөдөлмөр эрхлэгсдийн 38% нь үйлдвэрчний эвлэлийн зохион байгуулалтад орсон нь Скандинавын бусад улсуудтай харьцуулахад харьцангуй доогуур үзүүлэлт юм. Голланд улсын хувьд социал демократууд давамгайлах байр суурьтай гэж хэлэх боломжгүй. Учир нь консервативчууд парламентад голлох үүрэгтэй байдаг бөгөөд бүх нийтэд сонгуулийн эрх олгогдсон цагаас хойш Христосын ардчиллагчид тогтмол засгийн газрын бүрэлдэхүүнд багтаж ирсэн. Голланд нь парламентын засаглалтай эзэнт улс. Голландын парламент хоёр танхимтай. Нэгдэх танхим нь 75 гишүүнтэй, тэднийг сенаторууд гэж нэрлэдэг. Тэд муж улсуудын гишүүдээс дөрвөн жилийн хугацаатайгаар сонгогддог. Хоёрдугаар танхим 150 гишүүдтэй бөгөөд мөн дөрвөн жилийн хугацаатайгаар сонгогддог. Хоёр танхимд нэгэн зэрэг гишүүн байж болохгүй. Мөн танхимын гишүүд сайд болон төрийн нарийн бичгийн даргын албыг нэгэн зэрэг хашиж болохгүй. Голландад уламжлал ёсоор парламент ба засгийн газар нь хоёр тусдаа салбар байсаар ирсэн. Гишүүдэд хувь хүний хувьд болон боловсрол мэдлэгийн хувьд харилцан адилгүй шаардлага тавигддаг. Иймээс парламентын ажлын туршлага бүхий сайдууд ба төрийн сайдуудын эзлэх хувь европын бусад орнуудтай харьцуулбал харьцангуй бага юм.

Хатан хаан ардчилсан хууль ёсны дагуу баталгаажаагүй ч засгийн газрыг бүрдүүлэхэд нөлөөлөх боломжтой байхад парламентын нөлөө сул байна гэсэн шүүмжлэл олонтаа гардаг. Парламент засгийн газрыг баталдаггүй, мөн итгэл үзүүлэх эсэх тухай санал хураалт явагддаггүй. Мэдээж засгийн газарт итгэл үл үзүүлэх эсэх тухай санал хураадаггүй тул огцрохыг шаардах боломжгүй. Гэхдээ үндсэн хуульд «Засгийн газар парламентын

өмнө хариуцлага хүлээх» үндсэн зарчмыг хуульчилсан байдаг тул хатан хаан хоёрдох танхимын дийлэнх олонхын саналыг аваагүй хэн нэгнийг ерөнхий сайдад санал болгох эрхгүй.

ХБНГУ-тай харьцуулахад Голландад үндсэн хуулийн шүүхийн тогтолцоо байдаггүй. Парламентаас батлагдан гарч буй хуулиудыг үндсэн хуулийн үзэл санаанд нийцэж буй эсэхэд хяналт тавих үүрэг бүхий дээд шатны шүүх байдаггүй.

Голландын сонгуулийн тогтолцоо нь олон улсад цэвэр пропорционал сонгуулийн тогтолцооны үлгэр жишээ болдог. Ямар нэг босго тогтоодоггүй тул хоёрдугаар танхимын гишүүн болоход 0.67%-ийн санал хангалттай. Нийт улс орныг засаг захиргааны хувьд 19 танхимын сонгуулийн тойрогт хуваадаг. Эдгээр тойргуудад улстөрийн намууд өөр өөр нэрдэвшигчдийн жагсаалтыг дэвшүүлдэг нь өнөө үед ховор тохиолдол болсон байна. Улс төрийн намуудын тэргүүлэх нэр дэвшигчид буюу ялсан тохиолдолд ерөнхий сайд болох нэр дэвшигчийн нэрийг тухайн намын нэрсийн жагсаалтын эхэнд бичдэг. Сонгогчдын дийлэнх нь буюу ойролцоогоор 90% нь намуудын нэр дэвшигчдийн жагсаалтын эхний нэрийг чагталдаг. Голландад улс төрийн намуудын үүргийг үндсэн хуулиар онцгойлон заадаггүй. Намууд чөлөөт нэгдлүүд бөгөөд эвсэл холбоодын тухай иргэний хууль зүйн эмхтгэлийн заалтуудыг дагаж мөрддөг. Энэ нь намуудын дотоод ардчилсан бүтэц эсвэл намуудын санхүүжилт болон зарцуулалтын хяналтын тухай заалт байдаггүй гэсэн үг юм. Улсын төсвөөс мөн намуудад шууд санхүүжилт олгодоггүй. Зөвхөн сонгуулийн кампанит ажлын сурталчилгаанд бага зэргийн санхүүжилт олгодог. Харин фракцууд болон депутат тус бүрийн ажилд улсын төсвөөс шууд санхүүжилт олгодог.

Үндсэн эрхүүдийн систем

Сонгодог эрх чөлөөний эрхүүд болон үндсэн эрхүүд Голландад

үндсэн хуулийн үндсэн бүрэлдэхүүн хэсэг болох үндсэн эрхүүдийн каталогт 1-р бүлгийн 1 - 23-р зүйлд тусгагдсан байдаг. Нэн түрүүнд шашин шүтлэг, улс төрийн итгэл үнэмшил, үндэс угсаа, хүйс, бусад ямар нэгэн шинжийн улмаас аливаа хэлбэрээр ялгаварлан гадуурхахыг хориглоно гэж заасан байдаг. Үндсэн хуулиар либерал эрх чөлөөний эрхүүдээс гадна нийгмийн үндсэн эрхүүдийг баталгаажуулсан байдаг. Хангалуун чинээлэг амьдрал, өмч хөрөнгийг шударгаар хуваарилах, ажлын байрыг шинээр бий болгох, баталгаажуулах, нийгмийн хамгааллын өргөн хүрээтэй систем, амьжиргааны баталгааг хангах байгаль орчны нөхцөлийг дахин бүрдүүлэх, хэвээр хадгалах нь төрийн үүрэг мөн гэж заасан байдаг. (14-р бүлэг, 19 - 21-р зүйл.) Үндсэн хуулийн дээрх зүйлүүд нь зөвхөн шаардсан шинж чанартай. Эдгээрт Германы үндсэн эрхүүд шиг зөвхөн хувь хүмүүсийн, баталгаажуулахыг шаардах эрх бүхий эрхүүд биш юм.

Өндөр насны тэтгэвэрт гарсан хойноо амьжиргааны баталгаатай эх үүсвэрээр хангуулах үндсэн эрхийг Голландад өндөр насны нэгдсэн даатгалаас хангадаг. Хөдөлмөр эрхэлж байх хугацаандаа хэр хэмжээний даатгалын шимтгэл төлж байснаас үл хамааран бүх иргэд 64 насанд бүрэн хүрснийхээ дараа өндөр насны тэтгэвэр тогтоолгох эрхтэй. Өндөр насны нэгдсэн даатгал ард түмний даатгалын нэг хэлбэр бөгөөд Голландад оршин суугч бүр хамрагддаг.

Үйлдвэрчний эвлэлийн байгууллага байгуулах үндсэн эрхийг бүх ажилтнууд эдэлдэг. Цагдаа, төрийн албан хаагчид, армийн албан хаагч нар мөн дээрх эрхээ эдэлдэг. Нийт хөдөлмөр эрхлэгсдийн 28% нь өнөөгийн байдлаар үйлдвэрчний эвлэлийн зохион байгуулалтад ороод байна.

Нийгмийн баримжаат төр

Голландад нийгмийн даатгалын хөгжил хоёр өөр үе шатыг

туулсан байна. Нэгдүгээр үе нь дэлхийн хоёрдугаар дайныг дуустал үргэлжилсэн. Хоёрдугаар үе нь 1945 оноос өнөөг хүртэл. Нэгдүгээр үед Германы Бисмаркийн загварын ажилтнуудын нийгмийн даатгалтай төстэй нийгмийн даатгалыг нэвтрүүлсэн. Нийгмийн даатгалын газрууд нь Германыхаас өөр буюу төр болон эдийн засгийн байгууллагууд байдаг. Нийгэм - улс төрийн идэвх санаачилгын хоёрдугаар шатанд Веберижийн - загвартай төстэй шинэ хэлбэрийн нийгмийн даатгал байгуулагдсан байна. Ийнхүү ард түмний даатгалын суурь тавигджээ. Эдгээр даатгалын газрууд нь төрийн байгууллагууд байлаа. Хөдөлмөр эрхэлдэг эсэхээс үл хамааран аливаа эрсдэлээс бүх ард түмнийг нийтэд нь хамгаалах нь уг даатгалын үндсэн санаа байлаа. 1957 онд өдөр настны хууль батлагдан гарсны дараа анхны ард түмний даатгал хэрэгжиж эхэлсэн байна. Энэхүү хууль даатгалын санаан дээр суурилсан боловч Голландын бүх ард түмнийг хамарч байлаа. Тэтгэврийн хэмжээ даатгалын санд төлсөн урамшууллын хэмжээнээс хамаарахгүй, хуулиар хатуу тогтоосон хэмжээтэй байлаа. Даатгал нь хөдөлмөр эрхлэгсдийг бус харин Голландад оршин суудаг иргэн бүрийг хамруулах үүрэгтэй. Мөн бэлэвсэн - өнчиний тухай хууль, хүүхдийн хуримтлалын тухай хуулиудыг мөн Голландын нийт оршин суугчдыг хамруулах үндсэн чиглэлд тохируулан өөрчилсөн байна. Өнөөгийн байдлаар Голландад ард түмний таван даатгал, ажилтнуудын дөрвөн даатгал үйл ажиллагаа явуулдаг.

Голландын бүх нийтийн сайн сайхны төлөөх төр нь Баруун Европын цорын ганц холимог хэлбэр юм. Хэдийгээр хувь хүртэх хүмүүсийн хүрээг бүх ард түмнийг хамруулан тэлсэн ч даатгалын ерөнхий зарчим алдагдаагүй. Ард түмний даатгал болон ажилтнуудын даатгалын сонгодог хэлбэрүүд зэрэгцэн оршдог. Европын холбооны хүрээнд Голландын даатгалын систем нь хамгийн өндөр хүчин чадалтай, хамгийн өргөн хүрээтэй системд тооцогддог. Нэн ялангуяа хувь хүмүүст

зориулсан гэрээр нь асрах, гэр бүлийн халамж, өвчтөнүүдийг амбулаториор эмчлэх, өндөр настны хөдөлмөр эрхлэлт, залуучуудын хөдөлмөр эрхлэлт зэрэг салбарт хамгийн өндөр хөгжсөн.

Капитализмын хэв шинж

Петер Холл, Девид Соскисе нарын хэв шинжийн судалгааны дагуу Голландын капитализм нь зохицуулалттай эдийн засгийн хэлбэрт хамаарна. Ямар шалгуураар энэ хэлбэрт хамруулах болсон шалтгаанууд болон Голландын аж үйлдвэрийн харилцааны хэлбэрүүдийг авч үзвэл:

- Полдерийн загвар

1994 оноос Голланд орон ажлын байрыг нэмэгдүүлснээр ажилгүйдэл буурч эдийн засаг нь үсрэнгүй хөгжилд хүрч гялалзаж эхэлсэн байна. Голландын энэ хөгжил гадаад орнуудын анхаарлын гадна үлдсэнгүй, хүмүүс Голландын гайхамшиг буюу **«dutch miracle»** ба «Полдерийн загвар»-ын тухай ярьцгааж байлаа. Юуны өмнө урт хугацааны цалингийн хөнгөлөлт, үйлдвэрчний эвлэлүүдийн хамтын ажиллагааг эрмэлзсэн хандлага, ажил олгогчид ба ажилтнуудын хоорондын мэдээлэл солилцох харилцаа болон нийгмийн түншүүд, засгийн газар, байгууллагуудын оролцоо зэрэг нь гадаад ертөнцийн анхаарлыг татаж байлаа. Полдерийн загварын онцлог шинжүүд нь юуны өмнө **«Stichting van de Arbeid»** буюу «Хөдөлмөрийн сан», **«Sociaal Economische Raad»** буюу «Нийгэм - эдийн засгийн зөвлөл» байлаа.

Хамтын ажиллагааны эдгээр байгууллагууд нь дайны дараах үеэс тогтворжиж эхэлсэн. 1945 онд байгуулагдсан «Хөдөлмөрийн сан» нь нийгмийн түншүүд ба засгийн газар хоорондын хэлэлцээрт хамгийн чухал үүрэгтэй байгууллага юм. Уг сан өнөөг хүртэл эдийн засгийн амьдралын бүх салбарт үйл ажиллагаа явуулдаг. Жишээ нь: цалингийн бодлого,

нийгмийн даатгал, хөдөлмөрийн харилцааны зохицуулалт зэрэг. Үүсэн байгуулагдсанахаа дараа «Хөдөлмөрийн сан» нь засгийн газарт зөвлөгөө өгөх үүрэгтэй байжээ. Уг сан зөвлөх үүргээ 1950 онд шинээр байгуулагдсан «**Sozial - Economische Raad**» буюу «Нийгэм эдийн засгийн зөвлөл»-д НЭЗЗ шилжүүлэн өгсөн байна. НЭЗЗ нь гурван талт бүтэц бүхий хөдөлмөр, хөрөнгө, титэмтний удирдах дээд түвшнээс тус бүр 11 төлөөллийг багтаасан байгууллага юм. Титэмтний төлөөлөл гэдэг нь засгийн газрын төлөөлөл бус харин төв банкны ерөнхийлөгч, Ерөнхий Төлөвлөлтийн газрын дарга, эдийн засагч эрдэмтэд болон өмнө нь өндөр албан тушаал хашиж байсан улс төрчдийн төлөөлөл юм. Эдгээр хүмүүс өөрсдийн туршлага дээр тулгуурлан удирдах үүрэгтэйгээр оролцдог. Засгийн газар, Холбоодын хоорондын хэлэлцээрүүд ихэвчлэн хөдөлмөрийн сан дээр явагддаг. Дээрх хоёр шийдвэр гаргалтын байгууллагуудын гүйцэтгэж ирсэн үүргийн улмаас зөвхөн Голландын хэлэлцээрийн уламжлал гэж нэрлэгддэг, удаан хугацааны туршлага бүхий байгууллагууд юм.

Аж үйлдвэрийн харилцаанд байгууллагуудын хүрээлээр дамжуулан хариуцлага ногдуулах энэхүү онцлог хэлбэр нь бүх талаараа сайн байсангүй. 1990-ээд оны хөдөлмөр эрхлэлтэд гарсан их амжилт нь олон талт цогц арга хэмжээний үр дүн байсан юм.

- Цалингийн тодорхой хэсгээр фонд бүрдүүлэх Ваассенарын хэлэлцээр
- Ажил олгогчдыг мэргэжлийн ур чадвар багатай ажилчдыг ажилд авсан тохиолдолд цалингийн хөнгөлөлт олгох
- Ажлын цагийг илүү уян хатан болгох
- Эрүүл мэнд болон хөдөлмөрийн чадвараа алдалтын даатгалын шинэчлэл хийсэн.
- Хагас өдрөөр хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого явуулсан.

- Цалингийн тодорхой хэсгээр фонд бүрдүүлэх

Цалингийн тодорхой хэсгээр фонд бүрдүүлэх бодлогыг 1982 онд Үйлдвэрчний эвлэл ба ажил олгогч эздийн хооронд хийгдсэн ерөнхий хэлэлцээрийн үр дүнд хэрэгжүүлж эхэлсэн байна. /Ваассенарын хэлэлцээр/ Тухайн үеийн үйлдвэрчний холбооны удирдагч асан Уим Кок, Хрис фон Веен нар хэлэлцээрийн энэ заалтыг оруулсан нь төрийн оролцоогүйгээр хоёр талт хэлэлцээрийг дахин эхлүүлсэн юм. Энэ хэлэлцээрийн үр дүнд Голландын эдийн засаг шинэ нөхцөл буюу олон улсын тавцан дээрх өрсөлдөөн, даяаршилд амжилттай дасан зохицож чадсан байна. Уг хэлэлцээр Голландын үндэстний мөнгөн тэмдэгтийн хөрвөх бодит ханшийг бууруулах, Голландын компаниуд болон бүтээгдэхүүнүүдийн өрсөлдөх чадварыг сайжруулахад хувь нэмрээ оруулсан юм. Цалингийн тодорхой хэсгээр фонд бүрдүүлэх бодлого нь солилцооны хоёр арилжааг агуулж байгаа юм. **Нэгдүгээрт:** Орчин үед долоо хоног тутмын болон жилийн нийт ажлын цаг буурч буйтай солилцож байгаа юм. **Хоёрдугаарт:** Цалингийн тодорхой хэсгээр фонд бүрдүүлэх бодлого нь татвар, нийгмийн даатгалын шимтгэлийг бууруулсныг нөхөж байгаа юм. Төсвийн секторын санхүүжилт сайжирсан, үйлчилгээний салбарт ажлын байрууд шинээр буй болгосноор татвар төлөгчдийн эгнээ өссөн нь цалингийн тодорхой хэсгээр фонд бүрдүүлэх арга хэмжээг санхүүжүүлэх эх үүсвэрийг бүрдүүлсэн байна. Хөдөлмөр эрхлэлт эрс нэмэгдсэн нь дээрх хэлэлцээрийг амжилтад хүргэх үндэс болсон байна.

Мэргэжлийн ур чадвар багатай ажилтнуудад цалингийн хөнгөлөлт үзүүлэх

1990 онд дэвшүүлэн тавьсан хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд мэргэжлийн ур чадвар шаардахгүй, хялбар, цалин хөлс багатай ажлын байруудыг туршлага багатай, мэргэжлийн ур чадвар доогуур ажилтнуудад зориулан олноор нь бий болгох зорилт багтаж байлаа. 1994 оноос мэргэжил эзэмшээгүй, бага цалинтай ажилтнуудыг хөдөлмөр

эрхлэлтэд татан оролцуулахад чиглэгдсэн нэлээд олон тооны төсөл хөтөлбөрүүд хэрэгжиж эхэлсэн. Энэ үеэс залуучуудын ажилгүйдэл, удаан хугацаагаар ажилгүй байгаа хүмүүсийн тоо буурсан байна. «Мелкертийн ажил» гэж тухайн үеийн Нийгэм - Хөдөлмөр эрхлэлтийн сайдын нэрээр нэрлэгдсэн ажлын байрууд үүний нэг жишээ юм. Ажилгүй залууст зориулан төсвийн салбарт ажлын байруудыг бий болгосон байна. Залуучууд долоо хоног тутамд нийтдээ 32 цагийн ажлыг хийж цалингийн доод түвшний 120% хүртэлх хэмжээний цалинг авна. Нэмэгдэл болгож ажил олгогчдод засгийн газраас эдгээр ажилтнуудын нийгмийн даатгалын шимтгэлээс тодорхой хувь хэмжээгээр болон бүтэн чөлөөлөх зэрэг хөдөлмөр эрхлэлтийн тусгай хөнгөлөлтүүдийг нэвтрүүлсэн байна. Нэн түрүүнд удаан хугацаагаар ажилгүй байсан эмэгтэйчүүд, үндэстний цөөнхүүд, мэргэжлийн ур чадвар багатай ажилтнуудад энэ арга хэмжээ үр өгөөжөө өгсөн байна. Сүүлийн үед цагийн хөлс нь цалингийн доод түвшний 115%-тай тэнцэх хэмжээнд хүртэлх ажлуудад дээрх дэмжлэгүүдийг үзүүлдэг болсон байна. Засгийн газраас үзүүлэх хөнгөлөлтийн хэмжээ дээд тал нь жилийн орлогын 25%-тай тэнцүү хэмжээнд байж болно. Ихэвчлэн ажил мэргэжлийн гараагаа шинээр эрхлэгсэд энэ саналыг хүлээн авдаг.

Ажлын цагийн уян хатан зохицуулалт

1996 онд Голланд улсад «Уян хатан байдал ба Аюулгүй ажиллагаа» хоёр талт хэлэлцээр байгуулагдсан байна. Энэхүү хэлэлцээр нь хөдөлмөрийн зах зээлийн уян хатан байдал ба нийгмийн баталгааг илүү сайжруулах арга хэмжээний шинэ тэнцвэрийг хангахад чиглэгдсэн учраас ажил олгогчид, ажилтнуудын хооронд төдийгүй найдвартай ажлын байранд ажиллагсад, найдваргүй ажлын байранд ажиллагсад хоёрын хооронд харилцан буулт болсон юм. Ингэснээр найдваргүй хөдөлмөрийн харилцаа жишээ нь: Цагаар ажиллагсад, хувиараа хөдөлмөр эрхлэгсдийн нийгмийн баталгаа сайжирч байгаа юм. Хувиараа хөдөлмөр эрхлэгсэд аль нэгэн ажил олгогчид

тасралтгүй гурван сар ажилласан бол хөдөлмөрийн гэрээ нь автоматаар хүчин төгөлдөр болдог. Хөдөлмөрийн харилцаанд орсны дараах туршилтын хугацаа богиносгож тасралтгүй гурван жил ажилласан тохиолдолд хугацаат хөдөлмөрийн гэрээг хугацаагүй хөдөлмөрийн гэрээгээр солих тухай хэлэлцээр хийгдэнэ. Илүү уян хатан байдлыг бий болгохын тулд ажлаас халагдахаас хамгаалах хугацааг дээд тал нь зургаан сар байсныг дөрвөн сар хүртэл богиносгож цагаар ажиллагсдын цагаар ажиллах дээд хугацааг зургаан сар байхаар тогтоосон нь цагаар ажиллах компаниудыг үүсгэн байгуулах нөхцөлүүдийг хөнгөвчилсөн арга хэмжээ болсон юм.

Хөдөлмөрийн чадвар алдалтын даатгалын шинэчлэл
Хөдөлмөр эрхлэлтийн коэффициентыг дээд зэргээр нэмэгдүүлэх тухай Голландын бодлогын гол зорилт нь хөдөлмөр эрхлэлтийг дуусгавар болгох хугацааг илүү хатуу тогтоох, тэр ч байтугай аливаа хөнгөлөлт үзүүлэхгүй байхыг шаардсан юм. Иймээс засгийн газар нь хэдийгээр үйлдвэрчний эвлэлийнхний эсэргүүцэлтэй тулгарч байсан ч эрүүл мэндийн болон хөдөлмөрийн чадвар алдалтын даатгалыг өөрчлөн зохион байгуулахаар шийдвэрлэсэн юм. 1992 онд ажил олгогчдын санхүүгийн сонирхлыг татахуйц шинэ хуулийг батлан гаргаснаар ажил олгогчид хөдөлмөрийн чадвар алдалтын даатгалыг орон тооны илүүдэлтэй ажилтнуудаасаа салахад ашиглахаа больсон байна. Хөдөлмөрийн чадвараа алдалтын тодорхой хувь бүхий ажилтнуудыг нэг жил ба түүнээс дээш хугацаанд ажиллуулсан ажил олгогчид тэдний жилийн нийт цалингийн тавин хувь хүртэлх хэмжээний бонус олгож байхаар болсон байна. 1994 онд батлагдан гарсан эрүүл мэндийн даатгалын тухай шинэ хуулийн дагуу өвчтэй байх хугацаанд олгох мөнгийг эрүүл мэндийн даатгалын кассуудаас ажил олгогч уруу шилжүүлдэг болсон байна. Ингэснээр ажилтан ажлын байран дээрээ байхгүй байх хугацааны зардлыг өвчлөл, ослоор багасгах боломжтой болжээ. Ажил олгогчдыг

хөнгөвчлөхийн тулд эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн хэмжээг нийт цалингийн дөрвөн хувьд хүртэл бууруулсан байна.

Хагас өдрөөр хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого Голландын замналын бусад чухал элементүүд бол асар түргэн хугацаанд нэмэгдэж буй хагас өдрөөр хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн зах зээл дэх эмэгтэйчүүдийн оролцоо нэмэгдэж буй явдал юм. Гучин жилийн өмнө тус улс эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтээр эдийн засгийн хөгжлийн хамтын ажиллагааны судалгаанд хамрагдсан орнуудын дунд хамгийн сүүлийн байранд орж байсан бол 1973 оноос эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийн коэффициент 29%-иас 60% болтол өссөнөөр дээрх судалгаанд хамрагдагч орнуудын дунд хамгийн өндөр өсөлттэй орон болсон байна. Боловсролын түвшин нэмэгдсэн, нэгж хөдөлмөрийн үр өгөөж буурсан, эмэгтэйчүүдийн тэгш оролцоог хангах хөдөлгөөнүүд мэдээж тодорхой хувь нэмэр оруулсан. 1960-аад оны үед Голландын нийтийн сайн сайхны төлөөх төрд «тэжээх загвар» давамгайлж байлаа. Эмэгтэйчүүд ихэвчлэн хорь орчим насандаа эрт, тун цөөхөн хувь нь гэрлэж анхны хүүхдээ гаргасныхаа дараа дахин хөдөлмөр эрхэлдэг байлаа. Эмэгтэйчүүд гэрийн эзэгтэй, ээжийн үүрэг хүлээж эрэгтэйчүүд гэр бүлийн бүхий л орлогыг олох үүргийг хүлээдэг байлаа. 1973 он хүртэл ажил олгогчид эмэгтэйчүүдийг гэрлэсэн, жирэмсэлсэн гэдэг шалтгаанаар ажлаас халах эрхтэй байлаа. Түүнээс гадна эмэгтэйчүүдийн олсон орлогыг эр нөхрийнх нь олсон орлого дээр нэмсний дараа татвар ногдуулдаг байсан учраас татварын илүү ачааллыг үүрч байлаа. Харин 1993 оноос хувь хүн бүрд татвар ногдуулах зарчим үйлчилж эмэгтэйчүүдийн орлогыг нөхрүүдийнхээ олсон орлогод нэмэр төдий зүйл гэдэг утгаар авч үзэх явдлыг арилгасан байна. Эмэгтэйчүүдийн уламжлалт ролийн үнэлэмж өөрчлөгдсөн байна. Бага насны хүүхдүүдтэй мөртлөө хөдөлмөр эрхэлж буй эмэгтэйчүүдийг сөрөг утгаар авч нэр хоч зүүхээ

больсон байна. Эмэгтэйчүүд үр хүүхэдтэй болсныхоо төлөө карьер болон орлогын алдагдалд орохыг хүлээн зөвшөөрөхөө больж хүүхдээ хүмүүжүүлэхийн хажуугаар хөдөлмөр эрхлэхийн тулд ажлын цагийг илүү уян хатан болгохыг шаардах болсон байна. Ажил олгогчид ч мөн адил нэн ялангуяа үйлчилгээний секторт эмэгтэйчүүдийг олноор авч ажиллуулах нь өндөр цалин төлөхөөс зайлсхийх нэг арга юмаа гэдгийг олж харсан байна. Жишээ нь: банкны үйлчилгээнд мэдээллийг компьютерт оруулахад эмэгтэй ажиллах хүчийг хугацаатай хөдөлмөрийн гэрээний үндсэн дээр авч ажиллуулж эхэлсэн байна. Олон тооны бүтэн өдрөөр ажиллах ажлын байруудыг хагас өдрөөр ажиллах ажлын байранд шилжүүлсэн байна.

Хагас өдрөөр хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхэд 1980-аад оноос хэрэгжүүлж эхэлсэн хагас өдрийн хөдөлмөр эрхлэлтийг бүтэн өдрийн хөдөлмөр эрхлэлттэй адилтгах зорилтот бодлого нөлөөлсөн байна. Жишээ нь: Голландад хагас өдрөөр хөдөлмөр эрхлэлтийн хөдөлмөрийн болон нийгмийн даатгалын эрх зүйн босгыг арилгасан байна. Хөдөлмөр эрхлэлт эхэлсэн л бол эхний цагаас эхлэн нийгмийн даатгалд хамрагдах үүрэг ногдоно. Түүнээс гадна хувийн секторт бүтэн ба хагас өдрөөр хөдөлмөр эрхлэлтийн хөдөлмөрийн хөлсний ялгааг 7% хүртэл бууруулсан байна. Хагас өдрийн ажлын байрны тавиас дээш хувийг багтааж буй төсвийн секторт дээрх ялгаа үүнээс ч доогуур болтлоо буурсан байна. Нийгмийн даатгалын болон орлогын татварын системээр ийнхүү өөрчлөн зохион байгуулсан нь хагас өдрийн ажлын байруудад ажиллах сонирхлыг нэмэгдүүлсэн байна. Үүний зэрэгцээ парламентаас хагас өдрөөр хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хууль зүйн үндэслэлийг тогтоож өгсөн байна.

Улс төрийн үүрэг роль:

Дээрх арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд улс төр чухал үүрэг гүйцэтгэсэн байна. Тодорхой цаг хугацааны агшинд эр зориг

шаардсан хатуу арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн байна. Лүвверсийн толгойлсон эхний засгийн газраас хүмүүсийн эрх ашгийг хөндсөн арга хэмжээнүүд хатуу шүүмжлэлтэй тулгарч байсан бол Лүвверсийн толгойлсон гуравдагч засгийн газрын үед **CDA PvdA** намуудын эвслийн үед хөдөлмөрийн чадвар алдалтын тухай хуулийг шинэчлэн найруулах үед илүү хүчтэй шүүмжлэлд өртөж байжээ. Хүчтэй эсэргүүцэлтэй тулгарч том хэмжээний жагсаал цуглаан өрнөж байлаа. Түүний дараагийн сонгуульд хоёр нам хоёулаа үлэмж хэмжээний саналыг алдаж байжээ. 1982-2002 оны үед засгийн эрхийг барьж байсан эвслүүд эдийн засгийн бодлогод адил төстэй чиглэлийг барьж байсныг тэмдэглүүштэй юм. Энэ нь Засгийн газрын бодлогын эдийн засгийн зөвлөл зэрэг байгууллагууд дээрх бодлогын эх суурийг бэлтгэж тэдгээрийн мэдээлэл олон нийтийн мэтгэлцээнд нөлөө үзүүлж байсантай холбоотой юм. Засгийн газрын бодлогын эдийн засгийн зөвлөл нь олны эсэргүүцэлтэй тулгарч болзошгүй маргаантай сэдвүүдийн хүрээнд прагматик мэтгэлцээн өрнүүлэх замаар өөрсдийн хувь нэмрээ оруулж байсан юм. Энэ нь дээрх арга хэмжээнүүдийг нийгэмд хүлээн зөвшөөрөгдөхөд хувь нэмрээ оруулж байлаа.

Улс төрийн соёл ба иргэний нийгэм

Голландын улс төрийн соёлд сүмүүд болон шашин шүтлэг онцгой байр суурь эзэлдэг. Улс төрийн амьдрал нь 1960-аад оныг хүртэл баганачлах үзэгдэл буюу олон соёлууд, шашин шүтлэг, улс төрийн бүлэглэлүүдийн хоорондын харилцан тусгаарлах оролдлогоор тодорхойлогдож байжээ. Хүн ард нь нийгмийн болон улс төрийн хувьд шашин шүтлэгээр зааглах шугамын дагуу зохион байгуулагдаж байлаа. Нэн ялангуяа протестантууд болон католик шашинтнуудын хувьд энэ баганачлал илүү ач холбогдолтой байлаа. Голландад христийн шашны энэрэнгүй үзэл нийгмийн үнэлэмжид чухал үүрэгтэй байдаг. Энэ нь ард түмний хандив тусламж өгөхөд бэлэн байдал, нийтийн сайн сайхны төлөөх үйлсэд доод давхаргын

өмнө үүрэг хүлээх зэрэгт тодоор илэрдэг. 1960-аад оны үед Голландад өрнөсөн шашны зарим нэг ёс заншлыг бууруулах арга хэмжээнүүд эрчимтэй өрнөсөн нь нийгмийн дунд тогтсон баганачлалыг үгүй болгоход нөлөөлж шашин шүтлэг хоорондын тусгаарлах шугам ач холбогдлоо гээсэн байна. Гэсэн хэдий ч христийн үнэлэмжийн чиг хандлагыг тогтоогч ач холбогдол өнөөг хүртэл буураагүй хэвээр байна. Иймээс Голландын хөрөнгөтний намуудад шашин шүтлэгийн ерөнхий зарчмууд тэдний үнэлэмжид илүү чухал байр суурь эзэлдэг, тэдгээрийг нийтийн сайн сайхны төлөөх төрийн үйлчилгээний хүрээг нэмэгдүүлэх, хөгжүүлэх бодлого дээр баримталдаг тул Британийн консерватив намуудтай адилтгах боломжгүй юм. Ийм учраас Голланд улс нь нийгмийн болон соёлын хувьд дотроо тодорхой зааг хязгаарт хуваагдмал нийгэм тул тухайн улсын улс төрийн соёлд эвлэрэнгүй үзэл, уян хатан байдал давамгайлсан байдаг.

Голландад бусад орнуудын нэгэн адил өдгөө иргэдийн улс төрийн идэвх оролцоо буурч байна. Үүний улмаас улс төрийн намын харьяалалгүй иргэдийн тоо 1971 оноос 1998 оны хооронд 58%-иас 79% хүртлээ өссөн байна. Олон улсын түвшинд харьцуулахад ард түмнийх нь дунд пост материалист үзлийг баримтлагсдын тоо харьцангуй өндөр байдаг. Германд 18% байдаг бол Голландад 27% байна.

Хэтийн төлөв

Нийгмийн ардчиллын хэм хэмжээг хөдөлмөр эрхэлж буй ард иргэд болон зах зээлийн нийгэмд хөлөө олоогүй хүмүүсээ хамгаалж буй хамгаалалтаар тодорхойлно, Уг хамгаалалт нь тэднийг улс төрийн болон нийгмийн амьдралд тэгш эрхтэйгээр оролцох боломжийг бүрдүүлнэ гэж үзвэл Голландад холимог тэнцвэр харагдана: 1979 онд зөвхөн цөөн тооны ядуу гэр бүл бүртгэгдэж байсан бол 1980-аад оны үеэс ядуу гэр бүлийн тоо гайхал төрүүлмээр хэмжээнд эрс нэмэгдсэн байна. Бүр 1990-ээд

оны хоёрдугаар хагаст ядуу гэр бүлийн тоог дахин бууруулах боломж бүрдсэн байна. 1980-аад оны үеэс Голландын хөдөлмөрийн зах зээл дээр гарсан амжилт нь ард иргэдийн доод давхаргын амьдралын түвшинг улам дордуулсан хохирол дээр тогтож байсан юм. Нийгмийн эрхүүдийг хязгаарласан нь Голландын нийгмийн ядуу давхаргууд эдийн засгийн дахин сэргэлтээс бага хэмжээгээр хувь хүртэхэд хүргэсэн юм. Харин олон улсын түвшинд харьцуулахад нийгмийн ардчиллын хэм хэмжээ илүү эерэг үзүүлэлттэй харагддаг. Өнөөгийн ядуурлын коэффициент нь 8.1%-тай байгаа нь Их Британийн 12.5%, АНУ-ын 12.5%-тай харьцуулахад харьцангуй доогуур байгаа юм. Удаан хугацаагаар ажилгүй байгаа иргэдийн тоо нь доод рекордыг эвдэж зөвхөн 0.7%-тай байгаа юм. Эдгээр үзүүлэлтүүд Голланд орныг улс орнуудын харьцуулалтад амжилттай хөгжиж буй орнуудын загвар орон болоход хүргэж байгаа юм.

7.5 Герман улс

Улс төрийн систем

Германы улс төрийн системийг олон тооны хориглон тоглогчид, тэдний нийгэмд эзэлж буй байр суурь тодорхойлж байдаг. Парламентын бие даасан байдал нь үндсэн хууль, хууль тогтоолтод тавигдах үндсэн хуулийн шүүхийн хэм хэмжээний хяналтаар ихээхэн хязгаарлагдсан байдаг. Парламент нь засаглалын хуваарилалтын онолын дагуу эрх мэдлийг хязгаарлахад чиглэгдсэн бүтэцтэй. Учир нь Холбооны зөвлөл буюу холбооны улсуудын парламент нь Холбооны парламент буюу Бундестагаас өөр хууль ёсны үндэслэлтэй байдаг. Холбооны зөвлөлд муж улсуудыг сонгогдсон депутатууд нь биш харин засгийн газрууд нь төлөөлдөг.

Германы төрийн тогтолцоо нь холбооны бүтэцтэй бөгөөд уг бүтэц нь Холбооны парламентын үйл ажиллагааны чадамжийг шийдвэрлэх хэмжээнд хязгаарлаж байдаг. Хэдийгээр хууль тогтоох эрхийг Бундестаг эдэлдэг ч холбооны улсуудад

хамааралтай бүх шийдвэр гаргалтад хамтран шийдвэр гаргах эрхийг эдэлж үүгээрээ холбооны улсуудын оролцоог баталгаажуулж өгдөг. Холбооны хуулиудыг хэрэгжүүлэх үүргийг зарчмын хувьд холбооны улсуудын засгийн газрууд хүлээдэг.

Либерал ардчилсан улсуудын дунд Герман улс нь намуудын оролцоог хамгийн туйлбартайгаар хуульчлан баталгаажуулсан орон юм. Зөвхөн үндсэн хуулиар төдийгүй улс төрийн намуудын тухай хууль, сонгуулийн хуулиар намуудын байр суурийг баталгаажуулсан. Германы улс төрийн намуудын систем нь бүхэлдээ хоёр хэсэгт хуваагддаг. Христосын ардчилсан болон шинэ либерал нөлөө давамгайлсан Христосын Ардчилсан Холбоо (ХАХ) ба Германы Социал Демократ Нам (ГСДН). Намууд нь холбооны түвшинд дангаараа олонхыг бүрдүүлэх чадамжгүй улс төрийн намууд юм. Иймээс тэд эргэлзээтэй үед шинэ либерал Чөлөөт Ардчилсан Нам, 90 Холбоо\Ногоонтнууд) болон хуучин коммунист намын суурин дээр үүсгэн байгуулагдсан Ардчилсан Социализмын Намтай холбооны улсуудын болон холбооны түвшинд эвслийн засгийн газруудыг байгуулдаг. Энэ хооронд шинэ холбооны улсуудын нутаг дэвсгэр дээр Гурван - Намын - Систем тогтож Ардчилсан Социализмын Нам нь хүчтэй гуравдагч улс төрийн хүчин болон бэхэжсэн байна.

Холбооны түвшинд сонгуулийн холимог системтэй бөгөөд сонгогчид хоёр санал өгдөг: **Эхний** саналаа тухайн сонгуулийн тойрогт шууд нэр дэвшигчид, **хоёр дохь** саналаа улс төрийн намуудаас тухайн холбооны улсад зориулсан гаргасан жагсаалтад тус тус өгдөг. Парламентын суудлын хуваарилалтад хоёрдох санал нь шийдвэрлэх ач холбогдолтой байдаг. Учир нь шууд мандатыг суудлын хуваарилалтад оролцуулан тооцдог. Мандатын хуваарилалтад сонгогчдын нийт саналын хамгийн доод тал нь 5%-ийг авсан эсвэл гурваас дээш шууд мандат авсан намууд оролцох эрхтэй. Герман улс тодорхой босго бүхий пропорциональ сонгуулийн системтэй.

Бундестаг засгийн газрыг сонгодог бөгөөд засгийн газрыг огцруулах, огцруулах төдийгүй шаардлагатай тохиолдолд дараагийн шинэ ерөнхий сайдыг сонгох эрхтэй. (Итгэл үзүүлэх эсэх тухай санал хураалт явуулах) Германы сонгох эрх ба улс төрийн намуудын систем нь өнөөгийн нийгмийн бүтцийн нөхцөлд байнга эвслийн засгийн газрууд байгуулагдахад хүргэж байгаа юм. Герман улс нь Их Британитай харьцуулахад олонхын саналыг авсан нам дангаараа эрх барих боломжийг бүрдүүлдэггүй онцлогтой. Ингэснээр засгийн газрын эрх мэдэл өндөр хэмжээнд хуваагддаг тул зөвшилцлийг эрхэмлэхээс өөр аргагүй нөхцөл байдалд хүргэдэг. Тарифын бие даасан байдлын хүрээнд олон ашиг сонирхлуудыг төвлөрүүлэн өргөн хүрээнд зохион байгуулалтад оруулдаг нь дээрх зөвшилцөлд хүрэх таатай нөхцөлийг бүрдүүлдэг. Нийгэм - эдийн засгийн ашиг сонирхлуудын хүчтэй нэгдэл нь нэг талаас германы системийн үр өгөөж, тогтвортой байдлыг хангаж нөгөө талаас маш өргөн хүрээнд зөвшилцөлд хүрэхээс өөр аргагүй байдлыг бүрдүүлдэг. Германы систем нь зөрчилдөөний цар хүрээ өөрчлөгдсөн нөхцөлд тун хязгаарлагдмал хүрээнд өөрчлөлт хийх боломжтой. Уг систем уламжлалт асуудлуудыг жишээ нь: нийгмийн асуудал шийдвэрлэхэд тохиромжтой бүтэцтэй. Шинэ хэлбэрийн асуудлууд, жишээлбэл байгаль орчны асуудлуудыг шийдвэрлэх хэлэлцээрийн бүтэц бүрэлдээгүй, нэгдсэн байр сууринд хүрэхэд нэн хүндрэлтэй байдаг. Дээрх асуудлууд ихэвчлэн хэлэлцээрийн хүрээнд бус намуудын системийг өргөтгөх замаар шийдвэрлэгддэг байна.

Холбооны Бүгд Найрамдах улсад Бундестаг хууль санаачлах эрхийг эдэлдэг боловч ихэнх хуулийн төслүүдийг засгийн газраас санаачилдаг. Хуулиудыг Бундестаг болон Холбооны зөвлөлөөс баталдаг. Бундестаг болон Холбооны зөвлөл нэгдсэн байр сууринд хүрч чадаагүй тохиолдолд хоёр танхимын төлөөлөл бүхий зуучлах комиссыг томилдог. Шийдвэрлэх зөвлөгөөнүүд байнгын хороодын түвшинд явагддаг. Байнгын

хороодод намуудын бүлгүүд гишүүдийнхээ тооноос хамааран төлөөллөө илгээдэг. Бусад холбоод хууль тогтоох процессод чухал байр суурь эзэлдэг. Учир нь холбоодын саналыг байнгын хороод дээр сонсдог. Холбооны үндсэн хуулийн шүүх - үндсэн хуулийн цэц хуулиудад хэм хэмжээний хяналтыг тавьж байдаг. Уг хяналтыг Холбооны засгийн газар, холбооны улсуудын засгийн газар, Бундестагийн гишүүдийн хүсэлтээр хэрэгжүүлдэг. Хувь хүмүүс тэдний эрх зөрчигдсөн гэж үзвэл зөвхөн холбооны үндсэн хуулийн цэцэд гомдол гаргах эрхтэй.

Үндсэн эрхүүдийн систем

Үндсэн эрхүүд нь хууль тогтоолт, шийдвэр гүйцэтгэл, шүүн шийтгэхүйн заавал биелүүлэх эрх болон батлагддаг. Үндсэн эрхүүдийн хэрэгжилтийн талаар холбооны үндсэн хуулийн шүүхэд гомдол гаргаж болно. Нийгмийн үндсэн эрхүүдийг үндсэн хуульд маш хязгаарлагдмал хэлбэрээр хуульчилсан байдаг. Үндсэн хуулийн маш чухал заалтууд бол:

1-р зүйлийн 1 Хүний алдар хүнд халдашгүй дархан байна. Хүний алдар хүндийг хүндэтгэх, хамгаалах нь төрийн бүх эрх мэдлийн үүрэг мөн.

6-р зүйлийн 4 Эх хүн бүр нийгэм хамт олныг хамгаалах, халамжлахыг шаардах эрхтэй.

20-р зүйл 1 ХБНГУ бол ардчилсан, нийгмийн баримжаат холбооны улс мөн.

20-р зүйлд нийгмийн баримжаат төрийн шаардлагуудыг хуульчилсан байдаг. Уг зүйл заалтад нийгмийн тэнцвэртэй байдлыг хангах, ингэснээр нийгэмд шударга журам тогтоож иргэдийнхээ аюулгүй байдлыг хангах нь төрийн үүрэг мөн гэж заасан байдаг.

1961 онд батлагдан гарсан Холбооны нийгмийн халамжийн тухай хуулиар Герман улс иргэдийнхээ хангалттай амьжиргааны эх үүсвэртэй байх эрхийг баталгаажуулсан. Уг хууль эмзэг давхаргынханд нийгмийн халамжид хамрагдах эрхээ хангуулахын тулд гомдол гаргах эрхийг нь баталгаажуулж өгсөн. Нийгмийн халамжийг зарчмын хувьд хоёр бүлэгт хуваасан: **Нэгдүгээрт**: амьжиргааны эх үүсвэрийг бүрдүүлэх мөнгөн тэтгэлэг, **хоёрдугаарт**: амьдралын онцгой нөхцөлд материаллаг болон үйлчилгээний санхүүжилтийг олгох. Жишээ нь: Эх болох, тахир дутуу болох, бусдын асрамж шаардлагатай болох гэх мэт. Халамжийн дээрх хоёр хэлбэрүүд Германд амьжиргааны баталгаажих доод түвшнийг хангадаг. Олон улсын түвшинд харьцуулахад нийгмийн халамж нь бусдын туслалцаа зайлшгүй шаардлагатай болсон үед болон ядууралтай тэмцэх хамгийн үр өгөөжтэй хэлбэр юм.

Хурал цуглаан хийх болон эвлэлдэн нэгдэх эрх чөлөө нь үндсэн хуулиар баталгаажсан байдаг. 2001 оны статистик мэдээллээр 544.701 холбоод ХБНГУ-ын хэмжээнд бүртгэгдсэн байна. Германы Чөлөөт Цагийн нийгэмлэг 1997 онд ойролцоогоор 84 сая гишүүдтэй байжээ. Холбоодын зохион байгуулалтын түвшин 64%-д хүрээд байна. /Нийт насанд хүрсэн хүн амын дотор аль нэг эвсэл холбоодод гишүүнчлэлтэй иргэдийн эзлэх хувь хэмжээ/ Холбооны улсын нийгмийн идэвх өндөр.

Германд шударга болон зохистой хөдөлмөрийн нөхцөлийн тухай хэлэлцээрүүд ажил олгогч эздийн холбоод, үйлдвэрчний эвлэлүүдийн хооронд хийгддэг. Тарифын хэлэлцээрийн систем нь төрийн нөлөөллөөс бүрэн ангид байдаг. Германы Үйлдвэрчний Эвлэлийн Холбоо ГҮЭХ нь үйлдвэрчний дээвэр байгууллага бөгөөд 13 бие даасан үйлдвэрчний эвлэлийн холбоодыг нэгтгэж байдаг. Өнгөрсөн хугацаанд үйлдвэрчний эвлэлийнхэн тавьсан шаардлагуудаа амжилттай хэрэгжүүлсээр ирсэн. Долоо хоногийн 38.5 ажлын цаг, ажилтнуудын

шийдвэр гаргалтад оролцох оролцоог сайжруулах, өвдсөн үед цалинг үргэлжлүүлэн олгох, амралтын мөнгө, жилийн амралтын хугацааг доод тал нь дөрвөөс таван долоо хоног болгох, залуучуудын хөдөлмөрийг хамгаалах тухай хууль гэх мэт. Тарифын хэлэлцээр хийгдэж байх үед тэмцлийн арга хэмжээнүүдийг зохион байгуулахгүй байх үүргээ үйлдвэрчний эвлэлийнхэн биелүүлдэг. Уг үүргийг энх тайвныг сахих үүрэг гэж нэрлэдэг. Тарифын гэрээ дууссаны дараа эсхүл хүчингүй болсны дараа ажил олгогчид болон ажилтнууд нэгдсэн тохиролцоонд хүрээгүй бол ажил хаялт зарлаж болно. Гэхдээ тухайн салбарын үйлдвэрчний гишүүдийн хамгийн доод тал нь 75% нь ажил хаялтыг дэмжих тухай саналаа өгсөн байх шаардлагатай.

Нийгмийн баримжаат төр

Герман улсад төрийн нийгмийн бодлого 120 гаруй жилийн түүхтэй бөгөөд Вильгельмийн эзэнт улсаас нэгдсэн Герман улсыг хүртэл улс төрийн олон дэглэмийн нүүрийг үзсэн байна. Германы нийгмийн бодлогын үндсэн загвар нь Висмаркийн нийгмийн даатгалын систем бөгөөд уг загвар нь консерватив хамтын ажиллагаан дээр суурилсан нийгмийн баримжаат төрийн дэглэмт улсуудын дунд үлгэр жишээ болсоор байгаа юм. Уг загвар урт удаан хугацааны туршид үндсэндээ хэвээр хадгалагдаж улам өргөжин тэлсээр байна.

Герман улс либерал зах зээлд чиглэсэн загвар болон улс төрийн болон нийгмийн тэгш байдлыг хангах, түгээмэл, нийтийн сайн сайхны төлөө бүх иргэдээ бүх талаар хангах загваруудын дундаж замыг сонгон авсан байна. Дээрх дундаж замын үндэс нь даатгуулагч ба тэдний ажил олгогчдын шимтгэлээс зонхилон санхүүжих төрийн заавал даатгуулах нийгмийн даатгал юм. Үндэсний социалист төр болон хуучин Ардчилсан Герман Улсаас бусад Германы төр хэзээ ч нийгмийн бодлогын үндсэн санхүүжүүлэгч байгаагүй юм. Өдгөө нийгмийн салбарын

төсвийн зөвхөн гуравны нэг хувь нь татвараас санхүүжиж байна.

Төрийн нийгмийн бодлогын үндсэн үзэл санаа нь юуны өмнө хамгаалалт шаардлагатай ажилчдыг хамгаалалтдаа авах явдал байлаа. Хожим дээрх үндсэн үзэл баримтлалыг бүх ажилтнуудыг гэр бүлийнх нь хамт даатгалд хамруулах болгон өргөтгөсөн байна. Нийгмийн даатгалын хараат хөдөлмөр эрхлэгч даатгуулагчдыг хамгаалах үндсэн санаа нь урьдын нэгэн адил хэвээр хадгалагдан үлдсэн бөгөөд нийт харьяат иргэд эсвэл бүх оршин суугчдыг хамруулах санааг агуулаагүй хэвээр байгаа юм. Иргэдийн нийгмийн статусыг хэвээр хадгалах нь Германы нийгмийн бодлогод чухал ач холбогдолтой, нэн ялангуяа өндөр насны баталгаа буюу тэтгэврийн даатгалд хамруулах. Ажилтнуудын идэвхтэй хөдөлмөр эрхэлж байхдаа олж авсан нийгмийн статусыг өндөр насны тэтгэвэрт хэвээр хадгалах хэмжээнд тэтгэврийн давхаргуудыг ялгавартай тогтоох нь чухал бүрэлдэхүүн хэсэг нь мөн.

Томоохон хэмжээний нийгмийн шинэчлэл Герман улсад ард түмний хоёр том намууд болох ХАХ болон ГСДН-уудын хооронд зөвшилцөлд хүрсэн тохиолдолд амжилтад хүрдэг. Нийгмийн секторын байгууллагуудыг үндсээр нь өөрчлөх тухай саналыг дээрх хоёр нам өнөөг хүртэл дэвшүүлээгүй байгаа юм.

Нийгмийн бодлогын үндсэн асуудлаар суурь тохиролцоонд хүрсэн байдгаараа Герман улс Их Британиас төдийгүй Швед, Голланд улсуудаас ялгаатай. Эдийн засаг - нийгмийн бодлогын зохистой харьцааг урт хугацааны туршид хадгалж буй нийгмийн сайн сайхны төлөөх бараг бүх орнууд хөрөнгөтний болон ажилчны намуудын хооронд дээрх үндсэн суурь тохиролцоонд хүрч чадсан, уг тохиролцоон дээр суурилаад нийтийн сайн сайхны төлөө харилцан буултууд хийж чаддагаараа онцлог байдаг. Сүүлийн арван жилийн дотор нэн ялангуяа хоёр Герман улс нэгдсэний дараагаар ард түмний хоёр намуудын эдийн

засаг - нийгмийн бодлогын зөрүүтэй байдал хурцадсан байна.

Боловсролын систем

Боловсролын тогтолцооны хариуцлага Герман улсад холбооны улсын бүтцээр тодорхойлогддог. Хууль тогтоох эрхийг Холбооны улсууд хэрэгжүүлж боловсролын тогтолцоогоо бие даан шийдвэрлэдэг. Холбоо нь сургуулиас гадуур боловсрол, мэргэжил дээшлүүлэх сургалт, дээд боловсролын тогтолцооны үндсэн зарчмууд, боловсролыг дэмжих, залуучуудад туслах, шинжлэх ухааны хойч үеийг бэлтгэх ажлыг зонхилон хариуцдаг. Холбоо болон холбооны улсууд зарим үүргийг хамтран хэрэгжүүлдэг. Жишээ нь: Дээд сургуулиудыг өргөжүүлэх, шинээр байгуулах болон боловсрол төлөвлөлт. Хөтөлбөрийн болон бүтцийн чухал тогтоомжуудыг Холбоо болон Холбооны улсууд заавал хамтран тогтоодог. Зөвшилцлийн зарчим үйлчилдэг.

1960-аад оны дундуур Герман улсад боловсролын салбар дахь тэгш бус боломжуудын тухай нийгмийн шинжлэх ухааны төрөл бүрийн ололтууд дээр үндэслэн боловсролын бодлогын тухай мэтгэлцээн өрнөж улмаар үндсэн шинэчлэлүүд хийгдсэн байна. 1969 онд анх удаа Холбооны боловсролын яам байгуулагдсан. Мөн 1969 онд дээд сургуулиудыг байгуулахад төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлж 1976 онд дээд боловсролын тухай ерөнхий хууль батлагдан гарсан байна. Ерөнхий боловсролын сургуулиуд, мэргэжлийн дээд сургуулиудыг улс орон даяар байгуулж их сургуулиудын аж ахуйн тооцоон дээр суурилсан системийг дахин өөрчлөн зохион байгуулсан байна. Өргөтгөх арга хэмжээнүүдийн үр дүнд болон бусдын туслалцаа шаардлагатай оюутнуудад сургалтын тэтгэлэг олгох хөтөлбөрүүдийг нэвтрүүлсний үр дүнд боловсролд хамрагдагсад нэн ялангуяа нийгмийн доод давхаргынхан болон охидын боловсрол олох боломж нэмэгдсэн байна.

Өдгөө Германы боловсролын тогтолцоо дахин шүүмжлэлд

өртөөд байна. ПИСА - судалгааны дүнгээр Германы ерөнхий боловсролын сургуулийн тогтолцоо олон улсын түвшнээс доогуур байгаа нь тогтоогдсон байна. Ядуу гэр бүлээс гаралтай сурагчдын дээд шатны сургуульд хамрагдах боломж боловсролтой гэр бүлээс гаралтай хүүхдүүдийнхээс харьцангуй доогуур байна. Германаас бусад аль ч орнуудад нийгмийн гарал, мэргэжил эзэмших боломж хоёрын хооронд ийм хүчтэй шууд хамаарал байдаггүй байна. Маш эрт тодорхой бүлгүүдэд хуваагддаг ерөнхий боловсролын сургуулийн систем нь дээрх шууд хамаарлыг арилгахад саад тотгор болдог.

Германы мэргэжлийн боловсролын тогтолцоог «дуал буюу хосолсон систем» гэж нэрлэдэг бөгөөд уг систем үйлдвэрлэлийн практик мэргэжлийн сургалтыг хослуулдаг онцлогтой. Мэргэжлийн боловсрол олгох нь үйлдвэрлэгч эдийн засгийн салбарын үүрэг бөгөөд нэн ялангуяа Аж үйлдвэр - Худалдаа болон Гар урчуудын танхимын үүрэг юм. Дуал системийг эдийн засагтай холбох нь нэг талаас бодит мэргэжлийн талбарыг практиктай холбож өгдөг давуу талтай. Нөгөө талаас эдийн засгийн өсөлт, бүтцийн нөхцөлүүдийн улмаас хэтэрхий цөөн тооны боловсрол олгох орон тоо гарч байгаатай холбоотой дагалдах бэрхшээлүүд гарч байгаа юм. Иймээс мэргэжлийн сургалтын ирээдүй эдийн засгийн бэрхшээлтэй үед ч гэсэн аль болох олон залуучуудад мэргэжлийн боловсролыг зохих түвшинд олгох боломж бүрдүүлж чадах уу? гэдгээс ихээхэн хамаарна.

Герман улсын хувьд насанд хүрэгсдийн боловсролд төрийн зохицуулалт харьцангуй сул. Насанд хүрэгсдэд боловсрол олгох байгууллагууд харьцангуй зохицуулалтгүй, эрэлтийн олон талт байдлаас хамаардаг. Олон нийтийн санхүүжилттэй төрийн дэмжлэгтэй мэргэжил дээшлүүлэх боломжууд байдаг ч дийлэнх сургалтуудыг хувийн чөлөөт байгууллагууд хариуцан явуулдаг. Мэргэжил дээшлүүлэх сургалтуудаар дамжуулан хөдөлмөрийн зах зээл, дээд боловсролын болон соёлын

бодлогын зорилтуудыг хэрэгжүүлдэг.

Герман улс олон улсын түвшинд харьцуулахад боловсролд бага хэмжээний хөрөнгийг зарцуулдаг. 2000 оны байдлаар боловсролын салбарын санхүүжилтэд төсвийнхөө зөвхөн 1%-ийг зарцуулжээ. Харин уг зардал Голландад 10% Шведэд 7% -тай тэнцэж байжээ.

Капитализмын хэв шинж

Петер Холл, Дэвид Соскисе нарын хэв шинжийн судалгаагаар Герман улс бол зохицуулалттай зах зээлийн эдийн засгийн шалгарсан загвар мөн. Зохицуулалттай зах зээлийн эдийн засагт компаниуд олон асуудлыг стратегийн хамтарсан оролцоогоор шийдвэрлэдэг. Тэнцвэртэй байдал нь бүхэлдээ биш гэхэд зарим хэсэгт дэмжигч байгууллагуудын оролцооноос шалтгаалдаг. Холл, Соскисе нар германы зохицуулалттай зах зээлийн эдийн засгийг дараах 5 чухал салбаруудад тодорхойлсон байна:

Санхүүгийн систем

Германы хамтын удирдлагын систем нь компаниудад олон нийтэд нээлттэй санхүүгийн мэдээллүүд, эсхүл компанийн тухайн үеийн ашгаас төдийлөн хамааралгүйгээр хөрөнгө босгох бололцоог олгодог. Герман улсад компаниудын санхүүжилтэд банкны зээл ихээхэн үүрэг гүйцэтгэдэг. Банкны зээлийн тусламжтайгаар компаниуд удаан хугацааны дараа ашгаа өгөх төслүүдэд хөрөнгө оруулалт хийх, өндөр мэргэжлийн ажилтнуудыг эдийн засгийн хямралын үед ч тасралтгүй ажиллуулах бололцоог олгодог.

Эдийн засаг нь хамтын удирдлагатай. Өөрөөр хэлбэл компаниудын стратеги зөвхөн хувьцаа эзэмшигчдийн ашиг сонирхлоор тодорхойлогддоггүй. Харин нийгмийн ашиг сонирхлыг төлөөлөгчдийн олон талт хүсэл сонирхлоос хамаардаг гэсэн үг юм. Компаниудын үйл ажиллагаанд

банкнуудын төлөөлөл, компанийн эздийн төлөөлөл, ажилтнуудын төлөөлөл, төрийн актёруудаас бүрдэх хяналтын зөвлөлүүд хяналт тавьдаг. Компаниудын удирдлагад тэгэхээр тухайн компанийн хувьцааны үнэлгээ, хувьцаа эзэмшигчдийн сонирхол АНУ-тай харьцуулахад төдийлөн чухал бус юм.

Компаниудын дотоод бүтэц

Компаниудын дотоод бүтэц нь Сүлжээний - Мониторингийн системийг илүү хүчтэй болгож өгдөг. Германы топ буюу тэргүүлэх менежерүүдийн компани дамнасан үйл ажиллагаа явуулах орчин тун бага байдаг нь либерал эдийн засгаас эрс ялгаатай юм. Түүний оронд компаниудын менежментийн баг компанийн аж ахуйн чухал шийдвэрүүдийг гаргахдаа зөвхөн хувьцаа эзэмшигчид ба ажилтнуудын төлөөлөл бүхий хяналтын зөвлөлийн саналыг аваад зогсохгүй бусад менежерүүд, нийлүүлэгчид, томоохон худалдан авагчдын саналыг авдаг. Зөвшилцлийн замаар шийдвэр гаргах энэхүү бүтэц нь мэдээлэл солилцоог идэвхжүүлж сүлжээний-мониторингийн хөгжлийг дэмждэг.

Зохицуулалттай зах зээлийн эдийн засаг тарилжааны сүлжээгээр дамжуулан үйл ажиллагаа явуулах нь менежментийн багийн сонирхлыг идэвхжүүлдэг. Удаан хугацааны хөдөлмөр эрхлэлтийн хөдөлмөрийн гэрээ олноороо байгуулагддаг. Компаниуд менежерүүдээ зөвшилцлийг бэхжүүлэхэд мэдлэг чадвараа дайчлахад нь дэмжиж байдаг тул нэр төрөө сэвтүүлэхгүй байхад ихээхэн анхаардаг. Зохицуулалттай зах зээлийн эдийн засгийн менежерүүд либерал зах зээлийн менежерүүдтэй харьцуулахад байнгын үр ашигтай ажиллах дарамт багатай байдаг.

Аж үйлдвэрийн харилцаа

Зохицуулалттай зах зээлийн эдийн засагт олон компаниуд өндөр мэргэжлийн ажиллах хүчний хөдөлмөр дээр суурилсан үйлдвэрийн стратегийг баримтлан ажилладаг. Дээрх өндөр

мэргэшсэн ажиллах хүчний хөдөлмөрийн бие даасан байдал өндөр бөгөөд бүтээгдэхүүн болон үйлдвэрлэлийн процессыг сайжруулахад тустай мэдээллийг менежментийн багтай солилцоход тэднийг идэвхжүүлж байдаг. Дээрх хэлбэрийн үйлдвэрлэлийн стратегийг баримтлан ажилладаг компаниуд ажиллах хүчээ «барьж» байх сонирхолтой байдаг. Бусад компаниуд тэдний ажиллах хүчийг өөртөө татвал ихээхэн хэмжээний хохирол амсах аюултай. Нөгөө талаас менежментийн багт мэдээлэл өгч буй ажилтнууд «дарлагдах» аюултай байдаг. Иймээс зохицуулалттай зах зээлийн эдийн засагт аж үйлдвэрийн харилцааны явцад үүсэх асуудлуудыг шийдвэрлэх байгууллагууд шаардлагатай байдаг.

Германы аж үйлдвэрийн харилцааны системд аж үйлдвэрийн түвшинд үйлдвэрчний эвлэл, ажил олгогч эздийн холбоодын хооронд тарифын хэлэлцээрүүд хийгдэж цалингийн хэмжээг тогтоодог. Аж үйлдвэрийн нэг салбарт мэргэжлийн ур чадварын хувьд адил ажилтнуудад адил хэмжээний цалинг олгодог. Уг систем компаниуд бусад компаниудын ажилтнуудыг урвуулахад бэрхшээл учруулдаг. Түүнээс гадна ажилтнуудад компанидаа хүч хөдөлмөрөө зориулсныхаа төлөө хамгийн өндөр цалинг авах боломжийг баталгаажуулдаг. Эдийн засагт дээрх хэлбэрийн хэлэлцээрийн зохицуулалтыг хийх нь цалингийн хэлэлцээрийн ханш унах нөлөөг бууруулдаг.

Дээрх байгууллагуудын компаниудын түвшин дэх бүрэлдэхүүн хэсэг бол ажилтнуудын сонгогдсон төлөөлөгчдөөс бүрдэх ажилтнуудын зөвлөлүүдийн систем юм. Дээрх ажилтнуудын зөвлөлүүд нь ажлаас халах, хөдөлмөрийн нөхцөлүүдийг тохиролцох тухай шийдвэр гаргалтад тодорхой эрхийг эдэлдэг. Ажилтнуудын зөвлөл дур зоргоороо ажлаас халах, хөдөлмөрийн нөхцөлийг өөрчлөхөөс хамгаалахаас гадна тухайн компанийн онцлогт тохирсон мэргэжил дээшлүүлэлтэд хөрөнгө оруулалт хийх, онцгой мэрийлттэй ажиллахад тэднийг

идэвхжүүлдэг. Тарифын хэлэлцээрт оролцогч талууд болох ажил олгогч эздийн холбоод, үйлдвэрчний эвлэлийнхэн сайн гэрээ байгуулсан нөхцөлд л ажилтнуудын зөвлөлийн ажил үр өгөөжтэй байдаг. Үйлдвэрчний эвлэлийнхэн ажилтнуудын зөвлөлүүдийн үйл ажиллагаанд гадаад баталгаажуулагчийн үүргийг гүйцэтгэдэг. Германд үйлдвэрчний эвлэлийнхэн харьцангуй хүчтэй. Хөдөлмөр эрхлэлтийн эрх зүйн хамгаалал сайн. Үүний улмаас АНУ зэрэг орнуудтай харьцуулахад хөдөлмөрийн зах зээл нь харьцангуй уян хатан бус байдаг.

Боловсрол болон мэргэжил дээшлүүлэх сургалтын систем Зохицуулалттай зах зээлийн хөдөлмөрт аж үйлдвэрийн эсвэл тухайн компанийн онцлогт тохирсон мэргэжлийн ур чадвар илүү шаардлагатай байдаг. Ажилтанд дээрх шаардлагыг хангах мэргэжлийн ур чадвар олгох боловсролын болон мэргэжил дээшлүүлэх сургалтын систем нь зохицуулалттай зах зээлийн эдийн засагтай улсуудад ихээхэн ач холбогдолтой юм. Уг системд ажиллаж буй ажилтнууд тэдний мэргэжил мэдлэг идэвхтэй хөдөлмөр эрхэлж буй үед нь хоцрогдож болзошгүй гэдэгт бэлэн байх хэрэгтэй бол мэргэжил дээшлүүлэлт болон боловсролд хөрөнгө оруулалт хийдэг компаниуд тэдэнд шаардлагатай мэдлэг чадварыг эзэмшсэн ажилтнуудыг нь ажилтнуудынхаа мэдлэг боловсролд хөрөнгө оруулалт хийдэггүй гаднын компаниуд урвуулан авахаас хамгаалах шаардлагатай болдог. Эдгээр асуудлуудыг Зохицуулалттай зах зээлийн эдийн засагт эдгээр асуудлуудыг шийдвэрлэх олон арга байдаг.

Герман улсын хувьд аж үйлдвэрийн бүхий л салбарыг нийтэд нь хамарсан ажил олгогчид болон үйлдвэрчний эвлэлийн байгууллагууд олон нийтийн дэмжлэгтэй боловсролын болон мэргэжил дээшлүүлэх системийг хянаж байдаг. Томоохон компаниудыг мэргэжлийн сургалтад хамрагдаж буй хүмүүсийг ажилд авсан бол сургалтдаа үргэлжлүүлэн хамрагдах боломжийг нь хангаж буй эсэхэд хяналт тавьдаг. Ингэснээр

ажил олгогчид болон үйлдвэрчний эвлэлийнхэн хамтран боловсролд хөрөнгө оруулалт хийгээгүй атлаа бусдын хөрөнгө хүчнээс завших сонирхолтой компаниудын бусдын хөрөнгө оруулалтыг завших явдалд хяналт тавьдаг. Тухайн аж үйлдвэрийн салбарын хэлэлцээрээр сургалтын хөтөлбөрүүд, мэргэжлийн ур чадварт тавигдах шаардлагуудын талаар нэгдсэн тохиролцоонд хүрдэг тул төгсөгчид зөвхөн тухайн мэргэжлийг эзэмшсэн компанидаа бус бусад компаниудад ч ажиллах баталгаа нь хангагддаг. нөгөө талаар боловсролын систем нь тухайн компаниудад ажиллахад шаардагдах онцгой ур чадварыг олгох баталгааг нь хангаж өгдөг. Германы ажил олгогч эздийн байгууллагууд нь гишүүддээ олон талт давуу талуудыг бүрдүүлж өгдөг бөгөөд тэдгээрт тухайн салбарын дийлэнх компаниуд гишүүнчлэлтэй байдаг өргөн хүрээтэй байгууллагууд юм. Ажил олгогч эздийн байгууллага нь байр сууриа баттай эзэлсэн байдаг тул тухайн системд шаардлагатай мониторинг болон зөвлөлдөх нэгжүүдээрээ дамжуулан боловсролын стандартууд болон квотыг тогтоож тэдгээрийн боловсруулалтад оролцож байдаг. Ингэснээр төгсөгчид тухайн захиалагч компанийн онцлогт тохирсон нарийн мэргэжил болон аль ч салбарт ажиллах боломжийг олгох ерөнхий мэдлэгийг эзэмшдэг.

Компаниуд хоорондын харилцаа

Зохицуулалттай зах зээлийн эдийн засагт олонх компаниуд удаан хугацааны хөдөлмөрийн гэрээгээр ажилтнуудыг ажиллуулахыг чухалчилдаг. Иймээс шинжлэх ухааны болон техникийн өндөр боловсрол эзэмшсэн ажилтнууд нь компаниуд солин ажиллах явдал либерал зах зээлийн эдийн засагтай харьцуулбал харьцангуй бага. Түүнчлэн технологийн шилжилт ч бага байдаг. Харин тодорхой технологийн хэрэглээг эдийн засагт нэмэгдүүлэх чиглэлээр компаниуд хоорондоо нягт хамтран ажилладаг. Германд дээрх харилцааг дэмжигч олон байгууллагууд байдаг. Хоршооллууд болон бусад арилжааны

чиглэлийн холбоод компаниудын ямар ажлыг сайжруулах шаардлагатай байгаа. Үүнд төсвийн хөрөнгийг хэрхэн ашиглаж болох талаар төрийн албан хаагчидтай хамтран тодорхойлох замаар шинэ технологийг дэмждэг. Арилжааны чиглэлийн дээрх холбоод болон үйлдвэрчний эвлэлийнхний өмнө тухайн секторын хувийн мэдээлэлд хүрэх зам нь нээлттэй байдаг тул олон нийтийн дэмжлэг үзүүлэх хөтөлбөрүүд үнэхээр үр өгөөжөө өгдөг. Судалгааны зонхилох хэсэг компаниудын хамтран байгуулсан судалгааны байгууллагуудад хийгдэж олон нийтийн судалгааны институттэй адил санхүүждэг. Аж үйлдвэрийн холбоодын дэмжлэгтэйгээр боловсруулагддаг техникийн хэрэглээний стандартууд нь шинэ технологийг дэлгэрүүлэхэд дэмжлэг үзүүлж олон компаниудын ажилтнуудын хамтын ажиллагааг дэмжих мэдлэгийн нэгдсэн суурийг бий болгоход дөхөмтэй байдаг. Үүнээс гадна Германд зөвшилцөл дээр суурилсан гэрээний эрх зүйн систем бэхэжсэн нь компаниуд хоорондын гэрээ байгуулахад дэмжлэг үзүүлж алсуураа технологийн шилжилтийг дэмждэг.

Улс төрийн соёл ба иргэний нийгэм

Ардчилсан оролцоо ба үндэсний онцлогууд улс орон бүрийн улс төрийн соёлын чухал элементүүд юм. Европын бусад орнуудтай харьцуулахад Германы ард түмний үндэсний бахархал туйлын сул, эцсийн байранд ордог. Хэлний зөрчлөөс болоод тарж бутарсан хэдий ч эх орноороо бахархагч Бельги иргэдийн тоо Холбооны Бүгд Найрамдах улсынхаас хамаагүй олон юм. Германы иргэдийн үндэсний бахархал ийнхүү суларсан нь Үндэсний Социализмын үеийн гашуун туршлагаас үүдэлтэй юм. Иргэд хүчирхэг эрх зүйт төр, улс орны эдийн засгийн болон нийгмийн ололт амжилтууд, алдар нэртэй хөгжмийн зохиолчид, яруу найрагчдаараа илүүтэй бахархдаг.

Германы иргэдийн ардчилсан оролцоо маш хүчтэй. Нийт иргэдийн 34% нь ямар нэг сайн дурын үйл ажиллагаа эрхэлдэг.

Ингэснээр ХБНГУ-ын 22 сая иргэн иргэний нийгмийн үйл ажиллагаанд оролцдог. Холбоо, нэгдлүүд, сүмүүд, нийгмийн доод давхаргын иргэдийн өмнө хариуцлага хүлээх болон бусад нийтийн сайн сайхны төлөөх байгууллагууд, сайн дурынхны агентлагууд, эмнэлгийн хөдөлгөөнүүдийн үйл ажиллагааны зэрэгцээ улс төрийн намууд, үйлдвэрчний эвлэл, сайн дурын алба хаах, өөртөө туслах байгууллагууд болон солилцооны сүлжээнүүдэд иргэний нийгмийн үйл ажиллагаа явагдаж байдаг.

Германы улс төрийн соёлд түгшүүрийн харанга дэлдэж буй нэг асуудал бол залуучуудын улс төрийн сонирхол буурч буй явдал юм. 2002 онд хийгдсэн залуучуудын тухай Шелийн 14-р судалгаа үүнийг баталж байгаа юм. 12 - 24 насны залуусын дөнгөж 34% нь улс төр сонирхдог гэж хариулсан байна. /1999 онд 43%, 1991 онд 51% байжээ. /Улс төрийн идэвх санаачилга, залуучуудын амьдралын хэв маягт улс төрийн эзлэх байр мөн буурчээ. Уг судалгаа залуучуудын дунд улс төрд итгэх итгэл мөн буурч байгааг харуулсан байна. Үүнийг автоматаар ардчилсан эрх зүйт төрөөс татгалзаж буй хэрэг гэж үзэх эсвэл хэт барууны үзлийг дэмжиж байна гэж үзэх нь өрөөсгөл юм. Улс төрийн намууд, үйлдвэрчний эвлэл, залуучуудын холбооны залуу гишүүдийн тоо буурсаар байна. Өнөөгийн залуучууд богино хугацааны арга хэлбэрүүдэд илүү идэвхтэй оролцох болсон байна. /Жишээ нь: Удөр мөрнийг үерлэх үеэр сайн дураараа туслах гэх мэт/ Тэд аливаа нэг байгууллагад урт хугацаагаар хамрагдахаас зайлсхийдэг болж тодорхой асуудал-төсөлд чиглэгдсэн идэвх санаачилгын хэлбэрийг илүүд үзэх болжээ.

Германы улс төрийн соёлын бас нэг онцлог бол Баруун болон Зүүн Германы иргэдийн ялгаатай байдал юм. Зүүн Германд нийгмийн тэнцвэртэй байдал, нийгмийн хамгааллын эрхийг илүү чухалчлан үздэг бол баруун Германд либерал эрх чөлөөний эрхүүдийг илүү чухалчилдаг. Холбооны

шинэ улсын иргэд төсөв хүчирхэг байхыг хүсдэг, нийгмийн баримжаат төрийг илүү дэмждэг нь тэд хуучин холбооны улсуудын иргэдтэй харьцуулахад нийгмийн шилжилтээс илүү хамааралтай байдагтай холбоотой юм. Холбооны шинэ улсуудын улс төрийн соёлын бас нэг онцлог бол бүх ард түмний шийдвэрт тулгуурласан ардчиллын элементүүдийг илүү дэмждэг. Энэ хандлага нь хуучин Ардчилсан Герман Улс ард түмэндээ ойр ардчилалтай гэж хүчтэй ухуулга хийдэг ч практик дээр хэрэгждэггүй байсантай холбоотой.

Холбооны шинэ улсуудад Германы Нэгдсэн Социалист Намыг залгамжлагч Ардчилсан Социализмын Нам намуудын системд хамгийн хүчтэй байр суурийг эзэлдэг. Уг нам нь ажил мэргэжил, үзэл бодлын хувьд хуучин АГУ-тай илүү холбоотой байсан хүмүүсийн харах нүд, сонсох чих нь болдог. Түүнээс гадна уг нам бол «барууныхан давамгайлдаг» гэж үнэлэгддэг намуудад харьяалагдахыг үл хүсдэг, эсэргүүцсэн байр суурьтай хүмүүсийг эх барьж авдаг өлгий юм. Холбооны улсуудын парламентуудад ХАХ, ГСДН, АСН-ын намуудын гурвалсан бүтэц олонтаа тохиолддог. Холбооны шинэ улсуудад сүмийн орчин байдаггүй тул ХАХ-г шашны шалтгаанаас бус прагматик шалтгаанаар сонгодог.

Германы улс төрийн соёл нэлээд удаан хугацааны туршид баруун болон зүүний зааглах шугамын дагуу тусгаарлагдсан хэвээр байх болно. Үүнийг Нэгдсэн Герман улсын хүн ам зүйн, улс төрийн, эдийн засгийн ялгаатай байдлын үр дүн гэж ойлгох нь зүйтэй юм.

7.6. Япон

Японы улс төрд Социал демократ нам хэзээ ч голлох үүргийг гүйцэтгэж байгаагүй юм. Гэсэн хэдий ч өндөр хөгжилтэй, зөвшилцөлд чиглэгдсэн шийдвэр гаргалтын процессоор тодорхойлогдох Японы нийгэм, улс төр, эдийн засгийн нийт

систем нь бүхэлдээ нэгэн төрлийн нийгмийн ардчиллын хэлбэрийг хадгалсаар ирсэн юм. Нийгмийн ардчиллын голлох элементүүд нь маш дэвшилтэй боловсруулагдсан үндсэн хуулийн зэрэгцээ ард түмний шударга ёсыг эрхэмлэх өндөр ухамсар, үндэсний үзэл юм.

Улс төрийн систем

Японы нийтийн сайн сайхны төлөөх систем нь улс төрийн олон ургалч систем дээр суурилдаг. Тухайн системийн заавал дурдах ёстой нэг онцлог нь олон арван жилийн туршид Либерал Ардчилсан Нам голлох байр суурь эзэлж ирсэн явдал юм. Уг нам зөвхөн богино хугацаанд буюу 1993 - 1994 оноос бусад бүх хугацаанд 1955 оноос хойш тасралтгүй ерөнхий сайдыг томилж байгаа юм. Нэлээд хожуу 1960 -аад оноос хойш сөрөг хүчний намуудын эгнээ өргөжиж эхэлсэн байна. Нэн түрүүнд Японы Социалист Нам нэлээд хүчирхэгжсэн байна. Японы улс төрийн систем ардчилалгүй гэдэг ихээхэн шүүмжлэлд өртдөг ч улс төрийн шийдвэр гаргалтын талаас нь авч үзвэл өргөн хэмжээтэй хэлэлцээрт чиглэгдсэн систем юм. Улс төрийн шийдвэр гаргалтын бүтэц нь **shingikai** буюу яамдуудын зөвлөлдөх комиссуудын хэлбэртэй байдаг. Сонирхлын холбоод, Олон нийтийн төлөөлөгчид, мэргэжлийн хүмүүс нь төрийн комиссууд ч гэж нэрлэж болох дээрх бүтцээр дамжуулан яамдууд, эсвэл ерөнхий сайдын ажилд оролцдог. Улс төрийн идэвхтэй олон нийт нь хуулиар баталгаажсан дээрх сувгаар дамжуулан бодлого тодорхойлоход оролцдог. Үүний зэрэгцээ яамдуудын зөвлөлдөх комисс нь шийдвэр гаргалтын үед гарсан зөрчилдөөнийг шийдвэрлэх төрийн нэгэн хэрэгсэл бөгөөд тухайн комиссуудад бодлогын салбаруудын оролцогчид, хохирогсдын төлөөллийг томилох замаар тэдний санал бодлыг шийдвэр гаргалтад тусгадаг. Дээрх комиссуудын шийдвэр гаргалт зөвшилцөл дээр суурилдаг учраас уг процессууд ихэвчлэн маш удаан үргэлжилдэг.

Үндэсний үзэл

19-р зууны дунд үеийг хүртэл Япон улс гадаад ертөнцөөс тусгаарлагдсан нөхцөлд өөрийн улс төр, нийгмийн системийг хөгжүүлж байжээ. 1854 онд Япон улс нээлттэй бодлого явуулахаас өөр аргагүй байдалд орсныг ард түмэн нь ихээхэн доромжлол хэмээн үзэж байжээ. Тэр цагаас хойш япон улс европын улсууд, АНУ-тай холбоо тогтоож тэдэнтэй адил төстэй болохыг оролдож эхэлжээ. Засгийн газар нь төрийн албан хаагчдаа системтэй мэдлэг туршлагатай болгохын тулд баруун европын орнууд уруу илгээж байжээ. Үүний үр дүнд жишээ нь Японы тэтгэвэр ба эрүүл мэндийн даатгалын систем нь Бисмаркийн загвараар байгуулагдсан. Японы үндсэрхэг үзэл хөгжилтэй орнуудтай адилхан хүчтэй, баян болох эрмэлзлээр илэрдэг. 1970-аад оны газрын тосны хямралын үед үндсэрхэг үзэл нь дотооддоо нэгтгэгч нөлөөг үзүүлж байлаа. Япон улс түүхий эдийн импортоос хараат улс тул түүгээр Японд халдаж болох юм гэдгийг мэдэрсэн явдал нь ажил олгогчид, ажилтнуудыг хамтын ажиллагаанд нэгтгэсэн юм. Үүнд үндсэрхэг үзлийн нэгтгэгч нөлөө тодорхой харагддаг. Эдийн засгийн хөгжлөөс хувь хүртэх боломж нэмэгдсэн нь Японы иргэдийн идэвх санаачилгыг өрнүүлж 1975 оноос хойш нийгмийн ардчилал бэхжихэд ихээхэн нөлөө үзүүлжээ.

Үндсэн эрхүүдийн систем

Японы үйлдвэрчний эвлэл нь хараат бус, идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг. Олон улсын хөдөлмөрийн байгууллагаас цэрэг, цагдаа нар, гал унтраагчдыг үйлдвэрчний эвлэлд нэгдэн орохыг хориглосон болон ажил хаяхыг хориглосон хуулийг шүүмжилдэг. Төрийн албан хаагчид мөн ажил хаяж болохгүй бөгөөд хамтын тарифын хэлэлцээрийг зөвхөн хязгаарлагдмал хүрээнд явуулах эрхтэй. Ажил хаях эрх хэсэгчилсэн байдлаар хангагддаг.

Эрэгтэй, эмэгтэйчүүд тэгш эрхтэй байх үндсэн эрх Японд бүрэн хангагдаагүй. Япон эмэгтэйчүүдийн карьер хийх боломж

хязгаарлагдмалаас гадна, зөвхөн эмэгтэй гэдэг шалтгаанаар цалин хөлсийг нь ялгавартай тогтоодог. Японы үйлдвэрчний эвлэлийн сүүлийн үеийн тайлангууд ажлын байран дээрх сексийн дарамт улам өргөжиж байгааг харуулсан байна. Хэдийгээр хуулиар сексийн дарамт учруулах, хүчирхийлэлд хуулийн хариуцлага ногдуулах заалттай боловч тийм тохиолдолд хариуцлага тооцсон жишээ маш цөөхөн байна. Японы үндэсний цөөнх болох аниу, буракамин нар болон 630.000 гаруй солонгосчууд нийгмийн болон эдийн засгийн хувьд ялгаварлагдан гадуурхагдаж аж төрдөг.

Япон улсын үндсэн хуульд хөдөлмөрлөх эрх 27-р зүйлээр, хүний ёсоор аж төрөх эрх Амьжиргааны баталгаажих доод түвшин 25-р зүйлээр тус тус баталгаажсан байдаг боловч хууль зүйн тайлбар талаас нь авч үзвэл дээрх заалтууд хангагдаагүй тохиолдолд гомдол гаргах эрх баталгаажаагүй. Гэсэн хэдий ч эдгээр эрхүүд Японы нийгмийн баримжаат төрийн маргашгүй суурийг бүрдүүлж байдаг. Үүнээс гадна Японы үндсэн хуулийн 11 ба 97-р зүйлүүд хүний эрхүүд бол халдашгүй дархан, заяагдмал эрхүүд мөн, бүх иргэд хүн болж төрсөн л бол дээрх эрхүүдийг эдэлнэ гэж заасан байдаг.

Нийгмийн баримжаат төр

Япон улс нь дотоодын нийт бүтээгдэхүүнд харьцуулсан нийгмийн салбарын зарлагын хувьд аж үйлдвэр өндөр хөгжсөн улсуудын дунд сүүлийн байранд ордог. 1991 оны байдлаар Нийгмийн нийт бүтээгдэхүүнийхээ зөвхөн (14.4%)-ийг олон нийтийн нийгмийн зардалд зориулж байжээ. Энэ үзүүлэлтээр япон улс АНУ (16%)-ын хойно орж байгаа бөгөөд нийгмийн нийт бүтээгдэхүүнийхээ (29.1%)-ийг нийгмийн зарлагад зориулдаг Герман улстай харьцуулахад 2 дахин бага байгаа юм. Энэ нь япон улсын нийгмийн үйлчилгээний тодорхой хувийг бусад харьцуулж буй орнуудаас өөр зарчмаар санхүүжүүлдэгтэй холбоотой юм.

Хэдийгээр Японы үндсэн хуулийн 25-р зүйлд нийгмийн баримжаат төрийн тухай нэмэлт тайлбар хийгдсэн, 1947 оноос хойш нийгмийн олон салбарт хуулиуд батлагдан гарсан боловч япон улс нийгмийн салбарын хөгжлөөр хоцрогдож буй орнуудын тоонд орсоор байгаа юм. Бүр хожуу 1970-аад оноос л нийгмийн хамгааллын өргөн хүрээтэй системийг байгуулж эхэлсэн байна. Энэ нь Либерал Ардчилсан Нам олон жилийн туршид барууны хэлбэрийн нийгмийн баримжаат төрийг гайхан ажиглаж зөв зохистой үлгэр жишээ гэж үзсээр байсан ч иргэд болон орон нутгийн байгууллагуудын дарамт нэмэгдсэний дараа л сая хэрэгжүүлж эхэлсэнтэй холбоотой юм. 1960-аад оны үед байгаль орчны бохирдлын асуудал хурцадсаны дараагаар ЛАН-ын «**Economy first**» буюу «эдийн засгийн хөгжлийг хэт шүтсэн» бодлогыг шүүмжилж эхэлсэн юм. Японы нийгмийн системийн онцлогууд бол Японы Социалист Нам болон бусад сөрөг хүчний намуудын шахалтаар нэвтрүүлсэн 70-аас дээш насны өндөр настнуудад эрүүл мэндийн үйлчилгээг үнэгүй хүргэх, хөдөлмөрийн зах зээл - болон хөдөлмөр эрхлэлтийн бодлогыг онцгойлон үзэх зэрэг юм. Хөдөлмөр эрхлэлтийн бодлого нь Японы нийтийн сайн сайхны төлөөх системд амьжиргааны баталгаажих доод түвшинг хангахад шийдвэрлэх үүргийг гүйцэтгэдэг. Учир нь Японд хүний ёсоор амьдрах эрхийг хүн бүр амьжиргааны эх үүсвэрээ өөрөө олох боломжийг бүрдүүлэх ажлын байраар хангагдсан байх ёстой хэмээн тайлбарладаг. Гагцхүү өөрийн идэвх чармайлт болон төрийн туслалцаатайгаар ажлын байр олоогүй тохиолдолд л төр тэдгээр хүмүүсийн амьжиргааны баталгаажих доод түвшинг хангана.

Газрын тосны хямралууд Японы нийтийн сайн сайхны төлөөх системийн үйлчилгээний хэмжээг бууруулаад зогсоогүй хүмүүсийн чиг хандлагыг өөрчилсөн юм. Европ хэв шинжийн нийтийн сайн сайхны төлөө төр 1970-аад оны эхэн үеийг хүртэл Японы бодлогын үлгэр жишээ болж байсан боловч барууныхан

өөрсдөө үлгэр жишээ байдлаа алдаж эхэлсэн юм. Япон улс нийтийн сайн сайхны төлөө европ хэв шинжийн төрийн байгууллагуудыг нэмж байгуулан олон улсын өрсөлдөөнд ялагдагч болохыг хүсээгүй учраас «Нийтийн сайн сайхны төлөө япон загварын нийгмийг байгуулах» уриаг дэвшүүлсэн юм. Гэр бүлүүд, нийгэм хамт олны нийтийн сайн сайхны төлөө үйлдвэрлэлд эзлэх байр суурийг нэмэгдүүлэх ёстой байлаа. Энэ нь нийгмийн үйлчилгээг бууруулна гэсэн үг биш, харин асар түргэн хугацаанд тэсрэлтийн хурдаар нэмэгдэж буй нийгмийн зардлыг эдийн засгийн шинэ нөхцөл боломжууд, хүн ам зүйн хөгжлийн хэтийн өөрчлөлтөд зохицуулах тактик, хүмүүсийн анхаарлыг өөр зүйлд хандуулах бодлого байлаа. Төрийн зүгээс нийгмийн зардалд зарцуулах хөрөнгийн хэмжээ 1951-2000 оны хооронд эрс нэмэгдсэн байна. Зөвхөн 1988-1991 онд Японы эдийн засгийн үсрэнгүй хөгжлийн үед бага зэрэг буурах хандлага гарч байжээ.

Японы нийгмийн баримжаат төр нь холимог эх үүсвэрээс санхүүждэг. Өндөр насны тэтгэвэр - эрүүл мэнд - асрамж - гэнэтийн осол - ажилгүйдлийн даатгал нь ажил олгогчид болон ажилтнуудын төлсөн шимтгэлээс санхүүждэг. Харин нийгмийн даатгалын шимтгэлийн хэмжээ нь Герман улстай харьцуулахад бага. Ажилгүйдлийн болон тэтгэврийн даатгалууд зөвхөн суурь тэтгэврийн даатгалд төрийн зүгээс санхүүгийн дэмжлэг үзүүлдэг. Эрүүл мэндийн даатгалын хувьд өвчтөн өөрөө эрүүл мэндийн даатгалын шимтгэлээс гадна эмчилгээний зардлын 20-30%-ийг төлдөг.

Капитализмын хэв шинж

Япон орон Герман, Голланд, Шведийн нэгэн адил зохицуулалттай зах зээлийн эдийн засагтай улсуудын тоонд багтдаг. Япон улс Герман улс шиг зах зээлийн эдийн засгаа аж үйлдвэрийн секторуудын хүрээнд зохицуулдаггүй, харин компаниудын бүлэглэлүүдийн хүрээнд зохицуулдаг онцлогтой.

Компаниудын хамгийн нөлөө бүхий сүлжээнүүд нь **keiretsu** буюу бүлгүүд болон компаниудыг эзэмшигч гэр бүлүүд ба тэдгээрийн аж үйлдвэрийн сектор дамнасан холбоонуудын нягт сүлжээнүүд дээр суурилдаг. Дээрх сүлжээнүүдийн хамгийн чухал хэлбэр бол босоо **keiretsu** буюу нэг том компанийг тойрсон олон жижиг компаниудын нэгдэл юм.

Герман улсад компаниуд аж үйлдвэрийн нэг секторын хүрээнд, нэн ялангуяа эмзэг салбаруудад хамтран ажилладаг бол Японы эдийн засаг аж үйлдвэрийн нэг салбар доторх компаниудын хүчтэй өрсөлдөөнөөр тодорхойлогддог. Японд эмзэг салбарын зохицуулалттай хамтын ажиллагаа нэг **keiretsu** -ийн хүрээнд өөрөөр хэлбэл өөр өөр секторт үйл ажиллагаа явуулдаг боловч компаниудын нэг гэр бүлд зохион байгуулагдсан компаниудын хүрээнд явагддаг.

Keiretsu -гийн зохицуулалтын энэхүү бүтэц боловсролын системүүд, болон шинэ технологи нэвтрүүлэх арга хэлбэрүүдэд чухал нөлөө үзүүлдэг. Компаниудын дотоодод зохион байгуулагддаг мэргэжлийн боловсрол, шинэ технологийг нэвтрүүлэх, аж үйлдвэрийн стандартуудыг тогтоох үйл явцууд ихэвчлэн босоо **keiretsu** -гийн хүрээнд явагддаг. Ажилтнуудыг зөвхөн тухайн компани эсвэл компаниудын бүлгүүдэд шаардагдах мэргэжлийн тусгай ур чадварыг эзэмшихэд зоригжуулдаг бөгөөд зөвхөн тухайн компаниудын гэр бүлийн хүрээнд ашиглах ажилтнуудыг бэлтгэхэд анхаарч ажилладаг. Ажилтнуудад зөвхөн тухайн компаниудын гэр бүлд шаардагдах мэргэжлийн ур чадварыг эзэмших хэрэгтэй гэдэг итгэл үнэмшлийг төрүүлэхийн тулд томоохон компаниуд насан туршид нь өөрийн компанид ажиллуулах ажилтай байлгах нөхцөлийг санал болгодог.

Дээрх амлалтаа биелүүлэхийн тулд Японы компаниуд маш түргэн хугацаанд шинэ бүтээгдэхүүнүүд, үйлдвэрлэлийн салбарт

шилжих хөрвөх чадвар маш өндөртэй байдгаас гадна нэг **keiretsu** - компаниудын бүлгийн дотор ажилтнуудаа шилжүүлдэг. **Keiretsu** - гийн зохицуулалт дээр голлон суурилсан үйлдвэрлэлийн систем ажилтнууд болон компаниуд, компаниудын бүлэг хоорондын энэхүү нягт холбооны давуу талыг ашигладаг. Уг нягт холбоосыг улам бэхжүүлэхийн тулд Японы компаниуд «компаниудын үйлдвэрчний эвлэл» -үүдийг байгуулсан бөгөөд энэ нь компанийн үйл ажиллагаанд ажилтнуудын санал бодлыг тусгахад илүү дөхөмтэй болсон байна.

Нийтэд нь авч үзвэл Японы эдийн засаг гурван багана дээр тогтдог: **Нэгдүгээрт** Японы менежментийн систем, **хоёрдугаарт** компаниудын болон бодлогын түвшинд зөвлөлдөх системүүд \гурван талт\, **гуравдугаарт** «банкнууд дээр суурилсан загвар - **stakeholder Modell**». Энэхүү гурван загвар хоорондоо нягт холбоотой ба эдийн засгийн системийн шинж чанарыг дээрх гурван баганын нэгдэл гэж ойлгох нь зүйтэй:

Японы менежментийн систем

1980-аад оны хоёрдугаар хагаст авто машины үйлдвэрлэлийн салбарт япон улс илэрхий тэргүүлж эхэлсэн нь Америкийн болон европын өрсөлдөгчдөө Японыг гүйцэхийн тулд Японы аж үйлдвэрийн үлгэр жишээ хөдөлмөр зохион байгуулалтын шинэ хэлбэрүүдээс суралцахыг шаардаж байлаа. Японы амжилтын нууцыг Массачусетсийн технологийн институтээс 1984-1989 оны хооронд 14 орны 90 гаруй автомашины үйлдвэрлэлийн монтажны сүлжээг судалсны үндсэн дээр тайлсан байна. Тэд анх удаа «**lean Production**» буюу «суралцагч үйлдвэрлэл» гэдэг нэр томъёог хэрэглэсэн байна. Барууны авто машины үйлдвэрлэлтэй харьцуулахад үйлдвэрлэлийн бүх нөөцөөс тун бага хэмжээгээр хэрэглэгдэж байсан учраас Тоёота компанийн зохион байгуулалтыг ийнхүү нэрлэсэн байна. Баруунд шаардагдах боловсон хүчний тал хувьтай тэнцэх тооны ажилтнууд фабрик дээр ажиллаж, баруунд шаардагддаг үйлдвэрлэлийн талбайн

тал хувь дээр үйлдвэрлэл явагдаж, хөрөнгө оруулалтын тал хувь нь үйлдвэрлэлийн хэрэгсэлд зарцуулагдаж ашгийн тал хувь нь шинэ бүтээгдэхүүнийг хөгжүүлэхэд зарцуулагдаж байжээ. Япончууд үйлдвэрлэл явуулахдаа баруунтай харьцуулахад тал хувьтай нь тэнцэх хэмжээний агуулахын нөөцөөр, үйлдвэрлэл дээр тун бага алдаа гаргаж, маш олон төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж байжээ. Японы авто машины үйлдвэрлэл нэг машин үйлдвэрлэхэд дунджаар 16.8 цаг зарцуулдаг бол Америкийн үйлдвэрүүд тухайн үед 25.1 цаг, европын үйлдвэрүүд 36.2 цаг зарцуулж байжээ.

Тун удалгүй Японы бүтээмжийн давуу тал технологийн шинэчлэлийн үр дүн биш харин группийн ажил дээр суурилсан, **KAIZEN** гэж нэрлэгддэг бусад элементүүдийг багтаасан аж үйлдвэрийн хөдөлмөр зохион байгуулалтыг өөрчилсний үр дүн гэдэг нь тогтоогдсон байна. **KAIZEN** гэдэг нь сайжруулан өөрчлөх буюу байнгын сайжруулалт гэсэн утгатай үг юм. Компаниудын **KAIZEN** гэдэг философи нь зөвхөн япончуудын эдийн засгийн амьдралыг илэрхийлээд зогсохгүй нийгмийн болон гэр бүлийн амьдралыг илэрхийлдэг. Энэ философи нь компанийн түвшинд бол ажилтнууд болон удирдах ажилтнуудын хамтын ажиллагааны суурь юм. Энэ нь бүгдээрээ байнга сайжруулалтын төлөө хичээн ажиллаж компанид бүх төрлийн үргүй зардал гарахаас сэргийлэх, «Ямар ч алдаа мадаггүй байх - Хөтөлбөр»-ийг хэрэгжүүлэх үүрэгтээ үнэнч байх, чанарын баталгааг хангахыг бүхнээс эрхэмлэж үйлчлүүлэгчдийн шаардлагыг хангахын тулд байнгын хяналт хэрэгжүүлнэ гэсэн үг юм. Японы үлгэр жишээг удалгүй Америкийн болон Европын компаниуд үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн байна. Шинэ хөдөлмөр зохион байгуулалтын хөдөлмөр эрхлэлтэд сайн нөлөө үзүүлнэ гэдэгт эргэлзэх хэрэггүй юм.

Компаниудын түвшин дэх зөвлөлдөх систем
1980 -аас 1990 -ээд онд баруунд өрнөж байсан Японы эдийн

засгийн бүтээмжийн тухай мэтгэлцээнүүдэд япон ажилчдын тайван зан, зарчимч байдлын тухай байнга яригддаг байлаа. Тэд «компанидаа туйлын үнэнч бөгөөд бүхий л мэдлэг чадвараа дайчлан ажилладаг» гэцгээдэг байлаа. Хэрэв тухайн үед Японы түүхийг хальт ч болов сөхөн харсансан бол дээрх нотолгоонууд бодит байдалд огт нийцэхгүй гэдгийг төвөггүй мэдэж болох байлаа. Учир нь япон ажилчид гадаадын мэргэжил нэгт нөхдөөсөө бараг ялгардаггүй юм. Ажлын байрны баталгаат байдал, орлогоо нэмэгдүүлэх нь тэдний гол сонирхол юм. Үүний тулд тэд зохион байгуулалтад орж хэрэв шаардлагатай гэж үзвэл тэмцэл өрнүүлдэг. Энэ нь дэлхийн хоёрдугаар дайны дараа ажил хаялт олноороо зохион байгуулагдсанаар нотлогддог. 1970-аад оныг хүртэл «тэмцэгч» бүлгүүдээс бүрдсэн үйлдвэрчний эвлэлийн зүүний жигүүр маш хүчирхэг байлаа.

Бусад орнуудын нэгэн адил Японы хөдөлмөр эрхлэгсдийн үйлдвэрчний эвлэлийн гишүүнчлэл 1970-аад оны үед гуравны нэг хувьтай байсан бол өдгөө тавны нэг болтлоо буурсан байна. Гишүүнчлэлийн тоо буурсан нь хараат ажилчдын тоо өссөнөөс голлон хамаарч байгаа юм. Тэдний тоо 1970-аас 2001 оны хооронд 33.5 саяас 53.7 сая болтлоо өссөн юм. Харин үйлдвэрчний эвлэлийн зохион байгуулалтад орсон ажилчдын тоо 1970-аад оноос хойш тогтмол байна. Японы үйлдвэрчний эвлэлийнхэн нэн түрүүнд томоохон компаниудад (аж үйлдвэр, тээвэр, мэдээлэл харилцаа), төрийн болон төрийн оролцоотой салбаруудад хүчтэй байдаг. 1000-аас дээш ажилтантай компаниудад 1960-аад оноос хойш үйлдвэрчний эвлэлийн зохион байгуулалтад орсон ажилтнуудын эзлэх хувь 55 орчим хувьтай байна. 100 - 999 хүртэлх ажилтнуудтай жижиг компаниудад үйлдвэрчний гишүүнчлэл 17%, 100-аас доош ажилтантай компаниудад дөнгөж 1.3% тай байна.

1970 -аад оны дунд үеэс хойш Японд өнөөгийн аж үйлдвэрийн

харилцаа бэхжин тогтсон байна. Нэн түрүүн хоёр багана байдаг. **Нэгдүгээрт** цалингийн хамтын хэлэлцээр, **хоёрдугаарт** бүх түвшинд ажилтнуудын шийдвэр гаргалтад оролцох эрх. Японы цалингийн хамтын хэлэлцээрийн германыхаас ялгагдах онцлог бол салбарын болон нутаг дэвсгэрийн тарифын гэрээнүүд байгуулагддаггүй. Хэлэлцээрүүд компаниудын үйлдвэрчний эвлэл, компаниудын хооронд явагддаг. Гэхдээ үйлдвэрчний эвлэлийн төв байгууллагатай байнга зөвшилцөн нягт хамтран ажилладаг. Үүний улмаас компаниудын цалингийн хамтын гэрээний чиглүүлэгч буюу нэгдсэн үнэлэмжийг тогтоох хүртэл ихээхэн хугацаа зарцуулагддаг байна. Хамгийн нөлөө бүхий компаниудын гэрээ байгуулагдаж дууссаны дараа бусад компаниудын гэрээнүүд байгуулагддаг. Гэхдээ компаниудын тухайн жилийн онцлог нөхцөл байдлыг байнга харгалзан үздэг. Эдгээр хэлэлцээрийн үр дүн эцсийн дүндээ салбарын тарифын гэрээ бүхий системийн үр дүнтэй бараг ижил байдаг. Компаниудын хэмжээнээс хамааран цалингийн орлого харилцан адилгүй байдаг. 10 - 99 ажилтантай жижиг компаниудын жилийн орлого 1000 ажилтантай компанийн жилийн орлогын ойролцоогоор гуравны нэгтэй тэнцдэг.

Ажилтнуудын шийдвэр гаргалтад оролцох оролцооны хувьд дараах зүйлүүд ажиглагддаг. Японд тогтмол бус хөдөлмөр эрхлэгсдийн нийт хөдөлмөр эрхлэгсдийн дунд эзлэх хувь 1975 оноос (9.9%)-аас 1990 (15.2%) оны хооронд 5-аас дээш хувиар өссөн байна. Тогтмол бус хөдөлмөр эрхлэгсдийн томоохон бүлэг бол хагас өдрөөр ажиллагсад юм. Тэдний тоо 1985 - 1995 оны хооронд 3.6 саяас 5.56 сая болтлоо өссөн байна. Энд тэд бүтэн өдрөөр ажиллах хүчинтэй ижил хэмжээний хөдөлмөр цагийг гүйцэтгэдэг гэдгийг тэмдэглэх нь зүйтэй. Тогтмол бус хөдөлмөр эрхлэгсдийн дийлэнх нь эмэгтэйчүүд байдаг. Тогтмол бус хөдөлмөр эрхлэлтийн шинэ хэлбэрт ажиллаж буй ажилтнуудын ашиг сонирхлыг үйлдвэрчний эвлэлийнхэн ойшоож үздэггүй. Менежмент эдийн засгийн тухайн байдлаас

хамааран тогтмол бус ажиллах хүчний тоог уян хатан өөрчилж болдог учраас тогтмол хөдөлмөр эрхлэгсдийн байнгын хөдөлмөр эрхлэлтийн харилцааг тэд хамгаалж байдаг. Компаниудын үйлдвэрчний эвлэлүүд ихэнх тохиолдолд ажлаас халагдсан тогтмол бус хөдөлмөр эрхлэгсдийн эрх ашгийг хамгаалдаггүй.

Үйлдвэрчний эвлэлийн ашиг сонирхлын төлөөллийн энэхүү дутагдал зохион байгуулалтын шинэ хэлбэр, идэвх санаачилга үүсэн бий болоход хүргэсэн байна. Орон нутгийн түвшинд ажилтнуудыг хөдөлмөр эрхлэлтийн хэлбэрээс нь үл хамааран зохион байгуулалтад оруулах оролдлого хийдэг **Community Unions** олон хотуудад байгуулагдсан байна. Энэ холбоо зөвхөн эмэгтэй ажилтнуудын эрх ашгийг хамгаалдаг жишээ нь: 1995 онд Токиогийн эмэгтэйчүүдийн үйлдвэрчний эвлэл **Josei Yunion Tokyo** байгуулагдсан байна.

Улс төрийн түвшин дэх зөвлөлдөх системүүд

Эдийн засгийн процессод оролцох төрийн оролцооны арга хэлбэр нь Японы барууны худалдааны түншүүдийн сэтгэлийг байнга зовоодог зүйл юм. Японд төр эдийн засгийн үйл ажиллагаанд өөрийн үзэмжээр нөлөөлөхийг оролдох нь хэвшил болсон зүйл. Төрийн оролцооны хэрэгслүүд нь яамдуудын хамтарсан төлөвлөгөөг боловсруулах, эдийн засгийн тодорхой салбаруудыг үсрэнгүй хөгжилд хүргэх эсвэл эрс доройтуулахын тулд компаниудын өрсөлдөх эрхийг хүчингүй болгох зэрэг даяаршлын удирдлагын өнөөгийн арга хэмжээнүүдийн зэрэгцээ эдийн засгийн хөгжлийн далайцыг хумих судалгаа, хөгжлийн идэвх санаачилгуудыг уялдуулах арга хэмжээнүүдийг авдаг.

Эдийн засгийн ерөнхий уур амьсгалд нөлөөлөх нэгэн чухал хэрэгсэл бол хүнд суртал буюу захиргааны байгууллагуудын олны анхаарлыг өөр тийш хандуулах (**Gyosei Shido**) өргөн хүрээ

бүхий мэдээлэлд нөлөөлөх арга хэмжээ юм. Уг захиргааны удирдлага нь төрийн албан хаагч - элитүүд, улс төрчид, тэргүүлэх эдийн засагчдын нягт холбоон дээр суурилдаг. Японд төр болон эдийн засгийн харилцааны хамтын ажиллагааг дэмжигч элементүүдийн талаар албан ёсоор онцлон тэмдэглэдэг. Дээрх удирдлагыг ихэвчлэн зөвлөгөөний үндсэн дээр хэрэгжүүлдэг. Төр болон компаниуд үүгээр зогсохгүй бүхэл бүтэн аж үйлдвэрийн хэтийн төлөвийн талаар шийдвэр гаргаж зөвшилцлийн үндсэн дээр дэмжих болон өөрчлөн байгуулах зорилтот арга хэмжээнүүдийг хэрэгжүүлдэг. Японд төрийн удирдлага нь эдийн засгийн хэрэгцээнд зохицсон, тэдгээрийн аяыг харсан бусад орнуудтай харьцуулахад асар хүчтэй юм.

Банкнуд дээр суурилсан загвар (stakeholder - Modell)

Япон улс Германтай нэгэн адил «банкнуд дээр суурилсан» буюу «**stakeholder - Modell**» компанийн ерөнхий зарчимтай орон юм. Германтай нэгэн адил хөрөнгө оруулагчдын санхүүжилт зонхилон банкны системээр дамжин хийгддэг бөгөөд санхүүгийн байгууллагууд болон аж үйлдвэрийн компаниуд хувьцааны хөрөнгөний ихэнх хувийг хянаж байдаг. 1995 оны байдлаар 69.19-ийг хянаж байжээ. Энэ нь байнга ийм байсан гэсэн үг биш бөгөөд 1949 онд хувьцааны хөрөнгөний 69.1 хувийг хувь хүмүүс болон хуулийн бус этгээдүүд эзэмшиж байжээ.

Дэлхийн хоёрдугаар дайны дараахан Америкийн эзэмшлийн бүсийн албан газрууд ардчиллыг бэхжүүлэх, дайны байдлыг намжаах үйл ажиллагааны хүрээнд том концернуудыг /**zai-batsu**/ уналтад оруулсан. Их хэмжээний хувьцаа эзэмшигч хувь хүмүүс үгүй болж хувьцаа олон хэсэгт тарсан байна. 1947 онд батлагдан гарсан монополийн эсрэг хуулиар хуулийн этгээдүүдийг өөрийн хөрөнгөөр хувьцаа худалдан авахыг хориглосон байна. Үүний нөлөөгөөр хувьцааны дийлэнх хувь хүмүүсийн эзэмшилд шилжсэн байна. Тухайн цаг үед Японы

капитализм аль чиглэлд хөгжих нь тодорхой бус байлаа.

Монополийн эсрэг хуульд нэлээд олон нэмэлт өөрчлөлт оруулсны эхнийх нь 1949 онд батлагдан гарч дээрх хориглолтыг сулруулсан бөгөөд «Хамтран хувьцаа эзэмших» үйл явц эхэлсэн байна. Маш олон тооны хувиараа хувьцаа эзэмшигчид инфляц маш өндөр байх үед хувьцаагаа зарсан байна. Үүний улмаас хувиараа эзэмшигчдийн гар дээр байгаа хувьцааны эзлэх хувь 1960 онд 46% байсан бол 1991 онд 23.2% болтлоо буурсан байна. Монополийн эсрэг хуулийн 1953 оны нэмэлт өөрчлөлтөөр компаниудын давхацсан хамаарал улам нэмэгдсэн байна. Компаниудын захирлууд тогтмол уулзах болсноор компаниудын бүлэглэлүүд шинээр бүрэлдэн бий болж эхэлсэн байна. Дээрх хамтын ажиллагаа 1964 онд Япон улс Эдийн Засгийн Хөгжлийн Хамтын Ажиллагааны байгууллагад гишүүнээр элссэнээс хойш улам бэхжиж үүний улмаас хөрөнгийн зах зээл либералчлагдахыг хүлээн зөвшөөрөхөөсөөр аргагүй байдалд орсон юм. Хүмүүс гадаадын хөрөнгөөр Японы компаниудын хувьцааг их хэмжээгээр худалдан авахаас болгоомжилж байлаа. Тоёота авто машины үйлдвэрийн хувьцааг худалдаалж эхэлсэнтэй холбогдуулан Японы томоохон компаниуд «Хувьцааг баталгаатай эзэмшилд байлгах» «*antei kabunuhi kosaku*» аргыг нэвтрүүлж эхэлсэн байна. Компаниуд хувьцаануудаа харилцан худалдах ба худалдан авна. Ихэвчлэн компаниудын нэгэн бүлэглэлийн дотор уг арилжаа явагдана. Хувьцаа эзэмшлийн үндсэн бүтэц үүнээс хойш бараг өөрчлөгдөөгүй байна. 1995 онд хувьцааны 7.4% ихэвчлэн төлөөллийн газруудтай гадаадын хөрөнгө оруулагчдын эзэмшилд очсон бөгөөд тэд байнга хувьцаа худалдан авах, худалдах үйл ажиллагааг эрхэлж байсан нь хөдөлмөрийн зах зээл дээр ихээхэн шуугиан тарьж зарим нэг тохиолдолд Японы компаниудыг хяналтдаа авах боломжийг бүрдүүлж байлаа.

Улс төрийн соёл ба иргэний нийгэм

Японы улс төрийн системийг маш их нэгдэлтэй улс төрийн соёлоор дэмжиж байдаг бөгөөд уг соёл тэгш байдлыг хангахад чиглэгдсэн норматив шаардлагуудаар тодорхойлогдож байдаг. 1950 - 1960-аад оны эдийн засгийн үсрэнгүй хөгжлийн үед ардчилсан улс төрийн системд итгэх итгэл маш өндөр байлаа. Тухайн цаг үед хүн бүр тэгш боломжоор хангагдсан гэдэг итгэл нийт япончуудад байлаа. Харин 1970-аад оны үеэс япон иргэд нийгмээ тодорхойлохдоо амнаас нь «итгэлгүй» гэдэг үг тун амархан унадаг болсон байна. 1990-ээд оны үед бодит байдал дээр хуваарилалтын индексүүд бага зэрэг буурсныг эс тооцвол олон улсын түвшинд харьцуулахад орлогын шударга хуваарилалтын байдлаараа тэргүүлдэг орны иргэд ийм сэтгэгдэлтэй байсан нь гайхал төрүүлдэг. Иргэдийнх нь шударга бус байна гэдэг сэтгэгдэл хувь хүмүүсийн хичээл зүтгэлийг бус бүтээмжийг үндэслэн цалин хөлс олгодогт оршиж буй юм. Үүний зэрэгцээ нийгмийн давхаргууд эцэг эхийн боловсролын түвшинг өвлөн авах явдал улам бүр нэмэгдэж Японы нээлттэй боловсролын нийгэмд хүн бүр өөрийн гарал үүсэл, хөрөнгө чинээ, авьяас чадвар, хувийн хичээл зүтгэлээс үл хамааран өөрийн байр суурийг олж болно гэдэг итгэл үнэмшил үгүй болсонтой холбоотой юм.

Ухамсрын энэ өөрчлөлт үнэлэмж өөрчлөгдөхөд хүргэсэн байна. 1960-аад оны сүүлчээс Японд шинэ пост - материаллаг үнэлэмж нэвтэрсэн нь ажиглагддаг. Дээрх үнэлэмж нэн ялангуяа орон нутгийн түвшинд томоохон амжилтад хүрч байсан, өдгөө ч амжилттай хэвээр байгаа нийгмийн олон хөдөлгөөнүүдийн суурийг бүрдүүлдэг. Иргэдийн идэвх санаачилга, сайн дурын хөдөлгөөнүүдийн тоо хэдэн саяар тоологддог. Хэдийгээр улс орон даяар улс төрийн сонирхлыг төлөөлдөг цөөхөн тооны байгууллагууд, холбоод байдаг боловч Японы иргэний нийгэм хүчирхэг.

Хэтийн төлөв

Японы нийгэмд нийгмийн ардчиллын бүх элементүүд оршин байдаг. Гэсэн хэдий ч эдгээр элементүүд хүчирхэг социал демократ нам, социал демократ үзэл санааны фундаментийг бүрдүүлээгүй юм. Тус орны захиргааны байгууллагуудын, шинжлэх ухааны, улс төрийн элитүүд дэлхийн өнцөг булан бүрд урт хугацааны найдвартай шийдлийг эрэлхийлж мэдээлэл, санаа, хөтөлбөрүүдийн тухай мэдээллүүдийг цуглуулж хэрэгжүүлсэн учраас нийгмийн ардчилалд өөрсдийн хувь нэмрээ оруулсан юм.

Японы системд бэрхшээлтэй аспектиуд байдаг. Уг систем үргэлждотогшоо чиглэдэг, үндэсний хүчин зүйлс давамгайлдаг тул тус улсад гадаадын үндэсний цөөнхүүдийг нэгтгэх талаар хөтөлбөр, практик саналууд байдаггүй. Ажиллах хүчний шилжих хөдөлгөөн эхэлсэн төдийгүй ирээдүйд улам өсөн нэмэгдэх хандлагатай байна. Япон улс ажиллах хүчний шилжилтийн асуудлыг тойрч биш дайрч гарах нь ойлгомжтой болоод байна. Өнөөгийн байдлаар Японд оршин сууж буй гадаадын иргэд тус улсын үндсэн хуулиар олгогдсон бүх эрхүүдийг эдэлдэггүй. Японы хойд хэсэгт оршин суудаг үндэстний цөөнх болох Айнү нарыг ялгаварлан гадуурхдаг хэвээр байгаа юм. 1990-ээд оноос тэдний эрх зүйн байдал сайжирсан ч хангалттай түвшинд хүрээгүй байна.

Үүний нэгэн адил хүйсийн тэгш байдлыг хангах үйл явцыг мөн сайжруулах шаардлагатай хэвээр байна. Мөн орон байргүй хүмүүсийг дэмжих, өдрийн хөлс, нийгмийн халамж хүртэгсдийн эрх зүйн байдлыг сайжруулах шаардлагатай байна. Үүнээс гадна өнгөрсөн түүхээ санагалзахаас ангижрах хэрэгцээ байгаа бөгөөд энэ нь хөрш орнуудтай харилцах харилцаанд хүндрэл учруулдаг. Дээрх нээлттэй асуудлуудын сүүдэр өргөн хүрээтэй, хүчирхэг нийгмийн үйлчилгээ үзүүлэх чадвартай нийгмийн хамгааллын систем бүхий нийгмийн ардчилалд сүүдрээ тусгаж байна.

7.7 АНУ Улс төрийн систем

АНУ бол ерөнхийлөгчийн засаглалтай орнуудын сонгодог жишээ. Энэ улсын онцлог шинж бол дуал буюу хосолмол бүтэц юм: Парламент болон засгийн газар нь тус бүрдээ бие даасан сонгогчдоос хууль ёсоор сонгогддог боловч үйл ажиллагааны чадамжийн хувьд хоорондоо хамааралтай. Гүйцэтгэх засаглал болон хууль тогтоогчид бие даасан үндсэн хуулийн байгууллагууд үйл ажиллагааны хувьд олон талаар давхацдаг. Конгресс ерөнхийлөгчийг улс төрийн шалтгаанаар албан тушаалаас нь огцруулж болохгүй, эсрэгээрээ ерөнхийлөгч конгрессыг тараах эрхгүй. Энэхүү хараат бус байдлын баталгааг хангахын тулд засгийн газрын гишүүд нь конгрессын гишүүн байж болохгүй. АНУ-д ерөнхийлөгч нь де факто ард түмнээс сонгогддог. Ерөнхийлөгчийн сонгууль мажоритар системээр явагддаг. Төлөөлөгчдийн танхимын гишүүд хоёр жил тутамд мөн ард түмнээс шууд сонгогддог. Сенатад нь АНУ-ын 50 холбооны улсуудаас тус бүр хоёр сенатор төлөөлдөг бөгөөд зургаан жилийн хугацаатайгаар сонгогддог.

Америкийн засгийн газрын системд хүчний хуваарилалтын онол хүчтэй нөлөөлдөг бөгөөд уг онолын гол төлөөлөгчид нь Монтескүеи, Жон Аок нар юм. Тэдний санал болгосон хуваагдал, мөн хязгаарлалтыг нэгэн зэрэг агуулсан хүчний хуваарилалт нь эрх мэдлийг буруугаар ашиглахаас сэргийлдэг. Уг хөтөлбөрийн дагуу хоорондоо давхацсан, боловсон хүчин болон хууль ёсны хувьд хараат бус, гэхдээ хоорондоо эрх мэдэл нь давхацсан байгууллагуудыг бий болгосон байна. Нэг талаас харахад үндсэн хуулийн байгууллага бүр бие даасан эрх мэдлийн хүрээ, нөгөө талаас харахад дээрх шүүх бүр бусад шүүхүүдийн эрх мэдэлд маш нөлөөтэйгөөр хөндлөнгөөс оролцох эрхтэй байдаг нь эрх мэдлийн давхцалыг бий болгодог. Иймээс уг систем нь бие биенээ харилцан хянадаг байгууллагуудын нэгдлээс бүрддэг. «Хяналт ба тэнцвэрт байдал», «**check and balances**»-ын систем юм. Уг

систем засгийн газар хэт хүчирхэгжиж эдийн засаг, нийгмийн амьдралд хөндлөнгөөс оролцохоос сэргийлж байдаг.

АНУ-ын үндсэн хуулийн систем нь аль болох өргөн хүрээтэй хүчний хуваарилалт болон эрх мэдлийн хязгаарлалтыг зорилго болгодог. Ингэснээр хувь хүмүүсийн эрх чөлөөг үндэслэлгүй төрийн эрх мэдлээс дээд зэргээр хамгаалах боломжийг бүрдүүлдэг. Үндсэн хуулийн систем нь дараах онцлогтой байдаг:

- Конгресс хууль тогтоогч эрх мэдлийг эдэлдэг. Конгрессын танхимууд Конгресс ба төлөөлөгчдийн танхим тэгш эрхтэйгээр хамтран ажилладаг. Ерөнхийлөгч нь бүх хуулийг хүчин төгөлдөр болохоос нь өмнө зөвшилцөх эрхтэй.
- Ерөнхийлөгч гүйцэтгэх эрх мэдлийг эдэлдэг. Ерөнхийлөгч нь төрийн тэргүүн бөгөөд засгийн газрын тэргүүн юм. Гэхдээ ерөнхийлөгч шийдвэр гаргахдаа Сенатын зөвлөгөөг авч зөвшилцөх үүрэгтэй.
- Дээрх шүүхийн эрх мэдлийг **Supreme Court** ба конгрессын томилдог иргэний шүүх эдэлдэг. Үүнээс гадна хэвтээ тэнхлэгт хүчирхэг холбооны бүтэц бүхий төрийн бүтцээр нөхөгдөж байдаг.
- Америкийн үндсэн хууль нь либерал иргэдийн эрхийг баталгаажуулж өгдөг. Харин нийгмийн болон эдийн засгийн эрхүүдийн баталгааг хангадаггүй. Иргэдийн эрхүүд төрийн үйл ажиллагааг хүндэтгэн үзэж шүүхийн хяналтын дор оршдог.

Америкийн системд улс төрийн намуудын өрсөлдөөн тэнцвэржүүлэгч үүргийг гүйцэтгэдэг. Америкийн улс төрийн намууд нь парламентын засаглалтай системүүдтэй харьцуулахад

улс төрийн удирдлагын нөлөө бүхий байгууллагууд биш харин сонгуулийн кампаниудыг явуулдаг байгууллагууд юм. Тэд хөтөлбөрүүд дээрээ тогтдоггүй, сайтар боловсруулсан засгийн газрын хөтөлбөртэйгөөр сонгуульд оролцдоггүй, ихэнх үйл ажиллагаагаа конгресст хаалттай бүлгүүдийн хэлбэрээр явуулдаггүй. Гүйцэтгэх үйл ажиллагааг фракцууд явуулдаггүй. Сенат ба төлөөлөгчдийн танхим нь аль намын гишүүн байх нь чухал бус харин конгрессын гишүүдийн хувийн сонирхлын адил төстэй байдал шийдвэрлэх рольтой.

Сүүлийн хориод жилд улс төрийн системд улс төрийн намуудын нөлөө ихээхэн өсөж өдгөөг хүртэл танил бус намын мөрийн хөтөлбөрүүдийн эрс туйлшрал ажиглагдах болсон байна. 1980-аад оноос Америкийн улс төрийн намууд үзэл суртлын хувьд хоорондоо эрс ялгарах болж үйл ажиллагааны тов тодорхой чиг хандлагуудыг дэвшүүлэх болжээ. Үзэл суртлын туйлшрал 1990-ээд оноос хойш улам хүчтэй болжээ. Энэ чиг хандлага цаашдаа хэвээр хадгалагдах нь уу? гэдгийг ажиглан хүлээх л үлдээд байна.

Америкийн засгийн газрын системийн үндсэн асуудал бол төрийн үйл ажиллагааны нэгдэл, нягт байдал сул байдагт оршино. Уг системийн байгууллагуудын эрс ялгаатай байдал, улс төрийн намуудын нэгдэл сул байдаг нь хэсэг бүлэг хүмүүсийн сонирхлуудын нөлөө хүчтэй байх нөхцөлийг бүрдүүлдэг. Үүний улмаас зохицуулалт муутай, амархан солигдож байдаг.

АНУ олон ургалч ардчиллын сонгодог жишээ юм. Америкийн засгийн газар сонирхлуудыг өндөр хэмжээнд зохион байгуулалтад оруулах боломжийг бүрдүүлдгийг тэмдэглэн хэлэх нь зүйтэй. Гэхдээ хэдийгээр өргөн хүрээтэй ч зохион байгуулалтад оруулах боломж муутай сонирхлуудын бүтэлгүйтэх нь олонтаа. Энэ бэрхшээл нь үндэстний цөөнхийг нэгтгэх, эсвэл ядууралтай тэмцэх нийгэм улс төрийн бодлого хэрэгжүүлэхэд тодорхой харагддаг.

Үндсэн эрхүүдийн систем

Хүйсийн тэгш байдлыг АНУ-д хуулиар баталгаажуулсан байдаг. Шүүхийн шийдвэрээр дэмжлэг үзүүлж байдаг. Дунджаар эмэгтэйчүүд нь эрчүүдээс бага цалин авдаг. Харин сургууль төгсөгчдийн дунд эрэгтэйчүүд ба эмэгтэйчүүдийн цалингийн ялгаа улам бага болсоор байна. 20 настай эмэгтэйчүүдийн цалин цалингийн нэг ангилалд багтдаг эрэгтэй ажилчдын цалингаас бараг ялгаагүй болсон байна. Эмэгтэйчүүд анагаах ухаан, хууль, сэтгүүл зүй зэрэг салбаруудын мэргэжил эзэмшдэг болсоор нэлээд хугацаа өнгөрсөн байна. Сэтгүүл зүй болон хуульчийн мэргэжлийн сургуулиудын эмэгтэй оюутнуудын тоо эрэгтэй оюутнуудынхаас давуу болж эхэлсэн байна.

АНУ-д орлогын тэгш бус байдал болон эрүүл мэндийн байдал судалгаанд хамрагдсан бусад орнуудтай харьцуулахад харьцангуй өндөр байна. Харин ажилгүйдлийн хувьд 1999 онд 4.1% байна.

Хэдийгээр АНУ-ын үндсэн хууль ажилчдын үйлдвэрчний эвлэл байгуулах, тарифын хэлэлцээр хийх эрхүүдийг баталгаажуулсан байдаг боловч ажилчны хөдөлгөөн нь харьцангуй сул байдаг. Ажилчдын 13% ба түүнээс дээш хувь, хувийн бизнесийн салбарын хөдөлмөр эрхлэгсдийн 10% нь үйлдвэрчний эвлэлийн гишүүд. Ажилчдын үйлдвэрчний зохион байгуулалт сул байдаг нь соёлын зарим хүчин зүйлсээс хамааралтай байдаг. Нөгөө талаас ажил олгогч эздийн хүчтэй эсэргүүцлээс хамаардаг.

Нийгмийн баримжаат төр

1935 онд батлагдан гарсан нийгмийн хамгааллын салбарын баримт бичиг нь Америкийн нийгмийн бодлогын үндсэн баримт бичиг юм. Уг баримт бичиг нь холбооны хэмжээнд өндөр нас - ард үлдэгсэд - тахир дутуугийн хамгааллын чухал харилцаануудыг зохицуулдаг. Бусад бүх нийгмийн бодлогын салбарууд холбооны улсуудын түвшинд зохицуулагддаг бөгөөд тэдгээрийн баталгаат үйлчилгээнүүд, хэлбэр, хамрах

хүрээ, хэмжээ нь харилцан адилгүй байдаг. Америкийн нийгмийн бодлого нь холбоо болон холбооны улсуудын хооронд эрх мэдэл, нийгмийн үйлчилгээний санхүүжилтийн талаар байнгын маргаан өрнүүлж байдаг.

Нийгмийн сайн сайхны төлөө бүтээгдэхүүн үйлдвэрлэгч байгууллагуудын зохион байгуулалт нэгдсэн улсад зах зээлийн зарчмын ноёрхлоор тодорхойлогддог. Тус оронд төрөөс авч явуулж буй арга хэмжээнүүд нь зах зээлийн хүчнүүдийн нөлөөнд хүндрэл учруулж болохгүй гэсэн ойлголт давамгайлдаг. Ийм ч учраас төрийн зааварчилгаанд хөдөлмөрлөх эрх тусгагдаагүй байдаг. Нийгмийн баталгаат байдлыг хангахад компаниудын нийгмийн үйлчилгээ бусад улсуудынхаас илүү өндөр үүргийг биелүүлдэг. Тэтгэвэрт гарахаас өмнөхөн ажилгүйдэлд өртсөн бол маш үр өгөөжтэй урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүд авагддаг. АНУ-д хүн бүр амьжиргааныхаа эх үүсвэрийг хөдөлмөр эрхэлж бүрдүүлэх ёстой. Бага насны хүүхдийн асаргаанд үзүүлэх олон нийтийн дэмжлэг сул. Хүүхдээ асрах нь зөвхөн хувь хүмүүсийн үүрэг гэж үздэг.

Нийгмийн сайн сайхны төлөө бүтээгдэхүүний зохион байгуулалтад гэр бүл хоёрдугаарт тавигддаг. Тэдгээрийн хоорондын эв нэгдэл хувь хүмүүсийн хамгаалалд маш чухал үүрэг гүйцэтгэдэг. Хот суурин газрын ядуурлын нэлээд хэсэг нь гэр бүлүүд хоорондын холбоо тогтвортой бус байдгаас үүдэлтэй.

Төр нь эх орны дайны ахмад дайчид, өндөр настнууд, тахир дутуу хүмүүсийн нийгмийн хамгааллыг хариуцдаг. Хүн амын бусад эмзэг давхаргуудын нийгмийн хамгааллыг сүмүүдийн холбоод болон бусад нийтийн ашиг тусын төлөөх байгууллагууд хариуцдаг.

Европтой харьцуулахад АНУ-д нийгмийн тэгш бус байдлын томоохон зөрүүтэй байдлыг хүлээн зөвшөөрдөг бөгөөд энэ нь зах зээлд чиглэсэн системийн нэгэн чухал нөхцөл юм. Орлогын

зөрүүтэй байдал европын ихэнх орнуудтай харьцуулахад илүү их байдаг. Америкийн системийн бас нэгэн онцлогийг эрүүл мэндийн системийн жишээн дээр тайлбарлая:

АНУ-ын эрүүл мэндийн систем бол бүх ард түмний орлогод эрүүл мэндийн зардлыг харьцуулсан харьцаагаар авч үзэх юм бол хоорондоо завсартай боловч дэлхийн хамгийн өндөр өртөгтэй систем юм. Үүний гол шалтгаан бол эмчилгээ ба даатгалын өртөг асар өндөр байдагтай холбоотой. АНУ-ын эрүүл мэндийн систем нь зах зээлийн үндсэн зарчим болох чөлөөт үнэ тарифтай тул үнийн өсөлтийг барих гэсэн ямар ч оролдлого олигтой амжилтад хүрдэггүй. Төрийн дорвитой бодлого дутагдахын зэрэгцээ хэрэглэгчдийн эрх ашгийн хамгаалалт хангалтгүй байдаг. Өвчилсөн тохиолдолд үзүүлэх нийгмийн хамгаалал олон улсын түвшинд харьцуулахад маш сул. Нэг талаас боловсролын тогтолцоо нь хувийн секторын нэгэн адил хувь хүмүүсийн чадамжаас шууд шалтгаалдаг. Эрүүл мэндийн секторын удирдлага зах зээлийн эдийн засгийн үнэлэмжээр тодорхойлогддог. Үүний улмаас үүсэх сөрөг талууд жишээлбэл хар арьстан эмэгтэйчүүдийн дундаж наслалт цагаан арьстан эмэгтэйчүүдийн дундаж наслалтаас зургаан жилээр доогуур байдгаар илэрдэг. Эрэгтэйчүүдийн хувьд дундаж наслалтын дээрх зөрүү найман жил байдаг. Хөдөлмөрийн насныхны эрүүл мэндийн даатгалын талаар төрийн ямар нэгэн зааварчилга байдаггүй. Үүний улмаас дараах хоёр үр дагавар үүсдэг. **Нэгдүгээрт:** эрүүл мэндийн даатгалын хамгаалал ихэвчлэн хөдөлмөрийн харилцаатай хамааралтай байдаг. Даатгалын шимтгэлийн дийлэнх хэсгийг ажил олгогчид төлдөг. Үүний улмаас даатгуулагчдын хэрэглэгчийн бие даасан байдал маш хязгаарлагдмал байдаг. **Хоёрдугаарт:** ажлаас халагдсан, ажлаас халагдах мэдэгдэл авсан ажилтнууд ажлын байраа алдахын зэрэгцээ мөн даатгалын хамгааллаа алддаг. Хүн амынх нь ойролцоогоор 15% нь эрүүл мэндийн даатгалд огт хамрагддаггүй.

Боловсролын систем

Зарим зохиогчид боловсролын бодлогод Америкийн нийгмийн бодлогын цөм нь оршдог гэж үздэг. Боловсролын бодлогын төрийн зохицуулалт бараг боломжгүй зүйл бөгөөд Европтой харьцуулахад боловсрол олж авах боломжийн тэгш байдлыг тогтвортой хангах асуудал ярих бололцоотой. Энэ нь тус улсын либертар, улс төрийн болон нийгмийн тэгш байдлыг хангах туйлын зорилготой хамааралтай бөгөөд боловсролын тогтолцоо нь гарааны боломжийн тэгш байдлыг хангахад анхаарах ёстой. АНУ-ын боловсролын салбарын үсрэнгүй хөгжил нь Америкийн нийгэмд нийгмийн гарлын хувьд харилцан адилгүй өргөн хүрээтэй дундаж давхарга бүрэлдэн тогтоход чухал хувь нэмрээ оруулсан байна.

АНУ-д Германы нэгэн адил боловсролын салбарт төрийн монополь байдаггүй. Боловсролын тогтолцоог нь сүмүүд үндэслэн байгуулсан бөгөөд хожим орон нутгийн засаг захиргаанууд хариуцах болсон байна. Холбооны оролцоогүйгээр муж улсууд болон орон нутгийн түвшинд Их сургуулиуд, ерөнхий боловсролын сургуулиуд байгуулагдсан. Сүмүүд ба хувийн боловсролын байгууллагуудын боловсролын тогтолцоонд оролцох оролцоо үүний улмаас өндөр байдаг.

АНУ-д боловсролын үнэмлэх олгох тогтолцоонд төрийн зохицуулалт үгүй тул боловсролын үнэмлэх ажил мэргэжлийн гараагаа эхлэхэд Европтой харьцуулахад төдийлөн чухал үүрэг гүйцэтгэдэггүй. Үүний улмаас АНУ-ын хөдөлмөр эрхлэлтийн систем Европтой харьцуулахад нэлээд нээлттэй. Мөн Германтай адил мэргэжлийн сургалтын дуал систем байдаггүй. Практик ажилд суралцахыг хүсэгчид **«training on the job»** буюу ажлын байран дээр суралцахаас өөр аргагүй.

АНУ-д төгсөгчдийн нийгмийн байр суурь дээшлэхэд сургалтын байгууллагуудын нэр хүнд чухал нөлөөтэй байдаг. Олон

нийтийн бус салбарын ерөнхий боловсролын сургуульд суралцахад ихээхэн хэмжээний мөнгө шаардагддаг. Хувийн идэвх санаачилга, тэтгэлэг олгох олон талт арга хэмжээнүүд авч хэрэгжүүлдэг боловч бага орлоготой гэр бүлээс гаралтай хүүхдүүдийн элсэлтэд санхүүгийн ихээхэн бэрхшээл учирдаг.

Капитализмын хэв шинж

АНУ нь либерал зах зээлийн сонгодог жишээ юм. Либерал зах зээлийг улс ардын аж ахуйн бүтээмжийн чадамж талаас нь авч үзвэл зохицуулалттай зах зээлээс дутахгүй бөгөөд уг бүтээмжид хүрэх арга хэлбэр нь өөр юм. Зохицуулалттай зах зээлийн компаниудын «зах зээлийн гольдролоор» бус зохицуулалт буюу хамтын ажиллагаа, стратегийн харилцан оролцоогоор зохицуулдаг зохицуулалтын асуудлуудыг шийдвэрлэхийн тулд либерал зах зээлийн компаниуд зах зээлийн харилцаанаас илүү хамааралтай байдаг.

Америкийн компаниудын хүчин чармайлтын бүхий л салбарт өрсөлдөх чадвартай зах зээлүүд маш бат бэх тул «зах зээлийн гольдролоор» бус компаниудын зохицуулалтын хэлбэрүүдийг дэмжигч байгууллагуудын дэмжлэг бага гэдгийг харуулж байна.

Санхүүгийн систем

АНУ-д компаниудын санхүүжилт ихэвчлэн хөрөнгийн зах зээлээр дамжин хийгддэг. Хөрөнгө босгоход ил тод байдал сайтай, голлон тоглогчдын маш олон төрлийн бүлгүүдээс бүрддэг Америкийн хүчирхэг хувьцааны зах зээл голлох үүрэгтэй. Компаниуд хоорондын харилцан холбоос сул. Аль ч компани, банкнуудын хяналтын зөвлөлд гаднын компаниудын төлөөлөл байдаггүй. Хувьцаа эзэмшигчдийн аль болох өндөр ногдол ашиг авах сонирхол компаниудын стратегийг тодорхойлдог. Гаднын капиталд нэвтрэн орох боломж тухайн компанийн хувьцааны зах зээл дээрх үнэлгээ, ашгийн болон зах зээлийн үнэлгээний талаарх нийтэд нээлттэй мэдээллээс

голлон хамаардаг. Компаниудын нэгдэл, компаниудыг худалдан авахад хуулийн хязгаарлалт сул. «Дайснаа худалдан авах» замаар буулгаж авах боломжтой.

Аж үйлдвэрийн харилцаа

АНУ-д зохицуулалттай зах зээлтэй харьцуулахад үйлдвэрчин, ажил олгогчдын холбоод харьцангуй сул. Ажлаас халагдахаас хамгаалах хуулийн хамгаалалт сул. Хөдөлмөрийн харилцаа нь түр хугацааны хөдөлмөр эрхлэлтээр тодорхойлогддог. Цалин хөлсний хэлэлцээрүүд зөвхөн компанийн түвшинд хийгддэг. Компанийн ажилтнуудын зөвлөлийг хэрхэн байгуулах тухай эрх зүйн ямар нэгэн заалт байхгүй. хөдөлмөрийн зах зээл нь бүхэлдээ маш уян хатан.

Менежментийн тэргүүлэх түвшин компаниудад хязгааргүй хяналтыг хэрэгжүүлдэг. Эдийн засгийн байдлаас шалтгаалан ажиллах хүчнийг маш богино хугацааны дотор ажилд авч, мөн халах боломжтой. Үүний үр дүнд компаниуд зах зээлийн хөгжилд маш уян хатан дасан зохицох чадвартай. нөгөөтээгүүр зах зээлийн өөрчлөлтөд дасан зохицох дарамт маш өндөр.

Хөдөлмөрийн зах зээлийн маш уян хатан байдалд мэргэжлийн боловсролын болон мэргэжил дээшлүүлэх системүүд нь зохицсон байдаг. Мэргэжлийн боловсрол - мэргэжил дээшлүүлэх сургалтуудыг формаль сургалтуудаар ерөнхий мэдлэг, ур чадвар олгох сургалтуудыг ихэвчлэн боловсролын байгууллагууд явуулдаг. Учир нь компаниуд тэдний бэлтгэсэн ажилтнуудыг өөр компаниуд урвуулан авахгүй гэдэгт итгэлтэй бус байдаг тул ажилтнуудынхаа боловсрол, аж үйлдвэрийн салбарын онцлог ур чадварыг олгоход хөрөнгө оруулалт хийх сонирхолгүй байдаг. Эдгээр компаниуд нь боловсролд хөрөнгө оруулалт хийхгүйгээр бусдын боловсролд зарцуулсан хүчин чармайлт, хөрөнгө оруулалтаас завших сонирхолтой компаниуд юм. Ажилтнуудын түр хугацаагаар ажил хийх

болзлыг хүлээн авах, уян хатан хөдөлмөрийн зах зээл дээр хөдөлгөөнтэй байх сонирхол байгаа цагт аж үйлдвэрийн онцлогт тохирсон ур чадварыг эзэмшүүлэхэд хөрөнгө оруулах сонирхол байхгүй байх нь тодорхой юм. Ажилтнуудын ажил мэргэжлийн замнал аль ч салбарт ажиллах боломжтой ерөнхий ур чадвараас хамаардаг. Боловсролын болон мэргэжил дээшлүүлэх сургалтын хөтөлбөрүүд тэр ч байтугай үйлдвэрлэлийн эдийн засаг, инженерийн шинжлэх ухааны ерөнхий ур чадварыг олгоход нарийн мэргэжил олгохоос илүү анхаарч байна.

Ерөнхий боловсролын өндөр түвшинд хүрэхэд нэмэлт сургалтын өртөг мэдээж саад учруулж байна. Иймээс АНУ-ын компаниуд сургалтад хөрөнгө оруулалт хийдэг ч зохицуулалттай зах зээлийн эдийн засагтай орнуудтай харьцуулахад бага юм. Компаниуд «эрэлт хэрэгцээ» өндөртэй мэргэжлүүдийг сонгон суралцахыг ажилтнуудад санал болгож байдаг. Үүний үр дүн бол ерөнхий мэдлэгийг сайтар эзэмшсэн, ажлын байр олноороо буй болж байгаа үйлчилгээний салбарт ажиллахад илүү тохиромжтой ажилтнуудын нөөц бүрдэж байна. Гэхдээ өнөөг хүртэл ажилтнуудын энэхүү нөөц компаниудад тэдний онцлог шаардлагад нийцсэн тодорхой хэмжээгээр мэргэшсэн ажиллах хүчнийг нийлүүлсэн хэвээр байна.

Компаниуд хоорондын харилцаа

Либерал зах зээлийн эдийн засагт компаниуд хоорондын харилцаа зах зээлийн харилцаа, заргалдах боломж бүхий формаль гэрээнүүд дээр суурилдаг. АНУ-д кастем систем болон монополийг хориглох хуулийн зохицуулалтуудаар үнэ тогтоох тохиролцоог хийдэг. Бусад компаниудтай гэрээний үндсэн дээр харилцаа тогтоох сонирхолтой компаниуд Америкийн эрх зүйн системээс бага дэмжлэг хүлээдэг.

АНУ-д эрдэмтэд, инженерүүд нэг компаниас нөгөө компани

уруу шилжих замаар техникийн шинэ ололтыг нэвтрүүлдэг. эсвэл судалгааны институтээс хувийн сектор луу шилжих замаар Хөдөлмөрийн зах зээл нь уян хатан тул дээрх шилжилт хөдөлгөөнийг дэмжиж байдаг. Эрдэм шинжилгээний ажилтнууд техникийн шинэ ололтуудыг практикт нэвтрүүлж байдаг. Технологийн дэвшлийг АНУ-ынх шиг либерал зах зээлийн эдийн засаг лиценз олгох, техникийн дэвшил, шинэ санааг бусдад худалдах замаар нэвтрүүлэхээс өөр аргагүй болдог.

Техникийн дэвшлийг ашиглах тал дээр судалгааны байгууллагуудын холбоод, компаниудын хоорондын хамтын ажиллагаа нь либерал зах зээлийн эдийн засагт зохицуулалттай зах зээлтэй харьцуулахад төдийлөн чухал бус үүргийг гүйцэтгэдэг. «**National Cooperative Research Act**»-ыг батлагдсанаас хойш бусад компаниудтай нягт хамтран ажилладаг компаниудын үйл ажиллагаа дэмжигдэх нь байтугай аюулд өртөх магадлалтай болсон байна. Тэднийг кастений хориглолтын хуулийг зөрчиж байна гэж гомдол гаргах магадлал нэмэгдсэн байна.

Улс төрийн соёл ба иргэний нийгэм

АНУ -д Америкийн үндэсний тусгаар тогтнолын тунхаглал, үндсэн хуулиар нь баталгаажсан хувь хүний эрх чөлөөг хүндэтгэн үзэх соёлын уламжлал бүрэлдэн тогтсон байдаг. Үүний улмаас Америкийн соёл маш өндөр хэмжээнд хувь хүмүүсийн аминч үзэл, бие даасан байдал ба өрсөлдөөний бахархлаар дүүрэн байдаг. Өөртөө туслах зарчим, хувь хүмүүсийн сайн үйлсийн төлөөх үйл ажиллагаа, шударга ёсны зарчим нь хэн чадаж байна, тэр хүн сайхан амьдрах ёстой гэдэг үзэл дээр суурилдаг зэрэг хандлагууд нь уг соёлын илэрхийлэл юм. АНУ-ын дийлэнх иргэд нийгмийн тэгш бус байдлын асар зөрүүтэй байдал бол хүмүүний хамтын амьдралын байх ёстой хэлбэр хэмээн хүлээн зөвшөөрсөн хандлагатай байдаг. Дээрх хандлага зан заншлыг ягштал баримтлах хувь төөргийг бурхан зурдаг гэдэг сургаал дээр суурилдаг бөгөөд нийгмийн дарвинизмд шашны

сургаалыг амьдралд хэвшил болгох явцад байр сууриа олсон байдаг. Ийм ч учраас хувь хүний амжилтыг хувь төөрөг сайтай буюу бурхнаас заяасан үүргээ олж гүйцэтгэж буйн улмаас гэж үздэг. Алдаж эндсэн бол төөрөг тавилан муутайн улмаас гэж үздэг. Энэ бүхний үндсэн дээр нийгэм улс төрийн хөндлөнгийн оролцоог сайшааж үздэггүй, түүний эсрэг байр суурьтай байдаг.

Европын дийлэнх улс орнуудтай харьцуулахад АНУ-д нийгмийн сайн сайхны төлөө бүтээгдэхүүнүүдийн ихээхэн хэсэг нь нийтийн тусын тулд үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагууд болон сүмүүдэд үйлдвэрлэгддэг. Мөн нийтийн сайн сайхны төлөө үйл ажиллагаа явуулдаг хувь хүмүүсийн үйл ажиллагааны олон хэлбэр байдаг.

Гэхдээ Тоскүевилли зэрэг ажиглагчдыг бишрүүлж байсан Америкийн нийгэмлэгүүдийн нягт хамтын ажиллагаа 20-р зууны гуравдугаар хагаст үндсээрээ өөрчлөгдсөн байна. Өдгөө олон холбоодын гишүүдийн тоо эрс цөөрч, гишүүд нь хэт насжих зэрэг бэрхшээлүүдээс гарахын тулд тэмцэж байна. Америкийн нийгэм, улс төрд «**General Federation of Womans Clubs**» буюу «Эмэгтэйчүүдийн клубүүдийн төв холбоо», чөлөөт хэрэмчид, ахмад дайчдын холбоо зэрэг холбоодын эзлэх орон зай хумигдаж өндөр мэргэшсэн удирдлага бүхий сонирхлын жижиг бүлгүүд идэвхтэй үйл ажиллагаа явуулах болсон байна. Эдгээр бүлгүүд байгаль орчны хамгааллаас авахуулаад ядуу гэр бүлүүдэд амьдарч буй хүүхдүүдийн нийгмийн халамж, томоохон хандивлагчдын улс төрд үзүүлэх нөлөөг багасгах, төрөөс олон нийтийн өмчийг захиран зарцуулалт дээр тавих шаардлагуудыг багасгах тухай зэрэг хууль тогтоолт, олон нийтийн санаа бодолд нөлөөлөх оролдлогуудыг хийдэг. 1970-аад оноос хойш «Олон нийтийн сонирхлын бүлгүүд» буюу «Public Interest Groups» маш олноороо үүсэн байгуулагдсан бөгөөд уг бүлгүүд маш хүчтэй либерал шинж чанартай.

7.8 Загваруудын харьцуулалт

А Улс төрийн систем

Хүснэгт 1: Улс төрийн системүүдийн харьцуулалт

Орнууд	Засгийн газрын систем	Намуудын систем	Сонгуулийн эрх	Хүчний Хувиарлалт
Герман	Парламентын Засгийн газартай	-Намуудын өрсөлдөөн голлох үүрэгтэй. -Намууд: Германы Социалдемократ Нам – ГСДН Христосын ардчилсан Холбоо-ХАХ Холбоо 90/Ногоонтон Ардчилсан Социализмын Нам-АСН, Чөлөөт Ардчилсан Нам, ЧАН, Христосын Нийгмийн Ардчилсан Холбоо – ХНАХ	-Тодорхой босго бүхий пропорциональ системтэй, Намууд нийт саналын хамгийн багаар болоход 5% -ийг авсан тохиолдолд парламентад суудал авах эрхтэй.	-Холбооны улсын бүтэцтэй, Холбоо ба Холбооны улсууд төрийн эрх мэдлийг хуваан эзэллэг. -Парламентаас батлагдан гарсан хууль Холбооны үндсэн хуулийн шүүх хяналт тавих эрхтэй.
Их Британи	Парламентын засгийн газартай	Үнэн хэрэг дээрээ хоёр намын системтэй -Хоёр том намууд бол: "Conservative Party" консерватив нам, "Labour Party" "Хөдөлмөрийн нам"	Энгийн мажоритори системтэй, сонгуулийн нэг тойрогтой	Засгийн газрын эрх мэдлийг тодорхой байгууллагуудаар хязгаарладаггүй, харин намуудын өрсөлдөөнөөр ардчилсан зарчмаар хяналт тавьж хууль ёсны болгодог.

Япон	Парламентын Засгийн газартай	- Намуудын дотоод задрал чухал үүрэгтэй. - Намуудын систем нь 1993 оныг хүртэл Либерал Ардчилсан Намын олонхиор тодорхойлогдож байсан. - Сөрөг хүчин маш их задарсан, харьяалангүй сул	- 1994 он хүртэл, олон хүнтэй тойрогт мажоритари системээр явагдсан. - Сонгуулийн систем нь жижиг намуудад парламентын доод танхимд орох боломжийг олгодог. - 1994 онд батлагдсан сонгуулийн эрхийн хэлбэр нь намуудын дотоод нэгдэл, засгийн газрын системийг бэхжүүлэх зорилготой. Энэ нь пропорциональ болон мажоритари системүүдийн холимог систем бөгөөд доод танхимын сонгуулийг уг системээр явуулдаг. - Түүнчлэн эрх мэдлийн төвлөрлийг хязгаарлах зорилготой. Босго нь 3%.	Парламентын хоёр танхимтай, хүчний хувиарлалтын систем - Доод танхим 511 гишүүдтэй. Дээд танхим нь 252 гишүүдтэй. - Хүчний хувиарлалтыг юуны өмнө хоёр парламентын сонгууль өөр өөр хугацаанд явагддагаар хангагддаг.
Голланд	Парламентын хаант засаглалтай.	- Намуудын систем нь баганачлал дээр тогтдог. - Нийтдээ баганачлалын 5 нам байдаг. 1960 онд намуудын систем шахалтанд орж шүүмжлэлд өртсөн. - Д 66 нэртэй нам байгуулагдсан. Улс төрийн намуудын өмнө хөтөлбөр, программчлалын шинэ стратеги боловсруулах шаардлага тулгарсан. - Намуудын хоорондын шашин шүтлэгийн зааглалт баганачлалын үнлэс болж байсан ач холбогдлоо бүрэн гээсэн. - Улс төрийн намуудад олгодог айсан төсвийн санхүүжилт үндсэндээ зогссон.	- Цэвэр пропорциональ системтэй. - Босго хувь байхгүй. - Намууд нэр дэвшигчдийн жагсаалтан дээр нэр дэвшигчдээ жагсааж сонгогчид зөвхөн нэг нэр дэвшигчийн төлөө саналаа өгдөг. - Улс орон бүхэлдээ сонгуулийн нэг тойрог гэж үздэг. Харин засаг захиргааны хувьд тус улсыг танхимын 19 сонгуулийн тойрогт хуваагддаг. - 12 жил тутамд нэг удаа мужуудын парламентын сонгууль явагддаг.	- Парламентын хоёр танхимтай. Эхний буруу дээд танхим нь 75, хоёрдугаар буруу доод танхим нь 150 гишүүнтэй.

Швед	Парламентын засгийн газартай. Парламентын хаант засаглалтай.	-Намуудын систем нь тогтвортой, тасралтгүй хөгжиж ирсэн. -1921-1980 оны хооронд Барууны ертөнцөд улс төрийн намуудын хамгийн тогтвортой системд тооцогддог. -Нийтдээ улс төрийн 5 намтай. -Социалдемократ Ажилчны Нам нь тэргүүлэх рольтой байдаг. -1988 онд Тодорхой асуудлуудын хүрээнд улс төрийн намууд нь тодорхой блокт хуваагдсан.	-29 сонгуулийн тойрогтой. -Сонгуулийн тойрог тус бүр дундажаар 10 мандаттай. -Райхстаг буюу парламент нь нийтдээ 349 суудалтай. Үүний 310 нь хатуу суудал, 39 нь тэнцэтгэх суудал юм. -Сонгуулийн мөчлөг нь 4 жил тутамд -4-ийн босготой. -Суудлуудыг Сэйт-Лагүегийн системээр хувиарладаг. -Бүх ард түмний зөвшилцөх шийдвэр гардаг.	- 1970 он: Райхстаг нь хоёр танхим бүхий системээс нэг танхимт системд шилжсэн. -Засгийн газарт тавих хяналт нь парламентын өмнө яамдууд нь хариуцлага хүлээх зарчмаар хэрэгжлэг. -Захиргааны үйл ажиллагааг аль болох хараат бус байлгах бодлого баримталаг.
АНУ	Ерөнхийлөгчийн засгийн газартай.	-Намуудын өрсөлдөөн нь төдийлөн чухал үүрэггүй. -Намууд нь улс төрийн удирдлага болон сонирхлуудыг зохихон байгуулагч байгууллагуудын хувьд мөн төдийлөн чухал бус байгууллагууд -Улс төрийн намууд нь мөрийн хөтөлбөрийн хувьд төдийлөн хоорондоо ялгардаггүй. -Улс төрийн намууд нь конгресст хаагдмал фракцуудын хэлбэрээр үйл ажиллагаа явуулдаггүй.	-Мажорити системтэй.	-Тус улсын систем нь Монтескүеий, Жон Локе нарын хүчний хувиарлалтын онол дээр суурилдаг. Хүчний хувиарлалт ба давхцал нь үндсэн зарчмууд нь юм. -Босоо тэнхлэгийн хүчний хувиарлалт нь холбооны улсын бүтцийн хэлбэрээр оршдог.

Эх сурвалж: Лээнер, Франц\Виндмайер, Ульрих нарын Засгийн газрын тухай онолуудын харьцуулалт 2002 он, 4-дэх сайжруулсан хэвлэлт, Опладен: леске, Будрих, Исмайер, Вольфганг Баруун Европын улс төрийн системүүд 2003 он, 3-дагч хэвлэлт,

Б Үндсэн эрхүүдийн систем

Хүснэгт 2: Хүмүүсийн зовлон зүдүүр ба орлогын ядуурал

Орнууд	Дэс дараалал ядуурлын индексийн дагуу судалгаанд хамрагдсан 17 орныг байрлуулсан.	Ядуурлын индекс хувиар %	Төрөлтийн үед 60 нас наслахгүй байх магашлал Судалгаанд хамрагдсан оронд эзлэх хувь 2000-05 он	Нийт хүн амд эзлэх хувь процентаар 16-65 нас, үүргийн бичиг үсэг тайлагддаггүйн зовлон эдэлж буй хүмүүс	Удаан хугацааны ажилгүйдэлд өртөгсөд, хөдөлмөрийн насны нийт хүн амд эзлэх хувь 2001 оны байдалгаар	Ядуурлын доод түвшингээс доогуур түвшинд амьдрагсдын нийт хүн амд эзлэх хувь эзлэх хувь ядуурлын доод түвшинд дундаж орлогын 50%-иас доош орлоготой хүмүүс багтана. 1990-2000 он
Герман	6 -р байр	10.2	9.2	14.4	4.2	7.5
Англи	15 -р байр	14.8	8.9	21.8	1.3	12.5
Япон	10 -р байр	11.1	7.5	...	1.4	11.8
Голланд	4 -р байр	8.4	8.7	10.5	1.6	8.1
Швед	1 -р байр	6.5	7.3	7.5	1.1	6.6
АНУ	17 -р байр	15.8	12.6	20.7	0.3	12.5

Үүргийн бичиг үсэггүй гэдэг ойлголт нь өдөр тутмын ердийн текст ойлгох чадваргүй гэсэн үг юм.

Эх сурвалж: http://www.undp.org/hdr2003/indicator/pdf/hdr03_table_4.pdf (Download 2004 оны 07-р сарын 22-ны байдлаар)

Жич: Ядуурлын индекс нь дөрвөн салбарыг хэмжих индекс юм. эрүүл саруул, урт удаан амьдрал, Мэдлэг/боловсролын түвшин, зохистой амьдралын түвшин, нийгмээс тусгаарлах. Ядуурлын индексийн англи нэр томъёо нь: human poverty index

Хүснэгт 3: Дундаж наслалт

Орон	Дундаж наслалт
Герман	78
Их Британи	78
Япон	81
Голланд	78
Швед	80
АНУ	77

Эх сурвалж: Freedom House 2003

В Нийгмийн баримжаат төр

Хүснэгт 4: Судалгаанд хамрагдсан нийгмийн баримжаат төрийн хэв шинжүүд

Орон	Хэв шинж	Санхүүжилт	Хамгаалалтын зорилтууд
Герман	-Эспринг - Андерсоны судалгаагаар Германы нийгмийн баримжаат төр нь консерватив-нэгдсэн дэглэмийн үндсэн хэлбэр юм. -Төрийн идэвхтэй оролцооны хэлбэртэй. -Даатгал нь хөдөлмөр эрхлэлттэй нягт олбоотой. -Гэр бүл нь хамгааллын болон даатгалын байгууллагуудад голлох үүрэг гүйцэтгэдэг. -Даатгал, статус хоорондоо нягт холбоотой. Шилжилтийн буюу даатгалаас олгох мөнгөн тэтгэлэгийн хэмжээ нь өмнө нь авч байсан орлогын хэмжээнээс шууд хамаардаг. -Төрийн албан хаагчид нь тусгай хангамж эдэлдэг. -Нийгмийн эрхүүд нь иргэдийн статусаас бус харин хөдөлмөр эрхлэлтийн статусаас хамаардаг.	- Ажилгүйдэл, өвчлөл, тэтгэвэр, асрамж, жирэмсэн эхийн даатгалууд нь ажилтнууд болон ажил олгогчдын төлөх шимтгэлээс санхүүждэг. - Тэтгэврийн болон жирэмсэн эхийн хамгааллын даатгалуудад улсын төсвөөс татаас олгодог. - Үйлдвэрлэлийн ослын даатгал зуун хувь ажил олгогчдын төлөх шимтгэлээс санхүүждэг. - Нийгмийн халамжийг төсвөөс санхүүжүүлдэг.	Хүн амын дийлэнх хэсгийн өнөөгийн амьдралын түвшинг баталгаажуулах

Япон	-Нийгмийн үйлчилгээний коэффициент доогуур, гэхдээ нийгмийн зарлага өндөр -Бүх иргэд хөдөлмөр эрхлэх эрх ба үүрэгтэй. Үндсэн хуулийн 27-р зүйл -Нийтийн сайн сайхны төлөө бүтээгдэхүүн үйлдвэрлэлд гэр болон төр голлох үүрэгтэй. Эрүүл мэндийн даатгал: хүн амын түгээмэл хамгаалал -Хувийн болон олон нийтийн ажил олгогчдын сайн дурын хувь нэмэр нийгмийн үйлчилгээнд чухал ач холбогдолтой. -Хөдөлмөрийн зах зээл ба хөдөлмөр эрхлэлтэд нийгмийн даатгалыг санхүүжүүлэхийн тулд хөдөлмөр эрхлэлтийн коэффициентийг нэмэгдүүлэх бодлого баримталдаг.	-Тэтгэвэр, эрүүл мэнд, асрамж, гэнэтийн осол, ажилгүйдлийн даатгалууд ажилтнууд, ажил олгогчдын шимтгэлээс санхүүждэг. -Шимтгэлийн хувь хэмжээ Германтай харьцуулахад бага. -Ажилгүйдлийн даатгалд төрөөс татаас олгодог. -Ард түмний тэтгэврийн даатгалд даатгалыг бүх иргэд хамрагдах суурь даатгал татвараас хэсэгчлэн санхүүжүүлдэг. -Эрүүл мэндийн систем: Эмчээр эмчлүүлсэн нийт зардлын 20-30%-ийг өвчтөн хувиасаа төлдөг.	Амьдралын түвшинг баталгаажуулах
Голланд	Нийтийн сайн сайхны төлөө төрийн холимог хэлбэр нэг талаас Беверижийн загварын элементүүд нөгөө талаас Висмаркийн загварын элементүүд -Үг холимог хэлбэр Европын бусад аль ч оронд байдаггүй. -Хөдөлмөр эрхлэлтийн статусын дагуу нэг талаас харьяат иргэдийн хангамж, нөгөө талаас даатгалын системийн бүрэлдэхүүн хэсгүүдтэй. -Нийгмийн баримжаат төрийн хөгжилд шашин ба сүмүүд онцгой үүрэг гүйцэтгэсэн. 1960-аад оныг хүртэл баганачлалтай байсан.	-Ердийн нийгмийн даатгал нь нас өндөр болох, ажилгүйдэл, амаржих, тахир дутуу болох эрсдэлүүдээс хамгаалдаг. Үг даатгалууд шимтгэлээс санхүүждэг. -Амьжиргааны баталгаажих доод түвшинг татвараас санхүүжүүлдэг.	-янз бүр

Швед	Нийтийн сайн сайхны төлөө социал демократ төр -Удаан хугацааны туршид орчин үеийн нийтийн сайн сайхны төлөө төрийн үлгэр жишээ загвар болсоор ирсэн. -Үндсэн хэв шинж: түгээмэл -Хэрэглээнээс хамааралтай, ялгавартай халамжийн үйлчилгээнээс аль болох татгалздаг. -Харьяат иргэдийн хангамж -Шилжилтийн мөнгөн тэтгэлэгийн хэмжээ харьцангуй өндөр.	-Ердийн даатгал гэнэтийн осол, нас өндөр болох, эцэг эх болох, өвчлөлийн үед тохиолдох эрсдэлүүдээс хамгаалдаг ажил олгогчдын төлөх шимтгэл, татвараас санхүүждэг. -Ажилгүйдлийн даатгал мөн дээрх эх үүсвэрүүдээс санхүүждэг. -Амьжиргааны баталгаажих доод түвшин зөвхөн татвараас санхүүждэг.	Амьжиргааны баталгаажих доод түвшинг хангах
АНУ	Шилжилтийн мөнгөн тусламжийн хэмжээ бага. -Төрийн нийгэм,улс төрийн оролцоог сайшаадаггүй, эсрэг хандлагатай. -Нийтийн сайн сайхны төлөө бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн зохион байгуулалтанд зах зээлийн зарчим голлох үүргийг гүйцэтгэж удаах байранд нь гэр бүл ордог. -Хүн бүр амьжиргааныхаа эх үүсвэрийг хөдөлмөр эрхлэлтээс бүрдүүлэх ёстой. -Төрийн үйлчилгээ ахмад дайчил, өндөр настнууд, тахир дутуу иргэд дээр төвлөрдөг. Нийгмийн бусад бүлгүүдийн нийгмийн үйлчилгээг сүмүүд, нийтийн сайн сайхны төлөө ашгийн бүс байгууллагууд хариуцдаг. -Ганц бие ажилгүй хүнд зарчмын хувьд ажилгүйдлийн тэтгэмж олгодоггүй. -Европтой харьцуулахад асар зөрүүтэй нийгмийн тэгш бус байдлыг хүлээн зөвшөөрдөг. -Үйлдвэрчний эвлэл нь сул	-Төрийн өндөр насны, ард үлдэгсдийн, тахир дутуугийн даатгал ажилтнууд, ажил олгогчдын шимтгэлээр санхүүждэг. -Ажилгүйдлийн даатгалыг ажил олгогчдын олгож буй нийт цалингийн хэмжээнээс хамааран тогтоодог, тодорхой зорилтын хүрээнд өөрчлөгдөж болох татвараас санхүүжүүлдэг. -Холбооны улсуудын даатгалын системүүдэд холбооноос татаас олгодог.	Амьжиргааны баталгаажих доод түвшинг хангах

Эх сурвалж: Эспринг, Андерсен, Госта 1998 Нийтийн сайн сайхны төлөө капитализмын гурван ертөнц.

Лессених, Штепан\Остнер, Иллона Нийтийн сайн сайхны төлөө төрийн улс төрийн эдийн засгийн тухай

Нийтийн сайн сайхны төлөө капитализм. Нийгмийн баримжаат төрийн хэтийн төлөвийн харьцуулсан судалгаа

Франкфурт ам Майн Нео Йорк Кампүе 19-56 хуудас.

Хүснэгт 5. Татвар болон нийгмийн даатгалын шимтгэлийн олон улсын харьцуулалт ДНБ-нд харьцуулсан хувиар, 1980 - 2000 он

Орон	1980		1990		2001	
	Татвар	Нийгмийн даатгалын шимтгэл	Татвар	НДШ	Татвар	НДШ
Герман	24.6	37.5	22.3	35.7	21.7	36.4
Их Британи	29.3	35.2	30.7	36.8	31.0	37.4
Япон	17.8	25.1	21.4	30.1	-	-
Голланд	27.0	43.6	26.9	43.0	25.6	39.9
Швед	33.8	47.5	39.0	53.6	37.3	57.2
АНУ	21.1	27.0	19.8	26.7	-	-

Эх сурвалж: Эдийн засгийн хөгжлийн хамтын ажиллагааны байгууллагын 1965-2001 оны статистик үзүүлэлтүүд:

Интернетэд дараахи хаягаар үзнэ үү: <http://www.sozialpolitik-aktuell.de/docs/2/Tabell13.pdf>

Хүснэгт 6: Олон нийтийн нийгмийн зардал ДНБ-ний хувиар (1980-1995 он)

Төсвийн нийгмийн зардал		ДНБ-нд харьцуулсан хувиар %	
Орнууд	1980	1995	1998
Герман	23.7	28.0	27.29
Их Британи	18.3	22.5	24.70
Япон	9.9	13.8	14.66
Голланд	28.5	27.8	23.90
Швед	29.8	33.0	30.98
АНУ	13.4	15.8	14.59

Эдгээр тоонуудыг интернетийн дараахи вев-сайтаас авлаа: http://www.oecd.org/statisticdata/0.2643,en_2649_34635_1_119656_1_1,00.html

Эх сурвалж: Шарф,ФритцВ.\Шмидт, ВивиенаА.2000:Нээлттэй эдийн засгийн нийгмийн халамж ба хөдөлмөр, Volume I and II.Oxford:University press

Хүснэгт 7: Төсвийн нийгмийн зарлага ДНБ-нд эзлэх хувиар 1998

Орон	Нийт	Тэтгэвэр	Тахир дуугүйн тэтгэмж	Гэр бүлийн үйлчилгээ	Гэр бүлийн мөнгөн тэтгэлэг	Ажилгүйдэл	Хөдөлмөрийн зах зээлийн өнөөгийн бодлого	Эрүүл мэнд
Герман	27,29	10,46	1,05	0,80	1,93	1,32	1,26	7,80
Англи	24,70	9,77	2,64	0,49	1,73	0,32	0,31	5,62
Япон	14,66	5,67	0,32	0,26	0,21	0,50	0,25	5,65
Голланд	23,90	6,21	2,39	0,40	0,81	2,60	1,32	5,97
Швед	30,98	7,46	2,10	1,68	1,63	1,93	1,96	6,64
АНУ	14,59	5,07	0,86	0,29	0,22	0,25	0,18	5,86

Эх сурвалж: Эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллага, Нийгмийн зардлын суурь тооцоо, Social expenditures database

Хүснэгт 8: Тэтгэвэр авагч ба тэтгэвэр

Орнууд	Нийт хүн амд эзлэх хувь	Нийт зарлагад эзлэх хувь
Герман	17	13,1
Англи	16	11,8
Япон	-	-
Голланд	14	12,9
Швед	17	11,4
АНУ	-	-

1. Нийт хүн амын дунд 65-аас дээш насныхны эзлэх хувь
 2. Эдийн засгийн хүч буюу ДНБ-д тэтгэврийн зардлын эзлэх хувь
 3. Европын статистикт эдгээр орнуудын мэдээллүүд тавигдаагүй байна.
- Эх сурвалж: Евростат, 2001 оны байдлаар

Хүснэгт 9: Үр өгөөжийн хувь

Орнууд	Үр өгөөжийн хувь	
	1980	2001
Герман	1,4	1,4
Их Британи	1,9	1,7
Япон	1,8	1,4
Голланд	1,6	1,7
Швед	1,7	1,6
АНУ	1,8	2,1

Эх сурвалж: Дэлхийн банк 2003 Дэлхийн хөгжлийн шалгуурууд, Вашингтон: 100-102

Хүснэгт 10: Жирэмсэн эхчүүдэд олгох тэтгэмжийн хэмжээ

Орнууд	Жирэмсний амралтын үргэлжлэх хугацаа	Жирэмсний тэтгэлэгийн хэмжээ
Герман	14 долоо хоног	Орлогыг 100% олгоно.
Их Британи	18 долоо хоног	Эхний 6 долоо хоногт орлогын 90% дараа нь долоо хоног тутмын 115 Евро олгоно.
Япон	14 долоо хоног	Орлогын 60%
Голланд	16 долоо хоног	Орлогын 100%
Швед	64 долоо хоног	Эхний жилд орлогын 80% дараа нь тодорхой хэмжээний мөнгөн тэтгэлэг
АНУ	12 долоо хоног	Тэтгэмж олгодоггүй.

Г. Хөдөлмөрийн зах зээл

Хүснэгт 11: Ажилгүйдлийн коэффициент Бүртгэлтэй ажилгүйчүүдийн нийт хараат хөдөлмөр эрхлэгсдийн тоонд харьцуулсан хувь хэмжээ

Орнууд	Ажилгүйдлийн		Коэффициент
	Нийт	Эрэгтэйчүүд	Эмэгтэйчүүд
Герман	8,1	7,6	8,6
Их Британи	6,0	6,7	5,1
Япон	4,8	5,0	4,5
Голланд	3,6	2,7	4,9
Швед	7,1	7,4	6,7
АНУ	4,1	3,7	4,6

1990 оны тоонууд

Эх сурвалж: Олон Улсын Хөдөлмөрийн байгууллага 2002 2001-2002 оны Хөдөлмөрийн зах зээлийн үндсэн үзүүлэлтүүд Женев:ОУХБ 262-283 хуудас

Хүснэгт 12: 2000 оны хөдөлмөр эрхлэлтийн коэффициент (employment-to-population ratio)

Орнууд	Хөдөлмөр эрхлэлтийн		коэффициент
	Нийт	Эрэгтэйчүүд	Эмэгтэйчүүд
Герман	53,7	63,6	44,5
Англи	59,7	67,4	52,3
Япон	59,5	72,7	47,1
Голланд	70,9	80,3	61,3
Швед	66,7	69,5	63,9
АНУ	62,7	70,0	56,0

1999 оны тоонууд: Эх сурвалж: 2002 оны хөдөлмөрийн зах зээлийн үндсэн үзүүлэлтүүд, ОУХБ 2002, Женев 2000

Хүснэгт 13: Үйлдвэрчний зохион байгуулалтын зэрэг

Орнууд	Зохион байгуулалтын зэрэг
Герман	28%
Их Британи	30%
Япон	22%
Голланд	28%
Швед	90%
АНУ	13%

Эх сурвалж: http://www.gesis.org/Dauerbeachtung/Sozialindikatoren/Daten/System_Sozialer_Indikatoren/keyindik/P009.pdf[26.07.2004]

Эх сурвалж: http://www.boekler.de/cps/rde/xchg/SID-3DOAB75D-91C0F2DF/hbc/hs.xsl/512_1531.html[26.04.2004]

Эрх чөлөөний байр: Freedom House 2003

Хүснэгт 14: Үйлдвэрчний эвлэлийн зохион байгуулалтын зэрэгт гарсан өөрчлөлтүүд ба тарифын хэлэлцээрүүдийн цаг үеийн хөгжил

Орнууд	Үйлдвэрчний эвлэлийн зохион байгуулалтын зэрэг			Тарифын хэлэлцээрийн систем		
	1950-1973	1974-1984	1985-1992	1950-1973	1974-1984	1985-1992
Герман	38	40	37	2,0	2,0	2,0
Их Британи	45	51	41	1,7	2,1	1,0
Япон	34	31	25	1,4	2,0	2,0
Голланд	40	36	28	3,7	3,4	2,1
Швед	71	86	95	3,7	3,7	2,9
АНУ	29	23	15	1,3	1,0	1,0

Жич: 1 -Компанийн түвшин дээрх цалингийн хэлэлцээр

2 -Аж үйлдвэрийн түвшин дээрх цалингийн хэлэлцээр

3 -Аливаа шахалтаас ангид цалингийн ерөнхий гэрээ

4 -Шахалтын дор явагдах цалингийн ерөнхий гэрээ

Хүснэгт дэх тоонууд бол тухайн цаг үеийн дундаж тоо

Эх сурвалж: Холл/Соскисе нар 2001 он

Хүснэгт 15: Бага орлоготой иргэдийн шимтгэлийн дарамт

Орнууд	НДШ-ийн дарамт
Герман	47,7
Их Британи	28,4
Япон	19,4
Голланд	38,8
Швед	49,2
АНУ	29,2

Жич: Нийгмийн даатгалын шимтгэлд ажилтнууд, ажил олгогчдын төлөх хувь

Хувь хүмүүсийн орлогын албан татвар

Эх сурвалж: Феррера, Мауризо, Роодес, Мартин 2000 он Баруун Европын бодлого

Европын улсуудын нийгмийн халамжийн өөрчлөтүүд

Volume: дугаар 2, 147-р хуудас

Хүснэгт 16: Ажилгүйдлийн коэффициент 1970 - 1998

Орнууд	1970	1973	1976	1979	1981	1984	1987	1990	1993	1996	1998
Герман	0,6	1,0	3,9	3,2	4,5	7,9	7,6	6,2	8,8	10,3	11,2
Англи	2,4	2,1	4,8	4,5	9,1	11,4	10,2	5,9	10,3	8,0	6,5
Япон	1,2	1,3	2,0	2,1	2,2	2,7	2,8	2,1	2,5	3,3	4,2
Голланд	0,9	2,2	4,1	3,6	5,8	10,6	8,0	6,0	6,5	6,6	4,1
Швед	1,5	2,5	1,6	2,1	2,5	3,1	2,1	1,6	8,2	8,1	6,5
АНУ	5,0	4,9	7,7	5,8	7,6	7,5	6,2	5,6	6,9	5,4	4,6

Эх сурвалж: Шарф, Фритц В\Шмидт, Вивиена 2000 Нээлттэй нийгэм дэх нийгмийн халамж ба хөдөлмөр, Volume I and II. Oxford: University Press, хуудас 341

Хүснэгт 17: Стандартчилагдсан ажилгүйдлийн Коэффициент
2004 оны 03 -р сар

Орнууд	2004
Герман	9,7
Их Британи	4,7
Япон	4,7
Голланд	4,7
Швед	6,4
АНУ	5,7

Эх сурвалж:

<http://www.oecd.org/dataoecd/41/13/18595359.pdf>

[Download 2004 оны 08-р сарын 01-ний байдлаар]

Хүснэгт 18: Хагас өдрийн хөдөлмөр эрхлэлт хувиар

Орнууд	1975	1985	1995
Герман	22-р байр	20-р байр	19-р байр
Англи	7-р байр	8-р байр	4-р байр
Япон	8-р байр	1-р байр	2-р байр
Швед	9-р байр	15-р байр	10-р байр
АНУ	15-р байр	19-р байр	14-р байр
ЭЗХХАБ-ын дундаж	15-р байр	16-р байр	13-р байр
Нийт	31 байр	31 байр	31 байр

Д. Боловсролын систем

Хүснэгт 19: (PISA) судалгааны дүн

Орнууд	унших	математик	Байгалийн шинжлэх ухаанууд
Герман	22-р байр	20-р байр	19-р байр
Их Британи	7-р байр	8-р байр	4-р байр
Япон	8-р байр	1-р байр	2-р байр
Швед	9-р байр	15-р байр	10-р байр
АНУ	15-р байр	19-р байр	14-р байр
ЭЗХХАБ-ын дундаж	15-р байр	16-р байр	13-р байр
Нийт	31 байр	31 байр	31 байр

Голланд улс 2000 оны PISA судалгаанд хамрагдаагүй.

Эх сурвалж: Германы PISA консерциум 2003 онд хэвлэгдэн гарсан. 2000, ХБНГУ-ын холбооны улсуудын байдлыг ялгавартайгаар авч үзэх нь Opladen: Leske + Budrich, 52-р хуудас

Хүснэгт 20: Боловсролд зарцуулсан мөнгөний улсын төсөвт эзлэх хувь хэмжээ 1992-2000 онд

Орнууд	1992-2000 онд улсын төсвөөс боловсролд зарцуулсан мөнгөний хувь хэмжээ
Герман	1
Их Британи	4
Япон	6
Голланд	10
Швед	7
АНУ	2

Хүснэгт 21: Судалгаа болон хөгжилд зарцуулсан мөнгөний хэмжээ ДНБ-нд эзлэх хувиар

Орнууд	Судалгаа болон хөгжилд зарцуулсан Мөнгөний хэмжээ ДНБ-нд эзлэх хувиар
Герман	2,51
Их Британи	1,89
Япон	3,06
Голланд	1,89
Швед	4,27
АНУ	2,74

Эх сурвалж: Globus Infografik GmbH, 59.Jg., 2004 оны 08-р сарын 02

Хүснэгт 22: Нийгмийн гарал ба сургалтын амжилтын хоорондын холбоо, Нийгмийн бүтцийн дээд ба доод дөрөвний нэгээс гаралтай 15 настай, дунд зэргийн унших чадвартай хүүхдүүдийн хоорондын ялгаа. Эцгийн эсвэл эхийн нийгмийн хамгийн өндөр статусыг сонгон авсан.

Орнууд	Нийгмийн бүтцийн дээд дөрөвний Нэгээс гаралтай хүүхдүүдийн унших чадвар	Нийгмийн бүтцийн доод дөрөвний нэгээс Гаралтай хүүхдүүдийн унших чадвар	Нийгмийн бүтцийн дээд ба доод дөрөвний нэгээс гаралтай хүүхдүүдийн Унших чадварын ялгаа
Герман	538	427	111
Их Британи	576	474	102
Япон	543	507	27
Голланд	-	-	-
Швед	556	484	72
АНУ	552	455	97

Дээрх тоонууд унших чадварыг илэрхийлж байгаа бөгөөд тоо хэчнээн их байна, унших чадвар төдийчинээ сайн гэсэн үг.

Эх сурвалж: Германы PISA консерциум 2003 он PISA 2000 ХБНГУ-ын холбооны улсуудын байдлыг ялгавартайгаар үзэх нь: Opladen: Leske + Budrich хэвлэлийн газар, 384-р хуудас

Жич: Судалгаанд хамрагдсан улсуудын унших чадварыг харуулсан. Гэхдээ өөр өөр хэмжээтэйгээр. Нийгмийн гарал ба сурлагын амжилт дээрх улсуудад дараах байдлаар хоорондоо холбоотой. Хүснэгтийн 4-р баганыг хар. Герман улс нийгмийн дээд ба доод давхаргаас гаралтай залуучуудын 111 онооны зөрүүтэй байдлаар залуучуудын унших чадварын зөрүүтэй байдлын хувьд хамгийн их зөрүүтэй орон болж байна. Хэдийгээр АНУ боловсрол эзэмших боломжийн хувьд нийгмийн байдал хамгийн ихээр нөлөөлдөг орон хэмээн байнгын шүүмжлэлд өртдөг нэлээд зөрүүтэй боловч нийгмийн гарлаас үүдэлтэй амжилтын зөрүүтэй байдал харьцангуй бага 97 байгаа юм. Япон улсад дээрх ялгаа 27 буюу хамгийн бага байна. Швед улс 72 оноогоор эхнээсээ хоёрдугаар байрт орж байгаа юм. Математик болон байгалийн шинжлэх ухааны чадварын тухай PISA судалгаа нийгмийн гарлаас үүдэлтэй ялгаа үндсэндээ ойролцоо байгааг харуулж байна.

7.9 Дүгнэлт

Сонгон авсан улс орнуудын ардчиллын загваруудын ерөнхий танилцуулга та бүхэнд толилуулж буй нийгмийн ардчиллын хөтөлбөрийн судалгааны материалуудын тодорхой хэсгүүд билээ. Уг материалууд чухал харилцан шүтэлцээнүүдийг томоохон салбаруудын жишээн дээр тодорхой харуулж байна. Дээрх харилцан хамаарлуудыг жишээ нь улс төрийн системийн бүтцийн хэлбэр, нийгмийн харилцааг бодлогоор зохицуулах боломжийн хамаарал дээр тодорхой тайлбарласан. Жишээлбэл АНУ-ын улс төрийн систем нь улс төрийн эрх мэдлийг хэрэгжүүлэхэд өргөн хүрээтэй хязгаарлалтуудыг тавьдаг тул эдийн засаг, нийгмийн салбарыг бодлогоор

зохицуулахад асар их саад тотгор учруулдаг бол Их Британи, Голланд, Швед зэрэг орнуудын парламентын ардчилалтай орнуудад эрх мэдэл бүхий хориглон тоглогчид байдаггүй тул улс төрийн эдийн засаг болон нийгмийн салбаруудад гүнзгий өөрчлөлтүүдийг хийх боломж нээлттэй байдаг.

Улс төрийн соёл болон иргэний нийгэм нь бодлогоор зохицуулах боломжуудыг ашиглах нөхцөлүүдийг тогтоож өгдөг. АНУ-ын хувиа бодсон аминч үзэл, ядууралд хувь хүн өөрөө л буруутай, ядуу байна гэдэг тэр хүнд ногдуулж буй бурхны шийтгэл гэдэг үзэл давамгайлдаг тул нийгмийн ардчиллын бодлого хэрэгжүүлэхэд таагүй нөхцөл бүрдсэн байдаг. Эв санааны нэгдэл дээр суурилсан Шведийн улс төрийн соёл, хувь хүн бүр нийгэмтэйгээ эрх ашгаараа холбоотой байдаг тул нийгмийн ардчиллын бодлого хэрэгжүүлэхэд таатай нөхцөлийг бүрдүүлдэг.

Улс орнуудын харьцуулсан судалгаа нь нийгмийн ардчилал болон либертар ардчилал нь аливаа нэгэн улс орон нэгэн цагт сонгон авсан бол хожим хойно дахин өөрчилж эсвэл халж сольж болдоггүй хатуу хөтөлбөр биш гэдгийг харуулж байна. Нийгмийн ардчилал болон либертар ардчиллын загваруудын идеал хэв шинжүүд байдаг бөгөөд улс орнууд практик бодлогоороо их бага хэмжээгээр ойртох бодлогыг хэрэгжүүлж болно. Аль хэмжээнд ойртох бэ? гэдгийг улс төрийн соёл дангаараа шийдэхгүй. Харин тухайн орны улс төрийн эдийн засгийн үндсэн асуудлуудын шийдвэрт шинэ хариултуудыг шаарддаг нийгмийн болон эдийн засгийн гүнзгий хямралуудын үед хуримтлуулсан туршлага шийдвэрлэх үүргийг гүйцэтгэх нь олонтаа. 1930-аад оны үед АНУ-д тохиолдсон хүнд үе тус улсыг макро эдийн засаг, нийгмийн хамгааллын салбаруудад нийгмийн ардчиллын хэв шинжид ойртох бодлого хэрэгжүүлэхэд хүргэсэн юм. Гэхдээ зөвхөн түүхэн тодорхой хугацаанд хэрэгжүүлсэн билээ. Шведийн туршлага нийгмийн

баримжаат төрийн хамгааллын бүтцийг зөвхөн нийгмийн халамж хэрэгтэй хүмүүсийг хамруулаад зогсохгүй дундаж давхаргынхныг хамруулан байгуулах нь нийгмийн ардчиллын төслийг удаан хугацааны туршид найдвартай дэмжих улс төрийн соёлыг бэхжүүлдэг гэдгийг харуулж байна.

Мөн улс орнуудын харьцуулсан судалгаа нь нийгмийн ардчиллын улс төрийн эдийн засгийн үйл ажиллагааны салбаруудын бүтцүүд хоорондоо нягт хамааралтай гэдгийг харуулж байна. Зохицуулалттай зах зээлийн эдийн засагтай орнууд нийгмийн хамгааллын үндсэн эрхүүд дээр суурилсан хэлбэрүүдийг сонгон авдаг бол АНУ болон бусад либерал зах зээлийн эдийн засагтай орнуудад либерал нийгмийн баримжаат төрийн хэлбэр бүрэлдэн тогтсон байна. Улс төрийн эдийн засгийн дээрх хоёр нэгж элементүүдийн хоорондоо төсөөтэй бөгөөд зарим талаараа үүргийн хувьд нэг нь нөгөөгийнхөө хэрэгжих нөхцөлийг бүрдүүлж өгдөг.

Нийгмийн ардчиллын тухай ойлголтод системүүдийн хувилбарууд -ын олон талт байдал онцгой чухал ач холбогдолтой. Нийгмийн ардчиллын норматив суурь болсон түгээмэл үндсэн эрхүүд бүх иргэдийн үндсэн эрхүүдийг баталгаажуулах улс төрийн эдийн засгийн практикийг шаарддаг. Гэхдээ практик дээр уг орон зайд тухайн улс орнууд цаг үеийн бэрхшээлүүдийг даван туулах явцдаа хуримтлуулсан туршлага болон бүтэц, түүх, эдийн засаг, соёлын онцлог нөхцөлүүдээс хамааран зохицуулалтын маш олон хэлбэрүүдийг хэрэгжүүлэх боломжууд агуулагдаж байдаг. Мөн дээрх харьцуулсан судалгаа тухайн нийгэмд нийгмийн баялгаас тэгш хувь хүртэх боломжид боловсролын систем шийдвэрлэх үүрэг гүйцэтгэдэг гэдгийг харуулж байна. Шведийн жишээ хүүхдийг аль болох бага наснаас нь сургалт хүмүүжлийн арга хэмжээнд хамруулаад нэлээд хожуу сурлагын амжилтаар нь ангилах ерөнхий боловсролын бүтэн өдрийн сургалтын

систем сурагчдын төрөлх авьяас билгийг хөгжүүлэх, нийгмийн боломжийг тэгш хуваарилахад чухал ач холбогдолтой гэдгийг бэлхнээ харуулж байна.

Номын хүснэгтүүд олон талт харьцуулсан үнэлгээ хийх боломжийг олгож байна. Жишээлбэл хүснэгтүүд АНУ-ын либерал зах зээлийн эдийн засаг ажилгүйдлийн асуудлыг харьцангуй эерэг шийдвэрлэж чаддаг ч Голландын зохицуулалттай эдийн засгийн шинэчлэлийн арга хэмжээнүүд шиг үр өгөөжтэйгөөр шийдвэрлэж чадахгүй байгааг харуулж байна. Туршлагаас харахад АНУ, Их Британийн либертар ардчилалд нийгмийн тэгш бус байдал болон ядуурал илүү байна. Боловсролын салбарт Швед улс тэргүүлэх байрыг эзэлдэг, АНУ боловсролын салбарт тэргүүлэгч орны тоонд багтахгүй ч ажилгүйдлийн асуудлыг харьцангуй сайн шийдвэрлэсэн, харин бага ангиас нь сурлагын амжилтаар нь ангилж салгадаг, зөвхөн хагас өдрийн сургалтын системээр ерөнхий боловсролыг олгодог Германы систем нийгмийн ялгаатай байдлыг дэмждэг гэдгийг харуулж байна.

Харин Японы загварын тоо ба чанарын үзүүлэлтүүдийн хооронд зөрчил ажиглагдаж байгаа тул илүү нарийвчлан судлах шаардлагатай. Энэ нь нэн түрүүнд нийгмийн хамгааллын зардлыг харилцан адилгүй аргачлалаар тооцдогтой холбоотой. Японд ажилгүйдлийн салбарт зарцуулах нийгмийн хамгааллын зардал асар доогуур үзүүлэлттэй байгаа нь үүнтэй холбоотой. Жишээлбэл асар өндөр өртөгтэй барилгын салбарт ажлын байрыг нэмэгдүүлэх хөтөлбөрүүд мөн чанартаа нийгмийн баримжаат төрийн өргөн хүрээтэй хөтөлбөрүүд боловч Японы улсын төсвөөс санхүүждэггүй тул нийгмийн зардалд тооцогддоггүй. Япон орон нэн ялангуяа нийгмийн үндсэн эрхүүдийн салбарт нийгмийн ардчиллын үндсэн шалгууруудыг сайн хангадаг боловч нийгмийг ардчилах зэрэг бусад салбарт төдийлөн сайн хангадаггүй байна.

Япон улс нийгмийн ардчилал нь зөвхөн европын соёлын хүрээнд хэрэгжих боломжтой европ мөрөөдөл биш гэдгийг баталдаг. Нийгмийн ардчиллын үндсэн хөтөлбөрүүд соёлын болон шашны онцлог уламжлалуудаас хамаардаггүй. Учир нь нийгмийн ардчиллын хөтөлбөрүүд бүхэлдээ үндсэн эрхүүдийг хэрэгжүүлэх зорилгод чиглэгддэг бөгөөд эцэстээ амьдралын боломжийг шударгаар хуваарилж түүнийг нь хувь хүн бүр өөрийнхөө соёл, шашны төсөөллийн дагуу амьдралын бодит үнэн болгодог.

АНУ-ын жишээ сайн болон сул хөгжсөн ардчиллуудын хооронд шилжилтүүд боломжтой боловч бүтцийн хязгаарлалтууд оршин байдаг, тэдгээрийн гадна талд ардчиллын мөн чанар өөрчлөгддөг гэдгийг нүднээ илхэн харуулж байна. Хэдийгээр АНУ нийгмийн хамгааллын олон хөтөлбөрүүдийг хэрэгжүүлсэн боловч уг хөтөлбөрүүдийн дутагдалтай талууд, түгээмэл нийгмийн эрхүүд дээр баттай суурилаагүй байдал, эдийн засгийн чухал салбаруудад зах зээлүүд ноёлдог зэргээс шалтгаалан либертар ардчиллын хэв шинж давамгайлах нөхцөл бүрддэг. Энэ нь ардчиллын үл хувирах мөн чанарын тухай шинэ нээлт биш бөгөөд харин эхний ээлжид Америкийн либертар ба нийгмийн ардчиллын актёруудын хүчний харьцаагаар тодорхойлогдох тухайн цаг үеийн оношлогоо юм.

Дээрх харьцуулсан судалгаа түгээмэл үндсэн эрхүүдийн хүрээнд тодорхойлогдох ардчиллын нийгмийн үндсүүдийн оновчтой зохион байгуулалт аливаа нийгмийн тулгарсан бэрхшээлүүдийг шийдвэрлэж явцад тогтсон ёс зүй, хуримтлуулсан туршлагын хүрээнд шийдэгддэг асуудал гэдгийг харуулж байна. Нийгмийн ардчиллын шаардлагууд нь түгээмэл боловч олон талт соёл, нийгэм, социал зохион байгуулалтын өргөн орон зай нээлттэй байдаг.

Бодлогын практик VIII

8.1 Нийгмийн ардчиллын бодлогын актёрууд

Нийгмийн ардчиллын нөлөө бүхий чадварлаг актёруудыг тодорхойлоход дараах гурван гарц илүү ойрхон байдаг.

Нэгдүгээрт: Ашиг сонирхлуудын дүн шинжилгээний гарц, нийгмийн ардчиллын төсөлтэй холбоотой улс төр, нийгэм, эдийн засгийн сонирхлууд уг төслийн төлөө ажиллах сонирхолтой актёруудыг төрүүлдэг.

Хоёрдугаарт: Түүхийн гарц, Өнөөг хүртэл нийгмийн ардчиллын төлөө ажиллаж ирсэн актёруудын түүхэн судалгааг хийх

Гуравдугаарт: Нийгмийн онолын гарц, нийгмийн болон улс төрийн нэгдэлд нийгмийн ардчилал чухал ач холбогдолтой учраас ардчиллын бодлого болон харьяат иргэдийн төлөө ажиллах актёруудыг төрүүлдэг.

Ашиг сонирхлын дүн шинжилгээ талаас нь авч үзвэл нэн ялангуяа үйлдвэрчний эвлэлийн ашиг сонирхлыг төлөөлөгчид ажилчин, албан хаагчдын төлөө, түүнчлэн улс төрийн намууд

ч тэдний ашиг сонирхлыг төлөөлөгчид гэж өөрсдийгөө үздэг нь харагдаж байна.

Харин түүхийн судалгааны үр дүн европын олон оронд Христосын ардчилсан намууд, нийгмийн зохион байгуулалтын томоохон төлөөлөгчид нийгмийн ардчиллын төслийг дэмжиж байсныг харуулж байна. Скандинавын орнуудад Христосын ардчилагчдаас гадна жижиг болон дундаж тариаланчдын намууд, тэдний нийгмийн холбоод, түгээмэл нийгмийн баримжаат төрийн найдвартай өмгөөлөгчид байдаг.

Нийгмийн онолын гарц нь нийгмийн дундаж давхаргынхан сонгогчид, иргэний нийгмийн идэвхтэй төлөөлөгчид нийгмийн ардчиллыг шударга нийгмийг байгуулахад оруулах хувь нэмэр, нийгэм хамт олны нэгдэлд тустай гэж үзсэн тохиолдолд дэмждэг гэдгийг харуулж байна.

Улс орнуудын харьцуулсан судалгаа нь нийгмийн ардчиллын олон төрлийн актёрууд байдаг гэдгийг харуулж байна. Уг судалгаагаар зөвхөн нийгэм, эдийн засгийн бус харин улс төрийн болон морал ба соёлын ашиг сонирхол ч нийгмийн актёруудыг нийгмийн ардчиллын төлөө хүчин зүтгэхэд нөлөөлдөг гэдгийг харуулж байна. Даяаршлын тавцан дээр үндэстэн дамнасан иргэний нийгмийн байгууллагууд, Европын Холбоо гэх мэтийн улс төрийн хамтын ажиллагааны бүс нутгийн системүүд, гуравдагч ертөнцийн олон улс орнууд нийгмийн ардчиллын актёрууд юм.

Улс үндэстнүүдийн нийгмийн, бүс нутгийн, даяаршлын зэрэг бүхий л түвшин дээр нийгмийн ардчиллын төслүүдийг хэрэгжүүлэхэд аль болох өргөн хүрээтэй актёруудын эвслүүдийг байгуулах нь чухал байна. Үүний тулд нийгмийн ардчилал бол ямар нэгэн онцгой үзэл санаа бус харин хэсэг хэсгээр нь, алхам алхмаар нь хэрэгжүүлж болох бодлогын төсөл юм гэдгийг

ойлгох нь чухал. Олон төрлийн хүсэл сонирхол, сэдлүүд нийгмийн ардчиллын төслийг хэрэгжүүлэхэд түлхэц болдог.

8.2 Бодлогоор зохицуулах ба дасан зохицох стратеги

Нийгмийн ардчиллын зорилтуудын хооронд жам ёсоор зөрчилтэй асуудлууд үүсдэг. Тухайлбал амьдралын боломжийн тэгш байдал ба эдийн засгийн динамик, эрх чөлөө ба тэгш байдал, соёлын олон талт байдал ба төрт улсын иргэдийн хамтын нийгэмлэг, нийгмийг ардчилах ба эдийн засгийн чадамж, нийгмийн баримжаат төрийн хамгаалал ба хувийн хариуцлага зэргийн хооронд жам ёсны зөрчилдөөн үүсдэг.

Нэгд дээрх учир шалтгааны улмаас болон хоёрт нийгмийн ардчиллын төслийн бодит зорилтууд ба боломжтой хэрэгслүүдийг хооронд нь ялгаж салгах шаардлагатай учраас нийгмийн ардчилал бол зөвхөн тодорхой зарчмууд дээр суурилсан прагматизм гэж ойлгох хэрэгтэй. Бодит зорилтуудыг хэрэгжүүлэхэд хэрэглэгдэх хэрэгслүүдийг хуримтлагдсан туршлага болон боломжийн илүү сайн хувилбаруудын хүрээнд үнэлж цэгнэж үзэх нь зүйтэй. Зорилтуудыг хэрэгжүүлэхэд тус дөхөм болох бүх хэрэгслүүд бол хууль ёсны хэрэгслүүд юм. Нээлттэй байдал, бусдын туршлагаас суралцахад бэлэн байх, бусдад үнэлэгдсэн хэрэгслүүд ба замуудыг өөрийн орны нөхцөлүүд дээр үнэлэн цэгнэх, хэрэв тухайн сонгон авсан хэрэгслүүд амжилтад хүргэхгүй бол өөрчлөгдсөн нөхцөл байдалд илүү амжилтад хүргэх найдлага бүхий шинэ хэрэгслүүдийг сонгон авч хэрэглэх - энэ бүхэн бол нийгмийн ардчиллын төслийн онол ба практикийн үндэс мөн.

Бодлогын актёрууд ямагт системийн бүтцийн, системийн логикийн болон актёруудын бүтцийн хязгаарлагдмал нөхцөл байдлын дунд үйл ажиллагаагаа явуулдаг. Эдийн засгийн бодлого төлөвлөлтийн эрх мэдлийн хэмжээ зарчмын хувьд

хязгаарлагдмал ч гэсэн эдийн засгийн функцийн хуулиудын үндсүүдийн талаар ойлголт сайтай байх, практик үйл ажиллагаагаа тэдгээр хуулиудын хүрээнд явуулах нь боломжийг шавхан ашиглахад таатай нөхцөлийг бүрдүүлдэг. Хэдийгээр эдийн засгийн системд тодорхой хэмжээнд бодлогоор нөлөөлөх бололцоо байдаг ч, эдийн засгийн функцийн логикт улс төрөөс ерөнхий нөхцөлүүдийг тогтоож өгөх, төрийн зүгээс зохистой түвшинд зохицуулалт хийх замаар нөлөөлөх боломжтой ч эдийн засгийн дэд системүүд шийдвэрлэх хязгаарлалтыг тогтоож байдаг. Уг хязгаарыг зөрчсөний хариуг функцийн гажуудал болон төрийн оролцооны хүсээгүй үр дагавар гарах зэргээр тэр дороо авч орхидог.

Улс орнууд системийн ерөнхий нөхцөлүүдийг бүрдүүлэхэд өөрийн хүч үл хүрэлцэх тул нийгмийн ардчиллын зорилтуудыг хэрэгжүүлэхэд олон салбаруудад дасан зохицох стратегийг хэрэгжүүлж байхад, даяаршсан дэлхийн нээлттэй эдийн засаг хэр хэмжээнд нэгдсэн системийн хатуу шинж чанартай байх бэ? гэдэг бүхэлдээ нээлттэй асуулт юм. Түүнчлэн эдийн засгийн нөхцөлүүд хэр хэмжээнд өөрийн зохицуулалтыг хийж чадах бэ? гэдэг ч тодорхой бус юм. Үндэстэн дамнасан тоглолтын өргөн уудам орон зайд өнөөгийн нийгмийн шинжлэх ухааны мэдлэгийн түвшинд өргөн хүрээтэй зөвшилцөлд хүрдэг юм гэхэд, мөнтүүнчлэн улсүндэстнүүдийн, эдийн засгийн, нийгмийн маш олон тооны актёрууд улс төрийн үйл ажиллагааны хөтөлбөрүүдээ дээрх зөвшилцөлд тохируулан өөрчилдөг юм гэхэд тэдгээрийн хэрэгжилт эцсийн бүлэгт даяаршлын бодлогыг тодорхойлогч хориглон тоглогчдын найдаж болох, удаан хугацаанд оршин тогтнох чадвартай зөвшилцөлд хүрч чадах эсэхээс шууд хамаарна. Жишээлбэл АНУ нь либертар бодлогын стратегийг тодорхойлогч хамгийн хүчирхэг актёрын хувьд нээлттэй зах зээлүүд ба улс үндэстнүүдийн улс төрийн үйл ажиллагааны чадамжийн харьцааг тодорхойлсоор байх тул даяаршлын эдийн засагт хариуцлага ногдуулах хамгийн

оновчтой санал ч маш хязгаарлагдмал хүрээнд хэрэгжих боломжтой хэвээр байх болно. Энэ тохиолдолд дэлхийн нээлттэй зах зээл «**fact of life**» буюу амьдралын өгөгдөл мэт оршин тогтносон хэвээрээ л байх болно. Гэхдээ дэлхийн нээлттэй зах зээл бол үнэн хэрэг дээрээ өөрчлөх боломжгүй зүйл огтхон ч биш.

Нийгмийн ардчиллын бодлогыг тодорхойлогчид даяаршлын бодлогын нөлөө бүхий хориглон тоглогчдыг зөвшилцөлд хүрэхийг хүлээн гар хумхин суухыг хүсэхгүй нь мэдээж тул (зарчмын хувьд зөвшилцөлд хүрэх эсэх нь ч тодорхой бус, зөвшилцөлд хүрлээ ч олон салбарт тодорхой бус байхад) өнөөгийн бэрхшээлүүдийг даван туулахын тулд хоёрдогч хувилбар буюу салаа замыг сонгон авахаас өөр аргагүй. Нэг талаас тэд зорилго нэгт хүчнүүдтэй хамтран үндэстэн дамнасан эдийн засгийн бодлого зохицуулалтын нөхцөлийг бүрдүүлэхийн төлөө хамтран ажиллаж нөгөө талаар тухайн өгөгдсөн нөхцөл байдалд тохирсон, үндэсний эсхүл даяаршлын тавцан дээр бодлогын зорилтуудыг хамгийн дээд зэргээр хэрэгжүүлэхийн тулд дасан зохицох стратегийн үнэлгээг хийж хэрэгжүүлэхийн төлөө ажиллаж байна.

Улс орнуудын туршлагаас харахад Европын нийгмийн ардчиллын «капитализмд нийгмийн хариуцлага хүлээлгэх бодлогуудыг» даяаршлын тавцан дээр хэрэгжүүлбэл алсдаа амжилтад хүргэх бодлого мэт харагдаж байна. Гэхдээ сөрөг даяаршлын өнөөгийн хүрсэн түвшнийг хадгалах, эерэг даяаршлын албадмал байдлаар нотлогдох дэвшлүүд алийг нь ч засаж залруулах боломжгүй хөгжилд хүргэх автомат динамик хэмээн тайлбарлаж болох юм. Риегер, Лайвфрид нар нэн ялангуяа АНУ-ын дотоод зах зээлээ хамгаалах гадаад худалдааны бодлого нь нийгмийн бодлогын орлогын баталгааг хангах байнгын, нэр хүндтэй, функционал тэнцэтгэлийг хангах оролдлого юм гэдгийг нотолсон.

Нийгмийн ардчиллын норматив нотолгоо бүхий шаардлагуудад нийцүүлэн даяаршилд бодлогоор хариуцлага ногдуулах боломжтой юу гэдэг асуудалд даяаршлын дээр дурдагдсан нөлөөнүүдээс ямар нөлөөнүүдийг ерөнхийд нь бодлогоор зохицуулах боломжтой бэ? эсвэл нөлөөг бүрмөсөн арилгах боломжтой юу? ингэснээр бодлогын актёруудад даяаршлын бодлогын өргөтгөсөн хүрээнд даяаршлын өмнө байсан үйл ажиллагааны нөхцөлүүдийг дахин бүрдүүлж өгөх боломжтой юу? гэдэг асуултууд шийдвэрлэх нөлөөтэй.

Best case scenarios - Хамгийн сайн найруулгыг хэрхэн хийх бэ?

Иймэрхүү эерэг даяаршлын жишээ түүхэнд байхгүй тул улс орнуудын туршлагад чиглэсэн онолд зорилтот жишиг хэмжигдэхүүн гэж ойлгох нь зүйтэй бөгөөд «хамгийн сайн найруулгыг» хийхэд тохирох ерөнхий нөхцөлүүдийг ч хийсвэрээр тооцоолох боломжтой. Зарчмын хувьд хэрэгжүүлэх боломжтой, тэдгээрийн хэрэгжилтийг дэмжих актёруудын эвсэл олдох боломжтой, тэдгээрийн нөлөөллийг дээрх актёруудын эвсэл урьдчилан тооцсон нөхцөлд даяаршлын, нийгэм эдийн засгийн зохицуулалтыг эерэгээр зохион байгуулах олноо танигдсан бүх саналууд болон даяаршлын нэгдсэн байгууллын бүтцээс уг найруулга хамаарна. Үр дүнд нь дараах бүтцүүд харагдаж байна:

Нэгдүгээрт, Санхүүгийн урсгалууд: НҮБ-д харьяалагдах даяаршлын санхүүгийн хяналтын байгууллага байгуулах боломж харагдаж байна. Түүнчлэн түр хугацааны үндэстэн дамнасан санхүүгийн урсгалд Товины татварын загвараар татвар ногдуулах боломж бий. Ингэснээр түр зуурын, богино хугацаанд их хэмжээний ашиг олох зорилго бүхий санхүүгийн урсгалыг хэмжээний хувьд бууруулж хөдөлгөөний хэмнэлийн хувьд уртасгах боломж бүрдэх юм. Богино хугацаанд өндөр ашиг олох зорилготой их хэмжээний санхүүгийн урсгалыг улс

орнуудын улс ардын аж ахуйд оруулах ба гаргах, гаргасан мөнгөө дахин эргэлтэд оруулах хөдөлгөөнийг даяаршлын санхүүгийн хяналтын байгууллагыг байгуулаад ч зогсоох боломжгүй гэдэг нь бодит үнэн юм. Эерэг даяаршлыг хамгийн шилдэг эерэг хэлбэрээр байгуулаад ч үндэсний болон бүс нутгийн актёруудад хамгийн тогтвортой үйл ажиллагааны нөхцөлүүдийг бүрдүүлээд ч санхүүгийн дээрх урсгалыг зогсоох боломжгүй.

Хоёрдугаарт, нийгмийн болон экологийн стандартуудыг мөрдөх: Дэлхий дахинд мөрдөгдөх, хяналтын дор хэрэгжих боломжтой ОУХБ-ын стандартуудыг мөрдөж Рио\Киотогийн процессыг тууштай хэрэгжүүлбэл дэлхий даяар нийгэм, экологийн тогтвортой байдал тогтож тогтвортой хөгжил баталгаажиж хүлээн зөвшөөрөгдөх боломжгүй бүс нутгийн давуу талуудыг бууруулахсан. Дэлхий дахинд хамгаалалттай секторуудад өрнөж буй өрсөлдөөний хурцадмал байдал бүрэн намжихгүй нь ойлгомжтой. Нийгмийн болон экологийн нэгдсэн стандартуудыг мөрдсөнөөр ойрын ирээдүйд харьцангуй баталгаатай хамгааллын стандартууд ба нийгмийн хамгааллын үйлчилгээ бүхий дэлхийн нэгдсэн нийгмийн баримжаат төр байгуулагдчихгүй нь мөн ойлгомжтой. Харин өдгөө байгуулагдаад байгаа нийгмийн баримжаат төрийн харилцан адилгүй түвшин нь хамрагдсан улс орнуудын эдийн засгийн бүс нутгийн давуу тал хэвээр үлдэж ингэснээр тэдний зах зээл дээр өрсөлдөх чадамж, нийгэм, эдийн засгийн хөгжлийн боломж тухайн давуу байдлаас хамаарсан хэвээр байх магадлал илүү өндөр байна. Даяаршлын өрсөлдөөний нөхцөл улам бүр хурцадмал болсоор байгаа нөхцөлд үр ашиг өндөртэй улс ардын аж ахуйнуудын хоорондын өрсөлдөөн дэлхийн эдийн засаг шударгаар зохицуулагдсан нөхцөлд ч хурцадмал хэвээрээ байх болно.

Гуравдугаарт, Өндөр бүтээмжийн салбар дахь өрсөлдөөн: Өндөр бүтээмжийн таваар болон үйлчилгээний үйлдвэрлэлийн хамгаалагдсан салбар дахь өрсөлдөөний хурцадмал байдлыг дэлхийн худалдааны журмуудыг илүү шударга болгож үндэстэн дамнасан концернуудын үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулсан нөхцөлд ч улам бүр хурцдах болно. Учир нь дээрх хэлбэрийн арга хэмжээнүүд нь зах зээлүүдийн нээлттэй байдлыг улам бүр нэмэгдүүлж бага цалин хөлстэй орнуудын зах зээл дээр гарах нөхцөлийг улам бүр хөнгөвчилж харин дэлхийн зах зээл дээрх монополиудад тавих хяналтыг сайжруулах болно.

Даяаршлын тогтвортой байдлыг хангах

Хэдийгээр нийгмийн ардчиллын хэтийн төлөв талаас нь харахад дээр дурдсан даяаршлын зохицуулалтын бүх бодлого онолын хувьд сайн нотлогдох, ардчиллын бодлогын хүрээнд хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагатай, зарчмын хувьд бодлогоор хэрэгжүүлэх боломжтой боловч тэдгээрийн хэрэгжүүлэлтийн хүрээнд гарах үр дагавруудыг нь тооцож үзэхэд нээлттэй зах зээлийн нөлөөллийн үндсэн элементүүдийн улс үндэстнүүдийн болон бүс нутгийн улс төрийн эдийн засаг болон бүс нутгийн бодлогын актёруудад үзүүлэх нөлөө багасахгүй хэвээр байх болно. Даяаршлын нээлттэй зах зээлүүдэд дахин хариуцлага ногдуулснаар даяаршилд дасан зохицох дарамтыг зарчмын хувьд үгүй болгож ингэснээр даяаршлын тавцан дээр улс үндэстнүүдийн нийгмийн түвшин дээр социал демократууд засгийн эрхэнд байсан алтан үеийнх шиг үйл ажиллагааны нөхцөлүүдийг дахин бүрдүүлэх хэтийн төлөв харагдахгүй л байна.

Нээлттэй зах зээлийн нөхцөл дэх нийгмийн ардчиллын бодлогод бодлогоор зохицуулах ба дасан зохицох стратегийн хоорондын онолын хувьд сайн нотлогдсон, бодит оновчтой харьцааг олох нь маш чухал. Улс төрийн эдийн засгийн

салбарт даяаршлын тухайн үеийн нөхцөлүүдэд зохицсон, улс орнуудын туршлагаар удаан хугацаанд үйлчлэх боломжтой шинэчлэлийн хөтөлбөрүүдийн төслүүдийг боловсруулах тэдгээрийг хэрэгжүүлэх шаардлагатай. Үүний зэрэгцээ дунд хугацаанд бодлогоор нөлөөлөх боломж бүхий даяаршсан зах зээлийн ерөнхий нөхцөлүүдийг шинэчлэн зохион байгуулахын төлөө ажиллах шаардлагатай. Дасан зохицох стратегийн хүрээнд зах зээлүүдэд даяаршлын хариуцлага ногдуулах төсөл амжилттай хэрэгжсэн тохиолдолд ч нөлөөтэй хэвээр үлдэх өөрчлөлтүүдийг эхнээс нь хийхэд анхаарах хэрэгтэй. Эдгээр шаардлагуудыг уг номын улс төрийн эдийн засаг бүлэгт дурдсан үйл ажиллагааны стратегиуд хангаж буй.

8.3 Либертар ардчилал:

Гажуудалтай ардчилал

Огт ардчилалгүй улс төрийн дэглэм болох ганцаарчлан захирах дэглэм болон эрх зүйт төрт ардчилал хоёрын хооронд шилжилтийн төрөл бүрийн хэлбэрүүд байдаг. Ардчилалд шилжих шилжилт эсхүл тэдгээрийн нуран унах хэлбэрүүд дээрх шилжилтийн үндэс болдог. Бүх нийтийн тэгш сонгуулийн эрхийг олгож ардчиллын чухал үндсүүдийн нэгийг тавьсан ч бусад талаараа ардчилсан нормуудыг огт эсхүл бүрэн бус хангасан байдаг нь гажуудалтай ардчиллын шинж юм. Гажуудалтай ардчиллын гажуудал нь бүрэн төгс ардчиллын хөгжлийн эхний үеийн илэрхийлэл байх нөхцөлд төгс ардчиллын үр үндсийг өөртөө агуулж байдаг. Дээрх гажуудлууд өмнө нь оршин байсан ардчилсан бүтцүүдийн цомхтголоос үүдэлтэй бол тухайн оршин буй ардчиллын задралын эхийг тавих боломжтой бөгөөд хэлбэр төдий ардчилсан улс төрийн системүүдэд урт хугацааны туршид шахалт үзүүлдэг.

Засгийн газрын бодлогын практикт Волфганг Меркелийн систематикийн дагуу юуны өмнө дараах цар хүрээнүүдэд ардчиллын ноцтой гажуудлууд оршдог.

Ардчиллын гажуудлууд

Нэгдүгээрт ноёлогч ангийн гарцад: Иргэдийн тодорхой бүлгүүдийг улс төрийн хүсэл зоригийг бүрдүүлэх процесс болон сонгуульд огт оролцуулахгүй байх, эсхүл тэдний оролцоонд асар их саад тотгор учруулах

Хоёрдугаарт ноёлогч ангийн шаардлага: Үндсэн эрхүүд хумигдах эсхүл хязгаарлагдах хэлбэрээр эрх зүйт төрийн улс төрийн эрх мэдлийг хэрэгжүүлэх хязгаарууд зөрчигдөх

Гуравдугаарт, Ноёлогч ангийн монополь: нийгмийн зарим нэг салбарууд ардчилсан хууль ёс ба ноёлогч ангийн мэдлээс гарах, жишээлбэл тухайн орны арми ардчилсан хяналтаас гарах гэх мэт

Дөрөвдүгээрт, Ноёлогч ангийн бүтцэд: тодорхой ашиг сонирхлууд улс төрийн хүсэл зоригийг бүрдүүлэх процессоос тусгаарлагдсан нөхцөлд ноёлогч ангийн бүтцийн гажуудал үүсдэг.

Тавдугаарт, Ноёрхлын арга хэлбэрт: Улс төрийн эрх мэдлийг хэрэгжүүлэхэд хувь хүмүүсийн эсхүл бүлгүүдийн эрхүүд зөрчигдөх

Энэ утгаар нь авч үзвэл цэвэр либертар ардчиллыг гажуудалтай ардчилал хэмээн ойлгож болно. Ингэж хэлж болох олон үндэслэл бий. Хэрэв олон нийтийн мэдээллийн хэрэгслүүд арилжааны зарчимд бүрэн шилжиж ардчилсан олон нийтийн мэдээлэл үлэмж хэмжээгээр хязгаарлагдсан нөхцөлд ноёлогч ангийн шаардлагын гажуудал үүснэ. Нийгмийн болон эдийн засгийн хүчирхэг актёрууд улс төрийн процессод хүчтэй нөлөөлж байхад иргэдийн дийлэнх нь нийгмийн болон эдийн засгийн нөөц дутагдсаны улмаас улс төрийн оролцооны боломжуудаа ашиглаж чадахгүй байгаа бол ардчилсан ноёлогч ангийн монополь зөрчигдсөн гэж үздэг.

Мөн дээрх шалтгааны улмаас улс төрийн процессод нийгэм, эдийн засгийн сонирхлоо тусгуулах тэгш эрхт боломж бүрдээгүй нөхцөлд ноёлогч ангийн бүтцийн гажуудал үүсдэг. Либертар ардчилал нь нийгэм болон эдийн засгийн байдлын хувьд сул ард иргэдийн нийгэм, эдийн засгийн нөөцийг баталгаажуулж өгөхөөс татгалздаг тул нийгмийн шударга байдлыг хангах нөхцөлүүд төдийгүй улс төрийн ардчиллын хэм хэмжээнүүдийг зөрчдөг. Эдгээр шалтгаанууд нь нийгмийн ардчилал нь либертар ардчиллын бүх иргэдийн үндсэн эрхүүдийг тэгш хангадаггүй гажуудлыг засахын тулд хэрэгжүүлэх шаардлагатай төсөл, зайлшгүй үр дагавар мөн гэдгийг харуулж байна.

Хэтийн төлөв IX

Өнөөгийн даяаршсан дэлхий дээр хоорондоо өрсөлдөгч ардчиллын хоёр өөр загвар зэрэгцэн оршиж байна: Эдгээр нь АНУ-д үлгэр жишээ байдлаар хэрэгжиж буй либертар ардчилал ба Европ тивийн олон орнуудад ойролцоогоор ижил түвшинд хэрэгжиж буй нийгмийн ардчиллын загвар юм. Либертар ардчилал зөвхөн иргэний болон улс төрийн эрхүүд дээр суурилдаг бөгөөд нийгмийн эрх чөлөөний үндсэн зарчмуудыг өөрийн гольдролоороо хөгжих зах зээл, өмчлөх хязгааргүй эрх чөлөө, гэрээний чөлөөт харилцаагаар хэмждэг. Нийгмийн ардчилал нь нийгэм, эдийн засаг, соёлын үндсэн эрхүүдийг хангах зорилтыг тавьж нийгмийн баримжаат зах зээлийг үндсэн эрхүүд дээр суурилсан нийгмийн баримжаат төртэй хослуулан бодитоор хангахыг эрмэлздэг.

Дээрх хоёр хөтөлбөрүүдийг улс орон бүрийн нийгмийн зохион байгуулалт болон дэлхийн нэгдсэн байгууллыг байгуулахад хэрэгжүүлэх боломжтой. Либертар ардчилал нь зах зээлийн даяаршлын нэгэн хэлбэр бол, нийгмийн ардчилал нь зах зээлийн даяаршлыг байгуулаад зогсохгүй даяаршсан дэлхийд ардчиллын хариуцлагыг ногдуулахын тулд улс төрийн даяаршлыг байгуулах зорилготой.

Даяаршил нь нийгмийн ардчиллын үндэс суурийг үгүй болгож буй хэрэг бус харин нийгмийн ардчилалд шинэ сорилтуудыг тулган тавьж буй учраас түүнийг хэрэгжүүлэх шаардлага улам хурцаар тавигдаж байна. Улс орнуудын туршлагуудын харьцуулсан судалгаа нь нийгмийн ардчиллын ирээдүйн хөтөлбөрүүдэд чиглүүлэгч үүргийг гүйцэтгэх дараах гурван мэдлэгийг бидэнд олгож байна:

Нэгдүгээрт: Нийгмийн баримжаат зах зээлүүд ба үндсэн эрхүүд дээр суурилсан нийгмийн баримжаат төрийн хосолсон хэлбэрүүд либерал зах зээлүүдийн нэгэн адил даяаршлын өрсөлдөөнд тэсэж үлдэх чадвартай. Даяаршил нь өрсөлдөх чадвараа хадгалан үлдэх сонирхолтой бүх улс орнуудад либертар ардчиллын загварыг заавал хэрэгжүүлэх шаардлага тавьдаг гэдэг нотолгоо үндэслэлгүй юм.

Хоёрдугаарт: Даяаршлын ардчиллыг алгуур хэрэгжүүлэх, үндэстэн дамнасан эдийн засаг ба улс төрийн харилцааг дэлхий дахинаа бодлогоор зохицуулах шаардлагатай төдийгүй энэ нь боломжтой юм.

Гуравдугаарт: Даяаршлын тавцан дээр улс төрийн шийдвэр гаргалтын болон хариуцлагын бүтцийг байгуулж чадсан нөхцөлд ч дэлхийн Өмнөд ба Хойд хэсгийн бүх улс орнууд дэлхий дахины хөдөлмөрийн шинэ хуваарилалт, өрсөлдөөний илүү хүнд нөхцөлд дасан зохицох шаардлагатай. Уг шинэ нөхцөлд бүх үндсэн эрхүүдийг хангах нийгмийн баримжаат төрийн болон эдийн засгийн нөхцөлүүдийг бүрдүүлэх нь нийгмийн ардчилалд ирээдүйд ногдож буй үүрэг юм.

Нийгмийн ардчилал нь тэгш эрх чөлөөг хангахад шаардагдах нийгэм, эдийн засаг, соёлын нөхцөлүүдийг бүрдүүлэхийг зорилгоо болгодог. Энэ бол удаан хугацаа шаардах, тухайн цаг үеийн нөөцүүд ба нөхцөлүүдээс хамааран өөр өөр арга

замаар харилцан адилгүй түвшинд биелэгдэх зорилго юм. Нийгмийн эрхүүдийн хэрэгжилт нь иргэн бүрд амьдралынхаа өмнө өөрөө хариуцлага хүлээж зөвхөн хүчин мөхөстөх тэр үед л нийгэм хамт олны зүгээс баталгаатай дэмжлэг ирнэ гэдэг ухамсар тогтсон байхыг шаарддаг. Нийгмийн хамгаалал болон оролцооны эрхүүд дээр баттай суурилаагүй, засгийн газарт дээрх эрхүүдийг хангахад чиглэсэн эдийн засаг, нийгмийн бодлого явуулах үүрэг ногдуулаагүй бол ардчилал олон иргэдийн хувьд цээж баримал шиг хагас дутуу хэвээр үлддэг. Иймээс нийгмийн ардчилал бол хүмүүсийн амьдралыг сайжруулах, тэдний үндсэн эрхүүдийн баталгааг хангах шаардлага төдийгүй ардчиллын шаардлагуудыг хангаж, ингэснээр тогтвортой ардчиллыг байгуулах нөхцөлүүдийн нэг мөн.

Фридрих - Эбертийн сангийн тухай Х

Фридрих-Эбертийн сан (ФЭС) нь 1925 онд үүсгэн байгуулагдсан, нийтийн тусын төлөө үйл ажиллагаа явуулдаг, нийгмийн ардчиллын үзэл санааг дэмжин дэлгэрүүлэгч Германы хамгийн ахмад улс төрийн сан юм. Манай сан ардчилсан сонгуулиар сонгогдсон Германы анхны ерөнхийлөгч Фридрих-Эберт агсны нэрээр нэрлэгддэг бөгөөд үүсгэн байгуулагдсан цагаасаа хойш түүний улс төрийн үйл ажиллагаандаа эрхэмлэдэг байсан Эрх чөлөө - Эв санааны нэгдэл - Шударга ёс хэмээх гурван зарчмыг бодит амьдрал дээр хэрэгжүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлж ирлээ. Манай сан энэхүү үүргээ дотоодод болон хилийн чанадад улс төрийн боловсрол, олон улсын хамтын ажиллагааг дэмжих төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх, сургалтын тэтгэлэг өгөх, дэмжлэг үзүүлэх хэлбэрээр биелүүлж байна.

Ардчилал ба хөгжлийг даян дэлхийд дэмжих, энхтайван, аюулгүй байдалд өөрийн хувь нэмрээ оруулах, даяаршлыг зохистойгоор зохион байгуулах, даяаршилд хариуцлага ногдуулах, Европын холбоог өргөжүүлэх, хөгжүүлэх нь ФЭС-гийн гадаад хамтын ажиллагааны үндсэн чиглэлүүд мөн. Дэлхий 100 гаруй улс

орнуудад хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрүүдээрээ дамжуулан ардчилал ба шударга ёсыг бэхжүүлэхэд шаардагдах төрийн болон иргэний нийгмийн бүтцүүдийг хөгжүүлэх, бэхжүүлэх, хүчирхэг, чөлөөт үйлдвэрчний эвлэлүүд, хүний эрх, хүйсийн тэгш байдлыг хангахад дэмжлэг үзүүлдэг.

1995 оноос манай сан Монгол улсад өөрийн төлөөлөгчийн газраа байгуулан ажиллаж байна. ФЭС улс төрийн шийдвэр гаргагчид, нэн ялангуяа УИХ-тай нягт хамтран ажиллаж байна. Мөн иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран ажиллаж Монгол улсын улс төр, эдийн засаг, нийгмийн шинэчлэлд хувь нэмрээ оруулж байна. Бид ажилтнуудын эрх ашгийг төлөөлөгч үйлдвэрчний эвлэлийг бэхжүүлэх, хүйсийн тэгш байдлыг хангах эмэгтэйчүүдийн оролцоог онцгойлон дэмждэг.

Зохиогчийн тухай XI

1943 Их сургуулийн доктор профессор Томас Маейр онд Лейпциг хотноо төрсөн. Дортмундын Их Сургуулийн улс төрийн шинжлэх ухааны тэнхимд ардчиллын онол, улс төрийн онол, Европын чиглэлээр багшилдаг.

Франкфурт Майнд философи, улс төрийн шинжлэх ухаан, сэтгэл зүй, германы уран зохиолын чиглэлээр Адорно, Хоркхаймер, Хавермас, Апел, Печер нарын дэргэд суралцсан.

Европын коммист Европын олон нийт, мэдээлэл солилцоо, соёл, уламжлалын Advisory Group Social and Humanities гишүүн.

Европын даяаршил, бүс нутгийн хөгжил судлал хариуцсан Европын комиссын Network of Excellence Carnet гишүүн.

1995 - 2007 онд Фридрих Эбертийн сангийн улс төрийн боловсрол академийн захирал.

Германы Социалдемократ намын үнэт зүйлсийн комиссын дэд дарга.

1964 - 2007 онд Германы Социалдемократ намын хөтөлбөрийн комиссын гишүүн, дэд редактор.

Шинэ нийгэм соёл, улс төрийн сэтгүүлийн Франкфуртын дэвтрүүдийн хамтран эрхлэгч, ерөнхий редактор.

Улс төр, улс төрийн мэдээлэл солилцоо, ардчиллын онолын чиглэлээр олон тооны нийтлэл, эрдэм шинжилгээний ажил, номуудыг бичсэн. Тэдгээр нь 15 гаруй хэлээр орчуулагдан хэвлэгдсэн.

- Фундаментализм. Орчин үеийн эсрэг босох нь 1989 он
- Социализмаас юу үлдэв ээ? 1990 он
- Соёл, уламжлалыг хадгалах хэнээрхэл 1998 он
- Улс төр гэж юу вэ? 2000 он
- Улс төрийн шилжилт 1994 он
- Identity Mania. The Political Instrumentalization of Cultural Difference. Zed. London 2000
- Хэвлэл мэдээллийн эрин. Хэвлэл мэдээлэл улс төрийг колонижилж байна. 2002 он
- Media Democracy 2004. Polity Press Cambridge
- Европын соёл, уламжлал 2004 он
- Нийгмийн ардчиллын онол 2005 он
- Нийгмийн ардчиллын практик 2006 он
- The Theory of Social Democracy. Polity Press Cambridge 2007
- Социализм гэж юу вэ? 2008 он
- Ардчилал гэж юу вэ? 2008 он

Ном зүй XII

Алберт, Матиас/Рүт/Хүррелман, Клаус (2003) Залуучууд ба улс төр. Залуучуудын 14-дэх Шелл судалгааны хүрээнд залуучуудын улс төрийн сонирхол, идэвх санаачилгыг судлах нь: Улс төр ба ца үеийн түүх, Парламент долоо хоног тутмын сонигийн хавсралт, В 15/2003: 3 - 5

Алберт Михаел (1992) Капитализм капитализмын эсрэг. Франкфурт ам Майн: Кампус хэвлэлийн газар

Алеман фон Ульрих (1989) ХБНГУ дахь зохион байгуулагдсан сонирхлууд 2 дахь хэвлэл. Опладен: Леске ба Будрих

Алеман фон Ульрих (2000) ХБНГУ -ын намуудын систем 3 дахь хэвлэл, Опладен:Леске ба Будрих

Алстон Филипп (1979) The Nations' Specialized Agencies and Implementation of the International Covenant on Economic, Social and Cultural Rights. In: Columbia journal of transnational law, 18,pp.79 - 118

Anderson, Elisabeth (1990) The Ethnical Limitations of the Market. In: Economics and Philosophy, No 6,pp. 179 - 205

Andeweg,Rudi B./Irwin Galen A. (2002) Governance and Politics of the Netherlands. Houndmills: Palgrave Macmillan.

Анхаймер, Хэльмут К./Приллер, Экхард/Сайвел,. Волфганг/Циммер, Анетта (1998): Гуравдагч сектор Германд. Төр ба зах зээлийн зохион байгуулалт нийгмийн өөрчлөлтөнд. 2 дахь хэвлэл, Берлин: edition sigma

Анхайнер, Хэльмут К./Приллер Экхард/Циммерь Анетта (1998) Гуравдагч секторын иргэний нийгмийн цар хүрээний тухай. Клингеман, Ханс - Диетер/Найдхарт, Фридхельм
Зохиогч: Ардчиллын ирээдүй: Даяаршлын эрин үеийн сорилтууд. Эдийн засгийн жилийн тойм -2000. Берлин: edition sigma

Aspring,S. (1989): 100 ar i Sverige. Vaegen till folkhemmet.Stockholm:Tiden

Atkinson,Anthony B.(1996): Income Distribution in Europe and the United States. In: Oxford Review of Economic Policy,12,pp.15 - 28

Barber, Benjamin R.(1995): Jihad vs.McWorld.New York: Random House.

Баратта фон Марио (2002) .Франкфурт ам Майн: Фишерын халаасны ном хэвлэлийн газар, 31 - 49-р хуудас

Ватке, Густав - Вилхельм/Шрайвер, "охан/Зоммер, Диетер (2000): Германы хэлэн сурагчдын нийгмийн гарал - 90-ээд оны хөгжлийн хандлага. Дээд сургуулийн мэдээллийн системийн товч мэдээлэл, A9|2000.

Вланке, Вернхард (1998) Социалдемократ шинэчлэлийн бодлого "идэвхжүүлэгч төрд". Вукмиллер, Михаел Зохиогч: Ардчиллын хөдөлгөгч хүч 492 - 509-р хуудас

Век. Ульрих (1986): Эрсдэлт нийгэм. Өөр орчин үед шилжих замдаа. Фракфурт ам Майн.: edition suhrkamp

Век, Ульрих 1997: Эрх чөлөөний хүүхдүүд. Франкфурт ам Майн.: edition suhrkamp

Век, Ульрих 1998 Даяаршлын бодлого. Франкфурт ам Майн.: edition suhrkamp

Век, Ульрих 2002 Эрх мэдэл ба сөрөг эрх мэдэл даяаршлын эрин үед. Дэлхий шинэ улс төрийн эдийн засаг. Франкфурт ам Майн.: edition suhrkamp

Benner, Mats/Vad, Torben B.P.(2000): Sweden and Denmark: Defending the Welfare State. In: Scharpf,Fritz/Schmidt,Vivien A (Hrg): Welfare and Work in the Open Economy.Volume II, S.399 - 466

Венз, Артур/Шарф, Фритц В/Цинтл, Райнхард (1992): Босоо тэнхлэг дээрх улс төрийн сүлжээ. Хэлэлцээрийн системийн онолын талаар.: Франкфурт ам Майн.: Кампус хэвлэлийн газар

Вергер "оханнес (2001): Эдийн засгийн систем, Шерферс, Вернхард/Заф, Вольганг зохиогч: Германы нийгмийн гарын толь бичиг. Опладен: Леске ба Будрих 738 - 750-р хуудас

Вернштайн, Эдуард (1910): Ажилчны хөдөлгөөн. Франкфурт ам Майн.: Утга зохиолын газар, Рүйттен ба Лоенинг

Веяаме фон Клаус (1996): Германы улс төрийн систем. Оршил. Мюнхен/Цүйрих: Пипер.

Briggs,Asa (1961): The welfare state in historical perspective. In: Archives Europeenes de Sociologie, Heft 2, S.221 - 258.

Брок, Адольф/Вүлп, Франц (1982) 1976 онд батлагдан гарсан шийдвэр гаргалтанд оролцох эрхийн тухай хуулийн талаар ХБНГУ -ын үндсэн хуулийн цэцээс гаргасан шийдвэр Баримт: Шинжлэх ухаан нийгмийн тухай мэтгэлцээнд Бремен муж улсын хувь нэмэр. Сэдэв: Оролцооны эрхийн тухай ажилчин ба хөрөнгөтний сонирхол.: Мэтгэлцээнд оруулсан хувь нэмэр. 5-р дэвтэр, 140 - 152-р хуудас

Buergenthal,Thomas (1997): The normative and Institutional Evolution of International Human Rights. In: Human Rights Quarterly, vol.19, pp.703-723.

Холбооны боловсрол судалгааны яам 2004: Бүтэн өдрийн сургуулиуд ба хөрөнгө оруулалтын хөтөлбөр "Ирээдүй, Боловсрол, Халамж". Download unter: <http://www.bmbf.de/de/1125.php>[14.07.2004]

Commission on Global Governance (1995): Our Global Neighborhood. Oxford University Press.

Crouch,Colin (2001): Welfare State Regimes and Industrial Relations Systems. The Questionable Role of Path Dependency. In: Ebbenhau, Bernhard/Manow, Philip (edit): Comparing Welfare Capitalism. Social Policy and Political Economy in Europe, Japan and the USA. London:Routledge, pp.105 - 124.

Кзада, Роланд/Лютц, Сүзанне/Метте, Штефан (2003): Зохицуулалтын бодлого. Зах зээл ба техникийг номхруулах нь. Опладен: Леске ба Будрих.

Германы Бундестаг (2002): Дэлхийн эдийн засгийн глобальчлалын комиссын илтгэл. Опладен: Леске ба Будрих

Германы ПИСА - судалгааны консорциум. (2001): ПИСА 2000. Сурагчдын суурь мэдлэгийг олон улсын түвшинд харьцуулсан байдал. Опладен: Леске ба Будрих

Германы ПИСА - судалгааны консорциум (Зохиогч)(2001): Германы Холбооны улсуудын ялгаатай байдал. Опладен: Леске ба Будрих

Доернер, Манфред (2000): Улс төрийн соёл ба Хэвлэл мэдээлүүдийн цэнгээнт нэвтрүүлгүүд. Констанц

Dworkin, Ronald (1981): What is Equality? Part 2: Equality of Resources. In: Philosophy&Public Affairs, No 10.

Dworkin, Ronald (2000): *Sovereign Virtue. The Theory and Practice of Equality*. London: Harvard University Press.

Эгле, Христоф (2004): “Германы загвар”-аас “Өвчтэй эр” хүртэл. ХБНГУ-ыг нийгмийн ардчиллын хэтийн төлөв ба тэнцэтгэлийн өнцгөөс харахад. Томас Майер: Нийгмийн ардчиллын онол, 2-р дэвтэр.

Espring - Andersen, Goesta (1990): *The Three Worlds of Welfare Capitalism*. Cambridge: Polity.

Espring - Andersen, Goesta (1996): *Welfare States in Transition. National Adaptions in Global Economies*. London/Thousand Oaks/New Delhi: SAGE Publications.

Энкиетте -ын комисс: “Иргэдийн идэвх санаачилгын ирээдүй”, Германы Бундестаг (2002) Иргэдийн идэвх санаачилгын илтгэл: Иргэдийн иргэний нийгмийн ирээдүйд хүрэх зам. Опладен: Леске ба Будрих

Espring - Andersen, Goesta (1999): *Social Foundations of Postindustrial Economies*. Oxford: Oxford University Press.

Espring - Andersen, Goesta (2002 a): *Why We Need Welfare State*. Oxford: Oxford University Press.

Espring - Andersen, Goesta (2002b): *A Child - Centred Social Investment Strategy*. In: (ders.): *Why We Need a New Welfare State*. Oxford: Oxford University Press, pp.68 - 95

Fabian Essays (1962): by Shaw, Georg Bernard/Webb, Sidney/Wallas, Graham/The Lord Olliver/u.a.London.

Ferrera, Maurizio/Rhodes, Martin (2000): *West Europaen Politics. Special Issue on Recasting Europaen Welfare States*. Volume 23, April 2000. Number 2.

Freedom House (2003): *Country Ratings: Germany, Japan, Netherlands, Sweden, United Kingdom, United States of America*. Download unter: <http://www.freedomhouse.org/research/freeworld/2003countryratings/09.06.2004>

Френзел, Мартин 2002 Нийгмийн ардчиллын шинэ замналууд. Дани ба Германы харьцуулалт. 1982 - 2002 Виесбаден: Дт. Их сургуулийн хэвлэлийн газар

Фридрих, Хорст/Виедемайер, Михаел 1998 Ажилгүйдэл - байнгын асуудал. Цар хүрээ, шалтгаанууд, стратегиуд. Опладен: Леске ба Будрих.

Фултон, Лионел 2001 Британийн үйлдвэрчний эвлэл ба нэгдсэн эзэнт улсын хөдөлмөрийн харилцаа. Фридрих Эбертийн Сан. Working Paper 1/2001

Goodman, Roger/Peng, Ito (1996): The East Asian Welfare States: Peripatetic Learning, Adaptive Change, and Nation - Building. In: Espring - Andersen, Goesta (edit): Welfare States in Transition. National Adaptions in Global Economies. London/Thousand Oaks/New Delhj: SAGE Publications.

Gottlieb, Robert (1993): Forcing the spring. The Transformation of the American Environmental Movement. Washington: Island Press.

Gray, John (1995): Liberalism. Second Edition. Buckingham: Open University Press.

Грайфенхаген, Мартин/Грайфенхаген, Силвиа 2002 ХБНГУ-ын улс төрийн соёлын гарын ном. 2-дахь хэвлэл. Виесбаден: Баруун Германы хэвлэлийн газар.

Гукенвиел, Херман Л.2001 Боловсрол ба боловсролын систем, Шеферс, Бернхард/Зарф, Волфганг Эрхлэн гаргасан. Германы нийгмийн толь, Холбооны боловсролын төв. Опладен: Леске ба Будрих, 89 - 102 хуудас.

Гургдиес, Эрик 2004: Хөгжил, Шведийн нийгмийн сайн сайхны төлөөх төрийн хөгжил ба хамгаалал. Томас Майер: Нийгмийн ардчиллын онол, 2-р дэвтэр

Хавермас, Юүрген 1990: Олон нийтийн бүтцийн өөрчлөлт. Иргэний нийгмийн категорын судалгаа. Франкфурт ам Майн. Сүүркамф.

Хавермас, Юүрген 1992: Нотолгоо ба хэрэгжилт. Эрх ба эрх зүйт төрийн тухай мэтгэлцээнд оруулах хувь нэмэр. Франкфурт ам Майн. Suhrkamp Verlag.

Хавермас, Юүрген 1996: Бусдыг татан оролцуулах нь. Улс төрийн онолын судалгаа. Франкфурт ам Майн.: Сааркамф. Хавермас, Юүрген/Лүүман, Никлас 1971: Нийгмийн онол уу? эсвэл нийгмийн технологийн онол уу? Системийн судалгаа ямар үр дүнд хүргэдэг бэ? Франкфурт ам Майн.: Сааркамф

Hall, Peter A./Soskice, David W. (2001): Varieties of Capitalism. The Institutional Foundations of Comparative Advantage. Oxford/New York: Oxford University Press.

Hawken, Paul/Lovins, Amory/Lovins, L. Hunter (1999): Natural Capitalism. Creating the Next Industrial Revolution. Boston: Little Brown & Co.

Хаяаек, Фридрих Аугуст фон 1997 Ардчиллын тухай 3 лекц, Шударга ёс ба социализм. Түйвенген: Моор

Хаяаек, Фридрих Аугуст фон 1981: Нийгмийн шударга ёсны тухай хоосон мөрөөдөл. Либерал зарчмууд ба улс төрийн эдийн засгийн шинэ зураглал. Лехийн Ландсберг: Орчин үеийн үйлдвэр хэвлэлийн газар

Хайделмайер, Волфганг 1997: Хүний эрх. 4-дэх хэвлэл. Падерборн: Фердинанд Шөннайт хэвлэлийн газар

Heidenheimer, Arnold J. (1981): Education and Social Security entitlements in Europe and America. In: Flora, Peter/Heidenheimer, Arnold J. (Eds.): The Development of Welfare States in Europe and America. New Brunswick/London, pp. 269 - 304.

Хайнеман, Эдуард 1929: Капитализмын нийгмийн онол. Түйвенген: Моор. Хайнеман, Эдуард 1963: Эдийн засгийн системүүдийн нийгмийн онол. Түйвенген: Моор.

Хайтмайер, Вилхэльм 1997 ХБНГУ: Зөрчилт нийгмийн зөвшилцөлт нийгэмд хүрэх зам. Франкфурт ам Майн. Сааркамф хэвлэлийн газар.

Хайтмайер, Вилхэльм 2004а Нийгмийг юу задралд хүргэж байна бэ? Франкфурт ам Майн.: Сааркамф хэвлэлийн газар.

Хайтмайер, Вилхэльм 2004 б Нийгмийг юу нэгтгэж байна бэ? Франкфурт ам Майн.: Сааркамф хэвлэлийн газар.

Held, David (1995): Democracy and the Global Order. From the Modern State to Cosmopolitan Governance. Cambridge: Polity Press.

Held, David (2000): A globalizing world? Culture, economics, politics. London: Routledge.

Held, David/McGrew, Anthony (2000): The Global Transformations Reader. An Introduction to the Globalization Debate. Cambridge: Polity Press. Held, David/McGrew, Anthony/Goldblatt, David/Perraton, Jonathan (1999): Global

Transformations. Politics, Economics and Culture. Cambridge: Polity Press.

Хеллер, Херман 1934: Төрийн онол. Эрхлэн гаргасан Герхард Ниемайер. Лайден: : A. W. Sijthoff's Uitgeversmaatschappij N. V

Хеллер, Херман 1971 а: Бүтээлийн цуглуулга. Эхний боть: Чиг хандлага ба шийдвэр. Лайден: A.W.Sijthoff.

Хеллер, Херман 1971 б: Бүтээлийн цуглуулга. Хоёрдугаар боть: Эрх, Төр, Эрх мэдэл. Лайден: A.W.Sijthoff.

Hemerijck, Anton (2002): The Self - Transformation of the European Social Model(s). In: Esping-Andersen, Gosta (Hrsg.): Why We Need a New Welfare State. Oxford: University Press.

Hemerijck, Anton/Unger, Brigitte/Visser, Jelle (2000): How Small Countries Negotiate Change: Twenty-Five Years of Policy Adjustment in Austria, the Netherlands, and Belgium. In: Scharpf, Fritz W./Schmidt, Vivien A. (Ed.): Welfare and Work in the Open Economy. Volume II. Diverse Responses to Common Challenges, pp. 175 - 263.

Хинчман, Лей 2004а: АНУ: Либерал нийгмийн сайн сайхны төлөөх төр мөн үү? Томас Майер:Нийгмийн ардчиллын онол, 2-р дэвтэр

Хинчман, Лей 2004б: Тогтвортой хөгжил. Газар ба хөдөлмөр. Томас Майер: Нийгмийн ардчиллын онол, 2-р боть.

Хинч, Вилфриед 2002: Үндэслэлтэй тэгш бус байдал. Нийгмийн шударга ёсны ерөнхий зарчмууд. Берлин: де Грайтер.

Ховхаус, Леонард Трелауни 1911: Либерализм. Лондон: Уиллямс ан Норгате. Хоеффе, Отфриед 1999: Ардчилал даяаршлын эрин үед. Мюнхен, Век

Ханфорд, Роланд 1971: Нийгмийн сайн сайхны төлөөх диктатур. Шведийн загвар. Фракфурт: Уллштайн.

InterAvtion Council (1997): Хүний үүрэг хариуцлагын тайлбар. Download unter: : <http://www.interactioncouncil.org> [06.06.2004

Jackson, Gregory (2001): The Origins of Nonliberal Corporate Governance in Germany and Japan. In: Streeck, Wolf gang/Yamamura, Kozo (Hrsg.): The Origins of Nonliberal Capitalism. Germany and Japan in Comparison. IthacaLondon: Cornell University Press, S. 121 - 170.

Женике, Мартин 1999 Байгаль орчны бодлого. Бонн: Диец хэвлэлийн газар.

Жан, Детлеф 2003: Шведийн улс төрийн систем. Исмайер

Jahn, Detlef (2003): Das politische System Schwedens. In: Ismayr, Wolfgang (Hrsg.): Die politischen Systeme Westeuropas. 3. Auflage. Opladen: Leske + Budrich, S. 93 - 130.

Камппетер, Вернер 2003: Хөдөлмөрийн зах зээл ба Японы нийгмийн хамгаалын систем. Бодит байдал. Токио: Германы элчин сайдын яам.

Камппетер, Мернер 2004: Нийгмийн ардчилал Японд. Германд үлгэр жишээ болох уу? Хэвлэгдээгүй эх.

Кастендиек, Ханс 1998: Хөдөлмөрийн харилцаа ба үйлдвэрчний эвлэлийн ашиг сонирхлын төлөөлөл. Оре, Карл\Волле, Ангелика эрхлэн гаргав: Холбооны улсуудын илтгэл: их Британи. Түүх. Улс төр. Эдийн засаг. Нийгэм. Бонн. 331 - 357 хуудас.

Кауфман, Франц - Хавер 2003: Нийгмийн сайн сайхны төлөөх төрийн хувилбарууд. Германы нийгмийн сайн сайхны төлөөх төрийн хувилбарууд. Германы нийгмийн баримжаат төрийг олон улсын түвшинд харьцуулах нь. Франкфурт ам Майн.: Сааркамф хэвлэлийн газар.

Каул, Инге/Консайкао, Педро/Ле Гоулбен, Карл/Болле, Ангелика эрхлэн гаргасан:

Даяаршлын олон нийтийн таваарын хангамж, Даяаршлыг төлөвлөн зохион байгуулах нь. НҮБХХ-т зориулан хэвлэв. New York. Oxford: Oxford University Press.

Кайзер, Фолке 2000: Нийгмийн стандартуудын олон улсын зохицуулалт Лейпцигийн Их Сургуулийн улс төрийн шинжлэх ухааны факультетад хийсэн дипломын ажил.

Керстинг, Волфганг 1993: Либерализм, Коммунтаризм, Ардчиллын тухай. Гоелер, Г. Эрхлэн гаргасан. Өнөөгийн ардчиллын философийн үндэслэлүүд. Баден - Баден: Номос хэвлэлийн газар.

Клайн, Ансгар 2001: Иргэний нийгмийн мэтгэлцээн. Улс төрийн шалтгаан ба ардчиллын онолд үзүүлэх үр дагавар. Опладен: Леске ба Будрих

Клайнфелд, Ралф 2001 Голланд. Ройттер. Вернер/Рүйттерс, Петер Эрхлэн гаргасан. Баруун европын холбоод ба холбоодын систем. Опладен: Леске ба Будрих. 287 - 312-р хуудас.

Крелл, Христиан 2004: Британийн нийгмийн баримжаат төрийг нийгмийн ардчиллын толиор тольдохуйд. Томас Майер: Нийгмийн ардчиллын онол. Хоёрдугаар боть.

Ласалле, Фердинанд 1864: Ажилчдын шинжлэх ухаан. Берлиний эрүүгийн шүүхийн өмнө өмчгүй ангийн өмчтөнгүүдийг үзэн ядаж, үл хүндэтгэж буйг өмгөөлөн хэлсэн үг. Берлин: Иринг.

Ли, Оен-Жеунг 2004: Японы нийгмийн ардчилал. Японы систем дэх нийгмийн ардчиллын элементүүд. Томас Майер. Нийгмийн ардчиллын онол. 2-р боть.

Лээнер, Франц /Бидмайер, Ульрих 2002: Засгийн газрын харьцуулсан онол. 4-дэх хэвлэл. Опладен: Леске ба Будрих.

Leibfried, Stephan (2001): Welfare State Futures. Cambridge: University Press.

Лепсзи, Норверт 2003: Голландын нийгмийн систем. Исмайер, Волфганг эрхлэн гаргав: Баруун Европын улс төрийн систем. 3-дах хэвлэл. Опладен: Леске ба Будрих, 349 - 387 хуудас.

Lewis, Jane (1993): Women and Social Policies in Europe. Work, Family and The State. Cornwall: Hartnolls.

Локе, Жон 1967: Засгийн газрын хэлэлцээрүүд. Эрхлэн гаргасан Вальтер Ойхнер. Франкфурт ам Майн: Europ. Verl. -Anst.

Лоевентал, Ричард 1978: Капитализмаас алсад. Нийгмийн шинэ чиг хандлага тогтооход миний оруулах хувь нэмэр. 3 -дах хэвлэл. Бонн: Диетц.

Лүүман, Никлас 1993: Нийгмийн эрх. Франкфурт ам Майн.: Сааркамф.

Lund, Brian (2002): Understanding State Welfare. Social Justice or Social Exclusion. London.

Маршал, Томас Х.1992: Иргэний эрхүүд ба нийгмийн ангиуд. Нийгмийн сайн сайхны төлөөх төрийн социологи. Сери: Онол ба нийгэм, 22 -р дэвтэр. Франкфурт ам Майн: Кампус хэвлэлийн газар.

Матцер, Эгон 1982: Маргаашийн нийгмийн сайн сайхны төлөөх төр. Төрийн оролцооны цаг үедээ зохицсон загвар. Вена.

Маянтц, Ренате/Розевитц, Вернд/Шиманк, У./Стихвээ, Р. 1988 Ялгаатай байдал ба бие даасан байдалд хүрэх. Нийгмийн дэд системүүдийн хөгжлийн тухай. Франкфурт ам Майн. Франкфурт ам Майн. /Нью Йорк: Кампус хэвлэлийн газар.

McGrew, Anthony (2000): Democracy beyond Borders? In: Held, David/McGrew, Anthony (edit.): The Global Transformations Reader. An Introduction to the Globalization Debate. Cambridge: Polity Press, pp. 405 - 419.

Meidner, Rudolf (1980): Our Concept of the Third Way. Some Remarks on the Socio-political Tenets of the Swedish Labour Movement. In: Economic and Industrial Democracy, 1/3, pp. 343 - 369.

Меннинген, В. 1971: Нийгмийн сайн сайхны төлөөх төртэй улсуудын тэгш бус байдал. Шведийн социалдемократуудын Алба-Мирдалын илтгэл. Рейнбек: Робоолт.

Меркел, Волфганг 1999: Гажуудалтай ардчилал. Меркел, Волфганг/Буш, Андреас Эрхлэн гаргав, Ардчилал баруунд ба зүүнд. Франкфурт ам Майн.: Сааркамф

Merkel, Wolfgang (2000): Social Justice and Social Democracy at the Beginning of the 21st Century. Herzliya.

Меркел, Волфганг/Эгле, Христов/Хенкес, Христиан/Остхайм, Товиас/Петринг, Александр 2005: Нийгмийн ардчиллын шинэчлэгдэх чадвар. Засгийн газрын бодлого баруунд. Виесбаден: БС хэвлэлийн газар.

Меркел, Волфганг/Пүүле, Ханс - Юүрген/Кройссант, Аурел/Эйчер, Клаудиа/Тиери, Петер 2003 Гажуудалтай ардчилал. Нэгдүгээр боть.: Онол. Опладен: Леске ба Будрих.

Меркел, Волфганг/Крүйк, Мирко 2003: Нийгмийн шударга ёс ба ардчилал. Уялдаа холбооны эрэлд. Бонн: Фридрих Эбертийн сан. Олон улсын бодлогын шинжлэл.

Майер, Томас 1977: Вернштайны бүтээлч социализм. Эдуард Вернштайны социализмын онолд оруулах хувь нэмэр. Берлин/Бонн: Ж.Х.В. Диец ХХК.

Майер, Томас 1991: Ардчилсан социализм ба нийгмийн ардчилал. Оршил. Бонн: Ж.Х.В. Диец хэвлэлийн газар.

Майер, Томас 2001 Медиократие. Колоничлолын бодлого хэвлэл мэдээллээр. Франкфурт ам Майн.: Сааркамп хэвлэлийн газар.

Майер, Томас 2002 а Нийгмийн ардчилал ба даяаршил. Европын хэтийн төлөв. Бонн: Ж.Х.В. Диец хэвлэлийн газар.

Майер, Томас 2002 б: Уламжлалт бодлого. Соёлын олон талт байдлыг буруугаар ашиглах нь. Франкфурт ам Майн. Сааркамф хэвлэлийн газар.

Майер, Томас 2005а: Нийгмийн ардчиллын онол. 1-р боть. Виесбаден: Нийгмийн шинжлэх ухааны хэвлэлийн газар.

Майер Томас 2005б: Нийгмийн ардчиллын онол. 2-р боть. Улс орнуудын харьцуулсан судалгаа. Виесбаден: Нийгмийн шинжлэх ухааны хэвлэлийн газар.

Милл, Жон Стюарт 1969: Эрх чөлөөний тухай. Франкфурт ам Майн.: Sauerlaender.

Милл, Жон Стауерт 1971: Төлөөллийн ардчиллын тухай дүгнэлтүүд. К.Л. Шелийн удирдлага дор Эрхлэн гаргав.

Milner, Henry (1989): Sweden. Social democracy in practice. Oxford: Oxford University Press.

Мюллер, Михаел 1999: буцах боломжтой. Атомын эрчим хүчгүйгээр эрчим хүчээр найдвартай хангах бололцоотой. Бонн: Диец.

Мюллер, Михаел 2002: Тогтвортой хөгжил. Франкфурт ам Майн.: Сааркамф хэвлэлийн газар.

Мюнх, Ричард 1991: Мэдээллийн нийгмийн диалектик. Франкфурт ам Майн.: Сааркамф хэвлэлийн газар.

Murphy, Liam/Nagel, Thomas (2002): The Myth of Ownership. Taxes and Justice. Oxford: University Press.

Naeringsdepartementet (2002): Benchmarking av naeringspolitiken.

Наптали, Фритц 1966: Эдийн засгийн ардчилал. Түүний мөн чанар, зорилт. Франкфурт: Европ. Хэвлэлийн газар.

Найдхардт, Фридрих 1994: Олон нийт, олон нийтийн санаа бодол, нийгмийн хөдөлгөөнүүд. Коелний нийгэм, нийгмийн сэтгэл зүй сэтгүүл. Тусгай дугаар 34. 7 - 41-р хуудас.

Нида-Рюмелин, Жулиан 1999: Ардчилал хамтын ажиллагаа мөн. Франкфурт ам Майн.: Сааркамф.

Nida-Rümelin, Julian (2002): Ethische Essays. Frankfurt a. M.: Suhrkamp.

Ниесен, Петер 2002: Либертаризмын улс төрийн онол: Роверт Нозик ба Фридрих А фон Найикв Бродокз, Андре/Шаал, Гари С. Эрхлэн гаргав. Орчин үеийн улс төрийн онолууд 1. Опладен: Леске ба Будрих, 77 - 117-р хуудас

Нови, Клаус 1978: Нийгэмчлэх стратеги. Ваймарын Бүгд Найрамдах Улсын Эдийн засгийн шинэчлэлийн тухай мэтгэлцээн. Франкфурт ам Майн. Нью Йорк: Кампус хэвлэлийн газар. Nozick, Robert (1974): Anarchy, State and Utopia. Oxford: University Press.

O'Connor, James (1998): Natural Causes. Essays in Ecological Marxism. New York: Guilford Press.

Оффе, Клаус/Коска, Юүрген эрхлэн гаргав 2000 Хөдөлмөрийн түүх ба ирээдүй. Франкфурт ам Майн. Кампус.

Office for National Statistics (2003): Social Trends No. 33. London.

Пайне, Томас 1973: Хүний эрхүүд. Франкфурт ам Майн.: Сааркамф хэвлэлийн газар.

Паридон, Киес фон 2004 Бүтээн байгуулалт - Хямрал - Амралт. Голландын эдийн засаг 1945 оноос хойш. Виеленга, Фризо/Тауте, Илона Эрхлэн гаргав. Голландын илтгэл. Түүх - Нийгэм. Холбооны улс төрийн боловсролын төв. 399-р дэвтэр. 363 - 422-р хуудас.

Pierson, Paul (2000): The Three Worlds of Welfare Capitalism Research. In: Comparative Political Studies, 33, pp. 791 - 821.

Polanyi, Karl (1977): The great transformation. Politische und ökonomische Ursprünge von Gesellschaften und Wirtschaftssystemen. Wien: Europa Verlag.

Powell, Martin/Hewitt, Martin (2002): Welfare State and Welfare Change. Buckingham: Open University Press.

Приллер, Экхард 2001: Олон улсын гуравдагч сектор. Зах зээлийг нэмэгдүүлж төрийн оролцоог бууруулсаар байх уу? Берлин: Сигма хэвлэлийн газар.

Putnam, Robert (2000): Bowling Alone. The Collapse and Revival of American Community. New York.

Пүтнам, Роверт 2001: Нийгэм ба хамтын утга. Нийгмийн капиталыг олон улсын түвшинд харьцуулах нь. Вертелсман сангийн хэвлэлийн газар.

Раулс, Жон 1972: Шударга ёсны онол. Франкфурт ам Майн.: Сааркамф хэвлэлийн газар.

Раулс, Жон 1993: Шударга ёс шударга харьцааны илэрхийлэл: улс төр бол метафизик биш. Хоннет, Аксел эрхлэн гаргав.: Коммунтаризм. Орчин үеийн нийгмийн орчин үеийн үндсийн тухай ёс зүйн мэтгэлцээн. Фракфурт ам Майн./Нью Йорк: Кампус хэвлэлийн газар. 36 - 67-р хуудас.

Раулс, Жон 1998: Улс төрийн либерализм. Франкфурт ам Майн.: Сааркамф хэвлэлийн газар.: Сааркамф хэвлэлийн газар.

Рээсе - Шефер Вальтер 2000: Улс төрийн онол өнөө үед. Мюнхен/Вена: Үлденбоург

Rein, Martin u.a. (1987): Stagnation and renewal in social policy: The rise and fall of policy regimes. New York: Armonk.

Рэсзат, Беате 1998: Эдийн засаг ба аж үйлдвэрийн бүтэц: Шинж чанар ба асуудалтай салбарууд. Роол, Манфред/Майер, Ханс Юүрген Эрхлэн гаргав: Улс орнуудын илтгэл. Япон. Газар зүй, Түүх, Эдийн засаг, Нийгэм, Соёл, Холбооны улс төрийн боловсролын төв. Цуврал дэвтэр 355. 278 - 285-р хуудас.

Rhodes, Martin (2000): Restructuring the British Welfare State: Between Domestic Constraints and Global Imperatives. In: Scharpf, Fritz W./Schmidt, Vivien A. (Hrsg.) (2000a): Welfare and Work in the Open Economy. Volume II. Diverse Responses to Common Challenges. Oxford. S. 19 - 68.

Rohatyn, Felix (1993): Introduction. In: Albert, Michel (edit.): Capitalism vs. Capitalism. How America's Obsession With Individual Achievement And Short-Term Profit Has Led It To The Brink Of Collapse. New York: Four Walls Eight Windows, p. XV - XIX.

Rosenau, James/Czempiel, Ernst Otto (1992): Governance Without Government. Order and Chance in World Politics. Cambridge.

Rothstein, Bo (1996): The social democratic state. The Swedish model and the bureaucratic problem of social reforms. Pittsburgh: University of Pittsburgh Press.

Rothstein, Bo (1998): Just Institutions Matter. The Moral and Political Logic of the Universal Welfare State. Cambridge: University Press.

Rothstein, Bo/Steinmo, Sven (2002): Restructuring the welfare state. Political institutions and policy change. New York: Palgrave Macmillan.

Ruggie, John Gerard (1998): Constructing the world polity. Essays on international institution-alization. London: Routledge.

Ханс - Воеклерийн сангийн мэргэжилтнүүдийн боловсролын төв. 2002: Боловсролын салбарын шинэчлэлийн зөвлөгөө. Вайнхайм/Мюнхен: Жүвента хэвлэлийн газар

Эдийн засгийн хөгжлийн мэргэжилтнүүдийн зөвлөлийн зөвлөмж 2003 Жилийн тайлан.
2002 - 2003

Саламон, Лестер М./Анхайер, Хэльмут К. 1998: Гуравдагч секторын олон улсын чиг хандлага. Анхайнер, Хэльмут К/Приллер, Экхард/Сайвел, Волфганг/Циммер, Анетта Эрхлэн гаргасан.: Германы гуравдагч сектор. Нийгмийн өөрчлөлтөнд төр ба зах зээлийн зохион байгуулалт. 2-дох хэвлэл. Берлин: Сигма хэвлэлийн үйлдвэр. 153 -174-р хуудас.

Samuelson, Paul A. (1954): The pure theory of public expenditure. In: Review of Economics and Statistics, No 36, pp. 387 - 389.

Сартори, Гиобанни 1997: Ардчиллын онол. Дармштадт: Примус хэвлэлийн газар.

Шэферсь Вернхард/Заф, Волфганг 2001: Германы нийгмийн гарын толь бичиг. Улс төрийн боловсролын төв. 2-дох хэвлэл. Опладен: Леске ба Будрих.

Шарф, Фритц В. 1972: Үл гүйцэлдэх үзэл ба дасан зохицох бодлогын хоорондох ардчиллын онол. Констанц: Их Сургуулийн хэвлэлийн газар.

Шарф, Фритц 1999: Засаглал Европт. Үр өгөөжтэй ба ардчилсан? Франкфурт ам Майн./ Нью Йорк: Кампус хэвлэлийн газар.

Scharpf, Fritz/Schmidt, Vivian A. (2000): Welfare and Work in the Open Economy. Volume I and II. Oxford: University Press.

Шриллер, Тео 1978: Либерализм Европд. Нидерзахсений улс төрийн боловсролын төв. Эрхлэн гаргав. Ханобер.

Шиманк, Үбе 1985: Нийгмийн ялгаатай байдлын системийн онолын тахйлбаруудад актёруудын оролцоо дутмаг байна - Мэтгэлцээний санал. Социологи сэтгүүлийн 14, 6-р дэвтэр. 421 - 434-р хуудас.

Шиманк, Үбе 1988: Нийгмийн дэд системүүд бол актёруудын төсөөлөл мөн. Социологи ба нийгмийн сэтгэл зүйн Коелний сэтгүүл 40. 3-р дэвтэр. 619 - 639-р хуудас.

Шиманк, Үбе 1992: Улс төрийн удирдлагыг тодорхойлогч элементүүдийг актёруудын онолын зүгээс. Сэдвийн каталог. Вүссхоф, Хайнрих эрхлэн гаргав. Улс төрийн удирдлага. Удирдах боломж - удирдах чадвар. Үндэслэлийн тухай мэтгэлцээнд оруулах хувь нэмэр. Баден-Баден. 165 - 191-р хуудас.

Шиманк, Үбе 1996: Нийгмийн ялгаатай байдлын онолууд. Опладен.

Шиманк, Үбе. 2000: Үйл ажиллагаа ба бүтэц. Актёрын онолын социологийн оршил. Вайнхайм/Мюнхен: Жүбента.

Шлайхер, Андреас 2003: 2003 оны боловсролын салбарын үйл ажиллагаанд өгөх үнэлэлт. OECD briefing notes for Germany.

Шлүхтер, Волфганг 1968: Нийгмийн баримжаат эрх зүйт төрийг байгуулах шийдвэр. Херман Хеллер ба Ваймарийн Бүгд Найрамдах Улсын төрийн онолын мэтгэлцээн. Коелн/Берлин: Киефенхойер ба Виеш.

Шмидт, Йосеф 1996: нийгмийн сайн сайхны төлөөх төрийн харьцуулсан судалгаа. Европын нийгмийн хамгааллын систем: Зохион байгуулалт, Санхүүжилт, Бүтээмж, Асуудлууд. Опладен: Леске ба Будрих.

Шмидт, Манфред Г. 1998: Германы нийгмийн бодлого. Түүхэн хөгжил ба олон улсын харьцуулалт. 2-дох хэвлэл. Опладен: Леске ба Будрих

Шмидт, Манфред Г. 2000: Ардчиллын онол. Оршил. 3-дах хэвлэл. Опладен: Леске ба Будрих.

Schmidt, Vivian A. (2000a): Still Three Modells of Capitalism? The Dynamics of Economic Adjustment in Britain, Germany and France. In: Czada, Roland/Ltz, Susanne (Hrsg.): Die politische Konstitution von Maerkten. Wiesbaden: Westdeutscher Verlag, S. 38 - 73.

Schmidt, Vivian A. (2000b): Values and Discourses in the Politics of Adjustment. In: Scharpf, Fritz W./Schmidt, Vivian A.: Welfare and Work in the Open Economy. Volume I. From Vulnerability to Competitiveness. Oxford: University Press, pp. 229 - 309.

Шнайдер, Маркус 1994: Эрүүл мэндийн системүүдийн олон улсын харьцуулалт. Аугсбург.

Шүберт, Гүннар Фолке/Найдхардт, Фридхэльм. 2002: Нийгмийн сайн сайхан - үндэс нь юунд оршиж байна? ВЗБ 2002 оны жилийн ном. Берлин: Сигма хэвлэлийн газар.

Шбан, Гезине 1979: Аж үйлдвэржсэн нийгмийн ардчилсан социализм Коелн: Европ. Хэвлэлийн газар.

Ардчилал социализмд? Тууштай социалдемократ бодлогын онол. Штүтгарт/Берлин/Коелн/Майнц: Коолхаймер:

Шбан, Гезине 1988 : Улс төрийн тогтвортой байдлын нөхцөл ба асуудлууд. Баден - Баден: Номос хэвлэлийн газар.

Шбан, Гезине 1995: Шинжлэх ухаан ба Улс төр олон нийтийн хариуцлагад. Үсрэнгүй хөгжлийн үеийн асуудлуудыг оношлох нь. Баден - Баден: Номос хэвлэлийн газар.

Шведийн институт. 1999: Шведийн бодит байдал. Шведийн хэвлэл мэдээлэл. Штокхолм.

Шведийн институт. 2001: Шведийн бодит байдал. Гимназийн сургалт ба насанд хүрэгчдийн боловсрол. Штокхолм.

Швейцарийн Урс 1999: Гэрээний онол. Түйвенген: Моор Сиевек.

Сээлайв-Кайзер, Мартин 2001: Даяаршил ба Нийгмийн бодлого. Германы мэтгэлцээн ба нийгмийн сайн сайхны төлөөх системүүдийн харьцуулсан судалгаа Японд болон АНУ-д. Нийгмийн бодлогын институт. 12. Франкфурт ам Майн. Кампус хэвлэлийн газар.

Сайферт, Карл - Хайнц/Хоеминг, Диетер 1995: ХБНГУ-ын үндсэн хууль. Халаасны коментар. 5-дах хэвлэл. Баден - Баден: Номос хэвлэлийн газруудын нийгэмлэг.

Сайферт, Волфганг 1998: Японы нийгэм өнөөдөр: Хамтын ажиллагаа амьжиргааны эх үүсвэрт аюул учруулж байна. Поол, Манфред/Майер, Ханс Юүрген Эрхлэн гаргав: Улс орнуудын илтгэл Япон. Газар зүй. Түүх. Нийгэм. Эдийн засаг. Соёл. Холбооны улс төрийн боловсролын төв. Цуврал дэвтэр 355, 103 - 111-р хуудас.

Сэйлс, Эрик 2004: Нийгмийн ардчилал, Голландын нийгмийн сайн сайхны төлөөх төр ба хөдөлмөр эрхлэлт. Майер, Томас: Нийгмийн ардчиллын онол, 2-р боть.

Selznick, Philip (1995): From Socialism to Communitarianism. In: Walzer, Michael (edit.), Toward A Global Civil Society. Oxford: Berghahn Books, pp. 127 - 132.

Sen, Amartya Kumar (1993): Moral codes and economic success. London: Suntory - Toyota Intern. Centre for Econ. and Related Disciplines.

Sen, Amartya Kumar (1999a): Global justice: Beyond international equity. In: Kaul, Inge (Hrsg.): Global Public Goods. International Cooperation in the 21st century. New York: Oxford University Press, 5.116 - 125.

Sen, Amartya Kumar (1999b): Human rights and economic achievements. In: Bauer, Joanne R. (Hrsg.): The East Asian challenge for human rights. Cambridge: Cambridge University Press, 5.88 - 99.

Shinkawa, Toshimitsu (1990): Nihongata no fukushi seijikeizaigaku (Politische Wohlfahrtsökonomie nach japanischer Art) Tokyo: Sanichi Siobo. (hier wurde verwendet: koreanische Übersetzung von Yun, Mun-Gu, Seoul: Hongikjae 2001).

Смит, Адам 1974: Үндэстний чинээлэг амьдралын түвшин: Түүний байгалийн жам ёс ба шалтгаануудын судалгаа. Мюнхен. Век.

Штаанке, Холмер 1998: 1854 - 1945 оны хоорондох Японы гадаад бодлого. Поол, Манфред/Майер, Ханс Юүрген Эрхлэн гаргасан. Улс орнуудын илтгэл. Газар зүй. Түүх. Улс төр. Нийгэм. Соёл. Холбооны улс төрийн боловсролын төв. Цуврал дэвтэр 355, 135-143-р хуудас.

Stedward, Gail (2000): New Labour's Education policy. In: Coates, David/Lawler, Peter (Hrsg.): New Labour in power. Manchester/New York, S. 169 - 180.

Стрээк, Волфганг 1994: Төр ба Холбоод. Опладен: Баруун Германы хэвлэлийн газар.

Стрээк, Волфганг 1998: Олон улсын эдийн засаг, үндэсний ардчилал. Ардчиллын онолд тавигдаж буй шаардлагууд. Макс-Планкийн нийгмийн судалгааны институт. Тусгай дэвтэр. Франкфурт ам Майн./ Нью Йорк: Кампус хэвлэлийн газар.

Сваан, Аврам де 1993: Халамжлагч төр: Сайн сайхны төлөөх үйлс, Шинэ цагийн Европ ба АНУ -ын эрүүл мэнд ба боловсрол. Франкфурт ам Майн. Кампус хэвлэлийн газар.

Thelen, Kathleen (2001): Varieties of Labour in Developed Democracies. In: Hall, Peter A./ Soskice, David (Hrsg.): Varieties of Capitalism. The Institutional Foundations of Comparative Advantage. Oxford: S. 71 - 103.

Тоде, Эрик 2002: Шинэчлэлийн олон улсын монитор - Бид бусдаас юуг суралцах ёстой бэ? Улс төр ба цаг үеийн түүх. В 46 - 47/2002, 13 - 21-р хуудас

Тиммерманс, Арко 1991: Голландын хаант улс. Штефани Вьенфриед Эрхлэн гаргав: Европын Холбооны улсуудын засгийн газрын олонхи ба сөрөг хүчин . Опладен: Люеске ба Будрих, 282 - 314-р хуудас.

Tinbergen, Jan (1965): International Economic Integration. Second, Revised Edition. Amsterdam.

Vereinte Nationen (1950): Draft International Covenant on Human Rights and Measures of Implementation. Resolution 421 (V) vom 04.12.1950.

Бестер, Михаел фон Оертцен, Петер 1992: Нийгмийн шинэ орчин ба олон ургальч ангит нийгэм. Хановер.

Бестер, Михаел фон Оертцен, Петер 1993: Нийгмийн орчин нийгмийн өөрчлөлтөнд. Нэгдэл ба гадуурхлын хооронд. Коелн: Бунд хэвлэлийн газар.

Биссер, Желле/Хемеритжикс, Антон 2000: Голландын нийгмийн баримжаат төрийн прагматик дасан зохицол - суралцах ёстой туршлага уу? Лайвфриед, Штефан/Ваегшал, Убе Эрхлэн гаргав. Германы нийгмийн баримжаат төр. Тэнцэтгэл - Шинэчлэл - Хэтийн төлөв. Франкфурт ам Майн. Кампус хэвлэлийн газар. 452 - 472-р хуудас.

Биссер, Желле/Хемеритжикс, Антон 1998: Голландын гайхамшиг уу? Нийгмийн баримжаат төрийн шинэчлэл ба Голландын хөдөлмөр эрхлэлтийн өсөлт. Франкфурт ам Майн. /Нью Йорк Кампус хэвлэлийн газар

Vitols, Sigurt (2001): Varieties of Corporate Governance: Comparing Germany and the UK. In:

Hall, Peter A./Soskice, David (Hrsg.): Varieties of Capitalism. The Institutional Foundations of Comparative Advantage. Oxford: S. 337 - 360.

Фон Вайзекер, Карл - Христиан 2000: Даяаршлын логик. Геттинген.

Фон Вайзекер, Эрнст - Ульрих 1999: Байгаль орчны зуун: Хэтийн төлөв: Байгаль орчинд ээлтэй ажиллаж амьдрах. Франкфурт ам Майн.: Кампус хэвлэлийн газар.

Фон Вайзекер, Эрнст - Ульрих 2001: Компаниудын тогтвортой хөгжилд байгальд ээлтэй хөгжил нөлөөлөх нь. Вүффертал: Цаг уурын Вүффертал - Институт Эрчим хүч ХХК.

Waengnerud, Lena (1994): Male and Female Party Images in Sweden. In: Scandinavian Political Studies 17, S. 143 - 170.

Вальцер, Михаел 1992: Шударга ёсны орчин. Олон ургальч үзэл ба тэгш байдлыг өмгөөлөн хэлэх үг. Франкфурт ам Майн.: Кампус хэвлэлийн газар

Walzer, Michael (1995): Toward A Global Civil Society. Oxford: Berghahn Books.

Wattenberg, Martin P. (1990): The Decline of American Political Parties: 1952-1988. Cambridge: Harvard University Press.

WCED Report (World Commission on Environment and Development) (1987): Our Common Future. (auch - Brundtland - Report genannt) Oxford: Oxford University Press.

Wellmer, Albrecht (1993): Bedingungen einer demokratischen Kultur. Zur Debatte zwischen Liberalen und Kommunitaristen. In: Brumlik, Micha/Brunkhorst, Hauke (Hrsg.): Gemeinschaft und Gerechtigkeit. Frankfurt a. M.

Wood, Stewart (2001): Business, Government, and Patterns of Labour Market Policy in Britain and the Federal Republic of Germany. In: Hall, Peter A./ Soskice, David (Hrsg.): Varieties of Capitalism. The Institutional Foundations of Comparative Advantage. Oxford. S. 247 - 274.

Woyke, Wichard (2000): Handwoerterbuch Internationale Politik. 8.Auflage. Opladen: Leske&Budrich6

НИЙГМИЙН АРДЧИЛЛЫН ИРЭЭДҮҮЙ